ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны долдугаар сарын 10* *№30 (109)*

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

274. Гэр бүлийн тухай (1999-6-11-ний хууль) 552
275. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (1999-6-17-ны хууль) 567
276. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-6-17-ны хууль) 568
277. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-6-17-ны хууль) 569
278. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай (1999-6-17-ны хууль) 569
279. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-6-17-ны хууль) 570

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

280. Хуулийн төслүүд буцаах тухай Дугаар 44 571

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

281. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн тухай Дугаар 111 572
282. Улсын Ерөнхий прокурорын орлогчийг томилох тухай Дугаар 112 572
283. Д. Лхагваад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай Дугаар 113 572
284. XXI зууныг угтаж хэрэгжүүлэх Үндэсний Ерөнхий хөтөлбөр санаачлах тухай Дугаар 114 572

Дөрөв. Монгол Улсын засгийн газрын тогтоол

285. Журам (хөтөлбөр), дүрэм, зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай Дугаар 79 573

Тав. Яам, агентлагийн акт

286. Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар тушаалын 5 дугаар хавсралт 576

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох журам, нөхцлийг тогтоож, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Гэр бүлийн тухай хууль тогтоомж

2.1.Гэр бүлийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."гэрлэлт" гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндэсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг;

3.1.2."гэр бүл" гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг;

3.1.3."гэрлэгчид" гэж гэрлэлтээр холбогдсон харилцан эгтэл эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг;

3.1.4."гэр бүлийн гишүүн" гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садангийн хүнийг;

3.1.5."төрлийн хүн" гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмээ эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг;

3.1.6."садангийн хүн" гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг;

3.1.7."овог" гэж нэг өвөг дээдсээс гаралтай эцгийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд үе уламжлан хэрэглэгдэгдэг нэрийг;

3.1.8."хүнд нөхцөлд байгаа хүүхэд" гэж Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль[1]-ийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүүхдийг.

4 дүгээр зүйл. Гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчим

4.1.Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ.

4.2.Иргэнийг гэрлэхэд нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хоригломо.

4.3.Гэр бүл нь нийгмийн үндэсэн нэгж мөн.

4.4.Гэр бүл, эх нялхас, хүүхдийн аших сонирхлыг төр хамгаална.

4.5.Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ.

4.6.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэр бүлийн харилцаанд Монгол Улсын иргэнтэй адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ

5 дугаар зүйл.Гэр бүлийн эрхийг хамгаалах

5.1.Шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль[1]-д заасны дагуу гэр бүлийн эрхийг хамгаална.

5.2.Төрийн захиргааны болон нийгмийн халамжийн байгууллага нь энэ хуульд заасны дагуу гэр бүлийн эрхийг хамгаална.

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

[2] Иргэний хууль "Ардын эрх" сонины 1994 оны 257, 258; 1995 оны 1, 2; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дугаарт тус тус нийтлэгдсэн.

[1] Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль."Ардын эрх" сонины 1996 оны 121, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1996 оны 9 дугаарт тус тус нийтлэгдсэн.

[1] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль- "Ардын эрх" сонины 1994 оны 130-133; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 8 дугаарт тус тус нийтлэгдсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Гэрлэлтийн харилцаа үүсэх үндэслэл, гэрлэх нөхцөл, журам, гэрлэлт дуусгавар болох

6 дугаар зүйл. Гэрлэх нөхцөл

6.1.Энэ хуулийн 9.1-д заасан харшлах шалтгаангүй бол 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн эрэгтэй, эмэгтэй хоёр бүүр Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй харилцан зөвшөөрөлцсөнөөр Монгол Улсад гэрлэж болно.

6.2.Эрэгтэй хүн нэг эхнэр, эмэгтэй хүн нэг нөхөртэй байна.

6.3.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэх асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтална.

6.4.Монгол Улсын иргэд хоорондоо, эсхүл Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн буюу харьяалалгүй хүнтэй гадаад улсад тухайн улсын хуулийн дагуу гэрлэсэн нь энэ хуулийн 9-д харшлахгүй бол Монгол Улсад хүчинтэйд тооцогдоно.

6.5.Энэ хуулийн 6.4-т заасан этгээдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүргийг тэдгээрийн байнга оршин суугаа улсын хуулиар тодорхойлно.

6.6.Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй гадаад улсад гэрлэсэн бол тэдгээрийн эрх, үүргийг гэрлэсэн улсын хуулиар, сонгоогүй бол энэ хуулиар тодорхойлно.

7 дугаар зүйл.Гэрлэх журам

7.1.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ гэрчийн этгээдийг байлцуулан иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

7.2.Гэрлэлтийг бүртгэсэн өдрөөс эхлэн гэрлэгчдийн эрх, үүрэг үүснэ.

7.3.Гэрлэлтийн бүртгэлийг хуулиар тогтоосон журмын дагуу гүйцэтгэнэ.

8 дугаар зүйл.Гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээ

8.1.Гэрлэхийг хүсэгчид өөрсдийн оршин суугаа газрын эмнэлгийн байгууллагаас эрүүл мэндийн тодорхойлолт гаргуулсан байна.

8.2.Гэрлэхийг хүсэгчийн хэн нэгэнд нь өнгөний болон дархлалын олдмол хомсдол, сүрьеэ, сэтгэцийн өвчний шинж тэмдэг илэрсэн бол мэргэжлийн эмнэлгийн байгууллагад шинжилгээ хийлгэнэ.

8.3.Эмнэлгийн байгууллага нь шинжилгээний хариуг гэрлэхийг хүсэгчдэд танилцуулж, удамшил, гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөлгөө өгч, тэдний хэн нэг нь энэ хуулийн 8.2-т заасан өвчтэй нь тогтоогдсон бол түүний үр дагаврын талаар тайлбарлаж өгнө.

8.4.Гэрлэхийг хүсэгчдийн шинжилгээний хариу нь эмнэлгийн байгууллагын нууц байна.

9 дүгээр зүйл.Гэрлэхэд харшлах шалтгаан

9.1.Дараахь байдал нь гэрлэхэд харшлах шалтгаан болно:

9.1.1.өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол;

9.1.2.гэрлэгчид хоёулаа, эсхүл хэн нэг нь энэ хуулийн 6.1-д заасан насанд хүрээгүй бол;

9.1.3.төрөл, садангийн хүмүүс хоорондоо гэрлэх;

9.1.4.харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх;

9.1.5.үрчлэгч, үрчлүүлэгч хоёр гэрлэх;

9.1.6.гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй бол.

9.2.Иргэний хуульд заасны дагуу насанд хүрээгүй хүнийг иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж зарласан нөхцөлд энэ хуулийн 9.1.2 үл хамаарна.

10 дугаар зүйл.Гэрлэгчдийн эрх, үүрэг

10.1.Гэрлэгчид нь гэр бүлийн дотор тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.

10.2.Гэрлэгчид нь гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хуваарьт зөрөнгөтэй байх, дундаа хамтран өмчлөх эд хөрөнгөө зээмших, ашиглах, захиран зарцуулах, материалын болон сэтгэл санааны хохирлоо бүрууталж этгээдээс гаргуулах тэгш эрхтэй.

10.3.Гэрлэгчид нь бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах, гэр бүлд шаардагдах эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх, хэн нэгнийхээ эрхийг зөрчихгүй, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх, угийн бичиг хөтлөх үүрэгийг адил хүлээнэ.

10.4.Угийн бичиг хөтлөх журмыг Засгийн газар батална.

11 дүгээр зүйл.Гэрлэлт дуусгавар болох

11.1.Гэрлэгч нас барсан болон түүнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрлэлт дуусгавар болсонд тооцогдоно.

11.2.Гэрлэлтийг захиргааны буюу шүүхийн журмаар цуцалсан, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцсон бол гэрлэлт дуусгавар болно.

11.3.Гэрлэлт дуусгавар болсныг бүртгэх журмыг хуулиар тогтооно.

12 дугаар зүйл.Гэрлэлт цуцлах журам

12.1.Гэрлэлтийг хуульд заасан үндэслэлээр захиргааны буюу шүүхийн журмаар цуцална.

12.2.Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглоно.

12.3.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний гэрлэлт цуцлах асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийг баримтлана.

13 дугаар зүйл.Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлах

13.1.Гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид энэ тухай тус тусдаа бичиж, гарын үсэг зурсан хүсэлтээ иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад гаргана.

13.2.Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан хүсэлтийг хянан үзэж 30 хоногийн дотор гэрлэлтийг цуцалж болно.

14 дүгээр зүйл.Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах

14.1.Энэ хуулийн 13-т зааснаас бусад тохиолдолд гэрлэгчдийн харилцан тохиролцсон буюу тэдний хэн нэгний, эсхүл иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон эхнэр, нөхрийн асран хамгаалагчийн нэхэмжлэлийн дагуу гэрлэлт цуцлах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

14.2.Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна.

14.3.Гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусмагц шүүх гэрлэлтийг цуцална.

14.4.Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална.

14.5.Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа тохиролцож болно.

14.6.Гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууныг байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

14.7.Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ.

14.8.Гэрлэлт цуцалснаас гэр бүлийн гишүүнд оногдох дундын эд хөрөнгийн хэсгийг тодорхойлоход гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал, хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс, түүнчлэн дундын эд хөрөнгөө зүй бусаар ашигласан, нуусан, гэрлэлт цуцалсан нь түүний буруутай үйлдлээс шалтгаалсан нь тогтоогдсон нөхцөлд шүүх Иргэний хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэнэ.

14.9.Шүүх гэрлэлт цуцалсан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсноос хойш ажлын гурван өдрийн дотор гэрлэлтийг бүртгэсэн иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад явуулна.

14.10.Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэд болон Монгол Улсын иргэн нь гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ хуульд харшлахгүй бол гэрлэлт цуцлуулсныг хүчинтэйд тооцно.

14.11.Гадаад улсад байнга оршин суугаа Монгол Улсын иргэн гэрлэлтээ Монгол Улсад захиргааны ба шүүхийн журмаар цуцлуулж болно.

15 дугаар зүйл. Гэрлэлт сэргээх

15.1.Гэрлэлтээ цуцлуулсан хүмүүс эвлэрснээ хамтран илэрхийлж өргөдөл гаргасан бөгөөд өөр хүнтэй гэрлээгүй бол гэрлэлтийг сэргээнэ.

15.2.Сураггүй алга болсонд тооцогдсон, нас барсан гэж зарлагдсан хүн эргэн ирж, нөхөр буюу эхнэртэйгээ хамтран амьдрах хүсэлтээ гаргасан бөгөөд нөхөр буюу эхнэр нь өөр хүнтэй гэрлээгүй бол иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага гэрлэлтийг сэргээж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох, түүний үр дагавар

16 дугаар зүйл. Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцох

16.1.Энэ хуулийн 9-д заасныг зөрчиж гэрлэсэн, гэр бүл болох зорилгогүйгээр гэрлэлт бүртгүүлсэн нь илэрсэн тохиолдолд гэрлэгчдийн хэн нэгний, эсхүл эрх нь зөрчигдсөн бусад хүний болон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын нэхэмжлэлээр шүүх гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

16.2.Иргэний хуульд заасны дагуу иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж зарлагдсан насанд хүрээгүй гэрлэгчийн ашиг сонирхлын үүднээс, эсхүл гэрлэлтээ хүчин төгөлдөр бус гэж тооцуулахыг зөвшөөрөөгүй бол шүүх нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож болно.

17 дугаар зүйл.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос үүсэх үр дагавар

17.1.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос үүссэн эд хөрөнгийн маргааныг Иргэний хуулийн эд хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөх заалтын дагуу шүүх шийдвэрлэнэ.

17.2.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон тохиолдолд гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ хүчин төгөлдөр бус байна.

17.3.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон нь энэ гэр бүлээс төрсөн хүүхдийн эрх, ашиг сонирхолд нөлөөлөхгүй.

17.4.Гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос гэрлэгчийн эрх, ашиг сонирхол хохирсон нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсөн тал өөрт учирсан материалын болон сэтгэл санааны хохирлыг буруутай этгээдээс Иргэний хуульд заасны дагуу гаргуулах эрхтэй.

18 дугаар зүйл.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох

18.1.Буслад учруулсан материалын хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс гэрлэлтээ хуурамчаар цуцлуулсан нь тогтоогдсон тохиолдолд шүүх гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

19 дүгээр зүйл.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос үүсэх үр дагавар

19.1.Гэрлэлт цуцлалт хүчин төгөлдөр бус гэж тооцогдвол гэрлэлтийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан тохиолдолд бусдад учирсан хохирлыг гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгөөс Иргэний хуульд заасан журмаар гаргуулах бөгөөд бусад асуудлыг энэ хууль болон холбогдох бусад хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааны зохицуулалт

20 дугаар зүйл.Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах

20.1.Гэр бүлийн эд хөрөнгийн харилцааг Иргэний хуулиар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаа

21 дүгээр зүйл.Эцэг, эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг үүсэх

21.1.Хүүхэд төрснөөр эцэг, эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ.

21.2.Хүүхдийг үрчлэн авснаар эцэг, эх, хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ.

21.3.Дагавар хүүхэд хойт эцэг, хойт эхийн хооронд эцэг, эх, хүүхдийн эрх, үүрэг үүснэ.

21.4.Хүүхдийн эцэг, эх нь гэрлэлтээ бүртгүүлсэн бол гэрлэлтийн гэрчилгээг, гэрлэлтээ бүртгүүлээгүй бол хуульд заасны дагуу захиргааны буюу шүүхийн журмаар эцэг, эхийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтоогдоно.

21.5.Гэрлэлтээ бүртгүүлээгүй хүмүүсийн дундаас төрсөн хүүхэд нь гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлээс төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

22 дугаар зүйл.Хүүхдийн эцэг, эхийг захиргааны журмаар тогтоох

22.1.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эх хамтарч, эсхүл хүүхдийн эцэг, эх болох нь тогтоогдоогүй эцэг буюу эх өөрөө өргөдөл гаргасан бол иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага эцэг, эхийг тогтооно.

23 дугаар зүйл.Хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтоох

23.1.Энэ хуулийн 22-т зааснаас бусад тохиолдолд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, төрөл, садангийн хүн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага буюу 14 нас хүрсэн хүүхдийн хэн нэгний өргөдлийг үндэслэн эцэг, эхийг шүүх тогтооно.

23.2.Эцэг, эхийг тогтооход хариуцагч хүүхдийн эцэг, эхтэй эр, эмийн харилцаатай байсныг нотлох баримт, эмнэлгийн шинжилгээ, бусад баримтыг үндэслэнэ.

23.3.Хүүхэд Монгол Улсын иргэн бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдолтой эцэг, эх тогтоох асуудлыг Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн дагуу шийдвэрлэнэ.

23.4.Гадаад улсын хуулиар Монгол Улсын иргэнтэй холбогдолтой эцэг, эх тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд тооцно.

23.5.Гадаад улсад оршин суух байгаа хүүхдийн эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын иргэн бол энэ хуулийн дагуу эцэг, эх тогтоолгох хүсэлтийг Монгол Улсын дипломат болон консулын байгууллагаар уламжлан тавьж болно.

24 дүгээр зүйл.Хүүхдийн нэр, эцгийн нэр, овог

24.1.Эцэг, эх тохиролцсоны үндсэн дээр хүүхэддээ нэр, овог өгнө.

24.2.Олдсон хүүхэд сум, дүүргийн Засаг дарга, эсхүл иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагын ажилтан нэр, овог өгч болно.

24.3.Хүүхэд эцгийн нэрийг авна.

24.4.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эхээс төрсөн, эсхүл хүүхдийн эцгийг тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэргүй бол хүүхэд эхийн нэрийг авна.

24.5.Үрчлэгдсэн хүүхэд үрчлэгчийн нэрийг авч болно.

24.6.Хүүхдэд нэр, овог өгөх, хүүхэд эцэг, эхийн нэр авахтай холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл.Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах

25.1.Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ.

25.2.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохыг хориглоно.

25.3.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаална.

25.4.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж байгаа нь тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилж болно.

25.5.Бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа эрх зүйн чадамжгүй гэж тооцогдон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан, удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран хламжлах бололцоогүй, эсхүл тэжээн тэтгэхээс зайлсхийсэн хүний хүүхдийн эрх, ашиг сонирхлыг сум, дүүргийн Засаг дарга хамгаална.

25.6.Энэ хуулийн 25.4, 25.5-д заасан хүүхдийн тухай мэдээллийг ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, эмнэлгийн байгууллагын холбогдох албан тушаалтан болон иргэн хүүхдийн оршин суугаа /оршин байгаа/ газрын сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй.

25.7.Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль[1]-ийн 2 дугаар зүйлд заасны дагуу цагдаагийн байгууллагаас шилжүүлсэн хүүхдийг хүлээн авсан хүүхдийн буюу харгалзан дэмжих байгууллага нь гурав хоногийн дотор энэ тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэх үүрэгтэй.

25.8.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 25.6, 25.7-д заасан хүүхдийн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш гурав хоногийн дотор хүүхдийн амьдралын нөхцөлийг судалж, эцэг, эх болон төрөл садангийн хүн байхгүй нь тогтоогдсон бол түүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ.

25.9.Сум, дүүргийн Засаг дарга нь хүнд нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлж, бүртгэл хөтлөн, түүнийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнд шилжүүлж болно.

25.10.Хүүхдийг энэ хуулийн 25.9-д заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол сум, дүүргийн Засаг дарга нь асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, үрчлүүлэх, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл.Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүрэг

26.1.Эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.

26.2.Эцэг, эх дарааҳ үүрэг хүлээнэ:

26.2.1.хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх;

26.2.2.хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх;

26.2.3. хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох;

26.2.4.хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах.

26.3.Эцэг, эх нь хүүхдийн эрүүл мэнд, сэтгэхүй, ёс суртахууны хүмүүжилд хохирол учруулах, хүүхэддээ хэрцгий хандах, эцэг, эх байх эрхээ зүй бусаар ашиглахыг хориглоно.

26.4.Эцэг, эх гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд энэ хуулийн 26.2-т заасан тэдгээрийн үүрэг хэвээр үлдэнэ.

[1] Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль-"Ардын эрх" сонины 1994 оны 140, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 10 дугаарт тус тус нийтлэгдсэн.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан тохиолдолд эцэг, эх үүгээ хэрэгжүүлэх журмыг тусгайлан тохиролцоогүй бол түүнийг шүүх тогтооно.

26.6.Хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшлахаарагүй бол гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хэн нэг нь нөгөөдөө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хоригдоно.

26.7.Хүүхдийн эцэг, эх нь эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан нь энэ хуулийн 26.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

26.8.Эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар хүүхдээсээ тусдаа амьдарч байгаа нөхцөлд энэ хуулийн 26.2-т заасан үүргээ хэрэгжүүлж байгаад нь харьяалах сум, дүүргэ, баг, хорооны Засаг дарга, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага хяналт тавина.

26.9.Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хохироосон эцэг, эх хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээж, энэ хуулийн 30.1.-д заасан үйлдлийг хийж, хүүхдээ бага наснаас нь өсгөн хүмүжүүлэгүй нь тогтоогдсон бол түхайн хүүхдийн эцэг, эхийн хувьд эдлэх эрхээ алдана.

27 дугаар зүйл.Эцэг, эх байх эрхийг хязгаарлах

27.1.Хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга санаатай гачигдуулсан, хөдөлмөрийг нь зүй бусаар ашигласан, гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан хүний эцэг, эх байх эрхийг зургаан сар хүртэл хугацаагаар шүүх хязгаарлаж болно.

27.2.Эцэг, эх байх эрхийг хязгаарлах тухай нэхэмжлэлийг эцэг буюу эх нь, эсхүл төрөл, садангийн хүн, бусад иргэн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага шүүхэд гаргах эрхтэй.

28 дугаар зүйл.Эцэг, эх байх эрх хязгаарласнаас үүсэх үр дагавар

28.1.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүн уг хүүхдийг биечлэн өсгөн хүмүүжүүлэх, төлөөлөх, хүүхэдтэй холбогдуулан хууль тогтоомжоор олгосон эрхээ алдана.

28.2.Шүүх нь эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүнээс хүүхдийг тэжээн тэтгэхэд шаардагдах тэтгэлгийг гаргуулах асуудлыг шийдвэрлэнэ.

28.3.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан бол хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлнэ.

28.4.Энэ хуулийн 28.3-т заасан тохиолдолд түүнтэй холбогдсон зардлыг түхайн эцэг, эхээс гаргуулах ба эцэг, эх нь төлбөрийн чадваргүй бол түүний оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг дарга хариуцаж болно.

28.5.Сум, дүүргийн Засаг дарга хохирлоо барууттай эгтэгдээр нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

28.6.Энэ хуулийн 27.1.-д заасан нөхцөл арилаагүй, эсхүл эцэг, эх нь хүүхдийнхээ эрх, ашиг сонирхлыг хохироож байгаа нь тогтоогдсон бол эцэг, эх байх эрхийг хязгаарласан тухай шүүхийн шийдвэр гарснаас хойш зургаан сарын дараа сум, дүүргийн Засаг дарга болон энэ хуулийн 27.2-т заасан этгээд тухайн хүний эцэг, эх байх эрхийг хасуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

28.7.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүний хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөхүгй хэвээр үлдэнэ.

29 дүгээр зүйл.Эцэг, эх байх эрх хязгаарласныг хүчингүй болсонд тооцох

29.1.Энэ хуулийн 27.1-д заасан нөхцөл арилсан нь тогтоогдсон бол эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүний хүсэлтийг шүүх хянан үзэж, хүүхдийг эцэг, эхэд нь буцааж өгөх тухай шийдвэр гаргаж болно.

29.2.Хүүхдийг эцэг, эхэд нь буцааж өгөх нь түүний эрх, ашиг сонирхолд харшлахаар байгаа бол шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож болно. Хэрэв хүүхэд долоон нас хүрсэн бол түүний саналыг харгалзан үзнэ.

30 дугаар зүйл.Эцэг, эх байх эрх хасах

30.1.Эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан /хүүхдээ хаях, саналтай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, бусийг нь үнэлэх, шунахай зорилгоор ашиглах, эрх зүйн зөрчилд татан оруулах зэргээр/, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан, сэтгэл санааны хүнд дарамтад байлгасан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатайгаар зайлсхийсэн, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүний эцэг, эх байх эрхийг шүүх хасаж болно.

30.2.Эцэг, эх байх эрх хасуулах тухай нэхэмжлэлийг эцэг буюу эх нь, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад иргэн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага тухайн эцэг, эхийн оршин суугаа газрын шүүхэд гаргах эрхтэй.

30.3.Эцэг, эх байх эрх хассан тухай шийдвэрийн хувийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын гурван өдрийн дотор шүүх иргэний гэр бүлийн бүртгэлийн төв байгууллагад явуулна.

31 дүгээр зүйл. Эцэг, эх байх эрх хассанаас үүсэх үр дагавар

31.1.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн уг хүүхдийн эцэг, эхийн хувьд эдлэх эрхээ алдана.

31.2. Шүүх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан хүнээс хүүхдийн төтгэлэг гаргуулах асуудлыг шийдвэрлэнэ.

31.3.Эцэг, эх нь хоёулаа эцэг, эх байх эрхээ хасуулсан бол уг хүүхдээд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох буюу, эсхүл түүнийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлнэ.

31.4.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөхгүй хэвээр үлдэнэ.

32 дугаар зүйл.Эцэг, эх байх эрхийг сэргээх

32.1.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний эцэг, эх байх эрхээ сэргээх тухай хүсэлтийг шүүх хянан үзэж, эцэг, эх байх эрхийг хүүхдийн эрх, ашиг сонирхлын үүднээс сэргээж болно.

32.2.Хүүхэд гүрчлэгдсэн бол эцэг, эх байх эрхийг сэргээхгүй.

32.3.Эцэг, эх байх эрх сэргээх нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшилж байгаа нь тогтоогдсон бол энэ хуулийн 30.1-д заасны дагуу эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний эцэг, эх байх эрхийг шүүх нь долоон нас хүрсэн хүүхдийн саналыг харгалзан сэргээхгүй байж болно.

33 дугаар зүйл. Хүүхдийн талаархи эцэг, эхийн эрхийг хамгаалах

33.1.Эцэг, эх нь хүүхдийг хууль бусаар авсан хүнээс хүүхдээ эргүүлж авахыг шаардах эрхтэй.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан асуудлаар маргаан гарсан тохиолдолд эцэг, эх нь эрхээ хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Тэжээн тэтгэх, тэтгүүлэхтэй холбогдсон харилцаа

34 дүгээр зүйл.Тэжээн тэтгүүлэх эрх

34.1.Тэжээн тэтгүүлэх хүн тэжээн тэтгүүлэх эрх үүссэн цагаас хойш хугацаа харгалзахгүй-гээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

35 дугаар зүйл.Тэжээн тэтгэх үүрэг

35.1.Гэрлэгчид бие биеэ, эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эхээ, төрөл, садангийн хүмүүс бие биеэ энэ хуульд заасны дагуу тэжээн тэтгэх үүрэгтэй.

36 дугаар зүйл.Гэрлэгчид харилцан бие биеэ тэжээн тэтгэх үүрэг

36.1.Гэрлэгчид харилцан бие биеэ тэжээн тэтгэх үүрэгтэй.

36.2.Гэрлэгчдийн хэн нэг нь бие биеэ тэжээн тэтгэх үүргээсээ татгалзсан, эсхүл тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулаагүй бол туслалцаа шаардлагатай болсон нөхөр, эхнэр тэжээн тэтгүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

37 дугаар зүйл.Гэрлэгчдийн тэжээн тэтгүүлэх эрх үргэлжлэх

37.1.Гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бус болсонд тооцогдохоос өмнө, эсхүл гэрлэлтээ цуцлуулснаас хойш нэг жилийн дотор хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлуулахаас өмнө бий.

болсон нөхцөл байдалтай шууд холбоотой үүссэн, гурван нас хүрээгүй болон тахир дутуу хүүхдээ асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлээгүй буюу гэрлэлтээ цуцлуулах үед тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эсхүл гэрлэлт цуцлуулахаас өмнө тэтгэвэрт гарсан бол салсан нөхөр буюу эхнэрээрээ тэжээн тэтгүүлэх эрхтэй.

38 дугаар зүйл.Эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх үүрэг

38.1.Эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй.

38.2.Эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулан тэтгэлэг тогтоож болно.

38.3.Эцэг, эх харилцан тохиролцож гэрээ байгуулаагүй бол тэтгэлгийг шүүх тогтооно.

38.4.Тэтгэлэг тогтоосон шийдвэрийн хувийг шүүх иргэний гэр бүлийн бүртгэлийн төв байгууллагад явуулна.

38.5.Тэтгэлгийг гагцхүү хүүхдийн хэрэгцээнд зарцуулна.

38.6.Тэтгэлэг хүүхдийн хэрэгцээнд зарцуулагдаагүй нь тогтоогдсон бол тэтгэлэг төлөгч түүнийг зориулалтаар нь зарцуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

38.7.Тэтгэлэг төлөгч өөр хүүхэдтэй бөгөөд тэдгээр нь тэтгэлэг авагчаас бага орлоготой, тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадвараа алдсан, эсхүл тэтгэлэг авагч хүүхэд өөрөө хангалттай орлоготой бол шүүх тэтгэлгийн хэмжээг багасгаж болно.

39 дүгээр зүйл.Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүүхдэд олгох тэтгэлэг

39.1.Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүүхдэд олгогдсон тэтгэлгийг тухайн байгууллагын дансанд шилжүүлж, 50 хувийг хүүхдийн ахуйн хэрэгцээнд зарцуулж, үлдсэн хувийг хүүхдийн нэр дээр хадгаламжийн дансанд шилжүүлнэ.

40 дүгээр зүйл.Тэтгэлгийн хэмжээ

40.1.Хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараахь хэмжээгээр тогтооно:

40.1.1. 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар;

40.1.2. 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр.

40.2.Зөвхөн цалин хөлсөөс өөр орлогогүй хариуцагчаас гаргуулах хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь түүний сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй.

40.3.Энэ хуулийн 40.2-т заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын жагсаалтыг Засгийн газар тогтооно.

40.4.Гэрлэгчид бие биеэ, түүнчлэн төрөл, садангийн хүнээ тэжээн тэтгэх тэтгэлэг нь тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн хэмжээнээс багагүй байна.

41 дүгээр зүйл.Тэтгэлэг олгох хэлбэр, хугацаа

41.1.Тэтгэлгийг дор дурдсан хэлбэрээр олгож болно:

41.1.1.мөнгөн хэлбэрээр;

41.1.2.эд хөрөнгөөр.

41.2.Тэтгэлгийг дараахь хугацаагаар олгож болно:

41.2.1.сар, улирал, хагас жил, жилээр;

41.2.2.нэг удаа.

41.3.Тэтгэлгийг хариуцагчийн цалин хөлсөөс суутгал хийх буюу хамтран өмчлөх эд хөрөнгөөс оногдох хэсгийг тодорхойлох үед болон бусад байдлаар олгож болно.

42 дугаар зүйл.Тэтгэлгийн хэмжээг өөрчлөх

42.1.Шүүхийн шийдвэрээр суутгах, эсхүл тэжээн тэтгэх гэрээний дагуу төлөх хүүхдийн тэтгэлгийн хэмжээ нь тэтгэлэг төлөгчийн цалин хөлсний 50 хувиас хэтэрсэн буюу шүүхээр өөр тэтгүүлэгчид тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэсэн бол тэтгэлэг төлөгч тэтгэлгийн хэмжээг өөрчлөн тогтоолгохоор шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

43 дугаар зүйл.Насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай хүүхдийн эцэг, эхээ тэжээн тэтгэх үүрэг

43.1.Хөдөлмөрийн чадвартай хүүхэд нь төрүүлсэн, үрчлэн авсан хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, хойт эцэг, хойт эхээ тэжээн тэтгэх үүрэгтэй.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан хүнийг тэжээн тэтгэх үүрэг бүхий хэд хэдэн хариуцагч байвал шүүх тэдний эд хөрөнгийн болон гэр бүлийн байдлыг харгалзан үзэж, тэтгэлгийн хувь, хэмжээг хүн тус бүрт ногдуулан тогтоож болно.

44 дүгээр зүйл.Төрөл, садангийн хүний тэжээн тэтгэх үүрэг

44.1.Насанд хүрээгүй бүтэн өнчин, эсхүл эцэг, эхээрээ тэжээн тэтгүүлэх боломжгүй хүүхдийг хөдөлмөрийн чадвартай төрсөн, үрчлэн авсан ах, эгч, дүү, өвөг эцэг, эмэг эх, хойт эцэг, хойт эх нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

44.2.Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээрээ тэжээн тэтгүүлэх боломжгүй, хөдөлмөрийн чадваргүй өвөг эцэг, эмэг эхээ хөдөлмөрийн чадвартай ач, зээ нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

44.3.Өөр тэжээн тэтгэх хүнгүй бол төрөл, садангийн хүмүүс бие биеэ хөдөлмөрийн чадваргүй үед нь тэжээн тэтгэх үүрэгтэй.

44.4.Энэ зүйлд заасан тэтгэлгийн хэмжээг талууд харилцан тохиролцоогүй тохиолдолд шүүх энэ хуулийн 40.4-ыг үндэслэн тогтооно.

45 дугаар зүйл.Тэжээн тэтгэх тухай гэрээ

45.1.Талууд тэжээн тэтгэх тухай гэрээг бичгээр үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байна.

45.2.Тэжээн тэтгэх тухай гэрээг сайн дураар биелүүлэхгүй байгаа тохиолдолд тэдний хэн нэгний хүсэлтээр шүүгч захирамж гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар биелүүлнэ.

45.3.Тэжээн тэтгэх тухай гэрээний дагуу тогтоох тэтгэлгийн хэмжээ нь энэ хуулийн 40.4-т заасан хэмжээнээс багагүй байна.

45.4.Тэжээн тэтгэх тухай гэрээний дагуу тогтоох тэтгэлгийн хэлбэр, хугацаа нь энэ хуулийн 41 дүгээр зүйлд заасантай адил байна.

45.5.Тэтгэлгийг эд хөрөнгөөр олгохоор талууд харилцан тохиролцон бол эд хөрөнгийг орон нутгийн зах зээлийн тухайн үеийн ханшаар үнэлнэ.

46 дугаар зүйл.Тэжээн тэтгэх тухай гэрээг өөрчлөх, цуцлах

46.1.Тэжээн тэтгэх тухай гэрээг талуудын харилцан тохиролцсоноор өөрчилж, цуцалж болно.

46.2.Тэжээн тэтгэх тухай гэрээг өөрчлөх, цуцлах тухай тохиролцоог үндэсн гэрээтэй адил хэлбэрээр хийнэ.

46.3.Тэжээн тэтгэх тухай гэрээг өөрчлөх, цуцлах тухай асуудлаар гарсан маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

47 дугаар зүйл.Тэжээн тэтгэх тухай гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох

47.1.Хүчин төгөлдөр бус тэжээн тэтгэх гэрээ, тэжээн тэтгэх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай асуудлыг Иргэний хуулийн холбогдох заалтаар зохицуулна.

47.2.Тэжээн тэтгүүлэгчийн эрх, ашиг сонирхол хохирсоноос тэжээн тэтгэх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай нэхэмжлэлийг түүний эцэг, эх, гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага гаргаж болно.

48 дугаар зүйл.Хариуцагчаас нэмэлт зардал гаргуулах

48.1.Тэжээн тэтгүүлэгчид онцгой нөхцөл байдал тохиолдсон /хүндэвр өвчилсөн, тахир дутуу болсон, эмчлүүлсэн, сургуульд орсон гэх мэт/ үед түүнд нэмэлт тэтгэлэг гаргуулах, эсхүл гарсан зардлыг хариуцуулахаар энэ хуулийн 47.2-т заасан этгээд шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

49 дүгээр зүйл.Тэтгэлэг нөхөн гаргуулах

49.1.Тэтгэлэг төлөгч тэтгэлэг төлөхөөс санаатай зайлсхийсэн, цалин хөлс, бусад орлогоо нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол шүүх тэжээн тэтгүүлэгч, бусад иргэн, холбогдох байгууллагын нэхэмжлэлийг үндэслэн төлөгдөөгүй тэтгэлгийг нөхөн төлүүлж болно.

49.2.Тэтгэлэг нөхөн төлүүлэхэд тэтгэлэг төлөгч хөдөлмөр эрхлэгчий буюу цалин хөлс, бусад орлогын хэмжээг тогтоох боломжгүй бол тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтална.

49.3.Тэтгэлэг төлөгч хөдөлмөрийн чадваргүй болсон тохиолдолд тухайн хугацааны тэтгэлгийн хэсгийг буюу бүхэлд нь нөхөн төлүүлэхээс шүүх чөлөөлж болно.

50 дугаар зүйл.Тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүйгээс хүлээх хариуцлага

50.1.Тэтгэлэг төлөх тухай талууд гэрээ байгуулсан бөгөөд тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол учирсан хохирлыг гэрээнд заасан журмаар нөхөн төлнө.

50.2.Шүүхийн шийдвэрээр тогтоосон тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүй бол хожимдуулсан хоног тутамд тогтоосон тэтгэлгийн үнийн дүнгийн 0,5 хувиар алданги төлнө.

50.3.Алдангийн нийт хэмжээ төлөгдөөгүй тэтгэлгийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

50.4.Тэтгэлгийг хугацаанд нь төлөөгүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх талаар гэрээнд заагаагүй бол энэ хуулийн 50.2, 50.3-т заасныг баримтална.

51 дүгээр зүйл.Тэтгэлгийг эд хөрөнгөөс гаргуулах

51.1.Тэтгэлэг төлөгчийн мөнгөн хадгаламж болон бусад эд хөрөнгөөс тэтгэлэг гаргуулахдаа Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль[1]-ийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

52 дугаар зүйл.Тэжээн тэтгэх үүрэгээс чөлөөлөх

52.1.Шүүх дор дурдсан тохиолдолд тэжээн тэтгэх үүрэгээс чөлөөлж болно:

52.1.1.тэтгүүлэгч нь согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэсэн, санаатайгаар биедээ гэмтэл учруулснаас

52.1.2. эцэг, эх, хойт эцэг, хойт эх нь эцэг, эх байх эрхээ хасуулсан бол хүүхдийг.

53 дугаар зүйл.Тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болох

53.1.Дор дурдсан тохиолдолд тэжээн тэтгэх үүрэг дуусгавар болно:

53.1.1.тэжээн тэтгэх тухай гэрээний хугацаа дууссан;

53.1.2.тэтгүүлэгч гэрлэсэн, хөдөлмөрийн чадвартай болсон;

53.1.3.тэтгүүлэгч хүүхэд бусдад үрчлэгдсэн, 18 нас хүрсэн;

53.1.4.тэтгэгч, эсхүл тэтгүүлэгч нас барсан.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Хүүхэд үрчлэх

54 дүгээр зүйл.Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх

54.1.Хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс үрчлүүлнэ.

54.2.Хүүхдийг энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмын дагуу гадаадын иргэнд үрчлүүлж болно.

55 дугаар зүйл.Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий нөхцөл

55.1.Хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл болон хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг бичгээр гаргаж, нотариатаар, гэрчлүүлсэн байна.

55.2.Гэрлэгчдийн хэн нэг нь хүүхэд үрчлэн авч байгаа бол энэ тухай зөвшөөрлийг эхнэр буюу нөхрөөсөө авна.

55.3.Бүтэн өнчин хүүхэд, түүнчлэн эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй бол хүүхдийг нь үрчлүүлэх тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн хүүхдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын зөвшөөрлийг авна.

---

[1] Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль-"Ардын эрх" сонины 1996 оны 248, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1997 оны 1 дугаарт тус тус нийтлэгдсэн.

55.4.Долоон нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авна.

55.5.Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг энэ тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дараа үрчлүүлж болно.

55.6.Үрчлэн авахыг хүсэгч нь хүүхдийн оршин суугаа сум, дүүргийн Засаг даргад хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ гаргана.

55.7.Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан ,үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана.

55.8.Хүүхэд үрчилсэн тухай шийдвэрийг үндэслэн иргэний гэр бүлийн бүртгэлийн ажилтан хүүхэд үрчилснийг бүртгэнэ.

56 дугаар зүйл.Хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн бүртгэл, хяналт

56.1.Сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн хэмжээн дэх хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн судалгаа гаргаж, бүртгэл хөтөлнө.

56.2.Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн нэгдсэн бүртгэл хөтөлж, хяналт тавина.

57 дугаар зүйл.Үрчлэгч

57.1.Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой хүн байна.

57.2.60-аас дээш настай, эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, урьд нь үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцаан өгсөн, ашиг хонжоо олох зорилготой, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, сүрьеэ, сэтгэцийн өвчтэй, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн болон хорих ял эдэлж байгаа хүнд хүүхэд үрчлүүлэхийг хоригломо.

57.3.Бүтэн өнчин хүүхдийг төрөл, саданг үйн хүн нь үрчлэн авахад энэ хуулийн 57.2-т заасан насны хязгаарлалт үл хамаарна.

58 дугаар зүйл.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах

58.1.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана.

58.2.Монгол Улсад зургаан сараас доошгүй хугацаанд оршин суух байгаа гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авахад энэ хуулийн 58.1 хамаарахгүй.

58.3.Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч гадаадын иргэн нь энэ хуулийн 55.1, 55.3-т заасан зөвшөөрлөөс гадна дор дурдсан бичиг баримт бүрдүүлнэ:

58.3.1.хүүхэд үрчлэн авахыг хүсэгчийн /нөхөр, эхнэртэй бол хамтаруг гаргасан/ хүсэлт, түүний нотариатаар гэрчлүүлсэн албан ёсны орчуулга;

58.3.2.үрчлэгч нь сүрьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй эсэх талаархи эмнэлгийн магадлагаа;

58.3.3.өргөдөл гаргагчийн гэрлэлтийн гэрчилгээний хуулбар /гэр булгэй бол/;

58.3.4.өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрын талаар холбогдох байгууллагын тодорхойлолт /цагдаагийн байгууллагын тодорхойлолт хамаарна/;

58.3.5.өргөдөл гаргагчийн амьдралын болон санхүүгийн боломжийн тухай тухайн улсын холбогдох байгууллагын тодорхойлолт;

58.3.6.өргөдөл гаргагчийн талаархи хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлолт.

58.4.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авсныг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль[1]-ийн 11[1] дүгээр зүйлд заасан байгууллага бүртгэнэ.

58.5.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтийг Монгол Улсын дипломат болон консулын байгууллагаар уламжлан энэ хуулийн дагуу шийдвэрлэхэд энэ хуулийн 58.1 хамаарахгүй.

58.6.Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлтэй гадаадын

[1] Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль- "Ардын эрх" сонины 1994 оны 7, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 2 дугаарт тус тус нийтлэгдсэн.

иргэний бүртгэл хөтөлж, хүүхдийг үрчлэх, үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар бусад улс, тэдгээрийн холбогдох байгуулагатай хамтран ажиллана.

58.7.Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журмыг хууль зүйн болон эрүүл мэнд, нийгмийн хамгаллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд хамтран тогтооно.

58.8.Хүүхдийнхээ эх орон, эцэг, эхийг нь мэдүүлэх үүргийг үрчлэн авсан эцэг, эх нь хүлээнэ.

58.9.Үрчлэгдсэн хүүхэд харьяатаа сонгох эрхийг Харьяатын тухай Монгол Улсын хууль[1]-д заасны дагуу эдэлнэ.

58.10.Энэ зүйл нь харьяалагүй хүнд нэгэн адил хамаарна.

59 дүгээр зүйл.Үрчлэгдсэн хүүхэд, үрчлэн авсан эцэг, эхийн эрх, үүрэг

59.1.Үрчлэгдсэн хүүхэд нь төрсөн хүүхдийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

59.2.Үрчлэн авсан эцэг, эх нь төрсөн эцэг, эхийн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

59.3.Үрчлэгдсэн хүүхэд нь үрчлүүлсэн эцэг, эхээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөж, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхээ алдана.

59.4.Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг үрчлэгдсэн хүүхэд нь уг тэтгэвэр авах эрхээ хэвээр эдэлнэ.

60 дугаар зүйл.Үрчлэлтийн нууц

60.1.Үрчлэлтийн нууцыг мэдэж байгаа албан тушаалтан, бусад этгээд түүнийг хадгалах үүрэгтэй.

60.2.Үрчлэгч болон үрчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр үрчлэлтийн нууцыг задруулсан бол хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

61 дүгээр зүйл.Үрчлэлтийг хүчингүйд тооцох

61.1.Үрчлэгч нь эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэй хэрцгий харьсан, хуурамч бичиг баримт бүрдүүлэн үрчлэн авах шийдвэр гаргуулсан, энэ хуулийн 57.2-т заасан этгээд болох нь илэрсэн тохиолдолд төрүүлсэн эцэг, эх, сонирхогч бусад этгээд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн өөрийн нэхэмжлэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцно.

61.2.Шаардлагатай гэж үзвэл бусад үндэслэлээр шүүх үрчлэлтийг хүчингүйд тооцож болно.

62 дугаар зүйл. Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавар

62.1.Үрчлэлтийг хүчингүйд тооцсон тохиолдолд хүүхдийг төрүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь бүцаах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

62.2.Хүүхдийг эцэг, эхэд нь бүцааж өгөх нь хүүхдийн эрх, ашиг сонирхолд хохиролтой нь тогтоогдсон, эсхүл хууль ёсны өөр төлөөлөгч байхгүй бол түүнийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.

62.3.Хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэхтэй холбогдсон зардлыг үрчлэгчээс гаргуулж, үчирсан гэм хорыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх

63 дугаар зүйл.Асран хамгаалалтад байх хүн

63.1.Дараахь хүнийг асран хамгаална:

63.1.1.бага насны /14 нас хүрээгүй/ бүтэн өнчин хүүхэд;

63.1.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний бага насны хүүхэд;

63.1.3.эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа, хорих газарт ял эдэлж байгаа зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран халамжлах бололцоогүй хүний бага насны хүүхэд;

63.1.4.сэтгэцийн өвчний улмаас шүүхээс иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон хүн.

63.2.Бүтэн өнчин ах, эгч, дүү нарт нэг асран хамгаалагч тогтоож болно.

[1] Харьяатын тухай Монгол Улсын хууль- "Ардын эрх" сонины 1995 оны 139, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 10-11 дугаарт тус тус нийтлэгдсэн.

64 дүгээр зүйл.Харгалзан дэмжвэл зохих хүн

64.1.Дараахь хүнийг харгалзан дэмжинэ:

64.1.1.насанд хүрээгүй /14-өөс 18 хүртэлх насны/ бүтэн өнчин хүүхэд;

64.1.2.эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон болон эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүний насанд хүрээгүй хүүхэд;

64.1.3.эцэг, эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлж байгаа буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх, асран хамгамлах боломжоогүй хүний насанд хүрээгүй хүүхэд;

64.1.4.согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэснийг улмаас иргэний эрх зүйн эрхийн хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүн;

64.1.5.эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон хүн.

65 дугаар зүйл.Асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа хүний эрх

65.1.Асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа хүн дараахь эрх эдэлнэ:

65.1.1.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гэр бүлд амьдрах;

65.1.2.сурч боловсрох нөхцлөөр хангуулах, эсэн мэнд амьдрах;

65.1.3.нийгмийн даатгалын болон халамжийн төтгөвөр, төтгөмж авах;

65.1.4.орон сууцандаа амьдрах эрхээ хэвээр хадгалах;

65.1.5.хууль тогтоомжид заасан бусад эрх.

66 дугаар зүйл.Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага

66.1.Энэ хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасан хүнийг судлан тогтоох, түүнд хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх үүргийг сум, дүүргийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

66.2.Хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй, эрүүл мэндийн байдал, өндөр настай болсны улмаас эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлж чадахгүй болсон асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн асрамжид байсан хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага, асран хүмүүжүүлэгчид шилжүүлсэн хүүхдийг нийгмийн халамжийн байгууллага асран хамгаалж, харгалзан дэмжинэ.

66.3.Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад болон асран хүмүүжүүлэгчид шилжсэн хүүхэд, нийгмийн халамжийн байгууллагад шилжсэн хүний эд хөрөнгийг шүүх эрхлэн хамгаалагчид хариуцуулна.

67 дугаар зүйл.Асран хамгаалах, харгалзан дэмжих

67.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дор дурдсан жүрмаар тогтооно:

67.1.1.эд хөрөнгийн зохих болоцоотой төрөл, садан буюу төрөл, садан бус хүний бичгээр гаргаж, нотариатаар гэрчлүүлсэн зөвшөөрлийг нь үндэслэн сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоох;

67.1.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол хүүхдийг нас, эрүүл мэндийн байдлыг нь харгалзан хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх;

67.1.3.харгалзан дэмжигч тогтоогдоогүй бол өндөр настан, тахир дутуу хүнийг асрамжийн газарт шилжүүлэх;

67.1.4.сэтгэцийн өвчний улмаас иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүнийг сэтгэл мэдрэлийн эмнэлэгт болон холбогдох байгууллагад шилжүүлэх.

67.2.Тухайн хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай байгаа тухай мэдээллийг аливаа байгууллага, иргэн холбогдох сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй.

67.3.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг асран хамгаалж, харгалзан дэмжихэд энэ хуулийг дагаж мөрдөнө.

67.4.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэнд тухайн улсын хуулиар асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон нь энэ хуульд харшлаагүй бол хүчинтэйд тооцно.

67.5.Асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаанд үнэ төлбөргүй гүйцэтгэнэ.

68 дугаар зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоож болохгүй хүн

68.1.Дор дурдсан хүнийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоохыг хоригломо:

68.1.1.эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан;

68.1.2.өөрөө асран хамгаалуулж, харгалзан дэмжүүлж байгаа;

68.1.3.мансууруулах бодис, согтуурууддаг ундаа байнга хэрэглэдэг;

68.1.4.хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн;

68.1.5.үрчлэн авсан хүүхдээ өөрийн бууруугаас буцаан өгсөн.

69 дүгээр зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг

69.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь дараахь үүрэг хүлээнэ:

69.1.1.асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг хоол, хүнс, орон сууцаар хангах, асран сувилах;

69.1.2.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

69.1.3.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, үнэт цаас, бусад баримт бичгийг банкинд хадгалуулах;

69.1.4.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний үл хөдлөх эд хөрөнгө, мал, банкинд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрт нь зориулан захиран зарцуулах, орон сууц хөлслөх гэрээг цуцлах, асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоохдоо тухайн сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авах;

69.1.5.хүүхэдээн үүргийнхээ талаар тухайн сум, дүүргийн Засаг даргад жил бүр тайлагнах.

69.2.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь энэ зүйлд заасан үүргээ биелүүлэхдээ асрамж, дэмжлэгтээ байгаа /бага насны хүүхэд, сэтгэцийн өвчтэйгээс бусад/ хүний саналыг харгалзана.

70 дугаар зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хориглох зүйл

70.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч дараахь үйлдэл хийхийг хориглоно:

70.1.1.асрамж, дэмжлэгтээ байгаа хүнтэй хэлцэл хийх;

70.1.2.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүнтэй хэлцэл хийх;

70.1.3.асрамж, дэмжлэгтээ байгаа хүн болон өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүний хооронд үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлэхэд уг хүнийг төлөөлөх;

70.1.4.асрамж, дэмжлэгтээ байгаа хүний үл хөдлөх эд хөрөнгө, мал, мөнгөн хадгаламж, үнэт цаас, үнэт зүйлийг бэлэглэх, өөрт нь зориулахаас бусад тохиолдолд худалдах, арилжих, барьцаалах, дэнчин тавих болон бусад хэлбэрээр захиран зарцуулах;

70.1.5.сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрөлгүйгээр орон сууц хөлслөх гэрээг цуцлах, асрамж, дэмжлэгтээ байгаа хүний нэрийн өмнөөс шинээр аж ахуй эрхлэх, эрхэлж байгаа аж ахуйн ажлыг зогсоох.

71 дүгээр зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагааны талаар Засаг даргын эдлэх эрх

71.1.Сум, дүүргийн Засаг дарга асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагааны талаар дараахь эрх эдэлнэ:

71.1.1.асран хамгаалах, харгалзан дэмжвэл зохих хүний талаарх мэдээллийг хүлээн авч, нөхцөл байдлыг судалсны үндэсэн дээр холбогдох материал бүрдүүлж асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоох, өөрчлөх тухай шийдвэр гаргах;

71.1.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад, өндөр настан, тахир дутуу хүнийг асрамжийн газарт шилжүүлэх шийдвэр гаргах.

71.1.3.асрамж, дэмжлэгт байгаа хүн нэг бүрт хувийн хэрэг нээж хөтлөх;

71.1.4.хувийн хэрэгт асрамж, дэмжлэг тогтоосон тухай шийдвэр, эрүүл мэндийн талаархи эмнэлгийн байгууллагын магадлагаа, төрсний гэрчилгээ, эсхүл нас тогтоосон баримт бичиг, оршин суугаа газрын хаяг, төрөл, садангийн хүний тухай мэдээлэл, эд хөрөнгийн жагсаалт, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хийсэн гэрээ болон шаардлагатай бусад материалыг хавсаргах;

71.1.5.асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй гэрээ байгуулж, биелэлтийг нь шалгах;

71.1.6.асрамж, дэмжлэгт байгаа хүний эрх, ашиг сонирхолд хохирол учирч болзошгүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс тодорхой хэлцэл хийхийг хориглох;

71.1.7.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн бууруатай үйл ажиллагаанаас асрамж, дэмжлэгт байгаа хүний эд хөрөнгөд хохирол учирсан нөхцөлд хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах.

72 дугаар зүйл.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаэнд хяналт тавих

72.1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд сум, дүүргийн Засаг дарга дор дурдсан жүрмаар хяналт тавина:

72.1.1.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдсон баримт бичгээ танилцах;

72.1.2.асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн мэдэлд байгаа эд хөрөнгийн данс бүртгэлийг гаргуулж, түүний бүрэн бүтэн байдал, асрамж, дэмжлэгт байгаа хүний нэрийн өмнөөс эрхэлж буй аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцлийг шалгах.

72.2.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаатай холбогдуулан аливаа байгууллага, иргэн нь сум, дүүргийн Засаг даргад гомдол гаргах, мэдээлэл өгөх эрхтэй.

73 дугаар зүйл.Асран хамгаалах, харгалзан дэмжих эрх, үүрэг даусгавар болох

73.1.Асран хамгаалуулж байгаа хүүхэд 14 нас хүрмэгц асран хамгаалагч нь харгалзан дэмжигчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

73.2.Дараахь тохиолдолд асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг даусгавар болно:

73.2.1.асран хамгаалах, харгалзан дэмжих нөхцөл арилж, хүүхдийг эцэг, эхэд нь буцаасан;

73.2.2.хүүхдийг үрчлүүлсэн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлсэн;

73.2.3.харгалзан дэмжүүлэгч насанд хүрсэн;

73.2.4.асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан;

73.2.5.шүүхийн шийдвэрээр харгалзан дэмжүүлэгчийг иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай гэж тооцсон;

73.2.6.асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсүүл асрамж, дэмжлэгт байгаа хүн сураггүй алга болсон буюу нас барсанд тооцогдсон, нас барсан.

73.3.Асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь эрхээ урвуулан ашигласан, үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас асрамж, дэмжлэгтээ байгаа хүнийг харааг хяналтгүй, эсүүл шаардлагатай тусламж үзүүлээгүй орхисон бол шүүх асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүй болгож, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг шинээр тогтоох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэнэ.

73.4.Асран хамгаалах, харгалзан дэмжих үүргээс чөлөөлөгдсөн, эсүүл үг эрх, үүрэг дуусгавар болсон тохиолдолд асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь асрамж, дэмжлэгтээ байсан хүний эд хөрөнгийн талаархи тайлан тооцоог гурван сарын дотор сум, дүүргийн Засаг даргад гарган өгч, эд хөрөнгийг өөрт нь буюу хууль ёсны төлөөлөгч, өв залгамжлагчид шилжүүлнэ.

74 дүгээр зүйл.Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа

74.1.Хүнд нөхцөлд байгаа бага насны буюу насанд хүрээгүй хүүхдийг иргэн гэр бүлдээ авч, өөрийн зардлаар асран хүмүүжүүлж /цаашид "асран хүмүүжүүлэх" гэх/ болно.

74.2.Хүүхдийг асран хүмүүжүүлэхдээ нийгмийн халамжийн байгууллага болон асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэний хооронд төдөрхой хугацаагаар гэрээ байгуулна.

74.3.Хүүхэд асран хүмүүжүүлэх тухай гэрээнд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгох нөхцөл, асран хүмүүжүүлэгчийн болон нийгмийн халамжийн байгууллагын эрх, үүрэг, асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад көнгөлөлт, гэрээ дуусгавар болох үндэслэл, үр дагаврыг заана.

74.4.Хүүхдийг асран хүмүүжүүлэхэд тухайн гэр бүлд тааламжгүй нөхцөл буй болсон нь тогтоогдсон, эцэг, эхэд нь бүцаан өгсөн, үрчлүүлсэн бол нийгмийн халамжийн байгууллагын шаардлагаар, хүндэтгэн үзэх бусад шалтгаан /өвчилсөн, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдал өөрчлөгдсөн, харилцан үл ойлголцох, маргаантай байдал/ буй болсон бол асран хүмүүжүүлэгчийн саналчилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.

74.5.Асран хүмүүжүүлэхээр шилжүүлэхдээ долоон нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авна.

74.6.Асран хүмүүжүүлэхээр шилжүүлсэн хүүхэд тэжээгчээ алдсаны болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авах, хууль тогтоомжийн дагуу орон сууцаар хангагдах эрх эдэлнэ.

74.7.Энэ хуулийн 74.3-т зааснаар асран хүмүүжүүлэгчид олгох урамшууллыг шаардагдах зардлыг Нийгмийн халамжийн тухай хууль[1]-д заасны дагуу нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.

74.8.Энэ хуулийн 66.2-т заасны дагуу нийгмийн халамжийн байгууллага асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хувиар асран хүмүүжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавина.

75 дугаар зүйл.Асран хүмүүжүүлэх гэрээ байгуулж болохгүй хүн

75.1.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан, асран хүмүүжүүлж байсан буюу үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас бусаан өгсөн, шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон, согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг, эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлж байсан болон хорих ял эдлэж байгаа хүнтэй асран хүмүүжүүлэх гэрээ байгуулахыг хоригломо.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

76 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

76.1.Энэ хуулийг 1999 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын 1973 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн тогтоолоор батална Гэр бүлийн хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн Гэр бүлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ГАНБОЛД

---

[1] Нийгмийн халамжийн тухай хууль-"Ардын эрх" сонины 1998 оны 287, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1998 оны 12 дугаарт тус тус нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуульд дор дурдсан агуулгатай 97 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 98 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 168[1] дүгээр зүйл, 392 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг тус тус нэмсүгэй:

1/97 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Гэрлэснээс хойш гэр бүлийн гишүүний хэн нэг нь эд хөрөнгө дур мэдэн бусдад шилжүүлсэн, олсон ашиг орлогоо санаатайгаар нуун дарагдуулсан нь тогтоогдсон бол эрх нь зөрчигдсөн гэр бүлийн гишүүн зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр шүүхэд гомдол гаргах эрхтэй."

2/ 98 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

"7.Бусдад учруулсан материалын хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс, олсон ашиг орлогоо гэр бүлийн бусад гишүүдийн хувааарьт эд хөрөнгөд, эсхүл хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд шилжүүлсэн нь нотлогдсон бол тэр хэмжээгээр уг эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулж болно."

3/168[1] дүгээр зүйл:

"168[1] дүгээр зүйл.Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ

1.Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээгээр гэрлэгчдээс гэр бүлийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэгчдийн хэн нэг нь нас барсан, эсхүл гэрлэлтийг цуцалсан тохиолдолд нөгдох эд хөрөнгийг энэ хуулийн гэр бүлийн эд хөрөнгийн тухай зохицуулалтын хүрээнд тодорхойлно.

2.Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээнд эд хөрөнгийн бус харилцааг зохицуулах, гэрлэгчдийн хэн нэгний эрхийн чадамж, хөдөлмөрийн чадваргүй, туслалцаа шаардлагатай талын эрхийг хязгаарлах, түүний эрх, ашиг сонирхолд харшлах нөхцөлийг тусгахыг хориглоно.

3.Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээг зөвхөн гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө байгуулж болно.

4.Гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ гэрлэлт бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5.Талууд гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлнэ. Энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

4/ 392 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"3.Өмнөх гэрлэлт хүчинтэй байхад дахин гэрлэлтээ бүртгүүлсэн, эхнэр, эсхүл нөхөр, хүүхэд, гэр бүлийн бусад гишүүнийг байнга хүчирхийлсэн, гэрлэгч болон гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлийг илтэд дорөмжилсон иргэн эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөн буюу бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ.

4.Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэм хорыг арилгах хэмжээг үйлдлийн шинж чанар, нөхцөл байдал, хохирогчид учирсан сэтгэл санааны үр дагавар зэргийг харгалзан Захиргааны хариуцлагын тухай болон Эрүүгийн хуульд заасан торгуулийн хэмжээнд багтаан мөнгөөр тооцож тогтоно."

2 дугаар зүйл.Иргэний хуулийн 97 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "нэмэгдсэн бол" гэсний дараа "түүнчлэн анх гэр бүл болоход нь зориулагдсан орон сууцыг"; 377 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "нэр хүнд" гэсний дараа "гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг хохироосон" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний хуулийн 7 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"7 дугаар зүйл.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах

1.Иргэн, хуулийн этгээд өөрийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ гутаагдсан гэж үзвэл уг мэдээ няцаалгах, иймхүү гутаагдсанаас учирсан гэм хорыг арилгуулах, гэрлэгч өөрийн эрх, ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзвэл түүнээс учирсан эд хөрөнгийн бус гэм хорыг арилгуулахыг тус тус шаардах эрхтэй.

2.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан

мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг, гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөн этгээд буруугүй болохоо нотолж чадахгүй бол учирсан гэм хорыг арилгах үүрэгтэй.

3.Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас болон гэрлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчсөнөөс учирсан гэм хорын хэмжээ, арилгах аргыг энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх тодорхойлно."

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 7.1.3; 7.2.6; 34.4.6 дахь заалт тус тус нэмсүгэй:

1/7.1.3:

"7.1.3.хүүхэд асран хүмүүжүүлэх зорилго бүхий төрийн бус байгууллагаас хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгохтой холбогдон гаргасан зарим зардал;"

2/7.2.6:

"7.2.6.хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлээс авч асран хүмүүжүүлсэн иргэнд үзүүлэх урамшууллын зардал;"

3/34.4.6:

"34.4.6.хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлээс авч асран хүмүүжүүлсэн иргэн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх зорилго бүхий төрийн бус байгууллагатай гэрээ байгуулах, асран хүмүүжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээг цуцлах;"

2 дугаар зүйл.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2, 3.1.6-ын "бүтэн өнчин" гэснийг "хүнд нөхцөлд байгаа"; "7.1.3"-ыг "7.1.4"; "7.2.6"-г "7.2.7"; "34.4.6; 34.4.7; 34.4.8"-ыг "34.4.7; 34.4.8; 34.4.9" гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д. ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 9 дэх заалтын "хүн ам зүй," гэсний дараа "гэр бүл," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай 134 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 135[1],135[2] дугаар зүйл, 136 дугаар зүйлийн 8,9,10,11 дэх заалт 147[1], 147[2] дугаар зүйл тус тус нэмсүгэй:

1/134 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэр бүлийн байгүйн хүчирхийлэлд байгаа тохиолдолд эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцалж болно."

2/135[1] дүгээр зүйл:

"135[1] дүгээр зүйл.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай нэхэмжлэл гаргах

1.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай нэхэмжлэлийг зохигчдын хэн нэгний нь оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2.Нэхэмжлэлд гэрлэлт цуцлалтыг ямар үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай бичиж, холбогдох нотлох баримтыг хавсаргана."

3/135[2] дугаар зүйл:

"135[2] дугаар зүйл. Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай хэргийг хэлэлцэх

1.Гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай хэргийг хэлэлцэхдээ зохигчид, зохигчдын төлөөлөгч буюу өмгөөлөгчийг шүүх хуралдаанд оролцуулна.

2.Талуудын хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.

3.Шүүх нэхэмжлэлийг хангавал гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох тухай шийдвэр гаргана."

4/136 дугаар зүйлийн 8,9,10,11 дэх заалт:

"8/хүүхдийн эцэг, эхийг тогтоох тухай;

9/эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх тухай;

10/хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох тухай;

11/асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосныг хүчингүйд тооцох тухай."

5/147[1] дүгээр зүйл:

"147[1] дүгээр зүйл. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлт гаргах, хэргийг хэлэлцэх

1.Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтгийг хүүхдийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2.Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтэд энэ тухай шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

3.Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох тухай хэргийг хэлэлцэхдээ үрчлүүлэгч, үрчлэн авагч талуудыг шүүх хуралдаанд оролцуулна.

4.Талуудын хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгааналр ирээгүй бол шүүх хуралдааныг хойшлуулна.

5.Зохигчдын төлөөлөгч, өмгөөлөгч болон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

6.Шүүх нэхэмжлэлийг хангавал хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцох тухай шийдвэр гаргана.

7.Шүүх энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан шийдвэр гаргахдаа хүүхдийг төрүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хууль ёсны төлөөлөгч байхгүй бол хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэхийг шийдвэрлэж, учирсан гэм хорыг нөхөн төлүүлэхээр тогтооно."

6/147[2] дугаар зүйл:

"147[2] дугаар зүйл. Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлт гаргах, хэргийг хэлэлцэх

1.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтийг асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.

2.Асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн оршин суугаа газар тодорхойгүй бол хүсэлтийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

3.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосныг хүчингүйд тооцуулах тухай хүсэлтэд энэ тухай шалтгааныг тодорхой дурдаж, холбогдох нотлох баримтыг хавсаргана.

4.Шүүх хуралдааны талуудыг оролцуулна.

5.Зохигчдын төлөөлөгч, өмгөөлөгч болон нийгмийн халамжийн байгууллагын төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болно.

6.Шүүх нэхэмжлэгч хангавал асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрийг хүчингүйд тооцох тухай шийдвэр гаргана."

2 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 135 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/82 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт:

"3/Гэр бүлийн тухай хуульд шүүх шийдвэрлэхээр заасан асуудал;"

2/135 дугаар зүйл:

"135 дугаар зүйл.Гэрлэгчдийн эд хөрөнгийн буюу тэжээн тэтгэх гэрээг биелүүлэх тухай захиramж гаргах

Гэрлэгчид харилцан тохиролцож эд хөрөнгийн гэрээ, талууд тэжээн тэтгэх тухай гэрээг тус тус байгуулсан бөгөөд тэдгээрийг сайн дураар биелүүлээгүй тохиолдолд аль нэг талын хүсэлтээр эдгээр гэрээг биелүүлэхтэй холбогдуулан шүүгч захиramж гаргана."

3 дугаар зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "арга хэмжээ авч болно" гэснийг "бүх талын арга хэмжээ авна"; 134 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн дугаарыг 3, 4 гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Гэр бүлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Д.ГАНБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр **Дугаар 44** **Улаанбаатар хот**

Хуулийн төслүүд буцаах тухай

Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гэр бүлийн тухай хуулийн төслийг дагалдуулан Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай болон Нийгмийн халамжийн сангаас хүн амын эмзэг хэсэгт төрөөс үзүүлэх нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг шаардлагагүй гэж үзэж хууль санаачлагчид буцаасугай.

ДЭД ДАРГА **Д.ГАНБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 6 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 111** **Улаанбаатар хот**

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн тухай

1. Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан Дашдоржийн Дэмбэрэлцэрэнг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг томилох хүртэл "Шүүхийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 7,25[1] дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг орлож байхыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн танхимын тэргүүн шүүгч Чимэдлхамын Ганбатад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 112** **Улаанбаатар хот**

Улсын ерөнхий прокурорын орлогчийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн Цэнд-Аюушийн Жамъянсэнгээг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 113** **Улаанбаатар хот**

Д. Лхагваад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Мэргэжлийн боксын спортод тогтвортой өндөр амжилт гарган, тив, дэлхийн аварга болж, эх орныхоо алдрыг дуусгасан гавьяаг нь үнэлж Мэргэжлийн боксын холбооны тамирчин Дугарбаатарын Лхагваад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр | **Дугаар 114** | **Улаанбаатар хот**

XXI зууныг угтаж хэрэгжүүлэх Үндэсний Ерөнхий хөтөлбөр санаачлах тухай

Дэлхий дахины нийтийн он тооллын шинэ зуун, шинэ мянган давхцан эхлэхэд богино хугацаа үлдлээ. Улс орнууд эдгээр түүхэн үйл явдалд онцгойлон бэлтгэж байна.

Монголын ард түмэн туургa тусгаар улс орноо тээж нийт хүн төрөлхтөнтэй хөл нийлүүлэн эрх тэгшээр зуунаас зуун руу урамтай алхлан орох бахтай сайхан хувь заяа эдүгээ ажилаж, амьдарч буй нийт иргэд, өтгөс бууролуд, залуучууд, нялх балчир үрсэд маань оногдожээ.

Шинэ зуун эхлэхтэй холбогдуулан, XXI зуунд олон улс гүрний дунд Монгол улсынхаа эзлэх байр суурь, нэр сүрийг улам бататган бэхжүүлж, улс орноо цэцэглүүлэн хөгжүүлэх нь монголын ард түмний ариун үйлс болж байгааг тэмдэглэж ЗАРЛИГ буулгах нь:

Нэг. Зуун солигдох цаг үеийг үндэсний эв нэгдэл, төр улс, түмэн олныхоо билэг дэмбэрэлд бодож, XXI зууныг угтаж хэрэгжүүлэх Үндэсний Ерөнхий хөтөлбөрийг дор дурдсанаар батцлан төлөвлөж гүйцэтгэх нь зүйтэй гэж тогтоосугай.

1. XX зуунд Монголын төр, улс оронд ноо гавьяат үйлс бүтээсэн алдар цуутай хүндэтгэлт хүмүүсийн нэр гаргаж амьдрал үйлсийг нь судлан сурталчлах олон талт арга хэмжээ авах.

П.1.XX зууны Монгол орны амьдрал, түүхэн замналыг харуулсан он дарааллын бичиг гаргаж, баримтат кино бүтээх.

П.2.XX зууны Монголын шинжлэх ухаан, соёл, урлаг, уран барилгад гарсан шилдэг бүтээлүүдийн дээжийг салбар, төрөл зүйлээр нь эмхэтгэж хэвлэх, видео, аудио, CD-д буулгах.

П. 3. "Монголын соёлын хотол чуулган XX зуун" хөтөлбөр хэрэгжүүлэх.

III. XXI зууны эхлэлд зориулсан үндэсний мөнгөн тэмдэгт зоос гаргах.

IY. Үндэсний түүх, соёлын өв болж үлдсэн барилга байууламж, хөшөө дурсгал, сүм хийд, ном судрыг тодорхой төлөвлөгөө, дэс дараатайгаар сэргээн засварлах.

Y. Энэ зарлигийн үчир холбогдол болон XXI зуунд Дэлхийн улс орнууд хэрхэн бэлтгэж, ямар ажил хийж байгаа талаар нийт иргэдэд сайтар тайлбарлан таниулж мэдээлж байхыг төрийн болон төрийн бус бүх шатны байгууллагуудын удирдлага, хэвлэл, мэдээллийн газруудад уриалсугай.

Хоёр. Үндэсний Ерөнхий хөтөлбөрийг 2000 оны 12 дугаар сарын 31-ний дотор багтаан биелүүлэх бүх талын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

Гурав. Үндэсний Ерөнхий хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлж байгааг хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар /С. Баяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Ж. НАРАНЦАЦРАЛТ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 19-ний өдөр | **Дугаар 79** | **Улаанбаатар хот**

Журам /хөтөлбөр/, дүрэм, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Иргэний нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Иргэний нисэхийн ажуулгүй байдлын журам /хөтөлбөр/-ыг 1 дүгээр хавсралтын, Иргэний нисэхийн ажуулгүй байдлын зөвлөлийн дүрмийг 2 дугаар хавсралтын, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагдсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Дэд бүтцийн хөгжлийн сайд **Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 1999 оны 79 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЖУРАМ /ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хүчнээс хамгаалах, нисэх буудал болон агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангахад энэхүү журмын зорилт оршино.

Энэ журам нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцийн 17 дугаар хавсралт, 0лон улсын иргэний нисэхийн байгууллага (ИКАО)-ын 8973/5 тоот удирдамж болон Иргэний нисэхийн тухай хуульд нийцүүлэн гаргасан баримт бичиг мөн.

2.Энэ хөтөлбөрт хэрэглэсэн нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

а/"агаарын тээврийн компани" гэж агаарын тээвэрлэгчийн буюу арилжааны нислэгийн хүчин төгөлдөр гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийг;

б/"агаарын хөлгийн зогсоол" гэж зорчигчдыг агаарын хөлөгт суулгах, буулгах, агаарын хөлөгт тээш, ачаа ачих, буулгах, агаарын хөлгийг шатахуунаар сумлах, техникийн болон бусад үйлчилгээ хийх талбай, ашиглагдаж буй аэродромын хэсгийг;

в/"ачаа" гэж агаарын тээврийн компанийн хөлгөөр тээвэрлэхээр байгаа тээш, шуудангаас бусад эд зүйлсийг;

г/"тээш" гэж зорчигчийн тохиролцсоны дагуу агаарын тээврийн компанитай үндсэн дээр агаарын хөлгөөр тээвэрлүүлж буй зорчигчийн хувийн эд зүйлсийг;

д/"бүртгэгдсэн тээш" гэж агаарын тээврийн компанийн хариуцлаганд хүлээн авч тээшний тасалбар буюу эдүүлт олгогдсон зорчигчийн эд зүйлсийг;

е/"гар тээш" гэж зорчигч өөрөө хариуцан биедээ авч явахыг зөвшөөрсөн, нийт жин нь 5 кг-аас хэтрэхгүй эд зүйлсийг;

ж/"иргэний нисэхийн үйл ажиллагааны эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэл" гэж Олон улсын иргэний нисэхийн байгуллагын 8973/5 тоот удирдамжийн 1 дүгээр бүлгийн тодоройхойлотод заасан үйлдлийг;

з/"металл илрүүлэгч" гэж хүний биедээ авч яваа металл эдлэлийг илрүүлэхэд ашигладаг цахим төхөөрөмжийг;

и/"аюулгүй байдлын хамгаалагдсан бүс" гэж нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт хамгаалагдсан бүс гэж тодорхойлсон аэродромын хэсгийг;

к/"нийтийн эзэмшлийн бүс" гэж ямар нэг зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй орж гарч болох нисэх буудлын барилга байгууламж, түүний орчны талбайг;

л/"нисэх буудлын хяналтын бүс" гэж нисэх буудал үйл ажиллагаагаа явуулдаг хяналт шалгалт бүхий бүс;

м/"үзлэгийн дараах бүс" гэж аюулгүй байдлын үзлэгт орсон зорчигчдыг агаарын хөлөгт суулгахаас өмнө хүлээлгэх зориулалт бүхий нисэх буудлын хэсгийг;

н/"хориотой бүс" гэж зохих зөвшөөрөлтэйгээс бусад хүн нэвтрэхийг хориглосон тэмдэг тавьсан нисэх буудлын хэсгийг;

о/"шилжин суух зорчигч" гэж тээвэрлэлтийн гэрээний дагуу аялаа үргэлжүүлэхийн тулд нэг нислэгээс нөгөө нислэгт шилжин суух буй этгээдийг;

п/"дамжин өнгөрөх зорчигч" гэж завсрын буудалд нисэн ирсэн аялагчаас нислэгээ цааш үргэлжүүлж буй этгээдийг.

3.Иргэний нисэхийн аюулгүй байдлын хууль тогтоомж нь Иргэний нисэхийн аюулгүй байдлын тухай Олон улсын конвенци, Иргэний нисэхийн тухай хууль, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, энэхүү журам болон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Хоёр. Иргэний нисэхийн аюулгүй байдлын талаархи иргэний нисэхийн болон бусад байгууллагын бүрэн эрх

4.Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид Ерөнхий газар/ нь Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулах асуудлыг эрхэлсэн эрх бүхий байгууллага мөн бөгөөд нисэхийн аюулгүй байдлыг хангуулах үйл ажиллагааг зохицуулахдаа дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

а/иргэний нисэхийн аюулгүй байдлын стандарт, дүрэм, зааврыг хянаж баталгаажуулах, дагаж мөрдүүлэх;

б/иргэний нисэхийн аюулгүй байдлын талаар үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах;

в/нисэх буудлын болон агаарын тээврийн компанийн аюулгүй байдлын хөтөлбөрийг батлах;

г/гадаад улсаас Монгол Улсад нислэг үйлдэж байгаа агаарын тээврийн компанийн аюулгүй байдлын хөтөлбөрийг хянаж, хүлээн зөвшөөрөх;

д/шаардлагатай тохиолдолд иргэний нисэхийн эсрэг гарсан хөндлөнгийн хууль бус үйлдлийг холбогдох байгууллагуудын оролцоотойгоор таслан зогсоох арга хэмжээ авах;

е/нисэх буудлын аль нэгэн хэсэг (агаарын хөлгийн зогсоол болон явгалах зам талбай, навигацын тоног төхөөрөмжийн орчны газар, түрээслүүлсэн талбай зэрэг)-т нэвтрэн орох журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

ж/иргэний нисэхийн аюулгүй байдлын холбогдолтой үйл ажиллагаа эрхлэх байгууллагыг баталгаажуулах.

5.Нисэх буудлын захиргаа нь нисэх буудлын аюулгүй байдлын асуудлыг хариуцаж, дор дурьдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/ нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр боловсруулах;

б/нисэх буудлын аюулгүй байдлын албыг байгуулж, ажилтныг томилох;

в/нисэх буудлын аюулгүй байдлын хороог байгуулах;

г/Ерөнхий газрын зөвшөөрлийн үндэсн дээр нисэх буудалд тоног төхөөрөмж шинээр байрлуулах, суурилуулах, нисэх буудалд өөрчлөлт, өргөтгөлийн ажил хийх.

6.Нисэх буудал, түүний цогцолборын аль нэг хэсгийг түрээслэгч нь нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт заасан нислэгийн талбайд нэвтрэх шаардлагыг биелүүлж, аюулгүй байдлыг хангах талаар хариуцлага хүлээнэ.

7.Агаарын тээврийн компани нь зорчигч болон агаарын хөлгийн аюулгүй байдлыг хангах үүрэг хүлээнэ.

Агаарын тээврийн компанийн аюулгүй байдлын хөтөлбөрт дараахь зүйлийг тусгасан байна. Үүнд:

а/хөтөлбөрийн зорилго, түүнийг хэрэгжүүлэх талаар компанийн хүлээх үүрэг, хариуцлага;

б/аюулгүй байдлын ажилтны хүлээх үүрэг, хариуцлага;

в/зорчигч, нисэх баг болон агаарын хөлгийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах талаар;

г/аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүд /агаарын хөлгийн нислэгийн өмнөх үзлэг; дамжин өнгөрөх ба шилжин суух зорчигчдын аюулгүй байдлыг хангах, тэдгээрийн тээшийн бүрэн бүтэн байдлыг хариуцах; буудалд буртгэгдээгүй дагалдах болон салангид тээшийг тээвэрлэх, агаарын хөлгийн ачааны хэсэгт зэвсэг тээвэрлэх, хууль хяналтын байгууллагын хяналтаад байгаа этгээдийг тээвэрлэхтэй холбогдсон журмууд; тухайн компанийн агаарын хөлөгт нэвтрэх журам г.м/;

д/онцгой нөхцөл/ агаарын хөлгийг булаах, тэсэрч дэлбэлэх бодис хэрэглэхээр сүрдүүлэх, нислэгийн үед агаарын хөлөгт аюул учруулахуйц сэжигтэй зүйл илрэх г.м /-д авах арга хэмжээний төлөвлөгөө;

е/нисэхийн аюулгүй байдлын ажилтны сургалтын талаар.

8.Цагдаагийн байгууллага нь нисэх буудалд хэв журам сахиулахын зэрэгцээ гэмт халдлага гарахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсоох, дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

а/иргэний нисэхийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хууль бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх;

б/нисэх буудал, түүний орчинд тогтмол хяналт тавих (үүнд эргүүл хийх орно);

в/онцгой нөхцөл байдал (агаарын хөлгийг булаах, барьцаалах, авч зугтаах, тэсэрч дэлбэлэх бодис хэрэглэхээр сүрдүүлэх г.м.) бий болсон үед таслан зогсоох арга хэмжээ авах;

г/ажилтнуудаа нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон сургалтанд хамруулах.

9.Үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх талаар гадаад харилцаа, улсын хил, гааль, аюулгүй байдлыг хангах байгууллагууд болон хуулиар хяналтын байгууллагууд нэг адил үүрэг хүлээнэ.

Төгсгөл нь дараагийн дугаарт нийтлэгдэнэ.

Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар
тушаалын 5 дугаар хавсралт [1]

ЖОЛООЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТ АВАХ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгохтой энэ журмыг мөрдөнө.

2.Тээврийн хэрэгслийн төрөл, зориулалтаас хамааран А,В,С,Д,Е англиллын, мөн трактор, өөрөө явдаг машин, механизм жолоодох болон багшлах эрхийн үнэмлэх олгоно.

3.Жолооч бэлтгэх сургууль, курсыг сургалт явуулах эсэх тухай дүгнэлт гаргах, сургалтын хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих, мэргэжлийн шалгалт авч үнэмлэх, талон олгох, жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн бүртгэл хөтлөх, лавлагаа өгөх үүргийг Замын цагдаагийн газрын мэргэжлийн комисс эрхлэн гүйцэтгэнэ.

4.Мэргэжлийн комиссын гишүүн нь автотехникийн багшаар болон түүнээс дээш зэрэгтэй, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг сайн мэдэг, жолоодох дадлага туршлагатай хүн байна.

5.Мэргэжлийн комисс нь сургалтын чанар зохих хувьд хүрээгүй болон материаллаг баазгүй, багшлах боловсон хүчний хувьд шаардлага хангахгүй гэж үзсэн жолооч бэлтгэх сургууль, курсыг хаах тухай санал гаргах, сургалтыг түр хугацаагаар зогсоох, шалгалтыг хойшлуулах, хичээлийн хөтөлбөрт цагийн (төрөл тус бүрээр) 20-иос дээш хувьд суугаагүй, эрүүл мэндээр жолоочид тэнцэхгүй гэсэн мэдлагаа гаргах болон гэмт хэрэг үйлдсэн, ууж согтуурсан сонсогчийг жолооч бэлтгэх сургууль, курсээс хасах, шалгалтанд оруулахыг хойшлуулах мөн зам, тээврийн осол, зөрчил гаргасан хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хууль тогтоомжид заасны дагуу хасах, ангилал бууруулах, дахин шалгалтанд оруулах эрх эдлэнэ.

6.Автомашин, механизмын жолооч бэлтгэх курст замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм болон жолоодлогын дадлагын хичээл заах багш нарт багшлах эрхийн үнэмлэх олгоно. Уг үнэмлэхийн дугаарыг жолоочийн үнэмлэх, талоны хуудсанд бичиж бүртгэл хөтөлнө.

7. "Жолооч бэлтгэх журам "-ын дагуу сургууль, курст суралцаж хөтөлбөрт цагийг хангасан, хуульд заасан насанд хүрсэн хүмүүсийг мэргэжлийн шалгалтанд оруулна.

8."В" ангиллын болон мотоцикль, механизмын жолооч болохоор зохих бэлтгэл, дадлага хийсэн хүмүүсийн хүсэлт, тодорхойлотыг үндэслэн шалгалтанд оруулж болно.

Хоёр Мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох үйл ажиллагаа:

9.Жолоочийн мэргэжлийн шалгалтанд орох хүмүүс дор дурьдан материалыг бүрдүүлсэн байна.

Үүнд:

а. Жолооч бэлтгэх сургууль, курст суралцаж зохих хөтөлбөр хангаж төгссөн тухай тодорхойлолт, гэрчилгээ;

б. Эрүүл мэндийн тодорхойлолт;

в. Иргэний пасспорт;

г. Шалгалтын хураамж төлсөн баримт.

10. 8 дугаар зүйлд заасан материалыг бүрдүүлсэн хүнээс шалгалт авч тэнцсэн тохиолдолд жолоочийн үнэмлэх,талоны хуудас бичиж шалгалтын комиссын гишүүд гарын үсэг зурна.

11. Жолоочийн мэргэжлийн шалгалтыг мэргэжлийн комиссын гишүүд оролцсон комисс авч, төгсгөлөл (дүнгийн хуснэгт) хөтлөн комиссынгишүүд гарын үсэг зурна.

12. Шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг Мэргэжлийн комиссын дарга томилно.

13. Орон нутагт зохион байгуулагдсан мотоцикль, механизмын жолооч бэлтгэх болон үнэмлэх, талон үрэгдүүлсэн, талон цоолуулсан, жолоодох эрх сэргээх, "С" ангиллаас "В"-д "Д"-эс "В" болон "С" ангилалд, урьд нь1,2-р зэрэгтэй байсан жолооч "Д" болон "Е" ангилалд шалгалтыг аймаг, дүүргийн шалгалтын комисс авч дүн материалыг Мэргэжлийн комисст ирүүлнэ.

Тайлбар: Орон нутагт байгаа механизм,мотоциклийн жолооч бэлтгэх сургууль, курсын сонсогчдоос шалгалт авах комиссыг аймаг, хотын Засаг даргын захирамж, тухайн сургууль, курсын захирлын тушаалаар томилж болно.

14."С " ангиллаас "В" ангилалд, "Д" ангиллаас "В" болон "С" ангилалд шилжихийг

---

1. Хууль зүйн сайдын 1999 оны 73 дугаар тушаал болон тушаалын 1,2,3,4 дүгээр хавсралт <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн 28,29 дүгээрт нийтлэгдсэн .

хүсвэл тухайн ангиллын жолоодлогын шалгалт авна.

15. Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд автомашин, механизм мотоциклийн бүтэц зохион байгуулалт, ажиллагаа, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг сайн мэддэг, жолоодох дадлага туршлагатай, техникийн дээд болон дунд боловсрол мэргэжилтэй, хууль дүрэм, жолоодлогын шалгалт авах арга зүйн мэдлэгтэй хүнийг оруулна.

16. Их, дээд болон тусгай дунд сургууль-ьд замын хөдөлгөөний дүрэм, автомашины бүтэц, зохион байгуулалт, жолоодлогын хөтөлбөр үзэж судлан зохих бэлтгэл хийсэн болон тракторын жолоочоор 10-с доошгүй жил тасралтгүй ажилласан хүмүүсийг түргэвчилсэн хөтөлбөрөөр суралцуулж болно.

17. Жолоочийн мэргэжил эзэмших хүн сургууль, курст суралцаж төгсөөд хүндэтгэн үзэх шалтгаанаар шалгалтаа өгч чадаагүй бол курс төгссөн өдрөөс хойш 6 сарын дотор шалгалтаа нөхөн өгч болно.

Тайлбар: Жолооч бэлтгэх сургууль,курс төгссөн үед хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шалгалтанд ороогүй (орхин явсан) хүнийг тухайн шалгалтанд амжилтгүй дүн үзүүлсэнд тооцно. Хэрвээ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шалгалтанд орж чадахгүй бол тухайн шалгалтын өмнө тэр тухайгаа холбогдох материалын хамт шалгалтын комисст мэдэгдсэн байвал зохино.

18.Мэргэжлийн шалгалтанд 3 удаа орж тэнцээгүй хүмүүс дахин шалгалтанд орохын тулд давтан курст суралцан байвал зохино.

19. Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалтыг онолын болон дадлагын гэсэн хоёр шаттайгаар явуулах бөгөөд онолын шалгалт гэдэгт замын хөдөлгөөний дүрмийн шалгалт, суурин жолоодлогын талбайд авах шалгалт хамаарна.Дадлагын шалгалтыг замын хөдөлгөөнд шууд оролцуулан жолоодох ур чадвар хэр зэрэг эзэмшсэн, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг хэрхэн биелүүлж байгааг харгалзан үнэлж дүгнэнэ. Давтан шалгалтын хугацаанд 7 хүртэл хоногоор, шаардлагатай гэж үзвэл 1 сар хүртэл хугацаагаар тогтоно. Жолоочийн мэргэжилд шалгуулж байгаа хүн нэг шалгалтанд тэнцээд бусад шалгалтыг 6 сарын дотор өгч чадаагүй буюу тэнцээгүй бол тэнцсэн шалгалтын дүнг хүчингүйд тооцно.

20. Авто инженер, механикийн мэргэжлээр их, дээд болон тусгай дунд сургууль төгссөн дипломтой хүнийг тусгайлан жолоочийн сургууль, курс хийлгэлгүйгээр "В", "С" ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох шалгалтанд шууд оруулж болно.

21. Мэргэжлийн шалгалтанд тэнцэж жолоочийн үнэмлэх, талоны хуудас нээж, комиссын гишүүдийн баталгаатай гарын үсэг зурсан бол үнэмлэх, талон бичиж олгоно. Үнэмлэх талон олгох тухай Мэргэжлийн комиссын тогтоол гарна. Жолоодох эрхийн үнэмлэх, талоныг хар тушаэр болон бусад техник хэрэгслээр бичиж, тээврийн хэрэгсэл жолоодох ангиллыг тусгай тэмдэглэл хийж тодруулна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн шалгалт авах:

22. Шалгалт авах хэлбэр, хугацаа:

-Карт буюу тест (бичгээр)
-Цахим төхөөрөмжийн тусламжтайгаар

Тайлбар: Шинээр жолооч болохоос бусад тохиолдолд 10асуулт бүхий тестээр шалгалт авна. Бичгээр шалгалт авах хугацаа 10 асуулт бүхий картад 15 минут, 20 асуулт бүхий картад 25 минутаас хэтрэхгүй байвал зохино.

23. Тестийн шалгалтыг бүх хариултын 90 буюу түүнээс дээш хувийг зөв хариулсан хүнийг тэнцсэнд тооцно. Шалгалт өгч байгаа хүн шалгалтын үед шалгалтын комиссын гишүүний тайлбарласан журмыг зөрчвөл тухайн шалгалтанд муу дүн үзүүлсэнд тооцно

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийн шалгалтын агуулга

24. Хууль, дүрмийн шалгалт авахдаа дор дурьдсан мэдлэг, ойлголт байгаа эсэхийг тогтооно.

-Тухайн ангиллын тээврийн хэрэгслийн бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн ажиллагаа, ашиглалтын тухай мэдлэг;

-Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн мэдлэг;

- Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг;

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндсийн тухай мэдлэг;

-Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад жолоочийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаатай холбогдсон дүрэм журмын тухай мэдлэг;

-Зам тээврийн осол,хэрэгт холбогдсон жолоочийн хүлээх захиргааны болон эрүүгийн хариуцлагын тухай мэдлэг;

-Зам тээврийн осол, хэрэгт нэрвэгдсэн хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх аргууд

Жолоодлогын шалгалт авах

25. Жолоодлогын дадлагын шалгалтыг тухайн шалгалт өгч буй ангиллын тээврийн хэрэгсэл дээр авна. Жолоодлогын шалгалт авах тээврийн хэрэгсэл тоормосны нэмэгдэл дөрөөтэй, ар талаа харах нэмэгдэл тольтой, техникийн хувьд замын хөдөлгөөний дүрмийн шаардлага бүрэн хангасан байвал зохино. Жолоодлогын шалгалтыг оноогоор дүгнэж болно.

Жолоодлогын шалгалтын агуулга

26. Жолоодлогын шалгалтыг тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох чадвар эзэмшсэн, хэвшиж дадсан байдлыг магадлахын тулд жолоодлогын тусгай талбай болон суурин газрын замын хөдөлгөөнд оролцох байдал гэсэн хоёр шаттайгаар явуулна.

27. Жолоодлогын дадлагыг тодорхойлохын тулд жолооны шалгалт өгөх хүнээр дор дурьдсан үйлдлүүдийг хийлгэнэ.

Үүнд:

Нэгдүгээрт : Жолоодлогын тусгай талбайд:

-ухрах үйлдэл хийж зогсоолд тавих;

-гүвээн дээр зогсож байгаа тээврийн хэрэгслийг өгсөх болон ухрах үйлдэл хийлгэх

-Таван ширхэг туг сүлжих;

-Хажуугийн зогсоолд зөв байрлуулах;

-Оврын хязгаарлалт бүхий тунельд ухрах;

-Наймын тоо эргэх;

Хоёрдугаарт: Суурин газрын замын хөдлөгөөнд:

-хязгаарлагдмал хэсэгт төрөл бүрийн үйлдэл хийх ;

-замын зорчих хэсгээр зөв байрлаж явах;

-баруун, зүүн гар тийш, буцаж эргэх үйлдлийг зөв хийж буй эсэх;

-хөдөлгөөний чигийг өөрчлөх, замын уулзварт буцаж эргэх үйлдлийг зөв хийж буй эсэх;

-хөдөлгөөний үед орчны байдлыг зөв үнэлж, хурд тохируулж явах;

-ар талаа харах толийг зөв ашиглаж буй эсэх;

-гэрэлтүүлэх болон урьдчилан анхааруулах дохио, хянах хэрэгслүүд, нэмэгдэл төхөөрөмжүүдийг зөв ашиглаж буй эсэх;

-хөдөлгөөний чигээ өөрчлөх гэж байгаагаа урьдчилан анхааруулж буй байдал;

-шулуун замд мөн зөвшөөрөгдсөн гэрлээр эргэх үед гарцаар гарч явааа явган зорчигчийг урьдчилан өнгөрүүлэх дүрэм биелүүлж дадсан эсэх;

-гэрэл дохио, хөдөлгөөн зохицуулах эрх бүхий хүмүүсийн заалтыг удирдлага болгож буй эсэх;

-замын тэмдэг, тэмдэглэлийн заалтыг биелүүлж байгаа эсэх;

-хоорондын болон хажуугийн зайг зөв барьж яваа эсэх;

-гүйцэж түрүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэж байгаа эсэх;

-зогсоолын талбайд тээврийн хэрэгслээ зөв байрлуулж буй эсэх;

28.Жолоодлогын шалгалтыг орон нутгийн болон суурин газрын аль ч замд авч болох бөгөөд шалгалт авах хугацаа ба явуулж шалгах замын хэмжээ энэ журмын 26 дугаар зүйлд заасныг бүрэн шалгах бололцоо хангасан байвал зохино.

29. Жолоочийн үнэмлэх талоны хуудсыг дор дурдсан журмаар хүн нэг бүр дээр хөтөлнө.

Нүүрэн талд нь жолоочийн овог нэр, регистрийн дугаар, жолооч болсон он,сар, өдөр, төгссөн сургууль, курсын нэр, хүйс, цусны бүлэг, боловсролын тухай тэмдэглэл, ар талд нь шинээр болон мэргэжил дээшлэх мөн давтан курст суралцсан сургууллиас олгосон гэрчилгээний дугаар, хэзээ ямар зөрчил гаргасны учир арга хэмжээ авагдсан болон архивын дугаарын тэмдэглэл байна.

Гурав: Ангилал дээшлүүлэх болон жолоодох эрхийг хасах :

30. Тээврийн хэрэгсэл жолоодох "В" ангиллаас "С" ангилалд, "В" болон "В,С"-ээс "Д"-д, "В","С"-ээс "Е"-д, "ВСД"-ээс "Е"-д, "ВСЕ"-ээс "Д"-д шалгуулах хүмүүс ангилал дээшлүүлэх курст суралцана.

31. Ангилал дээшлүүлэх хүмүүс дор дурдсан шаардлагыг хангасан байна.

а.Жолоочоор 1 жилээс доошгүй хугацаагаар тасралтгүй ажилласан байх;

б.Замын хөдөлгөөний дүрэмд заасан насанд хүрсэн байх;

в. Дээрх хугацаанд зам тээврийн осол, зөрчил гаргаагүй байх;

г. Эрүүл мэндийн хувьд тэнцсэн байх.

32. Замын хөдөлгөөний дүрэм удаа дараа зөрчсөн жолоочийг шаардлагатай гэж үзвэл шинээр мэргэжил эзэмшигчийн нэг адил шалгалтанд оруулах ба 3 удаа тэнцэхгүй бол жолоодох эрхийн үнэмлэх ,талоныг хураан давтан курст суралцахыг шаардана.

33. Сургалтыг чанаргүй явуулсан тохиолдолд, мөн техник эзэмших чадвар, хувийн сахилга хариуцлагаас хамааруулан хууль дүрэм болон жолоодлогын багшлах эрхийг 1 жил хүртэл хугацаагаар хасч болно.

Дөрөв.Үнэмлэх, талон нөхөн олгох

34. Жолоодох эрхийн үнэмлэх, талоноо үрэгдүүлсэн жолоочоос зохих журмаар хэвлэлд зарлуулж уг үнэмлэх, талоныг хүчингүйд тооцсоны дараа хууль дүрмийн шалгалт авч, тэнцсэн тохиолдолд нөхөж олгоно.

35. Гэнэтийн аюул (гал түймэр, үер г.м)-ын улмаас үнэмлэх талоноо үрэгдүүлбэл албан газар, орон нутгийн Цагдаагийн байгууллага (Гал түймэртэй тэмцэх алба)-ын тодорхойлолтыг үндэслэн шалгалттүйгээр нөхөж олгоно.

36. Энэ журмын 34, 35 дугаар зүйлүүдэд заасны дагуу нөхөн олгосон үнэмлэх, талон дээр " нөхөв" тэмдэглэл хийнэ.

37. Хууль дүрэм зөрчсөний улмаас талоноо 3 удаа цоолуулж хүчингүй болгосон жолоочоос хууль дүрмийн шалгалт авч тэнцвэл талоныг нөхөж олгох ба олгосон талон дээр "Цоологдож нөхөв" гэсэн тэмдэг дарна.

38. Жолоочийн үнэмлэхээ үрэгдүүлсэн, хүчингүй болгосон шалтгаанаар шалгагдах 50-иас дээш насны жолоочийг амаар шалгаж болно.

39. Үнэмлэх талоноо үрэгдүүлсэн жолоочид ажлын шаардлагыг харгалзан 1 сар хүртэл хугацаатайгаар тээврийн хэрэгсэл жолоодох түр зөвшөөрөл олгож болно.

40. Жолоочийн эрхийн үнэмлэх нь талоны хамт хүчингүй бөгөөд талон цоологдсон, үрэгдсэн, хүчингүй болсон тохиолдолд тээврийн хэрэгсэл жолоодохыг хориглоно.

41.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эрэгтэмт хэрэг үйлдэж хорих болон жолоодох эрх хасах ял шийтгүүлсэн захиргааны журмаар тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж 1 жил хүртэлх хугацаагаар мэргэжлийн ажлаас хөндийрсөн хүнээс замын хөдөлгөөний тухай хууль, дүрмийн шалгалт авч тэнцвэл эрхийг сэргээн олгох ба 3 удаа шалгахад тэнцээгүй бол давтан курст суралцахыг шаардана.

42. Мөн 41 дүгээр зүйлд заасан шалтгаанаар 1 жил болон түүнээс дээш хугацаагаар жолоочийн ажлаас хөндийрсөн болон хүчингүй болсон (АМС, Авто-III гэх мэт) үнэмлэх талоныг солих шалгалтанд орох хүнийг хууль дүрмийн давтан курст суралцахыг шаардана.

43.Нэг жилийн дотор анхааруулах талоноо 2 удаа 3 цоолуулсан мөн үнэмлэх, талон үрэгдүүлсэн, хүчингүй болгосны улмаас шалгалтанд орж 3 удаа тэнцээгүй бол давтан курст суралцахыг шаардана. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх талоныг хэвлүүлж, орлогод авах, зарцуулах ажлыг Замын цагдаагийн газар хариуцана.

44. Жолоочийн үнэмлэх, талон, түр зөвшөөрөл олгох, солих, ангилал дээшлүүлэх, эрх сэргээх тухай үндэсн материал (жолоочийн хуучин үнэмлэх, өргөдөл тодорхойлт; албан бичиг, дипломын хуулбар, мөнгө тушаасан баримт г.м)-ыг архивын журмаар хадгална.

45. Үнэмлэх, талон, эрүүл мэндийн тодорхойлт, түр зөвшөөрлийн хуудсыг ээлж нь буюу итгэмжлэл бүхий хүний биеийн байцаалт болох бичиг баримтыг шалган үзэж гарын үсэг зуруулан он, сар, өдрийг тэмдэглэж олгоно.

46. Бичих,хэвлэх ажиллагааны явцад буруу бичигдэж хэвлэгдсэн, зурагны ломбо буруу гарч үнэмлэх, түр зөвшөөрөл хүчингүй болсон тохиолдолд тусгай комисс томилон шалгуулж акт гарган байгууллагын санхүүд шилжүүлэн устгал хийнэ.

Тав. Гадаад орны жолоодох эрхийн үнэмлэхтэй хүмүүст тус улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох:

47.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн гадаад орны үнэмлэхтэй Монгол улсын иргэнээс шаардлагатай гэж үзвэл хууль дүрмийн шалгалт авч үндэсний үнэмлэх, талон сольж олгоно. Монгол Улсын иргэд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн өөрийн орны үндэсний үнэмлэхтэйгээр автомашин жолоодоно.

48.Тус улсад 3 сараас дээш хугацаагаар ирсэн жолоодох эрхийн үнэмлэхтэй гадаадын иргэний үндэсний үнэмлэхийг гэрээ хэлэлцээрээр ажиллаж байгаа, байгууллагын хүсэлт тодорхойлолтыг үндэслэн үндэсний үнэмлэхэд нь заагдсан ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхээр сольж олгоно. Олон улсын жолоодох эрхийн

үнэмлэхтэй гадаадын иргэдийн үнэмлэхийг Венийн конвенцид нэгдсэн орнуудаас олгосон бол солилуулахыг шаардахгүй бөгөөд бусад орноос олгосон олон улсын жолоодох эрхийн үнэмлэхийг үндэсний үнэмлэхийн нэгэн адил шийдвэрлэнэ.

49.Гадаадын иргэдийн үнэмлэх сольсон, олгосон тухай бүртгэл хөтөлж, холбогдох баримтыг архивын журмын дагуу хадгална.

50.Түр улсад оршин суугаа гадаад иргэнээс манай улсын жолоочийн үнэмлэх шинээр авахыг хүсвэл ердийн журмаар шийдвэрлэнэ.

Зургаа. Жолоодох эрхийн үнэмлэх олгох бүртгэл хөтлөх:

51.Мэргэжлийн шалгалтын протоколыг шалгалтын төрөл бүрээр хөтлөх ба тэнцсэн хүмүүст тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох тухай Мэргэжлийн комиссын тогтоол гаргаж комиссын дарга батална.

52.Мэргэжлийн комиссын тогтоолоор жолоодох эрхийн үнэмлэх, талон бичиж тус бүрийн дугаарыг бүртгэлийн дэвтэрт нэгбүрчлэн бүртгэх ба тухай бүрт нь цахим технөрөмжид оруулна. Бүртгэлийг үнэмлэх шинээр олгосон, ангилал дээшлүүлсэн, үнэмлэх нөхсөн, талон нөхсөн, эрх сэргээн олгосон байдлаар төрөлжүүлж хөтөлнө.

Долоо. Замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг бүртгэл хөтлөх:

53.Жолооч хууль тогтоомжийн дагуу эрүүгийн болон захиргааны арга хэмжээ авагдан тухай нэгдсэн тоо бүртгэлийг Мэргэжлийн комисс хөтөлнө.

54.Жолоочийн гаргасан замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг нэгдсэн санал оруулах, мэдээлэл лавлагаанд ашиглах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг тодорхойлохын тулд зөрчлийн бүртгэлийг хөтөлнө.

55. Замын цагдаагийн албадууд замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гаргасан жолооч нарт Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авсан тухай бүртгэл хөтөлж, жагсаалтыг дараа сарын 5-ны дотор Мэргэжлийн комист ирүүлэн, жолоочийн үнэмлэх талоны хуудсанд тэмдэглүүлнэ. Хэрэв тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан бол тодорхойлолтыг жолоочийн үнэмлэх, талоны хамт Мэргэжлийн комист ирүүлнэ.

56.Мэргэжлийн комисс нь аймаг, дүүргийн замын цагдаагийн албадаас ирүүлсэн замын хөдөлгөөний дүрмийн зөрчил, түүнд авсан арга хэмжээний тухай мэдээг цахим төлөөрөмжид оруулж тэмдэглэнэ, нэгдсэн мэдээг дараа сарын 8-ны дотор гаргана.

Найм. Лавлагаа гаргаж өгөх:

57.Байгууллага иргэдийн хүсэлтийн дагуу жолооч осол зөрчил гаргаж байсан эсэх, мөн жолоодох эрхтэй эсэх, эрх сэргээх хугацааны тухай лавлагаат гаргаж өгнө.

58.Лавлагааг гаргуулахад дор дурдсан материалыг бүрдүүлнэ.

59.А. Албан бичиг буюу өргөдөл;

Б. Биеийн байцаалт, иргэний паспорт (үнэмлэх).

Ес. үнэмлэх талон бичих, батлах, хэвлэн олгох:

59.Шинээр жолооч болохоор мэргэжлийн шалгалтаа өгч тэнцсэн хүмүүст дараах материалыг бүрдүүлсэн тохиолдолд үнэмлэх, талон олгоно.

Үүнд:

а. Эрүүл мэндийн тодорхойлолт;

б. Жолоочийн үнэмлэх олгох хуудас;

в. Өнгөт гэрэл зураг (1 хувь);

г. Хичээлийн хөтөлбөр хангасан тухай тодорхойлолт эсвэл өргөдөл;

д. Үнэмлэх талоны үнэ тушаасан баримт.

Арав. Үнэмлэх талон нөхөн авах буюу эрх сэргээх:

60.Үнэмлэх, талоноо үрэгдүүлсэн, талоноо гүрван удаа цоолуулсан, эрх сэргээх хүмүүст дараах материалыг бүрдүүлсэн тохиолдолд үнэмлэх талоныг нөхөн олгох буюу эрхийг сэргээнэ.

а. Шалгалт өгч тэнцсэн тухай баримт;

б. Эрүүл мэндийн тодорхойлолт;

в. Зарлуулж хүчингүй болгосон тасалбар болон талон цоолуулсан, эрх хасагдсан тухай лавлагаа;

г. Үнэмлэх талоны үнэ тушаасан баримт.

61.Шалгалтын комисс материалыг үндэслэн авч, хянаж, гарын үсэг зурсны дараа архив хариуцсан байцаагчид шилжүүлнэ.

62.Архив хариуцсан байцаагч материалыг хянаж үнэмлэх талоны хамт архивчид шилжүүлэн бичилт, олголтын ажлыг шуурхай зохион байгуулна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ ЭХ ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны долдугаар сарын 17 №31 (110)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

285. Таримал ургамлын үр, сортын тухай (1999-6-17-ны хууль) 582

286. Үрийн тариалангийн даатгалын тухай (1999-7-2-ны хууль) 585

287. Конвенци соёрхон батлах тухай (1999-6-24-ний хууль) 586

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

288. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 42 586

289. Бүгд Найрамдах Салвадор Улстай дипломат харилцаа тогтоох тухай Дугаар 45 586

290. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 47 587

291. Хуулийн төсөл буцаах тухай Дугаар 48 587

292. Засгийн газарт үүрэг өгөх тухай Дугаар 51 587

293. Ажлын хэсэг байгуулах тухай Дугаар 52 588

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

294. Зарим аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчийн тухай Дугаар 115 588

295. Прокурорын зэрэг дэв олгох тухай Дугаар 116 590

Дөрөв. Монгол Улсын засгийн газрын тогтоол

296. Засгийн газрын 1999 оны 79 дүгээр тогтоолын хавсралтууд 590

297. Буудайн элеваторын тухай Дугаар 81 595

298. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай Дугаар 82 596

299. Банк, санхүүгийн үйлчилгээний найдвартай байдлыг хангах зарим арга хэмжээний тухай Дугаар 83 608

300. Үүрэн телефон хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив батлах тухай Дугаар 84 608

301. Зөвлөлдөх хороо байгуулах тухай Дугаар 86 609

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр **Улаанбаатар хот**

ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тарималжуулах, үрийн ба сортын чанарт хяналт тавих, үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Тарималжуулах үр, сортын тухай хууль тогтоомж

2.1. Тарималжуулах үр, сортын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3. 1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "үр" гэж тухайн сортын нөхөн үржлийг хангах чадвартай, дахин сэргээх, үржүүлэх болон аж ахуйн зориулалтаар ашиглаж байгаа амьд үр, суулгац, тарьц, хөврөл, үргал эрхтэнийг;

3.1.2."сорт" гэж селекцийн аргаар бий болгосон, аж ахуй, биологи, удамшил, халбэр зүйн тогтвортой шинж тэмдгийг агуулсан нэг гарал үүсэлтэй бүлэг ургамлыг;

3.1.3."торгон үр" гэж тодорхой сортын нөхөн үйлдвэрлэлийг хангах зориулгоор зориуд сонгон авч цэвэрлэж үржүүлсэн үрийг;

3.1.4. "сортын үр" гэж чанарын ангиллаар торгон үрийн дараагийн шатанд хамаарагдах үрийг;

3.1.5. "баталгаат сорт" гэж тухайн бүс нутагт биологи, аж ахуйн нийтлэг болон тодорхой шинжээр шалгарч, сорт сорилтын зөвлөлөөр батлагдан, тариалах сортын нэрсийн жагсаалтанд бүртгэгдсэн сортыг;

3.1.6. "ирээдүйтэй сорт" гэж сорт сорилтын эхний дунгээр аж ахуй, биологийн үндэсэн үзүүлэлтэзрээ баталгаат сортоос давж байгаа боловч албан ёсоор зөвшөөрөгдөөгүй байгаа сортыг;

3.1.7. "сортын хяналт" гэж үрэнд зориулан тариалсан талбайг мэргэжлийн байгууллагаас газар дээр нь шалган сортын цэвэр байдлыг хянаж баталгаажуулах үйл ажиллагаа;

3.1.8. "эрлийз" гэж нэгдүгээр үеийн эрлийзийн давуу чанар (гетерозис)-ыг ашигласан зөвхөн таваарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалтаар ашиглаж байгаа эрлийз ургамлыг;

3.1.9. "тарималжуулах ургамлын сангийн хадгаламж" гэж Монгол Улсын тарималжуулах ургамлын удмын санд бүртгэгдсэн сорт, дээжийг амьдаар нь хадгалах, хамгаалах, ашиглах үйл ажиллагаа.

4 дүгээр зүйл. Тарималжуулах ургамлын удмын сангийн хадгаламж

4.1.Тарималжуулах ургамлын удмын санг арвижуулах, хадгалах, хамгаалах, селекцид ашиглах зорилгоор тарималжуулах ургамлын удмын сангийн хадгаламж байгуулна.

4.2.Тарималжуулах ургамлын удмын сангийн хадгаламж нь Монгол Улсын селекцийн болон нутгийн сорт, эрлийз, нутгийн дээж, гадаадын сортоос бүрдэнэ.

4.3.Тарималжуулах ургамлын удмын сангийн хадгаламж нь төрийн мэдэлд байх бөгөөд түүнийг сэлбэх, шинэчлэх, ашиглах асуудлыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосон мэргэжлийн байгууллага эрхэлнэ.

[1] Монгол Улсын Үндсэн хууль –" Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

5 дугаар зүйл. Үрийн нөөцийн улсын сан

5.1. Байгалийн гамшгийн улмаас тариалах үрээ нөөцөлж чадаагүй үйлдвэрлэгч болон хүнс, тэжээлийн үр тарианы үйлдвэрлэл дагнан эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилгоор үрийн нөөцийн улсын сан бүрдүүлнэ.

5.2. Үрийн нөөцийн улсын сан бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар тогтооно.

6 дугаар зүйл. Таримал ургамлын үр, сортын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нутгийн захиргааны байгууллагын эрх, үүрэг

6.1. Таримал ургамлын үр, сортын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрхтэй:

6.1.1. хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын захиалга, гэрээгээр торгон, сортын болон эрлийзийн үр үржүүлэх;

6.1.2. өөрийн бүтээсэн шинэ сортыг удам гарвалын хувьд баталгаажуулах тухай хүсэлтээ сорт сорилтын зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх.

6.2. Таримал ургамлын үр, сортын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэгтэй:

6.2.1. өөрийн бүтээсэн шинэ сортыг таримал ургамлын удмын сангийн хадгаламжид бүртгүүлэх, хадгалуулах;

6.2.2. өөрийн үйлдвэрлэсэн үрийг үр, хорио цээрийн хяналтад хамруулах;

6.2.3. тарих үрийн чанарын улсын стандарт хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэсэн технологи нь тодорхой, баталгаат сортын болон эрлийзийн үр борлуулах, бусдад шилжүүлэх;

6.2.4. тарих үрийн чанарын улсын стандарт хангасан үр импортлох;

6.2.5. үрийн тариалангийн талбайд сортын хянан баталгаа хийлгэх;

6.2.6. үрийн нөөцийн улсын санд зөвхөн тарих үрийн чанарын улсын стандарт хангасан үр бэлтгэн нийлүүлэх.

6.3. Торгон болон сортын үр үйлдвэрлэх зорилгоор үр үйлдвэрлэгчид агро-цаг уурын тааламжтай нөхцөл бүхий талбай зэзмшүүлэх, үр үржүүлгийн талбайд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэхэд бүх шатны Засаг дарга эрх мэдлийнхээ хүрээнд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Улсын сорт сорилт, үр, сортын чанарт тавих хяналт

7 дугаар зүйл. Улсын сорт сорилт

7.1. Таримал ургамлын шинэ сортыг удам гарвалын хувьд хянаж баталгаажуулах, тариалангийн бүсэд баталгаат сорттой харьцуулан сорих замаар сонгон шалгаруулж, тариалах технологийг нь судлан боловсруулах зорилгоор улсын сорт сорилт хийнэ.

7.2. Улсын сорт сорилтыг зохион байгуулах, зохицуулах, шинэ сортыг удам гарвалын хувьд хянаж баталгаажуулах чиг үүргийг сорт сорилтын зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) хэрэгжүүлнэ.

7.3. Зөвлөл нь орон тооны бус байна.

7.4. Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.5. Сорт сорилтыг мэргэжлийн байгууллага, иргэн (цаашид "сорт соригч" гэх) хэрэгжүүлнэ.

7.6. Сорт сориг нь дараахь үүрэгтэй:

7.6.1. тариалангийн бүсэд сортыг сорих, тариалах технологийг боловсруулах ажлыг батлагдсан арга зүйн дагуу гүйцэтгэх;

7.6.2. харьяалах бүсэд ирээдүйтэй сортын үр үржүүлэх;

7.6.3. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үр үржүүлгийн болон сортын тариалангийн технологийн талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

7.6.4. шинэ сорт өмчлөгч этгээдийн зөвшөөрлийн үндсэн дээр сорт сорих;

7.6.5. Зөвлөлд жил бүр ажлаа тайлагнах.

7.7. Зөвлөлөөс удам гарвалын хувьд баталгаажуулсан биологийн аргаар гаргасан шинэ сортын зохиогчид Зохиогчийн эрхийн тухай хуулийн[2] 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу зохиогчийн эрхийн гэрчилгээ олгоно.

---

[2] Зохиогчийн эрхийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 4-6 дугаарт нийтлэгдсэн.

8 дугаар зүйл. Сортыг өмчлөх

8.1. Энэ хуулийн 7.7-д заасан гэрчилгээ авсан этгээд уг сортын өмчлөгч байна.

8.2. Сортын өмчлөгч нь дараахь эрх эдэлнэ:

8.2.1. сортын технологийн баримт бичгийг боловсруулах, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд биечлэн оролцох, зохиогчийн хяналт тавих;

8.2.2. сорт ашиглуулсны төлбөр авах;

8.2.3. өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх, өвлүүлэх.

8.3.Сорт ашиглуулсны төлбөрийн хэмжээг өмчлөгч, ашиглагчийн харилцан тохиролцсоны дагуу гэрээний үндсэн дээр тогтооно.

8.4. Сорт ашигласны төлбөр төлөх хугацаа 5 хүртэл жил байна.

8.5. Зохиогчийн ажлыг санхүүжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага сорт ашиглуулсаны төлбөрийн 50 хүртэл хувийг эзэмших эрхтэй.

9 дүгээр зүйл. Таримал ургамлын үр, сортын чанарт тавих хяналт

9.1. Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналтыг үрийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

9.2.Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

9.3. Үрийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн[3] 21 дүгээр зүйлийн 2,3,4,5,6 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.

9.4. Үрийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас гадна дараахь бүрэн эрх хэрэгжүүлнэ:

9.4.1. үрийн нөөцийн улсын санд үр нийлүүлэх, торгон ба сортын үр үржүүлэх гэрээ бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тариалах үрэндээ чанарын шинжилгээ хийлгэж баталгаажуулсан эсэхэд хяналт тавих;

9.4.2. үрийн талбайд сортын хянан баталгаа хийх, хянан батлагч нарын ажилд хяналт тавих;

9.4.3. хүнсний ногооны үр, бусад үргамал, эрлийзийн үр үржүүлгийн технологийн мөрдөлтөд хяналт тавих;

9.4.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тариалах, борлуулах үр болон импортолсон үрэнд чанарын шинжилгээ хийлгэж баталгаажуулсан эсэхэд хяналт тавих.

9.5. Үрийн чанарыг үр шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатори магадлан шинжилж баталгаажуулна.

9.6. Энэ хуулийн 9.5-д заасан лабораторийн үйл ажиллагааны журмыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

10 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1. Таримал ургамлын үр, сортын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд үрийн хяналтын улсын байцаагч буюу шүүгч дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

10.1.1. Энэ хуулийн 6.2.2; 6.2.5-г зөрчсөн иргэнийг 10000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 40000-250000 төгрөгөөр торгох;

10.1.2.Энэ хуулийн 6.2.3; 6.2.4; 6.2.6-г зөрчсөн иргэнийг 20000-50000 төгрөгөөр, албан тушаалтныг 40000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох.

10.2. Сорт өмчлөгчийн эрх зөрчигдсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Иргэний хуулийн[4] дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

---

[3] Төрийн хяналт, шалгалтын тухай хууль- " Ардын эрх" сонины 1990 оны 90, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 4 дүгээрт тус тус нийтлэгдсэн

[4] Иргэний хууль – "Ардын эрх" сонины 1994 оны 257,258, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

ҮРИЙН ТАРИАЛАНГИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үрийн тариалаанд заавал даатгуулахтай холбогдсон даатгалын компани болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Үрийн тариалангийн даатгалын тухай хууль тогтоомж

2.1.Үрийн тариалангийн даатгалын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Иргэний хууль[2], Даатгалын тухай хууль[3], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."үрийн тариалан" гэдэгт үрийн зориулалтаар ашиглахаар тариалсан үр тариаг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Үрийн тариаланг даатгах

4 дүгээр зүйл. Даатгалын хүрээ.

4.1.Тухайн жилд үр тариа тариалсан нийт талбайн 20 хувийг үрийн тариалан гэж үзэж өмчийн хэлбэр үл харгалзан заавал даатгуулна.

5 дугаар зүйл. Үрийн тариалангийн даатгалын эрсдэл

5.1.Үрийн тариаланг дараахь эрсдэлээс заавал даатгана:

5.1.1.байгалийн эрсдэл: ган, үер, хүчтэй салхи, шуурга, мөндөр, хяруу, цас, цочир хүйтрэл зэрэг;

5.1.2.ургамлын гоц хөнөөлт өвчин;

5.1.3.хөнөөлт шавьж , мэрэгчид;

5.1.4.түймэр.

6 дугаар зүйл. Даатгалын гэрээ, баталгаа

6.1.Үрийн тариалангийн даатгалын гэрээ болон баталгаатай холбогдсон харилцааг Даатгалын тухай хуулийн 9.1; 9.2 - т заасны дагуу зохицуулна.

6.2.Үрийн тариалангийн даатгалын гэрээг тариалсан талбайн хэмжээ, байршлын зургийг үндэслэн тариалалт дууссан өдрөөс хойш 20 хоногийн дотор байгуулна.

7 дугаар зүйл. Даатгалын хураамж

7.1.Үрийн тариаланг заавал даатгуулах даатгалын хураамж нь даатгалын үнэлгээний 8.0 хувь байна.

8 дугаар зүйл. Даатгалын нөхөн олговор

8.1.Үрийн тариалангийн даатгалын нөхөн олговрын хэмжээ нь үрийн тариалангийн даатгалын үнэлгээний 80.0 хувьтай тэнцүү байна.

8.2.Үрийн тариаланд хохирол учирсан нь тогтоогдсон бол даатгагч энэ тухай дүгнэлт гаргасан өдрөөс хойш 21 хоногийн дотор даатгалын нөхөн олговор даатгуулагчид олгоно.

[1] Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

[2] Иргэний хууль-"Ардын эрх" сонины 1994 оны 257, 258; 1995 оны 1,2; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

[3] Даатгалын тухай хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1998 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

8.3.Үрийн тариалангийн даатгалын нөхөн олговортой холбогдсон харилцааг Даатгалын тухай хуулийн 13.1, 13.2, 13.3, 13.4, 13.5, 13.6, 13.7.5, 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.13, 13.14, 13.15-д зааснаар зохицуулна.

8.4.Даатгалын тохиолдол үүсэзгүйн улмаас даатгуулагч хоёр жил дараалан нөхөн олговор аваагүй бол даатгагч гурав дахь жилээс эхлэн нөхөн олговор аваагүй жил тутамд тухайн жилийн даатгалын хураамжийн хэмжээг 25.0 хувиар бууруулан тооцно. Иймэхүү бууруулан тооцсон нь энэ хуулийн 8.1-д заасан нөхөн олговрын хэмжээнд нөлөөлөхгүй.

8.5.Даатгалын байгуулагч нь үрийн тариалангийн заавал даатгалаас татгалзах эрхгүй бөгөөд даатгалын эрсдэлийг бүрэн буюу хэсэгчлэн давхар даатгуулж болно.

8.6.Энэ хуулийн 5.1-д заасан эрсдэл тухайн даатгалын компанид даатгагдсан нийт талбайн 70-аас дээш хувьд тохиолдсоны улмаас даатгагч нь нөхөн олговрыг бүрэн нөхөн төлж чадахгүй болсон нь тогтоогдсон нөхцөлд нөхөн олговрын зөрүүг Засгийн газар хариуцна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

9 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Даатгагч энэ хуулийн 8.1-д заасан нөхөн олговрыг энэ хуулийн 8.2-т заасан хугацаанд олгоогүй буюу олгохоос зайлсхийсэн бол шүүгч учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хугацаа хэтэрсэн хоног тутамд олгоогүй буюу дутуу олгосон төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алданги ногдуулна.

9.2.Энэ хуулийн 4.1-д заасны дагуу үрийн тариаланг даатгуулаагүй бол даатгалын улсын байцаагч энэ хуулийн 7.1-д заасан хураамжийг нөхөн төлүүлж, гэм буруутай иргэнийг 10000-25000 хүртэл, албан тушаалтныг 10000-40000, хуулийн этгээдийг 50000-200000 төгрөгөөр торгоно.

10 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

10.1. Энэ хуулийг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улаанбаатар хот

КОНВЕНЦИ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бонн хотноо 1979 онд батлагдсан "Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай Конвенци"-ийг үлээн зөвшөөрч, түүнд нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 42

Зарим байгууллагын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гишүүдийн өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Д.Дашпүрэвийг Нийгмийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Төрийн байгууллатын байнгын хорооны гишүүнээр, Улсын Их Хурлын гишүүн Р.Одонбаатарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Улаанбаатар хот

Дугаар 45

Бүгд Найрамдах Салвадор Улстай дипломат харилцаа тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: харилцаа тогтоосугай.

Бүгд Найрамдах Салвадор Улстай дипломат

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Дугаар 47 Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас 1999 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль"-ийн төсөл нь одоо үйлчилж байгаа Нийгмийн даатгалын тухай хуулийн зарим заалттай зөрчилдөж байна гэж үзэх уг төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Дугаар 48 Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас 1998 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төсөл нь үзэл баримтлалын хувьд зөв боловч тэтгэвэрт гарсан нийт иргэдэд хамаарал багатай, тэтгэвэр ямар хэмжээгээр нэмэгдэх, түүнийг тооцох нөхцөл, журам тодорхойгүй, тэтгэврийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдон гарах төсөв, санхүүгийн зардлын судалгаа, тооцоо хангалттүй байгаа тул уг төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 51 Улаанбаатар хот

Засгийн газарт үүрэг өгөх тухай

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналын дагуу Монгол Улсын Ерөнхий сайд Ж. Наранцацралтын ОХУ-ын Засгийн газрын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогчид хаяглаж илгээсэн захидлын тухай асуудлыг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Монгол Улсын Ерөнхий сайд Ж. Наранцацралтаас Монгол Улсын хууль, төрийн албан хэргийн хөтлөлтийн журам зөрчиж 1999 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр ОХУ-ын Засгийн газрын Ерөнхий сайдын нэгдүгээр орлогчид илгээсэн захидал нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн, үндэсний эрх ашигт нөлөөлөх хохирол учруулахуйц үйл ажиллагаа болсон байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн" 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ж. Наранцацралт/-т даалгасугай:

1/Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ОХУ-ын өмчлөлд ногдох хувийн хувьчлал нь"Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагааны тухай" Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн Засгийн газрын хоорондын 1991 оны хэлэлцээрийн хорин нэгдүгээр зүйлийн "Хэлэлцэн тохирогч Тал тус бүр Хамтарсан үйлдвэрийн Дүрмийн сан дахь хөрөнгийн өөрт ногдох хэсгийг хэлэлцэн тохирогч нөгөө Талтай зөвшөөрөлцсөнөөр сонирхогч бусад Талуудад бүрэн хэмжээгээр, эсвэл хэсэгчлэн худалдах эрхтэй. Тэгэхдээ энэхүү хөрөнгийг худалдан авах давуу эрхийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талд олгоно." гэсэн заалттай нийцэж явагдсан байх ёстой гэсэн Монгол Улсын өмнөх Засгийн газруудын барьцтаж байсан бүрэн суурь хэвээр байгаа дахин нотолж, ОХУ-ын Засгийн газар, холбогдох байгууллагуудад нэн яаралтай мэдэгдэх;

2/ энэ тогтоолын 1 дэх хэсэгт даалгасныг хэрхэн хэрэгжүүлсэн талаар Улсын Их Хуралд 1999 оны 7 дугаар сарын 19-ний дотор танилцуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо /Да. Ганболд/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг 1999 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 52** **Улаанбаатар хот**

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 36 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайд Ж. Наранцацралтаас 1999 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Оросын Холбооны Улсын Засгийн газрын Ерөнхий сайдын орлогчид хаяглан захидал бичсэн нөхцөл байдал, үүнээс үүсч болох үр дагаврыг шалгаж тодруулах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

1. Ц. Төмөртогоо –УИХ-ын гишүүн

Гишүүд:

2. С. Төмөр –УИХ-ын гишүүн

3. Л. Лувсан-Очир –УИХ-ын гишүүн

2. Шалгаж тодруулсан дүнг Улсын Их Хуралд танилцуулахыг ажлын хэсэг /ахлагч Ц. Төмөртогоо/-т даалгасугай.

3. Энэ тогтоолыг 1999 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 5-ны өдөр **Дугаар 115** **Улаанбаатар хот**

Зарим аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчийн тухай

1. Монгол Улсын "Шүүхийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг т заасан бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан 1 дүгээр хавсралтад дурдсан аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн шүүгчдийг тус тусын шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчийг томилох хүртэл "Шүүхийн тухай хууль"- ийн 6 дугаар зүйлийн 7, 27 дугаар зүйлийн 1,29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тухайн шүүхийн ерөнхий шүүгчийг орлож байхыг 2 дугаар хавсралтад дурдсан шүүгч нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

Монгод Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 115 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт

1. Архангай аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Дугажийн Дамдиндорж
2. Баян-Өлгий аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Зодогийн Нацаг
3. Баянхонгор аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Ламжавын Цэдэндамба
4. Дорноговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Лувсангийн Баяраа
5. Дорнод аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Тэрбишийн Энхтуяа
6. Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Дуламын Пунцаг
7. Өвөрхангай аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Пагамын Адьяасүрэн
8. Өмнөговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Цэвэгмэдийн Сумъяа
9. Сүхбаатар аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Дамдинсүрэнгийн Гансүх
10. Төв аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Цэрэндоржийн Рашзэвэг
11. Ховд аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Доржийн Тайванхүү
12. Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч Балжирын Пүрэвдорж
13. Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Силамын Сайран
14. Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Дамдинсүрэнгийн Нацаг
15. Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Баянтөгсийн Намхайдорж
16. Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн Ерөнхий шүүгч Намхайн Цогоо
17. Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Гомбын Лхагвамаа
18. Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Содномтүнрэвийн Буд
19. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Содномбалжирын Цоодол
20. Увс аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч Жаргалын Сүрэнжав
21. Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Тавхайн Жигжидсүрэн
22. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Базарсүрэнгийн Сарантуяа
23. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Тогтохын Уранцэцэг
24. Нийслэлийн Хан-уул дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Лхамжавын Сарангэрэл
25. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Даваахүүгийн Мөнхтуул

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 115 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт

1. Архангай аймгийн шүүхийн шүүгч Дугажийн Дамдиндорж
2. Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгч Зодогийн Нацаг
3. Баянхонгор аймгийн шүүхийн шүүгч Ламжавын Цэдэндамба
4. Дорноговь аймгийн шүүхийн шүүгч Лувсангийн Баяраа
5. Дорнод аймгийн шүүхийн шүүгч Тэрбишийн Энхтуяа
6. Орхон аймгийн шүүхийн шүүгч Дуламын Пунцаг
7. Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгч Пагамын Адьяасүрэн
8. Өмнөговь аймгийн шүүхийн шүүгч Цэвэгмэдийн Сумъяа
9. Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгч Дамдинсүрэнгийн Гансүх
10. Төв аймгийн шүүхийн шүүгч Цэрэндоржийн Рашзэвэг
11. Ховд аймгийн шүүхийн шүүгч Доржийн Тайванхүү
12. Нийслэлийн шүүхийн шүүгч Балжирын Пүрэвдорж
13. Баян-Өлгийн аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Силамын Сайран
14. Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Дамдинсүрэнгийн Нацаг
15. Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Баянтөгсийн Намхайдорж
16. Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгч Намхайн Цогоо
17. Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгч Гомбын Лхагвамаа
18. Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Содномтүнрэвийн Буд
19. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч Содномбалжирын Цоодол
20. Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Жаргалын Сүрэнжав
21. Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгч Тавхайн Жигжидсүрэн
22. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч Базарсүрэнгийн Сарантуяа
23. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч Тогтохын Уранцэцэг
24. Нийслэлийн Хан-уул дүүргийн шүүхийн шүүгч Лхамжавын Сарангэрэл
25. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч Даваахүүгийн Мөнхтуул

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Дугаар 116 **Улаанбаатар хот**

Прокурорын эрэгч дэв олгох тухай

"Монгол Улсын Прокурорын байгуулагын тухай хуулъ"-ийн 36 дугаар зүйлийн 1,2 дахь хэсгийг үндэслэн Улсын ерөнхий прокурор М.Атанхүягт "Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх", Улсын ерөнхий прокурорын орлогч Ц.Жамъянсэнгээд "Төрийн хууль цаазын шадар зөвлөх"-ийн эрэгч дэвиг тус тус олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Засгийн газрын 1999 оны 79 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам
(Үндэсний хөтөлбөр)

Төгсгөл. Түрүүч нь №30-д нийтлэгдсэн.

Гурав. Хяналт, зохицуулалт

10.Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг улс үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулах үүрэг бүхий иргэний нисэхийн аюулгүй байдлын Үндэсний зөвлөл /цаашид Зөвлөл гэнэ/ ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг Засгийн газар батална.

11.Олон улсын нисэх буудал дээр аюулгүй байдлын асуудлаар нисэх буудлын захиргаанд зөвлөх үүрэг бүхий Нисэх буудлын аюулгүй байдлын хороо /цаашид Хороо гэх/ ажиллана. Хорооны бүрэлдэхүүн, дүрмийг нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрт тусгасан байна.

12. Хэвлэл, мэдээллийн төлөөлөгч нь иргэний нисэхийн эрэгч гарсан хөндлөнгийн хууль бус үйлдэлтэй холбоотой аливаа мэдээллийг холбогдох төлөөлөгчөөр дамжуулж авна.

13.Монгол Улс өөрийн иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрөө аль нэг улсын хүсэлтийн дагуу танилцуулж болох бөгөөд олон улсын иргэний нисэхийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх зорилгоор аль нэг улстай туршлага солилцож, хамтран ажиллаж болно.

Аль нэг улсын хүсэлтээр тухайн улсын агаарын тээврийн компанийн гүйцэтгэж байгаа тодорхой чиглэлийн нислэгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон арга хэмжээ авч болно.

Аль нэг улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюул занаалхийж байгаа талаар олж авсан мэдээлэлэ үнэн зөв болох нь тогтоогдсон нөхцөлд Ерөнхий газар тухайн улсын эрх бүхий байгууллагад энэ тухай яаралтай мэдэгдэнэ.

14. Монгол Улсын Засгийн газар иргэний нисэхийн аюулгүй байдлын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагыг томилсон тухайгаа Олон улсын иргэний нисэхийн байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

Иргэний нисэхийн үйл ажиллагааны эсрэг гарсан хөндлөнгийн хууль бус үйлдлийн тухай тайланг Монгол Улс Олон улсын иргэний нисэхийн байгууллагад тогтмол хүргүүлнэ.

Дөрөв. Хамгаалагдсан бүс тогтоох ба тэдгээрт нэвтрэх

15.Ерөнхий газар нь нисэх буудлын захиргаа болон холбогдох бусад байгууллагатай хамтарч иргэний нисэхийн аюулгүй байдлыг тасралтгүй хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах бүсийг тогтоож, бүсийн бүдүүвч зургийг батлах бөгөөд энэхүү бүсийг хамгаалагдсан бүс гэж тодорхойлно.

Хамгаалагдсан бүсэд нэвтрэх журмыг холбогдох эрх зүйн актаар зохицуулна.

Хамгаалагдсан бүсүүдийг Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлберт тодорхой заасан байна.

Нисэх буудлын гадна орших хамгаалагдсан бүсэд дараахь тоног төхөөрөмжийг байрлуулсан талбай бартана. Үүнд:

- радиолокатор
- навигацын хэрэгслүүд / ILS. VOR, NDB /
- хэрэглэлийн суултын систем /ILS-Instrument Landing System/
- хэт богино давтамжийн чиглүүлэх станц /VOR-VHF Omnidirectional Radio Range/
- чиглүүлэх станц /NDB-Nondirectional Radio Beacon/
- хэт богино давтамжийн станц /VHF-Very High Frequency/
- УКВ-алсын удирдлагатай хэт богино давтамжийн станц.

16.Хамгаалагдсан бүс нь нийтийн эзэмшлийн бүсээс хашаа хамгаалалтаар тусгаарлагдсан

байх бөгөөд түүний бүрэн бүтэн байдал, тэдгээрт зөвшөөрөлгүй нэвтрэн орох аливаа оролдлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг нисэх буудлын захиргаа авна.

17. Хамгаалагдсан бүсэд хувь хүмүүсийг нэвтрүүлэхдээ дараах журмыг баримтална:

а/ агаарын хөлгөөр зорчигчоос паспорт буюу иргэний үнэмлэх, агаарын тээврийн компаниас олгосон нислэгийн тийз болон суугчийн тасалбар (уг тасалбар дээр зорчигчийн овог нэрийг бичсэн байх шаардлагатай).

б/ бусад хүмүүсээс хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэх.

18.Хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэхийг нисэх буудлын аюулгүй байдлын албанаас олгоно. Үнэмлэхэд дор дурьдсан зүйлийг тусгасан байна:

а/ үнэмлэх эзэмшигчийн зураг, овог нэр, эрхэлж буй ажил, албан тушаал;

б/үнэмлэхний хүчинтэй хугацаа;

в/тухайн үнэмлэх хүчин төгөлдөр үйлчлэх бүс. Нэвтрэх үнэмлэхийг тухайн эзэмшдэд үнэмлэх олгуулахаар холбогдох байгууллагаас бичгээр иргүүлсэн хүсэлтийг үндэслэн олгоно.

19.Нисэх буудлын аюулгүй байдлын албан хамгаалагдсан бүсэд тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх журмыг тогтоож, хэрэгжилтэд нь хяналт тавина.

Тээврийн хэрэгсэлд нислэгийн талбайд нэвтрэх зөвшөөрөл олгохдоо тодорхой хязгаарлалт тогтоох бөгөөд нэвтрэх зөвшөөрөлд дараахь зүйлүүдийг тусгасан байна:

а/тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар;

б/тээврийн хэрэгслийг эзэмшигч /ашиглагч/-ийн таних тэмдэг, тодорхойлолт;

в/хүчинтэй хугацаа;

г/тухайн нэвтрэх зөвшөөрөл хүчин төгөлдөр үйлчлэх бүс.

Тав. Үзлэг хийх

20. а. Аюулгүй байдлын алба нь агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болохуйц аюултай зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис г.м.) авч орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш болон ачаанд иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан зааврын дагуу үзлэг хийнэ.

б.Үзлэгийн болон үзлэгийн дараахь бус рүү нэвтэрч буй үзлэгээс чөлөөлөгдөөгүй хүн бүр үзлэгт хамрагдаж , биедээ авч яваа эд зүйлийг шалгуулна. Үзлэгийн дараахь бүсэд худалдах бараа таваар, тэнд ажилладаг хүмүүс дээрх зааврын дагуу үзлэгт хамрагдана.

в. Үзлэгт хамрагдсан зорчигчдыг тусгайлан бэлтгэсэн үзлэгийн дараахь бүсэд байрлуулна.

г.Үзлэг хийхэд металл илрүүлэгч, рентген туяаны аппарат зэрэг зөвшөөрөгдсөн тоног төхөөрөмжийг ашиглана.

д. Үзлэгийн дараахь бүсэд үзлэгт ороогүй хүмүүс нэвтэрсэн нь тогтоогдвол зорчигч, тэдгээрийн гар тээшинд сонгох замаар үзлэг хийнэ.

е. Үзлэгийн үеэр илэрсэн аюултай бодис болон эд зүйлийг хураан авч агаарын хөлгийн ачааны хэсэгт тээвэрлэх ба аяллын эцэст зорчигчид эргүүлэн өгч болох бөгөөд энэ талаарх журмыг агаарын тээврийн компаний аюулгүй байдлын хөтөлбөрт тусгасан байна.

ж. Үзлэг хийлгэхээс татгалзсан зорчигчийг агаарын хөлгөөр тээвэрлэхгүй.

21. Нисэх буудлын захиргаа, агаарын тээврийн компани нь дамжин өнгөрөх, шилжин суух зорчигч нь агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон бодис болон эд зүйл агаарын хөлгөт авч орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ /үзлэгээр ороогүй хүмүүстэй уялуулахгүй байх г.м./ авна.

22. Нисэхийн аюулгүй байдлыг ханган зорилгоор үзлэгийн дараахь бүсэд нэвтэрч буй нисэх багийн гишүүд, нисэх буудлын ажилтан болон бусад хүмүүс, тэдгээрийн гар тээшинд зорчигчдын нэг адил үзлэг хийнэ.

23. Дор дурдсан тохиолдолд үзлэг хийхдээ тусгай журам баримтална.

а. Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн Конвенци /36-р зүйл/-д заасны дагуу дипломат эрх бухий этгээд, түүний гар тээш, тээшинд үзлэг хийх тохиолдолд өөрийг нь, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулна.

б. Зохих журмын дагуу лацадсан дипломат илгээмжинд үзлэг хийхгүй.

в. Төрийн нууцын зэрэглэлтэй ачаанд тусгай багаж төхөөрөмжийн тусламжтайгаар үзлэг хийнэ.

г. Монгол Улсын Засгийн газрын урилгаар тус улсад албан ёсны айлчлал

хийж буй гадаад улсын төрийн төргүүн /эзэн хаан, ерөнхийлөгч/, Засгийн газрын төргүүн, парламентын гишүүн, сайд нарыг аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлнө. Харин тэдгээрийг дагалдан яваа хүмүүс / гэр бүлийнхэн, хувийн үйлчлэгч г.м./ -т нисэх буудлын тусгай өрөөнд үзлэг хийнэ.

д. Монгол Улсын Засгийн газрын урилгаар тус улсад айлчилж буй гадаадын зочид, тэдгээрийг дагалдан яваа хүмүүс/гэр бүлийнхэн, хувийн үйлчлэгч г.м./-т нисэх буудлын тусгай өрөөнд үзлэг хийнэ.

Хэрэв тус улсад айлчилсан гадаадын зочин иргэний нисэхийн тогтмол нислэгээр аялах бол түүнд болон түүнийг дагалдан яваа хүмүүс, ачаа тээшинд нь хийх үзлэгийг байрлаж байсан байранд нь, эсхүл нисэх буудлын тусгай өрөөнд хийнэ.

е. Их хэмжээний үнэт зүйл авч яваа, тахир дутуу, эсхүл зүрхний аппараттай зорчигчдод тусад нь үзлэг хийнэ. Үзлэгийг тусгай рентген, гар металл илрүүлэгч багаж хэрэгсэл ашиглаж болно.

24. Тус улсад хувийн айлчлал хийж буй гадаадын зочид ердийн журмын дагуу үзлэгт хамрагдана.

25.Агаарын хөлгийн бүхээгт зэвсэг тээвэрлэхийг хориглох бөгөөд зэвсгийг тээшинд хийж тээвэрлэж байгаа тохиолдолд тээшний гадна талд ямар нэгэн тэмдэглэгээ хийхийг хориглоно.

26. Хууль хяналтын байгууллагын ажилтны харгалзан хүргэж яваа этгээдийн талаар агаарын тээврийн компани нь нислэг үйлдэхээс өмнө мэдсэн байх шаардлагатай бөгөөд энэ талаар нарийвчилсан мэдээллийг нисэх багийн даргад урьдчилан танилцуулна.

Гэмт этгээдийг зөвхөн харгалзагчтай нөхцөлд тээвэрлэх бөгөөд нэг нислэгээр тээвэрлэх гэмт этгээдийн тоо 2-оос илүүгүй байна.

27. Агаарын тээврийн компани нь бүртгэгдсэн тээшийг зөвхөн тийзтэй зорчигч, эсхүл нисэх буудлаас эрх олгогдсон ажилтнаас хүлээж авна. Бүртгэгдсэн тээш нь аяллын төгсгөл хүртэл агаарын тээврийн компаний хамгаалалтанд байна.

Зорчигч (үүнд шилжин суух, дамжин өнгөрөх зорчигч орно)-ийн бүртгэгдсэн тээшинд үзлэг хийх журмыг нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлберт тусгана.

28. Агаарын тээврийн компани болон ачаа илгээгч бүх төрлийн ачаа, шуудангаарын хөлөгт ачихаас өмнө аюулгүй байдлыг ханган зорилгоор шалгалт хийнэ.

Тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, шуудангийн хадгалалт, тэдгээрт тавих хяналтыг нисэх буудал болон агаарын тээврийн компани хариуцана.

Зургаа. Иргэний нисэхийн аюулгүй байдлын талаар мэдээлэл цуглуулах, тараах

29.Ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг аюул заналхийллийн тухай мэдээлэл олж авах арга зам болон мэдээлэлд тавигдах шаардлагыг тодорхойлно.

30.Ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүй байдлын талаар дор дурьдсан мэдээллийг тараана. Үүнд:

а/ онцгой аюул заналхийллийн талаархи мэдээлэл / энэ аюул заналхийлэл нь иргэний нисэхийн үйл ажиллагааны эсрэг, эсхүл тодорхой нэг нисэх буудал, агаарын тээврийн компани, зорчигчийн эсрэг чиглэсэн байх/ .

б/ аюулгүй байдлын талаархи мэдээлэл

31.Дор дурьдсан байгууллагууд иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн аюул заналхийллийг үнэлж дүгнэнэ:

а/ Иргэний нисэхийн ерөнхий газар;
б/ Агаарын тээврийн компани;
в/ Нисэх буудлын захиргаа.

Агаарын тээврийн компани, нисэх буудлын захиргаа нь өөрийн саналыг Ерөнхий газраар дамжуулж тавина.

Долоо. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд гарсан хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаар мэдэгдэх

32. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд энэ талаар:

1/ тухайн агаарын хөлгийг буртгэсэн улсад;

2/ тухайн агаарын хөлгийг ашиглаг улсад;

3/ хууль бус ажиллагааны улмаас нас барсан, шархадсан, эсхүл барьцаалагдсан хүн байгаа бол тэдгээрийн харьяалах улсад;

4/ хууль бус ажиллагаанд өртсөн агаарын хөлөгт байсан иргэдийн харьяалах улсад тус тус мэдэгдэнэ.

33. Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд Монгол Улс Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдээллийг дор дурьдсан хугацаанд хүргүүлнэ:

а/ хөндлөнгийн хууль бус үйлдлийн тухай анхны мэдээллийг тухайн үйл явдал болсноос хойш 30 хоногийн дотор;

б/ хөндлөнгийн хууль бус үйлдлийн тухай эцсийн мэдээллийг тухайн үйл явдал болсноос хойш 60 хоногийн дотор.

Найм. Иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалт

34.Нисэх буудал болон агаарын тээврийн компани нь өөрийн аюулгүй байдлын ажилтны ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын хөтөлбөр боловсруулж Ерөнхий газраар баталгаажуулах бөгөөд сургалтын хөтөлбөр нь энэхүү хөтөлбөрийн зорилт, шаардлагыг хангасан байхын зэрэгцээ дараахь асуудлуудыг тусгасан байна:

а/сургалтанд хамрагдах хүмүүсийн гүйцэтгэх үүрэг, хариуцлага;

б/ сургалтанд шаардагдах материал, тоног төхөөрөмж, гарын авлага;

в/ нисэх багийнханд зориулсан сургалт.

35. Нисэх буудал болон агаарын тээврийн компани нь нисэхийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагаанд ямар нэг хэмжээгээр оролцдог хүмүүст зориулж тэдний иргэний нисэхийн аюулгүй байдлын талаархи ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулна

36.Нисэх буудал болон агаарын тээврийн компани нь иргэний нисэхийн эсрэг гарсан хөндлөнгийн хууль бус үйлдлийг таслан зогсоох зорилго бүхий иргэний нисэхийн аюулгүй байдалтай холбогдсон дасгал сургуулийн хөтөлбөр боловсруулах бөгөөд богино хугацааны дасгал сургуулийн хөтөлбөрийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан сургалтын багц хөтөлбөрт нийцүүлэн боловсруулна.

Ес. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд гарсан хөндлөнгийн хууль бус үйлдлийн эсрэг авах арга хэмжээ

37. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд гарсан хөндлөнгийн хууль бус үйлдлийн эсрэг авах арга хэмжээг Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан "Иргэний нисэхийн эсрэг гарсан хөндлөнгийн хууль бус үйлдлийн эсрэг авах арга хэмжээ"-ний зааварчилгын дагуу зохион байгуулна.

38. Дээрх зааварчилгад агаарын хөлгийг булаан авсан үйлдлийг таслан зогсоох арга хэмжээний төлөвлөгөө болон уг арга хэмжээнд оролцох байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүргийг тодорхой тусгана.

39. Дээрх зааварчилгад агаарын хөлөг, нисэх буудал, агаарын хөлгийг удирдах навигацын тоног төхөөрөмжийн ойр орчимд тэсрэх бөмбөг болон бусад тэсрэх төхөөрөмж байрлуулахаар сурдүүлэх үед авах арга хэмжээг хэрхэн зохион байгуулах, уг арга хэмжээнд оролцох байгууллагуудын үүрэг хариуцлагыг нарийвчлан заана.

Арав . Аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хөрөнгийн эх үүсвэр

40.Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн хөрөнгийн эх үүсвэрийг Ерөнхий газрын жил бүрийн төсөвт тусгаж, эх үүсвэр, зарцуулалтыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын баримт бичиг (Doc 8973/5, Doc 9184, Doc 9562, Doc 9082)-үүдэд заасан зарчмыг баримтлан гаргана.

Засгийн газрын 1999 оны 79 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөл (цаашид "Зөвлөл" гэнэ) нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах, түүнийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааг улс үндэсний хэмжээнд уялдуулан зохицуулна.

2.Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газар батална. Зөвлөлийг Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайд тэргүүлнэ.

3.Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний нисэхийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрхийн актуудыг дагаж мөрдөнө.

4.Зөвлөлийн өдөр тутмын болон техник хангалтын үйл ажиллагааг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн хариуцна.

5.Зөвлөл нь холбогдох хууль тогтоомж, энэ дүрмээр олгогдсон үүрэг зорилтоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хурлаараа хэлэлцэж эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн албан даалгавар гаргах бөгөөд протокол хөтөлнө.

6.Зөвлөлөөс эрх хэмжээнийхээ дагуу гаргасан шийдвэрийг төв, орон нутгийн төрийн захиргааны бүх шатны холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн бүрэн эрх

7.Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/агаарын хөлгийг булаан авах, авч зугтаах болон иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдсон хөндлөнгийн аливаа хууль бус үйлдлийн үед бий болсон онцгой нөхцөл байдлыг зохицуулах, шийдвэр гаргах;

б/барьцаалах замаар агаарын хөлгийг булаан авах, авч зугтаах тохиолдолд нисэх буудлын аюулгүй байдлын хорооны үйл ажиллагааг удирдах;

в/иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдлыг хангуулах асуудлаар Иргэний нисэхийн ерөнхий газарт зөвлөлгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

г/иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

д/иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах тогтолцооны үзэл баримтлалыг боловсруулах;

е/нисэхийн аюулгүй байдлын асуудлаар эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актын төсөл, мөн иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох тухай санал зэргийг зохих журмын дагуу Засгийн газарт оруулж хэлэлцүүлэх;

ж/иргэний нисэхийн үйл ажиллагаанд гарч болзошгүй хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсоох, түүний хор уршгийг арилгахад иргэний нисэхийн байгууллага, аж ахуйн нэгжийн хүч, хэрэгслийг татан оролцуулах, иргэний нисэхийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны уялдаа хангах.

8.Зөвлөл нь иргэний нисэхийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хууль бус үйлдэл хийхээр заналхийлэх, түүнчлэн агаарын хөлгийг булаан авах, авч зугтаах явдалтай холбогдсон онцгой нөхцөл байдлыг зохицуулахад тодорхой нэг нисэх буудлын аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээ авах.

9.Зөвлөл нь иргэний нисэхийн аюулгүй байдлын хэм хэмжээг мөрдөөгүй Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээдийн эзэмшлийн агаарын хөлгийн нислэгийг зогсоох тухай шийдвэр гаргана.

10.Агаарын хөлгийг булаан авсан, авч зугтаасан, түүнчлэн иргэний нисэхийн үйл ажиллагаан дахь хөндлөнгийн хууль бус бусад үйлдлийг магадлан шалгах комиссыг зөвлөл байгуулна.

Гурав. Бусад зүйл

11.Зөвлөлийн хурлыг хагас жилд 1-ээс доошгүй удаа хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн даргын, даргын эзгүйд орлогч даргын шийдвэрээр хурлыг зарлан хийлгэж болно.

12.Зөвлөлийн хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудал болон түүнтэй холбоотой материалыг тухайн асуудлыг хариуцсан байгууллага, албан тушаалтан бэлтгэж зөвлөлийн хурал болохоос 5 хоногийн өмнө зөвлөлд ирүүлсэн байна.

13.Зөвлөлийн хуралд техникийн шинжээч, мэргэжилтнүүдийг урьж оролцуулж болно.

14.Зөвлөл нь ажлынхаа тайланг жил бүрийн 2 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байна.

15.Зөвлөлийн шийдвэрийг биелүүлээгүй буюу иргэний нисэхийн аюулгүй байдлын журмыг зөрчсөн албан тушаалтанд захиргааны шийтгэл ногдуулах тухай саналыг зөвлөл холбогдох эрх бүхий албан тушаалтан, байцаагчид тавьж болно.

Засгийн газрын 1999 оны 79 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	- Дэд бүтцийн хөгжлийн сайд
Орлогч дарга	- Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
Гишүүд:	-Улсын аюулгүй байдлыг Хангах газрын дарга; -Улсын ерөнхий прокурорын орлогч (харилцан тохиролцсоноор); -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Иргэний нисэхийн ерөнхий газрын захирал; -Хилийн цэргийг удирдах газрын дарга; -Цагдаагийн ерөнхий газрын дарга; -Гаалийн ерөнхий газрын дарга; -Улсын иргэний хамгаалалтын газрын дарга; -Улсыг агаарын довтолгооноос Хамгаалах цэргийн командлагч.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 81** **Улаанбаатар хот**

Буудайн элеваторын тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ гурил-тэжээл" хувьцаат компанийн 18000 тонн буудай агуулах хүчин чадал бүхий "С" элеваторыг шинэчилсэн үнэзр нь тус компанийн 1994 онд авсан төсөв болон хөдөө аж ахуйн сангийн зээлийн ерийн зарим хэсэгт тооцон авахыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт зөвшөөрсүгэй.

2."С" элеваторыг шинэчилсэн үнэзр нь тус компанийн 1994 онд авсан төсөв болон хөдөө аж ахуйн сангийн зээлийн ерийн зарим хэсэгт тооцон авах асуудлыг тус компанийн эрх барих байгууллагад тавьж шийдвэрлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригтод даалгасугай.

3.Элеваторыг зээлийн ерөнд авсны дараа "Буудай" санд зээмшүүлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий Сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Сангийн сайд **Я.ОЧИРСҮХ**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд **Ч.СОДНОМЦЭРЭН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 82** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Агаарын тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Агаарыг хамгаалах хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралтын, "Агаарыг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагдсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Байгаль орчны сайд С.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 1999 оны 82 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АГААРЫГ ХАМГААЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Өнөөгийн байдал

Агаар нь хүн болон аливаа амьд биетийн амьдралын зайлшгүй хэрэгцээ бөгөөд түүнийг өөр зүйлээр орлуулах ямар ч боломжгүй билээ.

Дэлхийн хүн ам олширч үйлдвэрлэл,үйлчилгээ өргөжсөнөөс янз бүрийн бохирдуулах бодис агаарт их хэмжээгээр гаргах болсон нь агаарын цэвэр, ариун чанарыг алдагдуулж байгаа төдийгүй озоны давхаргыг гэмтээх зэрэг агаарын бүтцийг эвдэх аюул учруулахад хүрч байна.

Агаар нь амьсгалын замаар хүний бие, эрүүл мэндэд шууд нөлөөлөхийн хамт цацраг идэвхжил, химийн хорт бодисыг богино хугацаанд их хэмжээний газар тараах орчин болдог.

Манай улсын хүн амын 55 орчим хувь нь хот, суурин газар оршин суух байна. Үйлдвэрлэл, үйлчилгээ төвлөрч, хүн ам харьцангуй нягт суурьшсан Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Чойбалсан, Мөрөн, Сүхбаатар зэрэг хот, суурин газрын агаар, орчны бохирдолтын түвшин бусдаас өндөр байна.

Сүүлийн жилүүдийн ажиглалт, судалгаанаас үзэхэд Улаанбаатар, Дархан хотод хүхэрлэг хийн агууламж, Улаанбаатар, Эрдэнэт хотод азотын давхар исэл болон нүүрстөрөгчийн дутуу исэл, Улаанбаатар, Багануурт агаарын тоос нэмэгдэх хандлагатай байна.

1998 оны байдлаар авто техникийн улсын үзлэгээр тоологдсон бүх төрлийн 71490 автомашины бараг 50 хувь нь 10-аас дээш жил эдлэгдсэн хүүчин машин байгаа бөгөөд трактор, өөрөө явагч хэрэгсэл, мотоцикл 37105 байна.

Нийслэлийн гурван дулааны цахилгаан станц, түүний 65 га талбайтай үнсэн сан, 150 шахам уурын зуух, гэр хорооллын 60 гаруй мянган өрхийн ердийн галлагаатай зуух, түүнчлэн газрын эвдрэл, үйлдвэрлэлийн явц, үйл ажиллагаанаас үүссэн шороо тоос, 500 мянган шоо метр хог хаягдал бүхий хогийн цэгүүд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг нэмэгдүүлэх гол эх үүсвэр болж байна.

Судалгаанаас үзвэл дулааны цахилгаан станцуудаас 62 мянган тонн, уурын зуухнаас 10 мянган тонн, тээврийн хэрэгслээс 50 орчим мянган тонн, гэр хорооллоос 9 мянган тонн агаар бохирдуулах бодис жил бүр нийслэлийн агаарт хаягдаж байна. Өвлийн их ачаалалтай галлагааны үед дулааны цахилгаан станцуудаас цагт дунджаар 60 гаруй тонн үнсийг үнсэн санд, 4 тонн үнс, 4,5 сая шоометр утаа, 6 кг хүхэрлэг хийг агаарт хаядаг байна.

Авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс ялгаран гарч буй утаа нь хүний амьсгалах түвшинд ойр зайд буюу 0,2 м өндөрт цацагдаг бөгөөд түүний найрлагад хүний амьсгалын замын цочмог болон архаг өвчин, харшлын эмгэг үүсгэх, элэг, бөөр, уушгийг гэмтээх, зүрх судас, мэдрэл сэтгэхүйн системийн эрхтний үйл ажиллагаа

алдагдуулах, амьсгал боох, хорт хавдар үүсгэх үйлчилгээтэй нүүрстөрөгчийн исэл, азотын исэл, нүүрсустөрөгч, хүхэрлэг хий, хөө тортог, хар тугалга, бенз(а)пирен, альдегид зэрэг 200 гаруй төрлийн хорт бодис байдаг.

Хийн мандлын агаарыг бохирдуулагч бодисууд нь хүний бие махбодийн дархлын урвалыг өөрчилж, гадны эмгэг төрүүлэгч нянгуудыг эсэргүүцэх чадварыг сулруулж улмаар хүн амын өвчлөл, ялангуяа харшил үүсэх нөхцөл бүрдүүлдэг.

Ялангуяа нийслэлд өвлийн улиралд газар орчмын салхины хурд бага байдаг учир хотын дээр агаарын температурын тонгоруу тогтож агаарт утаа тортог, элдэв хорт хийн хольцууд нэмэгдэх нэгэн нөхцөл болдог байна.

Сүүлийн арваад жилийн судалгаанаас үзэхэд нийслэлийн хүн амын амьсгалын замын өвчлөл улсын дунджаас олон хувь дээгүүр, хүүхдийн амьсгалын өвчлөл 1980 оноос хойш 3 дахин, насанд хүрэгсдийнх 1,8 дахин ихэссэн, бага насны хүүхдийн өвөрмөц хамгаалах тогтолцооны түвшин бохирдол багатай хот, суурингийнх хүүхдийнхээс доогуур байгаа нь тогтоогдсон байна.

Улаанбаатар хотын цаг агаарын байдалд үнэлгээ хийхэд хүний биед тохиромжтой цаг агаарын нөхцөл жилдээ 270 /79,3%/, харьцангуй тохиромжгүй нөхцөл 64 хоног /17,6%/, бүр тохиромжгүй нөхцөл 31 хоног байдаг байна. Харьцангуй тохиромжгүй, бүр тохиромжгүй нөхцөл ихэвчлэн хавар, намрын агаар хямарсан хоногуудад тохиолддог аж.

Судалгааны үр дүнгээс үзэхэд агаар дахь хүхэрлэг хийн агууламжийн хэмжээ нь амьсгалын замын өвчин гарах тоотой шууд хамааралтай болох нь ажиглагджээ.

2.Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, бодит шаардлага

Агаарыг хамгаалах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагыг дараахь байдлаар тодорхойлж байна:

а/хөгжил нь агаар, ус, хөрс, биологийн орчинд хохирол учруулах, түүнийг эвдэх, устгахад чиглэсэн байх ёсгүй гэсэн тогтвортой хөгжлийн дэлхий нийтийн гол зарчмыг өөрийн оронд хэрэгжүүлэх;

б/монгол орны газар нутгийн хийн мандлын агаар дахь байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөллээс үүсэх агаарын бохирдлооc гадна аж үйлдвэржсэн хоёр том гүрний дунд оршиж байгаа учир хил дамжин ирэх бохирдлын улмаас агаарын чанарт өөрчлөлт орох магадлалтайг харгалзан түүнээс сэргийлэх арга хэмжээ авах;

в/цэвэр агаар нь зөвхөн нэг орны төдийгүй манай дэлхийн амьдралын эх булаг, аливаа амьд биетийн оршин тогтнох зайлшгүй нөхцөл бөгөөд дэлхийн бөмбөрцгийн дулааныг гадагш алдахгүй, нарны хорт туяа, солирын мөргөлтөөс хамгаалах бамбай болж байдаг тул түүнийг хамгаалж цэвэр, ариун байлгах нь улс, үндэстэн, иргэн бүрийн үүрэг мөнийг ухамсарлан, түүнийг хамгаалах талаар бодитой ажил хийх·

г/"Агаарын тухай" Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд заасан агаарыг хамгаалах хөтөлбөр боловсруулан Засгийн газраар батлуулж, хэрэгжүүлэх тухай заалтыг бодит биелэл болгох.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

1.Хөтөлбөрийн зорилго

Хүний эрүүл,аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгод нийцүүлэн агаарыг аливаа бохирдлоос хамгаалах бодлого, үйл ажиллагаа явуулж, агаарыг цэвэр,ариун байлгах нөхцөл бүрдүүлэхэд оршино.

2.Хөтөлбөрийн үндсэн зорилт

Хөтөлбөрийн үндсэн зорилтыг дараахь байдлаар тодорхойлж байна:

а/агаарыг хамгаалах үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, менежментийн зохистой тогтолцоог бий болгох;

б/агаарын чанарын хяналт, шинжилгээний ажлын техник хэрэгсэл, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;

в/агаар хамгаалах арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үндсийг бүрдүүлэх.

3.Хэрэгжүүлэх үе шат, хугацаа

Хөтөлбөрийг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

-1999-2004 онд агаарыг хамгаалах эрх зүйн орчинг бүрдүүлж боловсронгуй болгох, үндэсний стандарт, зөвшөөрөх дээд хэмжээг тогтоох, шинэчлэн боловсруулах, агаар бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийг хэмжих, тодорхойлох багаж, техник хэрэгслээр хангах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад агаар хамгаалах сэтгэлгээг бүрэлдүүлэн төлөвшүүлэх;

-2005-2010 онд үлсын хэмжээнд байгаа бохирдуулагч эх үүсвэр нэг бүрээс агаарт гаргах бохирдуулах бодис болон үзүүлэх физикийн хортой нөлөөллийн төрөл хэлбэр, хэм хэмжээг тогтоон тэдгээрийг татвар, төлбөр, урамшууллын хөшүүргээр бүрэн зохицуулах нөхцөл бүрдүүлэх.

Гурав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтлах зарчим:

а/хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалах бусад хөтөлбөр, нийгэм, эдийн засаг, бүс нутгийг хөгжүүлэх үндэсний бодлого болон НҮБ-ын Орчны хөтөлбөр, олон улсын байгууллагаас агаар хамгаалах талаар баримталж буй бодлого, зөвлөмж, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдан зохицсон байх;

б/хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд терийн болон терийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр оролцуулах нөхцөл бүрдүүлж, тэдний хувь нэмрийг хөхиүлэн дэмжих, агаар хамгаалах хууль тогтоомжийг биелүүлдэг дадал, заншилд сургаж хэвшүүлэх;

в/эхний ээлжинд Улаанбаатар хот, хүн ам төвлөрөн суурьшсан бусад томоохон суурин газрын агаарын бохирдлыг бууруулахад түлхүү анхаарч, бохирдлыг эдийн засгийн хөшүүргээ хэрэглэх замаар багасгаж, "Бохирдуулагч нь төлөх зарчим"-ыг туушталт баримтлахаас гадна хил дамжин ирж буй бохирдолд тавих хяналтыг сайжруулах, өргөжүүлэх.

Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилтууд,үйл ажиллагаа дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

1.Агаарыг хамгаалах үйл ажиллагаог зохицуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх,менежментийн зохистой тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд:

1/терийн захиргааны байгууллагуудаас шийдвэрлэх асуудлууд:

а/агаар бохирдуулсны төлберийн тухай хуулийн тесийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;

б/зөвшөөрегдөх хэмжээнээс хэтрүүлэн агаарт бохирдуулах бодис гаргаж, физикийн хортой нөлөөлөл үзүүлж байгаа эх үүсвэрүүдийн үйл ажиллагааг зохицуулах журмыг Агаарын тухай хуулийн холбогдох заалтын дагуу боловсруулан хэрэгжүүлэх;

в/агаарыг хамгаалах чиглэлээр олон улсын хэмжээнд мөрдөж буй хууль, эрх зүйн баримт бичиг, зөвлөмж, аргачлал, арга туршлагыг судлан нэвтрүүлэх, холбогдох гэрээ, хэлэлцээрт нэгдэн орох үйл ажиллагаог өргөжүүлэх, нэгдэн орсон Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх арга хэмжээ авах;

г/агаарыг хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

д/агаарыг хамгаалахтай холбогдсон хууль, тогтоомжийг боловсронгуй болгож, терийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэд хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавин хариуцлага тооцдог механизм, тогтолцоог бүрдүүлэх;

е/үндэсний стандарт, бохирдуулах бодис, хортой нөлөөллийн зөвшөөрегдөх дээд хэмжээг шинээр боловсруулах, шинэчлэн тогтоох.

2/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, терийн бус байгууллага, олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлага:

а/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын агаарт гаргах бохирдуулах бодис, үзүүлэх физикийн хортой нөлөөллийн хэмжээг хууль тогтоомжид заасны дагуу тогтоолгож, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх;

б/агаарыг хамгаалах тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар олон нийтийн санал хүсэлтийг өргөн авах, мэдээллийн хэрэгслээр тэдгээрийг сурталчлах;

в/агаарыг бохирдуулагч эх үүсвэрт тавих иргэдийн болон бүх нийтийн хяналтыг төрийн хяналттай хослуулан зөрчлийг газар авахуулалгүй зогсоох арга хэмжээ авдаг болж хэвшүүлэх.

2.Агаарын чанарын хяналт, шинжилгээний ажлын техник хэрэгсэл, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

1/төрийн захиргааны байгууллагуудаас шийдвэрлэх асуудлууд:

а/агаарын чанарын хяналт-шинжилгээний цэг сүлжээг өргөтгөх, мэргэжлийн байгуул-лага, ажилтнуудыг техник хэрэгслээр бүрэн хангах;

б/тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт бусад эх үүсвэр болон нефть-химийн бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх цэгүүдийг экологийн магадлан оношилгоо хийх зөөврийн болон суурин лабораторитой, томоохон хот, суурин газрыг агаарын чанарын шинжилгээний нүүдлийн лабора-ториудтай болгох ажлыг зохион байгуулах;

в/агаарыг бохирдуулах эх үүсвэ-рүүдийг дотоодын хяналт-шинжилгээний багаж хэрэгсэлтэй, агаарыг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллуулах асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлүүлэх;

г/агаар бохирдуулагч эх үүсвэрийн дотоодын хяналтын дүн, мэргэжлийн байгууллагын хяналт шинжилгээний үзүүлэлт, экологийн магадлан оношилгооны лабораторийн шинжил-гээний дүгнэлт гурвын нэгдлийг хангах үндсэн дээр агаар бохирдуулсны төлбөр ногдуулах шалгуур үзүүлэлтийг боловсруулах, задлан шинжилгээний ажилд орчин үеийн арга, өргөн боломж бүхий техник, технологи нэвтрүүлэх шат дараалсан арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

д/агаарыг бохирдуулах эх үүсвэ-рүүдийн улсын нэгдсэн мэдээллийн систем бий болгон ашиглах;

е/агаарын чанарын хяналт-шинжилгээний мэргэжлийн боловсон хүчин, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтан бэлтгэх, давтан сургах ажлыг техник, технологийн шинэчлэлтэй уялдуулан чиглэсэн зорилготой хэрэгжүүлэх.

2/.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлага:

а/агаарыг бохирдуулах эх үүсвэр нь бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийнхөө хэмжээг хянах шинжилгээний багаж хэрэгсэлтэй байх журмыг мөрдүүлж, дотоодын хяналтын тогтолцоог бий болгох;

б/бохирдуулагч эх үүсвэрүүд, ялангуяа тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт бусад эхүүсвэрт экологийн магадлан оношилгоо хийлгэх ажлыг хуулиар тогтоосон хугацаанд хийж, агаар бохирдуулах түвшингээ тогтоолгох;

в/экологийн магадлан оношилгоог зайлшгүй хийлгэх шаардлагатай эх үүсвэрийн тухайд иргэд, олон нийтийн хяналтыг зохион байгуулах.

3.Агаарыг хамгаалах арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үндсийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

1/төрийн захиргааны байгууллагуудаас шийдвэрлэх асуудлууд:

а/агаар бохирдуулсны төлбөрийг бохирдуулагч нь нөхөн төлж агаар хамгаалдаг зарчмыг бүрэн утгаар нь хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн хөшүүрэг нэвтрүүлэх, төлбөрөөс олсон орлогыг нь агаар хамгаалах үйлсэд зарцуулах;

б/агаарыг хамгаалах ажилд бохирдуулах бодис, хортой нөлөөллийг бууруулах, багасгах тэргүүний техник, технологи нэвтрүүлсэн зэрэг тодорхой хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг эдийн засгийн аргаар урамшуулах тогтолцоо бий болгох;

в/эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх урт, дунд хугацааны болон жил, жилийн үндсэн чиглэлд агаарыг хамгаалах, агаарын чанарын шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, утаагүй түлш болон бүрэн шаталттай шинэ хийцийн зуух үйлдвэрлэх, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг төлөвлөн, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

г/агаарыг хамгаалах, тухайлбал тээвэрийн хэрэгсэл, дулааны цахилгаан станц, бусад томоохон эх үүсвэрүүдээс гарч буй бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийг бууруулахад чиглэсэн дэд хөтөлбөр, төслүүдийг санхүүжүүлэх, хөнгөлттэй зээл олгох, гадаад орон, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төслүүдэд хамруулах зэрэг арга хэмжээг өргөжүүлэх;

д/Улаанбаатар хотын зонхилох салхины чиглэлийн дээр байрлаж буй агаар бохирдуулах эх үүсвэрийг нүүлгэн шилжүүлэхэд чиглэсэн болон нийслэлийн хүн амын механик есөлтийг хязгаарлах зорилгоор агаар бохирдуулсны төлбөрийг хөшүүрэг болгон ашиглах асуудлыг судалж шийдвэрлэх.

2/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоо, үүрэг, хариуцлага:

а/агаарт бохирдуулах бодис гаргасныхаа төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах;

б/агаарыг хамгаалах бүх нийтийн хөдөлгөөнийг өрнүүлэх, ялангуяа агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн техник, технологи боловсруулах, нэвтрүүлэх чиглэлээр өрнөсөн аливаа үйл ажиллагаа, санаачилгыг дэмжих, түүнийг урамшуулахад зориулж санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

в/агаар бохирдуулсны төлбөрийн орлого болон бусад хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад иргэд, олон нийтийн хөндлөнгийн хяналт тавих арга хэлбэрийг боловсронгуй болгох.

Тав.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

1.Удирдлага, зохион байгуулалт:

а/хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн алба, аймаг, нийслэл, орон нутгийн түвшинд мэргэжлийн албаны тухайн аймаг, нийслэлийн салбарууд хэрэгжүүлнэ;

б/хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга зүйн зөвлөгөө өгөх, салбар дундын зохицуулалт хийх, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн үйл ажиллагааны нэгдлийг хангах үндсэн дээр хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх "Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үндэсний зөвлөл"-ийг зохих журмын дагуу байгуулан ажиллуулна;

в/бүрэн шаталттай, агаарт бохирдол багатай гаргах зуухны төсөл шалгаруулах замаар гэрийн зуухны бүтэц, хийцийг сонгон шалгаруулж олноор үйлдвэрлэх, түүнчлэн нар, салхины эрчим хүчээр болон хийн түлш хэрэглэх зарчмаар ажиллах багаоврын дулааны эх үүсвэрээр эхний ээлжинд Улаанбаатар хотын зонхилох салхины чиглэл дээр байгаа гэр хороолыннхныг хамруулж, цаашид хотын нийт айл өрхийг хангах арга хэмжээг зохион байгуулж, дэс дараатайгаар хэрэгжүүлнэ.

2.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/агаарыг хамгаалах, хяналт-шинжилгээний арга хэмжээнд зориулан улсын төвлөрсөн болон орон нутгийн жил бүрийн төсвөөс гаргах хөрөнгө;

б/шинээр байгуулж буй болон ажиллаж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах хөрөнгө;

в/хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, техникийн болон буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө;

г/аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдийн хандивын хөрөнгө.

Зургаа. Хамтын ажиллагаа

1.Гадаад оронтой байгуулах гэрээ, хэлэлцээрт агаарыг хамгаалах асуудлыг тодорхой чиглэлээр тусгаж хэрэгжүүлнэ;

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд агаарт гаргах бохирдуулах бодисын хэмжээ, найрлага, үзүүлэх физикийн хортой нөлөөллийг тодорхойлох, хэмжих өргөн боломж бүхий орчин үеийн техник, технологи, тоног төхөөрөмжөөр хангах, арга зүй, аргачлал эзэмших, нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх чиглэлээр НҮБ-ын системийн байгууллага, олон улсын бусад байгууллага, гадаад орнуудтай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлнэ;

3.Байгаль хамгаалах үйлсэд зориулагдсан олон улсын сан, гадаад орны зээл, тусламж, хандивын хөрөнгөөс агаарыг хамгаалах ажилд хуваарилан, оновчтой зарцуулна;

4.Хүлэмжийн хийн хаягдлыг хязгаарлах, бууруулах, бүрэн зогсооход чиглэсэн технологи, арга зүйг эзэмших, түүнийг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллана;

5.Агаарын шинжилгээ судалгаа явуулах, мэдээлэл цуглуулах болон байнгын ажиглалт явуулах ажлыг тодорхойлох, үнэлж дүгнэх болон санхүүжүүлэхэд чиглэгдсэн олон улсын болоод Засгийн газрын хоорондын хөтөлбөр хэрэгжүүлэх, нэгдсэн сүлжээнд хамрагдах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

1.Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газраар батлуулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

2.Нийслэл, аймаг, орон нутгийн түвшинд агаарыг хамгаалах чиглэлээр хийх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан тухайн шатны Засаг дарга нар батлан хэрэгжилтэд хяналт тавина.

3.Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн алба хариуцах бөгөөд нийслэл, аймаг, орон нутгийн түвшинд мэргэжлийн албаны салбарууд гүйцэтгэнэ.

4.Агаар хамгаалах ажлын ерөнхий аргачлал, арга зүйн зөвлөлгөөгөөр хангах, техник, технологи, боловсон хүчний бодлого, мэргэжил дээшлүүлэх, давтан сургах зэрэг асуудлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн алба зохицуулна.

Найм.Гарах үр дүн

Дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч буй тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд төр, засгаас явуулж буй бодлогыг хэрэгжүүлж, амьд байгалийн түлгуур орчин болсон хий мандлын агаарыг цэвэр, ариун байлгаж, иргэдийн эрүүл, аюулгүй агаар орчинд амьдрах нөхцөл бүрдүүлж, дараахь үр дүнд хүрнэ:

1.Нүүрсний чанарт тохирсон техник, технологийн шинэчлэлт хийх, түлшний чанарыг сайжруулах болон утаат шүүх, цэвэрлэх шинэ загварын шүүлтүүр тавьж, технологийн горимын дагуу байгаа хэвийн ажиллуулах, бохирдлын зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлэх үндсэн дээр дулааны цахилгаан станцууд зэрэг суурин эх үүсвэрүүдийн агаарт гаргах бохирдлыг 2010 оны түвшинд одоогийнхоос 1,8 дахин бууруулах;

2.Экологийн магадлан оношилгоонд тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах, сайн чанарын шингэн болон дэвшилтэт шинэ төрлийн түлш хэрэглэх ажлыг өргөжүүлэх замаар хөдөлгөөнт эх үүсвэрийн агаарт гаргах бохирдлын хэмжээг 1,5 дахин бууруулах;

3.Бүрэн шаталт явагдах технологи бүхий үндэсний стандартын шаардлага хангасан зуухаар нийслэлийн гэрт оршин сууж буй өрхийг 2005 оны түвшинд бүрэн, утаагүй түлшээр нийслэл, зарим аймгийн төвийн гэрт болон галлагаатай орон сууцанд амьдарч буй өрхийн 50 хувийг 2010 онд тус тус хангах үндсэн дээр гэр хорооллоос гарах бохирдлыг одоогийнхоос 2 дахин бууруулна;

4.Нийслэл, хүн ам төвлөрсөн суурин газруудад агаар бохирдуулах томоохон суурин эх үүсвэрүүдийг шингээр байгуулах асуудлыг бодлогоор зохицуулах, түүнчлэн нийслэлийн зонхилох салхины чиглэлд болон бохирдуулах бодис харьцангуй тогтмол хадгалагдаж байгаа газруудад байрлаж байгаа үүсвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх, шинээр эх үүсвэрүүдийг байрлуулахгүй байх удирдлага, зохион байгуулалтын болон эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлснээр нийслэлийн агаарын бохирдлыг 2010 оны түвшинд 40-өөс багагүй хувиар багасгана.

Засгийн газрын 1999 оны 82 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"АГААРЫГ ХАМГААЛАХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Гарах үр дүн	Хариуцан гүйцэтгэх байгуулага
1	2	3	4	5	6
1	"Агаар бохирдуулсны төлбөр"-ийн тухай хуулийн төсөл боловсруулан батлуулна	а/ хуулийн төслийг боловсруулж батлуулах	1999 онд	Агаар бохирдуулах эх үүсвэрээс гаргах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах, багасгахад хөшүүрэг болох хууль эрхийн акт бий болно	Байгаль орчны яам, Дэд бүтцийн хөгжлийн яам
		б/ энэ хуулийг дагалдан гарах журам, дүрмийг гаргаж батлагаажуулах	1999-2000 онд		
2	"Агаарыг хамгаалах хөтөлбөр", "Агаарын тухай" болон "Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх, хяналт тавих арга хэмжээ авна	а/ хөтөлбөр болон хуулиудын үр дүн, явцыг сурталчлах	2000 оноос	Хөтөлбөр болон хуулийн зорилго, чиглэл, ач холбогдлыг олон нийтэд ойлгуулна	Байгаль орчны яам, хэвлэл мэдээллийн байгууллага
		б/нийслэл, аймгийн дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах	2000 онд	Нийслэл, аймаг тус бүр өөрийн онцлог бүхий дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ	Засаг дарга нар
3	Үндэсний стандарт, бохирдуулах бодис, хортой нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг шинээр боловсруулах, хянан үзэх, хугацааг сунгах	а/ агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг агаарыг бохирдуулах эх үүсвэрээр тогтоох	2000 оноос	Зөвшөөрөгдөх дээд хэмжээг бохирдуулах бодисын нэр төрлөөр тогтооно	Агаарын чанарын мэргэжлийн алба
		б/ агаарт байж болох хортой бодисын болон үзүүлэх физикийн хортой нөлөөллийн хүлцэх хэм хэмжээний стандартыг боловсруулах	2001 оноос	Үндэсний стандарттай болно	Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар

Төрийн мэдээлэл 1999 он № 31 (110)

1	2	3	4	5	6
4	Агаарын чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх, мэргэжлийн байгууллага, ажилтнуудыг техник хэрэгслээр хангах	а/ Монгол Улс дахь олон улсын хяналт-шинжилгээний сүлжээний цэг 2-ыг нэмж байгуулна.Говь-алтай, Баянхонгор, Өмнөговь,Төв, Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн төвд, Хөтөл, Заамар зэрэг хүн ам, үйлдвэрлэл төвлөрсөн төв сууринг хяналт-шинжил-гээний улсын нэгдсэн сүлжээнд хамруулж , нийс-лэлд хяналт-шинжилгээний 4 цэг, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Чойбалсан хотод нүүдлийн лабораторийг байгуулна	2000-2004 онд	Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан хяналт-шин-жилгээний сүлжээ бий болно	Байгаль орчны яам, Сангийн яам, Дэд бүт-цийн хөгжлийн яам
		б/ агаарын чанарын хяналт- шинжилгээний цэгийг болон хяналтын байцаагч нарыг орчин үеийн шинжилгээ хя-налтын багаж хэрэгслээр хангана	2000-2004 онд	Агаарын чанарын хяналтын түвшин дээшилнэ	Сангийн яам, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар , Байгаль орчныг хамгаа-лах алба
5	Экологийн магадлан оношилгоо хийх зөөврийн болон суурин лаборатори байгуулна	явуулын 5, суурин 2 лаборатори байгуулна	2000-2004 онд	Тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт бусад эх үүсвэр болон нефть бааз, шатахуун түгээх цэг, органик уусгагч агаарт гаргадаг эх үүсвэрүүдэд бохирдуулах бодисын хэмжээг нэр төрлөөр нь тогтоох боломж бүрдэнэ	Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, Сангийн яам

1	2	3	4	5	6
6	Агаар бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах болон дотоод хяналт тавих тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр суурин эх үүсвэрүүдийг тоноглох арга хэмжээ авна	а/ суурин эх үүсвэрүүдэд байгаа бохирдуулах бодисыг цэвэрлэх, физикийн хортой нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмж, дотоод хяналтын багаж хэрэгслийн улсын тооллого, үзлэг явуулна	1999-2000 онд	Бүртгэл мэдээллийн сан бүрдэнэ	Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн төв болон салбар албад
		б/ суурин эх үүсвэр бүрийг цэвэрлэх, хортой нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмж, дотоод хяналтын багаж хэрэгсэлтэй болгоно	2000-2008 онд	Агаарт гаргах бохирдуулах бодисыг цэвэрлэх, хортой нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмжтэй болж, бохирдуулах бодисыг хэмжих багаж хэрэгслээр хангагдана	Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага
7	Агаарын чанарын хяналт-шинжилгээний мэргэжлийн боловсон хүчин, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтан бэлтгэх, давтан сургах ажлыг техник, технологийн шинэчлэлттэй уялдуулан чиглэсэн зорилготой хэрэгжүүлнэ	а/ агаарын чанарын хяналт-шинжилгээний нарийн мэргэжлийн боловсон хүчний хэрэгцээний судалгаа, захиалга хийх журмыг боловс руулж хэрэгжүүлнэ	2000 оноос	Мэргэжлийн боловсон хүчний тасралтгүй нөөцтэй болно	Байгаль орчны яам, Гэгээрлийн яам, Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албад
		б/ мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах мэргэжлийн сургалтын төв байгуулах үндсэн дээр мэргэжлийн чадавхийг дээшлүүлнэ	2001 оноос	Инженер, техникийн ажилтны мэргэжил дээшлүүлэх байнгын сургалт явуулах материаллаг бааз бүхий төвтэй болно	

1	2	3	4	5	6
8	Нүүрсний чанарт тохирсон техник, технологийн шинэчлэлт хийх, түлшний чанарыг сайжруулах болон нүүрсний шаталтаас гарч буй утаан дахь бохирдуулах бодисыг шүүх, цэвэрлэх, хоргүйжүүлэх шинэ загварын шүүлтүүр тавьж, түүнийг технологийн горимын дагуу байнга хэвийн ажиллуулах, бохирдлын зөвшөөрлийн тогтолцоог дулааны цахилгаан станцууд зэрэг суурин эх үүсвэрт нэвтрүүлэх	а/ дулааны цахилгаан станцуудад хэрэглэж буй нүүрсний чанарт тохирсон техник, технологийн шинэчлэлт хийх	2005-2010 онд	Техник ,технологийн шинэчлэлт хийж түлшний чанарыг сайжруулах болон утаат шүүх цэвэрлэх шинэ загварын шүүлтүүр тавьж бохирдлын зөвшөөрлийн тогтолцоог нэвтрүүлснээр дулааны цахилгаан станцууд зэрэг суурин эх үүсвэрүүдийн агаарт гаргах бохирдлыг 2010 онд одоогийнхоос 1,8 дахин бууруулна	Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, Сангийн яам, нийслэл, аймгийн Засаг дарга
		б/ дулааны цахилгаан станцуудаас гарч буй утаан дахь бохирдуулах бодисыг цэвэрлэн шүүх, хоргүйжүүлэх шинэ загварын шүүлтүүр тавих, түүнчлэн станцуудад хэрэглэх түлшний чанарыг сайжруулах арга хэмжээ авах	2003-2010 онд	-"-	-"-
		в/ дулааны цахилгаан станцууд зэрэг суурин эх үүсвэрүүдийг бохирдлын зөвшөөрлийн тогтолцоонд хамруулах	2004-2008 онд	-"-	-"-

1	2	3	4	5	6
9	Экологийн магадлан оношилгоонд тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах, сайн чанарын шингэн болон шинэ төрлийн түлш хэрэглэх ажлыг өргөжүүлэх	а/ тээврийн хэрэгсэл болон агаар бохирдуулах хөдөлгөөнт бусад эх үүсвэрүүдийг экологийн магадлан оношилгоонд бүрэн хамруулж, агаар бохирдуулж буй түвшинг байнга тодорхойлох арга хэмжээ авах	2002-2010 онд	Үндэсний болон олон улсын стандартын шаардлагад тэнцсэн тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оруулна	Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, нийслэл, аймгийн Засаг дарга
		б/ сайн чанарын түлш шатахуун хэрэглэж, агаарт бохирдуулах бодис багатай гаргадаг, сонгомол түлшээр ажилладаг шинэ хийцийн автомашин ашиглах ажлыг өргөжүүлэх	2001-2010 онд	Тээврийн хэрэгслээс гарч буй бохирдлын хэмжээг 2010 онд одоогийнхоос 1.5 дахин бууруулна	Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам
10	Нийслэл, аймгийн төвийн гэр болон гаднагаатай орон сууцанд амьдардаг өрхийг бүрэн шаталттай шинэ хийцийн зуух, утаагүй түлшээр хангах	а/ нийслэлийн гэр болон гаднагаатай орон сууцанд суух буй өрхийг бүрэн шаталттай шинэ хийцийн зуух болон утаагүй түлшээр хангах	2001-2005 онд	Бүрэн шаталттай шинэ хийцийн зуухаар нийслэлийн гэрт оршин суух буй өрхийг бүрэн, утаагүй түлшээр нийслэл, зарим аймгийн төвийн гэрт болон галлагаатай орон сууцанд амьдарч буй өрхийн 50 хувийг 2010 онд тус тус хангах үндсэн дээр гэр хороолоос гарах бохирдлыг одоогийнхоос 2 дахин бууруулна	Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, аймаг, нийслэлийн Засаг дарга
		б/ суурин эх үүсвэрүүдийг шингээр байгуулах болон зонхилох салхины чиглэлд байрлаж байгаа агаар бохирдуулах эх үүсвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх удирдлага, зохион байгуулалт, эдийн засгийн хөшүүргийг хослон хэрэгжүүлснээр нийслэлийн агаарын бохирдлыг багасгах	2005-2010 онд	Томоохон эх үүсвэрийг шингээр байгуулахэд агаар хамгаалах асуудалтай нягт уялдуулан хот төлөвлөлтийг бодлогоор зохицуулна. Нийслэлийн агаарын бохирдлыг 2010 оны түвшинд одоогийнхоос 40-өөс багагүй хувиар багасгана	Дэд бүтцийн хөгжлийн яам, Байгаль орчны яам, аймаг, нийслэлийн Засаг дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 83** **Улаанбаатар хот**

Банк, санхүүгийн үйлчилгээний найдвартай байдлыг хангах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Улсын төсвийн орлого, зарлага, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл, гааль, татвар зэрэг улсын төсвийн төлбөр тооцооны холбогдох дансыг төлберийн чадвартай, аймаг, сумдад үйлчилгээ хүргэх сүлжээ бүхий арилжааны банкуудад 1999 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс байршуулах ажлыг зохион байгуулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд С.Сонин, Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, аймаг, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2.Харилцагчид төлбөр тооцооны үйлчилгээнийх хөлсийг тухайн банкинд байршуулсан дансны үлдэгдэлд хүү тооцох зарчмаар төлбөр хийх гэрээ байгуулж ажиллахыг төсвийн захирагч нарт даалгасугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг энэ оны 10 дугаар сард багтаан Засгийн газарт тайлагнахыг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Сангийн сайд **Я.ОЧИРСҮХ**

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд **С.СОНИН**

Дэд бүтцийн хөгжлийн сайд **Г.БАТХҮҮ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 5 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 84** **Улаанбаатар хот**

Үүрэн телефон хэрэглээ эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төсвийн санхүүжүүлэлтээр үүрэн телефон хэрэглээ эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг 1,2 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хавсралтад заасан албан тушаалтны үүрэн телефон хэрэглээ зардлын нормативыг Засгийн газрын гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас бусад албан тушаалтанд улс хоорондын ярианы эрхгүй, нэг сард 65.0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байхаар тогтоосугай.

3.Үүрэн телефон хэрэглээх зайлшгүй шаардлагатай төрийн өмчит аж ахуйн нэгжийн албан тушаалтны жагсаалт болон зардлын нормативыг батлан гаргаж, мөрдүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Д. Зориггод даалгасугай.

4.Энэ тогтоолыг 1999 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдүүлж, хэрэгжилтэд нь байнгын хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Я. Очирсүхэд үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Сангийн сайд **Я.ОЧИРСҮХ**

Засгийн газрын 1999 оны 84 дүгээр Тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗАР, ЗАРИМ АГЕНТЛАГУУДЫН ҮҮРЭН ТЕЛЕФОН ХЭРЭГЛЭХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн

2.Монгол Улсын Засгийн газрын Хэрэг дарга

3.Төрийн захиргааны албаны зөвлөлийн эрхлэх газрын дарга

4. Яамдын Төрийн нарийн бичгийн дарга
5. Улсын аюулгүй байдлыг хангах газрын дарга
6. Төрийн өмчийн хорооны дарга
7. Үндэсний татварын ерөнхий газрын дарга
8. Гаалийн ерөнхий газрын дарга
9. Цагдаагийн ерөнхий газрын дарга
10. Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга
11. Хилийн цэргийг удирдах газрын дарга
12. Эрүүл ахуй, халдвар, нян судлалын хяналтын албаны дарга
13. Эрчим хүчний удирдах газрын дарга
14. Улсын Иргэний хамгаалалтын газрын дарга
15. Шүүхийн шийдвэр бтиелүүлэх ерөнхий газрын дарга
16. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга
17. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга

Засгийн газрын 1999 оны 84 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

НИЙСЛЭЛ, ЗАРИМ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭН ТЕЛЕФОН ХЭРЭГЛЭХ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, түүний орлогч
2. Дархан-уул, Орхон, Сэлэнгэ аймгийн Засаг дарга, орлогч дарга нар
3. Улаанбаатар хотын ерөнхий менежер
4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга
5. Нийслэлийн дүүргүүдийн Засаг дарга
6. Нийслэл болон Дархан-уул, Орхон, Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын дарга
7. Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 2-ны өдөр **Дугаар 86** **Улаанбаатар хот**

Зөвлөлдөх хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газар, Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын хооронд байгуулсан хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Эдийн засал, бизнесийн зөвлөлдөх хороо"-г доорхи бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

А.Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж:

Ч.Содномцэрэн	-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд (Засгийн газрын төлөө-лөгчдийн ахлагч);
Н.Батбаяр	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
Д.Махвал	-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
Ц.Дамиран	-Дэд бүтцийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
А.Зангад	-Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;
Д.Болдбаатар	-Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, хамтын ажилла-гааны газрын дарга;
Д.Зоригт	-Төрийн өмчийн хорооны дарга;

Ж.Баасандаш -Үндэсний татварын ерөнхий газрын дарга;

Т.Лхагваа -Улсын гаалийн ерөнхий газрын дарга;

Д.Жаргалсайхан -Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дарга;

М.Болд -Монгол банкны дэд ерөнхийлөгч (тохиролцоноор).

Б.Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимыг төлөөлж:

С.Дэмбэрэл -Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (МХАҮТ-ын төлөөлөгчдийн ахлагч);

С.Батболд -Танхимын тэргүүлэгч гишүүн, "Алтай Трейдинг" компанийн ерөнхий захирал, "Уул уурхайн ассоциаци"-ийн тэргүүлэгч;

Б.Жаргалсайхан -Танхимын тэргүүлэгч гишүүн, "Буян" компанийн ерөнхий захирал;

У.Уламбаяр -Танхимын тэргүүлэгч гишүүн, "Санта- мон" компанийн ерөнхий захирал;

Б.Эрдэнэбат -Танхимын зөвлөлийн гишүүн,"Эрэл" компанийн ерөнхий захирал;

Н.Даш-өлзий -Танхимын тэргүүлэгч гишүүн, "Өлзийт төв" ХХК-ийн ерөнхий захирал, Монголын ажил олгогчдын эздийн холбооны тэргүүлэгч;

Б.Галтбаатар -Танхимын зөвлөлийн гишүүн, "Ж энд М" ХХК-ийн ерөнхий захирал;

С.Пүрэв -Танхимын зөвлөлийн гишүүн, "Гангар Инвест" ХХК-ийн ерөнхий захирал;

Н.Зоригт -Танхимын тэргүүлэгч гишүүн,"Туушин" компанийн ерөнхий захирал, Монголын тээвэр зуучлалын холбооны удирдах зөвлөлийн гишүүн;

Р.Лутаа -"Тахь-Ко" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч;

Ч.Буд -"Очир" ХХК-ийн ерөнхий захирал.

2."Эдийн засаг, бизнесийн хөгжлийн зөвлөлдөх хороо нь эдийн засаг, бизнесийн хөгжлийн чиглэлээр явуулж буй бодлогын хэрэгжилт, өнөөгийн байдлын талаар хамтарсан судалгаа хийж үнэлэлт дүгнэлт өгөх, цаашдын төлөвийн асуудлаар зөвлөлдөж зөвлөмж гаргах чиг үүрэгтэй байхаар тогтоосугай.

3.Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэл нарт даалгах нь:

а/"Эдийн засаг, бизнесийн хөгжлийн зөвлөлдөх хороо"-ны үйл ажиллагааг улиралд нэгээс доошгүй удаа зөвлөлдөх уулзалт, ярилцлага явуулж байхаар зохион байгуулсугай;

б/зөвлөлдөх хорооны ажиллах журам, уулзалт, ярилцлагаар хэлэлцэх асуудлын хүрээ, гаргах зөвлөмжийн хэлбэр зэргийг хорооны анхдугаар хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх, хорооны үйл ажиллагааны талаар Засгийн газарт мэдээлж байсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Хөдөө аж ахуй, үйлдвэрийнсайд Ч.СОДНОМЦЭРЭН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 Төрийн ордон
☎ 329612
Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны долдугаар сарын 23* *№32 (111)*

Гарчиг

Нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоол

302. Засгийн газрыг огцруулах тухай **Дугаар 53** **611**

Хоёр. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

303. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай **Дугаар 132** **612**
304. Зарим шүүхийн шүүгчийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай **Дугаар 133** **612**
305. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай **Дугаар 134** **612**
306. Д. Алтангэрэлд шүүгчийн зэрэг дэв олгох тухай **Дугаар 135** **612**

Гурав. Яам, агентлагийн акт

307. Журам батлах тухай (Худалдаа, үйлдвэрийн улсын хяналтын албаны даргын тушаал) **Дугаар А/04** **613**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 53** **Улаанбаатар хот**

Засгийн газрыг огцруулах тухай

Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс Ерөнхий сайд Ж. Наранцацралтыг огцруулах тухай гаргасан саналыг хэлэлцээд явуулсан нууц санал хураалтын дүн, мөн Засгийн газрын нэр бүхий 7 гишүүн Засгийн газрын гишүүнээс нэгэн зэрэг огцрох тухай өөрсдийн санал, үндэслэл гаргасантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 17 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ерөнхий сайд Ж. Наранцацралтын тэргүүлсэн Засгийн газрыг огцруулсугай.

2.Засгийн газрын гишүүдийг шинээр томилогдох хүртэл хугацаанд үүргээ гүйцэтгэж байхыг Засгийн газрын гишүүн-сайд нарт даалгасугай.

3. Шинэ Ерөнхий сайдыг томилох хүртэл Ерөнхий сайдын үүргийг гүйцэтгэж байхыг Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцтгэгчид даалгасугай.

4. Энэ тогтоолыг 1999 оны 7 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р. ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 132** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1.Монгол Улсаас Щвейцарийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Сүх-Очирын Болдыг тохоон томилсугай.

2.Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Лувсанжамцын Удвалыг Монгол Улсаас Швейцарийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 133** **Улаанбаатар хот**

Зарим шүүхийн шүүгчийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Дэчингомбын Цэрэндолгорыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, өөрийнх нь хүсэлтийг харгалзан Баасанжавын Лхагвацэрэнг Говьсүмбэр аймгийн шүүхийн шүүгчийн, Сийлэгдоржийн Раднаасэдийг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ардын хэсгийн шүүгчийн, Гандангийн Дашзэвгийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Борхондойн Содномцэрэнг Өмнөговь аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 134** **Улаанбаатар хот**

Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Дэчингомбын Цэрэндолгорыг Хэнтий аймгийн шүүхийн шүүгчийн, Төмөрлүрэвийн Жаргалсайханыг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Раднаагийн Шүрхүүг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Халзанхүүгийн Гэрэлмаагаг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 135** **Улаанбаатар хот**

Д. Алтангэрэлд шүүгчийн зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрэм"-ийн 6 дугаар зүйлийг үндэслэн Улсын дээд шүүхийн шүүгч Даниагийн Алтангэрэлд Мэнгэлын шүүхийн тэргүүн түшээ зэрэг дэв олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Худалдаа, үйлдвэрийн улсын хяналтын албаны даргын тушаал

1999 оны 3 дугаар сарын 4-ний өдөр **Дугаар А/04** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын "Журам батлах тухай "1997 оны 178 дугаар тогтоолыг үндэслэн хүнсний захын үйл ажиллагааг боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1."Монгол улсын нутаг дэвсгэрт хүнсний зах ажиллуулахад баримтлах нийтлэг журам"-ыг хавсралтаар батална 1999 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2.Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын албад, дүүргийн орон нутгийн үйлчилгээний хэлтсийн дарга, худалдаа, үйлдвэр,үйлчилгээний улсын байцаагч нарт даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол улсын Худалдаа, үйлдвэрийн сайдын 1993 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 440 дугээр тушаалаар батлагдсан "Хүнсний зах ажиллуулах үлгэрчилсэн дүрэм"-ийг хүчингүй болсонд тооцуулах арга хэмжээ авахыг улсын ахлах байцаагч Ж. Хадаад даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА Л. ШАСНААБАДРАА

Худалдаа, үйлдвэрийн улсын хяналтын албаны даргын 1999 оны А/04 тоот тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ХҮНСНИЙ ЗАХ АЖИЛЛУУЛАХАД БАРИМТЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хүнсний төрөл бүрийн бараа, бүтээгдэхүүн /шашид хүнсний бараа гэнэ/ төмс, хүнсний ногоог хүнсний захад хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалан соёлтой худалдаалах, үйлчилгээний дэг журмыг худалдагч бүр баримтлан ажиллахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Хүнсний зах гэдэг нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүнсний бараагаар ажил үйлчилгээ явуулах нийслэлд 100.Аймаг, орон нутагт 60-аас доошгүй лангуу түрээслүүлэх зориулалт бүхий үйл ажиллагаа явуулах худалдаа үйлчилгээний төвлөрсөн цэг мөн.

Хоёр. Хүнсний захын үйл ажиллагаанд тавигдах үндсэн шаардлага

2.1.Хүнсний захын худалдаа, үйлчилгээ явуулах байр нь эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байхын зэрэгцээ лангуу, тавиур бухий худалдааны талбайтай хүнсний бараа хадгалах зориулалтын агуулах, хөргөх төхөөрөмжтэй халаалт, цэвэр, бохир усны шугамд холбогдсон, гэрэлтүүлэг, агааржуулалт зохих ёсоор хийгдсэн байна.

Захын гадна талбайг хатуу/цемент, асфальт/ хучилтаар тохижуулсан байна.

2.2.Худалдаа, үйлчилгээ явуулах ажлын нэгж байрыг 2 хавтгай дэрвөлжин метрээс багагүй талбайд тохижуулж шаардагдах тавиур, лангуугаар хангасан байна.

2.3.Хүнсний бүтээгдэхүүн хадгалах агуулахыг төрөлжүүлэн зохих байгууллагаар баталгаажуулсан халуун хүйтнийг болон чийглэгийг хэмжих багаж, төхөөрөмжөөр хангасан байна.

2.4.Худалдаа, үйлчилгээнд ашиглаж байгаа жин, хэмжүүр, туухайг мэргэжлийн байгууллагаар 6 сар дутам шалгуулж заалтыг үйлчлүүлэгчид үзэгдэхүйцээр байрлуулна. Мөн 20-иос доошгүй ажлын байрны дунд нэг хяналтын жин ажиллуулна.

2.5. Хүнсний зах нь хүнсний барааны чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавих лабораторитой байж мэргэжлийн хүнээр хангасан байна.

2.6.Түргэн гэмтэж чанараа алдах,

хадгалалтын онцгой нөхцөл шаардах хүнсний бараанд заавал хөргөгчинд хадгалан хөргөх лангуунд тавьж худалдаалж байгаа эсэхэд дотоодын хяналтыг өдөр дутам тавьж ажиллана.

2.7.Хүнсний захад гэр ахуйн химийн бараа, цахилгаан хэрэгсэл, сонин хэвлэлийн болон эмийн худалдаа тус бүр нэгийг зохих шаардлагыг хангасан нөхцөлд ажилуулж болно.

2.8. Хүнсний захын орчим явган зорчигчдын урсгал хөдөлгөөнд саад болохооргүй газарт тодорхой тооны автомашины зогсоолыг шаардлагын дагуу тохижуулж, замын хөдөлгөөний холбогдох заалт, тэмдгийг зохих газарт байрлуулж журам сахиулагч ажиллуулна.

2.9. Хүнсний захын гэрлэн хаяг, шагийн хувиарыг цэвэр үзэмжтэй хийж олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулна.

2.10.Худалдааны танхимыг худалдаалах бүтээгдэхүүний нэр төрлөөр нь төрөлжүүлсэн байна.

2.11.Эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг бүрэн хангасан цэвэрлэгээг тогтмол хийж, таглаа бүхий хог хаягдлын савыг тусгай газарт байрлуулсан байна.

2.12.Ариутгал, мэрэгч, шавьж устгах ажлыг мэргэжлийн байгууллагаар графикт хугацаанд нь чанартай хийлгэсэн байна.

2.13.Хүнсний захын захиргаа нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй худалдаа, үйлчилгээ явуулах гэрээ байгуулж хоёр талын үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан байна.

2.14.Нийгмийн хэв журам сахиулах талаар цагдаагийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.

2.15.Хүнсний зах нь эрх бүхий байгууллагаар батлагдсан цагийн хуваарийг хатуу баримтлан ажиллана.

Б. Худалдаа эрхлэгчийн хүлээх үүрэг

2.16.Худалдаа эрхлэгчид нь үйлчилгээ явуулахад шаардагдах бүх бичиг баримтыг эрх бүхий байгууллагаас авч, эрүүл мэндийн үзлэгт орж зохих тэмдэгэлзлийг хийлгэж, "Худалдаа хийх эрх"-ийн энгэрийн тэмдгийг аялын байрандаа заавал хэрэглэж заншсан байна.

2.17. Худалдан авагчдад "Бүх төрлийн хүнсний бараа худалдах дүрэм"-ийг хатуу баримтлан үйчилнэ.

2.18.Хүнсний захад борлуулах импортын болон эх орны үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүний чанарыг эрүүл ахуй, халдвар судлал, мал эмнэлэг, ургамал хорио цээрийн байгууллагаар тухай бүр шинжлүүлж зохих дүгнэлтийг авсан байна.

2.19.Түргэн гэмтэж чанараа алддаг, хадгалтын онцгой нөхцөл шаардлагатай хүнсний бараг заавал хөргөх лангуунд хадгалж худалдаална.

Гурав. Хүнсний захын үйл ажиллагаанд хориглох зүйл

3.1. Хүнсний зах болон түүний орчинд гар дээрээс худалдаа хийх.

3.2. Хүнсний захад согтууруулах ундаа худалдах.

3.3. Хүнсний захын талбайд зөвшөөрөгдсөнөөс өөр төрлийн худалдаа, үйлчилгээ явуулах.

3.4. Худалдаа хийх эрхийн зөвшөөрөл, энгэрийн тэмдгийг бусдад шилжүүлэх, мөн нэр заагдсанаас өөр хүнийг түр буюу удаан хугацаагаар худалдагчаар ажиллуулах.

3.5. Мах, хүнсний бараг ил задгайгаар тээвэрлэх.

3.6.Хүнсний захыг задгай талбайд ажиллуулах.

Дөрөв. Хяналт шалгалт, хариуцлага

4.1. Хяналт, шалгалтын явцад энэхүү дүрмийг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр бол эрх бүхий улсын байцаагч нар холбогдох хууль тогтоомжийн дагуу хууль бусаар олсон орлогыг хураах, торгууль, шийтгэвэр ногдуулах, худалдаа хийх эрхийг нь хасах, хүнсний захыг хаах хүртэл арга хэмжээ авна.

4.2.Хүнсний захын удирдлага энэхүү дүрмийг худалдаа эрхлэгчид сайтар сурталчилан ойлгуулж хоёр тал хатуу баримтлан ажиллана.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны долдугаар сарын 24. №33 (112)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

308. Гэрээ соёрхон батлах тухай (1999-7-8-ны хууль) 617
309. Протокол соёрхон батлах тухай (1999-7-8-ны хууль) 617

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

310. Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай Дугаар 46 617
311. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай Дугаар 49 618
312. Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Ц. Элбэгдоржийн хамгаалалт, хангамжийн тухай Дугаар 50 618

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

313. Д. Чимэд-Юндэнд хошууч генерал цол хүртээх тухай Дугаар 118 619
314. Д. Дамдинд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 119 619
315. Д. Пүрэвдоржид Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай Дугаар 120 619
316. Д. Баяраад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 121 619
317. Зарим хүнд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 122 620
318. Л. Чаминчулуунд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 123 620
319. Ш. Даваахүүд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 124 620
320. Ө. Батжаргалд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 125 620

321. Зарим эмч нарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай
Дугаар 126 621
322. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай
Дугаар 127 621
323. О. Алтандөлийг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай Дугаар 128 625
324. Н. Цэнд-Аюушийг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 129 625
325. Л. Наранцэцэг, Д. Цэрэнлхам нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай
Дугаар 130 625

Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

326. Журам батлах тухай Дугаар 87 625
327. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай
Дугаар 88 627
328. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан цэнхэр тасалбарыг төлбөрт тооцох тухай
Дугаар 90 629
329. Төсвийн орлогыг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай
Дугаар 91 629

Тав. Яам, агентлагийн акт

330. Журам баталж, комисс байгуулах тухай (Дэд бүтцийн хөгжлийн сайд, Хууль зүйн сайд, Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан тушаал)
Дугаар 100/78/54/53 632

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд 1999 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан "Эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн харилцааны тухай Гэрээ"-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр — Улаанбаатар хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь Конвенцийн 1997 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Киотогийн Протоколд нэгдэн орсныг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр — Дугаар 46 — Улаанбаатар хот

Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого"-ыг хавсралтаар батлалсугай.

2.Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээ, түүнд шаардагдах зардлын хөрөнгийн эх сурвалжийг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн төсөвт жил бүр тусган хэрэгжүүлж байхыг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 46 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Монголын уламжлалт анагаах ухаан нь монгол хүний бие махбодь, оюун санаа, сэтгэл зүйн онцлог, нүүдэлчдийн ахуй нөхцөл, ёс заншилтай зохицсон, өөрийн өвөрмөц төрхтэй, бие даасан эрдэм мэдлэг, оюуны соёлын нандин өв мөн.

2. Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухааны олоотоор баяжуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин эмгэгийг ангагаан эдгэрүүлэх, алдагдсан чадварыг нөхөн сэргээхэд өргөн ашиглах зарчимд үндэслэн хөгжүүлнэ.

3.Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, түс улсад шинжлэх ухаан, технологи хөгжүүлэх цогц арга хэмжээний хүрээнд улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусах замаар хэрэгжинэ.

4.Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого нь тухайн чиглэлээр 2015 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны тулгуур баримт бичиг мөн.

Хоёр.Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх төрийн бодлогын үндэсэн чиглэл

5.Монгол Улсын төрийн захиргааны болон эрүүл мэндийн төв, орон нутгийн байгуулагууд монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх бодлогыг хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

6.Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны бусад салбарын хөгжилтэй уялдуулан зохицуулж, төрөөс хийх хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар нэмэгдүүлж, үр өгөөжийг нь дээшлүүлэхийг бүх талаар дэмжинэ.

7.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн бүтцэд монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх төрийн бодлогын асуудал эрхэлсэн нэгжтэй байж, орон нутаг дахь бүтцийг эрүүл мэндийн байгууллагын харьяанд оновчтой зохион байгуулж, улсын хэмжээний нэгдсэн сүлжээнд оруулна.

8.Монголын уламжлалт анагаах ухааны салбарт ажиллах хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаог бүх талаар дэмжинэ.

9.Сум, дүүргийн болон ерөнхий мэргэжлийн тусламжийн түвшинд хэрэглэх монголын уламжлалт анагаах ухааны урьдчилан сэргийлэх болон эмчилгээний арга, дэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

10.Монголын уламжлалт анагаах ухааны өв сан, ном судар, эд зүйлийг цуглуулах, хамгаалах, судлах, мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулж, байнга баяжуулж ашиглана.

11.Орчин үеийн анагаах ухаанд шийдэхэд түвэгтэй байгаа зарим өвчнийг эмчлэх, оношлох, урьдчилан сэргийлэхэд уламжлалт анагаах ухааны шинэ арга бий болгох ажлыг хөхүүлэн дэмжинэ.

12.Монголын уламжлалт анагаах ухааны мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах үйл ажиллагаог төрөөс боловсролын талаар баримталж бодлоготой нягт уялдуулан явуулна.

13.Монголын уламжлалт анагаах ухааны олдлт амжилтад тулгуурлан байгалийн гаралтай түүхий эд ашиглаж аюулгүй, өндөр идэвх чанартай шинэ эм, биобэлдмэл, хүн амын хүнс тэжээлийн үйлдвэрлэл эрхлэхийг хөхүүлэн дэмжинэ.

14.Монгол орны эмийн үргамал, амьтны болон эрдсийн гаралтай эмчилгээний чанартай түүхий эдийн тархац, нөөцийг судлан экологийн тэнцвэрт байдлыг нь алдагдуулахгүйгээр ашиглана.

15.Эмийн үргамлыг тариалуулах, эрлэг амьтныг гаршуулах замаар уламжлалт эмнэлгийн гадаадаас авдаг түүхий эдийн орлох дотоодын түүхий эдийн нийлүүлэлтийг нэмэгдүүлж хэрэгцээгээ хангана.

16.Ховордсон эмийн үргамал, амьтны гаралтай түүхий эд /бугын эвэр, бөхөнгийн эвэр, хүдрийн заар, бугын чив, баавгайн цөс зэрэг/-ийг эцсийн бүтээгдэхүүн болголгүйгээр экспортлохыг хориглох асуудлыг дэс дараатай шийдвэрлэнэ.

17.Уламжлалт эмнэлгийн эмийн үйлдвэрлэлийн технологийн нөхцөлийг эмийн үйлдвэрлэл, хяналтын олон улсын үлгэрчилсэн дүрмийн шаардлагатай нийцүүлэн хяналтын шинэ аргачлал бий болгож, эмийг стандартчилж, экспортлох бодлогыг дэмжинэ.

18.Монголын уламжлалт анагаах ухааны олдлт амжилт, оношлогоо, эмчилгээ, нөхөн сэргээлтийн болон урьдчилан сэргийлэх үр дүнтэй арга, эм, эмийн бэлдмэлийг ойсуны өмчийн хамгаалалтад авч дэлхийн түвшинд сурталчлах ажлыг зохион байгуулна.

19.Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр дотоод, гадаадын эрдэм шинжилгээ, эмчилгээний байгууллагуудын хамтын ажиллагаат өргөтгөж, энэ талаарх үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжинэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр | **Дугаар 49** | **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар Баасангомбын Энэбишийг томилсугай.

2.Энэ тогтоолыг 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр | **Дугаар 50** | **Улаанбаатар хот**

Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Ц.Элбэгдоржийн хамгаалалт, хамгамжийн тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Цахиагийн Элбэгдоржийг нэгэн бүрэн эрхийн хугацаанд хамгаалах ажлыг Төрийн тусгай хамгаалалттын газар /О.Баяраа/-т хариуцуулсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан хугацаанд Ц.Элбэгдоржид шуурхай ажлын суудлын автомашинаар үйлчлэхийг Засгийн газар /Ж.Наранцацралт/-т даалгасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 118** **Улаанбаатар хот**

Д. Чимэд-Юндэнд хошууч генерал цол хүртээх тухай

Улсын аюулгүй байдлыг хангах газрын дэд генерал цол хүртээсүгэй.
дарга Доржготовын Чимэд-Юндэнд хошууч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 119** **Улаанбаатар хот**

Д. Дамдинд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Улсын их баяр наадамд завсаргүй таван удаа түрүүлж, таван удаа үзүүрлэж, 17 удаа шөвгөрч спортын өндөр амжилт үзүүлэн үндэсний биеийн тамирыг хөгжүүлэх үйлсэд оруулсан гарамгай хувь нэмрийг нь үнэлж үндэсний бөхийн дархан аварга Дарийн Дамдинд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 120** **Улаанбаатар хот**

Д. Пүрэвдоржид Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай

Монголын иргэний агаарын тээврийн байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй хөдөлмөрлөж манай улсад ашиглагдаж байгаа бүх төрлийн онгоц жолоодох өндөр ур чадвар эзэмшиж, нислэгийн аюулгүй байдлыг найдвартай хаНган ажиллаж байгааг нь үнэлж "МИАТ" компанийн БОИНГ-727 онгоцны нисгэх багийн дарга Даравгарын Пүрэвдоржид Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 121** **Улаанбаатар хот**

Д. Баяраад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай

Авто тээвэр болон худалдаа үйлчилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн жилүүдэд төвөөс алслагдсан орон нутгийн хүн амд шуурхай үйлчлэн зах зээлд ойртуулж, хөдөлмөрчдийг өргөн хэрэглээний бараагаар хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн Улаангом сумын "Алтан хөхийн оргил" компанийн захирал Дармаагийн Баяраад Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ний өдөр | Дугаар 122 | Улаанбаатар хот

Зарим хүнд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж , мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин олны таашаал хүлээсэн бүтээлүүд туурвиж, хөгжмийн урлагийг хөгжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

1.Гомбожавын Баасанжав - Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын найрал дууны багш,

2.Баянцагааны Түмэнжаргал - Монголын хөгжмийн зохиолч, хөгжмийн зохиолчдын эвлэлийн хорооны бие даасан уран бүтээлч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 123 | Улаанбаатар хот

Л. Чаминчулуунд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, драмын жүжиг, кино, хошин урлагийн хөтөлбөрүүдийн гол, туслах дүрийг амжилттай бүтээн, үзэгчдийн талархал хүлээж, жүжгийн урлагийг хөгжүүлэхэд болон мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Соёл урлагийн их сургуулийн кино драмын тэнхмийн эрхлэгч, жүжигчин Лувсангомбын Чаминчулуунд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 124 | Улаанбаатар хот

Ш. Даваахүүд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, монгол ардын болон зохиолын олон арван дуут чадварлаг дуулж, үзэгч сонсогчдын талархал хүлээн, нийтийн дууны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэж Улсын ардын дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин Шагдарын Даваахүүд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 125 | Улаанбаатар хот

Ө. Батжаргалд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж, ардын болон бусад хөгжмийн зэмсгүүдийг чадварлаг эзэмшин, олон арван жүжиг, концертод амжилттай оролцон тоглож, үзэгч, сонсогчдын талархал хүлээн, хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Өмнөговь аймгийн Хөгжимт драмын театрын гоцлол хөгжимчин Өлзийн Батжаргалд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 126 Улаанбаатар хот

Зарим эмч нарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж эмчилгээ, оношлогооны дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэн олон мянган хүнийг эмчлэн эдгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан эмч нарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

1.Сэрээнэнгийн Балгансүрэн -Эвэсэгт хүчний клиникийн төв эмнэлгийн хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн захирал, их эмч

2.Буяндэлгэрийн Бүлтэн -Клиникийн нэгдүгээр амаржих газрын эмэгтэйчүүдийн тасгийн эрхлэгч, их эмч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 127 Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Хөдөө аж ахуй үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрдэм шинжилгээ, эрүүл мэнд, биеийн тамир спорт, хууль хяналт, банк, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Дарьзавын Шагдар -Монголбанкны мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийн газрын ахлах нягтлан бодогч

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1.Лувсангончигийн Балдан -ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

2.Балгансүрэнгийн Банзрагч -Радио телевизийн сүлжээний газрын ахлах инженер

3.Цэрэндолгорын Батхүү -Нийслэлийн 4 дүгээр цахилгаан станцын ахлах машинч

4.Гомбын Буянхүү -Өмнөговь аймгийн Баяндалай сумын Баян багийн Засаг дарга

5.Дэндэвсүрэнгийн Гомбосүрэн -Батлан хамгаалахын их сургуулийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

6.Гомбожавын Дорж -Үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн "Эрэл" банкны гүйцэтгэх захирал

7.Бүрэгдаагийн Жамбаа -Хөвсгөл аймгийн Галт сумын Засаг даргын Тамгын газрын дарга

8.Пүрэвдоржийн Лувсандорж -Дундговь аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга

9.Жадамбаагийн Лувсанчүлтэм -Үйлдвэрлэл, худалдааны "Буян" ХХК-ийн Ноолуурын үйлдвэрийн ерөнхий механикч

10.Дамдинжавын Марав -Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч

11.Гунгаагийн Од -Өмнөговь аймгийн Гурвантэс сумын малчин

12.Лувсангийн Одончимэд -Монголын улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхийлөгч

13.Нанзадын Сосорбарам -Ахмад хуульч

14.Жавчигийн Сэрээтэр -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын танхимын үйл ажиллагаат дэмжих газрын дарга

15.Цогдогийн Цэдэндамба -ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

16.Мэнтэгсүрэнгийн Цэрэнмадмид -Монголбанкны Архангай аймаг дахь салбарын захирал

17.Ламжавын Шагдаррагчаа -Нийслэлийн "Барилга" корпорацийн ерөнхий захирал

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Цэвэгжавын Хүдэрчулуун -Дорнод аймгийн Цагдаагийн газрын эрүүгийн ахлах төлөөлөгч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Жигжиддоржийн Алтанцэцэг- - Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны тасгийн дарга
2. Намжилын Амарбаясгалан -Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын 10 жилийн сургуулийн багш
3. Жалын Баатар -Үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн тоосгоны үйлдвэрийн ажилчин
4. Ядамжавын Бадрал -ХААИС-ийн Дархан-уул аймаг дахь салбарын зөвлөх багш
5. Дашдондогийн Банзрагч -Нийслэлийн гуравдугаар цахилгаан станцын засварчин
6. Цэрмаагийн Батбилэг - Нийслэлийн барилга үйлдвэрлэлийн "Одкон холдинг" ХХК-ийн бэлдцийн үйлдвэрийн дарга
7. Дашнямын Баттогтох -Сэлэнгэ аймгийн Цагаан-нуур сумын "Баянду-лаан-Уул" ХХК-ийн тракторч-комбайнч
8. Биндэръяагийн Батхуяг -Орхон аймгийн 10 жилийн 1 сургуулийн багш
9. Баттулгын Бат-Эрдэнэ -Увс аймгийн Зүүнхангай сумын засаг дарга
10. Цэндсүрэнгийн Баярбаатар -Нийслэлийн дөрөвдүгээр цахилгаан станцын дарга
11. Сэрээнэнгийн Бямбанайдан -Төв аймгийн Алтанбулаг сумын малчин
12. Батбаярын Ганбаатар -Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажилтан
13. Цогсүрэнгийн Ганболд -Монгол телевизийн "ММ" агентлагийн захирал
14. Лувсандоржийн Гандэндармаа -УБХТН-ийн Хөвсгөл аймгийн зөвлөлийн дарга
15. Дашхүүгийн Гэрэлхүү -Нийслэлийн Багануур дүүрэг дэх Мах боловсруу-лах үйлдвэрийн дарга
16. Дуламжавын Даваацэрэн -Сүхбаатар аймгийн Шуудан холбооны албаны дарга
17. Алтангэрэлийн Дамбадаржаа -Нийслэлийн "Бүрэнбамбай" ХХК-ийн ерөнхий захирал
18. Насанбатын Дамдин -Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 45 дугаар сургуу-лийн багш
19. Дагвын Дариймаа -Ховд аймгийн УЗН-ийн хорооны нарийн бичгийн дарга
20. Галдангийн Даш -Архангай аймгийн Нефть хангамжийн баазын дарга
21. Сүрэнгийн Дашдэлгэр -УБХТН-ийн Завхан аймгийн зөвлөлийн жолоо-ны багш
22. Цэгмэдийн Дашзэвэг - Говь-Алтай аймгийн УЗН-ийн хорооны нарийн бичгийн дарга
23. Найдангийн Дэмчиг -Нийслэлийн "Эх баянгол" ХХК-ийн захирал
24. Цэрэнпилийн Жадамба -Үйлдвэрлэл, худалдааны "Буян" ХХК-ийн ерөнхий технологич
25. Сэрээтэрийн Жалсан -Үйлдвэрлэлийн, үйлчил-ний "Эрэл" ХХК-ийн "Эрэл барилга" ХК-ийн мастер
26. Сономын Жамц -Дэд бүтцийн хөгжлийн яамны мэргэжилтэн
27. Халтарын Жамъяндорж -Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн-гийн ахлах ажилтан
28. Ядамсүрэнгийн Зориг -Дорнод аймгийн биеийн тамир, спортын төвийн дасгалжуулагч

29. Сэгсэнбайн Кэнчлэг -Баян-Өлгий аймгийн Алтай сумын малчин

30. Жамбалын Лхагважав -Биеийн тамирын дээд сургуулийн оюутан

31. Ядамын Лхагвасүрэн -ХАА-н банкны Сүхбаатар аймаг дахь салбарын захирал

32. Цэндийн Лхамсүрэн -Монголбанкны мөнгөн, тэмдэгт, үнэт зүйлсийн газрын тоологч

33. Доржийн Лхасүрэн -Ховд аймгийн Дарви сумын малчин

34. Чимэдийн Мануулу -Төв аймгийн Архуст сумын Засаг даргын Тамгын газрын дарга

35. Көксегенийн Мектив -Төрийн өмчийн IY байрны ашиглалтын захиргааны дарга

36. Хавдалын Мерейхан -Баян-Өлгий аймгийн прокурор

37. Ширбазарын Мягмар -Төрийн хянан шалгах хорооны газрын дарга

38. Лувсандоржийн Мягмарсүрэн -Үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн Алтны үйлдвэрийн ашиглалтын геологич

39. Батсүхийн Намжил -Монголын ахмадын үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбооны тэргүүлэх ажилтан

40. Данзангийн Норовжанцан -Өвөрхангай аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн их эмч

41. Жигмэдравдангийн Нэргүй -"Монгол эмимпекс" концернийн харьяа Арханхангай компанийн захирал

42. Цэнджавын Нянтайсүрэн -Хөвсгөл аймгийн Их-уул сумын Засаг дарга

43. Дөрвөдийн Очир -Дорноговь аймгийн ХАА-н хоршоологчдын холбооны дарга

44. Данзангийн Пүрэв -Хэнтий аймгийн Норовлин сумын дунд сургуулийн багш

45. Равсалын Ринчинбазар -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга

46. Равдангийн Самдандовж -МУЗН-ийн ерөнхий нарийн бичгийн дарга

47. Маадайн Сандаг-Очир -Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын референт

48. Шилагарьдын Солонго -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт

49. Энэбишийн Сумъяа -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт

50. Лочингийн Сэлээд -Завхан аймгийн Прокурорын газрын туслах прокурор

51. Гаадайн Уртнасан -Сэлэнгэ аймгийн Сант сумын "Цагаантолгой" ХХК-ийн агрономч

52. Омарын Хасгарбай -Баян-Өлгий аймгийн Алтай сумын өндөр настан

53. Магсарын Хишигжаргал -Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын операторч

54. Тайвангийн Хулдаа -Баян-Өлгий аймгийн Алтай сумын өндөр настан

55. Чүлтэмийн Цогзолмаа -Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын нягтлан бодогч

56. Гүндсамбын Цэрэнбаатар -Нийслэлийн "Сар хайрхан" компанийн ерөнхий захирал

57. Бадарчийн Цэрэндондов -Баянхонгор аймгийн Баянлиг сумын малчин

58. Цэрэнсономын Цэрэннадмид -Баянхонгор аймгийн Баянлиг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга

59. Дашзэвэгийн Цэрэнсодном -МУЗН-ийн хөтөлбөрийн удирдагч

60. Дамдиндоржийн Цэрэнчанаа -Нийслэлийн Багануур дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн газрын ажилтан

61. Цэрэндоржийн Цэцэгчулуун -"Зууны мэдээ" сонины 1 орлогч эрхлэгч

62. Даваагийн Чойдаш -ХААҮЯ-ны ахлах мэргэжилтэн

63. Лувсанцэрэнгийн Чулуунбат -Монголын ахмадын холбооны дэд дарга

64. Лувсанчойндонгийн Эрдэнэ-Очир -Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын хэлтсийн дарга

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Тавхайн Наран -Цагдаагийн дээд сургуулийн санхүүгийн тасгийн дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Буджавын Адъяасүрэн -Говьсүмбэр аймгийн УЗН-ийн хорооны нарийн бичгийн дарга
2. Цэрэнгончигийн Алтанцэцэг -МУЗН-ийн хөтөлбөрийн зохицуулагч
3. Жадамбын Банзрагч -"Монголын алт" ХХК-ийн уурхайн хэсгийн дарга
4. Лувсанбалдангийн Бямбасүрэн -Үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн Тоосгоны үйлдвэрийн өрөгч
5. Мягмарын Ганбаатар -Нийслэлийн дөрөвдүгээр цахилгаан станцын засварын монтёр
6. Лувсанцэрэнгийн Ганболд -Хөвсгөл аймгийн Тариалан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга
7. Сандагжавын Даваа -Төв аймгийн Заамар сумын хүн эмнэлгийн эрхлэгч
8. Санжаагийн Даваажав -Үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн Барилгын хийц эдлэлийн үйлдвэрийн кранчин
9. Доржзовдын Дашзэвэг -"Монголын алт" ХХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн захирал
10. Даваагийн Дашлай -УБТЗ-ийн Төв засварын газрын цехийн эмч
11. Чулууны Дугуй -Нийслэлийн Баянгол дүүргийн 85 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
12. Лувсаншаравын Зоригтдорж -Сүхбаатар аймгийн "Түмэнцогт" ХК-ийн трактороч
13. Рэнцэнгийн Лхагваа -Зуунмод сумын III дунд сургуулийн захирал
14. Өргөнбаагийн Осоржамаа -Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын хэвлэх үйлдвэрийн нярав
15. Шатарын Пүрэв -Нийслэлийн 10 жилийн I дунд сургуулийн багш
16. Бямбасүрэнгийн Самбуубямба -Үйлдвэрлэл үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн Тоосгоны үйлдвэрийн бульдозерчин
17. Түвшинжаргалын Сарантуяа - Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын хэвлэх үйлдвэрийн хянагч
18. Нуралханы Төлеүбэй -Үйлдвэрлэл, үйлчилгээний "Эрэл" ХХК-ийн Барилгын хийц эдлэлийн үйлдвэрийн цехийн дарга
19. Санжаагийн Түвдэн -Орхон аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн их эмч
20. Сандагийн Цэгмэд -Орхон аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
21. Далхжавын Цэдэнсодном -Хөвсгөл аймгийн Галт сумын байгаль орчныг хамгаалах улсын байцаагч
22. Цоодолын Цэцэгмаа - Үйлдвэрлэл. Худалдааны "Буян" ХХК-ийн ноосны үйлдвэрийн мастер
23. Дарамын Цээлэй -Увс аймгийн Хяргас сумын малчин
24. Дамбадаржаагийн Цээрэгзэн -Баянхонгор аймгийн Баянхонгор сумын I яслийн эрхлэгч
25. Бандиахүүгийн Чогдон -Өвөрхангай аймгийн Гучин-Ус сумын дунд сургуулийн багш
26. Сүхийн Чулуунбаатар -Баян-Өлгий аймгийн Алтай сумын дунд сургуулийн багш

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

Лхамжавын Ганболд -Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн цагдаагийн газрын ахлах төлөөлөгч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 128 Улаанбаатар хот

О. Алтандөлийг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай

Усанд живсэн хоёр хүүхдийн амийг аврахаар эр зориг, хүчлэг ариун сэтгэл гарган тэмцэж амь эрсэдсэн нийслэлийн Чингэлтэй дүүргийн 8 дугаар хорооны иргэн агсан Оюунбаатарын Алтандөлийг "Шударга журам" медалиар нэхэн шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 129 Улаанбаатар хот

Н. Цэнд-Аюушийг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган галын аюулаас хүүхдүүдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Дорноговь аймгийн Сайншанд сумын 4 дүгээр багийн иргэн Нацагдоржийн Цэнд-Аюушийг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 130 Улаанбаатар хот

Л. Наранцэцэг, Д. Цэрэнлхам нарыг "Шударга журам" медалиар шагнах тухай

Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах энэргэнүй үйлст олон жил хувь нэмэр оруулж, иргэний үүргээ нэр төртэй биелүүлж байгаа нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэн, хүндэт донор Лувсандагвын Наранцэцэг, Төв аймгийн Зуунмод сумын "Хүмүүн" цогцолбор сургуулийн үйлчлэгч, хүндэт донор Дашцэрэнгийн Цэрэнлхам нарыг "Шударга журам" медалиар тутс тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИ ЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Дугаар 87 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Байлдаанд оролцсон ахмад дайчлад үнэмлэх, тэтгэмж олгох журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайны оролцогчдод тэтгэмж олгох заавар батлах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл /хуучин нэрээр/-ийн 1986 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Батлан хамгаалахын сайд Ш.ТҮВДЭНДОРЖ

Засгийн газрын 1999 оны 87 дугаар тогтоолын хавсралт

БАЙЛДААНД ОРОЛЦСОН АХМАД ДАЙЧДАД ҮНЭМЛЭХ, ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайнд биечлэн оролцсон ахмад дайчид /цаашид "ахмад дайчид" гэнэ/-д болон дайнд амь үрэгдэгсдийн эхнэр /нөхөр/-т үнэмлэх, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэхэд энэ журмыг дагаж мөрдөнө.

2.Энэ журмын 1 дүгээр зүйлд заасан онуудад байлдааны талбарт болон дайсны шууд хөнөөлийн дор байсан, эсвэл улсын хил давж хилийн цаана тусгай үүрэг, даалгавар биелүүлж явсан хүмүүсийг дайн, байлдаанд биечлэн оролцсонд тооцно.

3. 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайнд энэ журмын 2 дугаар зүйлд заасны дагуу үүрэг гүйцэтгэсэн хүмүүсийг хоёр дайнд оролцсон гэж үзнэ.

4. 1940-1948 онд улсын баруун хил дээр болсон зэвсэгт тулгаралтад оролцсон /6 дугаар морьт бригадын бие бүрэлдэхүүнд багтаж байсан/ хүмүүсийг байлдааанд оролцсон ахмад дайчинд тооцно.

5.1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайны үед байлдаанд оролцоогүй анги, нэгтгэлд алба хаажж байсан, түүнчлэн цэргийн захиалгат бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хангамж, үйлчилгээтэй холбогдсон үүрэг гүйцэтгэж байсан хүмүүс энэ журамд хамаарахгүй.

Хоёр.Байлдааанд оролцсоныг тогтоох, ахмад дайчны үнэмлэх олгох

6.Ахмад дайчны үнэмлэхийг дор дурдсан хүмүүст олгоно:

а/1939 оны байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, 1940-1948 онд улсын баруун хил дээр болсон зэвсэгт тулгаралт /цаашид "байлдаан" гэнэ/-д биечлэн оролцож явсан Монгол ардын хувьсгалт цэргийн болон хязгаарын цэргийн дарга, цэрэг;

б/байлдааны үед улсын аюулаас хамгаалах байгууллагын тусгай үүрэг, даалгавар гүйцэтгэж байсан хүмүүс;

в/байлдааны талбарт хангалт хийж байсан хүмүүс;

г/байлдаанд амь үрэгдэгсдийн бэлбэсэн эхнэр /нөхөр/.

7.Байлдаанд оролцсон хүмүүсийн баримт бичгийг дор дурдсан харьяаллаар бүрдүүлнэ:

а/монгол ардын хувьсгалт цэргийнхнийг Батлан хамгаалах яам;

б/хязгаарын цэргийнхнийг Хилийн цэргийг удирдах газар;

в/улсын аюулаас хамгаалах байгууллагынхныг Улсын аюулгүй байдлыг хангах газар.

8.Тухайн иргэний байлдаанд оролцсоны дараахь үндсэн баримтаар шалгаж тогтооно:

а/зэвсэгт хүчний болон улсын аюулгүй байдлыг хангах байгууллагын төв архивт хадгалагдаж байгаа баримт бичгийн лавлагаа;

б/байлдаанд оролцсон цэргийн анги /байгууллага/ болон командлалаас тухайн хүнийг дайнд биечлэн оролцож явсныг тодорхойлж олгосон үнэмлэх, бусад баримт бичиг;

в/байлдаанд оролцсонтой нь холбогдуулан улсаас шагнасан одон медаль, тэдгээрийн үнэмлэх.

9.Энэ журмын 8 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлсэн баримт бичгийг холбогдох төрийн захиргааны байгууллагын саналын хамтаар Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газарт уламжилна.

10.Бүрдүүлсэн болон магадлан шалгасан баримт бичгийн нотолгоо, саналыг үндэслэн байлдаанд оролцогчийн үнэмлэхийг Батлан хамгаалахын сайдын тушаалаар олгоно.

Гурав.Ахмад дайчинд олгох тэтгэмж, үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ

11.Ахмад дайчид,дайнд амь үрэгдэгсдийн эхнэр /нөхөр/-т олгох тэтгэмж, үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээг холбогдох хууль, эрх зүйн актаар зохицуулна.

12.Байлдаанд оролцсон хүмүүс, дайнд амь үрэгдэгсдийн эхнэр /нөхөр/ ахмад дайчны тэтгэмж олгуулах, хөнгөлөлт, үйлчилгээ эдлэх тухай өргөдлөө оршин суугаа сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийгмийн халамжийн байгууллагад гаргана.

13.Өргөдөлд дараахь бичиг баримтыг хавсаргана:

а/байлдаанд биечлэн оролцсон, дайны улмаас тахир дутуу болсон тухай үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, байлдаанд амь үрэгдсэн тухай архивын тодорхойлолт;

б/оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт.

14.Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нийгмийн халамжийн байгууллага өргөдөл, баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэж, тухайн иргэнд хариу өгнө.

15.Байлдаанд оролцогсод, байлдаанд амь үрэгдэгсдийн эхнэр /нөхөр/-т тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх, тэдгээртэй холбогдсон бүртгэл хөтлөх, тайлагнах ажлыг нийгмийн халамжийн байгууллага хууль тогтоомж, журмын дагуу хэрэгжүүлнэ.

16.Тэтгэмж авагч, хөнгөлөлт, үйлчилгээ эдлэгч оршин суугаа хаягаасаа өөр газарт байнга оршин суухаар тогтоосон журмын дагуу шилжвэл энэ тухайгаа харьяалах нийгмийн халамжийн байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.

17.Тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээтэй холбогдсон баримт бичгийг санаатайгаар бууруу бүрдүүлсэн хүмүүст зохих хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Дугаар 88 **Улаанбаатар хот**

Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол Улсын хуулийн 33 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1997 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 1997-2000 онд хувьчлах хөтөлбөр"-т дор дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

1.Хөтөлбөрийн "Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд" гэсэн "Гурав"-ын 2 дугаар жагсаалтаас 1 дүгээр хавсралтад нэр заасан аж ахуйн нэгжүүдийг хассугай.

2."Хөтөлбөр"-т "Арав.Уралдаант шалгаруулалт (тендер) буюу бусад аргаар хувьчлагдах аж ахуйн нэгжүүд (3 дугаар жагсаалт)" гэсэн жагсаалтыг нэмж оруулан 2 дугаар хавсралтын ёсоор батлуулсугай.

3."Хөтөлбөр"-ийн "Нэг"-ийн 4-т "4.Үнэ, цэнэтэй аж ахуйн нэгж (3 дугаар жагсаалт), Улс орны эдийн засагт ихээхэн ач холбогдолтой аж ахуйн нэгж.Эдгээрт хамрагдах аж ахуйн нэгжүүдийн хувьчлах тухай аж ахуй тус бүрийн онцлогт тохирсон шийдвэрийг Засгийн газраас гаргана." гэж нэмсүгэй.

4."Хөтөлбөр"-ийн "Дөрөв"-ийн 1-д "хоёр хэсгээс" гэснийг "3 хэсгээс" гэж өөрчилж "в/Уралдаант шалгаруулалт (тендер) буюу бусад аргаар хувьчлагдах үнэ цэнэтэй аж ахуйн нэгжүүд (3 дугаар жагсаалт)" гэж нэмсүгэй.

5."Хөтөлбөр"-ийн Гурав.Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд гэсэн 2 дугаар жагсаалтад 124.Улаанбаатар, Хан-уул, Эрчим импэкс, 100, 93 гэж нэмсүгэй.

6."Хөтөлбөр"-ийн "Зургаа.Томоохон аж ахуйн нэгжийг битүүмжилсэн дуудлагын худалдаагаар худалдах журам"-ын "А.4,25 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө бүхий аж ахуйн нэгжүүдийг худалдах журам" гэсэн дэд бүлгийг хүчингүй болсонд тооцсугай.

7."Хөтөлбөр"-ийн "Зургаа.Томоохон аж ахуйн нэгжийг битүүмжилсэн дуудлагын худалдаагаар худалдах журам"-ын "Б.4,25 тэрбум төгрөгөөс доош хөрөнгө бүхий аж ахуйн нэгжүүдийг худалдах журам" гэсэн дэд бүлгийн 1 дэх заалтын "... 4,25 тэрбум төгрөгөөс доош хөрөнгө бүхий томоохон аж ахуйн нэгжүүдийг ..." гэснийг "... томоохон аж ахуйн нэгжүүдийг ... " гэж өөрчлөн найруулсугай.

8.Хөтөлбөрийн "Б.4,25 тэрбум төгрөгөөс доош хөрөнгө бүхий аж ахуйн нэгжүүдийг худалдах журам" гэсэн дэд бүлгийн гарчгийг хассугай.

9."Хөтөлбөр"-ийн "Зургаа"-д дараахь заалтуудыг нэмж оруулсугай.Үүнд:

"...17.Хувьчлагдаж байгаа аж ахуйн нэгж төрийн өмчийн ногдол ашгийн өртэй бол хувьчлах доод үнийг уг өртэй тэнцүү хэмжээгээр нэмэгдүүлнэ.

18.Хувьчлагдаж байгаа аж ахуйн нэгж улсын нөөцийн бараа хадгалдаг бол тухайн аж ахуйн нэгжийн хувьчлалд оролцохыг сонирхогч болон түүнийг хувьчилж авсан этгээд нь уг нөөцийн барааг үргэлжлүүлэн хадгалах талаар тогтоосон журмын дагуу Улсын нөөцийн газартай тохиролцож, баримт бичиг үйлдэж, хамтарсан тушаалаар гэрээ байгуулан ажиллана.

19.Хувьчлагдаж байгаа аж ахуйн нэгж гадаадын болон дотоодын зээлийн өртэй, бүцалтгүй тусламжийн бараа хадгалдаг, борлуулдаг бол уг аж ахуйн нэгжийн хувьчлалд оролцохыг сонирхогч болон хувьчилж авсан этгээд нь уг үүргийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх талаар Сангийн яам, холбогдох газруудтай тохиролцож, баримт бичиг үйлдэнэ.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Сангийн сайд **Я.ОЧИРСҮХ**

Засгийн газрын 1999 оны 88 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Гурав. Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд

(2 дугаар жагсаалт)

А. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд

№	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажилчдын тоо
38	Орхон	Орхон	Эрдэнэт үйлдвэр	51	7393
96	Улаанбаатар	Баянзүрх	Монголросцветмет	51	3931
108	Улаанбаатар	Сүхбаатар	НИК	80	3612
111	Улаанбаатар	Хан-уул	Говь ХК	75	1353
112	Улаанбаатар	Хан-уул	Монголаммикаль	45	211

Б. Улсын үйлдвэрийн газруул

№	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажилчдын тоо
9	Дархан-уул	Дархан-уул	Төмөрлөгийн үйлдвэр	100	475
35	Сэлэнгэ	Сайхан	Цемент шохойн компани	100	740
78	Улаанбаатар	Сүхбаатар	Монгол даатгал	100	370
88	Улаанбаатар	Сүхбаатар	Эмийн үйлдвэр	100	78
93	Улаанбаатар	Хан-уул	МИАТ	100	596
105	Улаанбаатар	Чингэлтэй	Улсын их дэлгүүр	100	395
116	Улаанбаатар	Чингэлтэй	Хөрөнгийн биржс	100	71

Засгийн газрын 1999 оны 88 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Дөрөв. Ураддаант шалгаруулалт (тендер) буюу бусад аргаар хувьчлагдах аж ахуйн нэгжүүд (3 дугаар жагсаалт)

№	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Байгууллагын нэр	Төрийн өмчийн эзлэх хувь	Ажилчдын тоо
1	Дархан-уул	Дархан-уул	Төмөрлөгийн үйлдвэр	100	475
2	Орхон	Орхон	Эрдэнэт үйлдвэр	51	7393
3	Сэлэнгэ	Сайхан	Цемент шохойн компани	100	740
4	Улаанбаатар	Баянзүрх	Монголросцветмет	51	3931
5	Улаанбаатар	Сүхбаатар	НИК	80	3612
6	Улаанбаатар	Сүхбаатар	Монгол даатгал	100	370
7	Улаанбаатар	Сүхбаатар	Эмийн үйлдвэр	100	78
8	Улаанбаатар	Хан-уул	Говь ХК	75	1353
9	Улаанбаатар	Хан-уул	Монголаммикаль	45	211
10	Улаанбаатар	Хан-уул	МИАТ	100	596
11	Улаанбаатар	Чингэлтэй	Хөрөнгийн биржс	100	71
12	Улаанбаатар	Чингэлтэй	Монголын цахилгаан холбоо	54.5	4911
13	Улаанбаатар	Сонгино-хайрхан	Монголболгаргео ХХК	50	300
14	Улаанбаатар	Чингэлтэй	Худалдаа хөгжлийн банк	70	191
15	Улаанбаатар	Багахангай	Мах боловсруулах үйлдвэр	100	58
16	Улаанбаатар	Сүхбаатар	Түшиг даатгал	100	15

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 90 Улаанбаатар хот

Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан цэнхэр тасалбарыг төлбөрт тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт, Монголын хөрөнгийн биржийн захирал О.Батбилэг нарт даалгах нь:

а/хувьчлалын төлбөрт тооцогдоогүй үлдсэн хөрөнгө оруулалтын баталгаажуулсан цэнхэр тасалбарыг индексжүүлэн /тухайн үеийн ТОР-75-аар/ Монголын хөрөнгийн биржээр хувьчлагдах төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниийн хувьчлалын төлбөрт тооцож ажилласугай;

б/хувьчлагдах аж ахуйн нэгжүүдийн төрийн мэдлийн хувьцааг Монголын хөрөнгийн бирж дээр цэнхэр тасалбар болон бэлэн мөнгөөр арилжаалах талаар хамтарсан журам гаргаж, энэ оны 7 дугаар сарын 1-нээс мөрдүүлсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Сангийн сайд Я.ОЧИРСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 91 Улаанбаатар хот

Төсвийн орлогыг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Нэг. Үйл ажиллагаагүй боловсронгуй болгох талаар

1.Бэлэн мөнгөөр худалдаа үйлчилгээ явуулдаг бүх газарт 2000 онд багтаан кассын систем нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан энэ оны 7 дугаар сараас эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

2.Бэлэн мөнгөний гүйлгээг цэгцлэх зорилгоор иргэд гар дээрээс валют солих үйл ажиллагааг журамлан валют солих үйлчилгээний цэгүүдийг банк, санхүүгийн байгууллагын харьяалал, хяналтын дор зохион байгуулах арга хэмжээг 6,7 дугаар сард багтаан авч хэрэгжүүлэхийг Монгол банкны ерөнхийлөгч Ж.Унэнбатад зөвлөж, Сангийн сайд Я.Очирсүх болон Засаг дарга нарт даалгасугай.

3.Аж ахуйн нэгж,байгууллагын тайлан тэнцлийн гаргалтын байдалд дүн шинжилгээ хийх, мэдээ мэдээллийг үнэн зөв гаргах,хувьчлагдсан аж ахуйн нэгжийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр байнгын хяналтын тогтолцоо бий болгох арга хэмжээ авахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт, Үндэсний татварын ерөнхий газрын дарга Ж.Баасандаш нарт үүрэг болгосугай.

Хоёр. Ажлын хариуцлага, дэг журмыг сайжруулах талаар

1.Татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээг санаатайгаар нуусан, бууруулсан байж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд хуулийн хүрээнд хяналт, шалгалт хийж, улсын хэмжээнд татварын хууль тогтоомжийг адил тэгш, жигд сахиулах, төсвийн орлогыг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Сангийн яам, Үндэсний татварын ерөнхий газар, бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

2.Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгох талаар онцгой анхаарч ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

3.Гааль, татвар, шимтгэл, өмч хувьчлалын орлого бүрдүүлэлттэй холбогдсон асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй байгууллагаар нь судалгаа хийлгэж, дүнг нэгттгэн Засгийн газрын нэрийн өмнөөс шүүхэд хүсэлт гаргах ажлыг зохион байгуулахыг Хууль зүйн сайд Л.Цог, Сангийн сайд Я.Очирсүх нарт даалгасугай.

Гурав. Зохион байгуулах ажлын талаар

1.Нийгмийн даатгалын шимтгэл, гаалийн болон бусад албан татварыг барагдуулах, төлөвлөгөөт зорилтоо биелүүлэх чиглэлд эрчимтэй,тодорхой арга хэмжээ хамтран зохион байгуулж дүнг 7 дугаар сарын 5-ны дотор танилцуулахыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга Ж.Баасандаш, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Ц.Сүхбаатар, Гаалийн ерөнхий газрын дарга Т.Лхагваа, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгасугай.

2.Төсвийн орлого бүрдүүлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг 1999 он дуустал түр хугацаагаар байгуулж, түүний бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтын, ажиллах жүрмыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагдуй.

3.Хууль бусаар орлогын эх үүсвэр бүрдүүлж өмч хувьчлалаар объект худалдан авсан, татварын болон банкны зээлийн өр, төлбөрөө барагдуулаагүй этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулахыг Хууль зүйн сайд Л.Цог, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгасугай.

4.Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ эрхлэгч иргэний орлогын албан татварын хуульд хамрах хүрээг нь өргөтгөх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг энэ оны 6 дугаар сард багтаан боловсруулахыг Сангийн сайд Я.Очирсүх, Үндэсний татварын ерөнхий газрын дарга Ж.Баасандаш нарт даалгасугай.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд байгууллага хяналт тавьж улирал тутам Засгийн газарт мэдээлж ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Батбаярт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Сангийн сайд **Я.ОЧИРСҮХ**

Хууль зүйн сайд **Л.ЦОГ**

Засгийн газрын 1999 оны 91 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга -Сангийн сайд

Зөвлөлийн орлогч дарга
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Гишүүд:
- -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- -Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- -Улсын аюулгүй байдлын хангах газрын дарга;
- -Цагдаагийн ерөнхий газрын дарга;
- -Улсын Гаалийн ерөнхий газрын дарга;
- -Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга;
- -Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын дарга;
- -Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга;
- -Үндэсний татварын ерөнхий газрын дэд дарга.
- -Монгол банкны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор)

Нарийн бичгийн дарга

-Үндэсний татварын ерөнхий газрын дарга

Засгийн газрын 1999 оны 91 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРДҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДСОН ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1.Төсвийн орлогыг бүрдүүлэхтэй холбоотой татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/ нь татвараа хугацаанд нь бүрэн төлдөггүй, татварын өрөө барагдуулах талаар санаачилга гаргадаггүй, татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрхээ санаатайгаар нуусан буюу буруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй хуулийн хүрээнд шийдвэрлэгэй тэмцэл явуулж, улсын хэмжээнд татварын хууль тогтоомжийг адил тэгш, жигд сахиулах, төсвийн орлого бүрдүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Батбаярт даалгасугай.

2.Зөвлөл нь Ерөнхий сайдын дэргэд ажиллах бөгөөд орон тооны бус байна. Зөвлөлийн ажлын аппаратын үүргийг Улсын татварын ерөнхий газар гүйцэтгэнэ.

3.Зөвлөл нь дор дурдсан тохиолдолд татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулна.

а/татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн нь мэдэгдэж байгаа болон ноцтой зөрчсөн байж болзошгүй татвар төлөгчийн талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс мэдээлэл ирүүлсэн;

б/татвар төлөгчийн үйл ажиллагаанд хууль хяналтын байгууллагын оролцоотойгоор хяналт, шалгалт хийх шаардлагатай байгаа талаар татвар, гаалийн байгууллагаас хүсэлт тавьсан;

в/хууль тогтоомжийн дагуу төлөх ёстой татвараа хугацаанд нь бүрэн төлөөгүй буюу төлөхөөс зайлсхийсэн этгээдийн орлого, эд хөрөнгөөс татварын өр төлбөрийг хууль хяналтын байгууллагын оролцоотойгоор гаргуулах талаар гааль, татварын байгууллагаас хүсэлт ирүүлсэн.

4.Энэ журмын 3 дугаарт заасан мэдээлэл, хүсэлтийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь зөвлөлийн нарийн бичгийн даргад албан ёсоор ирүүлнэ.

5.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн мэдээлэл, хүсэлтийн дагуу татвар төлөгчийн үйл ажиллагаанд татварын хяналт, шалгалт хийх шаардлагатай бол зөвлөлийн нарийн бичгийн дарга татвар, гааль болон хууль хяналтын байгууллагуудын оролцох оролцоог нарийвчлан заасан хяналт, шалгалт хийх ажлын удирдамж, төлөвлөгөөг боловсруулж зөвлөлийн хуралд танилцуулж, зөвлөлийн даргаар батлуулна.

6.Хяналт, шалгалт хийх ажлын удирдамжид шалгагдах татвар төлөгчийн нэр, хаяг, улсын бүртгэлийн дугаар, шалгалт хийх хугацаа, шалгалтанд хамаарах үйл ажиллагааны хугацаа, шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт, шалгалтын дүнг гаргаж хэлэлцэн шийдвэрлүүлэх хэлбэрийн талаар тодорхой тусгана.

7.Хяналт, шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гааль, татварын байгууллагын төлөөлөгчдийг оруулах ба шаардлагатай гэж үзвэл хууль, хяналтын байгууллагын мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

8.Хяналт, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон хүмүүсийг хяналт, шалгалт хийх хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлж хяналт, шалгалтын ажлыг хугацаанд нь бүрэн хийх нөхцөл боломжоор хангана.

9.Ажлын хэсэг нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх зарчим баримтлан "Татвар нөгдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай" хуулийн хүрээнд ажиллана.

10.Ажлын хэсэг нь хяналт, шалгалттай холбогдсон шаардлагатай баримт, материалыг аж ахуйн нэгж, банк, санхүүгийн байгууллагаас гаргуулж авах эрхтэй.

11.Хяналт, шалгалтын ажлыг хугацаанд нь дуусгах боломжгүй бол ажлын хэсгийн ахлагчийн хүсэлтийг үндэслэн хугацааг нь сунгах шийдвэрийг зөвлөл гаргана.

12.Ажлын хэсэг нь хийсэн шалгалтын талаар дэлгэрэнгүй танилцуулга болон шалгалтын мөрөөр авах арга хэмжээний талаархи саналын төсөл бэлтгэж зөвлөлд танилцуулна.

Хяналт шалгалтын материалыг зөвлөлд танилцуулахдаа шалгагдсан татвар төлөгч, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг заавал байлцуулна.

13.Зөвлөл нь ажлын хэсгээс гаргасан танилцуулга, авах арга хэмжээний талаархи саналыг 7 хоногийн дотор хэлэлцэж хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

14.Хяналт, шалгалтын үйл ажиллагааны явц, шийдвэрийн талаар Зөвлөлөөс албан ёсны мэдээллийг Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаар дамжуулан олон нийтэд хүргэж байна.

15.Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл татвар төлөлт, хураалттай холбогдсон асуудлыг тодорхой арга хэмжээ авахуулахаар Засгийн газарт танилцуулж болно.

16.Зөвлөл нь татварын өрийг барагдуулах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар холбогдох байгууллагад хугацаатай үүрэг өгч, биелэлтэд нь хяналт тавина.

17.Зөвлөлийн шийдвэрийн дагуу татварын хяналт, шалгалт хийхэд шаардлагатай хөрөнгө зардлыг холбогдох байгууллагуудын төсөвт зардлаас, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын нөөц, холбогдох бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД, ХУУЛЬ ЗҮЙН САЙД, САНГИЙН САЙД, БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 100/78/54/53** **Улаанбаатар хот**

Журам батлах, комисс байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 153 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, авто тээврийн хэрэгсэлд техникийн үзлэг тооллого явуулах ажлын чанарыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Автотээврийн хэрэгслийн техникийн үзлэг, тооллого явуулах журмыг 1 дүгээр, автотээврийн хэрэгслийн үзлэг, тооллогын төв комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтаар тус тус батална сугай.

2. Автотээврийн хэрэгслийн техникийн үзлэг, тоологын бэлтгэл ажлыг бүрэн хангуулж, тогтоосон хугацаанд чанартай явуулж, дүн мэдээг жил бүрийн III улиралд багтаан холбогдох байгууллагуудад илтгэхийг үзлэг, тоологын төв комисст даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Дэд бүтцийн хөгжлийн сайд, Замын цагдаагийн газар, татварын ерөнхий газрын даргын 1994 оны 70/64/48 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД **Г. БАТХҮҮ**

ХУУЛЬ ЗҮЙН САЙД **Л. ЦОГ**

САНГИЙН САЙД **Я. ОЧИРСУХ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **С. МЭНДСАЙХАН**

Дэд бүтцийн хөгжлийн сайд, Хуульзүйн сайд, Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 100, 78, 54, 53 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ТООЛЛОГО ЯВУУЛАХ ТӨВ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга Г. Ёндонгомбо	ДБХЯ-ны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын дарга
Нарийн бичгийн дарга Ц.Оюунбилэг	ДБХЯ-ны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын дэс түшмэл
Гишүүд Н. Лхагваа	Дэд бүтцийн Улсын хяналтын албаны дарга
П. Ориг	Авто тээврийн газрын дарга
Ж. Угантөр	Авто тээврийн газрын орлогч
Т. Занашир	Замын цагдаагийн газрын дарга
А. Баасан	Замын цагдаагийн газрын техник бүртгэлийн хэлтсийн дарга
Э. Гомбожав	Хотын ерөнхий менежер
С. Пионер	Хотын замын цагдаагийн газрын дарга
Ш. Цэрэндорж	Үндэсний татварын ерөнхий газрын хэлтсийн дарга
Я. Батцоож	Үндэсний татварын ерөнхий газрын хэлтсийн дарга
З. Батжаргал	БОХЯ-ны газрын дарга
Н. Нямдаваа	Хотын тээвэр зохицуулах газрын дарга

Дэд бүтцийн хөгжлийн сайд, Хуульзүйн сайд, Сангийн сайд, Байгахль орчны сайдын хамтарсан 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 100, 78, 54, 53 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГО ЯВУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Автотээврийн хэрэгслийн техникийн улсын үзлэг явуулах энэхүү журмын зорилго нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр ашиглагдаж байгаа бүх төрлийн автотээврийн хэрэгслийн техникийн байдлын улсын үзлэг явуулах, байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг тогтоох, хяналт тавих, дүгнэлт, мэдээ гаргах журам, зарчим, автотээврийн хэрэгсэл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд болон техникийн улсын үзлэг эрхлэх явуулах байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, эрх зүйн үндсийг тодорхойлж эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаат зохицуулахад оршино.

1.2.Энэ журмыг тээврийн хэрэгсэл эзэмшдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд дагаж мөрдөнө.

1.3.Үзлэг тооллогод бүх төрлийн автотээврийн хэрэгслийг жилд нэг удаа хамруулна.

1.4.Улсын үзлэг тооллогын төв комссыг Дэд бүтцийн хөгжлийн сайд, Хууль зүйн сайд, Сангийн

сайд, Байгаль орчны сайдын хамтарсан тушаалаар томилно. Аймаг, нийслэл, дүүргийн үзлэг тооллогын комиссийг Засаг даргын захирамжаар томилох ба шаардагдах хөрөнгийг тухайн орон нутгийн Засаг даргын тамгын газар хариуцаж энэ зардлыг жил бүрийн улсын төсөвт нэмэлт маягаар тусгуулна.

1.5.Автотээврийн хэрэгслийн техникийн улсын үзлэг, техникийн тооллого явуулах ажлын техникийн ажуулгүй байдлын магадлан оношлогоог Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто
тээврийн газар, техникийн тоолого бүртгэлийг Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн газар, экологийн магадлан шинжилгээг Байгаль орчны яамны Ус, Цаг уур, орчны шинжилгээний газар, тээврийн хэрэгслийн татварын хураалтыг Сангийн яамны Үндэсний Татварын ерөнхий газар тус тус хариуцна.

1.6.Үзлэг тооллогоор техник ашиглалтын шаардлага хангасан автотээврийн хэрэгслийг хөдөлгөөнд орохыг зөвшөөрсөн гэрчилгээ олгож, зохих тэмдэглэлийг хийнэ. Техникийн талаар зохих шаардлага хангаагүй тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгохгүй.

1.7.Зөвсөгт хүчний авто тээврийн хэрэгсэлд явуулах үзлэг тооллогыг түүний ашиглалтын болон техникийн албад хариуцан явуулах бөгөөд улсын нэгдсэн мэдээнд тусгана.

1.8.Тус улсад суугаа гадаадын дипломат болон олон улсын байгуулагын автотээврийн хэрэгсэлд хийх үзлэг, тооллогыг Гадаад харилцааны яамтай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр гүйцэтгэнэ.

Хоёр. Аймаг, хот, дүүргийн үзлэг тооллогын комиссийн эрх үүрэг.

2.1.Үзлэг тооллого эхлэхээс 20 хоногийн өмнө явуулах хугацаа, газрыг тодорхой заасан хуваарь гаргаж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд урьдчилан мэдэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

2.2.Үзлэг тооллогыг хуваарийн дагуу явуулж бүхий л ажлыг зохион байгуулна.

2.3.Үзлэг тооллогын явц, чанар, орвол зохих тээврийн хэрэгсэл бүрэн хамрагдсан эсэхэд хяналт тавина.

2.4.Автотээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, үзлэг, тооллогын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар тухайн нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хугацаатай үүрэг өгч биелэлтэд хяналт тавина.

2.5.Үзлэг тооллогын бэлтгэл ажил, явц, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохионо.

2.6.Үзлэг тооллогоор авто тээврийн хэрэгслийн төрөл загвар, улсын дугаар, арал, бүхээг, хөдөлгүүрийг дугаар, өнгө, зориулалт зэрэг үзүүлэлтийг ашиглалтын дэвтэр буюу гэрчилгээтэй нь тулгаж үзэхийн зэрэгцээ жолоочийн үнэмлэх, талон тухайн ангиллын тээврийн хэрэгсэлд тохирч байгаа эсэх, түүнийг жолоодохыг зөвшөөрсөн эмнэлгийн магадлалыг шалгана.

2.7.Автотээврийн хэрэгслийн бүртгэлийн үзүүлэлтүүд бичиг баримттай нь зөрсөн буюу засвартай байвал зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглож, холбогдох байгууллагаар шалгуулж шийдвэрлэнэ.

2.8.Шуурхай албаны болон технологийн шаардлагын дагуу ашиглагдах тээврийн хэрэгсэлд тавигдсан тоног төхөөрөмж, өнгө, будаг, бичлэг, гэрэл ба дуут дохио стандартын дагуу байгаа эсэхийг шалгана.

2.9.Үзлэг, тоологын бэлтгэлийг хангаагүй буюу үзлэгээс зайлсхийлсэн аж ахуйн нэгж байгууллагын холбогдох албан тушаалтан, жолооч, иргэдийг Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн арга хэмжээ авах ба тухайн тээврийн байгуулга, тээврийн хэрэгслийг Замын хөдөлгөөнд оролцохыг
хориглох шийдвэр гаргана.

/ашиглахыг хориглосон, гэмтэлтэй буюу зохих зөвшөөрөлгүйгээр өөрчлөн тоноглосон тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон, тогтоосон жүрмын дагуу бүртгүүлээгүй, техникийн улсын үзлэгт хүндэтгэх шалгааныгүйгээр оруулагчийг албан тушаалтан иргэдэд Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан арга хэмжээ авах ба тухайн хэрэгслийг Замын хөдөлгөөнд оролцохыг хориглох шийдвэр гаргана/

2.10.Үзлэг тооллогын дүн мэдээ, цаашид авах арга хэмжээг тусгасан илтгэх хуудас, материалыг үзлэг тоологын төв комисст ирүүлэх бөгөөд төв комисс нэгтгэн дүгнэж 20/VII-ны дотор Засгийн газарт танилцуулна.

Гурав. Тээврийн хэрэгслийг эзэмшиж, ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үүрэг

3.1.Тээврийн хэрэгслийг эзэмшиж, ашиглаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь тухайн тээврийн хэрэгслийг техникийн үзлэг тооллогод заавал хамруулах үүрэгтэй.

3.2.Үзлэг тооллогын өмнө аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь өөрсдийн эзэмшлийн тээврийн хэрэгслийн техникийн байдалд үзлэг хийж, илэрсэн эвдрэл гэмтлийг засах, өнгө үзэмжийг сайжруулах, тээврийн хэрэгслийн хувийн хэргийг бүрэн хөтлөж техник ашиглалтыг тодорхойлж дүгнэлт өгөх үзүүлэлтийг бэлтгэхийн хамт ашиглалтын данснаас хасч, сэлбэгт задалж хэрэглэсэн тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулж үзлэг эхлэхээс 1 сарын өмнө өөрсдийн эзэмшлийн тээврийн хэрэгслийн жагсаалтыг аймаг, хот, дүүргийн Замын цагдаагийн албанд гарган өгч Улсын бүртгэлтэй тулгасан байна.

3.3.Аймаг, нийслэл, дүүргийн үзлэг тооллогын комиссоос гаргасан хуваарийн дагуу тогтоосон байр, талбайд буюу цэгт тээврийн хэрэгслийг бэлэн байлгана.

3.4.Үзлэг тооллого явагдахаас өмнө жолооч нарын сахилга хариуцлагыг тодорхойлж тэдний эрүүл мэндийг үзүүлж магадлуулсан байна.

3.5.Тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон ашиглалтын дэвтэр бусад бичиг баримтыг үзлэг тооллогын комисст шалгуулна.

3.6.Төв болон аймаг, нийслэл, дүүргийн үзлэг тооллогын комиссоос өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлж хариу мэдэгдэнэ.

3.7.Оношлох, засварын аж ахуй, авто аж ахуй болон бусад эзэмшигч байгууллагууд үзлэг, тооллого явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг бэлтгэн өгч ажиллуулах, шаардлага гарвал зохих мэргэжлийн хүмүүсээр уг ажилд туслуулах үүрэгтэй.

3.8.Кран төхөөрөмжтэй тээврийн хэрэгслийг үзлэг тооллогод бэлтгэхдээ кран төхөөрөмжийн ажиллагааны баталгааг Дэд бүтцийн Улсын хяналтын албанаас авсан байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

Улсын архивын хэрэгцээнд

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот. 1999 оны долдугаар сарын 28. №34 (113)

Гарчиг

Монгол Улсын Хууль

331. Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай (1999 - 7 - 1-ний хууль) 635

332. Компанийн тухай (1999 - 7 - 2-ны хууль) 645

333. Нөхөрлөл, компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (1999-7-16-ны хууль) 682

334. Гэрээ соёрхон батлах тухай (1999-7-9-ний хууль) 682

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр **Улаанбаатар хот**

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ АЛБАДАН СААТУУЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчи йг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль тогтоомж

2.1.Албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,[1] Эрүүгийн байцаан шийтгэх хууль,[2] энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

[2] Эрүүгийн байцаан шийтгэх хууль-"Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл" сэтгүүлийн 1963 оны 6 дугаарт нийтлэгдсэн

3 дугаар зүйл. Албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх зарчим

3.1.Албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэхэд хууль дээдлэх, хүнлэг ёс, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримтална.

3.2.Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдэд эрүү шүүлт тулгах, эсэхүл бусад арга хэрэглэн түүний бие махбодийг тарчлаан зовоох буюу сэтгэл санааны дарамтад оруулахыг хориглоно.

4 дүгээр зүйл. Албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл

4.1.Гагцхүү Эрүүгийн байцаан шийтгэх хууль зүй саасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоол нь албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл болно.

5 дугаар зүйл. Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн байдал

5.1.Албадан саатуулагдсан, цагдан хоригдсон этгээд /цаашид "хоригдсон этгээд" гэх/ нь энэ хуулиар хязгаарласнаас бусад Монгол Улсын иргэний эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ.

5.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт албадан саатуулагдсан, цагдан хоригдсон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль,[1] энэ хууль болон бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Монгол Улсын иргэний адил эрх, эрх чөлөө эдэлж, үүрэг хүлээнэ.

5.3.Хоригдсон этгээдийн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран энэ хууль нэгэн адил үйлчилнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ АЖИЛТНЫ ЭРХ, ҮҮРЭГ, ЦАГДАН ХОРИХ НӨХЦӨЛ, ЖУРАМ

6 дугаар зүйл. Албадан саатуулах, цагдан хорих байрны тогтолцоо

6.1.Нийслэлд цагдан хорих төв, албадан саатуулах байр, аймгуудад цагдан хорих, албадан саатуулах байр /цаашид "хорих байр" гэх/ байна.

6.2.Нийслэл дэх цагдан хорих төв нь цагдаагийн төв байгууллагын, аймаг, сум, дүүргийн хорих байр нь тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын харьяанд тус тус ажиллана.

6.3.Нийслэл дэх цагдан хорих төв нь хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

6.4.Төв, суурин газраас алслагдсан нутаг дэвсгэрт байгаа цэргийн анги, салбарын сахилгын хорих байранд сэжигтнээр 14 хоног хүртэл хугацаагаар цагдан хорьж болно. Цэргийн анги, салбарын сахилгын хорих байранд мөрдөх журмыг цэргийн дүрмээр зохицуулна.

7 дугаар зүйл. Хорих байр байгуулах, өөрчлөх, татан буулгах

7.1.Хорих байр байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон цагдаагийн төв байгууллагын даргын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Хорих байрны санхүүжилт

8.1.Нийслэл дэх цагдан хорих төвийн зардлыг улсын төвлөрсөн төсвөөс, бусад цагдан хорих, албадан саатуулах байрны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

[1] Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль-"Ардын эрх" сонины 1994 оны 1 дүгээр сарын 11-ний 7, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 2 дугаарт тус тус нийтлэгдсэн.

9 дүгээр зүйл. Хорих байрны захиргааны нийтлэг үүрэг

9.1.Хорих байрны захиргаа нь дараахь нийтлэг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хоригдсон этгээдэд түүний эрх, үүрэг, хорих нөхцөл, журмын талаар тайлбарлах;

9.1.2.хоригдсон этгээд болон бусад хүмүүсээс хорих байрны талаар гаргасан өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлэж хариу өгөх;

9.1.3.хоригдсон этгээд нэг бүрт хувийн хэрэг нээх;

9.1.4.хоригдсон этгээдийн аюулгүй байдлыг хангаж өөртөө болон бусдад хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх.

10 дугаар зүйл. Хорих байрны ажилтан, түүний эрх, үүрэг

10.1.Хорих байрны ажилтнууд нь хамгаалалтын болон үйлчилгээний ажилтнаас бүрдэнэ.

10.2.Хорих байрны офицер, ахлагч, түрүүчийг хамгаалалтын ажилтан гэх бөгөөд тэдгээр нь цагдаагийн байгууллагын ажилтны эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

10.3.Хорих байрны ажилтнуудад дараахь зүйл хийхийг хориглоно:

10.3.1.хорих байранд энэ хуульд зааснаас бусад гадны хүмүүсийг нэвтрүүлэх;

10.3.2.хоригдсон этгээдтэй албаны бус зүйл ярих, уулзах, зохих зөвшөөрөл, хяналтгүйгээр хоол хүнс, хувцас, захидал болон бусад зүйл дамжуулах;

10.3.3.галт зэвсэг, тусгай хэрэгсэл, хорих өрөөний түлхүүрийг бусдад шилжүүлэх;

10.3.4.тухайн хэргийг шалган шийдвэрлэх үүрэг хүлээсэн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээс бусад албан тушаалтан болон байгууллага, иргэнд хоригдсон этгээдийн талаар лавлагаа өгөх;

10.3.5.хоригдсон этгээдтэй хүнлэг бус харьцах;

10.3.6.ганцаараа байх үедээ хорих өрөөг онгойлгох, хорих өрөөнд орох.

11 дүгээр зүйл. Хорих байранд нэвтрэх

11.1.Гадны хүмүүс хорих байранд нэвтрэх, ажил байдалтай нь танилцах, засвар үйлчилгээ, ариутгал, эмчилгээ хийх зөвшөөрлийг цагдан хорих төвийн болон аймаг, дүүргийн цагдаагийн байгуулагын дарга олгоно.

11.2.Хоригдсон этгээдийн хэргийг шалгаж байгаа буюу хянан шийдвэрлэх гэж байгаа хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, прокурор, шүүгч түүнтэй уулзахаар хорих байранд үнэмлэхээ үзүүлж нэвтрэх эрхтэй.

11.3.Биеийн байцаалттүй, галт болон хүйтэн зэвсэг, тусгай хэрэгсэл бүхий хүнийг хорих байранд нэвтрүүлэхийг хориглоно.

12 дугаар зүйл. Хорих байрны хамгаалалт

12.1.Нийслэл дэх цагдан хорих төвийн гадуур хамгаалалтыг дотоодын цэрэг, дотуур хамгаалалтыг цагдаагийн алба хаагчид хариуцна. Бусад хорих байрыг цагдаагийн алба хаагчид хамгаална.

12.2.Хорих байрны хамгаалалтад гэрэлтүүлэг, дохиолол, теле хяналтын хэрэгсэл болон нохой ашиглаж болно.

12.3.Хамгаалалтын ажилтан галт зэвсэг, бусад тусгай хэрэгслээр хангагдах ба тэдгээрийг Цагдаагийн байгууллагын тухай хуульд[1] заасан үндэслэлээр, журмын дагуу хэрэглэнэ.

12.4.Харуул хамгаалалтын ээлж солигдох бүрт хоригдсон этгээд нэг бүрийг тоглоол, захирамжтай нь тулгаж бүртгэн хүлээлцэнэ.

13 дугаар зүйл. Хорих өрөөнд тавигдах шаардлага

13.1.Хоригдсон этгээдийн байрлах өрөө нь төмөр хаалгатай, онгойлгох хязгаарлагчтай, хяналтын шагайвартай, гадна талдаа цооктой, цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, агаажуулах салхивчтай, модон шалтай, эсхүл модон наартай байх бөгөөд хорих өрөөний чийглэг 55-60 хувь, өвлийн улиралд 18 хэмээс багагүй дулаантай байна.

14 дүгээр зүйл. Хорих хугацаа

14.1.Хоригдох этгээдийг шүүгчийн захирамж болон прокурорын баталсан тогтоолыг үндэслэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хугацаагаар хорино.

[1] Цагдаагийн байгууллагын тухай хууль-"Ардын эрх" сонины 1993 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 211, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 8 дугаарт тус тус нийтлэгдсэн.

15 дугаар зүйл. Хоригдсон эттээдийн хувийн хэрэг

15.1.Хоригдох эттээдийг хорих байранд хүлээн авахдаа хорих байрны захиргаа энэ хуулийн 9.1.3-т зааснаар хувийн хэрэг нээх бөгөөд түүнд дараахь зүйлийг хавсаргана:

15.1.1.тухайн эттээдийг хорих тухай шийдвэр;

15.1.2.хоригдох эттээдийн гэрэл зураг;

15.1.3.хоригдох эттээдийн хуруугны хээний дарц (дактокарт);

15.1.4.эргэлт, уулзалт, хувцас сольсон талаархи тэмдэглэл;

15.1.5.хорих байранд ороход түр хураалгасан бичиг баримт, эд зүйлс, мөнгө, үнэт зүйл;

15.1.6.хоригдох эттээдийн хувийн байдлын талаархи мэдээлэл;

15.1.7.эрүүл мэндийн байдал, биеийн жингийн талаархи мэдээлэл;

15.1.8.өлсгөлөн зарласан, эмчид үзүүлсэн, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгчийг дуудуулсан зэрэг үйл явдлын талаарх тэмдэглэл;

15.1.9.хорих байранд ирсэн болон суллагдсан он, сар, өдөр, цагийн талаархи тэмдэглэл.

15.2.Хорих ял шийтгүүлсэн эттээдийн хувийн хэргийг хорих ял эдлүүлэх байгууллагад шилжүүлнэ.Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн бол хувийн хэргийг хорих байрны захиргаа гурван жилээс багагүй хугацаагаар хадгална.

16 дугаар зүйл. Хорих байрны дотоод журам

16.1.Хорих байранд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батална "Хорих байрны дотоод журам"-ыг дагаж мөрдөнө.

16.2.Хорих байрны дотоод журмаар дараахь асуудал зохицуулна:

16.2.1.хоригдох эттээдийг хүлээн авах, хорих өрөөнд байрлуулах;

16.2.2.хоригдсон эттээдэд хориглох зүйл;

16.2.3.хоригдсон эттээдэд өгөх цай, хоолны хэмжээ, хоригдол тус бүр хоолоо идэж байгаа эсэхэд хяналт тавих;

16.2.4.хоригдсон эттээдийн бие, эд зүйлд үзлэг хийх;

16.2.5.хоригдсон эттээдийг эргэх, түүнтэй уулзах;

16.2.6.хоригдсон эттээд захидал, цахилгаанаар харилцах;

16.2.7.хоригдсон эттээд ном, сонин, сэтгүүл авиглах;

16.2.8.хоригдсон эттээд шашны зан үйл үйлдэх;

16.2.9.хоригдсон эттээдийн эмнэлэг, ариун цэврийн үйлчилгээ;

16.2.10.хоригдсон эттээдийг салхилуулах;

16.2.11.хоригдсон эттээдийг мөрдөн байцаах ажиллагаа, шүүх хуралдаанд оруулах, буцаан авчрах;

16.2.12.хорих өрөөнд гаднаас хүн ороход түүний аюулгүй байдлыг хангах.

16.3.Хорих байны дотоод журамд хоригдсон эттээд хорих өрөөнд авч орж болох гутал, хувцас, бусад хэрэгцээтэй зүйл, түүнчлэн төлбөртэй үйлчилгээний төрлүүдийг тодорхой тусгана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХОРИГДСОН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

17 дугаар зүйл. Хоригдсон эттээдийн эрх

17.1.Хоригдсон эттээд дараахь эрх эдэлнэ:

17.1.1.өөрийн эрх, үүрэг, хорих байрны дотоод журам, өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхийн талаар мэдээлэл, тайлбар авах;

17.1.2.өөрийн хувийн аюулгүй байдлыг хангуулах;

17.1.3.хорих байрны дарга болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтантай хорих байранд ажиллах үеэр нь хувираа уулзах;

17.1.4.өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах;

17.1.5.энэ хуулийн 19-д заасан хүмүүстэй уулзах;

17.1.6.улсын нууцтай холбоотой болон гэмт үйлдэлд холбогдолтой урвуулан ашиглаж болзошгүйгээс бусад, өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах баримт бичиг, бичлэгийг биедээ хадгалах;

17.1.7.ном, сонин, сэтгүүл, ариун цэврийн хэрэгсэл өрөөндөө байлгах;

17.1.8.энэ хуулиар тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн унтах байр, дэвсгэр, хучлагаар хангагдах;

17.1.9.шөнийн цагт 8 цагаас багагүй хугацаагаар унтаж амрах;

17.1.10.эмнэлгийн тусламжийг Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль[1] заасан журмын дагуу авах;

17.1.11.хорих байны дотоод журамд заасны дагуу захидал, цахилгаанаар харилцах, бичгийн хэрэгсэл авиглах;

17.1.12.хорих байны дотоод журам зөрчихгүйгээр шашны зан үйл үйлдэх;

17.1.13.хорих байны дотоод журамд заасан хугацаагаар салхинд гарах;

17.1.14.боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх, шаардлагатай сурах бичиг, ном авиглах;

17.1.15.эргэлт авах;

17.1.16.иргэний эрх зүйн хэлцэлд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох;

[1] Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль-"Ардын эрх" сонины 1993 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 117, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 4-5 дугаарт тус тус нийтлэгдсэн.

17.1.17.өөрт холбогдох асуудлаар болон хорих байрны нөхцөл, журам, үйл ажиллагааны талаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах.

18 дугаар зүйл. Хоригдсон эрүүдийн үүрэг

18.1.Хоригдсон эрүүд дараахь үүрэгтэй:

18.1.1.хорих байрны дотоод журмыг чанд сахиж, хорих байрны ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

18.1.2.ариун цэврэр, эрүүл ахуйн шаардлагыг сахих;

18.1.3.хорих байрны ажилтныг ажил, үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулахгүй байх;

18.1.4.хуурамчаар өвчилсөн, эрүүл мэнд болон бие эрхтэнээ санаатайгаар хохирол, гэмтэл учруулсан бол эмчилгээний зардлыг хувиасаа төлөх;

18.5.хорих байрны эд зүйлийг эвдэж гэмтээх, нууцаар хулалдаа, наймаа хийх хэрэг зөрчил гаргахгүй байх.

19 дүгээр зүйл. Хоригдсон эрүүд өмгөөлөгч болон төрөл садан, бусад хүмүүстэй уулзах

19.1.Хоригдсон эрүүд нь хорих байранд өөрийн өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзаж болно. Уулзалт зохион байгуулахад өмгөөлөгчийн эрхийн үнэмлэх болон аймаг, нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлийн олгосон томилолтыг үндэслэх бөгөөд уулзалтын тоо болон хугацаа хязгаарлахгүй.

19.2.Хоригдсон эрүүдийг хорих шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны бүюу түүний удирдах дээд албан тушаалтны бичгээр олгосон зөвшөөрлөөр төрөл садан болон бусад хүмүүстэй уулзуулж болно.

19.3.Хоригдсон гадаад улсын иргэн нь энэ хуулийн 19.2-т заасан албан тушаалтны зөвшөөрлөөр хорих байрны захиргаагаар дамжуулан өөрийн улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажилтантай уулзаж болно.

19.4.Хоригдсон эрүүд өмгөөлөгч, төрөл садан болон бусад хүмүүстэй уулзахад хорих байрны харуул хамгаалалтын ажилтан байлцана. Хоригдсон хүнсний болон бусад зүйл, эсхүл гэмт хэргийн бодит үнэнийг тогтоохоод саад учруулах буюу гэмт хэрэг үйлдэхэд хүргэх мэдээлэл дамжуулахыг оролдсон тохиолдолд уулзалтыг нэн даруй таслан зогсооно.

20 дугаар зүйл. Хоригдсон эрүүдийн аюулгүй байдлыг хангах

20.1.Хоригдсон эрүүдийн амь нас, эрүүл мэндэд аюул тулгарсан, хоригдсон бусад эрүүдийн зүгээс түүнд заналхийлсэн, довтолсон тохиолдолд хорих байрны ажилтан хоригдсон эрүүдийн хувийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ цаг алдалгүй авах үүрэгтэй.

21 дүгээр зүйл. Захидал, харилцаа

21.1.Хоригдсон эрүүд төрөл садан болон бусад хүмүүстэй зохих журмын дагуу захидал, цахилгаанаар харилцах бөгөөд зардлыг өөрөө хариуцна.

21.2.Хоригдсон эрүүдэд ирсэн болон тэднээс явуулсан захидал, цахилгааныг хорих байрны захиргаа заавал хянана. Гэмт хэргийн бодит үнэнийг тогтооход саад нууцтай холбоотой захидал, цахилгаанаас хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд шилжүүлнэ.

21.3.Хоригдсон эрүүд нь ял эдэлж байгаа хүмүүстэй захидал, цахилгаанаар харилцахад зөвхөн хорих шийдвэр гаргасан албан тушаалтны зөвшөөрлийг үндэслэнэ.

21.4.Хоригдсон эрүүдийн нэр дээр ирсэн захидал, цахилгааныг хорих байрны захиргаа хүлээн авснаас хойш ажлын гурав хоногийн дотор хүлээлгэн өгөх ба гадаад хэл дээрх захидал, цахилгааныг монгол хэлэнд орчуулахад шаардлагатай хугацааг энэ хугацаан дээр нэмж тооцож болно.

21.5.Хоригдсон эрүүдийн ойрын төрөл, садангийн хүн хүнд өвчтэй байгаа, эсхүл нас барсан тухай мэдээг түүнд нэн даруй хүргэнэ.

21.6.Хорих байранаас суллагдсан эрүүдийн нэр дээр ирсэн захидал, цахилгааныг хорих байрны захиргаа хүлээн авснаас хойш ажлын гурав хоногийн дотор хаягаар нь илгээнэ.

22 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргах

22.1.Хоригдсон эрүүд нь төрийн болон нутгийн захиргаа, бусад байгууллага, албан тушаалтанд явуулах өргөдөл, санал, гомдлоо хорих байрны захиргаагаар дамжуулан илгээнэ.

22.2.Шүүх, прокурор болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий төрийн бусад байгууллагад явуулах өргөдөл, санал, гомдлыг хорих байрны захиргаа хянаж шалгаж болохгүй бөгөөд өргөдөл, санал, гомдлыг хүлээн авсан одрийн дараагийн өдрөөс хэтрүүлэхгүйгээр битүүмжилсэн дуртийгаар зохих байгууллагад илгээнэ.

22.3.Энэ хуулийн 22.2-т зааснаас бусад төрийн байгууллага, албан тушаалтан, түүнчлэн өмгөөлөгчид хаягласан өргөдөл, санал гомдлыг хорих байрны захиргаа хянаж, хүлээн авсан

33.4.Хураасан хориотой хүнсний болон бусад эд зүйлийг хорих байрны дагсын үндэслэл бүхий тогтоолоор зохих акт үйлдэж устгана.

33.5.Хоригдсон эгтээдийн биед хийх үзлэгийг түүнтэй ижил хүйсний хамгаалалтын ажилтан хийх бөгөөд үзлэгээр илэрсэн гэмтэл, шарх сорви болон биеийн жин, өндөр, оншлог, содон тэмдгийг бүртгэж, хувийн хэрэгт нь бүрэн тэмдэглэнэ.

33.6.Эмийн зүйлийг хоригдсон эгтээдэд байлгах эсэхийг хорих байрны эмчийн саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

33.7.Хорих байранд нэвтэрч байгаа хорих байрны хамгаалалтын ба үйлчилгээний ажилтан болон бусад эгтээд нь хорих байранд нэвтрүүлэхийг хориглосон эд зүйл авч яваа гэж үзэх тодорхой үндэслэл байвал тэдний бие, хувцас, эд зүйл, унаанд үзлэг хийж болно. Харин хорих шийдвэр гаргасан албан тушаалтан, өмгөөлөгч, прокурор, шүүгчийн бие, хувцас, эд зүйлд үзлэг хийхийг хориглоно.

34 дүгээр зүйл. Сахилгын шийтгэл ногдуулах, эдлүүлэх, чөлөөлөх

34.1.Дараахь зөрчил гаргасан сэжигтэн, яллагдагчийг сахилгын өрөөнд 15 хоног хүртэл, насанд хүрээгүй бол 7 хоног хүртэл хугацаагаар хорино:

34.1.1.хорих байрны ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй;

34.1.2.хорих байрны ажилтныг дороможилсон, түүн рүү дайрч довтолсон;

34.1.3.хоригдсон бусад эгтээдийг дарамталсан, дороможилсон;

34.1.4.соггууруулах болон мансууруулах ундааны зүйлийг бэлтгэсэн, хадгалсан, хэрэглүүлсэн;

34.1.5.хоригдсон хүнсний болон бусад эд зүйлийг бэлтгэсэн, хадгалсан, хэрэглэсэн;

34.1.6.мөрийтэй тоглосон;

34.1.7.жижүүр танхайрсан.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан зөрчил гаргасан эгтээдийг хорих байрны дагсын тогтоолыг үндэслэн сахилгын өрөөнд хорино.

34.3.Хоригдсон эгтээдийн гаргасан нэг зөрчилд нэгээс илүү сахилгын шийтгэл ногдуулж болохгүй.

34.4. Сахилгын шийтгэлийг зөрчил илрүүлсэн өдрөөс, хэрэв зөрчлийн талаар шалгаж тогтоох шаардлагатай бол шалгалтыг дууссан өдрөөс гурав хоногийн дотор, гэхдээ зөрчил гарснаас хойш нэг сарын дотор ногдуулна.

34.5.Сахилгын шийтгэл ногдуулахад зөрчил гаргасан эгтээдээс бичгээр тайлбар гаргуулах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзсан тохиолдолд энэ талаар тэмдэглэл үйлдэнэ.

34.6.Хоригдсон эгтээд сахилгын шийтгэлийн талаар эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхэд гомдол гаргах эрхтэй. Ийнхүү гомдол гаргасан тохиолдолд түхайн шийдвэрийн хэрэгжилтийг гурав хүртэл хоног түдгэлзүүлж болно.

34.7.Сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг даруй хэрэгжүүлэх бөгөөд түхайн нөхцөл байдалд тийм бололцоогүй бол шийтгэл ногдуулсан өдрөөс хойш арав хоногийн дотор хэрэгжүүлнэ.

34.8.Хорих байрны дарга нь эмчийн магадлагаа болон бусад үндэслэлээр сахилгын өрөөнд хорих шийтгэлийг биелүүлэхийг хойшлуулах, эсүл сахилгын өрөөнд хоригдож байгаа эгтээдийг хугацаанаас нь өмнө суллах, хугацааг нь багасгаж болно. Хэрэв иймхүү хойшлуулсан хугацаанд хоригдсон эгтээд нь дахин зөрчил гаргаагүй бол шийтгэлийг нөхөж эдлүүлэхгүй.

34.9.Зөрчил гаргасан эгтээдийг сахилгын өрөөнд ганцаарчлан хорино. Сахилгын өрөөнд шөнийн цагаар хүчлага, дэвсгэр тавьж олгоно. Сахилгын өрөөнд хоригдсон эгтээдэд сахилгын шийтгэлийг эдэлж дуустал захидал, цахилгаанаар харилцах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, өмгөөлөгчөөс бусад хүмүүстэй уулзах, хүнсний болон нэн хэрэгцээтэй зүйлийг худалдан авах, эргэлт авах, ном, сонин, сэтгүүл унших эрхийг нь хязгаарлана. Сахилгын өрөөнд хоригдож байхад нь илрүүлсэн эргэлтийг сахилгын өрөөнөөс суллагдсаны дараа олгоно. Сахилгын өрөөнд хоригдож байгаа эгтээдийг өдөрт 15 минут салхинд гаргана.

34.10.Сахилгын өрөөнд хоригдсон эгтээдийн эрхийг энэ хуульд зааснаас өөрөөр хязгаарлахыг хориглоно. Сахилгын өрөөнд хоригдсон эгтээдээс гаргасан өргөдөл, санал, гомдлыг энэ хуулийн 22-т заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

35 дугаар зүйл. Хоригдсон эгтээд учруулсан хохирлоо хариулах

35.1.Хоригдсон эгтээд нь хорих байрны эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг иргэний хууль тогтоомжид заасан журмаар төлнө.

35.2.Учруулсан хохирлын хэмжээг хорих байрны дагсын тогтоолоор тогтоно. Тогтоолыг уг эгтээдэд танилцуулж, гарын үсэг зуруулах бөгөөд тогтоолыг эс зөвшөөрвөл эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхэд гомдол гаргаж болно.

35.3.Хоригдсон эгтээд учруулсан хохирлоо сайн дурааралаа төлөхөөс татгалзвал хорих байрны захиргаа шүүхэд нэхэмжлэл гаргана.

35.4.Хохирлыг хоригдсон эгтээдийн садан төрөл, бусад хүмүүс барагдуулж болно.

35.5.Хохирол учруулсан эгтээд хохирлыг барагдуулалгүйгээр эл эдлүүлэх байгууллагад шилжсэн тохиолдолд хорих байрны захиргаа нь энэ тухай түхайн байгууллагад мэдэгдэж, ялтны хөдөлмөрийн хөлс болон бусад орлогоос хохирлыг төлүүлнэ.

35.6.Хохирол учруулсан эгтээд хохирлыг барагдуулалгүйгээр хорих байрнаас суллагдсан тохиолдолд хорих байрны захиргаа нь ердийн журмаар нэхэмжлэл гаргана.

35.7.Хоригдсон этгээдэд хорих байрны захиргааны бууруугаар эд материалын хохирол учирсан бол хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргана.

36 дугаар зүйл. Өлсгөлөн зарлах

36.1.Хоригдсон этгээд өлсгөлөн зарласнаа мэдэгдвэл хорих байрны дарга хэргийг нь шалгаж байгаа албан тушаалтан, прокурор, өмгөөлөгчид гурван цагийн дотор мэдэгдэж, бусад этгээдээс тусгаарлан эмчийн хяналтад авна.

36.2.Өлсгөлөн зарласан этгээдийн биеийн байдал, жин, өгсөн хоол, цай идэж уухыг татгалзсан тухай өдөр бүр тэмдэглэл үйлдэж, хувийн хэргэг нь хавсаргана.

36.3.Өлсгөлөн зарласан этгээдийн амь насанд аюул учирч болох тохиолдолд эмчийн бичгээр гаргасан дүгнэлтийг үндэслэн түүний эрүүл мэндийг сайжруулах албадлагын арга хэмжээ авч болно.

36.4.Өлсгөлөн зарласан нь өөр хорих байранд шилжүүлэх болон мөрдөн байцаах ажиллагаа, шүүх хуралдаанд оролцуулахаар хуяглан авч явахад саад болохгүй. Шаардлагатай тохиолдолд ийнхүү хуяглан авч явахад эмнэлгийн ажилтанг байлцуулна.

36.5.Өлсгөлөн зарласан этгээдийн тавьсан шаардлага үндэслэлтэй бол хорих байрны захиргаа шаардлагыг биелүүлэх боломжтой бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

36.6.Хоол, цай идэж уусан үеэс эхлэн өлсгөлөнг зогссонд тооцно.

37 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх

37.1.Хорих байрны хамгаалалтын болон дэг журам сахиулах үүрэг бүхий ажилтан энэ хууль, бусад хууль тогтоомжид заасан тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

38 дугаар зүйл. Мэх хэрэглэх

38.1.Хоригдсон этгээдийн гаргасан зөрчлийг хүч хэрэглэхгүйгээр таслан зогсоох боломжгүй бол хамгаалалтын ажилтан зэвсэггүйгээр туладлах мэх хэрэглэж болно.

39 дүгээр зүйл. Тусгай хэрэгсэл хэрэглэх

39.1.Дараахь тохиолдолд хоригдсон этгээдэд тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

39.1.1.хоригдсон этгээд хорих байрны хамгаалалтын болон дэг журам сахиулах үүрэг бүхий ажилтан, бусад хүмүүс рүү хүч хэрэглэн довтолсон;

39.1.2.хорих байрны дотоод журмыг бүлэглэн зөрчсөн, олныг хамарсан үймээн гаргасан;

39.1.3.хүн, барилга байгууламж, тээвэрийн хэрэгсэл барьцаалсан;

39.1.4.хоригдсон этгээд оргох, өөртөө гэмтэл учруулахыг завдсан.

40 дүгээр зүйл. Тусгай хэрэгсэл хэрэглэх

40.1.Тусгай хэрэгсэлд дараахь төрлийн хэрэгсэл хамаарна:

40.1.1.резинэн бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

40.1.2.гав;

40.1.3.албаны нохой;

40.1.4.усан хөөрөг болон хуягт машин.

40.2.Дараахь тусгай хэрэгслийг дор дурдсан тохиолдолд хэрэглэнэ:

40.2.1.резинэн бороохой, албаны нохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг энэ хуулийн 39-д заасан зөрчлийн үед;

40.2.2.гавыг энэ хуулийн 39.1.1, 39.1.4-д заасан зөрчлийн үед;

40.2.3.усан хөөрөг болон хуягт машиныг энэ хуулийн 39.1.2, 39.1.3-т заасан зөрчлийн үед хэрэглэнэ.

41 дүгээр зүйл. Галт зэвсэг хэрэглэх

41.1.Дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

41.1.1.хорих байрны ажилтан болон хоригдсон этгээд, бусад хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулахаар довтолсон;

41.1.2.хорих байрны ажилтны зэвсгийг булаахаар довтолсон;

41.1.3.барьцаалагдсан хүн, барилга байгууламж, тээврийн хэрэгслийг чөлөөлөх;

41.1.4.хорих байрны барилга байгууламж, тээврийн хэрэгслийг эзлэхээр бүлэглэн довтолсон;

41.1.5.зэвсэг хэрэглэн эсэргүүцэж байгаа этгээд болон хорих байрны ажилтан, бусад хүмүүсийн эсрэг хүч хэрэглэн довтолж байгаа этгээдийг баривчлахад;

41.1.6.хорих байрнаас оргосон этгээдийг баривчлах болон онц хүнд, хүнд гэмт хэрэгт мөрдөгдөж байгаа этгээдийг хуяглан хүргэх үед оргоохоор завдсан;

41.1.7.хорих байрны ажилтнаас зэвсгээ хураалгахыг шаардсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн;

41.1.8.хоригдсон этгээдийг хүч хэрэглэн суллахыг оролдсон.

42 дугаар зүйл. Хорих байранд онцгой дэглэм тогтоох

42.1.Дараахь тохиолдолд цагдаагийн төв байгууллагын дарга Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн ЗО хүртэл хоногийн хугацаагаар хорих байрайд онцгой дэглэм тогтоож болно:

42.1.1.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

42.1.2.тахал, гоц халдварт бусад өвчин болон их хэмжээний түймэр гарсан;

42.1.3.нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон;

42.1.4.хорих байранд зэвсэглэн халдсан;

42.1.5.бусад.

42.2.Онцгой дэглэм тогтоосон үед хоригдсон этгээдийн оролцоотой зохион байгуулагдаг бүх ажиллагааг зогсоох бөгөөд хорих байранд хүч нэмэгдүүлсэн хамгаалалт тогтоож, эргэлт, уулзалт, захидал харилцааг хориглон хуульд заасан бусад шаардлагатай арга хэмжээ авна.

42.3.Хоригдсон эгтээд болон бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд шууд аюул тулгарсан онцгой тохиолдолд хорих байны дарга энэ хуулийн 42.2-т заасан арга хэмжээг шуурхай авч, энэ тухайгаа цагдаагийн төв байгууллагын даргад нэн даруй мэдэгдэнэ.

42.4.Хорих байранд тогтоосон онцгой дэглэмийг түүнийг тогтоосон албан тушаалтан, эсхүл эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтан цуцална.

ТАВДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

43 дугаар зүйл. Хоригдсон этгээдийг суллах үндэслэл

43.1.Дараахь байгуулагa, албан тушаалтны шийдвэр нь хоригдсон этгээдийг суллах үндэслэл болно:

43.1.1.хуульд заасан журмын дагуу гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж;

43.1.2.прокурорын болон прокуророор батлуулсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн тогтоол;

43.1.3.хуульд заасан хорих хугацаа нь дуусан этгээдийг суллах тухай хорих байны даргын, эсхүл прокурорын тогтоол.

44 дүгээр зүйл. Хоригдсон этгээдийг суллах журам

44.1.Хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийг суллах тухай энэ хуулийн 43-т заасан тогтоол, захирамжийг хүлээн авмагц холбогдох этгээдийг нэн даруй суллана.

44.2.Хорих байрны дарга нь хоригдсон этгээдийг хуульд заасан хорих хугацаа дуусах болсон тухай 24 цаг ба түүнээс дээш хугацааны өмнө хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд болон харьяалах прокурорт бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

44.3.Энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалтанд мэдэгдсэн боловч хоригдсон этгээдийг цаашнь үргэлжлүүлэн хорих, эсхүл суллах тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр хорих байрны захиргаанд ирээгүй бол хорих байны дарга өөрийн тогтоолоор хуульд заасан хорих хугацаа дуусмагц хоригдсон этгээдийг нэн даруй суллана.

44.4.Хорих байрнаас суллагдсан этгээдэд түүнийг хорих үед хураасан зүйл, мөнгө, бичиг баримтыг хувийн хэрэгт байгаа бүртгэлийн дагуу хүлээлгэн өгч, гарын үсэг зуруулна.

45 дугаар зүйл. Прокурорын хяналт

45.1.Хорих байрны үйл ажиллагаа, нөхцөл, журам нь энэ хуульд хэрэхэн нийцэж байгаад Улсын ерөнхий прокурор болон түүний харьяа прокурорууд хяналт тавина.

45.2.Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд хяналт тавих эрх бүхий прокурор болон хэрэг хянаж байгаа прокурор нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

45.2.1.хорих байранд ямар ч цагт саадгүй нэвтрэх;

45.2.2.хоригдсон этгээд, бусад хүмүүстэй уулзах;

45.2.3.хоригдсон этгээдийн хувийн хэрэг болон шаардлагатай бусад материалтай танилцах;

45.2.4.өргөдөл, санал, гомдол, хэрэг зөрчлийг хянах, шалган шийдвэрлэх.

45.3. Энэ хуулийн 45.2-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан прокурорын шийдвэрийг хорих байрны захиргаа, ажилтан биелүүлэх үүрэгтэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

1999 оны 7 дугаар сарын 2-ны өдөр **Улаанбаатар хот**

КОМПАНИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь компани үүсгэн байгуулах, бүртгэх, өөрчлөн байгуулах, компанийн удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувь нийлүүлэгчдийн эрх, үүргийг тогтоох болон компани татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2.1.Энэ хууль болон Монгол Улсын бусад хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа бүх компани өмчийн хэлбэр, эд хөрөнгийн болон үйлдвэрлэлийн хэмжээ, дотоод зохион байгуулалтаас үл хамааран энэ хуулийг дагаж мөрдөнө.

2.2.Банк, санхүү, даатгал, үнэт цаасны салбарт компани үүсгэн байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны онцлогтой холбогдсон асуудлыг бусад хуулиар, нийтлэг асуудлыг энэ хуулиар тус тус зохицуулна.

2.3.Төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах замаар байгуулагдсан компанийн үйл ажиллагаат энэ хуулиар, тэдгээрийг үүсгэн байгуулахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар[1] зохицуулна.

2.4.Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн ба орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

2.5.Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн үйл ажиллагаат энэ хуулиар зохицуулна. Энэ тохиолдолд өмчлөгч нь төр байх бөгөөд хувь нийлүүлэгчид нь Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага байна.

2.6. Компаниас өөр хэлбэрийн ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг байгуулахтай холбогдсон харилцаа, тэдгээрийн үйл ажиллагаат бусад хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

КОМПАНИ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

3 дугаар зүйл. Компани, түүний хэлбэр

3.1.Хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагдаг, өөрийн тусгаарлагдсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.

3.2.Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа нэг эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

3.3.Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтооно. Хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар болон зарим асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг хуваалцахаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.

3.4.Компани нь дараахь хэлбэртэй байна:

3.4.1.хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй буюу хувьцаат компани;

3.4.2.хувь нийлүүлэгчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь компанийн дүрмээр хязгаарлагддаг хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани .

[1] Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль - "Ардын эрх" сонины 1996 оны 118, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1996 оны 11 дүгээрт тус тус нийтлэгдсэн.

4 дүгээр зүйл. Нээлттэй буюу хувьцаат компани

4.1.Нээлттэй буюу хувьцаат компанийн /цаашид энэ хуульд "хувьцаат компани" гэх/ хувьцаа эзэмшигч нь бүсад хувьцаа эзэмшигчийн саналыг харгалзахгүйгээр өөрийн эзэмшиж байгаа хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.

4.2.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн тоог компанийн дүрмээр хязгаарлахгүй.

4.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно. Хаалттай захиалгын үндсэн дээр нэмж гаргасан хувьцааг худалдан авагч нь цаашид түүнийг чөлөөтэй захиран зарцуулах эрх эдэлнэ.

4.4.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид өөр хоорондоо тохиролцсоны үндсэн дээр хувьцаагаа захиран зарцуулах эрхээ харицлан хязгаарласан гэрээ байгуулж болно. Энэ гэрээний үйлчлэх хугацаа нь 10 жилээс дээшгүй байх бөгөөд гэрээг хэдэн ч удаа сунгаж болно.

5 дугаар зүйл. Хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компани

5.1.Хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн /цаашид энэ хуульд "хязгаарлагдмал хариуцлагатай компани" гэх / үүсгэн байгуулагчдын тоо 50-иас дээшгүй байна. Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдсаны дараа хувьцаа эзэмшигчдийн тоог хязгаарлахгүй.

5.2. Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, тэдгээрийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт өөрөөр үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргана. Тэдгээрээс бусад үнэт цаасыг компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаат ба хаалттай захиалгын үндсэн дээр гаргаж болно.

5.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид нь компанийн бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, тэдгээрийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт өөрөөр үнэт цаасыг гурав дахь этгээдэд санал болгох үнээр эзэмшиж байгаа хувьцаанаасаа тоонд хувь тэнцүүлэн энэ зүйл болон компанийн дүрэмд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

5.4.Хувьцаагаа худалдахаар санал тавьж байгаа хувьцаа эзэмшигч нь саналаа бусад хувьцаа эзэмшигчдэд бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд худалдах гэж байгаа хувьцааны төрөл, тоо, худалдах үнэ, тэргүүн ээлжинд худалдан авч болох хувьцааны тоо, худалдан авах хугацаа, журмыг тодорхойлсон байна.

Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах хувьцаа эзэмшигч нь энэ шийдвэрээ тогтоосон хугацааны дотор бичгээр компанид мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд худалдан авч байгаа хувьцаа эзэмшигчийн овог, нэр, хаяг, худалдан авах хувьцааны тоо, төлбөр хийсэн баримт зэргийг тусгасан байна. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаат тэргүүн ээлжинд авах эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хэрэгжүүлэх, эсхүл энэ эрхээ бүхэлд нь буюу зарим хэсгийг нь бусад хувь нийлүүлэгчдэд шилжүүлэх эрхтэй.

5.5.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.3-т заасан эрхийг хувьцаа эзэмшигч тогтоосон хугацаанд бүрэн эдлээгүй тохиолдолд тэдгээрийг худалдан авах эрх компанид шилжих бөгөөд компани нь энэ эрхийг мэдэгдэлд заасан хугацаа дуусснаас хойш ажлын 5 хоногийн дотор хэрэгжүүлнэ.

5.6.Энэ хуулийн 5.3, 5.5-д заасан этгээдүүд тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хувьцаагаа худалдахаар санал тавьж байгаа хувьцаа эзэмшигч нь мэдэгдэлд заасан үнээс багагүй үнээр гуравдагч этгээдэд худалдах эрхтэй.

6 дугаар зүйл. Хараат болон охин компани

6.1.Компанийн нийт энгийн хувьцааны 20-51 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ. Хараат компани нь бие даасан тайлан баланс гаргадаг хуулийн этгээд байна.

6.2.Компанийн нийт энгийн хувьцааны 51-ээс 100 хүртэл хувийг өөр /толгой/ компани дангаараа эзэмшдэг бие даасан хуулийн этгээдийг охин компани гэнэ. Охин компани нь тусдаа санхүүгийн тайлан гаргахын зэрэгцээ толгой компанитайгаа нэгдсэн тайлан гаргана.

6.3. Хараат болон охин компани нь толгой компанийн өрийг хариуцахгүй бөгөөд тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол толгой компани нь хараат болон охин компанийн өрийг хариуцахгүй.

6.4. Толгой компани нь гуравдагч компанийн хараат болон охин компани байвал түүний охин компани нь гуравдагч компанийн хувьд мөн хараат болон охин компани болох бөгөөд энэ зарчмыг үүнээс ч илүү үргэлжилсэн хэлхээ холбоонд ашиглан хамаарлыг тогтооно.

6.5.Хараат болон охин компани нь толгой компанийн хувьцаат эзэмшиж болно. Охин компанийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй бөгөөд хувь нийлүүлэгчдийн хурлын ирцийг тооцохдоо тэдний эзэмшиж байгаа хувьцаат хасч тооцно. Эдгээр хувьцаат гуравдагч этгээдэд шилжүүлэхэд уг этгээдэд хувьцааны бүх эрх шилжинэ.

6.6. Компани өөрийн хараат болон охин компани, тэдгээрийн хараат, охин компануид болон бусад компанитай үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор нэгдэж болно.

6.7. Нэгдлийн оролцогчид нь бие даасан хуулийн этгээд хэвээр байх бөгөөд оролцогчдын үйл ажиллагааг уялдуулахад чиглэсэн харилцаг Иргэний хуульд[1] заасан жүрмын дагуу байгуулсан гэрээгээр зохицуулна.

6.8.Энэ хуулийн 6.7.-д заасан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд толгой компани нь хараат болон охин компанийн үйл ажилагааанд зөвхөн эзэмшиж байгаа хувьцааны эрхээр оролцоно

7 дугаар зүйл. Компанийн салбар, төлөөлөгчийн газар

7.1.Компанийн салбар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг тусгай нэгж бөгөөд компанийн үндсэн чиг үүргийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь, түүнчлэн төлөөлөгчийн газрын үүргийг гүйцэтгэж болно.

7.2.Компанийн төлөөлөгчийн газар нь компанийн оршин байгаа газраас өөр газар байрладаг нэгж бөгөөд компанийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулна.

7.3.Компани нь Монгол Улсад болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ гаргана.

7.4.Гадаадын хуулийн этгээдийн Монгол Улсад оршин байгаа салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэх байгууллагад бүртгүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадад салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг тухайн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.5.Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд түүнийг байгуулсан компаниас батална журмын дагуу үйл ажиллагаа эрхэм явуулна. Салбар, төлөөлөгчийн газрын үй хөрөнгийг түүнийг байгуулсан компанийн баланст тусгана.

7.6.Компанийн салбар, төлөөлөгчийн газар нь үйл ажиллагаагаа түүнийг байгуулсан компанийн нэрийн өмнөөс явуулна. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрын хүлээх үүргийг хариуцна.

7.7.Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрын эрх баригчийг томилох бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндэсэн дээр үйл ажиллагаа явуулна.

8 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааны чиглэл, байгуулах хугацаа

8.1.Компани нь хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд компани эдгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардагдах эрх, үүргийг хүлээнэ.

8.2.Компанийн эрхлэх үйл ажиллагааны хүрээг дүрмээр хязгаарлаж болно. Ингэж хязгаарласан нь энэ хязгаарлалтыг мэдэхгүйгээр хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа гуравдагчи этгээдийн өмнө уг компанийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.3.Хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа эрхлэх компани нь холбогдох эрх бүхий байгууллагаас бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр энэ үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

8.4.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийг тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулна.

9 дүгээр зүйл. Компанийн болон хувь нийлүүлэгчдийн хариуцлага

9.1.Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

9.2.Компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй.

9.3.Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

9.4. Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч болон бусад хэлбэрээр компанийн үйл ажиллагаат тодорхойлох эрх бүхий этгээдийн бүруутай үйл ажиллагааны улмаас компанид учирсан эд хөрөнгийн хохирлыг уг этгээд өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

[1] Иргэний хууль- "Ардын эрх" сонины 1994 оны 257, 258, 1995 оны 1, 2; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дүгээрт тус тус нийтлэгдсэн

9.5. Хувь нийлүүлэгчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувь нийлүүлэгч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

10 дугаар зүйл. Компанийн оноосон нэр, оршин байгаа газар

10.1.Компани оноосон нэртэй байх бөгөөд түүнийг хэрэглэх тохиолдол бүрд уг нэрийн ард компанийн хэлбэрийг тодорхойлсон хувьцаат компани буюу "ХК", хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК" гэсэн ялгах тэмдэглэл заавал заасан байна.

10.2.Компанийн оноосон нэр нь бусад компани, аж ахуйн нэгжийн оноосон нэртэй давхардаагүй байх бөгөөд компани оноосон нэрээ бүртгэх байгууллагад бүртгүүлснээр уг оноосон нэрийг хэрэглэх онцгой эрх авна.

10.3.Компани нь бүртгэх байгууллагад бүртгэгдсэн өөрийн бэлгэдэл болон барааны тэмдэгтэй байж болно.

10.4.Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний тэргүүлэх байгууллагын оршин байгаа газраар тодорхойлно. Тэдгээрийн өөрчлөлтийг тухай бүр бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

КОМПАНИ БАЙГУУЛАХ

11 дүгээр зүйл. Компани байгуулах

11.1.Компанийг шинээр буюу хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах /нэгдэх, нийлэх, хуваах, туслаарлах, өөрчлөх/ замаар байгуулж болно.

11.2.Компанийг хувьчлах замаар үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчийн үүргийг төр хуулээс бөгөөд хувьцааны захиалга авах, худалдах, шилжүүлэх ажиллагаат Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

12 дугаар зүйл. Компанийн үүсгэн байгуулагч

12.1.Компанийн үүсгэн байгуулагч нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, түүнчлэн хуульд заасан бол гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн байж болно.

12.2.Компаниас гаргасан хувьцааг иргэн, хуулийн этгээд, гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн эзэмшиж болно.

12.3.Компани нэг үүсгэн байгуулагчтай байж болно.

12.4.Компанийн үүсгэн байгуулагч нь тухайн компанийн хувьцааг эзэмшихгүй байж болно.

12.5.Төр, түүний байгууллага нь дараахь тохиолдолд компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувь нийлүүлэгч байж болно:

12.5.1.төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн;

12.5.2.төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн;

12.5.3. хууль тогтоомжид заасан жүрмын дагуу дампуурч байгаа компанийн төрд төлөх өрийг хувьцаагаар нь сольж авсан компанийн. Энэ төхиолдолд төр эдгээр хувьцааг 3 жилийн дотор бусад этгээдэд худалдах үүрэгтэй;

12.5.4.гадаадын хуулийн этгээдтэй хамтран байгуулсан компанийн;

12.5.5.хуульд заасан бусад.

12.6.Компанийг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг компанийн үүсгэн байгуулагчид хамтран хариуцна. Үүсгэн байгуулах хурлын буюу төлөөлөн удирдах зөвлөл / хэрэв нэг үүсгэн байгуулагчтай бол үүсгэн байгуулагч/-ийн шийдвэрээр энэ зардлыг компани хариуцаж болно.

12.7.Компанийг үүсгэн байгуулахтай холбогдсон зардлыг төлсөн этгээд нь бусад үүсгэн байгуулагчдаас эзэмшиж байгаа болон эзэмшихээр захиалсан хувьцааны тоотой нь хувь тэнцүүлэн энэ зардлыг нэхэмжлэн авах, эсхүл гаргасан зардлынхаа хэмжээнд хувьцаа эзэмших эрхтэй.

12.8.Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь бусад компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч байж болно.

13 дугаар зүйл. Шинээр компани үүсгэн байгуулах

13.1.Энэ хуулийн 13.2.-т заасны дагуу боловсруулсан төслийг нийтэд /хувьцаат/ санал болгож хувьцааны захиалга авах, эсхүл цөөн тооны этгээдээс /хаалттай/ захиалга авах аргаар

шинээр компани үүсгэн байгуулж болно.

13.2.Хувьцааны захиалга авах аргаар шинээр компани үүсгэн байгуулах төсөлд дор дурдсан зүйлийг тусгана:

13.2.1.эрхлэх үйл ажиллагааны чиглэл;

13.2.2.хувь нийлүүлэн хөрөнгийн төлөвлөсөн хэмжээ;

13.2.3.зарлах хувьцааны тоо, нэрлэсэн үнэ;

13.2.4.шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаа явуулах хугацаа;

13.2.5.төлөвлөсөн ашгийн хэмжээ;

13.2.6. захиалга эхлэх, дуусах хугацаа.

13.3.Нийтэд санал болгосон хувьцааны захиалга авахтай холбогдсон харилцааг Үнэт цаасны хороонооос гаргасан журмын дагуу зохицуулна.

13.4.Хувьцааны захиалгыг захиалгын хуудсаар авах бөгөөд түүнд захиалагчийн овог, нэр, захиалсан хувьцааны төрөл , ангилал, тоо, үнийн дүн, захиалсан огноо зэрэг зүйлийг тусгах бөгөөд захиалагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурсанаар захиалга хийгдсэнд тооцно.

13.5.Захиалсан нийт хувьцааны 30 хувьтай тэнцэх төлбөрийг захиалгын хугацаа дууссанаас хойш ажлын 30 хоногийн дотор хийнэ.

13.6.Төлбөр хийгдсэн хувьцааны үнийн дүн нь хуулиар тогтоосон өөрийн хөрөнгийн доод хэмжээнд хүрсэн бол компани байгуулах нөхцөл бүрдсэн гэж үзнэ.

13.7.Компани үүсгэн байгуулагдын хурлын шийдвэрээр компанийг үүсгэн байгуулна. Компанийг нэг эзтээд байгуулж байгаа тохиолдолд тухайн эзтээд нь үүсгэн байгуулах шийдвэр гаргана.

13.8.Компанийг нэгээс илүү үүсгэн байгуулагч байгуулах нөхцөлд үүсгэн байгуулагчид нь компанийг үүсгэн байгуулах талаар хамтран ажиллах гэрээ байгуулж болох бөгөөд энэ гэрээнд үүсгэн байгуулагчын хамтран ажиллах журам, үүсгэн байгуулагч тус бүрийн хүлээх үүрэг, тэдгээрийн худалдан авах хувьцаа болон бусад үнэт цаасны ангилал, төрөл тус бүрийн тоо, үнэ, худалдан авах хугацаа зэрэг шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгана. Энэ гэрээ нь компанийг үүсгэн байгуулах баримт бичигт хамаарахүй.

13.9.Хувьцаагаа нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн компани буртгэх байгууллагад бүртгүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор нийтэд санал болгож байгаа хувьцаагаа Үнэт цаасны тухай хуульд[1] заасан журмын дагуу Үнэт цаасны хороонд бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл. Компани үүсгэн байгуулах хурал

14.1.Компани үүсгэн байгуулах хурлыг үүсгэн байгуулагчид зарлан хуралдуулна.

14.2.Үүсгэн байгуулагчид санал нэгтэйгээр өөрөөр шийдвэрлээгүй бол үүсгэн байгуулагч бүр үүсгэн байгуулах хуралд саналын тэнцүү эрхтэй оролцоно.

14.3.Үүсгэн байгуулах хурлаар дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

14.3.1.компани байгуулах тухай шийдвэр;

14.3.2. компанийн дүрэм;

14.3.3.зарласан болон гаргах хувьцаа, тэдгээрээс үүсгэн байгуулагчынх худалдан авах үнэ;

14.3.4. төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

14.3.5.хянан шалгах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгох, тэдгээрийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

14.3.6.компани үүсгэн байгуулахад гаргасан зардлыг нөхөн олгох журам;

14.3.7.захиалсан хувьцааны төлбөрийн үлдэгдлийг төлж дуусгах хугацаа.

14.4.Үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх үүсгэн байгуулагчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэрийг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар гаргана.

14.5.Хурал даргалагчийг үүсгэн байгуулагчдаас сонгоно.

14.6.Үүсгэн байгуулагчид мөнгөн бус хэлбэрээр төлбөр хийх тохиолдолд санал болгож байгаа эд хөрөнгийнхээ үнийн талаар шаардлагатай гэж үзвэл үнэлгээний байгууллага болон холбогдох мэргэжлийн шинжээчдийн дүгнэлт гаргуулан санал боловсруулж үүсгэн байгуулах хуралд оруулна.

14.7.Мөнгөн бус хэлбэрээр хийгдэж байгаа эд хөрөнгийн үнийг үүсгэн байгуулах хуралд оролцогчид санал нэгтэй шийдвэрлэнэ.

14.8.Хэрэв ямар нэгэн шалтгаанаар компани байгуулагдаагүй бол захиалагчийн урьдчилан хийсэн төлбөрийг үүсгэн байгуулах хурал товолсон өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор нөхөн олгох үүргийг үүсгэн байгуулагчид хүлээнэ.

[1] Үнэт цаасны тухай хууль-"Ардын эрх" сонины 1994 оны 205; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 11 дүгээрт тус тус нийтлэгдсэн

15 дугаар зүйл. Компанийг улсын бүртгэлд бүртгүүлэх

15.1.Компани байгуулах тухай шийдвэр гарсанаас хойш ажлын 10 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгүүлэхээр холбогдох баримт бичгийг бүртгэх байгууллагад өгнө.

15.2.Компанийг бүртгүүлэхэд дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

15.2.1.компанийн нооосон нэр, оршин байх газар зэргийг заасан эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий бүртгүүлэх тухай өргөдөл, уг өргөдөлд тухайн компанитай харилцах шуудангийн хаягийг заавал заасан байна;

15.2.2.компани байгуулах тухай үүсгэн байгуулах хурлын шийдвэр;

15.2.3.компанийн дүрэм;

15.2.4.бүртгэлийн хураамж төлсөн баримт ;

15.2.5.бүртгүүлэх өдөр байх ёстой өөрийн хөрөнгийн доод хэмжээг харуулсан эхлэлтийн баланс.

15.3.Компанийг бүртгэхэд бүртгэх байгуллага нь энэ зүйлд зааснаас бусад баримт бичиг шаардах буюу баримт бичгийн агуулгад шаардлага тавьж үл болно.

15.4.Бүртгэх байгуллага өргөдлийг хүлээн аваад дараахь зүйлийг хянан үзнэ:

15.4.1.энэ хуулийн 15.2-т заасан баримт бичиг бүрэн бүрдсэн эсэх;

15.4.2.компанийн дүрэмд энэ хуулийн 16.2.-т заасан зүйлийг тусгасан эсэх;

15.4.3.компанийн нооосон нэр нь бусад компани, нөхөрлөлийн нооосон нэртэй давхардсан эсэх;

15.4.4.эхлэлтийн балансанд тусгагдсан компанийн өөрийн хөрөнгө нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээнд хүрсэн эсэх.

15.5.Бүртгэх байгуллага энэ хуулийн 15.2.-т заасан баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор компанийг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгох, эсхүл компанийг бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэр гаргана.

15.6.Компанийг улсын бүртгэлд бүртгэх тухай энэ хуулийн 15.4.-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд компанийг бүртгэхээс татгалзана.

15.7.Бүртгэх байгуллага компанийг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр гарсанаас хойш ажлын 3 хоногийн дотор татгалзах үндэслэлийг тусгасан мэдэгдлийг өргөдөлд заасан шуудангийн хаягаар өргөдөл гаргасан этгээдэд хүргүүлнэ. Бүртгэх байгуллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл үүсгэн байгуулагчид шүүхэд гомдол гаргаж болно.

15.8.Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах замаар байгуулагдсан компанийг энэ зүйлд заасан журмын дагуу дараахь баримт бичгийг үндэслэн улсын бүртгэлд бүртгэнэ:

15.8.1.өөрчлөн байгуулагдсан компани / компануд/-ын эрх бүхий төлөөлөгчийн гарын үсэг бүхий бүртгүүлэх тухай өргөдөл;

15.8.2.хуулийн этгээд /хуулийн этгээдүүд/-ийг өөрчлөн байгуулах тухай эрх бүхий байгуллагын шийдвэр;

15.8.3.шинээр байгуулсан компанийн дүрэм;

15.8.4.хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан тохиолдолд нийтэд санал болгосон хувьцаагаа Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу бүртгүүлэх зөвшөөрөл авсан тухай Үнэт цаасны хорооны шийдвэр;

15.8.5.өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээд /хуулийн этгээдүүд/-ийн дүрэм болон бүртгэлийн гэрчилгээ;

15.8.6.компани нэгдэх буюу өөрчлөх хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдаж байгаа тохиолдолд нэгдэх буюу өөрчлөх тухай шийдвэр, хуваах буюу тусгаарлах хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдаж байгаа тохиолдолд хуваах баланс;

15.8.7.бүртгэлийн хураамж төлсөн баримт.

15.9.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулдаг гадаадын хуулийн этгээд, түүний салбар буюу төлөөлөгчийн газар нь бүртгэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй. Бүртгэх байгуллага нь тэдгээрийг бүртгэх журмыг энэ хуульд заасан компанийг бүртгэх журамтай нийцүүлэн гаргана.

15.10.Компани улсын бүртгэлд бүртгүүлснээр байгуулагдсанд тооцогдож дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах эрхтэй.

16 дугаар зүйл. Компанийн дүрэм

16.1.Компанийн дүрэм нь түүний үүсгэн байгуулах үндэсэн баримт бичиг мөн.

16.2.Компанийн дүрэмд дараахь зүйлийг заавал тусгана:

16.2.1.компанийн бүрэн болон товчилсон нооосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;

16.2.2.компанийн оршин байгаа газрын хаяг;

16.2.3.компанийн зарласан энгийн хувьцааны тоо;

16.2.4.дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нөхцөлд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх;

16.2.5.хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;

16.2.6.хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон хянан шалгах зөвлөл / хянан шалгагчдын/-ийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх;

16.2.7.компанийн үйл ажиллагааны чиглэл;

16.2.8.дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл.

16.3.Компанийн дүрэмд Иргэний хууль болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөөгүй зүйлийг тусгаж болно.

16.4.Компани нь хувь нийлүүлэгчийн шаардлагаар компанийн дүрэм, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг түүнд танилцуулах үүрэгтэй.

17 дугаар зүйл. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах, бүртгэх

17.1.Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор батална.

17.2.Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулга нь хувь нийлүүлэгчдийн эрх ашгийг хөндсөн тохиолдолд эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтанд оролцоогүй хувь нийлүүлэгчид энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан журмын дагуу өгсөншиж байгаа хувьцаагаа компанид эргүүлэн худалдахыг шаардах эрхтэй.

17.3.Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэхэд дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

17.3.1.компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгүүлэх тухай компанийн эрх бүхий этгээдийн гарын үсэг бүхий өргөдөл;

17.3.2.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, орж байгаа өөрчлөлт нэмэлт, эсхүл шинэчилсэн найруулгын бүрэн эхийн хамтаар;

17.3.3.компанийн дүрмийн хуулбар, улсын бүртгэлийн гэрчилгээ;

17.3.4.бүртгэлийн хураамж төлсөн баримт.

17.4.Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийг шинэчлэн найруулах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

17.5.Бүртгэх байгууллага энэ хуулийн 17.3.-т заасан баримтыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан үндэслэлээ бүхий шийдвэр гаргана.

17.6.Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлт болон шинэчилсэн найруулгыг энэ хуулийн 17.3.-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд бүртгэхээс татгалзана.

17.7.Бүртгэх байгууллага компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дүрмийн шинэчилсэн найруулгыг бүртгэхээс татгалзсан тухай шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор татгалзах үндэслэлийг тусгасан мэдэгдлийг өргөдөлд заасан шуудангийн хаягаар илгээнэ. Бүртгэх байгууллагын энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл компани шүүхэд гомдол гаргаж болно.

17.8.Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨРИЙГ ХУВЬЦААГААР СОЛИХ

18 дугаар зүйл. Компанийг өөрчлөн байгуулах

18.1.Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр компанийг энэ хуульд заасан журмын дагуу нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

18.2.Хуульд заасан тохиолдолд шүүх компанийг хуваах, тусгаарлах шийдвэр гаргаж болно.

18.3.Нэгдэхээс бусад хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж байгаа нөхцөлд шинээр бий болж байгаа компанийг улсын бүртгэлд бүртгэснээр компани өөрчлөн байгуулсанд тооцно.

18.4.Нэгдэх хэлбэрээр өөрчлөн байгуулагдаж байгаа тохиолдолд нэгдэж байгаа компанийг улсын бүртгэлээс хасч нэгтгэсэн компанийн дүрэмд хэрэв өөрчлөлт орсон бол түүнийг улсын бүртгэлд бүртгэснээр тэдгээрийг өөрчлөн байгуулагдсанд тооцно.

18.5.Өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор өөрчлөн байгуулагдсан компани нь зээлдүүлэгч

болон бусад харилцагчдад өөрчлөн байгуулагдсан тухайгаа бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд дараахь зүйлийг тусгана:

18.5.1.өөрчлөн байгуулсан арга хэлбэр;

18.5.2.өөрчлөн байгуулагдсан болон өөрчлөн байгуулалтын үр дүнд шинээр үүссэн компани тус бүрийн байршил болон онооосон нэр;

18.5.3.өөрчлөн байгуулах тухай шийдвэр гарсан огноо;

18.5.4.хуваах болон тусгаарлах хэлбэрээр өөрчлөн байгуулж байгаа тохиолдолд хуваах баланс.

18.6.Хувьцаат компани нь өөрчлөн байгуулагдах, татан буулгах тухай шийдвэр гаргаснаас хойш энэ тухайгаа Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржэд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

19 дүгээр зүйл. Компануид нийлэх

19.1.Хоёр буюу хэд хэдэн компанийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон компанид шилжүүлэхийг компануид нийлэх гэнэ.

19.2.Нийлж байгаа компани тус бүрийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг нийлэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийн төсөл болон өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ, шинэ компанийн дүрэм, компани тус бүрийн үнэт цаасыг шинэ компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх журмыг тодорхойлсон саналаа компани тус бүрийн хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.

19.3.Компануид нийлэх тухай шийдвэр, гэрээг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор батална.

19.4.Гэрээнд шинээр үүссэн компанийн хувь нийлүүлэгчдийн хурал хуралдах хугацаа, товыг заана. Энэ хурлаар компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно. Хуралд оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын эрх нь нийлэх гэрээгээр тодорхойлсон хөрвөсөн саналын эрхтэй тэнцүү байна.

20 дугаар зүйл. Компани нэгдэх

20.1.Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг өөр компанид шилжүүлэхийг компани нэгдэх гэнэ.

20.2.Нэгдэж байгаа болон нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /хэрэв байхгүй бол гүйцэтгэх удирдлага / нь компани нэгдэх тухай шийдвэрийн төсөл болон нэгдэх гэрээг компани тус бүрийн хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ. Нэгдэх гэрээнд нэгдэх нөхцөл, журмыг тодорхойлохоос гадна нэгдэж байгаа компанийн үнэт цаас, нэгтгэж байгаа компанийн үнэт цаас, бусад хөрөнгөнд хөрвөх журмыг тусгасан байна.

20.3.Компанийг нэгдэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор гаргана.

20.4.Нэгдэж байгаа компанийн нийт энгийн хувьцааны 75-аас илүү хувийг эзэмшиж байгаа бөгөөд нэгдсэнээр компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд нэгтгэж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчид/-ийн хурлаар нэгдэх тухай шийдвэр гаргаж, нэгдэх журмыг баталж болно.

21 дүгээр зүйл. Компанийг хуваах

21.1.Компанийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүргийг шинээр үүсэх компаниудад бүрэн шилжүүлэхийг компанийг хуваах гэнэ. Компанийг хуваах тухай шийдвэрт өөрөөр заагаагүй бол хуваагдаж байгаа компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь компанийн хөрөнгийн хуваагдсан хэмжээтэй хувь тэнцүүлэн шинээр бий болсон компани тус бүрийн энгийн хувьцааны эзэмшигч болно.

21.2.Компанийг хуваах замаар өөрчлөн байгуулах, шинэ компани байгуулах, хуваах балансыг батлах асуудал болон тухайн компанийн үнэт цаасыг шинээр байгуулагдсан компанийн үнэт цаас буюу эд хөрөнгөд хөрвүүлэх журмыг хуваагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж хуралд оролцогчын саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.

21.3.Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаар компанийн дүрмийг батлаж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно. Энэ хурлыг хуралдуулах тусгайлсан журмыг хуваах замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрт заана.

21.4.Компанийг хуваахад түүний эрх, үүрэг шинээр байгуулагдсан компануудад хуваах

балансын дагуу шилжинэ.Компанийг хуваах тухай гэрээнд өөрөөр заагаагүй бол шинээр үүссэн компани бүр бусад компанийнхаа өмнөөс давхар хариуцлага хүлээнэ.

22 дугаар зүйл. Компанийг тусгаарлах

22.1.Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим хөрөнгө, эрхийг шинээр байгуулагдсан компанид шилжүүлэхийг компанийг тусгаарлах гэнэ. Компанийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь шинээр байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигч байна.

22.2.Компанийг тусгаарлах нөхцөл, журам, хуваах балансыг батлах болон шинэ компани байгуулах тухай шийдвэрийг өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ гаргана.

22.3.Шинээр байгуулагдсан компанийн хувь нийлүүлэгчийн хурал нь энэ байгуулагдсан компанийн дүрмийг баталж, хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол түүний гишүүдийг сонгоно.

22.4.Компанийг тусгаарлахад өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь өөрийн бүх өрийг хариуцна. Өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн өмнөөс түүний өрийг шинээр бий болж байгаа компаниар төлүүлэхийг хуваах балансаар тогтоож болно. Энэ тохиолдолд өөрчлөн байгуулагдаж байгаа компани нь шинээр байгуулагдсан компанид шилжүүлсэн үүргээ хамтран хүлээнэ.

22.5.Энэ хуулийн долдугаар бүлэгт заасныг үндэслэн компанийг тусгаарласны дараа шинээр байгуулагдсан компаниас гаргасан үнэт цаасыг бүгдийг нь, эсхүл түүний зарим хэсгийг нөгөл ашиг хэлбэрээр өөрчлөн байгуулагдсан компанийн хувьцаа эзэмшигчид шилжүүлж болно.

23 дугаар зүйл. Компанийг өөрчлөх

23.1.Хувьцаат компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаат компани болох замаар компанийг өөрчилж болно. Энэ өөрчлөх төслийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ боловсруулан хувь нийлүүлэгчдийн хуралд оруулан уг асуудlaap саналын эрхтэй хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

23.2.Компанийг өөрчлөх төсөлд өөрчлөх зорилго, нөхцөл, журам, хувьцаат харилцан хөрвүүлэх арга, тооцоо, өөрчлөлт оруулах хугацаа, хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах хугацаа зэргийг тусгасан байна.

23.3.Шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтөөр үүссэн компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж компанийн дүрэм, удирдах байгууллагыг шинэчлэн баталж болох бөгөөд үүнийг компанийг өөрчлөх төсөлд зааж өгнө.

23.4.Компанийг өөрчлөхөд түүний эрх, үүрэг шинээр бий болж байгаа компанид шилжинэ.

23.5.Компанийг өөрчлөх тохиолдолд холбогдох өөрчлөлтийг компанийн онооосон нэр болон дүрэмд тусгана.

24 дүгээр зүйл. Компани өөрчлөн байгуулсантай холбогдсон хувь нийлүүлэгчийн эрх

24.1.Нийлэх, нэгдэх буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн саналын эрхтэй хувь нийлүүлэгч нь өөрчлөн байгуулахын эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтанд оролцоогүй бол энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

24.2.Эргүүлэн худалдахаар тохиролцсон хувь нийлүүлэгчийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлнэ.

24.3.Өөрийн эзэмшилд байгаа хувьцаагаа эргүүлэн авахыг компаниас шаардаагүй хувь нийлүүлэгчдийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлж үл болно. Энэ тохиолдолд тухайн хувь нийлүүлэгч нь өөрийн хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардахаас бусад хувьцаа эзэмшихтэй холбогдсон эрхээ алдана.

25 дугаар зүйл. Компанийн өрийг хувьцаагаар солих

25.1.Компанийн хувьцааныг бусад үнэт цаас болон өрийг хувьцаагаар сольж болох бөгөөд үүнийг өрийг хувьцаагаар солих гэнэ.

25.2.Зөвлөлдүүлэгч болон бусад харилцагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол компанийн өрийг хувьцаагаар солиход хувьцаа авах тухайн зөвлөлүүлэгч, харилцагчийн зөвшөөрлийг авсан байна.

25.3.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийн өрийг хувьцаагаар солих төсөл боловсруулан хувь нийлүүлэгчидтэй хуралд оруулж, уг асуудлаар саналын эрхтэй хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар шийдвэрлүүлнэ.

25.4.Өрийг хувьцаагаар солих тухай төсөлд солигдох өр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, компанийн дүрэмд оруулах өөрчлөлт зэргийг зааж өгсөн байна.

25.5.Хувьцаа, худалдан авах эрхийн бичиг буюу хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэдгээрийн хөрвөх нөхцөлийн дагуу хөрвүүлэхийг компанийн өрийг хувьцаагаар сольсонд тооцохгүй.

25.6.Компанийн өрийг хувьцаагаар солих асуудлаар эсрэг саналтай байсан буюу санал хураалтанд оролцоогүй хувь нийлүүлэгч хувьцаа авахад оролцох эрхтэй.

26 дугаар зүйл. Компанийг татан буулгах

26.1.Компанийг хувь нийлүүлэгчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр Иргэний хууль, энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

26.2.Шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана:

26.2.1.дампуурсан;

26.2.2.нэг ч гишүүн үлдээгүй;

26.2.3.хуульд заасан бусад үндэслэл.

26.3.Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрээр татан буулгах байгаа компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчидийн нэхэмжлэлийг барагдуулсаны дараагаар компанид үлдэж байгаа эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувь нийлүүлэгчидийн хуралд оруулж, хуралд оролцогчдын саналын дийлэнх олонхоор шийдвэрлүүлнэ.

26.4.Татан буулгах комисс томилсоноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь татан буулгаж байгаа компанийн нэрийн өмнөөс шүүх хуралд төлөөлөн оролцоно.

26.5.Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн бүрэлтэй үйл ажиллагааны улмаас тухайн компанид, эсхүл зээлдүүлэгчид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

27 дугаар зүйл. Компанийг татан буулгахад өр төлбөрийг барагдуулах журам

27.1.Компанийг татан буулгах үед өр төлбөрийг барагдуулахдаа Иргэний хууль, энэ хууль болон бусад хуулийн заалтыг мөрдөнө.

27.2.Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах журам, хугацааг нийтэд мэдээлнэ. Нэхэмжлэл гаргах хугацаа нь татан буулгах тухайг нийтэд мэдээлснээс хойш 2 сараас багагүй, 6 сараас ихгүй байна.

27.3.Татан буулгах комисс нь компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг зээлдүүлэгчдэд бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

27.4.Хэрвээ татан буулгах тухай шийдвэр гаргах үед компани нь ямар нэгэн өргүй бол компанийг татан буулгах мэдэгдлийг нийтэд мэдээлэхгүйгээр түүнийг татан буулгаж болно. Энэ тохиолдолд компанийн эд хөрөнгийг энэ хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хуваарилна.

27.5.Нэхэмжлэл гаргах хугацаа дууссанаар татан буулгах комисс нь татан буулгаж байгаа компанийн эд хөрөнгийн тухай мэдээ, зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хэрхэн шийдвэрлэх дүнг агуулсан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / батална.

27.6.Татан буулгах комисс нь нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа тэдэнд бичгээр мэдэгдэх бөгөөд зээлдүүлэгч нь энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл татан буулгалтын балансыг батлахаас өмнө шүүхэд гомдол гаргаж болно.

27.7.Хэрэв татан буулгаж байгаа компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хангалтгүй бол татан буулгах комисс нь компанийн бусад эд хөрөнгийг худалдана. Хэрэв эдгээр эд хөрөнгийг худалдах нь энэ хуулийн арван гуравдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тохиолдолд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана.

27.8.Татан буулгаж байгаа компанийн зээлдүүлэгчидийн өр төлбөрийг татан буулгах комисс нь татан буулгах балансыг батална өдрөөс эхлэн түс балансын дагуу Иргэний хууль болон энэ хуульд заасан дараалалын дагуу барагдуулна.

27.9.Татан буулгах комисс нь өр төлбөрийг барагдуулсны дараа дуусгалтын баланс гаргана. Балансыг зээлдүүлэгчидийн нэхэмжлэлийг хэрхэн барагдуулсан тухай мэдэгдэл явуулснаас хойш ажлын 30 ба түүнээс дээш хоногийн дараа

гаргана.

27.10.Даусгалтын баланс гаргаснаас хойш шүүх тусгайлан шийдвэрлээгүй бол гаргасан аливаа нэхэмжлэлийг хүлээн авахгүй.

28 дугаар зүйл. Татан буугдаж байгаа компанийн эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах

28.1.Татан буулгах комисс нь хэлэлцүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг хуралдсанаас олсон орлогыг дараахь дараалалын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна:

28.1.1.давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг болон давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнэ, түүнчлэн энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу эргүүлэн авах давуу эрхийн хувьцааны төлбөр;

28.1.2.энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу эргүүлэн хуралдаж авах энгийн хувьцааны төлбөр;

28.1.3.үлдсэн эд хөрөнгийг хуралдсанаас олсон орлогыг компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн дунд тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн.

29 дүгээр зүйл. Компанийг татан буулгаж дуусгах

29.1.Компанийн бүх эд хөрөнгийг хуваарилсны дараа татан буулгах комисс нь компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсон тухай бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг бүртгэх байгууллагад хүргүүлнэ.

29.2.Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно. Энэ тухай бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ.

30 дугаар зүйл. Компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох

30.1.Бүртгэх байгууллага дараахь баримт бичгийг үндэслэн компанийн үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэнэ.

30.1.1.компанийг татан буулгах замаар дуусгавар болгож байгаа тохиолдолд компанийг татан буулгах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн бүтэцтэй шүүхийн шийдвэр, даусгалтын балансын хуулбар;

30.1.2.компанийн үйл ажиллагаа нь нэгдэх, нийлэх, хуваах, өөрчлөгдөсний улмаас дуусгавар болсон тохиолдолд өөрчлөн байгуулах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

30.1.3.хуваах замаар өөрчлөн зохион байгуулагдсаны улмаас компанийн үйл ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд хуваах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр, хуваах баланс;

30.1.4.компанийн дүрэм болон бүртгэлийн гэрчилгээ.

30.2.Компанийн үйл ажиллагаа нь нэгдэх, нийлэх, өөрчлөгдсөний улмаас дуусгавар болсон тухай мэдэгдэлд дуусгавар болсон компанийн эрх, үүргийг шилжүүлэн авсан хуулийн этгээдийн нэрийг бичнэ. Компанийн үйл ажиллагаа нь хуваагдсаны улмаас дуусгавар болсон тухай мэдэгдэлд дуусгавар болсон компанийн эрх, үүргийг хуваах балансын дагуу шилжүүлэн авсан компани тус бүрийн нэрийг бичнэ.

30.3.Дараахь тохиолдолд бүртгэх байгууллага, эсхүл хувь нийлүүлэгч, эсхүл зээлдүүлэгч компанийг татан буулгахаар шүүхэд хандаж болно:

30.3.1.компанийн үйл ажиллагаа явуулах дүрэмд заасан хугацаа дуусгавар болсон;

30.3.2.тусгай зөвшөөрөл шаардсан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд тус үйл ажиллагаа нь компанийн дүрмээр зөвшөөрөгдсөн цорын ганц үйл ажиллагаа байсан;

30.3.3.компанийг бүртгэх буюу үйл ажиллагаагаа эрхлэх явцад хуулийн ноштой зөрчил гарсан нь нөхөж болшгүй буюу эдгээр зөрчлүүдийн тухай бичгээр мэдэгдэл хүлээж авсан ч компани нь тэдгээрийг арилгаж чадаагүй байгаа.

ТАВДУГААР БҮЛЭГ

КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, КОМПАНИЙН ХУВЬЦАА, БУСАД ҮНЭТ ЦААС

31 дүгээр зүйл. Компанийн өөрийн хөрөнгө

31.1.Компанийн балансанд тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн нийт дүнгээс компанийн өр төлбөрийг хасаж үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө буюу хувь нийлүүлэгчдийн хөрөнгө гэнэ.

32 дугаар зүйл. Компанийн өөрийн хөрөнгийн доод хэмжээ

32.1.Хувьцаат компанийг бүртгэх өдөр түүний өөрийн хөрөнгө нь 10 сая төгрөг ба түүнээс дээш байна. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийг бүртгэх өдөр түүний өөрийн хөрөнгө нь нэг сая төгрөг ба түүнээс дээш байна.

32.2.Хоёр жил дараалан жилийн баланст тусгагдсан компанийн өөрийн хөрөнгө нь энэ хуулийн 32.1.-д заасан доод хэмжээнээс доогуур байвал нэхцөлд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь компанийг татан буулгах тухай асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ. Хурал нь компанийг татан буулгах асуудлыг шийдвэрлэж чадаагүй тохиолдолд компанийн нийт өрийн 10-аас илүү хувийг нэхэмжлэх эрхтэй зээлдүүлэгч нь компанийг татан буулгахаар шүүхэд хандаж болно.

33 дугаар зүйл. Компанийн хувьцаа

33.1.Үнэт цаасны тухай хуульд цаасны дагуу хувьцаа нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг хуваалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг эрхийг гэрчилнэ.

33.2. Хувьцаа нь энгийн ба давуу эрхийн гэсэн хэлбэртэй байна.

33.3.Компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээнэ.Компани нь давуу эрхийн хувьцааг гаргаж болно.

33.4.Хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон нэрлэсэн үнэтэй байж болно. Нэрлэсэн үнэтэй хувьцааг түүнээс доош үнээр гаргахыг хориглоно.

33.5.Хувьцаа бүр саналын нэг эрхтэй байна.

33.6.Хувьцаа хуваагдахгүй бөгөөд эзэмшигчийн нэртэй байна.

34 дүгээр зүйл. Компанийн зарласан болон гаргасан хувьцаа

34.1.Компаниас гаргах энгийн болон давуу эрхийн хувьцааны тоог компанийн дүрмээр тогтоох бөгөөд үүнийг зарласан хувьцаа гэнэ.

34.2.Зарласан хувьцаанаас хувь нийлүүлэгчдийн худалдан авч эзэмшсэн хэсгийг эргэлтэд гаргасан хувьцаа гэнэ.Хэрэв компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцааны төрөл тус бүрээс гаргах хувьцааны тоо, гаргах хугацаа, нөхцөлийг төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / тогтооно. Гаргасан хувьцааны тоог компанийн балансанд төрөл тус бүрээр нь тусгана.

34.3.Аль нэг төрлийн зарласан хувьцааны тоо нь тухайн төрлийн хувьцааны гаргасан тоо болон тухайн хувьцаанд хөрвөх үнэт цаасыг хөрвүүлэхэд шаардагдах хувьцааны тооны нийлбэрээс багагүй байна.

34.4.Компаниас гаргасан хувьцаа нь тэдгээрийг компани худалдан авах буюу эргүүлэн авах, эсхүл бусад төрлийн үнэт цаас, эд хөрөнгөд хөрвүүлэх хүртэл эргэлтэнд байна.

34.5.Компани өөрийн хувьцаа худалдан авах буюу эргүүлж авбал эдгээр хувьцааг зарласан болговч гаргагүй хувьцаа гэж тооцно. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь эдгээр хувьцааг дахин гаргаж болно.

35 дугаар зүйл. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх

35.1.Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:

35.1.1.хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;

35.1.2.давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлөөний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-өөс тогтоосон

хэмжээгээр ногдол ашиг авах;

35.1.3.компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг хуваалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.

35.1.4. хувьцаат компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 39 дүгээр зүйл болон компанийн дүрэмд заасны дагуу компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд хуваалдан авах эрхтэй.

35.1.5.компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцаа эзэмшигчид нь хувьцаанд хамаарах бусад үнэт цаасыг энэ зүйлд заасан бусад журмын дагуу тэргүүн ээлжинд хуваалдан авах эрх эдэлнэ.

35.2.Компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчийн эзэмшиж болох энгийн хувьцааны тоог хязгаарлаж болохгүй.

35.3.Энгийн хувьцааг компанийн давуу эрхийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хөрвүүлж үл болно.

35.4. Хувь нийлүүлэгчдийн хүрлаар хэлэлцэх зарим асуудлаар энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхийг энэ хууль болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр хязгаарлаж болно.

36 дугаар зүйл. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн эрх

36.1.Бүх төрлийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:

36.1.1.эрх бүхий байгууллагаас тогтоосон давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг тэргүүн ээлжинд авах;

36.1.2.энэ хууль, компанийн дүрэм болон тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан асуудлаар хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох;

36.1.3.компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг хуваалдсан орлогоос хуримтлагдсан ногдол ашиг болон эзэмшиж байгаа хувьцааны татан буулгалтын үнийг авах.

36.2.Компанийн дүрэм, эсхүл тухайн төрлийн давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт дор дурдсан зүйлийг тусгана:

36.2.1. татан буулгах үед түүнд төлөх төлбөр, төлөх журам, дэс дараалал;

36.2.2.хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл, давуу эрхийн нэг хувьцаанд ногдох саналын тоо;

36.2.3.давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаанд хөрвүүлэх бол түүний нөхцөл;

36.2.4.давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшилд байгаа давуу эрхийн хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах нөхцөл.

36.3.Компани нь давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг бүрэн төлсөн болон эргүүлэн авах үүрэг бүхий давуу эрхийн хувьцааг авсаны дараа энгийн хувьцааг эргүүлэн авах буюу хуваалдан авах, түүнд ногдол ашиг төлөх эрхтэй болно.

36.4.Энэ хуулийн 48.3.-т заасан нөхцөл үүсээгүй бол компани нь давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашгийг дүрэмд заасан хэмжээ болон хугацаанд төлнө.

36.5.Компанийг татан буулгах тохиолдолд энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдох хөрөнгийг олгохоос өмнө дарааллын дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд уг хувьцааны татан буулгалтын үнэ, төлөгдөөгүй ногдол ашгийг төлнө.

36.6. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчид нь хувь нийлүүлэгчдийн хуралд дараахь тохиолдолд саналын эрхтэй оролцоно:

36.6.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахдаа тэдгээрийн эрхийг хязгаарласан заалтыг оруулж байвал;

36.6.2.компанийг өөрчлөн байгуулах явцад давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаа, бусад төрлийн үнэт цаас болон бусад хөрөнгөнд хөрвүүлж байвал.

36.7.Энэ хуулийн 36.6.-д заасны дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн хурлын уг асуудлаарх шийдвэрийг компанийн дүрэмд дээрүүр тогтоогоогүй бол зөвхөн давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана.

36.8.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох хуралд давуу эрхтэй хувьцаа эзэмшигчдийг дараахь нөхцөлд саналын эрхтэй оролцуулахаар компанийн дүрэмд зааж болно:

36.8.1.компанийн дүрэмд энгийн хувьцаанд хөрвөх давуу эрхийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөн удирдах зөвлөлд өөрийн төлөөлөгчийг оруулж болохоор заасан бол;

36.8.2.давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй бол.

37 дугаар зүйл.Алтан хувьцаа

37.1.Засгийн газар төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмч давамгайлсан компанийн төрд ногдох хэсгийг бүхэлд нь хувьчлах тухай шийдвэр гаргахдаа тодорхой хугацаанд энэ хуулийн 37.2.-т заасан асуудлаар компанийн хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн болон гүйцэтгэх удирдлагын шийдвэрт хориг тавих эрхтэй, нөгдол ашиг авдагтүй, өөр ямар нэг эрхтүй алтан хувьцаат гаргахаар зааж болно.

37.2.Алтан хувьцаатай компанийн хувь нийлүүлэгчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаас дор дурдсан асуудлаар гаргасан шийдвэр нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрх ашигт харшилсан тохиолдолд хориг тавина:

37.2.1.хувьчлахаас өмнө эрхэлж байсан үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх;

37.2.2.компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;

37.2.3.их хэмжээний хэлцэл байгуулах;

37.2.4.бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох, өөрчлөх.

37.3.Хориг тавих тухай шийдвэрийг Засгийн газар гаргах бөгөөд энэ шийдвэрт хориг тавьж байгаа үндэслэлийг заана.

37.4.Энэ хуулийн 37.2.-т заасан асуудлаар компанийн гаргасан шийдвэр нь Засгийн газар батламжилснаар хүчин төгөлдөр болно.

37.5.Алтан хувьцааг бусдад шилжүүлж үл болно.

37.6.Хугацаа дуусмагц алтан хувьцаа нь хүчингүй болно. Хугацааг дахин сунгаж үл болно.

38 дугаар зүйл. Хувьцаанд хамаарах үнэт цаас

38.1.Энгийн хувьцааг худалдан авах эрхийн бичиг болон хувьцаанд хөрвөх үнэт цаас, опционыг хувьцаанд хамаарууллах бөгөөд тэдгээрийг гаргах, худалдах журмыг компанийн дүрмээр тодорхойлно.

39 дүгээр зүйл. Хувьцаа тэргүүн ээлжинд худалдан авах эрх

39.1.Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

39.2.Хувьцаат нэмж гаргах шийдвэр гаргах үед энгийн хувьцаа эзэмшигч бүрт гаргаж байгаа хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг хувь нийлүүлэгчдийн хурлын зар хүргэдэг журмаар хүргүүлнэ. Хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцаагаа худалдан авах тухай саналаа шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлнэ.

39.3.Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцаагаа худалдан авах үнэ нь тухайн хувьцааны зах зээлийн үнийн 90 хувь ба түүнээс дээш байж болохгүй.

39.4.Тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцаа худалдан авах хувь нийлүүлэгч нь тогтоосон хугацаанд нэр, хаяг, худалдан авах хувьцааны тоо, үнийг төлсөн баримтыг компанид ирүүлснээр тэргүүн ээлжинд худалдан авах эрхээр хувьцаагаа худалдан авсанд тооцно.

39.5.Хувьцаа эзэмшигч нь хувьцаат тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ бүхэлд нь болон хэсэгчлэн хэрэгжүүлж болно.Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь энэ эрхээ бусад этгээдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шилжүүлж болно.

39.6.Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа тухайн асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор хувьцаат тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэж болно.

40 дүгээр зүйл. Хувьцаанд хөрвөх үнэт цаас

40.1.Компанийн давуу эрхийн хувьцаа, өрийн бичгийг тодорхой нөхцөлд тодорхой тооны энгийн хувьцаанд хөрвүүлэх болзолтойгоор гаргаж болно.

40.2.Давуу эрхийн хувьцаа, өрийн бичгийг энгийн хувьцаанд хөрвөх эрхтэйгээр гаргаж байгаа үед хувьцаанд хөрвөх үнэт цаасыг хамт гаргана.

40.3.Хувьцаанд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт хөрвөх үнэт цаасны төрөл, хөрвөх энгийн хувьцааны тоо, хөрвөх үнэ, хугацаа зэрэг байна.

40.4.Хувьцаат компанийн гаргасан энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хөрвөх үнэ нь тухайн энгийн хувьцааны зах зээлийн үнээс доогуур байж болохгүй .

40.5.Хувьцааны хөрвөх үнэт цаасыг гаргаж байгаа үед энгийн хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшилд байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн эдгээр үнэт цаасыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

41 дүгээр зүйл. Опцион

41.1.Компанийн дүрмээр зөвшөөрсөн тохиолдолд компани тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцаог тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

41.2.Опционы бүрдүүлбэрт нэгж опцион эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо, төрөл, үнэ, эцсийн хугацаг заана.

41.3.Хувьцаат компанийн гаргасан энгийн хувьцаа худалдан авах опционы үнэ нь тухайн хувьцааны зах зээлийн үнээс доогуур байж болохгүй.

41.4.Энгийн хувьцаа худалдан авах опцион гаргаж байгаа үед энгийн хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшилд байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн эдгээр үнэт цаасыг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.

42 дугаар зүйл.Компанийн өрийн бичиг

42.1.Компани өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацаанд дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн авах нөхцөлтэйгээр өрийн бичиг гаргаж болно.

42.2.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол өрийн бичиг гаргах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / гаргана. Энэ шийдвэрт өрийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн авах үнэ, бусад мэдээллийг заана.

42.3..Компани нь нэг удаа бүрэн төлөгдөх, эсхүл хэсэгчлэн төлөгдөх өрийн бичиг гаргаж болно.

42.4.Компанийн өрийн бичиг нь өөр компаниас тусгайлан гаргасан баталгаатай байж болно.

42.5.Компани гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн авч болно. Энэ тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / гаргана.

43 дугаар зүйл. Үнэт цаас гаргах тухай шийдвэр

43.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, дүрэмд заасан бусад төрлийн үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ гаргана. Шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана.

43.2.Компани зарласан энгийн хувьцаагаа бүхэлд нь, эсхүл хэсгийг нь гаргах үүрэгтэй. Давуу эрхийн хувьцааг зарласан хэмжээгээр нь, эсхүл хэсгийг нь гаргаж болохоос гадна тодорхой хугацаанд гаргахгүй байж болно.

43.3.Нийтэд худалдахаар гаргаж байгаа үнэт цаас болон хувьцаат компанийн нэмж гаргаж байгаа хувьцааг Үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Үнэт цаасны хороонд бүртгүүлнэ.

44 дүгээр зүйл. Хувьцаа, бусад үнэт цаасны үнийг тогтоох

44.1.Дор дурдсанаас бусад тохиолдолд хувьцаа, бусад үнэт цаасны үнийг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ тогтооно:

44.1.1.хувьцааны хөрвөх үнэт цаас болон опцион гаргах үед үнийг тогтоосон бол;

44.1.2.хувьцаа худалдаж авах эрхийн бичгээр хувьцааг худалдаж байгаа бол;

44.1.3.компани үүсгэн байгуулж байгаа үед үүсгэн байгуулах баримт бичигт хувьцааны үнийг тогтоосон бол;

44.1.4. хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөр тохиолдол заасан бол.

45 дугаар зүйл. Үнэт цаасны төлбөр

45.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол гаргасан үнэт цаасны төлбөрийг худалдан авч байгаа этгээд нь мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр хийж болно.

45.2.Компанийг үүсгэн байгуулахаар гаргасан хувьцааны төлбөрийг компанийг улсын бүртгэлд бүртгэхээс өмнө төлнө. Цаашид нэмж гаргах үнэт цаасны төлбөрийг тэдгээрийг худалдан авах үед бүрэн төлнө.

45.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол үнэт цаасны төлбөрийг доорх тохиолдолд мөнгөн

бус хэлбэрээр хийж болно:

45.3.1.үүсгэн байгуулах үед хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийхийг энэ хуулийн 14.6-д заасны дагуу үүсгэн байгуулах баримт бичигт зөвшөөрсөн;

45.3.2.нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болохоор эрх бүхий байгууллагын шийдвэрт заасан;

45.4.Үүсгэн байгуулах үед хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж байгаа бол түүний үнэлгээг үүсгэн байгуулах хурлаар санал нэгтэй батална.

45.5.Үнэт цаасыг нэмж гаргаж байгаа үед түүний төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх үнэлгээг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ эцэслэн шийдвэрлэнэ. Хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл үнэлгээний талаар шийдвэр гаргахдаа мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэс болгоно.

46 дугаар зүйл. Үнэт цаас эзэмшигчийн бүртгэл

46.1.Компани нь үнэт цаас эзэмшигчийнхээ бүртгэлийг хөтөлж, үнэт цаасыг биет байдлаар гаргасан бол түүнийг хадгалах ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Энэ үүргээ үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

46.2.Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл нь тухайн үнэт цаас эзэмшигчийн овог, нэр, оршин суугаа хаяг, түүний эзэмшиж байгаа үнэт цаасны төрөл, хэмжээ болон үнэт цаасыг шилжүүлсэнтэй холбогдон шилжүүлэгдсэн үнэт цаасны хэмжээ /тоо/, шилжүүлсэн болон шилжүүлэн авсан эзэмшдийн овог, нэр зэргийг тусгасан байна.

46.3.Компанийн үнэт цаас эзэмшигч этгээд нь өөрийн нэр, оршин суугаа хаяг болон эзэмшилд байгаа үнэт цаасны хэмжээ /тоо/-г бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэхийн зэрэгцээ эдгээрт орсон нөхцөл, өөрчлөлтүүдийг цаг тухайд нь бүртгэл хөтлөх этгээдэд мэдэгдэх үүрэг хүлээнэ.

46.4.Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээд нь бүртгүүлсэн этгээдийн шаардсанаар түүний үнэт цаас эзэмших эрхийг бүртгэлээс хуулбар хийх замаар баталгаажуулах үүрэгтэй. Хуулбар нь үнэт цаасад хамаарахгүй.

46.5.Компани нь үнэт цаасыг биет бус хэлбэрээр гаргаж байгаа тохиолдолд эдгээр үнэт цаас эзэмшигчид тэдний эрхийг нотолсон баримт /сертификат/ олгож болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

НОГДОЛ АШИГ, КОМПАНИЙН ӨМЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

47 дугаар зүйл. Ногдол ашиг хуваарилах

47.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал / гаргана. Энэ байгууллага нь ногдол ашиг хуваарилахдаа хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдөр болсон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож энэ талаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.

47.2. Ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлодоо хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан өдрөөр тасалбар болгон тодорхойлно.Харин хувьцаат компанийн хувьд энэ бүртгэлийн өдрийг шийдвэр гарсан өдрөөс хойш тусгайлан тогтоох бөгөөд энэ тухай нийт хувь нийлүүлэгчдэд яаралтай зарлан мэдэгдэнэ.

47.3.Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

47.4.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

47.5.Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.

47.6.Хэрэв компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаандаа ногдол ашгаа төлөх үүрэгтэй. Ногдол ашгаа хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн нэхэмжлэлээр компани нь алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

48 дугаар зүйл. Нөгөлөл ашиг хуваарилах нөхцөл

48.1.Компани нь дор дурдсан тохиолдолд энгийн хувьцаанд нөгөлөл ашиг хуваарилна:

48.1.1.нөгөлөл ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

48.1.2.нөгөлөл ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй нөгөлөл ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;

48.1.3.компани нь эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

48.2.Компани эргүүлэн авсан өөрийн хувьцаанд нөгөлөл ашиг хуваарилахгүй.

48.3.Компани нь доор дурдсан тохиолдолд давуу эрхийн хувьцаанд нөгөлөл ашиг хуваарилна:

48.3.1.нөгөлөл ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх;

48.3.2.компани нь эргүүлэн авах үүрэгтэй давуу эрхийн хувьцаат бүрэн авсан байх.

48.4.Нөгөлөл ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь нөгөлөл ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор өөрийн хэвлэгдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

48.5.Компани нөгөлөл ашиг хуваарилаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл хувьнийлүүлэгчдийн ээлжит хуралд шалтгааныг тайлагнах үүрэг хүлээнэ.

49 дүгээр зүйл. Компанийн эд хөрөнгийн захиран зарцуулалтад тавих хязгаарлалт

49.1.Зэлдүүлэгчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор компанийн өөрийн хөрөнгө нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан хэмжээнээс бага болох, эсхүл компани төлбөрийн чадваргүй болохоор байвал компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг бусдад зах зээлийн үнээс доогуур үнээр худалдахыг хориглоно.

49.2.Энэ хуулийн 49.1.-г зөрчиж хийсэн хэлцэл шүүхийн шийдвэрээр хүчингүй болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

КОМПАНИ ӨӨРИЙН ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ БОЛОН ЭРГҮҮЛЭН АВАХ

50 дугаар зүйл. Үнэт цаас худалдан авах

50.1.Дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьнийлүүлэгчдийн хурал/-ийн шийдвэрээр өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно.

50.2.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25-н хувиас хэтэрч болохгүй.

50.3.Худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж тооцно.

50.4.Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэртээ худалдан авах хувьцаа, нөгөлөл хувийн тоо хэмжээ, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заажөгнө.

50.5.Дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь үнэт цаас худалдан авахдаа түүний төлбөрийг бэлэн мөнгөөр, үнэт цаасаар болон бусад эд хөрөнгийн хэлбэрээр хийж болно.

50.6.Компани нь өөрийн үнэт цаасыг анхдагч зах зээлд гаргах үед тэдгээрийг худалдан авч үл болно.

50.7.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьнийлүүлэгчдийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол компани нь энгийн хувьцаагаа энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьнийлүүлэгчдийн хурал/-өөс тогтоосон зах зээлийн үнээр худалдан авна.

50.8.Компани өөрийн гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авах шийдвэрийг дор дурдсанаас бусад тохиолдолд хувьнийлүүлэгчдийн хурлын уг асуудлаар саналын эрхтэй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэж байна:

50.8.1.хэрэв компани нь энгийн хувьцаагаа худалдан авахдаа хувьнийлүүлэгчдийн ээлжит байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авахаар шийдвэрлэсэн бол;

50.8.2.энэ хууль болон компанийн дүрэмд

заасан хувь нийлүүлэгчийн давуу эрхийг хэрэгжүүлж байвал;

50.8.3.хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр тогтоосон өөр нөхцөлүүд.

50.9. Өөрийн гаргасан энгийн хувьцаат худалдан авахдаа тэдгээрийг хувь нийлүүлэгчийн эзэмшиж байгаа энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн авахаар шийдвэрлэсэн бол худалдан авах хувьцааны тоо, худалдан авах үнэ, төлбөр хийх журам, хугацаа, худалдах саналыг хүлээн авах сүүлчийн өдөр зэргийг багтаасан мэдэгдлийг бүх хувь нийлүүлэгчдэд хүргүүлнэ. Хувьцаат компанийн хувьд энэ саналыг ажлын 30 ба түүнээс дээш хоногийн хугацаатайгаар бүх хувь нийлүүлэгчид хүргүүлнэ. Компанид худалдахаар санал болгож байгаа энгийн хувьцааны нийт тоо нь компанийн худалдан авахаар санал болгосон хувьцааны тооноос илүү байх нөхцөлд компани нь худалдахаар санал болгосон тоонд багтаан илүү хэмжээний хувьцаа төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчийн хурал / -ийн шийдвэрээр худалдан авч болно. Гэхдээ худалдан авах хувьцааны тоо нь энэ хуулийн 50.2-т заасан хэмжээнээс хэтэрч болохгүй бөгөөд энэ тохиолдолд хувьцаагаа хувь нийлүүлэгч бүрийн худалдахаар санал болгож байгаа хувьцааны тоотой хувь тэнцүүлэн худалдаж авна.

51 дүгээр зүйл. Компани өөрийн давуу эрхийн хувьцааг эргүүлэн авах

51.1.Төлбөрийн чадвар хангалттай нөхцөлд компани нь эргүүлэн авах үүрэг хүлээсэн давуу эрхийн хувьцааг бүгдийг нь, эсхүл зарим хэсгийг нь хугацаанаас нь өмнө эргүүлэн авахаар санал гаргаж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 66 дугаар зүйлд заасан жүрмын дагуу тэдгээр үнэт цаасыг эзэмшигчдэд мэдэгдэнэ.

51.2.Эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасыг анх гаргах үед эргүүлэн авах үнийг тогтоогоогүй бол энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал /-өөс тогтоосон зах зээлийн үнээр худалдан авна.

51.3.Эргүүлэн авах үүрэг хүлээсэн хувьцаат худалдан авах ханглаттай хөрөнгөгүй нөхцөлд компани нь шаардагдах хөрөнгөтэй болсноос хойш үнэт цаасыг эргүүлэн авахаар тэдгээрийн эзэмшигч нартай тохиролцон хойшлуулж болно. Тохиролцоогүй тохиолдолд энэ хуулийн 53 дугаар зүйлд заасан этгээдэд худалдан авахыг санал болгоно.

51.4.Өөрийн хувьцаат эргүүлж авснаар өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгөнөөс доогуур болох тохиолдолд компани нь өөрийн энгийн хувьцаат эргүүлэн худалдан авч болохгүй.

52 дугаар зүйл. Компанийн хувьцаат нэгттэх болон хуваах

52.1.Компани нь хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаат тухайн төрлийн нэг шинэ хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн хувьцаат нэгттэж болно.

52.2.Компани нь нэг хувьцаат тухайн төрлийн шинэ хоёр буюу түүнээс дээш тооны хувьцаанд хөрвүүлэх замаар өөрийн гаргасан хувьцааг хуваж болно.

52.3.Хувьцаат хуваах ба нэгттэсний үр дүнд бий болсон хувьцааны бутархай үлдэгдлийг компани нь энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-өөс тогтоосон үнээр эргүүлэн авч болно.

52.4.Компанийн хувьцаат нэгттэх буюу хуваах тухай асуудлыг шийдвэрлэхдээ хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

52.5.Компанийн хувьцаат нэгттэх буюу хуваахад компанийн зарласан тухайн төрлийн хувьцааны тоонд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгаж бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

52.6.Компанийн хувьцаат нэгттэх буюу хуваахаа түүнийг худалдан авах эрхийн бичиг болон түүнд хөрвөх үнэт цаасны бүрдүүлбэрт зохих өөрчлөлт оруулах үүргийг компани хүлээнэ.

53 дугаар зүйл. Компани өөрийн үнэт цаасыг эргүүлэн авах нөхцөл

53.1.Компани нь дор дурдсан нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах болон эргүүлэн авч болно:

53.1.1.компани нь үнэт цаасаа худалдан авах болон эргүүлэн авмагц шууд төлбөрийн чадвартай байх;

53.1.2.компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан доод хэмжээ болон давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх.

53.2.Энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан

эргүүлэн авах үүрэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн авсаны дараа компани нь бусад энгийн хувьцаа болон түүнд хамаарах үнэт цаасыг худалдан авч болно.

53.3.Хувьцаа худалдан болон эргүүлэн авсаны үр дүнд компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь төлбөр хийсэн өдрөөс хойш жилын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэд өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

54 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчийн шаардлагаар компани хувьцаагаа эргүүлэн авах

54.1.Дор дурдсан асуудлаар хувь нийлүүлэгчийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан буюу санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж байгаа хувьцаар компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй:

54.1.1.нийлэх, нэгдэх, хуваах болон хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх хэлбэрээр компаниг өөрчлөн байгуулах;

54.1.2.компани энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар батлах шаардлагатай их хэмжээний хэлцэл хийсэн;

54.1.3.компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлтийг компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батална;

54.1.4.компанийн дүрэмд заасан бусад тохиолдол.

54.2.Хувь нийлүүлэгч нь түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-ээс дээш хувийг эзэмшиж байгаа, түүнчлэн төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хяналтын багц хувьцаат хувьчлан авсан тохиолдолд бусад энгийн хувьцаа эзэмшигч бүр компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

Компани нь хяналтын багц хувьцааг эзэмшиж байгаа этгээдээд энэ хуулийн 54. 4.-т заасан үнээр худалдан авахыг зөвшөөрч болно.

54.3.Өөрийн эзэмшилд байгаа хувьцаат компанид эргүүлж авахыг шаардах эрхтэй хувь нийлүүлэгчийн нэрсийн жагсаалтыг эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн өдөр компанийн үнэт цаас эзэмшигчийн бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн гаргана.

54.4.Компани нь хувь нийлүүлэгчийн шаардлагаар эргүүлэн авах хувьцааг энэ эрхийг үүсгэсэн шийдвэрийн улмаас хувьцааны үнэд орсон өөрчлөлтийг үл харгалзан энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчийн хурал/-өөс тодорхойлсон зах зээлийн үнээр худалдан авна.

55 дугаар зүйл. Хувьцааг эргүүлэн авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам

55.1.Энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгч нь хувьцаагаа эргүүлэн авахыг компаниас шаардах эрх үүсгэсэн шийдвэр гарах тохиолдол бүрт компани нь энэ эрх, түүнийг хэрэгжүүлэх журмын талаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэх үүрэгтэй.

55.2.Өөрийн эзэмшиж байгаа хувьцаат компани эргүүлж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувь нийлүүлэгч нь эргүүлж авах тухай шаардлагыг бичгээр гаргах бөгөөд түүнд өөрийн овог, нэр, оршин суугаа хаяг болон эргүүлэн авахыг шаардаж байгаа хувьцааны тоо, төрлийг заана.

55.3.Хувь нийлүүлэгч нь хувьцаат компанид эргүүлэн авах тухай өөрийн шаардлагыг үүсгэсэн шийдвэр гарснаас, эсхүл ийм эрх үүссэн тухай компаниас бичгээр мэдэгдэл авсанаас хойш жилын 30 хоногийн дотор компанид явуулна.

55.4.Хувь нийлүүлэгч нь түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75 ба түүнээс дээш хувийг худалдан авах болон хувьчлалын дүнд хяналтын багцыг худалдан авсан тохиолдолд бусад хувь нийлүүлэгчид эзэмшиж байгаа хувьцаагаа эргүүлэн авахыг шаардаж болох талаар төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-өөс дээр дурдсан хувьцаат худалдан авсан өдрөөс хойш жилын 30 хоногийн дотор хувь нийлүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй. Хувь нийлүүлэгчид энэ мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш жилын 30 хоногийн дотор шаардлагаа бичгээр явуулна.

55.5.Компани нь хувьцаат эргүүлэн авах тухай хувь нийлүүлэгчийн шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш жилын 30 хоногийн дотор эргүүлэн авах эрхийн тухай мэдээлэлд мэдэгдэлд дурдсан зах зээлийн үнээр худалдан авах, эсхүл тэдгээрийн эргүүлэн авах эрхийг хэрэгжүүлэхээс татгалзсан үндэслэлээ хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.

55.6 Компани хувьцаагаа энэ зүйлд заасны дагуу эргүүлэн авахаас татгалзсан, эсхүл эргүүлэн авахаар тодорхойлсон зах зээлийн үнэ бодитой бус гэж үзвэл хувь нийлүүлэгч нь энэ талаарх гомдлоо уг шийдвэр гарснаас хойш 3 сарын дотор шүүхэд гаргаж болно.

55.7.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь

эргүүлэн авах хувьцааны зах зээлийн үнийн талаархи нэмэлт мэдээллээр хувь нийлүүлэгчдийг хангана.

56 дугаар зүйл. Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох

56.1.Компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн/компанийн хувьцаа болон бусад үнэт цаасыг оролцуулан/ зах зээлийн үнэ гэж эдгээр эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, түүнийг худалдах үүрэг хүлээгээгүй худалдагч болон эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, худалдан авах үүрэг хүлээгээгүй худалдан авагч хоёрын харилцан тохиролцсон үнийг хэлнэ.

56.2.Энэ хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ тогтооно.

56.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийг тогтоох шаардлагатай хэлцлийг компанитай байгуулахыг сонирхож байгаа тохиолдолд зах зээлийн үнийг уг хэлцлийг байгуулах талаар сонирхолгүй төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар тогтооно.

Энэ тохиолдолд уг хэлцэлд оролцогч, зуучлагч талуудтай нэгдмэл сонирхолгүй, энэ хэлцлээс шууд болон шууд бус замаар санхүүгийн ямар нэг ашиг авааргүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хараат бус гэж үзнэ.Хэрэв энэ шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргах бол уг асуудлаар сонирхлын зөрчилтэй хувь нийлүүлэгч санал хураалтад оролцох эрхгүй.

56.4.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ энэ хуулийн 56.2.-т заасны дагуу эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоохдоо хараат бус үнэлгээний байгууллага, аудиторийн дүгнэлтийг ашиглаж болно.

Харин хувьцаат компанийн хувьд энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хувьцааг эргүүлэн авах тохиолдолд хувьцааны үнийг хараат бус үнэлгээний байгууллага, аудиторийн дүгнэлтийг үндэслэн тодорхойлно.

Нийтэд худалдагдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо Хөрөнгийн биржийн албан ёсны мэдээнд тусгагдсан арилжааны сүүлийн 6 сарын дундаж ханшийг харгалзан тогтооно.

Компанийн хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, компанийн өөрийн хөрөнгө, ашиг зэргийн талаар бүрэн мэдээлэлтэй худалдан авагчаас өгөх боломжит үнэ болон бусад хүчин зүйлийг харгалзан үзнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ХУВЬЦААНЫ ХЯНАЛТЫН БАГЦЫГ ХУДАЛДАН АВАХ

57 дугаар зүйл. Хувьцааны хяналтын багц, түүнийг худалдан авах

57.1.Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцаат компанийн хяналтын багц гэнэ.

57.2.Хувьцаат компанийн энгийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах хүсэлтэй этгээд нь энэ хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх замаар худалдан авах санал гаргана.

57.3.Хяналтын багцыг худалдан авахаар санал болгосон хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ асуудлаар саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор тусгайлан шийдвэр гаргаагүй бол хяналтын багцыг эзэмшихээр санал гаргасан этгээдэд хувь нийлүүлэгчдийн зүгээс хувьцаагаа худалдахад нь ямар нэг саад учруулах эрхгүй.

58 дугаар зүйл. Компанийн хувьцаат худалдан авахыг хувь нийлүүлэгчдэд санал болгох

58.1.Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөсөө хойш ажлын 60 хоногийн дотор багтаан бусад хувь нийлүүлэгчдийн эзэмшиж байгаа хувьцаат уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жигнэсэн дундажаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй.

58.2.Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58.1.-д заасан саналыг гаргагүй бол уг этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрх эдлэхгүй.

Бусад хувь нийлүүлэгчдийн хувьцаат худалдан авах саналыг хувь нийлүүлэгчдийн хурлын зар

мэдээ хүргэдэг аргаар хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувьд Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржид энэ мэдэгдлийг нэгэн адил хүргүүлнэ.

Энэ саналд хяналтын багц хувьцааг худалдан авсан этгээд болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр, хаяг, тэдгээрийн эзэмшилд байгаахувьцааны тоо, худалдан авах үнийн санал болон саналыг хаах эцсийн хугацаа зэргийг тусгасан байна.

58.3.Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан этгээд нь энэ хуулийн 58.1.-д заасан саналыг гаргахдаа уг саналыг хаах хугацаа нь хувь нийлүүлэгчдэд саналаа явуулснаас хойш 30 ба түүнээс дээш хоног байхаар тогтооно.

58.4.Хэрэв хувьчлалын дүнд хяналтын багцыг авсан бол энэ хуулийн 58.1.-д заасан заалт үйлчлэхгүй бөгөөд компани хувьцаагаа эргүүлэн авах асуудал нь энэ хуулийн 54, 55 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагдана.

59 дүгээр зүйл. Компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авсан тухай мэдэгдэх

59.1Хувьцаат компанийн энгийн хувьцааны гуравны нэгээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт худалдан авсан буюу эзэмшиж байгаа этгээд нь энэ хэжээний хувьцааг худалдан авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор өөрийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн овог, нэр, хаяг, тус бүрийн эзэмшилд байгаа хувьцааны тоо ээргийн талаархи мэдэгдлийг тухайн компани болон Үнэт цаасны хороонд тус тус бичгээр хүргүүлнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

КОМПАНИЙН УДИРДЛАГА

60 дугаар зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурал

60.1Компанийн эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна. Нэг хувь нийлүүлэгчтэй компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгч өөрөө хэрэгжүүлнэ.

60.2Хувь нийлүүлэгчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

60.3.Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг компанийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулна. Энэ хугацаанд ээлжит хурлыг зарлаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/- ийн бүрэн эрх дуусгавар болж хувь нийлүүлэгчдийн хурал зарлах бүрэн эрх хяналтын зөвлөлд шилжинэ. Хяналтын зөвлөл хувь нийлүүлэгчдийн хурлыг бүрэн эрх шилжснээс хойш ажлын 15 хоногийн дотор зарлах үүрэгтэй. Хяналтын зөвлөл энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд уг компанийн аливаа нэг хувь нийлүүлэгч хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлахыг шаардаж шүүхэд хандах, эсхүл өөрөө зарлан хуралдуулж болно. Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлах, хуралдуулах зардлыг компани гаргана.

60.4. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг тухайн хурлаас сонгогдсон дарга удирдана.Хэрэв хурал өөр хүн сонгоогүй бол хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хувь нийлүүлэгчдийн хурлыг удирдана.

60.5.Шаардлагатай гэж үзвэл төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/, эсхүл саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчдийн санаачилгаар ээлжит бус хурлыг энэ хуулийн 62 дугаар зүйлд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.

61 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах

61.1 Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол гүйцэтгэх удирдлага/, эсхүл энэ хуулийн 60.3., 62.7.-д заасан этгээд гаргана.

61.2.Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараахь зүйлийг заана:

61.2.1.хурал хуралдуулах газар, өдөр болон цаг;

61.2.2.хурлын хэлэлцэх асуудал ;

61.2.3.хувьцаат компанийн хувьд хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

61.2.4.хурал хуралдуулах тухай хувь нийлүүлэгчид мэдэгдэх өдөр, журам;

61.2.5.хуралд бэлтгэх явцад хувь нийлүүлэгчдийн танилцаж болох бичиг, баримтын жагсаалт;

61.2.6.санал авах хуудсаар санал авах тохиолдолд санал авах хуудсын агуулга;

61.2.7.санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр.

62 дугаар зүйл. Ээлжит бус хурал

62.1.Шаардлагатай гэж үзвэл төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

62.2.Саналын эрхийн 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид нь, хянан шалгах зөвлөл, төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-д ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргах эрхтэй. Шаардлагыг бичгээр гаргана.

62.3.Шаардлагад үг хувь нийлүүлэгчийн овог, нэр, ээлжит бус хурал хуралдуулах болсон шалтгаан, хэлэлцэн шийдвэрлэх асуудал, шаардлага гаргасан эитэздийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог заана.

62.4.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь ээлжит бус хурлыг хуралдуулах тухай шаардлага хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хурал хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргана.

62.5.Гагцхүү дараахь тохиолдолд ээлжит бус хурлыг хуралдуулахаас татгалзах шийдвэр гаргах бөгөөд энэ шийдвэр, татгалзсан үндэслэлийн талаар шаардлага гаргасан хувь нийлүүлэгчид даруй- мэдэгдэнэ:

62.5.1.ээлжит бус хурал хуралдуулах тухай шаардлага гаргасан хувь нийлүүлэгчийн саналын эрх нь нийт саналын эрхийн 10 хувьд хүрээгүй;

62.5.2.ээлжит бус хурлаар хэлэлцэхээр санал болгож байгаа асуудал нь хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй.

62.6.Энэ шийдвэрийн талаархи гомдлыг шүүхэд гаргаж болно.

62.7.Энэ хуулийн 62.4.-т заасан хугацаанд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ шийдвэр гаргаагүй тохиолдолд шаардлага тавсан этгээд ээлжит бус хурал хуралдуулах тухай бие даан шийдвэр гаргаж болно.Энэ тохиолдолд хувь нийлүүлэгчдийн хурал зөвшөөрвөл хурлыг зарлах, хуралдуулахтай холбогдсон зардлыг компани хариуцаж болно.

62.8.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/нь хурал хуралдуулах тухай шийдвэр гаргасан тохиолдолд шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 45 хоногийн дотор хурлыг хуралдуулна.Энэ тохиолдолд хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг компани хариуцна.

63 дугаар зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрх

63.1.Дор дурдсан асуудлыг зөвхөн хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

63.1.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

63.1.2.нийлэх, нэгдэх, хуваах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

63.1.3.компанийн өрийг хувьцаагаар солих;

63.1.4.компанийн хэлбэрийг өөрчлөх;

63.1.5.компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

63.1.6.хувьцаар хуваах буюу нэгтгэх;

63.1.7.төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

63.1.8.хянан шалгах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

63.1.9.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчид нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд хуваалдан авах эрх эдлэх эсэх;

63.1.10.компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх батлах;

63.1.11.энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэллийг батлах;

63.1.12.энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

63.1.13.энэ хууль заасны дагуу компани өөрийн хувьцаагаа худалдан авахыг зөвшөөрөх ;

63.1.14.хэрэв компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

63.1.15.төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд;

63.1.16.энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд .

63.2.Төлөөлөн удирдах зөвлөлгүй хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчдийн хурал нь энэ хуулийн 63.1 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

63.2.1.компанийн үнэт цаасыг гаргах;

63.2.2.гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тогтоох;

63.2.3.компанийн гүйцэтгэх захирал болон хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүдийг сонгох, тэдгээрийн бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;

63.2.4.гүйцэтгэх удирдлагын гишүүний цалин урамшууллыг тогтоох ;

63.2.5.компанийн жилийн үйл ажиллагааны болон онцгүүрийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

63.2.6.компанийн аудиторыг сонгож, гэрээ байгуулах;

63.2.7.ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;

63.2.8.гүйцэтгэх удирдлагын дотоод зохион байгуулалтыг батлах;

63.2.9.компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;

63.2.10.энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;

63.2.11.энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд;

63.2.12.гүйцэтгэх удирдлага болон хувь нийлүүлэгчдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд.

64 дүгээр зүйл. Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

64.1.Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигчид энэ хуулийн 35 дугаар зүйл, давуу эрхийн хувьцаа эзэмшигчид энэ хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу саналын эрх эдэлнэ.

64.2.Хуульд өөрөөр заагаагүй бол нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.

64.3.Саналын эрхтэй хувь нийлүүлэгч нь санал хураалтаар шийдвэрлэх асуудал бүрээр санал өгөх эрхтэй. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны төрлийг тодорхойлно.

64.4.Энэ хууль болон компанийн дүрэмд энэ зүйлд зааснаас дээгүүр хэмжээ тогтоогоогүй бол төлөөлөх удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх зөвлөл/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлыг хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохдоо үнэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан хүнийг сонгоно.

64.5.Энэ хуулийн 63.1.1-63.1.6, 63.1.12-д заасан асуудлыг хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ. Компанийн дүрмээр эдгээр асуудлыг шийдвэрлэх саналын тоог энэ хэсэгт зааснаас дээгүүр тогтоож болно.

64.6.Хэлэлцэх асуудлын онцлогоос шалтгаалан зарим асуудлын хэлэлцэх жүрмыг компанийн дүрэмд тусгайлан тогтоож болно.

64.7.Хувь нийлүүлэгчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэж болохгүй. Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 67 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хэлэлцэх асуудлыг нэмж оруулах жүрмыг компанийн дүрэмд зааж болно.

65 дугаар зүйл. Хуралд оролцох эрх

65.1.Хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-өөс тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээд гарган хурал зарласан этгээдэд хүргүүлнэ.

Хувьцаат компанийн хувьд бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчдийн хүрлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдах өдрөөс 45 хоногоос өмнө байж болохгүй. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хурал болох өдөр нь бүртгэлийн өдөр болно.

65.2.Хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт нь хувь нийлүүлэгч бүрийн овог нэр, хаяг, түүний эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тооны талаархи мэдээг агуулсан байна.

65.3.Компани нь хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг компанийн энгийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг эзэмшигч этгээдэд шаардсан тохиолдолд түүнд танилцуулах үүрэгтэй.

65.4.Төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчдийн бүртгэлийг эрхлэх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

66 дугаар зүйл. Хурлын зар мэдээг хүргэх

66.1.Хурал зарлагч этгээд нь хурлын тухай зар мэдээг хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдэд мэдээлэх үүрэг хүлээнэ.

66.2.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хурлын зар мэдээг хүргэх журам, хугацаа компанийн дүрмээр тогтоож болно.

Хувьцаат компанийн хурлын зар мэдээг хүргэх журмыг Үнэт цаасны хороо тогтоож болно.

66.3.Хурлын тухай зар мэдээнд компанийн

оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар, бүртгэлийн өдөр, хурлаар хэлэлцэх асуудал болон гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох бичиг баримттай танилцах журам зэрэг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээллийг тусгасан байна.

Санал авах хуудсаар саналыг урьдчилан авах тохиолдолд санал авах хуудсыг хүлээн авах газар, сүүлчийн хугацааг тусгайлан мэдээлнэ.

66.4.Хувь нийлүүлэгчдээ дараахь бичиг баримтыг танилцуулна:

66.4.1.компанийн санхүүгийн жилийн тайлан;

66.4.2.санхүүгийн жилийн тайлангийн талаархи аудиторын дүгнэлт;

66.4.3.санхүүгийн өмнөх жилд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлүүд, тэдгээр нь энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан журмын дагуу хийгдсэн тухай аудиторын дүгнэлт;

66.4.4.компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдэд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;

66.4.5.компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;

66.4.6.компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал;

66.4.7.хувьцаат компанийн хувьд бизнесийн үйл ажиллагааны тайлан;

66.4.8.хувь нийлүүлэгчдийн хурлын хэлэлцэх асуудалтай холбогдсон хувь нийлүүлэгчдийн зайлшгүй мэдэх ёстой бусад мэдээлэл.

66.5.Компани нь хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувь нийлүүлэгчид дээрх бичиг баримттай танилцах боломжийг хангах үүрэг хүлээнэ.

67 дугаар зүйл. Хурлын хэлэлцэх асуудалд санал оруулах

67.1.Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

67.2.Нэмэлт саналаа бичгээр гаргах бөгөөд түүнд гаргаж байгаа санал, түүний шалтгаан, санал оруулж байгаа хувь нийлүүлэгчийн овог, нэр, түүний эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоог тусгана. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлж байвал нэр дэвшигчийн овог, нэр /хэрэв компанийн хувь нийлүүлэгч бол эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо/, дэвшүүлж байгаа хувь нийлүүлэгчийн овог, нэр, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоог тусгасан мэдэгдлийг бичгээр гаргана. Уг мэдэгдэлд нэр дэвшүүлж байгаа шалтгаанаа зааж болно.

67.3.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага / нь гаргасан нэмэлт саналыг дор дурдсанаас бусад тохиолдолд хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтанд уг саналыг хүлээн авсанаас хойш ажлын 15 хоногийн дотор багтаан оруулах үүрэг хүлээнэ:

67.3.1.санал гаргагч нь энэ хуулийн 67.1.-д заасан болзолыг хангаагүй;

67.3.2.энэ хуулийн 67.2.-т заасан мэдээллийг бүрэн тусгаагүй.

67.4.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь нэмэлт саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гарсанаас хойш ажлын 3 хоногийн дотор санал гаргасан хувь нийлүүлэгчид хүргүүлнэ. Энэ шийдвэрийн талаар санал гаргагч шүүхэд гомдол гаргаж болно.

67.5.Хувь нийлүүлэгчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хоригломо.

68 дугаар зүйл. Хурлын тооллогын комисс

68.1.Хувьцаат компанийн хувьд тооллогын комиссыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл томилон ажлуулна. Тооллогын комиссын үүргийг хөндлөнгийн гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэхээр хувь нийлүүлэгчдийн хурлаас тогтоож болно.

68.2.Хэлэлцэх асуудалтай шууд холбоотой компанийн албан тушаалтан болон эдгээр хүмүүстэй нэгдмэл сонирхолтой этгээдийг хурлын тооллогын комиссын гишүүнээр томилохыг хоригломо.

68.3.Хурлын тооллогын комисс дараахь үүрэг хүлээнэ:

68.3.1.хурлын ирц /кворум/-ыг тогтоож

хурлын даргад мэдээлэх;

68.3.2.тухайн хурлын хэлэлцэх асуудал бүрээр оролцогч этгээд бүрийн саналын эрхийн хэмжээг тогтоох;

68.3.3.хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах асуудалд тайлбар өгөх;

68.3.4.санал өгөх журмыг тайлбарлах;

68.3.5.санал өгөх журам болон хувь нийлүүлэгчдийн санал өгөх эрхийг хангах;

68.3.6.санал хураалтыг санал авах хуудсаар явуулж байгаа тохиолдолд санал авах хуудсыг тоолж, хүлээн авах;

68.3.7.санал хураалтын дүнг тоолж энэ тухай тэмдэглэл хөтлөх;

68.3.8.санал тоолж санал хураалтын дүнг нэгтгэж дүнгийн тухай шийдвэр гарган тооллогын комиссын дарга гарын үсэг зурж / тооллогын комиссын дарга нь тооллогын үр дүнгийн үнэн зөвийг хариуцна/ хуралд танилцуулах;

68.3.9.санал авах хуудсыг компанийн архивт хадгалуулахаар шилжүүлэх.

68.4.Төлөөлөн удирдах зөвлөлөөс хурлын тооллогын комисст хурал хийхтэй холбогдсон бусад үүргийг хариуцуулж болно.

69 дүгээр зүйл. Хуралд оролцох журам

69.1.Хувь нийлүүлэгч нь хуралд өөрийн биеэр буюу Иргэний хуульд заасны дагуу бичгээр олгосон итгэмжлэлийн үндэсн дээр өөр этгээдээр төлөөлүүлэн оролцож болно.

69.2.Төлөөлж оролцох этгээд энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөлд хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хуралд хүчинтэй. Хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй байна.

69.3.Санал авах хуудсаар саналаа ирүүлсэн хувь нийлүүлэгчийг хуралд оролцсонд тооцно.

69.4.Хувьцаат компанийн хувьд бүртгэлийн өдрөөс хойш хувьцаагаа бусдад шилжүүлсэн этгээд, шинэ эзэмшигч этгээдэд хуралд оролцох итгэмжлэл олгох, эсхүл уг шинэ эзэмшигч этгээдийн өгсөн зааврын дагуу санал өгч болно.

69.5.Компанийн хувьцааг хэд хэдэн этгээд дундаа хэсгээр өмчилж байгаа тохиолдолд хуралд оролцож санал өгөх эрхийг дундаа хэсгээр өмчлөгдийн харилцан тохиролцсоноор төдийгүй хэн нэг нь, эсхүл тэдний хамтын төлөөлөгч хэрэгжүүлнэ. Эдгээр этгээдийн төлөөлөн оролцох эрхийг Иргэний хуульд заасны дагуу баталгаажуулсан байна.

70 дугаар зүйл. Хурлын ирц /кворум/, хурал хүчин төгөлдөр болох

70.1.Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.Компанийн дүрмээр ирцийн хувийг энэ зүйлд зааснаас дээрүүр тогтоож болно.

70.2.Энэ хуулийн 70.1.-д заасан хувь хэрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлоно.Харин хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж үл болно.

70.3.Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол саналын эрхийн 20 ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид хуралд оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.

70.4.Компанийн дүрмээр илүү өндөр хувь тогтоогоогүй бол энэ хуулийн 63.1.1-63.1.6-д заасан асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

70.5.Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Уг хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

70.6.Хувьцаат компанийн хувьд хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

70.7.Түрүүчийн хуралд ирүүлсэн саналыг хойшлогдсон хурлын ирц, санал хураалтын дүнд тооцно.

70.8.Хойшлогдсон хурал нь ажлын 20 хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлах бөгөөд ирц /кворум/ -ийг энэ хуулийн 70.1.-д зааснаар тогтооно.

71 дүгээр зүйл. Санал авах хуудас

71.1.Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын саналыг санал авах хуудсаар авах бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани нь энэ аргыг хэрэглэж болно.

71.2.Хувь нийлүүлэгчид хурлын шийдвэрт өгөх саналаа санал авах хуудсанд тэмдэглэн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн тогтоосон журмын дагуу тооллогын комисст ирүүлнэ.

71.3.Санал авах хуудсын агуулга, загварыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирлага/ батална. Санал авах хуудсанд дараахь зүйлийг тусгана:

71.3.1.компанийн оноосон нэр;

71.3.2.хурал хийх газар, өдөр, цаг;

71.3.3.хувь нийлүүлэгчийн нэр, эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо;

71.3.4.санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, сонгуульд оролцох нэр дэвшигчийн овог нэр;

71.3.5.төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг сонгоход хэрэглэх санал хураах аргын нэр /ердийн, кумулятив/;

71.3.6.асуудал бүрээр ердийн журмаар саналаа өгөхөд "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" алин болохыг тэмдэглэсэн саналын хуудсыг, сонгуульд кумулятив аргаар саналаа өгөхөд уг аргын тухай тайлбар бүхий хувилбар нэр дэвшигчид өгөх саналын тоог тус тус тэмдэглэсэн саналын хуудсыг хэрэглэнэ.

72 дугаар зүйл. Санал авах хуудсыг хүчинтэйд тооцох

72.1.Санал авах хуудсаар өгсөн саналыг дараахь тохиолдолд хүчинтэйд тооцно:

72.1.1.ердийн журмаар санал өгөх асуудалд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн;

72.1.2.төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг ердийн журмаар санал хураах сонгох тохиолдолд нэр дэвшигчийн төлөө өгсөн зөвшөөрсөн санал нь сонгогдох гишүүдийн тооноос илүүгүй байх;

72.1.3.нэр дэвшигчийн төлөө өгөх саналаа кумулятив аргаар санал хураах сонгох тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшигч бүрд өгсөн саналын тооны нийлбэр нь тухайн хувь нийлүүлэгчийн саналын эрхийн тооны нийт дүнгээс илүүгүй байх бөгөөд саналын эрхийн тооны нийт дүн нь тухайн хувь нийлүүлэгчийн эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна.

72.2.Төлөөлөн удирдах зөвлөл болон бусад удирдлагын байгууллагын гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг нь тэмдэглэсэн байна.

73 дугаар зүйл.Эчнээ санал хураалтаар компанийн хувь нийлүүлэгчид шийдвэр гаргах

73.1.Хувьцаат компани нь хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувь нийлүүлэгчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг санал авах хуудсыг ашиглан явуулна.

Энэлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж үл болно.

73.2.Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл гаргана. Эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэрт дараахь зүйлийг тусгана:

73.2.1.эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлууд;

73.2.2.саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр;

73.2.3.санал авах хуудсыг хувь нийлүүлэгчдэд хүргүүлэх хугацаа;

73.2.4.санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;

73.2.5.санал авах хуудсын агуулга болон загвар;

73.2.6.эчнээ санал хураалт явуулахтай холбогдуулан хувь нийлүүлэгчид танилцуулах, бичиг баримтын жагсаалт эдгээртэй танилцах боломж, газар.

73.3.Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийг энэ хуулийн 65, 69 дүгээр зүйлд заасны дагуу тодорхойлно.

73.4.Санал авах хуудсанд энэ хуулийн 71.3.1, 71.3.3, 71.3.4, 71.3.5, 71.3.6-д заасан мэдээллийг тусгахын зэрэгцээ санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг заасан байна.

73.5.Хувьцаат компанийн хувьд эчнээ санал хураалтын санал авах хуудсыг түүнийг эргүүлж хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30 ба түүнээс дээш хоногийн өмнө хувь нийлүүлэгчдэд

тараана.

73.6.Нийт саналын эрхийн 50-иас дээш хувийг эзэмшигчид саналаа ирүүлснээр энэхүү санал хураалтыг хүчинтэй тооцно. Саналаа ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор тухайн асуудлыг шийдвэрлэнэ.

73.7.Энэхүү санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, дүнг гаргах ажлыг энэ хуулийн 68 дугаар зүйлд заасан эрх, үүрэг бүхий тооллогын комисс зохион байгуулна.

73.8.Тооллогын комисс нь санал авах хуудсыг хүлээн авсан сүүлчийн өдрөөс хойш ажлын 3 хоногийн дотор энэхүү санал хураалтын дүнгийн тухай тайлан гаргаж тооллогын комиссын дарга гишүүд гарын үсэг зурж төлөөлөн удирдах зөвлөлд хүлээлгэн өгнө.

73.9.Энэхүү санал хураалтын дүнгийн тухай тайланд дараахь зүйлийг тусгана:

73.9.1.санал авах хуудсыг хувь нийлүүлэгчдэд тараасан өдөр;

73.9.2.энэхүү санал хураалтаар шийвэрлэх асуудлууд;

73.9.3.санал ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

73.9.4.шийдвэрлэх асуудал бүрээр саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийн өгсөн саналын нийт тоо;

73.9.5.энэхүү санал хураалтын дүн;

73.9.6.энэхүү санал хураалтаар гаргасан шийдвэр.

73.10.Тооллогын комиссын тайланг үндэслэн гаргасан шийдвэрийг тайлан хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор төлөөлөн удирдах зөвлөл хувь нийлүүлэгчид мэдээлнэ.

74 дүгээр зүйл.Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл

74.1.Хувь нийлүүлэгчдийн хурал дуусснаас хойш ажлын 15 хоногийн дотор хурлын тэмдэглэлийг гаргаж бөгөөд хурлын дарга гарын үсгээ зурна. Хурлын тэмдэглэлийн үнэн зөвийг хурлын дарга харицуна.

74.2.Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл дараахь мэдээллийг агуулсан байна:

74.2.1.хурал болсон он, сар, өдөр, газар,цаг;

74.2.2.хурлын даргын овог, нэр;

74.2.3.хурлаар хэлэлцсэн асуудлууд;

74.2.4.хувь нийлүүлэгчдийн саналын эрхийн тоо, хурлын ирц;

74.2.5.санал авах хуудас хэрэглэсэн бол үү хуудасны загвар;

74.2.6.хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр зөвшөөрсөн , татгалзсан , тодгэлзсэн саналын тоо, гарсан шийдвэрийн бүрэн томьёолол.

74.3.Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэлд алдаа гарсан нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэс болохгүй.

74.4.Хязгаалагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын санал хураалтын дүн, гарсан шийдвэрийг тухайн хурал дээр зарлан мэдэгдэнэ. Хувьцаат компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын болон эчнээ санал хураалтаар гарсан шийдвэрийг тухайн хурал дээр, эсүүл хурал дууссаны дараа санал хураалтын дүн, гарсан шийдвэрийг хүргүүлэх замаар мэдэгдэнэ.

75 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

75.1.Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.

75.2.Хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно.

75.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог компанийн дүрмээр тогтооно.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь 9 ба түүнээс дээш гишүүнтэй байна.

75.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь компанийн хувь нийлүүлэгч биш байж болно.

76 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

76.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

76.1.1.компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох;

76.1.2.хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралуулах;

76.1.3.хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувь

нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

76.1.4.компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах;

76.1.5.компанийн дүрэмд заасан хувьцааны хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

76.1.6.энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

76.1.7.өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;

76.1.8.компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

76.1.9.компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл тэдгээрт олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;

76.1.10.компанийн аудиторыг сонгож түүнтэй хийх, гэрээний нөхцөлийг тогтоох;

76.1.11.компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

76.1.12.компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;

76.1.13.төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлах;

76.1.14.компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;

76.1.15.компанийг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

76.1.16.энэ хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

76.1.17.энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

76.1.18.энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудлууд.

76.2.Хувьцаат компанийн хувьд энэ хуулийн 76.1.6., 76.1.10., 76.1.17.-д заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд оролцож саналаа өгнө. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн гэж өөрөө, эсхүл эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, төрсөн ах дүү, болон нэгдмэл сонирхолтой этгээд нь сүүлийн 3 жилийн хугацаанд тухайн компанид , эсхүл түүний хараат болон охин компани эрх бүхий албан тушаал эрхэлж байгаагүй хүнийг тооцно.

77 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох

77.1.Энэ хууль буюу компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгосон тохиолдолд хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлаар гишүүнийг нөхөн сонгож болно. Дүрэмд өөрөөр заагаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувь нийлүүлэгчдийн хурал хийх өдрөөр дуусгавар болно.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.

77.2.Хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлийг кумулятив аргаар сонгосон бол төлөөлөн удирдах зөвлөлийг зөвхөн бүрэн бүрэлдэхүүнээр нь хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг нь дуусгавар болгож болно.

77.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь хувь хүн байна.

77.4.Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно.Энэ аргыг хэрэглэхэд энгийн хувьцаа тус бүр сонгогдох гишүүдийн тоотой тэнцүэх саналын эрхтэй байх бөгөөд хувь нийлүүлэгч нь өөрийн хувьцаанд ногдох саналаа бүгдийг нь нэг хүнд, эсхүл хэд хэдэн хүнд хуваан өгөх эрхтэй.

77.5.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг төлөөлөн удирдах зөвлөл нөхөн сонгууль явуулах хүртэл түр томилж болно.

78 дугаар зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

78.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

78.2. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаат зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

78.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргын томилсон, эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

78.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь үйл ажиллагааны журмаар тогтоосон эрх хэмжээний дотор компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах болон компанийн эрх ашгийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаагаа явуулна.

79 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

79.1.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэг удаа хуралдуулна, шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь тогтоол байна. Тогтоолд дарга гарын үсэг зурна.

79.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх удирдлага болон компанийн дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга шаардлагаар хуралдуулна. Төлөөлөн удирдах зөвлөл үйл ажиллагааныхаа жүрмыг тогтоож батална.

Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

79.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.Компанийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.Энэ хууль болон компанийн дүрэмд заасны дагуу хэрэв тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүн санал өгөх эрхгүй байвал шийдвэрийг саналын эрхтэй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос хоёр дахин бага болсон тохиолдолд компани нь гурван сарын дотор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохоор хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэгэ эрхтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэхээр компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заажболно.

79.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд дараахь зүйлийг тусгана:

79.4.1.хурал хийсэн газар болон цаг;

79.4.2.хуралд оролцон гишүүд;

79.4.3.хурлаар хэлэлцэгдсэн асуудал;

79.4.4.санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;

79.4.5.гаргасан шийдвэр.

Хурлын тэмдэглэлд хурал даргалагч гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

79.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн явдал төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

80 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлага

80.1.Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагаг удирдан зохион байгуулна.

80.2.Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ. Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд компанийн гүйцэтгэх захирал байна.

80.3.Хувьцаат компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болно. Харин төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хоригдоно.

80.4.Хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй

бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал, эсхүл гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн гишүүн нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажилладаг болно.

80.5.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-тэй байгуулсан хөлсөөр ажиллах гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурлын дарга/ гарын үсэг зурна. Гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагыг хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

80.6.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

80.7.Гүйцэтгэх удирдлагыг багийн хэлбэрээр хэрэгжүүлэх тохиолдолд компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-тэй байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдож багийн гишүүдийн ажиллах дотоод журмыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр батлан мөрдөж ажиллана. Журамд дараахь зүйлийг тусгасан байна.

80.7.1.багийн ахлагч болон гишүүдийн эрхлэх ажил үүргийн хуваарь, ажлын харилцан уялдаа холбоог зохицуулах байдал;

80.7.2.багийн ахлагчийг томилох журам;

80.7.3.багийн ахлагчийн эрх, үүрэг, хариуцлага.

80.8.Бат нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн өмнө компанийн үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага хүлээнэ.

Энэ хуулийн 80.5.-д заасан гэрээ, хэлцэл хийх төлөөллийг хэрэгжүүлэхэд компанийг төлөөлж багийн ахлагч гарын үсэг зурна. Багийн ахлагчийг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн багийн гишүүд сонгоно. Багийн ахлагч компанийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэнэ.

80.9.Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч багийн хурал, гаргасан шийдвэрийн тэмдэглэлийг заавал хөтөлнө. Энэ тэмдэглэлийн үнэн зөвийг багийн ахлагч биечлэн хариуцна.

80.10.Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ хэдийд ч гаргах эрхтэй.

АРАВДУГААР БҮЛЭГ

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

81 дүгээр зүйл.Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага

81.1.Төлөөлөн удирдах зөвлөл, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтнүүд зэрэг албан тушаал эрхэлдэг этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

81.2.Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн батална дотоод журамд заасан үүргийг биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана. Төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууц мэдээг гуравдахь этгээдэд дамжуулах, хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.

81.3.Хуульд өөрөөр заагаагүй бол компанийн эрх бүхий албан тушаалтан өөрийн хууль бус үйл ажиллагаанаас компанид учирсан хохирлыг хариуцна.

81.4.Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, түүний хэмжээг тогтоох, асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, компанийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

81.5.Энэ зүйлд заасны дагуу хэд хэдэн этгээдүүд хариуцлага хүлээх бол тэд компанийн өмнө хамтын хариуцлага хүлээнэ.

81.6.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эзэнийн хувьцааны 20 ба түүнээс дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь энэ хуулийн

81-д заасан эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

82 дугаар зүйл.Хүлээх хариуцлага

82.1.Компанийн эрх бүхий албан тушаалтан санаатайгаар дараахь хууль бус үйл ажиллагаа явуулсан бол компани болон түүний хувь нийлүүлэгч, зээлдүүлэгчдэд учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцна:

82.1.1.хувийн ашиг сонирхлын үүднээс компанийн нэрийг ашиглан аж ахуйн үйл ажиллагаа явуулсан;

82.1.2.компанийн хувь нийлүүлэгчид, зээлдүүлэгч болон бусад харилцагчдад хуурамч мэдээлэл өгсөн

82.1.3.энэ хуулийн 97 дугаар зүйлд заасан шаардлага зөрчиж нэгдмэл сонирхол бүхий этгээд болохоо мэдэгдээгүй;

82.1.4.энэ хуулийн 95 дүгээр зүйлд заасан журмын дагуу компанийн бичиг баримтыг хадгалаагүй;

82.1.5.энэ хуулийн 81.2.-т заасан зарчмыг баримтлаагүй;

82.1.6.энэ хуулийн 47, 48, 49, 53 дугаар зүйлд заасны дагуу ногдол ашиг хуваарилах, хувьцаа худалдан авах эрхийн бичгийг эргүүлж худалдан авах нөхцөлийг мөрдөөгүй, төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээ, компанийн дүрмээр тогтоосон эд хөрөнгө захиран зарцуулах эрх хэмжээг хэтрүүлсэн.

82.2.Энэ зүйлд заасан хариуцлагыг энэ хууль болон бусад хуульд заасан бусад хариуцлагатай давхар хүлээлгэж болно.

83 дугаар зүйл.Хувь нийлүүлэгчийн нэхэмжлэл гаргах эрх

83.1.Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

83.2.Компани болон түүний энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компани болон өөрт учирсан хохирлыг энэ хуулийн 81.6.-д заасан этгээдээр нөхөн төлүүлэхээр энэ хуульд заасан журмын дагуу шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

84 дүгээр зүйл.Их хэмжээний хэлцэл

84.1.Их хэмжээний хэлцэлд дараахь хэлцлийг тооцно:

84.1.1.хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсүүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл; /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/

84.1.2.компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсүүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

84.2.Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

84.3.Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь аудиторын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцийн /мөнгөний ханшны уналт/ түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

84.4.Нэг өмчлөгчтэй компанид энэ бүлгийн заалтууд үл хамаарна.

85 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл хийх

85.1.Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ санал нэгтэйгээр гаргана.

Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэй гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувь нийлүүлэгчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож байгаа хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор шийдвэрлэнэ.

85.2.Их хэмжээний хэлцэл хийх асуудлаар эсрэг саналтай байсан хувь нийлүүлэгчид нь энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу өөрийн эзэмшилд байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

86 дугаар зүйл.Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл

86.1.Компанийн эрх бүхий албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийг энэ хуулийн 86.2.-т заасан нөхцөлд компанитай, эсхүл түүний харааг болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх сонирхол бүхий этгээдэд тооцно.

86.2.Энэ хуулийн 86.1.-д заасан этгээд болон түүний эхнэр, нөхөр, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдүүд нь:

86.2.1.хэлцлийн нэг тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

86.2.2.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааных нь / ногдол хувийн/ 20-иос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

86.2.3.хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн, толгойлох компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцаа ногдол хувийн 20 болон түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

86.2.4.энэ хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр илэрхийлэгдэх бусад эрхийг худалдах болон худалдан авч байгаа.

86.3.Энэ бүлгийн заалтууд дараахь тохиолдолд үл хамаарна:

86.3.1.компанийн бүх энгийн хувьцааг нэг этгээд эзэмшиж байгаа компанид;

86.3.2.хувьцаа эзэмшигч нь энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа худалдан авах эрхээ эдлэхэд;

86.3.3.компани нь хувьцаа эзэмшигч тус бүрээс тэдний худалдахаар санал болгож байгаа хувьцааг санал болгосон нийт хувьцааны төрөл тус бүрийн тоотой хувь тэнцүүлэн худалдан авахад;

86.3.4.бусад компанийн энгийн хувьцааны 75 хувь буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа компани нь энэ хуулийн 20.4.-т заасны дагуу түүнийг нэгтгэх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулахад.

86.4. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувь нийлүүлэгчийн тоо нь 10-аас илүүгүй бол компанийн дүрэмд энэ хуулийн 86.3-т зааснаас бусад тохиолдлыг зааж болно.

87 дугаар зүйл.Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийсэн хэлцлийн улмаас үүсэх хохирлыг арилгах

87.1.Сонирхол бүхий этгээдийг энэ хуулийн 88, 89 дүгээр зүйлд заасан шаардлага, журмыг зөрчиж байгуулсан хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж үзсэн бол үүний улмаас компани болон түүний харааг компанид үүссэн хохирлыг бууруулах этгээд хариуцна.

87.2.Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87.1.-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

88 дугаар зүйл.Хэлцэл хийх сонирхол бүхий этгээдэд тавих шаардлага

88.1.Хэлцэл хийхэд сонирхлын зөрчил бүхий этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл / байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ болон аудиторт дараахь зүйлийг мэдүүлэх үүрэгтэй:

88.1.1.дангаараа буюу эхнэр /нөхөр/, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;

88.1.2.өөрөө буюу эхнэр /нөхөр/, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон түүний бүх хараат болон охин компанийн талаар;

88.1.3.компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа.

88.2.Хэрэв шийдвэр гаргах байгууллагын бүх гишүүд нь хэлцэл хийх сонирхол бүхий этгээд биш бол хэлцэл хийх сонирхол бүхий этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.

89 дугаар зүйл. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийх журам

89.1.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай хувьцаат компанийн шийдвэр, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх, шаардах тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх сонирхолгүй төлөөлөн удирдах зөвлөл/байхгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/-ийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана.

89.2.Сүүлийн 3 жил дор дурдсан үйл ажиллагаа эрхлээгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг хараат бус гишүүнд тооцно:

89.2.1.компанийн эрх бүхий албан тушаал эрхэлж байгаагүй, эсхүл уг этгээдийн эхнэр / нөхөр/, эцэг, эх, хүүхэд, ах, эгч, дүү, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь компани буюу түүний удирдах байгууллагад албан тушаал эрхэлдэггүй;

89.2.2.компанийн нэгдмэл сонирхолтой этгээд;

89.2.3.нэгдмэл сонирхолтой компанийн эрх бүхий албан тушаал эрхэлдэггүй.

89.3.Сонирхлын зөрчилтэй хэлцлээр хуваалдах, хуваалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 56 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

89.4. Хувьцаат компанийн хувьд дараахь тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл / хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувь нийлүүлэгчийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилтэй хувь нийлүүлэгчдийн саналын олонхоор гаргана:

89.4.1.энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 2 хувиас их байх;

89.4.2.компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанийн урьд гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 2 хувиас их байх;

89.4.3.төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүд нь /хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн бүх хараат бус гишүүд/ хэлцэл хийх сонирхолтой этгээд байх тохиолдолд.

89.5.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувь нийлүүлэгчийн хуралд оруулах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хэлцэл хийх сонирхолгүй гишүүдийн олонхийн саналаар; хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана.

89.6.Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд, эсхүл түүний эцэг эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын зөрчилтэй хэлцлийг энэ хуулийн 89.4.-т заасны дагуу батлуулах шаардлагагүй.

Энэ хуулийн 86 дугаар зүйлд заасны дагуу хэлцэл хийх сонирхол бүхий этгээдээр тооцоохоос өмнө компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хувь нийлүүлэгчдийн дараагийн ээлжит хурал болох хүртэл энэ хуулийн 89.4.-т заасан журмын дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулах шаардлагагүй.

89.7.Хувь нийлүүлэгчдийн хурал хийх өдөр компанийн буюу түүний хараат компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран компанийн буюу түүний хараат компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагаат батлах шийдвэр гаргах бөгөөд энэ нөхцөлд энэ хуулийн 89.4.-т заасан шаардлагыг хангасанд тооцно.

89.8.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай энэ бүлэгт тогтоосон журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах тухай энэ хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална.

90 дүгээр зүйл.Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журам зөрчсөний үр дагавар

90.1.Энэ хуулийн 86.1.-д заасан этгээд нь энэ хуулийн 88, 89 дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөний улмаас компани буюу түүний хараат компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ. Уг этгээдтэй байгуулсан хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

90.2.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн компанийн эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 82, 87 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

90.3.Энэ хуулийн 86.1.-д заасан этгээд нь энэ хуулийн 88, 89 дугаар зүйлийн шаардлага, журам зөрчсөн болон компанитай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцаат уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг уг хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

90.4.Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь, эсхүл компани нь энэ хуулийн 86.1.-д заасан этгээд, эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцаат эзэмшдэг хуулийн этгээдийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

90.5.Энэ хуулийн 90.3.-т зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 89 дугаар зүйлд заасан журам зөрчсөн бөгөөд эдгээр зөрчлийн талаар энэ хэлцлийг байгуулсан этгээд мэдээгүй болон мэдэх боломжгүй байсан нөхцөлд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцохгүй.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

91 дүгээр зүйл.Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт

91.1.Дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь санхүүгийн тайланг шалгуулж батлагаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулж болно. Хувьцаат компанийн дүрэмд аудиторыг заавал ажиллуулахаар заана.

91.2.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл / байгүй бол хувь нийлүүлэгчдийн хурал/ аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудиторын эрх, үүрэг, хариуцлага, аудиторд төлөх хөлсний хэмжээг заана. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг батлагаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ. Ээлжит бус шалгалтыг төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл энгийн хувьцааны 10-аас дээш хувийн эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Аудиторын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж гэрээг нь байгуулж хийлгэсэн хувь нийлүүлэгч хариуцаж төлнө. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компани болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.

91.3.Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаархи баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

91.4.Аудитор нь хувь нийлүүлэгчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

91.5.Дараахь этгээдийг компанийн ауди тороор сонгон ажиллуулахыг хориглоно:

91.5.1.компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

91.5.2.компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

91.5.3.компанитай аудитиас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

91.6.Аудиторын гаргасан дүгнэлтийн шинж чанараас хамаарууллан олгох хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.

91.7.Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалт /баримт шалгалт/ -ын дүнг үндэслэн компанийн аудитор нь дараахь мэдээллийг агуулсан дүгнэлт гаргана:

91.7.1.компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;

91.7.2.нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил байвал уг зөрчлийг тохиодол тус бүрээр тодорхойлох;

91.7.3.шалгалтын хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлүүдийн жагсаалт, уг хэлцлийг энэ хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай тодорхойлолт;

91.7.4. хувьцаат компанийн хувьд Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээллүүд;

91.7.5.компанийн дүрэм болон аудитын гэрээгээр тодорхойлсон бусад мэдээллүүд.

92 дугаар зүйл.Хянан шалгах зөвлөл

92.1.Хувьцаат компани нь хянан шалгах зөвлөлтэй байх бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани хянан шалгах зөвлөлтэй байж болно. Хянан шалгах зөвлөлийн гишүүдийн тоо, тэдгээрийг сонгох журам, бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг компанийн дүрмээр тогтооно.

92.2.Хянан шалгах зөвлөл нь компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувь нийлүүлэгчдийн хуралд танилцуулах, хувь нийлүүлэгчдийн санал, гомдлын дагуу компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаат хянан шалгах зэрэг энэ хууль болон компанийн дүрэмд заасан бусад бүрэн эрхтэй.

92.3.Хянан шалгах зөвлөлийн үүргийг нэг хянан шалгагч хэрэгжүүлэхээр дүрэмд тусгаж болно.

92.4.Хянан шалгах зөвлөлийн гишүүдийг хувь нийлүүлэгчдийн хурлаас сонгоно.

92.5.Хянан шалгах зөвлөлийн гишүүд нь компанийн эрх бүхий албан тушаалтан байхыг хориглоно.

92.6.Хянан шалгах зөвлөл нь энэ хуулийн 62.2-т заасны дагуу хувь нийлүүлэгчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахыг шаардах эрхтэй.

93 дугаар зүйл.Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан

93.1.Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Хувьцаат компанийн хувьд Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

93.2.Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацааг дүрмээр тогтооно.

93.3.Компани нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах бөгөөд түүний үнэн зөвийг компанийн гүйцэтгэх удирдлага хариуцна.

94 дугаар зүйл.Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

94.1.Компанийн санхүүгийн тайланд дараахь зүйлийг тусгана:

94.1.1.баланс;

94.1.2. орлого, үр дүнгийн тайлан;

94.1.3. мөнгөн гүйлгээний тайлан;

94.1.4. хуримтлагдсан ашгийн тайлан;

94.1.5. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт,

нэр төрөл, үнийн дүнгийн хамт;

94.1.6. нэмэлт тайлбар;

94.1.7.бусад.

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмээр санхүүгийн тайланд оруулах нэмэлт зүйлийг тогтоож болно.

94.2.Татвартай холбогдон авах нэмэлт тайлбарыг Сангийн яам, хувьцаат компанийн санхүүгийн тайлангийн агуулга болон нэмэлт тайлбарын талаархи загвар, журмыг Үнэт цаасны хороонооос тогтоож болно.

94.3.Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувь нийлүүлэгч нарт зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан илтгэл бичиж хүргүүлэх бөгөөд тайланд доорх зүйлийг тусгана:

94.3.1.тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаархи танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;

94.3.2.тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшил удирдлагын зардлын хэмжээ;

94.3.3.компанийн дүрмээр тогтоосон бусад мэдээлэл;

94.3.4.хувьцаат компанийн жилийн тайланд тусгах нэмэлт мэдээллийг Үнэт цаасны хороо тогтоож болно.

94.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувь нийлүүлэгчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ. Хуульд заасан тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт гаргахын өмнө санхүүгийн тайланг аудитор шалгаж баталгаажуулна.

95 дугаар зүйл.Компанийн бичиг баримтыг хадгалах

95.1.Компани нь дараахь бичиг баримтыг хадгалах үүрэгтэй:

95.1.1компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, компанийг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ;

95.1.2.хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх байгууллага болон хянан шалгах зөвлөлөөс баталсан компанийн дотоод бичиг баримт;

95.1.3.компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм;

95.1.4.нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

95.1.5.хувь нийлүүлэгчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон хамтын удирдлагын гүйцэтгэх байгууллагын хурлын тэмдэглэл, компанийн гүйцэтгэх байгууллагын үүрэгийг ганцаарчлан гүйцэтгэж байгаа этгээдийн тушаал болон шийдвэрүүд;

95.1.6.хянан шалгах зөвлөлийн хурлын тэмдэглэл, хянан шалгах зөвлөл болон аудиторын дүгнэлт;

95.1.7.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

95.1.8.хувьцаа болон үнэт цаас гаргах журам;

95.1.9.анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт;

95.1.10.компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо;

95.1.11.энэ хууль болон компанийн дүрмээр тодорхойлогдсон компанийн бусад дотоод бичиг баримт.

95.2.Компани нь энэ хуулийн 95.1.-д заасан баримтыг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газар буюу хувь нийлүүлэгчдийн мэдэх, тэдний нэвтрэх боломж бүхий газар хадгална.

95.3.Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга хадгална. Энэ хуулийн 95.1.-д заасан бусад бичиг баримтыг компани нь 5 жилийн хугацаагаар хадгалах бөгөөд энэ хугацаа дууссаны дараа эдгээр бичиг баримтыг архивт шилжүүлнэ.

95.4.Энэ хуулийн 95.1.-д заасан баримт бичгийг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах архивт шилжүүлэх зэрэг ажиллагааг компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /байхгүй бол гүйцэтгэх удирдлагын холбогдох албан тушаалтан/ эрхлэн гүйцэтгэнэ.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагаат биечлэн хариуцаж бичиг баримтыг хөтлөх үүрэг хүлээнэ.

96 дугаар зүйл.Компанийн талаар мэдээлэл авах

96.1.Хувьцаат компани нь өөрийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрс, тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо болон Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржийн дүрэм, журмаар тогтоосон бусад мэдээллийг өөрийн үнэт цаас эзэмшигчийн хүсэлтээр танилцуулах үүрэгтэй.

96.2.Компани нь анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, компанийн гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад бичиг баримттай танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах бололцоог хувь нийлүүлэгчдэд олгох үүрэг хүлээнэ.

96.3. Хувьцаат компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нэг хувь нийлүүлэгч нь компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг, эзэмшиж байгаа хувьцааны тоо зэргийг агуулсан бүртгэлийг шаардан гаргуулах эрхтэй. Компанийн гүйцэтгэх удирдлага, эсхүл хувь нийлүүлэгчдийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага уг шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шаардлага гаргасан өдрөөр тасалбар болгон бүртгэлийг гаргаж өгөх үүрэгтэй. Үүнтэй холбогдон гарах зардлыг шаардлага тавсан этгээд хариуцна.

97 дугаар зүйл.Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний талаархи мэдээлэл

97.1. Дараахь тохиолдлыг энэ хуульд заасан компанийн нэгдмэл сонирхолтой этгээд гэж тооцно:

97.1.1.тодорхой гэрээний үндсэн дээр хамтран компанийн шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс ;

97.1.2. толгойлох болон хараат компаниуд;

97.1.3. нэг толгойлох компанийн хараат компаниуд;

97.1.4.тодорхой гэрээний үндсэн дээр хамтран компанийн шийдвэрийг тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/;

97.1.5. нэг хүн / бүлэг хүн/ гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компаниуд;

97.1.6. компани болон уг компанийн албан тушаалтан;

97.1.7. гэр бүлийн гишүүд, эхнэр, нөхөр;

97.1.8. эцэг, эх болон хамт амьдардаг 18-аас доош насны хүүхэд.

97.2.Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрсдийн эзэмшиж байгаа үнэт цаасны тухай мэдээллээ нэгдмэл сонирхолтой этгээд болсон өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

97.3.Нэгдмэл сонирхолтой этгээд нь дээр дурдсан мэдээллийг өгөөгүй буюу хугацаа хэтрүүлж өгснөөс компанид хохирол учруулбал уг хохиролыг нэгдмэл сонирхолтой этгээд хариуцна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

98 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

98.1.Энэ хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан компаниуд 1999 оны 12 дугаар сарын 30-ны дотор компанийхаа дүрмийг энэ хуульд нийцүүлэн өөрчилнө. Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс компанийн дүрмийг энэ хуульд нийцүүлэн өөрчлөх хүртэлх хугацаанд гэдгээрийн үүсгэн байгуулсан бичиг баримт нь дээр дурдсан хэм хэмжээнд харш бус байгаа эсэгээрээ хүчин төгөлдөр байна. Энэ хуулийн хэм хэмжээнд өөрийн дүрмийг нийцүүлэн өөрчлөөгүй компанийн хувь нийлүүлэгч нь компанийн дүрмийг энэ хуульд нийцүүлэн өөрчлөхийг шаардах, шийдвэр гаргуулахаар шүүхэд хандах эрхтэй.

98.2.Энэ хуульд нийцүүлэн өөрчлөхтэй холбогдон гарсан дүрмийн нэмэлт, өөрчлөлтүүдийг бүртгэхэд компани нь хураамж төлөхгүй.

98.3.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн компанитай холбогдох хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж нь энэ хуульд харшлаагүй бол хүчин төгөлдөр байна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар
сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

НӨХӨРЛӨЛ, КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нөхөрлөл, компанийн тухай хуулийн III хэсэг, 6 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Нөхөрлөл, компанийн тухай хуулийн нэр, нэгдүгээр бүлгээс "компани", "салбар" гэсэн үгийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Компанийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар
сарын 9-ний өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын хооронд 1998 оны 10 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан Иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай Гэрээг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: << Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар -12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

"Интерпресс" хэвлэлийн газар хэвлэв
ИНТЕРПРЕСС ХЭВЛЭЛИЙН КОМПАНИ
Барилгачдын талбай-15,1-р давхар
Утас: 326898 Факс: 976-1-312175
E-mail:interpress@magicnet.mn

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны долдугаар сарын 30. №35 (114)

Гарчиг

Монгол Улсын Хууль

335. Тагнуулын байгууллагын тухай (1999-7-8-ны хууль) 683

336. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай (1999-7-8-ны хууль) 689

337. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай (1999-7-8-ны хууль) 690

338. Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (1999-7-8-ны хууль) 690

339. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-7-8-ны хууль) 690

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын тагнуулын байгууллага /цаашид "тагнуулын байгууллага" гэх/-ын тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, тагнуулын алба хаах журам, тагнуулын ажилтны эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын тухай хууль тогтоомж

2.1.Тагнуулын байгууллагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Гүйцэтгэх ажлын тухай хууль[2], Монгол Улсын аюулгүй байдлыг хангах тухай хууль[3], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

[1] Монгол Улсын Үндсэн хууль -"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

[2] Гүйцэтгэх ажлын тухай хууль- "Ардын эрх" сонины 1998 оны № 28, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1998 оны № 3 дугаарт тус тус нийтлэгдсэн.

[3] Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах тухай хууль- "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны № 3 дугаарт нийтлэгдсэн.

Уншигчдын анхаарал

<<Тагнуулын байгууллагын тухай >> хуулийн 14.1, 15.2, 12.1. 12, 17.2 дугаар заалтуудад Монгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хориг тавьсан тул хуулийн эдгээр заалтыг уг хоригуудыг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."гадаад татнуулын ажил" гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, төрийн болон оловоруулах, хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий татнуулын мэдээ, баримт сэлт олох ажиллагаа;

3.1.2."сөрөх татнуулын ажил" гэж Монгол Улсын эсрэг гадаад улсын тусгай алба, байгууллага, иргэдээс явуулж буй татнах, хорлон сүйтгэх ажиллагаа болон Татнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаа;

3.1.3."тусгай алба" гэж татнуулын ажил эрхэлдэг байгууллага, түүний салбар, нэгжийг;

3.1.4."татнуулын арга" гэж үүрэг зорилтоо хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий нууц болон бусад мэдээ, баримт, сэлтийг олох зорилгоор тусгай албаны ашиглаж буй арга хэмжээний цогцыг;

3.1.5."татнуулын мэдээ" гэж тусгай алба үндсэн үүрэг зорилтынхоо дагуу нууц арга, хэрэгслээ ашиглан олж буй мэдээ, баримт сэлтийг;

3.1.6."нууц арга, хэрэгсэл" гэж мэдээ, баримт сэлт нууцаар олоход зориулагдсан арга хэрэгслийг;

3.1.7."халхавчлах" гэж татнуулын ажлын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг өөр байгуулага, хүн, өөр үйл ажиллагаа, баримт бичиг болон бусад зүйл ашиглан далдлахыг;

3.1.8."нууц гүйцэтгэх ажилтан" гэж өөр байгууллагад халхавчийн дор ажиллаж байгаа тусгай албаны ажилтныг;

3.1.9."туслагч" гэж гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгуулагатай нууцаар хамтран ажиллаж байгаа хүнийг;

3.1.10."туслах ажилтан" гэж гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгуулагатай тодорхой гэрээ, урамшууллын үндэсэн дээр нууцаар хамтран ажиллаж байгаа хүнийг.

4 дүгээр зүйл.Татнуулын байгуулага

4.1.Татнуулын байгуулага гэж Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг татнуулын арга замаар хангах зорилго бүхий байгуулагуудын тогтолцоог хэлнэ.

5 дугаар зүйл.Татнуулын байгуулагын үйл ажиллагааны үндэсэн зарчим

5.1.Хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, нууцлалыг хангах, үйл ажиллагааны ил болон далд арга, хэрэгслийг хослуулах, байгуулага, иргэдийн туслалцаа дэмжлэгт тулгуурлах нь татнуулын байгуулагын үйл ажиллагааны үндэсэн зарчим мөн.

6 дугаар зүйл.Татнуулын байгуулагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах

6.1.Татнуулын байгуулага нь хуульд зааснаас бусад тохиолдолд хүний эрх, эрх чөлөөнд халдах, хязгаарлахыг хориглоно.

6.2.Татнуулын байгуулагын албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэх явцад иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хууль бусаар зөрчсөн бол татнуулын байгуулагад өөрөө, эсхүл прокурор, шүүх нь тухайн иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, эрх чөлөөг сэргээж, учруулсан хохирлыг арилгах, гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үүрэгтэй.

6.3.Татнуулын үйл ажиллагааны явцад тодорхой болсон иргэний нэр төр, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болох хувийн амьдралтай нь холбоотой мэдээ, мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гагцхүү уг хүний зөвшөөрснөөр ил болгож болно.

7 дугаар зүйл.Татнуулын байгуулагын төсөв

7.1.Татнуулын байгуулагыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана. Татнуулын байгуулагын төсөв нь үүрэг, зорилтоо бүрэн хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

7.2.Татнуулын байгуулагын гүйцэтгэх ажлын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж санал болгосноор Улсын Их Хурал тусгай зүйл болгон батална.

8 дугаар зүйл.Татнуулын байгуулагад туслалцаа үзүүлэх

8.1.Татнуулын байгуулага, түүний ажилтнаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгуулага, аж ахуйн нэгж, иргэн Улсын аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7, 8, 9 дүгээр зүйлд заасан шаардлагатай туслалцаа үзүүлэх үүргэтэй. Ийнхүү туслалцаа үзүүлснээс гарсан зардал, учирсан эд хөрөнгийн хохирлыг татнуулын байгуулагаа хариуцаж нөхөн төлнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тагнуулын байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, эрх хэмжээ

9 дүгээр зүйл.Тагнуулын байгууллагын тогтолцоо

9.1.Монгол Улсын тагнуулын байгуул-лагын тогтолцоо нь Тагнуулын ерөнхий газар, цэргийн тагнуулын байгууллага, тэдгээрийн салбар, нэгжээс бүрдэнэ.

10 дугаар зүйл.Тагнуулын ерөнхий газар, түүний чиг үүрэг

10.1.Тагнуулын ерөнхий газар нь тагнуулын байгууллагуудын үйл ажиллагаанд уялдуулан зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулж хэрэгжүүлэх зорилго бүхий төрийн захиргааны төв байгууллага мөн.

10.2.Тагнуулын ерөнхий газрыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэж, дүрмийг нь Засгийн газар батална.

10.3.Тагнуулын ерөнхий газрын харьяа тагнуулын салбар, нэгжийг Засгийн газрын шийдвэрээр нутаг дэвсгэрийн болон чиг үүргийн зарчмаар байгуулна.

10.4.Тагнуулын ерөнхий газрын харьяанд сургууль, сургалт, эрдэм шинжилгээ, аж ахуй, хангалт үйлчилгээний байгууллага, харуул хамгаалалтын болон тусгай бэлтгэл, зориулалт бүхий нэгж байгуулж болно.

10.5.Тагнуулын ерөнхий газар бэлгэ тэмдэгтэй байна. Бэлгэ тэмдгийн загвар, хэрэглээх журмыг Тагнуулын ерөнхий газрын дарга батална.

10.6.Тагнуулын ерөнхий газар тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.7.Тагнуулын ерөнхий газар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.7.1.гадаад тагнуулын ажиллагаа явуулах;

10.7.2.сөрөх тагнуулын ажиллагаа явуулах;

10.7.3.хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх;

10.7.4.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлаар мэдээлэл боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах;

10.7.5.хуульд заасан бусад чиг үүрэг.

11 дүгээр зүйл.Тагнуулын ерөнхий газрын үүрэг

11.1.Тагнуулын ерөнхий газар дараахь үүрэг гүйцэтгэнэ:

11.1.1.Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн асуудлаар тагнуулын мэдээ олох, цуглуулах, задлан шинжилгээ хийж, дүгнэлт гарган энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

11.1.2.гадаад улсын тусгай алба, байгууллага, иргэн, тэдгээрийн төлөөний этгээдийн тагнан турших, хорлон сүйтгэх ажиллагаат илрүүлэх, таслан зогсоох;

11.1.3.улсын эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болзошгүй ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох;

11.1.4.Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулан гэмт хэргийг илрүүлэх, хэрэг бүрттэлт, мөрдөн байцаалт явуулах болон уул гэмт хэрэг үйлдсэн буюу сэжигтэгдэж буй этгээдийг эрэн сурвалжлах;

11.1.5.Монгол Улсын хил, Зэвсэгт хүчин, бусад цэргийн аюулгүй байдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах;

11.1.6.төрийн мэдээлэл, холбоо харилцааны аюулгүй байдлыг хангах;

11.1.7.хилийн чанадад байгаа Монгол Улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг гадаадын тусгай албаны ажиллагаанд өртөхөөс сэргийлэх;

11.1.8.улсын эдийн засагт онцгой ач холбогдол бүхий объектод ноцтой осол сүйрэл гарахаас сэргийлэх, хүн, мал үргамлын гоц халдварт өвчин болон томоохон осол, сүйрлийн шалтгааныг тогтоох ажлыг холбогдох эрх бүхий байгууллагатай хамтран хийх;

11.1.9.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн тусламжаа үзүүлж, хамтран ажиллах;

11.1.10.хуульд заасан бусад үүрэг.

12 дугаар зүйл.Тагнуулын ерөнхий газрын эрх

12.1.Тагнуулын ерөнхий газар дараахь эрх эдэлнэ:

12.1.1.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд нууцаар ажиглах, үзлэг хийх, шуудан харилцаа хянах, харилцаа холбооны болон мэдээллийн бусад сүлжээнд нэвтрэх, гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл ашиглах;

12.1.2.хуульд заасан үүргээ биелүүлэхэд шаардлагатай мэдээ, баримт сэлтийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс гаргуулан авах;

12.1.3.гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл олж авах, улсын хилээр нэвтрүүлэх, ашиглах зөвшөөрөл олгох. Хуулиар эрх олгоогүй байгууллага, албан тушаалтан, иргэний хувийн зорилгоор хэрэглэсэн гүйцэтгэх ажлын техник хэрэгслийг тэмдэглэл үйлдэн хураан авч, улсын орлого болгох;

12.1.4.хуульд заасан үндэслэл, журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгж, иргэний орон байранд нэвтрэх, албан тушаалтан, иргэдээс тайлбар авах, биеийн байцаалтыг нь шалгах, бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд нь үзлэг хийх, Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчилд холбогдох бүхий баримт сэлт, эд зүйлийг уул асуудлыг шийдэгдэх хүртэл түр хураах;

12.1.5.Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулсан гэмт хэргийн сэжиг бүхий эттэздийг түр албадан саатуулах, шалгах;

12.1.6.халхавчийн байгууллага, аж ахуйн нэгж байгуулан ажиллуулах;

12.1.7.тагнуулын байгууллагын объект, эсхүл тодорхой үйл ажиллагааг нууцлахын тулд өөр байгууллагын хаяг, баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг халхавч болгон ашиглах;

12.1.8.судалгаа, шинжилгээ хийх, энэ ажилд мэргэжлийн байгууллага, хүний туслалцаа авах, татан оролцуулах;

12.1.9.хүн ам, экологийн аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй хордуулах, мансууруулах бодис болон галт зэвсгийг улсын хилээр нэвтрүүлэх, хадгалж хамгаалах, ашиглах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

12.1.10.байгуулага, ажилтныхаа аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

12.1.11.эрх тэгш байх, харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох зарчмын үндсэн дээр гадаад улсын тусгай алба, байгууллагатай хамтран ажиллах;

12.1.12.өмчийн хэлбэрээр ялгаварлахгүйгээр байгуулага, аж ахуйн нэгжийн захиалгаар аюулгүй байдлаа хангах, бизнесийн нууцаа хамгаалахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

(Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)

12.1.13.тагнуулын байгууллагын чиг үүрэгт холбогдох асуудлаар мэдээ, мэдээлэл хуваалдан авах;

12.1.14.үндэсний аюулгүй байдлыг хангах талаарх хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдох зааврыг эрх хэмжээнийхээ хүрээнд хууль нийцүүлэн батлах;

12.1.15.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгуулага, аж ахуйн нэгжид заавал биелүүлэх шаардлага, иргэнд сэрэмжлүүлэг өгөх;

12.1.16.хуульд заасан бусад эрх.

13 дугаар зүйл.Цэргийн тагнуулын байгууллага

13.1.Цэргийн тагнуулын байгууллага нь Монгол Улсын Зэвсэгт хүчний дээд удирдлагыг цэрэг-улс төрийн болон цэрэг-стратегийн тагнуулын мэдээллээр хангах үндэсн чиг үүрэг бүхий цэргийн байгуулага мөн.

13.2.Цэргийн тагнуулын байгуулагыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөөний үндэсн дээр Засгийн газар байгуулж, өөрчилж, татан буулгана.

13.3.Цэргийн тагнуулын байгуулагын дүрмийг Зэвсэгт хүчний ерөнхий штабын дарга болон Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар батална.

13.4.Цэргийн тагнуулын байгуулага үйл ажиллагаагаа явуулахад энэ хуулийн холбогдох заалтыг дагаж мөрдөнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тагнуулын ерөнхий газрын удирдлага, түүний бүрэн эрх

14 дүгээр зүйл.Тагнуулын ерөнхий газрын удирдлага

14.1.Тагнуулын ерөнхий газрын даргыг Засгийн газар томилж, чөлөөлнө. ***(Энэ заалтадМонгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хориг тавсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)***

14.2.Тагнуулын ерөнхий газрыг түүний дарга нэгдмэл захирамжийн зарчмаар удирдах бөгөөд даргын дэргэд зөвлөх эрх бүхий зөвлөл ажиллана.

15 дугаар зүйл.Тагнуулын ерөнхий газрын даргын бүрэн эрх

15.1.Тагнуулын ерөнхий газрын дарга Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлэх:

15.1.1.төв байгуулагыг шуурхай, орон нуттийн салбар, нэгжүүдийг нэгдсэн удирдлагаар хангах;

15.1.2.батална төсөөт багтаан байгуулагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалингийн сан, ажилтны цалингийн сүлжээ, хэмжээг тогтоож, төсвийг захиран зарцуулах;

15.1.3.тагнуулын болон гүйцэтгэх ажилд дагаж мөрдөх заавryг хуульд нийцүүлэн гаргах, биелэлтэд нь хяналт тавих ажлыг зохион байгуулах;

15.1.4.Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу нууц арга хүч, хэрэгсэл ашиглах эрхтэй албан тушаалтныг томилох, чөлөөлөх, сэлгэн ажилуулах, шилдэг гаргах;

15.1.5.гүйцэтгэх ажлын техник хэрэгсэл олж авах, үзэмших, ашиглах, захиран зарцуулах, шийдвэр гаргах;

15.1.6.үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар Монгол Улсын Ерөнхий-

лөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг мэдээллээр хангах, энэ талаар зохих санал тавих;

15.1.7.Тагнуулын ерөнхий газар, түүний ажилтны үйл ажиллагаанд хяналт тавьж, тэдгээрийн хэвийн аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах;

15.1.8.Тагнуулын ерөнхий газрыг төлөөлж дотоод, гадаадын байгууллагатай харилцах;

15.1.9.тагнуулын албан хаагчийг томилох, чөлөөлөх, түүнд цэргийн цол олгох;

15.1.10.халхавчийн байгууллага байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж чиглүүлэх;

15.1.11.төрийн байгууллагад байх халхавчийн орон тооны талаар Засгийн газарт санал оруулах;

15.1.12.Тагнуулын ерөнхий газрын дотоод асуудлаар тушаал, заавар гаргах;

15.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.

15.2.Тагнуулын ерөнхий газрын даргын түр эзгүйд түүний бүрэн эрхийг дэд дарга хэрэгжүүлнэ.

(Энэ заалтаар Монгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)

16 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт

16.1.Улсын Их Хурал бүтцийнхээ зохих хэсгээр дамжуулан тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийг хэрхэн сахин биелүүлж байгааг хянан шалгаж, тагнуулын байгууллагын даргын илтгэл, мэдээллийг сонсоно.

16.2.Монгол Улсын Ерөнхийлөгч-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь шаардагатай гэж үзвэл тагнуулын байгууллагын даргын илтгэл, мэдээллийг сонсож, тэдгээртэй холбоотой үйл ажиллагаатай танилцаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааныаар хэлэлцэн тогтсоны үндэсн дээр үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар даалгавар өгнө.

16.3.Монгол Улсын Ерөнхий сайд Тагнуулын ерөнхий газрын даргын мэдээллийг сонсож, түс байгууллагаас үндэсний аюулгүй байдлыг хангах талаар тухайн төсвийн жилд анхаарч ажиллах чиглэлийг тогтоож, төрийн болон бүлоо-руулахад ач холбогдол бүхий мэдээ, баримт сэлт олох, хуулиар харьяалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх талаар даалгавар өгнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тагнуулын байгууллагын албан хаагчийн эрх зүйн байдал

17 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын албан хаагч

17.1.Энэ хуульд заасан тангараг өргөж, тагнан турших болон түүнтэй адилтгах ажил эрхэлж буй төрийн тусгай албан хаагчийг тагнуулын ажилтан гэнэ.

17.2.Тагнуулын ажилтанд тавих ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг тагнуулын байгууллагын дарга тогтооно. *(Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 1999 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)*

17.3.Тагнуулын ажилтан цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэнэ.

17.4.Тагнуулын байгууллагын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно.

17.5.Тагнан турших болон түүнтэй адилтгах ажил эрхэлсэн хугацаанд цэргийн жинхэнэ албатасан хугацаанд тооцно. Иймхүү тооцох болзол, журмыг Засгийн газар тогтооно.

17.6.Тагнан турших ажилтай адилтгах ажил, албан тушаалын жагсаалтыг Тагнуулын ерөнхий газрын даргын санал болгосноор Засгийн газар тогтооно.

17.7.Тагнуулын байгууллагын захиргаа, үйлчилгээний ажилтны эрх зүйн байдлыг Төрийн албаны тухай хууль[1] болон Хөдөлмөрийн хууль[2], хууль тогтоомжийн бусад актаар зохицуулна.

18 дугаар зүйл.Тагнуулын ажилтны тангараг

18.1.Монгол Улсын иргэн тагнуулын албанд ороходоо:

"Монгол Улсын иргэн Би улсынхаа тусгаар тогтнол, аюулгүй байдлын төлөө амь бие хайргүй зүтгэж, төрийн хуулийг дээдлэн сахиж, төрийн болон албаны нууцыг чандлан хамгаалж, тагнуулын ажилтны үүрэг, ёс зүйн хэм хэмжээг чин шударгаар сахин биелүүлэхээ батлан тангараглая.

Би энэ тангаргаасаа няцвааc төрийн хуулийн цэрэлэл хүлээнэ" хэмээн тагнуулын ажилтны тангараг өргөнө.

18.2.Тагнуулын ажилтны тангараг өргөх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

19 дүгээр зүйл.Тагнуулын ажилтанд тавих ёс зүйн тусгай шаардлага

19.1.Тагнуулын байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрийг бусад албан хаагч биелүүлэх үүрэгтэй. Удирдах албан тушаалтны шийдвэр хууль тогтоомж болон энэ хуулийн 19.2-т нийцсэн байна.

19.2.Тагнуулын ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Авилгалын эсрэг хууль[3] заасчаас гадна дараахь зүйлийг хоригломо:

[1] Төрийн албаны тухай хууль -"Ардын эрх" сонины 1995 оны № 15-д, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны № 3 дугаарт тус тус нийтлэгдсэн

[2] Хөдөлмөрийн хууль- "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1999 оны № 25 дугаарт нийтлэгдсэн.

[3] Авилгалын эсрэг хууль- "Ардын эрх" сонины 1996.5.12-ны өдрийн № 92 дугаарт, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1996 оны № 6 дугаарт тус тус нийтлэгдсэн.

19.2.1.хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах, эрхийг нь хязгаарлах;

19.2.2.албан тушаал, байгууллагын нэрээр бусдыг эрхшээлдээ оруулахыг эрмэлзэх, далайган сүрдүүлэх;

19.2.3.албан тушаалаа болон захирагдагчаа хувийн зорилгоор ашиглах;

19.2.4.удирдлагын тусгайлан өгсөн эвтэйхэн зөвшөөрөлгүйгээр албан ажлыхаа талаар ниййтэд болон бусдад мэдээлэх, мэдээлэл дамжуулах;

19.2.5.хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хавсран гүйцэтгэж цалин хөлс авах;

19.2.6.ажил хаях, тагнуулын байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн бусад арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, тэдгээрт оролцох;

19.2.7.ажиллаж байх хугацаандаа болон ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа 2 жилийн хугацаанд тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтны эвтэйхэн зөвшөөрөлгүй гадаадад зорчих;

19.2.8.төрийн албан хаагчид хуулиар хориглосон бусад үйлийг.

20 дугаар зүйл.Тагнуулын ажилтанд хүлээлгэх хариуцлага

20.1.Тагнуулын ажилтан нь хууль болон ёс зүйн шаардлагыг зөрчсөн бол энэ хууль, бусад хуульд заасан хариуцлага хүлээнэ.

21 дүгээр зүйл.Тагнуулын ажилтанд хүлээлгэх сахилгын шийтгэл

21.1.Сахилгын зөрчил гаргасан тагнуулын ажилтанд дор дурдсан сахилгын шийтгэл оногдуулна:

21.1.1.сануулах;

21.1.2.албан тушаалын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар, 20 хүртэл хувиар бууруулах;

21.1.3.цэргийн цолыг бууруулах буюу хасах;

21.1.4.албан тушаал бууруулах;

21.1.5.тагнуулын албанаас халах.

21.2.Тагнуулын ажилтны сахилгын дүрмийг Засгийн газар батална.

22 дугаар зүйл.Тагнуулын ажилтны цалин

22.1.Тагнуулын ажилтны цалин нь Төрийн албаны тухай хуулийн 28.2.3-т заасан цалин, нэмэгдлээс бүрдэнэ.

22.2.Тагнуулын ажилтны албан тушаалын цалин дээр нэмж олгох албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг Засгийн газар тогтооно.

23 дугаар зүйл.Тагнуулын ажилтны амралт

23.1.Тагнуулын ажилтанд жил бүр ажлын 15 өдрийн амралт олгоно.

23.2.Тагнуулын ажилтанд төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

24 дүгээр зүйл.Тагнуулын ажилтны үүргээ биелүүлэх баталгаа

24.1.Тагнуулын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүргэгт нь үл хамаарах жил гүйцэтгүүлэхийг хориглоно.

24.2.Тагнуулын ажилтны эрх хэмжээнийхээ хүрээнд тавьсан хууль ёсны шаардлагыг иргэн, албан тушаалтан харьяалал харгалзахгүйгээр биелүүлэх үүрэгтэй.

24.3.Тагнуулын ажилтныг албан үүргээ гүйцэтгэж байх үед нь тагнуулын байгууллагын даргын эвтэйхэн зөвшөөрөлгүйгээр баривчлах, түр албадан саатуулах, бие, эд зүйл, тээврийн хэрэгсэлд нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

24.4.Үүргээ ёсчлон биелүүлснээс тагнуулын ажилтанд учирсан, мөн гүйцэтгэх ажлын арга хэмжээ зохиох, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тагнуулын ажилтны бууруулах үйл ажиллагаанаас бусдад учирсан хохирлыг төр хариуцна. 24.5.Эрх бүхий албан тушаалтны өгсөн тушаал, даалгаврыг тагнуулын ажилтан ёсчлон биелүүлснээс үүссэн хохирол, сөрөг үр дагаврыг тушаал, даалгавар өгсөн албан тушаалтан хариуцна.

24.6.Хуулиар эрх олгогдоогүй байгууллага, албан тушаалтан тагнуулын ажилтны албаны үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

24.7.Тагнуулын ажилтан нь хуульд заасан бусад баталгаагаар хангагдана.

25 дугаар зүйл.Тагнуулын ажилтанд үзүүлэх хөнгөлөлт, нөхөх төлбөр

25.1.Улсын хил дээр ажиллаж байгаа тагнуулын ажилтанд Хилийн тухай хуулийн[1] 36.4, 36.6-д заасан нь нэгэн адил хамаарна.

25.2.Албан үүргээ гүйцэтгэж яваад идэвхгүйсэн буюу хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар тагнуулын байгууллагад цаашид ажиллах боломжгүй болсон тагнуулын ажилтныг өөр ажлаар хангах буюу эсхүл мэргэжил зээмших, шинээр оршин суух газартаа төвхнөхөд тагнуулын байгууллага туслалцаа үзүүлж холбогдох зардлыг төр хариуцна.

25.3.Өндөржүүлсэн бэлэн байдал, шөнийн ээлжинд ажиллахад хоолны зардлыг, сургалт даддлагын үед хүнсний болон эдийн засгийн хангалттыг тагнуулын байгууллага хариуцна.

25.4.Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон тохиолдолд гарсан зардлыг тагнуулын байгууллага хариуцна.

25.5.Байгууллагынхаа шийдвэрээр өөр газарт шилжин ажиллах болсноос түүний эхнэр /нөхөр/ нь эрхэлж буй ажил, хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнд тагнуулын ажилтны нэг сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тагнуулын байгууллага олгоно.

---

[1] Хилийн тухай хууль- "Ардын эрх" сонины 1993 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн № 178, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 4-5-д тус тус нийтлэгдсэн.

25.6.Ээлжийн амралтаараа хөдөө орон нутагявах бол түүний болон эхнэр /нөхөр/-нийн нэрэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.

25.7.Тагнуулын байгууллагын албан хаагч нь хуульд заасан бусад хөнгөлөлт, нөхөн төлбөр эдэлнэ.

26 дугаар зүйл.Тагнуулын ажилтны тэтгэвэр, тэтгэмж, тусламж

26.1.Тагнуулын ажилтны тэтгэвэр, тэтгэмжийн харилцаанд цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

26.2.Албадын түгээн алба, байгууллага болон гэмт хэрэг үйлдэхэзэр зохион байгуулагдсан бүлэгт нэвтрэн тусгай үүрэг гүйцэтгэж байгаа тагнуулын ажилтанд тэтгэмж олгох жүрмыг Засгийн газар тогтооно.

26.3.Тагнуулын ажилтан нь хууль тогтоомжид заасан бусад тусламж авах эрхтэй.

27 дугаар зүйл.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх

27.1.Тагнуулын байгууллага, ажилтан нь энэ хуульд заасан тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэнэ.

27.2.Галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх жүрмыг хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Тагнуулын ерөнхий газрын дарга батална.

27.3.Тагнуулын ажилтан нь гэмт үйлдэл, эрх зүйн бусад зөрчлийг таслан зогсоох, түүнийг өдүүлсэн этгээдийг барьцаалан албадан саатуулах үүргээ өөр аргаар биелүүлэх боломжгүй бол биеийн хүч, гардан тулааны мэх хэрэглэж болно.

27.4.Тагнуулын байгууллага, ажилтан нь хуулиар харьцаалуулсан гэмт хэрэгтэй тэмцэх, хамгаалалтын үүргээ биелүүлэхэд дор дурдсан тусгай хэрэгсэл ашиглана:

27.4.1.нэг бүрийн тусгай хэрэгсэл;

27.4.2.тэсвэрийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;

27.4.3.хамгаалах тусгай хэрэгсэл.

27.5.Тагнуулын ажилтан нь гэмт үйлдлийг өөр арга хэрэгслээр таслан зогсоох боломжгүй бол дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

27.5.1.бусад этгээд өөрийн нь буюу тусламч, туслах ажилтны амь нас, эрүүл мэндэд нөлөөлөх хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;

27.5.2.тагнуулын байгууллагын тусгай хамгаалалттай объектод нэвтрэх зорилгоор зэвсэг хэрэглэж буюу бүдэглэн халдсан;

27.5.3.тагнуулын байгууллагад хуулиар харьцаалуулсан хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэжиглэгдэн этгээд зугатсан.

27.6.Бололцоотой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

27.7.Галт зэвсэг хэрэглэснээс хүний амь үрэгдсэн, эрүүл мэндэд нь хохирол учирсан бол зэвсэг хэрэглэсэн тагнуулын ажилтан эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, захирах даргадаа, дарга нь прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

27.8.Тагнуулын байгууллагад хэрэглэх галт зэвсэг, хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалтыг Тагнуулын ерөнхий газрын дарга батална.

28 дугаар зүйл.Тагнуулын ажилтан албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох

28.1.Тагнуулын ажилтан албан үүргээ биечлэн гүйцэтгэж байгаагаас гадна ажилдаа ирэх, ажлаас харих замд явсныг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

29 дүгээр зүйл.Хариуцлага

29.1.Тагнуулын байгууллагын тухай хууль зөрчсөн этгээдэд хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуульд дор дурдсан агуулгатай 30^6 дугаар зүйл нэмсүгэй:

"30^6 дугаар зүйл.Тагнуулын ажилтны хууль ёсны шаардлагыг биелүүлэх, заналхийлэх

Тагнуулын ажилтны хууль ёсны шаардлагыг зориуд үл биелүүлсэн, биелүүлэхгүй байхыг уриалсан, зэрэгүүцсэн, албан үүргээ биелүүлэхэд нь санаатайгаар саад учруулсан, албан үүргэтэй нь холбогдуулан тагнуулын ажилтныг дорломжилсон, гүтгэсэн, заналхийлсэн, хүч хэрэглэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 5000-20000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна".

2 дугаар зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "30^{4n} гэсний дараа "30^{6n} гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 125 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/121 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт:

2/"Тагнуулын ерөнхий газар Эрүүгийн хуулийн 60-65, 67, 68, 70-74, 79-84, 146[2], 153-157, 172[1], 249, 253-255 дугаар зүйлд заасан гэмт хэргийн талаар.

Өөрсдөө илрүүлсэн-Эрүүгийн хуулийн 192, 195-197 дугаар зүйлд заасан гэмт хэргийн талаар.

Тагнуулын ажилтны үйлдсэн Эрүүгийн хуулийн 292, 293 дугаар зүйлд заасан гэмт хэргийн талаар".

2/"125 дугаар зүйл.Мөрдөн байцаалт явуулах байгууллага Эрүүгийн хуулийн 60-65, 67, 70-74, 79-84, 146[2], 153-157 дугаар зүйлд заасан гэмт хэрэг болон тагнуулын ажилтны үйлдсэн Эрүүгийн хуулийн 292, 293 дугаар зүйлд заасан гэмт хэргээс Тагнуулын ерөнхий газрын мөрдөн байцаагч, бусад зүйлд заасан гэмт хэрэгт мөрдөн байцаах байгууллагын мөрдөн байцаагч мөрдөн байцаалт явуулна".

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Аюулгүй байдлыг ханган тухай хуулийн 5 дугаар зүйл, гуравдэрэв, тавдугаар бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "Улсын аюулгүй байдлыг хангах байгууллага" гэсний дараа, мөн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "тагнуул" гэсний өмнө, 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "мэдээ олох" гэсний дараа "гадаад" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.1."Гадаад тагнуулын ажил", "сөрөх тагнуулын ажил", "тусгай алба", "нууц арга, хэрэгсэл", "халхавчлах", "нууц гүйцэтгэх ажилтан", "туслагч", "туслах ажилтан" гэсэн нэр томъёог Тагнуулын байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно".

3 дугаар зүйл.Энэ хуулийг Тагнуулын байгууллагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны долдугаар сарын 31 №36 (115)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоол

340. Р. Амаржаргалыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх, Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай Дугаар 55 691

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

341. Хөгжлийн албан ёсны зээл, тусламжийг зохицуулах журмыг батлах тухай Дугаар 93 691

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 30-ны өдөр Дугаар 55 Улаанбаатар хот

Р. Амаржаргалыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх, Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 15 дугаар зүйл, санал хураалтуудын дүнг үндэслэн Монгол Улсын Их хурлаас ТОГТООХ нь:

1.Ринчиннямын Амаржаргалыг Монгол Улсын Их хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Ринчиннямын Амаржаргалыг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилсугай.

3.Энэ тогтоолыг 1999 оны 7 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 93 Улаанбаатар хот

Хөгжлийн албан ёсны зээл, тусламжийг зохицуулах журмыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Гадаад орон, олон улсын байгуулагаас Монгол Улсын Засгийн газрын шугамаар авах хөгжлийн албан ёсны зээл, тусламжийг зохицуулах журам"-ыг хавсралтын ёсоор батлсугай.

2.Энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг холбогдох сайд, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын удирдлагад үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 247 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Сангийн сайд Я.ОЧИРСУХ

Гадаад харилцааны сайд Н.ТУЯА

Засгийн газрын 1999 оны 93 дугаар тогтоолын хавсралт

ГАДААД ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВАХ ХӨГЖЛИЙН АЛБАН ЁСНЫ ЗӨВЛӨЛ, ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

1.Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаад орон, олон улсын байгууллагаас Хөгжлийн албан ёсны зээл, тусламж (цаашид зээл, тусламж гэх)-ийг авах, тэдгээрийн ашиглалтыг зохион байгуулах, хяналт тавих, хариуцлага тооцох, зээл, тусламжийг хүлээн авч хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын ажлыг уялдуулан зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Зээл, тусламжийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын үүрэг

2.Гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг зохицуулах зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх)-ийн үүрэг:

а/зээл, тусламжийн шугамаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, дараалал, бусад бодлогын асуудлаар Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт нийцүүлэн санал, зөвлөмж гаргаж Засгийн газарт оруулах;

б/зээл, тусламжтай холбогдсон асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал гаргаж, Засгийн газарт оруулах;

в/зээл, тусламжийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хүрсэн үр дүнгийн талаар холбогдох байгууллагуудын тайлан, мэдээллийг хэлэлцэж дүгнэлт гаргах.

3.Гадаад харилцааны яамны үүрэг:

а/Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гадаад орон, олон улсын байгууллагад зээл, тусламж авах хүсэлтийг албан ёсоор тавих, нот солилцох, ерөнхий хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах;

б/хандивлагчдын эгнээг өргөжүүлэхэд чиглэсэн хэлэлцээг явуулж холбогдох гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг хариуцах;

в/хоёр болон олон талын шугамаар тухайн жилд авах зээл, тусламжийг тодорхой хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд ашиглах асуудлыг салбарын яамдын саналыг үндэслэн Монгол Улсын үндэсний ашуулгүй байдал, эдийн засгийн гадаад бодлогын үзэл баримтлал, тусламжийн чиглэлд нийцэж бүй эсэх талаар албан ёсны дүгнэлт гаргаж Зөвлөлөөр хэлэлцүүлэн, Засгийн газарт оруулах;

г/хоёр болон олон талын шугамаар авах тусламжийн зохицуулалт, хэрэгжилтэд хяналт тавих.

4.Сангийн яамны үүрэг:

а/эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсэн чиглэл, зорилттой уялдуулан зээл, тусламжийн хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг салбарын яамдын саналыг үндэслэн тодорхойлж Зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газарт оруулах;

б/салбарын яамдын саналыг үндэслэн тухайн жилд шаардагдах зээл, тусламжийн хэрэгцээг гаргаж Зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газарт оруулах;

в/зээлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь зээлийн чиглэлд тохирч буй эсэхийг хянаж, тэдгээрийн боловсруулалтад санхүү, эдийн засгийн дүн шинжилгээ хийх;

г/хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд шаардагдах дотоодын хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээг улсын төсвийн зарцуулалттай уялдуулан тодорхойлж, жил бүрийн төсвийн төсөлд тусгах;

д/зээл ашиглагч байгууллагын төлбөрийн чадвар, төлбөр хийх эх үүсвэр болон улсын гадаад валютын нөөц, төсвийн орлогын бүрдэлт, санхүүжилтийн хөрөнгийн дотоод эх үүсвэртэй уялдуулан гадаад орон, олон улсын байгууллагын хөрөнгийн баталгаа гаргах;

е/Засгийн газрын шийдвэрийг үндэслэн зээлийн хэлэлцээрийг байгуулах, тусламжийн гэрээ, хэлэлцээнд оролцох.Тодорхой хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж буй байгууллага тус бүртэй улсын төсөвт эргэж

төлөгдөх нөхцөлтэйгээр дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулах;

ж/дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу зээл ашиглагч байгууллагаас орох орлогоор тусгай сан байгуулж, төлбөр тооцоог зохицуулах;

з/зээлийн ашиглалт болон өрийн үйлчилгээний байдалд хяналт тавьж, төсөв, төлбөрийн төнцэлд тухай бүр тусгах;

и/зээлийн өрийн үйлчилгээ, төлбөрийн хуваарийг хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрээр улсын эдийн засаг, төсөвт учруулах дарамт нөлөөллийг тооцож гаргах;

к/зээлийн гадаад, дотоод төлбөр тооцоонд хяналт тавьж, түүнийг улсын валютын нөөц, мөнгөний бодлоготой уялдуулах;

л/санхүүгийн болон барааны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдэх бараг бүсад холбогдох яамны саналыг үндэслэн сонгох, хүлээн авагч байгууллагыг сонгон шалгаруулах, борлуулалтын орлого төвлөрүүлэх үйл ажиллагааг хянах.

5.Салбарын яамд, тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын үүрэг:

а/тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг (цаашид "агентлаг" гэх) нь зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санал хүсэлтээ салбарын яаманд хүргүүлэх;

б/салбарын яам нь жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор зээлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг салбарын хөгжлийн дунд болон урт хугацааны зорилт, бодлоготой уялдуулан сонгон шалгаруулж Сангийн яаманд, тусламжаар хэрэгжүүлэхийг Сангийн болон Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлэх;

в/Засгийн газрын нэрийн өмнөөс зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээр байгуулагч нь тухайн гэрээ, хэлэлцээр болон бусад шаардлагатай баримт бичгийн баталгаат хуулбарыг тэдгээрт гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор Сангийн яам, Гадаад харилцааны яам, Улсын гаалийн ерөнхий газарт тус тус хүргүүлэх бөгөөд гэрээ хэлэлцээрт тусгайлан заасан бол тусламж олгогч талд холбогдох мэдээ, тайлан гаргаж өгөх ажлыг зохион байгуулах;

г/яам, агентлаг өөрийн хариуцсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар тендерийн баримт бичиг бэлтгэх, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэх зэрэг ажлыг хариуцах;

д/зээл, тусламжийг ашиглагч байгууллага нь зээл, тусламжийн хөрөнгийг гэрээний дагуу, зориулалтаар нь үр өгөөжтэй, хугацаанд ашиглаж байгаа эсэхэд хяналт тавих;

е/зээл, тусламжийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, удирдлага, зохион байгуулалт, техник-технологи, байгаль орчны зохих нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавих;

ж/агентлаг нь зээл, тусламжийн хөрөнгөөр нийлүүлэгдэж буй эд хөрөнгө (автомашин, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, технологийн дамжлага, материал гэх мэт)-ийг Сангийн сайдын 1995 оны 40 тоот тушаалын хавсралтаар батлагдсан журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тухай бүр тусгах;

з/Сангийн яам, Гадаад харилцааны яам, банкийг зээл, тусламжийн ашиглалт, зарцуулалт, түүнчлэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шалгах нөхцөлөөр хангаж шаардагдах материалыг гаргаж өгөх.

и/агентлаг нь Засгийн газрын шугамаар нийлүүлэгдэж буй тусламжийн барааг хүлээн авч борлуулах, борлуулалтын орлогыг төсвийн болон тусгай дансуудад төвлөрүүлэх. үүрэг хүлээх

к/гэрээ, хэлэлцээр болон санхүүгийн холбогдолтой баримтыг 10 жилээс доошгүй хугацаагаар хадгалах;

л/зээл, тусламжийн шугамаар нийлүүлсэн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалыг хүлээн авч борлуулах үүрэг хүлээсэн аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн улирлын мэдээ, тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор салбарын яаманд хүргүүлэх. Салбарын яам нь мэдээг нэгтгэн батлагдсан маягтын дагуу хагас, бүтэн жилээр гаргаж, зээлийн тайланг 1 ба 7 дугаар сарын 31-ний дотор Сангийн яаманд, тусламжийн мэдээг Гадаад харилцааны яаманд хүргүүлж байх.

Хоёр.Гадаадын зээл, тусламжийг хүлээн авч хэрэгжүүлэх хариуцлагын тогтолцоо

6.Зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах хариуцлагыг зээл ашиглагч байгууллага хүлээнэ.

7.Энэхүү журмын 5 дугаар заалтын "л"-д заасан зээл, тусламжийн ашиглалтын нэгдсэн мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь өгөх хариуцлагыг салбарын яамдууд хүлээх. Хэрэв холбогдох мэдээллийг ирүүлээгүй бол тухайн салбараас хэрэгжүүлэхээр шинээр санал болгосон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Зөвлөл болон Засгийн газарт оруулахгүй.

Гурав.Мэдээлэл солилцоо, мониторинг

8.Хөгжлийн албан ёсны зээл, тусламжийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл солилцох тогтолцоог Гадаад харилцааны яам, Сангийн яам тус тус бий болгон Засгийн газрын байгууллагуудыг холбогдох мэдээллээр хангах.

9.Гадаад харилцааны яам, Сангийн яам хөгжлийн албан ёсны зээл, тусламжаар хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар үнэлэлт дүгнэлтийг гаргаж, нэгдсэн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж Зөвлөлөөр хэлэлцүүлж, Засгийн газарт оруулах.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны наймдугаар сарын 11 №37 (116)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

342. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 696

343. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 700

344. Монгол Улсын Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 701

345. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 702

346. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 702

347. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 703

348. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 703

349. Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (1999-7-21-ний хууль) 704

350. Гэрээ соёрхон батлах тухай (1999-7-21-ний хууль) 704

351. Гэрээнд нэгдэн орох тухай (1999-7-21-ний хууль) 704

352. Конвенцид нэгдэн орох тухай (1999-7-21-ний хууль) 704

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

353. Банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл батлах тухай Дугаар 54 705

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

354. Д. Шарааг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 136 707

355. Ц. Жамъянд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 137 707

356. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 138 707

Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

357. "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр" батлах тухай Дугаар 96 708

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт, өгүүлбэр нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4,5 дахь заалт:

"4/"банкинд бүтцийн өөрчлөлт хийх" гэж банкны бүтэц зохион байгуулалт, дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулах, дүрмийн санг нэмэгдүүлэх буюу хорогдуулах зэргээр санхүүгийн чадварыг дээшлүүлж, алдагдлыг багасгахад чиглэсэн шаардлагыг;

5/ "банкны актив, пассив, өөрийн хөрөнгө" гэж олон улсын жишигт нийцүүлэн Монголбанкнаас батална нягтлан бодох бүртгэлийн журамд тодорхойлсон зүйлийг хэлнэ."

2/ 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/ улс төрийн аливаа нам, эвсэлд хандив өгөх."

3/ 20 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Банк, түүний нэгж байгуулахад зөвшөөрөл олгох журмыг Монголбанк тогтооно."

4/ 25 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт:

7/ дотоод хяналтын алба байгуулах, өөрчлөх."

5/ 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Дотоод хяналтын алба нь банкны удирдлагаас баталсан бодлого, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан зөв эсэхэд хяналт тавьж, актив хөрөнгийг хамгаалан үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэгтэйгээр банкны төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захиралд ажлаа тайлагнах зарчмаар ажиллана."

6/ 27 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 2 дахь догол мөр:

"Бусад активын эрсдлийн санг байгуулах, зарцуулах журмыг Монголбанк тогтооно."

7/ 27 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн 2 дахь догол мөр:

"Хууль тогтоомж зөрчиж дүрмийн санг бүрдүүлсэн нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон бол гэмт үйлдлийн улмаас учирсан хохирлыг дүрмийн санд оруулсан хөрөнгөөр барагдуулах, Монголбанкнаас эрх хүлээн авах албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд банкны алдагдлыг дүрмийн сангаас хаах нь үүнд тус тус хамаарахгүй."

8/ 31 дүгээр зүйлийн 6 дахь заалт:

"6/ банкны үйл ажиллагаат хянаж, Монголбанкинд илтгэж байх үүрэг бүхий хянагч томилох;"

9/ 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/ банкны үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг хянаж тохируулах арга хэмжээ авах."

10/ 36 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалт:

"8/банк өөрчлөн байгуулах."

11/36 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

"7.Банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлсний үр дүнд байгуулагдсан банкны хувь нийлүүлэгчдэд банкны удирдлагын бүрэн эрхийг шилжүүлж өгнө."

12/36[1] дүгээр зүйл:

"36[1] дүгээр зүйл.Онцгой дэглэмийн үед банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх

1.Банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг бүрэн эрхт төлөөлөгчийн саналыг харгалзан Монголбанк батална.

2.Бүрэн эрхт төлөөлөгч нь банкийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг дараахь байдлаар хэрэгжүүлж болно:

1/ активыг бусад этгээдэд худалдах;

2/ банкны дүрмийн санг өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх;

3/ банк, түүний нэгжийг худалдах;

4/ банкийг өөрчлөн байгуулах болон бусад шаардлагатай үйл ажиллагаа."

13/ 38[1] дүгээр зүйл:

"38[1]дүгээр зүйл. Банкны эрх хүлээн авах арга хэмжээг хэрэгжүүлэх

1.Банкны эрх хүлээн авах арга хэмжээг дор дурдсанаар хэрэгжүүлнэ:

1/банкинд бүтцийн өөрчлөлт хийх;

2/банкийг хуулийн этгээдийнх нь хувьд албадан татан буулгаж энэ хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу банкны актив хөрөнгийг захиран зарцуулах.

2. Банкинд бүтцийн өөрчлөлт хийх нь албадан татан буулгаснаас нэхэмжлэгчидийн нэхэмжлэлийн шаардлагыг илүү хэмжээгээр хангах боломжтой гэж үзвэл Монголбанк тухайн банкинд бүтцийн өөрчлөлт хийх тухай шийдвэр гаргаж, төлөвлөгөө батална.

3.Банкинд бүтцийн өөрчлөлт хийх тухай төлөвлөгөө батлах боломжгүй гэж үзсэн, эсхүл энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монголбанкны шийдвэр гаргаснаас хойш 6 сарын дотор банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөө амжилтгүй хэрэгжсэн тохиолдолд Монголбанк банкийг албадан татан буулгах тухай шийдвэр гаргана."

14/ 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

"10/энэ хуулиар хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн банкны олсон орлогыг хураах, банкийг 1000000 хүртэл төгрөгөөр, ажилтан, албан тушаалтныг 50000- 250000 хүртэл төгрөгөөр, зөвшөөрсөнөөс бусад тохиолдолд банкны нууцыг задруулсан этгээдийг 250000- 500000 хүртэл төгрөгөөр торгох."

2 дугаар зүйл.Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "тохиолдолд" гэсний дараа "бусдад гаргаж өгөх"; 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хувийг" гэсний дараа "хоёр талын тохиролцсон гэрээ болон"; 14 дүгээр зүйлийн нэрийн "гаргах" гэсний дараа "барьцаанд авах,"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "худалдаж" гэсний дараа "барьцаанд авч "; 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Банкны худалдан" гэсний өмнө "Санхүүгийн бус байгууллагаас"; 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "хуурамч" гэсний дараа "дүрмийн санг банкны зээлээр бүрдүүлсэн"; 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "төлбөрийн чадваргүй болсон" гэсний дараа ", эсхүл татан буугдсан", "байгууллага" гэсний дараа " /шүүх, Монголбанк, банкны хувь нийлүүлэгчдийн хурал/"; 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "банкны" гэсний дараа "дүрэм батлах,"; 27 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 2 дахь догол мөрний "нэмэгдүүлэх" гэсний дараа "хорогдуулах"; 36 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын "оруулах" гэсний дараа "шилжүүлэх"; 37 дугаар зүйлийн "шилжүүлэн" гэсний дараа "банкинд бүтцийн өөрчлөлт хийх буюу"; 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хугацаанд" гэсний дараа "урьд гарсан шүүхийн шийдвэрийн дагуу", "банкны" гэсний дараа "зээлийн барьцаалсан эд хөрөнгө болон"; 43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтын "бусдад олгосон" гэсний дараа "зээл болон"; 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3,4,5,6 дахь заалтын "албан тушаалтныг " гэсний өмнө "ажилтан, " гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Банкны тухай хуулийн дарааҳь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 1 дүгээр зүйл:

" 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь банк байгуулах зевшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, банкны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндэсэн зарчмыг тогтоох, банкны үйл ажиллагаанд хяналт тавих, банкинд албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино."

2/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт:

"1/"холбогдох этгээд" гэж тухайн банкны хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зевлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, банкны салбар, тооцооны төвийн захирал, тэдгээрийн өвөг эцэг, эмэг эх, эцэг, эх, эхнэр, нөхөр, ах, эгч, дүү, хүүхэд болон тэдэнд хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээдийг хэлнэ."

3/ 6 дугаар зүйл:

"6 дугаар зүйл. Банкны эрхлэх үйл ажиллагаа

"1.Банк Монголбанкны зевшөөрөлтэйгээр дарааҳь үйл ажиллагаа эрхэлнэ:

1/ мөнгөн хадгаламж;

2/ зээл;

3/ төлбөр тооцоо;

4/өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд батлан даалт гаргах;

5/гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;

6/үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;

7/үнэт зүйл хадгалах;

8/гадаад төлбөр тооцоо хийх;

9/үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;

10/санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;

11/хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх;

12/хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаат банк бус санхүүгийн байгууллага зөвхөн Монголбанкны зөвшөөрлөөр эрхэлж болно. Банк бус санхүүгийн байгууллагад энэхүү зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт тавихтай холбогдсон журмыг Монголбанк тогтооно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэг даатгалын байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны компанид хамаарахгүй."

4/ 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Банк нь банк байгуулах зөвшөөрөл авснаас хойш тухайн зөвшөөрлөөр авсан үйл ажиллагаагаа хэвийн явуулсан тохиолдолд Монголбанк энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зохих журмын дагуу өгч болно."

5/ 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Энэ хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэлээр Монголбанк банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ талаархи Монголбанкны шийдвэрийг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөл 30 хоногийн дотор банкны хувь нийлүүлэгчдийн хурлыг зарлан хуралдуулах бөгөөд тухайн хурлаас банкийг татан буулгах тухай шийдвэр гаргана. Татан буулгах ажиллагааг Иргэний хуулийн 31, энэ хуулийн 45 дугаар зүйлд заасан ерөнхий зарчмын дагуу гүйцэтгэж, нэхэмжлэгчдийн төлбөрийг барагдуулна."

6/ 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Банкны эрх барих байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна. Нэг хувь нийлүүлэгчтэй банкны хувьд хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийг хувь нийлүүлэгч өөрөө, төрийн өмчит банкны хувьд Засгийн газар, түүнээс эрх олгосон этгээд тус тус хэрэгжүүлнэ."

7/ 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"6/ дотоод хяналтын албаны ажиллах журам."

8/ 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Бүрэн эрхт төлөөлөгчийн цалин хөлсийг Монголбанк тогтоож, тухайн банкнаас гаргуулна."

9/ 38 дугаар зүйл:

"38 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авах, төлбөрийн чадваргүй болсонд тооцох үндэслэл

1.Монголбанк дор дурдсан үндэслэлээр банкинд эрх хүлээн авах арга хэмжээ авч болно:

1/онцгой дэглэм тогтоосноор банкны хэвийн үйл ажиллагаа хангагдаагүй гэж Монголбанк үзвэл;

2/ банк төлбөрийн чадваргүй болсон.

2.Монголбанк дор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд банкийг төлбөрийн чадваргүй болсонд тооцно:

1/банк хадгаламж эзэмшигч, харилцагч, бусад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон;

2/ банкны пассив нь актив хөрөнгөөсөө хэтэрсэн буюу алдагдал нь дүрмийн сан болон бусад сангийн нийлбэрээс хэтэрч өөрийн хөрөнгө алдагдсан.

3.Монголбанк энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр тухайн банкинд эрх хүлээн авагчийг томилж банкинд бүтцийн өөрчлөлт хийх, эсхүл албадан татан буулгах тухай шийдвэр гаргана."

10/ 44 дугаар зүйл:

"44 дугаар зүйл. Банкны эрх хүлээн авагчийн нэн даруй авах арга хэмжээ

1.Банкны эрх хүлээн авагч нь удирдлагын бүрэн эрх болон өмчлөх эрхийг шилжүүлэн авсны дараа дараахь арга хэмжээ нэн даруй авч хэрэгжүүлнэ:

1/ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу банкны хувь нийлүүлэгчдэд алдагдлыг хүлээлгэж, тэдгээрийн оруулсан хөрөнгийн хэмжээгээр дүрмийн сан, бусад сангаас хасалт хийж санхүүгийн тайланд тусгах;

2/ банкны нийт актив хөрөнгийн жагсаалт, бүртгэлийг гаргах, активыг хяналтандаа авах;

3/ бусдын эзэмшилд байгаа банкны актив

хөрөнгийг бүцааж авах;

4/ хадгалалтын гэрээгээр авсан бүсдын үнэт зүйлийг бүцааж өгөх;

5/ банкинд бүтцийн өөрчлөлт хийх буюу албадан татан буулгах талаархи санал дүгнэлт, төлөвлөгөөг 3 сарын дотор боловсруулж, Монголбанкинд танилцуулах.

2.Банкийг албадан татан буулгах тухай шийдвэр гарсан тохиолдолд банкны эрх хүлээн авагч нь дараахь арга хэмжээ авна:

1/ худалдаж борлуулах актив хөрөнгийн жагсаалт, түүнийг борлуулах үнэлгээг тогтоож, холбогдох этгээдэд мэдэгдэх;

2/ банкнаас авлагатай этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах хугацааг тогтоож, нийтэд мэдээлэх;

3/ нэхэмжлэгчдийн нэхэмжлэлийг хангах хэлбэр, хэмжээ, төлбөрийн хуваарь, дарааллыг тогтоож, нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 2 сарын дотор холбогдох нэхэмжлэгчид мэдэгдэх."

11/ 47 дугаар зүйл:

"47 дугаар зүйл.Банкны эрх хүлээн авах ажиллагааг дуусгавар болгох

Банкны эрх хүлээн авагч нь банкинд бүтцийн өөрчлөлт хийх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн болон нийт актив хөрөнгийг худалдан борлуулж дууссан тухай тайланг гаргаж Монголбанкинд өгнө. Энэхүү тайланг Монголбанк баталж, нийтэд мэдэгдсэнээр банкны эрх хүлээн авах ажиллагааг дуусгавар болсонд тооцно."

12/ 48 дугаар зүйл:

"48 дугаар зүйл. Банкны дампуурлыг зарлах

1.Банкны дампуурлыг шүүх зарлана.

2. Шүүх банкны дампуурлыг зарлаж татан буулгах асуудлыг энэ хуулиар тогтоосон зарчмыг үндэслэн дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ."

4 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн "гишүүдийн хурал" гэснийг "хувь нийлүүлэгчдийн хурал"; "банкны гишүүн" гэснийг "банкны хувь нийлүүлэгч"; 7 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "тайлан, мэдээлэлтэй " гэснийг "тайлан нь түүний санхүүгийн бодит байдалтай"; 11 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн "төлбөрийн баталгаа" гэснийг "батлан даалт"; 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хувьцаа, түүнтэй адилтгах хэлбэрийн үнэт цаасыг" гэснийг "хөрөнгийн зах зээл дээр арилжаалагдах үнэт цаас гаргах,"; 16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн " Банкны худалдан авах буюу барьцаа болгож авах хувьцаа, түүнтэй адилтгах хувьцаа хэлбэрийн үнэт цаасны" гэснийг "Банкны худалдах, худалдан авах, барьцаанд авах үнэт цаасны"; 20 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "30" гэснийг "60"; 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон" гэснийг "энэ хуульд заасан шалгуурыг хангаагүй"; 22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "салбар, төлөөлөгчийн газрыг " гэснийг "нэгжийг"; 23 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн " салбар " гэснийг "нэгж"; 27 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн "тухайн банкинд тавих хяналт, шалгалтанд саад учруулахаар бол" гэснийг "банкны тухай хууль тогтоомжид харшилж байвал"; мөн зүйлийн 10 дахь хэсгийн "өөрийн" гэснийг "хувь"; 31 дүгээр зүйлийн 6,7,8 дахь заалтын дугаарыг 7,8,9; 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "банкийг удирдах" гэснийг "банкны удирдлагын"; 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "бусад банкинд " гэснийг "бусдад"; 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "200000-аас 250000" гэснийг " 500000-1000000", 2 дахь заалтын "150000-аас 200000" гэснийг "250000-500000", 3 дахь заалтын "10000-аас 50000" гэснийг "50000-100000", "50000-аас 200000" гэснийг "500000-1000000", 4 дэх заалтын "5000-аас 20000" гэснийг "10000- 25000", "5000-аас 30000" гэснийг "50000-100000", 5 дахь заалтын "10000-аас 50000" гэснийг "50000-100000", "100000-аас 250000" гэснийг "500000- 1000000", 7 дахь заалтын "100000-аас 200000" гэснийг "500000- 1000000" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.. Банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "барьцаанд авах"; 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "түүнд"; 27 зүйлийн 11 дэх хэсгийн "урьдчилан"; 37 дугаар зүйлийн "банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгож,"; 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "бүюу өмч хөрөнгөтэй холбогдсон асуудлаар иргэний хэрэгт хариуцагчаар татагдаж байгаагүй"; 40 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгож,"; 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "банкны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүчингүй болж"; 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "дор дурьдсан хугацаанд" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3, 5 дахь заалт; 25 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалт; 27 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ТӨВ БАНК / МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд дор дурдсан агуулгатай дарааҳ зүйл, заалт, өгүүлбэр нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

"Монголбанкны худалдан авсан Засгийн газрын урт хугацаатай өрийн бичгийн үлдэгдлийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан түр хугацааны зээлийн үлдэгдлийн нийт хэмжээнд оруулахгүй."

2/23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/ банкны төлбөрийн чадварт гарсан хүндрэл нь банкны тогтолцоо, төлбөр тооцооны тогтолцооны шинж чанартай эрсдлийг үүсгэж болзошгүй болсон гэж үзэж Монголбанк онцгой дэглэм тогтоосон."

3/25[1] дүгээр зүйл:

"**25[1] дүгээр зүйл. Монголбанкны хянагч**

1.Монголбанкнаас томилсон хянагч нь дарааҳ бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ томилогдсон хугацаандаа банкны өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх болон удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, Монголбанкинд тайлагнах;

2/ банкны хувь нийлүүлэгчдийн болон төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд саналын эрхгүйгээр оролцох, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар зөвлөгөө өгөх;

3/банк хууль тогтоомж зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

4/ энэ хуульд заасан хянан шалгагчийн бүрэн эрх."

2 дугаар зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "журам" гэсний дараа "шийдвэр"; 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "хянан шалгагч" гэсний дараа ", хянагч"; 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "шийдвэрийг" гэсний дараа "иргэн, хуулийн этгээд" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "үйл ажиллагаг явуулах" гэснийг "банк байгуулах", 2 дахь хэсгийн "онцгой дэглэм тогтоох, банкны эрх хүлээн" гэснийг "албадлагын арга хэмжээ"; 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь

заалтын "аж ахуйн нэгж" гэснийг "иргэн, хуулийн этгээд", 4 дэх заалтын "аж ахуйн нэгж, байгууллага" гэснийг "хуулийн этгээд"; 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "төлбөрийн баталгаа" гэснийг "батлан даалт", 12 дахь заалтын "аж ахуйн нэгж, байгууллагад" гэснийг "иргэн, хуулийн этгээдэд"; 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "аж ахуйн нэгж, байгууллагын" гэснийг "иргэн, хуулийн этгээдийн"; 34 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн "аж ахуйн нэгж, байгууллагаас" гэснийг "иргэн, хуулийн этгээдээс" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "банкны үйл ажиллагаа явуулахад"; 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "хувьцаа, түүнтэй адилтгах хэлбэрийн" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Иргэний хуулийн 181[1] дүгээр зүйлийн 16 дахь хэсэг, 229 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай өгүүлбэр, хэсэг нэмсүгэй:

1/ 181[1] зүйлийн 16 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэр:

"Хэрэв банкны зээлийн гэрээгээр үл хөдлөх хөрөнгийг давхардуулан барьцаалсан тохиолдолд барьцаа бариулагч үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлснээс хойш ажлын нэг хоногийн дотор энэ тухай Монголбанкны дэргэдэх Зээлийн мэдээллийн санд мэдэгдэнэ. Энэ журмыг зөрчиж хийсэн барьцааны гэрээ нь хүчин төгөлдөр бус байна."

2/ 229 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Энэ нь банк болон банк бус санхүүгийн байгууллагаас зээл олгох гэрээнд хамаарахгүй.

"2 дугаар зүйл. Монгол Улсын Иргэний хуулийн 182 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"182 дугаар зүйл. Банк ба банк бус санхүүгийн байгууллагаас зээл олгох

Банк ба банк бус санхүүгийн байгууллагаас зээл олгохыг хууль буюу түүнд нийцүүлэн талуудын хооронд бичгээр байгуулсан гэрээгээр зохицуулна."

3 дугаар зүйл. Монгол Улсын Иргэний хуулийн дөчин тавдугаар бүлгийн нэрийг "Банк ба банк бус санхүүгийн байгууллагаас зээл олгох"; 368 дугаар зүйлийн нэрийг "Банк ба банк бус санхүүгийн байгууллагаас зээл олгох гэрээ", мөн зүйлийн "Банкнаас зээл олгох" гэснийг " Банк ба банк бус санхүүгийн

байгууллагаас зээл олгох", "банк" гэснийг "банк ба банк бус санхүүгийн байгууллага", "банкнаас олгох зээл" гэснийг "банк ба банк бус санхүүгийн байгууллагаас олгох зээл" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Иргэний хуулийн 181[1] дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн "бусдын эзэмшилд шилжүүлэх, худалдах, өвлүүлэх" гэснийг хассугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай , Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуульд дор дурдсан агуулгатай 127 [1] дүгээр зүйл нэмсүгэй:

"127 [1] дүгээр зүйл. Банкнаас авсан зээлийг төлөхөөс санаатайгаар зайлсхийж их хэмжээний хохирол учруулах

1.Банкнаас авсан зээлийг төлөхөөс санаатайгаар зайлсхийж хууран мэхлэх, оргон зайлах буюу зээлийн хөрөнгөөр олсон орлого болон зээлийн батлан даалт, барьцааны эд хөрөнгийг нуух, буруу мэдээлэх, тэдгээрийг өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх замаар банкинд их хэмжээний хохирол учруулсан бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ үйлдлийг зохион байгуулагдсан бүлэг эттэвд, эсхүл энэ гэмт хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд хийсэн бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж, найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 216[1] дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 **дугаар зүйл.** Энэ хуулийг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай , Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"6/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны хувьчлалын үндсэн чиглэлийг баталж, хувьчлал хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхэд Монголбанкаар дамжуулан хяналт тавина.

"2/ 9 дүгээр зүйлийн 10 дахь заалт:

"10/ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой банкны төрийн өмчид ногдох хэсгийг хувьчлах хөтөлбөр, банкин дахь төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх журмыг Монголбанктай зөвшилцөн батална."

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг "1. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах арга хэмжээг Засгийн газар, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой банкийг хувьчлах арга хэмжээг Засгийн газар, Монголбанктай хамтран баталсан хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ." гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын дугаарыг "7", 9 дүгээр зүйлийн 10 дахь заалтын дугаарыг "11" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай , Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ШҮҮХИЙН ШИЙДВЭР БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/ 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:

"4/ хуульд өөрөөр заагаагүй бол хувь нийлүүлэгчээс хуулийн этгээдийн дүрмийн санд оруулсан эд хөрөнгө."

2/ 22^1 дүгээр зүйл:

"22^1 дүгээр зүйл. Шүүгчийн захирамж биелүүлэх

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 160^1 дүгээр зүйлийн дагуу иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд батлан даагч, барьцаа бариулагчийн эд хөрөнгө битүүмжлэх тухай шүүгчийн захирамжийг шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэнэ."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай , Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай заалт, зүйл нэмсүгэй:

1/136 дугаар зүйлийн 12 дахь заалт:

"12/банкны зээлийн батлан даалт, барьцаа хөрөнгийн өмчлөлийг тогтоох тухай."

$2/160^1$ дүгээр зүйл:

"160^1 дүгээр зүйл. Банкны зээлийн батлан даалт, барьцаа хөрөнгийн өмчлөлийг тогтоох

1.Банкны зээлийн батлан даалт, барьцаа хөрөнгийн өмчлөлийг тогтоолгох тухай хүсэлтийг хүлээн авсанаас хойш шүүх 14 хоногийн дотор хэргийг хянан хэлэлцэнэ.

2. Банкны зээлийн батлан даалт, барьцаа хөрөнгийн өмчлөлийг тогтооход зайлшгүй шаардлагатай баримт бичиг /гэрээ, эд хөрөнгө өмчлөх эрхийн бичиг зэрэг/ -ийг сэргээж болно.

3. Банкны зээлийн батлан даалт, барьцааны гэрээний дагуу батлан даасан бүюу барьцаалсан хөрөнгөө банкны мэдэлд шилжүүлэхтэй холбоотой иргэний хэрэг үүсгэсэн тохиолдолд шүүгч энэ хуулийн 69 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг заавал авна."

2 дугаар зүйл.Энэ хуулийг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай , Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлд "3.Монголбанкнаас банк, түүний нэгж, банк бус санхүүгийн байгууллага байгуулах зөвшөөрөл олгоход энэ хураамж хамаарахгүй." гэсэн 3 дахь хэсэг нэмсүгэй.

2 **дугаар зүйл.**Энэ хуулийг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсын хооронд 1999 оны 5 дугаар сарын 31-ний өдөр гарын үсэг зурсан "Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Гэрээ" болон "Эрүүгийн хэргийн салбарт эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээ"-г Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу тус тус соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭНД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл."Эрчим хүчний Хартийн Гэрээ", "Эрчим хүчний үр ашиг болон хүрээлэн буй орчны холбогдолтой асуудлын тухай Эрчим хүчний Хартийн Протокол" болон "Эрчим хүчний Хартийн Гэрээний худалдааны холбогдох заалтуудын нэмэлт, өөрчлөлт"-д тус тус нэгдэн орсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.1954 оны 3 дугаар сарын 1-ний өдөр Нидерландын Вант Улсын Гаага хотноо гарын үсэг зурсан "Иргэний байцаан шийтгэх ажиллагааны асуудлаарх Конвенци"-д Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу нэгдэн орсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

Банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэл"-ийг хавсралтаар батална.

2.Энэхүү "Үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Засгийн газар /Р.Амаржаргал/, Монголбанк /Ж.Үнэнбат/-нд тус тус даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 54 дүгээр тогтоолын хавсралт

БАНКНЫ ХУВЬЧЛАЛЫН ТАЛААР БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Нэг.Ерөнхий зүйл

1.Энэ баримт бичиг нь төрөөс банкны хувьчлалын талаар баримтлах үндсэн чиглэлийг тодорхойлно.

2.Банкны хувьчлал нь Монгол Улсын эдийн засгийн шинэчлэлийн салшгүй хэсэг бөгөөд түүний зорилго нь санхүүгийн чөлөөт эх үүсвэрийг үр ашигтай хуваарилан улс орны эдийн засгийн өсөлтийгханган чадвар бүхий зах зээлийн зарчимд үндэслэсэн бүтэцтэй, тогтвортой, найдвартай үйл ажиллагаа бүхий банкны тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

3. Энэ Үндсэн чиглэлд "Банкны хувьчлал" гэдэгт төрийн өмчит банк, төрийн өмчийн оролцоотой банкин дахь төрд ногдох хувьцаа, ногдол хувийг холбогдох хууль тогтоомж, энэ Үндсэн чиглэлийн хүрээнд хувийн хөрөнгө оруулагчдад худалдах замаар хувийн өмчид шилжүүлэхийг ойлгоно.

4. Энэ Үндсэн чиглэлд "Стратегийн хөрөнгө оруулагч" гэдэгт банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг, нэр хүнд бүхий гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг ойлгоно.

5.Банкны хувьчлалыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, энэ Үндсэн чиглэл, түүний хүрээнд Засгийн газраас батлах Банкны хувьчлалын хөтөлбөр, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

6.Хувьчлалд хамрагдах зарим томоохон банкуудын санхүү, төлбөрийн чадвар муудаж, гэдний хэвийн үйл ажиллагаа нь алдагдаж байгаа харгалзан банкны хувьчлалыг банкны үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад түлхүү чиглүүлнэ.

Хоёр.Хувьчлалд тавигдах шаардлага

7.Банкны хувьчлалыг хэрэгжүүлснээр улсын эдийн засгийн аюулгүй байдал, банкны системийн найдвартай ажиллагааг хангаж, хадгаламж эзэмшигчид болон харилцагчдын эрх ашгийг хохироохгүй байна.

8.Банкны хувьчлалыг энэ Үндсэн чиглэлийн 5-д заасан эрх зүйн баримт бичгийн хүрээнд ил тод хэрэгжүүлнэ.

9.Банкийг стратегийн хөрөнгө оруулагчдад хувьчлах зарчмыг тэргүүн зэрэгт тавина.

10.Төрийн өмчийн хувьцааг багцалж худалдаж болох бөгөөд хөрөнгийн төвлөрлийг бий болгох зарчмыг баримтална.

11.Банкны хувьчлалаас улсын төвлөрсөн төсөвт орох орлогыг нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчилна.

12.Банкны хувьчлалын үр дүнд дараахь нөхцөлүүд хангагдсан байвал зохино:

1/ банкны удирдлагын үр чадвар, үр ашиг дээшилсэн байх;

2/ банкны өөрийн хөрөнгө нэмэгдэж, санхүү, төлбөрийн чадвар дээшилж, тогтвортой үйл ажиллагаа нь хангагдсан байх;

3/ банкны үйлчилгээ сайжирч, тэдэнд үйлчилгээний шинэ технологи, арга барилыг нэвтрүүлсэн байх.

Гурав.Банкны хувьчлалын хамрах хүрээ

13.Банкны дүрмийн санд төрөөс шууд болон шууд бус /төрийн өмчийн үйлдвэрийн газруудаас оруулсан хувь хөрөнгө/ хэлбэрээр оруулсан хувь хөрөнгө, түүнийг ашигласнаас бий болсон хуримтлагдсан ашиг, байгуулсан тусгай сангуудын үлдэгдэл хөрөнгийг оруулан тооцож хувьчлалд хамруулна. Шаардлагатай гэж үзвэл банкны үндсэн хөрөнгийг дахин үнэлж, дахин үнэлгээний сан байгуулан хувьчлах болно.

14.Төрийн өмчийн оролцоотой банкуудын дүрмийн сан дахь төрд ногдох хэсгийг нарийвчлан тогтоож хувьчлалд хамруулна.

Дөрөв.Банкны хувьчлалыг хэрэгжүүлэх

15.Энэ Үндсэн чиглэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай Монгол Улсын хуульд заасны дагуу Засгийн газар Монголбанктай зөвшилцөн "Банкны хувьчлалын хөтөлбөр"-ийг батлаж мөрдүүлнэ.

16.Банкны хувьчлалын хөтөлбөрт хувьчлалд хамрагдах банкуудын жагсаалт, хувьчлах арга, хэлбэр, үе шатыг тодорхой заасан байх ба тухайн банкны санхүү, төлбөрийн чадвар болон холбогдох бусад үзүүлэлтүүдийг харгалзан хувьчлах арга, хэлбэр, нөхцөл, үе шат, хувьчлалд хамрагдах хугацаат ялгавартай тогтоож хэрэгжүүлнэ.

17.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 34.1-д заасан төрийн өмчийг хувьчлах аргуудаас уралдаант шалгаруулалт, төрийн өмчийн хувьцаа, хувь хөрөнгийг худалдах, хуулийн этгээдийг хамтарсан хэлбэрээр зохион байгуулах зэрэг аргуудыг дангаар нь буюу хослуулан хэрэглэх замаар банкийг хувьчилна.

18.Хувьчлалд хамрагдах төрийн өмчийн банкийг компаний хэлбэрт оруулан зохион байгуулж түүний хувьцаа болон, төрийн өмчийн оролцоотой банкин дахь төрд ногдох хувьцаа, ногдол хувийг худалдах доод үнийг тогтоох жүрмыг Засгийн газар Монголбанктай зөвшилцөн батлах бөгөөд шаардлагатай гэж үзвэл үнэ тогтоох шинжээчдийн хэсгийг Засгийн газар томилж ажиллуулна.

19.Банкны хувьчлалын хөтөлбөрийг боловсруулах, хувьчлалыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг байгуулж ажиллуулна.

20.Банкны хувьчлалын ажлыг зохион байгуулахад нэр хүнд бүхий гадаадын зөвлөх компаниас хөрөнгө оруулалтын зөвлөх, зуучлагчийг авч ажиллуулж болно.

21.Төрийн өмчийн хувьцаа, ногдол хувийг худалдах үнэ нь сонгон шалгаруулалтын явцад хөрөнгө оруулагчдын эрэлтээс хамаарч тогтоогдох бөгөөд хувьчлах доод үнээс доогуур үнээр хувьчилж болохгүй.

22.Банкны үйл ажиллагаат сайжруулахад ажилчдын идэвхи санаачлагыг өрнүүлэх, тэдэнд өмчлөгчийн материаллаг сонирхол төрүүлэх зорилгоор худалдах нийт хувьцааны тодорхой хэсгийг ажилчдад худалдаж болно.

23.Иргэдийн хадгаламж төлөрөч байгаа төрийн өмчийн Хадгаламжийн банкийг хадгаламжийн даатгалын тогтолцоо бий болтол хувьчлалд хамруулахгүй.

24.Төлбөрийн чадваргүй болсон төрийн өмчийн Сэргээн босголтын банк, төрийн өмчийн оролцоотой Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлийн банк, Хөдөө аж ахуйн банк, төлбөрийн чадвар нь муудаж байгаа Экспорт Импорт банкууд дахь төрийн өмчийн хувьцаа, ногдол хувийг сонгон шалгаруулалтын эхний үе шатанд стратегийн хөрөнгө оруулагчдад шилжүүлэх зорилт тавина. Хэрэв сонирхогч стратегийн хөрөнгө оруулагч тодрохгүй бол хоёр дахь үе шатанд сонирхсон бусад хөрөнгө оруулагчдад хувьчилна.

25.Төлбөрийн чадваргүй банкуудыг хувьчлах арга хэмжээ нь тэдний бүтцийн өөрчлөлтийн үр дүн, хөрөнгө оруулагчдын эрэлтээс хамаарч хэрэгжинэ.

26.Төлбөрийн чадваргүй банкуудыг худалдан авах хөрөнгө оруулагч тодорвол тухайн банкны үйл ажиллагааг цаашид тогтворжуулах зорилтыг тэрүүнэ зэрэгт тавьж, харин төрийн өмчийн хувьчлалаас төсөвт орох орлогыг харгалзах үзүүлэлт болгохгүй байж болно.

27.Хөрөнгө оруулагчид банкны үйл ажиллагааны мөрдөж буй хууль тогтоомжийн чанд мөрдөж, банкны ашигт ажиллагаа хангаж өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг цаашид тогтвортой байлгах, санхүү, төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол биелүүлж ажиллах талаар төрийг төлөөлж Монголбанк, хөрөнгө оруулагчидтай дунд хугацааны /3-5 жилийн/ гэрээ байгуулж ажиллана.

28.Төлбөрийн чадваргүй, алдагдалтай ажиллаж байгаа банкуудад хөрөнгө оруулагч тодрохгүй бол тэдний алдагдыг зогсоож харилцагч, хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгийг хамгаалах зорилгоор Банкны тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу татан буулгах хүртэл шаардлагатай арга хэмжээ авна.

29.Төрийн өмчийн Сэргээн босголтын банк, Хадгаламжийн банкны иргэдийн хадгаламжийг төр эрсдэлээс бүрэн хамгаална.

30.Банкны хувьчлалд тавих хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор банкны дүрмийн сангийн бүтэц, Банкны хувьчлалын хөтөлбөр /хувьчлах банкны жагсаалт, үе шат, зорилт, гарах үр дүн, хувьчлах хугацаа, үнэ/-ийн талаар Улсын Их Хурлын дагын захирамжаар байгуулагдсан Банкны салбарт бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөх эрх бүхий зохицуулах зөвлөлд танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 29-ний өдөр — Дугаар 136 — Улаанбаатар хот

Д. Шараг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн, өөрийнх нь хүсэлтийг харгалзан Дэчингийн Шараг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 30-ны өдөр — Дугаар 137 — Улаанбаатар хот

Ц. Жамъянд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр уран чадвар эзэмшин нийтэд түгсэн олон шилдэг дууны ая, хөгжимт драм, бүжиг, киноны хөгжим туурвиж, хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Завхан аймгийн Хөгжимт драмын театрын уран сайхны удирдагч, хөгжмийн зохиолч Цэрэндашийн Жамъянд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 7 дугаар сарын 30-ны өдөр — Дугаар 138 — Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл үйлчилгээ, соёл урлаг, боловсрол, эрүүл мэнд, цагдаагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Намжилын Лосол - Завхан аймгийн Яруу сумын тууварч малчин
2. Рүүрагчийн Омоонцоо -Завхан аймгийн Улиастай сумын "Жаргалант" хоршооны ногоочин

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР :

1. Ойдовсамбуугийн Дашдэндэв - Архангай аймгийн Батцэнгэл сумын хүний эмнэлгийн салбарын эрхлэгч их эмч
2. Магванжавын Доржбал -Завхан аймгийн Отгон сумын тууварч малчин
3. Түвдэнгийн Пүрэвдорж -Завхан аймгийн Холбооны газрын үйлчилгээний албаны дарга
4. Дивааансалын Равдмаа -Архангай аймгийн Нефть хангамжийн баа-зын ерөнхий нягтлан бодогч
5. Даваасамбуугийн Сосорбарам -Завхан аймгийн Сонгино сумын хүний эмнэлгийн салбарын багa эмч
6. Жигжавын Цэндсүрэн -Завхан Нөмрөг сумын сумын дунд сургуулийн багш
7. Санжийн Цэрэндулам -Завхан аймгийн Улиастай сумын дөрөвдүгээр сургуулийн бага ангийн багш
8. Лавагийн Юра -Завхан аймгийн Улиастай сумын "Завхан баялаг" ХК-ийн гүйцэтгэх захирал

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Цогсүрэнгийн Жүгжинноров -Архангай аймгийн Цагдаагийн хэлтсийн цагдаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэрэндоржийн Гүрбазар - Завхан аймгийн Улиастай сумын Төмөр бетон заводын "Арбет" ХХК-ийн барилгачин
2. Далрайн Жавзандулам -Завхан аймгийн нийгмийн эрүүл мэндийн төвийн эх баригч эмч
3. Нямын Лхагвасүрэн -Завхан аймгийн Хөгжимт драмын театрын дуучин
4. Дамдинжавын Мишка -Завхан аймгийн Улиастай сумын "Хан хүрхрээ" ХХК-ийн экскаваторчин
5. Пүрэвийн Оюунбилэг -Завхан аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн мэс заслын тасгийн сувилагч
6. Лонжидын Пунцагдаш -Архангай аймгийн Холбооны газрын дарга
7. Нансалын Туяа -Завхан аймгийн Улиастай сумын гуравдугаар цэцэрлэгийн эрхлэгч
8. Довчингийн Чантуу -Завхан аймгийн Улиастай сумын нэгдүгээр дунд сургуулийн захирал
9. Жигжидийн Ядамсүрэн -Завхан аймгийн Холбооны газрын монтёр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 96** **Улаанбаатар хот**

"Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр" батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр"(цаашид хөтөлбөр гэж нэрлэнэ)-ийг хавсралтын ёсоор батлсугай.

2. Хөтөлбөрийг төрийн захиргааны албан хаагчдад мэдээлэх, ойлгуулах ярилцлага, хэлэлцүүлэг, сургалт-семинарыг яам, аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулахыг сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн жил бүрийн төсөвт тусган төлөвлөж байхыг Сангийн сайдад үүрэг болгосугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн зарим эх үүсвэрийг олон улсын байгууллага, хандивлагч орнуудын холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэхийг Гадаад харилцааны сайд Н. Туяа, Сангийн сайд Я. Очирсүх, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н. Батбаяр нарт даалгасугай.

5. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Н.Батбаяр)-т даалгах нь:

а. Холбогдох яам, аймагтай хамтран Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу "Төрийн албан хаагчийн сургалт" хөтөлбөрийг 1 яам, 1 аймаг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын жишээн дээр 1999 онд багтаан боловсруулан батлуулж мөрдүүлсүгэй;

б. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан ярилцлага, хэлэлцүүлэг, сургалт-семинарыг 1999 онд багтаан зохион байгуулсугай.

в. Хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, сургалтын байгууллагуудыг удирдлага, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа дэмжлэгээр хангаж ажилласугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд Ж. Наранцацралт

Хууль зүйн сайд Л. Цог

Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН АЛБАНЫ СУРГАЛТ БА МЭДЛЭГ ЧАДВАР БИЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР

(Алсын хараа, бодлого, стратеги)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөтөлбөрийн үндэслэл, зориулалт

"Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр" (цаашид "Хөтөлбөр" гэж нэрлэнэ)-ийг Засгийн газрын 1996 оны 280 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Төрийн албаны сургалт, зөвлөгөө" төслийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас боловсруулсан "Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгохуй" баримт бичгийг үндэслэн боловсруулсан болно.

Хөтөлбөрийг төрийн албаны сургалтын одоогийн байдал болон ирээдүйн хэрэгцээ, түүнийг хангахад чиглэсэн сургалтын үр дүн, нөөц, олон улсын зарим туршлагад хийсэн шинжилгээний дүнд тулгуурлан боловсруулав.

Хөтөлбөрийг Засгийн газраас Монгол Улсын төрийн захиргааны албаны хүрээнд мэдлэг чадвар бий болгохтой холбогдсон шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, мэдлэг чадвар бий болгох үйл явцыг бүх нийтээр ойлгож, зохион байгуулах, дэмжихэд ашиглана. Иймээс хөтөлбөр нь төрийн захиргааны бүх шатны байгууллага, сургалтын байгууллага, гадаад, дотоодын бусад түншүүдийг оролцуулан төрийн захиргааны албаны хүрээнд мэдлэг чадвар бий болгоход хамаатай бүх хүмүүс, байгууллагад зориулагдсан болно.

1.2. Хөтөлбөрийн хэрэгцээ

Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл нь төрийн захиргааны бүх шатны байгууллагын өмнө шинэ зорилт, чиг үүргээ мэдлэг чадвартай төрийн албан хаагчдын хүчээр хэрэгжүүлж, иргэдэд чанар сайтай төрийн үйлчилгээ үзүүлэх шинэ шаардлага, хариуцлагын шинэ тогтолцоог бий болгов. Энэ нь төрийн хэргийг эрхлэхэд урьд урьдаас улам их багтаамжтай мэдлэг, заримдаа бүр өргөн хүрээтэй цоо шинэ мэдлэг чадварыг шаардаж байна.

Төрийн захиргааны бүх шатны байгууллагын үр нөлөө, үр ашигтай үйл ажиллагаа явуулах гол нөөц нь мэдлэг чадвар бөгөөд гадаад, дотоод орчны байнгын өөрчлөлт нь төрийн албан хаагчдаас цаг үргэлжид мэдлэг чадвараа дээшлүүлж байх хэрэгцээг тодорхойлж байна.

1.3. Хөтөлбөрийн зорилго, бүтэц, үе шат

Хөтөлбөрийн зорилго нь төрийн захиргааны албаны хүрээнд мэдлэг чадвар бий болгоход удирдамж болохын хамт төрийн захиргааны албыг хөгжүүлэхэд түлхэц үзүүлэхэд оршино.

Хөтөлбөр нь түс тусын зорилго бүхий дараахь 3 хэсгээс бүрдэнэ:

- Алсын хараа;
- Бодлого;
- Стратеги.

Хөтөлбөр нь цаг хугацааны хувьд 1998-2015 оноудыг хамарч байгаа ба богино (1-2 жил), дунд (2-5 жил), урт (5-15 жил) хугацааны гэсэн гурван үе шаттай байна.

Хоёр. Алсын хараа

2.1. Алсын харааны үндэслэл

Хөтөлбөрийн алсын хараа нь төрийн захиргааны албаны хүрээхээр хүсэн тэмүүлж буй ирээдүйн дүр төрхийг тодорхойлох энэхүү хөтөлбөрийн бодлогыг тодорхойлох эх сурвалж болно.

2.2. Алсын харааны агуулга

Монгол Улсын төрийн захиргааны албаны ирээдүйн дүр төрхийг тодорхойлж буй алсын хараа доорхи байдлаар тодорхойлж байна:

- Үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн захиргааны албан бүрдүүлсэн байх;
- Мэдлэг чадвартай төрийн захиргааны албан хаагчидтай болсон байх;
- Төрийн захиргааны байгууллага бүр суралцагч байгууллага болсон байх;
- Төрийн захиргааны албан хаагчдын манлайлал ба оролцооны өндөр түвшинг хангах.

2.3. Алсын харааны тогтолцоо

Алсын харааны дээрх дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нь өөр хоорондоо харилцан нягт холбоотой, бие биеэ харилцан дэмжсэн дор дурдсан тогтолцоо бий болсон байна:



Гурав. Бодлого

Гурав. Бодлого

3.1. Үндсэн зарчим ба үнэт зүйлс

Алсын хараанд чиглэсэн хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход дор дурдсан үндсэн зарчим ба үнэт зүйлсийг баримтална:

- ***Ардчиллыг бэхжүүлэх:*** Мэдлэг чадвар бий болгох нь төрийн албаны ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлнэ. Иймд мэдлэг чадвар бий болгох үйл явцыг түүнд оролцох, хувийн санаачилга гаргах өргөн боломжийг хангасан ардчилсан замаар хэрэгжүүлнэ.
- ***Зах зээлийн эдийн засгийн орчны өөрчлөлтийг харгалзан үзэх:*** Мэдлэг чадварыг бий болгохдоо зах зээлийн эдийн засгийн орчны өөрчлөлтийг харгалзан үзнэ. Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох үйл явцад хувийн хэвшлийг оролцуулан болодшоотой бүх нөөцийг ашиглана.
- ***Үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх:*** Мэдлэг чадвар бий болгох нь төрийн албаны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэр хязгаарлагдмал тул сургалтын болон мэдлэг чадвар бий болгох үйл явцыг өртөг зардал хямдтайгаар хэрэгжүүлэхийг цаг ямагт чухалчилна.
- ***Ил тод байдал, хариуцлагын тогтолцоог эрхэмлэх:*** Мэдлэг чадвар бий болгох үйл явцыг нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлнэ. Мэдлэг чадвар бий болгох бүх үйл ажиллагаа нь тодорхой заагласан үүрэг, хариуцлагын тогтолцоотой байна.
- ***Адил тэгш боломжоогоор хангах:*** Хэнийг ч яс үндэс, нийгмийн гарал, хэл, арьс өнгө, нас, хүйс, албан ажил болон үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж болохгүй. Сургалт ба мэдлэг чадвар бий болгохыг төрийн албаны хүрээнд ялгаварлан гадуурхах хандлагыг /жишээлбэл: хүйсийн тэгш бус байдлыг арилгах/ тэнцвэржүүлэхэд ашиглах бөгөөд үүнийг оролцох боломжийг хүн бүрт олгох замаар хэрэгжүүлнэ.
- ***Үүрэг хариуцлага хүлээх:*** Удирдлага нь төрийн албан хаагчийг сургах, давтан сургах санаачилга гаргах, чадавхи бий болгох санаачилгыг урамшуулан дэмжих үүрэг хүлээнэ. Үүний нэгэн адил төрийн албаны бүх албан хаагч өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бусад хүмүүсийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

Төрийн захиргааны албаны ирээдүйн дүр төрхийг тодорхойлж бүй алсын хараанд хүрэхэд чиглэсэн хөтөлбөрийн бодлогыг дор дурдсан чиглэлээр тодорхойлж байна:

3.2. Үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн алба бүрдүүлэх талаар баримтлах бодлого

3.2.1. Мэдлэг чадвар бий болгох хөтөлбөрийн бодлогын гол зорилго нь төр, засгийн бодлогыг хэрэгжүүлэх, Монгол Улсын иргэдэд үр ашигтай, үр нөлөөтэй үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн захиргааны албыг бүрдүүлэхэд оршино. Энэ зорилго нь төрийн захиргааны байгууллагыг мэдлэг чадвартай төрийн захиргааны мэргэшсэн албан хаагч бүхий төрийн захиргааны суралцагч байгууллага болгон хөгжүүлж, Монгол Улсын иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний үр нөлөө, үр дүнг дээшлүүлснээр хэрэгжинэ.

3.2.2. Үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн захиргааны алба нь төрийн албаны нэр хүнд, Засгийн газарт хүмүүсийн итгэх итгэлийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

3.2.3. Төрийн захиргааны албаны үйл ажиллагааны чадавхи нь гадаад, дотоод орчны өөрчлөлтөд зохицон байнга сайжирч байх хандлагыг агуулна. Үүнтэй уялдан

төрийн захиргааны байгууллагыг өөрчлөн суралцагч байгууллага болгох, төрийн захиргааны албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх төрийн албаны сургалтын шинэ хэрэгцээ урган гарна.

3.2.4.Төрийн албан хаагч нь Монгол Улсын төрийн албаны хамгийн үнэ цэнэтэй хөрөнгө мөн. Иймд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг бий болгох аливаа арга хэмжээг хөрөнгө оруулалт гэж үзнэ. Иймээс төрийн албаны бүх түвшинд эрэгтэй, эмэгтэй албан хаагчдын мэдлэг чадварыг зүй зохистой ашиглах нь уг хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх, үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн захиргааны албыг бүрдүүлэх чухал хүчин зүйл гэж үзнэ.

3.3. Мэдлэг чадвартай төрийн захиргааны албан хаагчидтай
болсон байх талаар баримтлах бодлого

3.3.1. Хөтөлбөрийн бодлогын нэг гол зорилго нь төрийн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх хангалттай мэдлэг чадвартай төрийн захиргааны албан хаагчийн эгнээг бүрдүүлэхэд оршино. Энэ зорилго нь төрийн захиргааны суралцагч байгууллагын хөгжлийн түвшин, тэдгээрийн үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлснээр хэрэгжинэ. Мэдлэг чадвартай албан хаагч нь үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн захиргааны албыг бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

3.3.2. Төрийн алба, төрийн байгууллагын гадаад, дотоод орчны өөрчлөлтөөс урган гарсан төрийн захиргааны албаны сургалтын шинэ хэрэгцээг хангах зорилгоор төрийн албан хаагч мэдлэг чадвараа байнгаа дээшлүүлнэ.

3.3.3. Мэдлэг чадвар гэдэгт тодорхой орчинд аливаа чиг үүргийг гүйцэтгэх хувь хүний чадварыг ойлгоно. Үүнд хувь хүний онолын мэдлэг, ур чадвар, туршлага, хувийн шинж чанар, үнэт зүйлс багтана.

3.3.4. Мэдлэг чадварыг гурван төрөлд хуваах бөгөөд эдгээр нь бүгдээрээ адилхан ач холбогдолтой байна:

- ***Мэргэжлийн мэдлэг чадвар*** нь төрийн албан хаагчийн эзэмшсэн тодорхой салбарын мэргэжил (хуульч, эдийн засагч, агрономч, эмч, багш, инженер, төрийн захиргааны менежер зэрэг)-ээр тодорхойлогдоно.
- ***Нийгмийн мэдлэг чадвар*** гэдэг нь түнштэйгээ сайтар хамтран ажиллах, байгууллагын үйлчлүүлэгчтэй харилцах зэрэгт шаардагдах мэдлэг чадвар юм.

Үүнд бусадтай харилцах, мэдлэг болон мэдээллээ хуваалцах чадвар багтана.

- ***Үйл ажиллагаа /бизнес/-ны мэдлэг чадвар*** нь тухайн байгууллагын эрхэлж байгаа тодорхой үйл ажиллагаа /бизнес/-тай холбоотой. Үүнд байгууллагын эрхэм зорилго, зорилтуудыг мэдэрч, үйл ажиллагаа /бизнес/-ны хүрээлэн байгаа орчинг ойлгосны үндэсэн дээр аливаа хүний тусгайлан эрхэлж байгаа ажилдаа мэргэжлийн болон , нийгмийн мэдлэг чадварыг ашиглаж чаддаг байх явдал хамаарна.

3.3.5.Төрийн албан хаагч эрхэлсэн ажилтайгаа холбогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд дээрх мэдлэг чадваруудыг эзэмшсэн байвал зохино. Үйл ажиллагаа (бизнес) болон байгууллага өөрчлөгдөхийн хэрээр шинэ мэдлэг чадвар байнга шаардагдана.

3.3.6. Төрийн албан хаагчийн эзэмшсэн мэргэжил нь тухайн чиг үүргийг стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх баталгаа болж чадахгүй гэдгийг хүлээн зөвшөөрөвөл зохино. Практик туршлага нь мэдлэг чадвар бий болгоход амин чухал болно. Иймээс мэдлэг чадвар нь үйл ажиллагаа(бизнес)-ны чиг үүргэтэй нягт холбогдсон байна.

3.3.7. Ажилтнууд бие биенээсээ хэт тусгаарлагдмал байх нь ажлын үр дүнд гол төлөв сөргөөр нөлөөлнө. Иймд хувь хүний, бүлгийн болон байгууллагын аль алиных нь түвшинд мэдлэг чадвар бий болгох ёстой. Баг (бүх оролцогчид ижил мэдээллийг бүлгээр олж авах үед)-аар хамтран суралцаж олж авсан шинэ мэдлэг чадвар нь ганцаарчилсан (мэдээллийг бүлгийн доторкн нэг хүнд өгөх үед) сургалтынхаас илүү үр нөлөөтэй тул сургалтын энэ хэлбэрийг чухалчлан үзнэ.

3.4. Төрийн захиргааны байгууллага бүр суралцагч байгууллага
болсон байх талаар баримтлах бодлого

3.4.1. Хөтөлбөрийн бодлогын нэг гол зорилго нь төрийн захиргааны байгууллага бүрийг суралцагч байгууллага болгон хөгжүүлэхэд оршино. Энэ зорилго нь төрийн захиргааны албан хаагчийн болон төрийн байгууллагын чадавхи дээшилснээр хэрэгжинэ. Төрийн захиргааны суралцагч байгууллага нь үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн албыг бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэнэ.

3.4.2. Төрийн захиргааны байгууллага бүрийн үйл ажиллагаа нь хүн бүрийн мэдлэг чадварыг дээд зэргээр ашиглаж, шинээр суралцах явдлыг хөхиүлэн дэмжиж байхаар зохион байгуулагдана. Төрийн захиргааны бүх шатны байгууллагын албан хаагч нь

мэдлэг, ур чадвар, мэдээлэл, туршлагаа харилцан хуваалцаж, өдөр тутмын ажлынхаа туршлагаас суралцаж, шаардлагатай үед зохион байгуулалттай сургалтад хамрагдана.

3.4.3. Мэдлэг чадвар бий болгох ажлыг зөвхөн байгууллагын үйл ажиллагааны дүр төрхийн өөрчлөлттэй хослуулсан тохиолдолд үр ашигтай гэдгийг удирдлага болгоно.

3.4.4. Өөрийн үйл ажиллагаагаа сайжруулахын тулд тасралтгүй суралцаж, суралцах шинэ арга барилыг идэвхтэй хэрэглэдэг байгууллагыг "суралцагч байгууллага" гэж нэрлэнэ. Мэдлэг чадвар бий болгох явдлыг дэмжиж, өдөр тутмын ажил нь суралцах таатай боломжоор хангаж байдаг ажлын орчноор нь суралцагч байгууллагыг тодорхойлно. Энэ нь бүх түвшинд сайн харилцаатай, хамтран ажиллагчид хоорондоо мэдлэгээ байнга солилцож байдаг байгууллага юм. Энд хувь хүний санал, санаачилга, шинэ санаанд эергээр хандаж, түүнчлэн шинэ үйл явдалтай тулгарахаас буцахгүй, түүний үр дагавраас айхгүйгээр шийдвэрлэх хүсэл сонирхолтой байна.

3.5. Манлайлал ба оролцооны өндөр түвшинг хангах талаар

баримтлах бодлого

3.5.1. Төрийн захиргааны байгууллагын удирдлага нь суралцах бүх хэлбэрийг урамшуулан дэмжиж, суралцах үйлийг хөнгөвчилж, түүнд шаардагдах боломжит нөөцийг бий болгож, өөрөө үлгэр жишээ үзүүлдэг, ажлын сайн орчин нөхцөл бүрдүүлэхэд манлайлах, оролцооны өндөр төвшинг хангах үүрэг хүлээнэ.

3.5.2. Төрийн захиргааны байгууллагын ажилтнууд нь сургалтаас урам зориг аван идэвхжиж, хүсэмсээрээ хувь нэмрээ оруулах үүрэг хүлээх ёстой.

3.5.3. Манлайлал ба оролцооны өндөр түвшинг хангах нь үйл ажиллагааны чадавхи сайтай төрийн захиргааны алба бий болгох, төрийн захиргааны алба нь мэдлэг чадвартай албан хаагчидтай болсон байх, төрийн захиргааны байгууллага бүр суралцагч байгууллага болсон байх зорилтыг холбохыг шаардана. Дээрх шаардлагыг хангах үүрэг хариуцлагыг төрийн захиргааны байгууллагын удирдлага хүлээнэ. Тэд төрийн шинэ албыг төлөвшүүлэн манлайлж, байгууллагын одоогийн мэдлэг чадварыг үр ашигтай ашиглаж, цаашид шинэ шинэ мэдлэг чадвар бий болгохыг дэмжинэ.

3.5.4.Ямар нэг үйл ажиллагаа(бизнес) явуулах, байгууллагыг хөгжүүлэхэд хангалттай мэдлэг чадвар байгаа эсэхийг анхаарч, удирдлага байгууллагадаа хэрэгцээтэй мэдлэг чадвар бүхий хүмүүсийг элсүүлэн авах, мөн урьд нь ажилд авсан хүмүүсийн эрхэлсэн үүрэг даалгавраа хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг чадварыг дээшлүүлэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Энэ нь төрийн захиргааны байгууллагын бүх түвшинд манлайллын шинэ хэлбэрийг шаардана. Удирдлага ажлын шинэ орчныг бий болгох талаар идэвхи, санаачилгатай байвал зохино.

3.5.5.Төрийн захиргааны байгууллагын удирдлага зөвхөн өөрсдөө суралцагч байгууллагын үзэл санаагаар ажилласан үед л ямар нэг өөрчлөлт гарна. Тийм учраас удирдлагын хөгжил бол нэн тэргүүлэх чиглэл байна.

3.6. Мэдлэг чадвар бий болгох арга замын талаар баримтлах бодлого

3.6.1. Хүмүүс, байгууллага нь өөр өөр мэдлэг чадвартай байдаг бөгөөд төрөл бүрийн хэлбэрээр суралцах боломжтой. Иймээс мэдлэг чадварыг бий болгоход төрөл бүрийн өргөн хүрээтэй хандлага, олон янзын арга замыг чухалчилна.

3.6.2. Мэдлэг чадварыг өдөр тутмын ажлын явцад болон зохион байгуулалттай сургалтын хэлбэрийн аль алинаар нь бий болгоно.

3.6.3. Мэдлэг чадвар бий болгохын тулд дараахь шаардлагыг хангасан байна:

- ***Нийцэлт:*** Мэдлэг чадвар бий болгох арга хэмжээ нь төрийн албан хаагчдын болон байгууллагын эрэлт хэрэгцээнд нийцсэн байх ёстой. Үүнийг хангах үүднээс сургалтыг явуулахын өмнө хэрэгцээгээ үнэлэн үзнэ.
- ***Цаг хугацааны хүчин зүйл:*** Зайлшгүй шаардлага гарсан үед нь "зохих цагт нь сурсан" мэдлэг чадварыг ашиглах нь сургалтыг илүү үр ашигтай болгоно. Мөн удирдлага нь ирээдүйг харж, мэдлэг чадварын хэрэгцээг урьдчилан тодорхойлж, түүнийг төлөвлөнө.
- ***Нөөцийг үр ашигтай ашиглах.*** Мэдлэг чадварыг бий болгох явдлыг үр ашиг, үр нөлөөтэй болгохын тулд бүх боломжит нөөцийг ашиглана. Үүнд төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, туршлагыг оролцогчийнх нь хувьд мөн тэдний дотоодын сургагчаар ашиглана. Төрийн захиргаа удирдлагын хөгжлийн институт улсын болон хувийн их, дээд сургууль, коллеж зэрэг сургалтын гадныг байгууллагуудыг төрийн захиргааны байгууллагад шинэ мэдлэг чадвар бий болгох хэрэгцээ хангахад татан оролцуулна.

- ***Оролцох боломжтой байх:*** Мэдлэг чадвар бий болгоход төрийн захиргааны албан хаагч бүр оролцохыг зөвшөөрнө. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн өөр өөр нөхцөл байдал, онцлогийг тусгайлан харгалзан үзнэ.Төрийн захиргааны албан хаагчид сургалт ба мэдлэг чадвар бий болгоход оролцох нь сургалтыг хүртэгсдэд нь ойртуулах хамгийн зардал хямдтай, практик үр дүн сайтай боломж гэж үзнэ.
- ***Урамшуулал:*** Сургалт нь урамшуулан дэмжихийг шаардлаг учраас сэтгэл санаа, нийгэм, эдийн засгийн урамшилтай байна. Ажилтнуудаас ажлын бүюу ажлын бус цагаар өөрсдийнхээ мэдлэг чадварыг өргөтгөх явдлыг урамшуулан дэмжих үүднээс сэтгэл санааны болон эдийн засгийн урамшууллын аль алийг хэрэглэнэ. Жишээлбэл, шинэ чиг үүрэг хүлээх боломж олгох, өндөр цалинтай албан тушаалд дэвшүүлэх, эсвэл удирдлага нь ажилтныхаа амжилтыг хүлээн зөвшөөрч байгаагаа энгийн хэлбэрээр илэрхийлэх, суралцах явдлыг нь хөнгөвчлөх гэх мэт.

3.7. Аэсил дээр мэдлэг чадвар бий болгох талаар баримтлах бодлого

3.7.1. Суралцах нь ажлын байран дээрх өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болсон суралцагч орчинд мэдлэг чадвар хөгжинө. Суралцагч орчин бол хандлагын асуудал бөгөөд хүн бүрийн мэдлэг, туршлагын давуу тал, хэн нэгнийхээ алдаа, оноон дээр суралцахыг чухал гэж үзнэ.

3.7.2. Суралцахад шаардлагатай цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан үзнэ. Бүх түвшний төрийн албан хаагчид хувийн тусгай авах, хоорондоо шүүн хэлэлцэх, мэдлэг, мэдээллээ солилцох, түүнчлэн шинэ санаа, шийдэлд хүрэхэд шаардагдах цаг хугацааг үүнд хамааруулна.

3.7.3. Байгууллагын дотор суралцах нь хувь хүн, булэг, байгууллагын аль алиныг нь хөгжүүлнэ. Тийм учраас дор дурдсан ажлын оролцооны аргыг төрийн захиргааны бүх байгууллагад ашиглахыг өргөжүүлнэ:

- ***Багаар ажиллах:*** мэдлэг, мэдээллээ хуваалцахыг ажлын хэвшмэл хэсэг болгох;
- ***Өдөр тутмын уулзалт:*** хоёр хоёрооро гэсэн зарчмаар ажиллаж, тулгарсан асуудалд хариу өгч, шийдэлд хүрэх замаар суралцах;
- ***Төслийн ажил:*** ажилтны онцгой ур чадвар, ажлын туршлагад нь тулгуурлан тодорхой хугацааны дотор шинэ зүйлийг боловсруулахаар томилон ажиллуулах;
- ***Шийдвэрлэх асуудалд тулгуурлан суралцах:*** ажиллагчид мэдээлэл хайж олж авах, түүнийгээ хуваалцах, туршилт хийж, шийдэлд хүрэх ба төгсгөлд нь шинээр олсон зүйлийнхээ талаар бусаддаа мэдээлэх;
- ***Шавилан суралцах:*** илүү туршлагатай ажилтан нь туршлага багатай нэгэндээ дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
- ***Суралцагчийн хөтөлбөр:*** туршлагатай болох боломж олгохын тулд залуу ажилтнуудыг тухайн байгууллагын бүх газруудад ажиллуулах, ажиглалт хийлгэх;
- ***Ажил сэлгүүлэн ажиллуулах:*** мэдлэг чадвар бий болгох зорилгоор албан хаагчдыг төрөл бүрийн ажлын чиг үүргийг хэрэгжүүлэхээр өөр хооронд нь сэлгүүлэн ажиллуулах.

3.8. Төрийн захиргааны албаны сургалтын талаар баримтлах бодлого

3.8.1. Төрийн захиргааны албаны сургалт нь ажилтны болон удирдлагын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилго бүхий зохион байгуулалттай үйл ажиллагаа мөн гэж үзнэ.

3.8.2. Төрөл бүрийн хүртэгч бүлгийн хэрэгцээг хангах зорилгоор төрийн захиргааны албаны сургалт нь олон төрөл, хэлбэртэй байна.

3.8.3. Төрийн албаны сургалтыг зохион байгуулахад дараахь үзүүлэлтүүдийг харгалзана:

- **Зорилго:** Төрийн захиргааны албаны сургалт нь оролцогчид болон байгууллагын хэрэгцээнд тулгуурласан зорилготой байна. Жишээлбэл, шинээр ажилд авсан хүмүүст танилцуулах сургалт, бие хүний ур чадварыг дээшлүүлэх сургалт, байгууллага өөрчлөгдсөн болон боловсон хүчнийг шилжүүлж ажиллуулсан тохиолдолд давтан сургалт гэх мэт.
- **Түвшин**: Хэрэгцээ, боломжтой нөөцөндөө тохируулан бүх түвшний сургалт (баклавар, магистер, Ph доктор, мэргэшүүлэх, давтан сургах зэрэг) байна.
- **Байршил**: Төрийн захиргааны албаны сургалтыг гол төлөв ажлын байранд, дотоод нөөцөөр юмуу, багш урих замаар зохион байгуулна. Байгуулла-

гын хүрээнд бий болгох боломжгүй шинэ мэдлэг чадварын хэрэгцээ гарсан тохиолдолд гадны байгууллагын сургалтын үйлчилгээг ашиглана. Монгол Улсын төрийн захиргааны байгууллагуудын газар зүйн байршлын онцлогийг харгалзсан дугуйлангийн болон алсын зайн сургалт чухал үүрэгтэй байна. Орон нутаг, бүс нутаг, үндэсний түвшний сургалтын хэлбэрийг хослуулна. Үндэсний хэмжээнд сургах өөр тохирох сонголт байхгүй нөхцөлд гадаадын сургалтыг ашиглана.

- **Багшлах нөөц**: Бүх боломжтой багшлах нөөцийг сургалтад ашиглана. Төрийн албаны ажлын байран дээрх сургалтад хамтран ажиллагчид, менежерүүд, түүнчлэн ижил төстэй байгууллагын ажилтнууд сургагчийн үүргийг гүйцэтгэж болно. Байгууллагын багшлах нөөц хангалттүй үед Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институт, улсын болон хувийн их, дээд сургууль, коллежийн мэргэжлийн багшлах боловсон хүчин амин чухал үүрэгтэй. Сургалтын хэрэгцээ, үр дүнд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, сургалтын зохимжтой хөтөлбөр боловсруулан хөгжүүлэхэд төрийн захиргааны болон сургалтын байгууллага хоорондын нягт харилцан холбоо, хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ.
- **Суралцах боломжийг харгалзах:** Сургалтад хамрах бололцооноос хамааруулан суралцагчдыг аж-лаас нь бүрэн болон хагас чөлөөлж, эсвэл ажиллахын зэрэгцээ суралцах хувилбараар сургалтыг зохион байгуулна.
- **Сурган хүмүүжүүлэх хандлага:** Сургалтыг олон хэлбэрээр явуулна. Жишээлбэл, сургалт-семинар, дугуйлангийн болон алсын зайны сургалт, оройн ба эчнээ сургалт зэрэг хэлбэрийг дангаар буюу хослуулан зохион байгуулж болно. Оролцоо, суралцах явдлыг нэмэгдүүлэх үүднээс олон хэлбэрийн заах аргыг хэрэглэнэ. Тухайлбал бүлгээр ажиллах, жишээн дээр судалгаа, дадлага хийх болон лекц, бие дааж сурах гэх мэт. Сургалтын чиглэл, хандлагыг тухай тухайн тохиолдолд тохируулан тодорхойлох бөгөөд ингэхдээ хүртэгч бүлгийн хэрэгцээ болон цаг хугацаа, боломжит нөөцийг харгалзана.

3.9. Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох ажлын удирдлагын талаар баримтлах бодлого.

3.9.1. Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох нь хүний нөөцийн удирдлагын нэг гол чиг үүрэг мөн.

3.9.2. Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хэрэгцээг хүний нөөцийн төлөвлөгөөгөөр тодорхойлно.

3.9.3. Төрийн захиргааны албаны сургалт нь сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, үнэлгээ хийх гэсэн үе шаттай байна.

3.9.4. Монгол Улсын төрийн захиргааны өөрчлөлт шинэчлэл, төвлөрлийг сааруулах шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны албаны сургалт болон мэдлэг чадвар бий болгох ажлын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэх, түүнчлэн оролцоо, хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албаны сургалтын төвлөрлийг сааруулна.

3.9.5. Төрийн захиргааны албаны сургалтын төвлөрлийг Засгийн газар, төрийн захиргааны байгууллага болон сургалтын байгууллагын хооронд үүрэг хариуцлагын тодорхой зааг тогтоож өгөх замаар сааруулна.

3.9.6. Төвлөрлийг сааруулах зорилгоор төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох талаар доод түвшинд хүлээлгэсэн шинэ үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц чадавхи (цаг хугацаа, мэдлэг чадвар) бий болгоно.

3.9.7. Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох салбарт төвлөрлийг сааруулах ажлыг бусад салбарын, ялангуяа төрийн захиргааны байгууллагын санхүүжилтийн тогтолцоотой уялдуулна.

3.9.8. Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох салбарт төвлөрлийг сааруулах нь урт хугацааны үйл явц юм. Төрийн захиргааны байгууллагуудын өнөөгийн мэдлэг чадвар хязгаарлагдмал, мэдлэг чадвар бий болгох хэрэгцээ их байгаа зэргийг харгалзаж үзвэл, сургалтаар хангахад Засгийн газрын оролцоо ойрын ирээдүйд чухал үүрэгтэй хэвээр байна.

3.10.Төрийн захиргааны албаны сургалтын гүйцэтгэгчид ба тэдгээрийн үүрэг хариуцлагын талаар баримтлах бодлого

3.10.1. Төрийн захиргааны ажилтан бүр мэдлэг чадвар бий болгох үүрэг хариуцлагатай байна.

3.10.2. Төрийн захиргааны албаны сургалтын төвлөрлийг сааруулсан бүтцэд Засгийн газар хэрэгжүүлэх үүрэг хүлээхээсээ илүү чиглүүлэх, дэмжих үүрэг хүлээнэ.

3.10.3. Төрийн захиргааны байгууллагань сургалтыг идэвхгүй хүлээн авагчид биш харин өөрийн байгууллагын хэмжээнд мэдлэг чадвар бий болгох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төрийн захиргааны байгууллага бүр нь мэдээллийг өргөн хүрээтэй солилцож, төрөл бүрийн сургалтын байгууллагуудтай нягт хамтран ажиллана. Ялангуяа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Гэгээрлийн, Сангийн, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын зэрэг яамтай нягт хамтран ажиллахыг чухалчлан үзнэ.

3.10.4. Төрийн захиргааны албаны сургалтын гүйцэтгэгчдийн ирээдүйн үүргийг дараахь байдлаар тодорхойлно:

* **Засгийн газар** *(Төрийн захиргааны албаны эввлэлийг оролцуулан)*:

- Сургалтын бодлогыг тодорхойлж, зорилтуудыг тогтоон, стратегийг томъёолно;
- Зайлшгүй хэрэгцээт сургалтын нөөцөөр хангаж, төвлөрлийг сааруулсан сургалтын болон мэдлэг чадвар бий болгох бусад урьдчилсан нөхцөл бүрдүүлнэ. Жишээлбэл, тохиромжтой хууль зүйн орчин бүрдүүлэх, төрөл бүрийн сургалтын байгууллага бий болгохыг дэмжих г.м.;
- Сургалтын бодлого, стратегийг хэрэгжүүлэхэд нь төрийн захиргааны байгууллагад дэмжлэг үзүүлж, чиглүүлэх;
- Мэдлэг чадвар бий болгохын төлөө төрийн захиргааны байгууллагууд илүү их үүрэг хариуцлага хүлээхүйц чадавхийг бий болгох;

- Сургалтын бодлогын хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;
- Төрийн захиргааны байгууллага хооронд туршлага, мэдээллээ хуваалцаж байх сүлжээ байгуулах;
- Төрийн захиргааны байгууллага өөрөө хариуцаж чадахаргүй сургалт болон мэдлэг чадвар бий болгоход дэмжлэг үзүүлэх;
- Төрийн захиргааны байгууллага, ялангуяа нутгийн захиргааны байгууллагын түвшинд чадавхийг үнэлж дүгнэж байх.

❖ ***Төрийн захиргааны байгууллагууд*** (үүний дотор яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг):

- Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах;
- "Төрийн албан хаагчийн сур-галт" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Сургалтыг дэмжихүйц ажлын аргыг сонгож хэрэглэх болон ажил зохион байгуулах;
- Дангаараа юмуу төрийн захир-гааны холбогдох байгууллагатай хамтран өөрсдийн нөөцөөр гадны сургалтын үйлчилгээг худалдан авах.

❖ ***Сургалтын байгууллага*** (Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийг оролцуулан улсын болон хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежи):

- Засгийн газар, төрийн захиргааны байгууллагуудтай нягт харилцаатай байж төрийн албаны сургалтын өнөөгийн болон хэтийн эрэлт хэрэгцээг мэдэж байх;
- Арилжааны болон бусад замаар төрийн албаны хэрэгцээнд нийцэхүйц сургалтын хөтөлбөр боловсруулж хангах. Жишээлбэл: алсын зайн сургалт, дугуйлангийн сургалт, сургагч бэлтгэх хөтөлбөр, сургалтын материал гэх мэт.

3.11. Төрийн албаны сургалтын нөөцийн талаар баримтлах бодлого

3.11.1. Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох нь хүний, материалын, санхүүгийн гэсэн нөөцийг шаардана. Өөр нэг чухал нөөц бол цаг хугацаа юм. Гэвч эдгээр нөөцийг оновчтой зарцуулах нь төрийн захиргааны албаны үр ашиг, үр нөлөөг улам дээшлүүлнэ.

3.11.2. Монгол Улсын Засгийн газрын хэрэгцээт санхүүгийн нөөц хязгаарлагдмал учир төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгоход зардал хэмнэхийг чухалчлан үзнэ.

Ажлын байран дээрх сургалт, орон нутаг дахь дугуйлангийн болон алсын зайны, ажлын байран дээрх сургалт зэрэг зардал хямдтайгаар мэдлэг чадвар бий болгох нийтлэг арга замыг эрхэмлэнэ.

3.11.3. Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгоход санхүүжилтийн хүлээн авч болохуйц эх үүсвэрүүд нь:

- Төвлөрсөн төсөв;

- Орон нутгийн төсөв;
- Төрийн захиргааны байгууллагын төсөв;
- Олон улсын хамтын ажиллагааны сайн санааны санхүүжилт;
- Төрийн албан хаагчдын өөрсдийнх нь хандив байна.

3.11.4. Төрийн захиргааны албыг нийтлэг үүрэг хариуцлагынх нь дагуу ажиллуулахын тулд Засгийн газар нь төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгоход зориулан шууд буюу доод түвшний төлөөллөөр дамжуулан төрийн захиргааны байгууллалагуудыг санхүүжилтийн тогтолцоотой уялдуулан санхүүжүүлэх үүрэг хүлээнэ.

3.11.5. Хоёр болон олон талын хамтын ажиллагааны хүрээнд харилцан тохиролцсоны үндсэн дээр гаргаж байгаа буцалтгүй тусламж, техникийн туслалцаа нь төрийн албаны сургалтын нэг эх үүсвэр болно.

3.11.6. Зарим онцгой тохиолдолд төрийн албан хаагчид өөрсдөө сургалтад зориулж санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

Дөрөв. Стратеги

4.1. Стратегийн агуулга

Стратеги нь хөтөлбөрийн бодлогыг хэрэгжүүлэх практик удирдамж болно.

Стратеги нь төрийн захиргааны албаны өнөөгийн дүр төрхөөс ирээдүйн дүр төрхөд хүрэхэд шаардлагатай арга, нөөцийг багтаасан байна. Стратегийг хөтөлбөрийн алсын хараа ба бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гарааны цэг гэж үзнэ.

Төрийн албан хаагчид нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх хангалттай мэргэжлийн, нийгмийн, үйл ажиллагааны мэдлэг чадвартай байх явдлыг хангахуйцаар стратегийн чиглэлийг боловсруулахыг чухалчилна.

4.2. Стратегийг боловсруулж хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт

Төрийн захиргааны албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөрийн стратегийг яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн оролцоотойгоор тухайн төрийн захиргааны байгууллага нөхцөл байдалдаа нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлнэ.

Тав. Үр дүн

5.1. Төрийн албаны сургалтын төвлөрлийг сааруулна.

5.2. Сургалтын хэрэгцээгээ төрийн албан хаагч өөрөө, байгууллагын сургалтын хэрэгцээг байгууллагын удирдлага, ажилтан хамтран тодорхойлдог болно.

5.3. Сургалтын агуулгыг суралцагчдын болон байгууллагын хэрэгцээнд тулгуурлан боловсруулдаг арга зүйд шилжинэ. Ингэснээр сургалтын агуулгыг амьдралд ойртуулна.

5.4. Хувь хүний мэдлэг чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг чадвар, туршлага болгож хөгжүүлэх бөгөөд ингэснээр төрийн байгууллагыг суралцагч байгууллага болгон хөгжүүлнэ.

5.5. Шинэ мэдлэг чадвар, туршлага бий болгосноор сайн үйл ажиллагаатай төрийн албыг төлөвшүүлнэ.

Засгийн газрын нэр хүнд, иргэдээс Засгийн газарт итгэх итгэлийг бий болгоно.

5.6. Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтээс гадна улсын болон хувийн их, дээд сургууль, коллеж сургалтын бусад байгууллагын чадавхийг төрийн албаны сургалтад ашигладаг болно.

5.7. Байгууллагын дотоод нөөцийг ашиглаж, ажлын байран дээрх сургалтыг хөгжүүлнэ.

Телевиз, радио болон компьютерийн сүлжээг ашиглан алсын зайны сургалтын тогтолцоо бий болгоно.

Орон нутаг, бүс нутгийн хүрээнд төрийн албаны мэдлэг чадвар бий болгох тогтолцоо бий болно.

Энэ бүхний үр дүнд сургалтыг суралцагчдад ойртуулж, тэдний сурч хөгжих бололцоо улам илүү бүрдэнэ.

5.8. Сургалтын хяналт-шинжилгээний үнэлгээний арга зүйг нэвтрүүлнэ. Ингэснээр сургалтын үр дүнг сайжруулах чиглэлээр эргэх холбоог бий болгоно.

5.9. Төрийн албаны дээд тушаалын албан хаагчдыг дотооддоо сургах чадавхи бий болгохоос гадна гадаадын сургалтыг улам өргөн ашиглана.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн эрхлэгч
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны наймдугаар сарын 18 №38 (117)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

358. Ажлын хэсэг байгуулах тухай Дугаар 97 719
359. Хөтөлбөр батлах тухай Дугаар 98 720
360. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 1999 онд санхүүжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний тухай Дугаар 99 725
361. Дүрмүүд батлах тухай Дугаар 100 730
362. "Махны экспорт" төслийн тухай Дугаар 101 735
363. Бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 103 735

Хоёр. Яам, агентлагийн акт

364. Журам батлах тухай (Монгол Улсын Сангийн сайдын тушаал) Дугаар 65 736

Монгол Улсын Засгийн газрын тогтоол

1999 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 97 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хооронд байгуулсан БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ураны орд уудыг ашиглах тухай 1981 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Хэлэлцээрийн 7 дугаар зүйл, мөн Хэлэлцээрийг хүчингүй болгох тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд ын Протоколыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Мардайн ураны "Эрдэс" үйлдвэрийн үндсэн хөрөнгө, дэд бүтэц, уурхай, нийгэм соёлын объектууд болон Мардайн бүлэг ордуудын геологийн баримт бичгүүдийг Монголын талд хүлээн авах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч -Төрийн өмчийн хороо-ны дарга Д.Зоригт

Гишүүд: -Дорнод аймгийн Засаг дарга Л.Сүхбаатар;
-Хөдөө аж ахуй, Үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Бямбаа;
-Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга О.Очиржав;
-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Баасанхүү;

-Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дарга Д.Жаргалсайхан;
-Сангийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Д.Чимэддагва;
-Гадаад харилцааны яамны эрх зүйн газрын дарга Г.Сэсээр;
-Хууль зүйн яамны Эрх зүйн бодлогын хэрэг жилтийг зохицуулах газрын дарга М.Төрбаяр;
-Дэд бүтцийн хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батжав;
-Дэд бүтцийн хөгжлийн яамны Стратеги төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын мэргэжилтэн А. Цогт;
-Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ш. Энхбат;
-Гэгээрлийн яамны Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга Л.Батгулга;
-Төрийн өмчийн хорооны хамтарсан үйлдвэрүүдийн газрын албаны дарга Ц. Батцэрэн;
-Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын улсын ахлах байцаагч Д. Содном;
-Хөдөө аж ахуй,үйлдвэрийн яамны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын мэргэжилтэн А.Готовсүрэн
-Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын уул уурхайн албаны дарга Ц.Энхболд;
-Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын геологийн албаны дарга О.Чулуун.

Нарийн бичгийн дарга -Төрийн өмчийн хорооны төрийн өмчийн байгууллагын хангамж, эд хөрөнгийн бүртгэлийн газрын дарга Л.Энхтөр.

2.Ажлын хэсгийн ахлагч Д.Зоригтод даалгах нь:

а/Мардайн ураны "Эрдэс" үйлдвэрийн үндсэн хөрөнгө, дэд бүтэц, уурхай, нийгэм соёлын объектуудыг хэрхэн ашиглах чиглэл, санхүүжүүлэх эх үүсвэрийн талаар санал боловсруулж Засгийн газарт энэ оны 6 дугаар сард багтаан танилцуулсугай;

б/үйлдвэрийн үндсэн хөрөнгө болон геологийн баримт бичгүүдийг хүлээн авах бэлтгэлийг хангаж, Засгийн газар хоорондын Протоколд заасан хугацаанд газар дээр нь хүлээн авч үр дүнг Засгийн газарт танилцуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

Монгол Улсын
Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Хөдөө аж ахуй,
үйлдвэрийн сайд Ч. СОДНОМЦЭРЭН

Монгол Улсын Засгийн газрын тогтоол

1999 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 98 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Бөөний худалдааны сүлжээ" хөтөл-бөрийг 1 дүгээр хавсралтын, уг хөтөлбөрийг зохион байгуулж хэрэгжүү-лэх Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батална сугай.

2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд холбогдох яам, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, үйл ажиллагаа нь хугацаатайгаар төлөвлөн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт тайлагнаж байхыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд бегөөд Үндэсний зөвлөлийн дарга Ч.Содномцэрэн, хөтөлбөрийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Бөөний худалдааны сүлжээг төв болон орон нутагт байгуулах, холбогдох төслүүдийг хэрэгжүүлэх талаар 1999 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдах хандивлагч орнуудын уулзалтын үеэр сонирхогч орон, олон улсын байгууллагад санал болгохыг Гадаад харилцааны сайд Н.Туяа, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт даалгасугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Хөдөө аж ахуй,
үйлдвэрийн сайд Ч.СОДНОМЦЭРЭН

Засгийн газрын 1999 оны 98 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ СҮЛЖЭЭ" ХӨТӨЛБӨР

Нэг.Худалдааны өнөөгийн байдал

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр худалдааны төвлөрсөн сүлжээ задарч, төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын зэрэгцээ хувийн компани, байгууллага, жижиг худалдаанд олноор бий боллоо.

Төрийн өмчийн оролцоотой бөөний худалдаанд 6 том компаниас гадна Улаанбаатар хот, Дархан-уул, Орхон аймаг, бусад томоохон хот, суурин газарт худалдааны төв, супермаркет, хүнсний болон барааны захууд нээгдэн үйл ажиллагаагаа явуулж байна. Зөвхөн Улаанбаатар хотод барааны зах 4, хүнсний зах 20, түүхий эдийн зах 3, техникийн зах 1, түлш, модон материалын зах 1, бөөний худалдааны цэг 38, их дэлгүүр 6 ажиллаж байна.

Гэвч улсын хэмжээнд худалдаа, үйлчилгээ жигд тогтвортой хөгжих чадахгүй байна.

Хоёр.Бөөний худалдааны сүлжээг бий болгох нийгэм, эдийн засгийн шаардлага

1."Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөр нь худалдааны талаар төрөөс баримтлах бодлогын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бөөний худалдааны сүлжээг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн шаардлага нь дараахь нөхцөл байдлаас урган гарч байна:

а/ерөнхий уудам нутаг дэвсгэртэй, хүн ам нь сийрэг суурьшсан манай орны хувьд хөдөөгийн, ялангуяа алслагдсан бүс нутгийн хүн амын хэрэгцээг жигд хангаж, тэдэнд үзүүлэх худалдаа, үйлчилгээг тогтмолжуулж, тоо хэмжээг нэмэгдүүлэх;

б/үйлдвэрлэгч, хэрэглэгч, худалдагч, худалдан авагчийн хооронд үзлэдаа холбоог сайжруулж, түхайн бүс нутгийн хөгжлийн онцлогтой уялдуулан худалдаа, үйлчилгээг зөв зохистой хөгжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.Хөтөлбөрийн зорилго нь худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээ байгуулах замаар зах зээлийн зарчимд тулгуурласан бөөний худалдааны сүлжээний эдийн засаг, эрх зүй, зах зээлийн таатай орчин бүрдүүлэхэд оршино.

3.Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан зорилтуудыг шийдвэрлэнэ:

а/мэдээлэл хангамжийн таатай орчин бүрдүүлэх хүрээнд:

Манай улсад суурилагдсан орчин үеийн мэдээллийн техник, технологийн хүчин чадалд тулгуурлан худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээг бий болгож, хэрэглэгчид мэдээллээ чөлөөтэй солилцох боломжийг бүрдүүлэх;

б/эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх хүрээнд:

Мэдээллийн сүлжээгээр дамжуулан худалдаа үйлчилгээг түргэн шуурхай зохион байгуулах нөхцөлийг боловсронгуй болгох;

в/зах зээлийн таатай орчныг бүрдүүлэх хүрээнд:

Урьд өмнө суурилагдсан мэдээллийн сүлжээний үйлчлүүлэгчидийн тоог өргөжүүлэх;

г/эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд:

Худалдаа эрхлэгчдийн мэдээллийн сүлжээ ашиглах үйл ажилллагаг боловсронгуй болгох, үүргэ хариуцлагыг дээшлүүлэх эрх зүйн баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх.

4.Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дор дурдсан үйл ажилллагаг тэргүүн ээлжинд дэмжинэ:

а/худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээгээр дамжуулан хөдөө орон нутаг, алслагдсан бүс нутагт бөөний худалдааны сүлжээ байгуулах зорилгоор байгууллага, иргэд болон олон улсын байгууллагаас боловсруулсан хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх;

б/бүс, орон нутаг, сум, багийн худалдаа үйлчилгээний мэдээллийн салбар сүлжээнүүдийг байгуулах;

в/худалдаа, үйлчилгээний дэвшилтэт арга, техник технологийн сургалт, сурталчилгаа явуулах.

Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим

5.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь үндсэн зарчмыг мөрдлөг болгоно:


а/худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээг 1 дүгээр зураг үзүүлсэн байдлаар байгуулна;

б/сүлжээг байгуулахад иргэд, байгууллагын сайн дурын идэвхтэй үйл ажиллагаа, оролцоғ талуудын ил тод, тэгш байдлыг эрхэмлэнэ;

в/хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх шаардлагыг бүрэн ханган аж ахуйн нэгжийг өмчийн хэлбэр үл харгалзан мэдээллийн төв байгууллагаар сонгоно.

1 дүгээр зураг

Худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээний бүдүүвч



Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

6.Худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээг байгуулахад төрөөс баримтлах бодлогын хүрээнд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам дараахь арга хэмжээ авна:

а/бөөний худалдааны сүлжээг хэрэгжүүлэх мэдээллийн байгууллагыг сонгон тодорхой нөхцөл бүхий гэрээ байгуулж ажиллуулах;

б/"Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ыг харгалзан бөөний худалдааны сүлжээ байгуулах, зураасан кодын системийг хэрэгжүүлэх бодлогод эрх зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох журмыг боловсруулж хэрэгжүүлэх;

в/худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээ байгуулах зорилгоор иргэд, байгууллагаас боловсруулсан төслийг хэрэгжүүлэхэд эдэмжлэг үзүүлж, хөрөнгө оруулалт хийх, хамтран ажиллах гадаад, дотоодын түнш олоход зуучлах, холбогдох байгууллагад уламжлах, хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг судлан Сангийн Яам, Монгол банктай хамтран шийдвэрлэх;

г/олон улсын худалдааны байгууллагын тэргүүний стандартыг өөрийн орны нөхцөлд зохицуулан хэрэглэх, одоо мөрдөж буй стандартыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх ажлыг Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвтэй хамтран зохион байгуулах;

д/"Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, хот хоорондын тээвэр, холбоо, бусад төрлийн үйлчилгээг худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээгээр дамжуулан Дэд бүтцийн хөгжлийн яамтай хамтран зохион байгуулах, холбогдох мэдээлэл зуучлалын төвүүдийг байгуулж ажиллуулах.

7.Аймаг, нийслэлийн засаг захиргааны байгууллага:

а/аймаг, нийслэлийн түүхий эдийн нөөц, хэрэглээний бүтэц, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд үндэслэн бөөний худалдааны сүлжээ байгуулах дэд хөтөлбөрийг аймаг, нийслэл, сумын хэмжээнд боловсруулан хэрэгжүүлэх;

б/худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээний салбар төвүүдийг байгуулж, түүнд сонирхогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татан оролцуулах, төвийн сүлжээтэй холбох ажлыг зохион байгуулж, байнгын үйлчилгээгээр хангах;

в/мэдээллийн төвүүдийг түшиглэн бөөний худалдааны цэг, биржүүдийг иргэд, байгууллагын санааачилгад тулгуурлан байгуулах.

8.Төрийн бус байгууллагууд:

а/худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээнд шаардлагатай мэдээллийн санг дотоод, гадаадын төрийн болон хувийн өмчийн байгууллагуудын оролцоотойгоор бий болгох;

б/худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагааг сурталчлах, тэрүүний шилдэг хэлбэрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд нь туслаж үзүүлж, холбогдох сургалт, семинарыг зохион байгуулах;

в/олон улсын байгууллага болон компаниудын харилцааг хөгжүүлэхэд идэвхтэй зуучилж, яармаг, үзэсгэлэнгийн талаархи танилцуулга, **мэдээллийг нийтэд таниулах** үйл ажиллагааг өргөжүүлэх.

9.Аж ахуйн нэгж, байгууллагууд:

а/аж ахуйн нэгж, байгууллагууд нь худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээ болон бүс, орон нутаг, хөдөөд худалдааны цэг, төв байгуулахад идэвхтэй оролцогч, хэрэгжүүлэгч үндсэн нэгж байна;

б/төрөөс баримтлах бодлогын хүрээнд худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээгээр дамжуулан өөрсдийн сонгон авсан бүс, орон нутагт худалдааны төв, цэг байгуулахад хөрөнгө оруулалт хийх, худалдаа үйлчилгээг өргөжүүлэх;

в/худалдаа, үйлчилгээний мэдээллийн сүлжээний үйл ажиллагааг өргөжүүлэх, мэдээллийн санг арвижуулахад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

г/төв, орон нутагт одоо ажиллаж буй худалдааны цэг, биржийг мэдээллийн сүлжээтэй холбох ажлыг зохион байгуулах;

д/худалдаа үйлчилгээнд штрих кодын системийг худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээтэй хамт хэрэгжүүлэх.

Зургаа.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

10.Хөтөлбөрийг 1999-2004 онуудад дор дурдсан үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

1 дүгээр үе шат: 1999-2001 он. Худалдаа үйлчилгээний мэдээллийн төвийн сүлжээ байгуулах.

2 дугаар үе шат: 2002-2004 он. Орон нутгийн худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээ байгуулах.

Долоо.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

11.Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих асуудлыг Үндэсний зөвлөл гүйцэтгэнэ.

12.Үндэсний зөвлөл нь орон нутгийн салбар зөвлөлтэй байна. Орон нутгийн салбар зөвлөлийг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга байгуулна.

13.Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг түүний дүрмээр зохицуулна.

14.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар орон нутгийн салбар **зөвлөл эдийн засаг, нийгмийг** хөгжүүлэх үндсэн чиглэлийн хамт Үндэсний зөвлөлд хагас жилд нэг удаа, Үндэсний зөвлөл Засгийн газарт жилд нэг удаа тус тус тайлагнана.

15.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр нь худалдаа эрхлэгчид, сонирхогч байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө байх бөгөөд мэдээллийн санг бий болгох, төрийн байгууллагыг сүлжээнд

холбох зэрэг зарим арга хэмжээнд санхүүгийн дараахь эх үүсвэрийг ашиглана:

а/орон нутгийн төсөв;

б/олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж;

в/бусад.

Найм.Хөтөлбөрийн үр дүн

16.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

а/манай улсын аймаг, нийслэл, сум, дүүргийг хамарсан худалдаа үйлчилгээний мэдээллийн сүлжээ бий болно;

б/хөдөө, алслагдсан бүс нутгийн хүн амыг бараа, бүтээгдэхүүнээр найдвартай, тогтвортой хангах худалдааны бөөний төвүүд үүсэн байгуулагдахын хамт одоогоор үйл ажиллагаагаа явуулж буй байгууллагуудын үйлчилгээний хүрээ тэлж, хүн амын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг тогтмол хангах нөхцөл бүрдэнэ;

в/худалдааны салбарын бүтэц, зохион байгуулалт боловсронгуй болж, үйлчилгээний соёл дээшилнэ.

Засгийн газрын 1999 оны 98 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"БӨӨНИЙ ХУДАЛДААНЫ СҮЛЖЭЭ" ХӨТӨЛБӨРИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд

Гишүүд:
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;
-Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дарга;
-Үндэсний статистикийн газрын дарга (тохиролцсоноор);
-Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга;
-Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын яамны Мэдээлэл,хяналт-шинжилгээ,үнэлгээний газрын дарга;
-Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, хамтын ажиллагааны газрын орлогч дарга;
-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын үйлдвэр, худалдааны албаны дарга;
-Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор);
-Монголын хөрөнгийн биржийн захирал;
-Аж үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
-Бизнес хөгжлийн агентлагийн дарга (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга -Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Салбарын бодлого **зохицуулалтын газрын дарга**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 99 | Улаанбаатар хот

Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 1999 онд санхүүжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний тухай

"Монгол Улсын 1999 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 1999 онд санхүүжүүлэх барилга байгууламж,төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр хавсралтын, улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтын зориулалтаар Замын сангаас болон төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх зам, гүүрийн жагсаалтыг 2 дугаар хавсралтын, өмч хувьчлалын орлогоос төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хуваарийг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус батлалсугай.

2.Өмч хувьчлалыг шуурхай, далайцтай зохион байгуулан түүний орлогыг энэ тогтоолын 3 дугаар хавсралтад заасан хугацаанд дагуу улсын төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт, өмч хувьчилснаас орсон орлогыг зөвхөн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд зарцуулахыг Сангийн сайд Я.Очирсүхэд тус тус даалгасугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Сангийн сайд Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 1999 оны 99 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 1999 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая.төг)

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжүүлэх хугацаа	Төсвийн өртөг	1999 оны санхүүжилт	Захиалагч
I	110 кВ-ын шугам, дэд өртөө				
1	Чойбалсан-Баруун-урт, 1х10; 1х6.3мва, 185.75 км	1998-1999	4201.0	1200.0	ДБХЯ
II	35,10, 06 кВ-ын шугам, дэд өртөө				
1	Иххэт-Алтанширээ, 35 кВ, 1х0.4 мва, 102 км, Дорноговь	1998-1999	1100.0	946.0	-"-
2	Сагсай-Цэнгэл, 10 кВ, 1х0.4 мва, 37 км, Баян-өлгий	1999	225.0	225.0	-"-
3	Луус-Эрдэнэдалай, 35 кВ, 1х1 мва, 85.6 км, Дундговь	1999-2000	1039.0	740.2	-"-
4	Бүрэн-Дэлгэрхаан, 35 кВ,1х1 мва, 50 км, Төв	1999	776.0	776.0	-"-
5	Мянгад-Эрдэнэбүрэн, 35 кВ, 1х04 мва, 58,2 км, Ховд	1999-2000	641.0	312.0	-"-
6	Баянгол-Сайхан-овоо, 35 кВ, 1х0.4 мва, 55 км, Дундговь.	1999-2000	688.0	235.0	-"-
7	Луус-Хулд, 35 кВ, 1х1 мва. 35 км, Дундговь.	1999	526.0	526.0	-"-
8	Баянгол-Сант 10кВ, 1х0.4 мва, 50 км, Өвөрхангай.	1999-2000	200.0	70.0	-"-

9	Өмнөдэлгэр-Гурванбаян, 10 кВ, 1х0.4 мва, 48 км, Хэнтий	1999	177.0	177.0	-"-
10	Баянхонгор-Шаргалжуут, 10 кВ, 1х0.4 мва, 32.3 км, Баянхонгор	1999	200.0	200.0	-"-
11	Улаангом-Сагил, 35 кВ, 1х 04, 14 км, Увс	1999	100.0	100.0	-"-
12	Ханх-Монд, 10 кВ, 1х0.4 мва, 22 км, Хөвсгөл	1999	80.0	80.0	Аймгийн ЗДТГ
13	Мардай-Дашбалбар, 10 кВ, 1х0.16 мва, 55 км, Дорнод	1999	90.0	90.0	-"-
	ДҮН		10043.0	5677.2	
Ш	**Дулааны станц, төвлөрсөн зуух**				
1	Дапанзадгадын дулааны станцын Монголын талын хөрөнгө	1998-2000	1133.0	858.0	ДБХЯ
2	Дорнодын станцын шинэчлэлийн Монголын талын хөрөнгө	1998-2000	1000.0	500.0	-"-
3	III,IV цахилгаан станцын шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө	1997-1999	10032.0	1000.0	-"-
4	Төвлөрсөн зуухны даусгал, 2хКВТС-20, Зуунмод	1995-1999	1175.0	400.0	-"-
5	Дапанзадгадын дулааны станцын инженерийн гадна шугам сүлжээ	1999-2000	1000.0	500.0	ДБХЯ
6	Орон сууцны дулааны гадна шугам, ф-1000 мм, 6.3 км, Улаанбаатар	1999-2000	2000.0	300.0	Нийслэлийн ЗДТГ
	ДҮН		16340.0	3558.0	
IҮ	**Агаарын тээвэр**				
	Нисэх онгоцны буудлын барилга, Баян-өлгий	1999-2000	828.9	400.0	ДБХЯ
	ДҮН		828.9	400.0	
Ү	**Хөдөө аж ахуй**				
	"Улаанбуудай" сан	1999	1000.0	1000.0	ХААҮЯ
	ДҮН		1000.0	1000.0	
ҮІ	**Хот, нийтийн аж ахуй**				
1	Орон нутгийн нийтийн аж ахуйг хөгжүүлэх төслийн Монголын талын хөрөнгө	1998-2001	714.0	304.0	ДБХЯ
2	Цэвэрлэх байгууламж, 2100 м3/хон. Мандалговь	1998-1999	460.0	260.0	-"-
3	Цэвэр усны эх үүсвэрийн барилга, шугам, 2400 м3/хон. Баянхонгор	1997-1999	505.0	141.0	-"-
4	Марксын гудамжнаас Энхтайваны өргөн чөлөө хүртэлх цэвэр усны 0.7 км шугамыг 400 мм болгон өргөтгөх, Улаанбаатар	1998-1999	162.9	70.0	Нийслэлийн ЗДТГ
5	Цэвэрлэх байгууламжийн даусгал, Хөтөл	1999	130.0	130.0	ДБХЯ
6	Цэвэр усны шугам, 2700 м3/хон, Өвөрхангай	1999	175.0	175.0	-"-
7	Аймгуудын хлоржуулах систем	1998-1999	50.0	50.0	-"-
	ДҮН		2196.9	1130.0	
ҮП	**Орон сууц**				
	УИХ-ын гишүүд болон Тамгын газрын ажилтнуудад байгуулагын мэдлийн байр худалдан авах	1999	60.0	60.0	УИХ ТГ
	ДҮН		60.0	60.0	
ҮШ	**Боловсрол**				
1	Сургууль, 1176 суудал, Эрдэнэт	1998-1999	1353.8	869.8	Аймгийн ЗДТГ
2	Сургуулийн даусгал, 640 суудал, Үүлбаян сум, Сүхбаатар	1999	100.0	100.0	-"-
3	Сургуулийн даусгал, 320 суудал, Чойбалсан	1999	117.0	117.0	-"-
4	Сургуулийн барилга, 240 суудал, Цахир сум, Архангай	1999-2000	240.0	120.0	-"-
5	Сургуулийн даусгал 640 суудал, Зүүнговь сум, Увс	1998-1999	50.0	50.0	-"-
6	Хөдөө аж ахуйн МСҮТ-ийн барилга, Увс	1999-2000	240.0	140.0	-"-
7	Сургуулийн барилга, 240 суудал,Цогт-овоо сум, Өмнөговь	1999-2000	200.0	100.0	-"-
8	Бага сургуулийн барилга, Хөвсгөл, Мөрөн	1999	30.0	30.0	-"-
9	Сургуулийн барилгын даусгал, Сайхандулаан, Айраг сумд, Дорноговь	1999	76.0	76.0	-"-

10	Сургуулийн барилга 350 суудал, 13-р хороолол, Улаанбаатар	1999-2000	250.0	150.0	Нийслэлийн ЗДТГ
11	"Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийн монголын талын зардал	1999-2001	448.8	133.0	ГЯ
12	Төсвийн байгууллагуудын нэгдсэн контор, цэцэрлэгийн барилгын дуусгал, Ноён сум, Өмнөговь	1999	48.0	48.0	Аймгийн ЗДТГ
	ДҮН		3153.6	1933.8	
IX	**Эрүүл мэнд**				
1	«Эрүүл мэндийн салбарын хөгжил» төслийн Монголын Ховд, Хөвсгөл, Дорноговь, Улаанбаатар	1998-2002	2644.3	635.0	ЭМНХЯ
2	Нэгдсэн П эмнэлгийн эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө	1999	223.0	223.0	-"-
	ДҮН		2867.3	858.0	
X	**Түүх, дурсгал, спорт**				
1	«Эрдэнэ зуу» төслийн дагуу сэргээн засварлах	1997-2000	200.0	50.0	ГЯ
2	Спорт цогцолборын дуусгал, Алтай хот	1999	238.0	238.0	Аймгийн ЗДТГ
	ДҮН		438.0	288.0	
XI	**Нийгмийн хэв журам, аюулгүй байдал**				
1	Галын депо, 5 машины гараж, Булган	1999	150.0	150.0	ЦЕГ
2	Цагдаагийн хэлтэс, цагдан хорих байр, Ховд	1999	100.0	100.0	-"-
3	Цагдаагийн хэлтэс, цагдан хорих байр, Улаангом	1999-2000	560.0	55.0	-"-
4	Ганц худагийн урьдчилан хорих байр	1999-2000	400.0	245.0	-"-
	ДҮН		1210.0	550.0	
XII	**Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар**				
1	Ажлын байр бий болгох, Дархан	1998-1999	195.0	97.0	ШШБЕГ
2	Нүүрсний уурхайн хөрс хуулалт, Хөвсгөл	1999	17.0	17.0	-"-
	ДҮН		212.0	114.0	
XIII	**Батлан хамгаалах**				
1	Хоолны газар, Штабын барилгын дуусгал, Ховд	1998-1999	155.0	75.0	БХЯ
2	Бригадын цэргийн байр, Өвөрхангай	1999	150.0	150.0	-"-
	ДҮН		305.0	225.0	
XIV	**Хилийн цэрэг**				
1	Тарь-нуурын застав, Дорнод	1999	86.0	86.0	ХЦҮГ
2	Асгатын застав, Увс	1999	109.0	109.0	-"-
3	Хайрханы застав, Увс	1999	84.0	84.0	-"-
4	Тамсагбулагт хилийн отряд байгуулах, Дорнод	1999-2000	735.0	150.0	-"-
	ДҮН		1014.0	429.0	
XV	**1998 онд гүйцэтгэсэн ажлын санхүүжилт**	1999	280.0	280.0	СЯ
XVI	**Тоног, төхөөрөмж**	1999	1852.0	1582.0	-"-
XVII	**Их засвар**	1999	1568.3	1568.3	-"-
XVIII	**Замын сан**	1994-2001	24226.2	8842.0	ДБХЯ
	Үүнээс: төвлөрсөн төсвийн санхүүжилт			4069.1	
XIX	**Гаалийн сан**	1998-1999	2410.0	2410.0	УГЕГ
	Хөрөнгө оруулалтын нийт дүн		**70005.2**	**30905.3**	

Засгийн газрын 1999 оны 99 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТААР ЗАМЫН САНГААС БОЛОН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАМ, ГҮҮРИЙН ЖАГСААЛТ

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хүч чадал	Барих хугацаа	Төсөвт өртөг	1999 оны санхүүжүүлэх хэмжээ	Үүнээс: Замын сан	Үүнээс: Улсын төсөв	Ашиглалтад оруулах: Хүч чадал	Ашиглалтад оруулах: Улирал
А	1	2	3	4	5	6	7	8	9
	Нэг. Хатуу хучилттай зам								
1	Хөндлөн гол тэнхлэгийн баруун чиглэлийн зам. (Элсэнтасархай-Хархорин)	31,6 км	1998-1999	2462.6	1400	1200	200	31,6 км	Ш
2	Замын-үүд	3,2 км	1996-2000	228.9	57	57			
3	Багануурын чиглэлийн зам	37,5 км	1999-2000	2625	149.7	0	149.7		
	Хоёр. Хайрган зам, гүүрийн засвар								
1	Өвөрхангай - Баянхонгор (Тариц, Арц, Тээл голын гүүр, Гарьд орчмын засвар)	20,6 км	1995-2000	1890	250	0	250		
	Гурав. Төмөр бетон гүүр								
1	Говь-алтайн Тайшир, Завхан гол.	222 м	1995-1999	451	234.5	234.5		222м	Ш
2	Архангайн Өлзийт, Орхон гол.	171м	1996-1999	571.3	289.9	289.9		171м	Ш
3	Хэнтийн Норовлин, Улз гол.	77,8м	1996-1999	436.2	251	251		77,8м	Ш
4	Хөвсгөлийн Галт, Идэр гол.	162,9 м	1997-2000	280	100	0	100		
5	Сэлэнгэ Зүүнхэрэа, Хараа гол.	170 м	1993-2000	510	131.3	131.3			
6	Архангайн Цахир, Тэрхийн гол.	217,5 м	1996-1999	436.5	239.8	239.8		217,5м	Ш
7	Завханы Баянтэс, Тэсийн гол.	144,9 м	1995-2000	440.1	220		220		
8	Баян-өлгийн Сагсайн гол.	90 м	1998-1999	224	161.9	161.9		90м	IУ
9	Булганы Тэшиг, Эгийн гол.	289,3м	1994-2000	1137.2	212.9	0	212.9		
10	Увс, Гашуунын гол.	150 м	1999-2000	277.6	100	0	100		
11	Хөвсгөл, Их-Уул, Зүлэгтийн гол.	54 м	1996-1999	237.1	146.6	146.6		54 м	Ш

А	1	2	3	4	5	6	7	8	9
	Дөрөв. Модон гүүр								
1	Дорнод Эрээнцав, Улз гол	87,8 м	1999-1999	70	70	0	70	87.8	IY
	Тав. "Авто замын хууль" -ийн дагуу санхүүжүүлэх бусад арга хэмжээ, зам засварт		1999-1999	400	400	350	50		
	Зургаа. Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Кувейтийн сангийн зээлээр хэрэгжих төслийн дотоод эх үүсвэр								
1	Дархан-Эрдэнэтийн хатуу хучилттай замын Кувейтийн сангийн зээлийн Монголын талын хөрөнгө	184 км.	1996-2000	5084	1568.3	1538.9	29.4		
2	Кувейтийн сангийн зээлийн хүүгийн төлбөр		1999-1999	230	172	172			
3	Улаанбаатар-Дархан-Алтанбулагийн замын өргөтгөл, шинэчлэлтийн (Орхон, Бургалтайн т/б гүүрийн хамт) Азийн хөгжлийн банкны зээлийн Монголын талын хөрөнгө	312 км.	1997-2000	5330	2199.1		2199.1		
4	Хөрхорин-Цэцэрлэг-Тосонцэнгэлийн хэсэгчилсэн хайрган замын Дэлхийн банкны зээлийн Монголын талын хөрөнгө	80 км.	1997-1999	1104.7	488		488		
	ДҮН				8842	4772.9	4069.1		

Засгийн газрын 1999 оны 99 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

1999 ОНД ТӨРИЙН ӨМЧ ХУВЬЧИЛСНААС ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭХ ҮҮСВЭРТ ТӨВЛӨРӨХ ХӨРӨНГИЙН ХУВААРЬ

(сая төгрөг)

Төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ	Эхний 5 сарын гүйцэтгэл	II улирал	III улирал	IY улирал
23000.0	3874.8	1580.0	7545.6	10000.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 100 | Улаанбаатар хот

Дүрмүүд батлах тухай

Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийг 1 дүгээр хавсралтын, "Барилгын техникийн улсын хяналтын дүрэм"-ийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлалсугай.

2.Барилга байгууламжид хувийн хэрэг хөтлөх, улсын гэрчилгээ олгох ажлыг 2002 онд багтаан хийхийг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Хууль зүйн сайд Л.Цог, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хяналтын дүрмүүд батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 211 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.БАТХҮҮ

Засгийн газрын 1999 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Ерөнхий зүйл

1.Энэ дүрэм нь Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдсан инженерийн хийцтэй бүх төрлийн барилга байгууламжийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2.Энэ дүрмийн зорилт нь барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцөл, найдвартай ажиллагааг хангах, хүгацаанаас өмнө элэгдэж хуучрахаас хамгаалах, зориулалтаар нь зөв зохистой ашиглах ерөнхий шаардлагыг тогтоох, барилга байгууламжийн техникийн хувийн хэрэг /цаашид "хувийн хэрэг" гэнэ/ хөтлөх, улсын бүртгэлд бүртгэх журмыг тогтооход оршино.

3.Барилга байгууламжийн ангилал, зориулалт болон техник технологийн онцлогоос шалтгаалан ашиглагдах тавигдах нэмэлт шаардлагыг энэхүү дүрэмд нийцүүлж барилгын асуудал эрхэлсэн сайд батална.

4.Барилга байгууламжид эвдрэл гэмтэл учруулах, мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр даацын үндсэн бүтээц, зориулалтыг өөрчлөх болон тухайн барилга байгууламж дотор хууль дүрмээр хориглосон байгаль орчин буюу хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хоёр.Барилга байгууламжийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн үндсэн үүрэг

5.Барилга байгууламжийг ашиглахдаа Барилгын тухай хууль, энэхүү дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг өөрийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон агаар, ус, хөрсийг бохирдлоос сэргийлэх, хот байгуулалтын шаардлагын дагуу зориулалтаар нь ашиглагчийн хэвийн нөхцөлийг хангах нь өмч-

лөгч, эзэмшигч, ашиглагчийн үндсэн үүрэг байна.

6.Өмчлөгч, эзэмшигч, ашиглагчнь барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан бүюу ашиглаж эхэлсэн үеэс эхлэн тэдгээрийн хэвийн ажиллагаагаар хангах, илэрсэн эвдрэл гэмтлийг тухай бүр нь арилгах арга хэмжээ авах үүрэгтэй.Үүнд:

а/өмчлөгч нь барилга байгууламжийн техникийн баримт бичгийг иж бүрдүүлэн хувийн хэргийг хөтөлж, улсын бүртгэлд бүртгүүлэх;

б/барилгын орчныг хүний эрүүл мэнд, байгаль орчин болон зэргэлдээх барилга байгууламжийн ашиглалт, иргэдийн суурьшил, хөдөлгөөнд сөрөг нөлөө үзүүлэхээргүйгээр байлгаж сэргээн тохижуулах ба барилга байгууламжийн гадна өнгө үзэмжийг засаж сайжруулах;

в/барилга байгууламжийг ашиглах явцад түүний ангилал, зориулалтаас хамааруулан 2-5 жил тутамд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар эзлэгт үзлэг хийлгэж барилгын үндсэн бүтээц, инженерийн шугам сүлжээний чанар, байдалд техникийн дүгнэлт гаргуулан илэрсэн зөрчлийг арилгах талаар шаардлагатай арга хэмжээг авах;

г/барилга байгууламжийн дээвэр, адрын хучилт болон бусад бүтээц дээр цас мөс, хог шороо, тоосонцор, сангас зэрэг хуримтлагдан даац хэтэрч осол гарахаас сэргийлэх;

д/барилга байгууламжийн даацын бүтээцүүдэд зураг төсөлд тусгаснаас илүү ачаа өгөлгүй ашиглах ба тэдгээрт байнгын хяналт тавьж эвдрэл гэмтэл гарсан үед холбогдох арга хэмжээг шуурхай авах;

е/галын аюулгүй байдал болон ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийн шаардлагыг биелүүлж ашиглах;

ж/барилга байгууламжийн гадна тохижилт, зам талбай, барилгын гол болон хажуу, нүүр талын өнгө үзэмжийг өөрчлөхдөө тухайн аймаг, нийслэлийн ерөнхий архитектороос зөвшөөрөл авах;

з/барилга байгууламжид байрлуулах нэмэлт элемент, төхөөрөмж, реклам чимэглэл зэргийн зураг төсөл, барилга угсралтын ажлыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлж, барилгын хийц бүтээцэд эвдрэл гэмтэл, орчин тойронд аюул осол гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

и/барилга байгууламжийг ашиглахдаа эрчим хүчний алдагдал гаргах, инженерийн шугам сүлжээнд зураг төсөлд тусгаснаас илүү ашиглалтын үеийн хэрэглээний хэт ачаалал өгөхгүй байх;

к/барилгын бүтээцэд ан цав гарвал мэргэжлийн байгууллагад хандаж зохих арга хэмжээ авахуулах;

л/барилга байгууламжид ноцтой эвдрэл гэмтэл, нуралт үүссэн тохиолдолд барилгын техникийн хяналтын байцаагчид мэдэгдэж холбогдох арга хэмжээг авахуулах;

м/өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь эрх бүхий холбогдох байгууллагын шийдвэр, зөвшөөрөлгүйгээр болон харилцан тохиролцохгүйгээр бусад барилга байгууламжийн цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны хангамжийг таслахгүй байх.

Гурав.Ашиглаж байгаа барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгэх

7.Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжийг шинээр ашиглалтад оруулсан, өргөтгөл, шинэтгэл, засвар хийсэн тохиолдолд хувийн хэргийг дүрмийн хавсралтад зааснаар хөтөлж баяжуулалт хийж байна.

8.Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх, тэдгээрийг улсын бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр явуулах бөгөөд үүнтэй холбогдсон зардлыг ашиглагч, өмчлөгч, эзэмшигч нь хариуцна.

9.Барилга байгууламжийн чанар байдалд хэмжилт, судалгаа, тооцоо хийж үнэлэлт, дүгнэлт өгөхдөө барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан аргачлалын

агуу эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

10.Барилга байгууламжийн бүтээцийн бат бэх байдал, тогтвор, найдвартай ажиллагаанаас хамааруулан дор дурдсан 3 төрлийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно. Үүнд:

а/газар хөдлөлтийн үйлчлэл болон бусад динамик, статик ачаалалд найдвартай ажиллах барилгад ноогоон өнгөтэй гэрчилгээ;

б/газар хөдлөлтийн үйлчлэл болон бусад динамик, статик ачаалалд найдвартай ажиллах чадваргүй бөгөөд цаашид бэхэлж сайжруулах боломжтой барилгад шар өнгөтэй гэрчилгээ;

в/газар хөдлөлтийн үйлчлэл болон бусад динамик, статик ачаалалд найдвартай ажиллах чадваргүй бөгөөд цаашид бэхэлж сайжруулах хязгаарлагдмал боломжтой барилгад улаан өнгөтэй гэрчилгээ.

11.Барилга байгууламжийн нүүрэн талын хананд улсын бүртгэлийн гэрчилгээний өнгөтэй, гэрчилгээний дугаартай, 40х40 см-ийн хэмжээтэй самбарыг байрлуулна.

12.Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч өөрчлөгдсөн тохиолдолд барилгын улсын бүртгэлийн гэрчилгээг солиулна.

13.Барилга байгууламжийн чанар байдлыг тодорхойлсон техникийн дүгнэлтийг үндэслэн холбогдох мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжээр засвар бэхэлгээний зураг төсөл хийлгэсний үндсэн дээр бэхлүүлж засан дахин дүгнэлт гаргуулж улсын бүртгэлийн гэрчилгээг солиулах шаардлагатай.

14.Барилга байгууламжийг нураах болон ашиглах боломжгүй болсон тохиолдолд тэдгээрийг улсын бүртгэлээс хасуулна.

15.Улсын бүртгэлийн ногоон өнгөтэй гэрчилгээ нь 15 жил, шар өнгөтэй гэрчилгээ нь 8 жил, улаан өнгөтэй гэрчилгээ нь 5 жилийн хугацаатай байна.

16.Барилга байгууламж нь хэд хэдэн өмчлөгч, эзэмшигч, ашиглагчтай бол бүртгүүлэх хүсэлтээ тэдгээр нь тус тусдаа гаргах бөгөөд нэгдсэн дүгнэлтийг үндэслэн нэг төрлийн гэрчилгээг олгоно.

17.Өмчлөгч нь барилга, байгууламжийн чанарыг тодорхойлсон техникийн дүгнэлт болон түүнийг үндэслэн тогтоосон хөрөнгийн үнэлгээ хийлгэж, улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтээ тухайн барилга байгууламжийн байрлах бүй аймаг, хотын Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт гаргана.

18.Тухайн орон нутгийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага энэ дүрмийн 32-т заасан баримт бичгийг хүлээн авч хянан үзээд 1 сарын дотор Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн асуудал хариуцсан Засгийн газрын агентлагт хүргүүлнэ.

19.Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн асуудал болон барилгын техникийн хяналтын асуудал хариуцсан Засгийн газрын агентлагууд хамтран байгуулсан орон тооны бус зөвлөл барилга байгууламжийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

Дөрөв.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдад хүлээлгэх хариуцлага

20.Барилга байгууламжийг ашиглах явцад ноцтой эвдрэл гэмтэл гарах, нуралт үүсэх тохиолдолд зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын хэн бүрүүтай нь хариуцлага хүлээнэ.

21.Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагчид энэ дүрмийг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХУВИЙН ХЭРГИЙН БҮРДЭЛ

1.Барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд
2.Инженер геологийн судалгаа, хайгуулын ажлын дүгнэлт
3.Тэг тэнхлэг тавьсан акт
4.Барилга байгууламжийн иж бүрэн зураг төсөл
5.Барилга угсралтын ил далд ажлын гүйцэтгэлийн актууд
6.Барилга байгууламжийг барих буюу ашиглах явцад зохиогч болон барилгын техник, байгаль орчин, эрүүл ахуй, галын зэрэг хяналтын албаанаас өгсөн дүгнэлт
7.Барилга байгууламжийг ашиглалтад оруулсан акт
8.Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн ба бусдад ашиглуулахаар тохирсон гэрээ
9.Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл
10.Барих болон ашиглах явцад гаргасан зураг төслийн өөрчлөлт
11.Илэрч байсан согог гэмтэл, зөрчлийн жагсаалт-акт
12.Их ба урсгал засвар хийсэн зураг, төсөв, гүйцэтгэлийн акт
13.Улсын бүртгэлд бүртгэхтэй холбогдсон баримт бичиг
14.Барилга байгууламжтай холбогдсон бусад баримт бичиг.

Засгийн газрын 1999 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Барилгын техникийн улсын хяналтын зорилго нь инженерийн хийцтэй барилга байгууламжийн зураг төсөл, тэдгээрийн угсралт, ашиглалт, инженер геологийн судалгааны ажил, түүнчлэн барилгын материал эдэлхүүний үйлдвэрлэл, импорт, өргөх байгууламжийн угсралт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны байдал, Барилгын тухай болон Хот байгуулалтын тухай хууль тогтоомж болон барилгын норм, дүрэм, улсын стандартын мөрдөлт, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаат зохицуулахад оршино.

2.Барилгын техникийн хяналтыг улсын хэмжээнд барилгын техникийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын тохируулагч агентлагийн барилгын техникийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, нийслэлийн хэмжээнд тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн барилгын техникийн хяналтын улсын байцаагч тус тус хэрэгжүүлнэ.

3.Барилгын техникийн улсын хяналтын улсын ерөнхий байцаагчийг агентлагийн даргын санал болгосноор барилгын асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

4.Барилгын техникийн хяналтын асуудал эрхэлсэн агентлаг болон аймаг, нийслэлд ажиллах барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг барилгын техникийн хяналтын улсын ерөнхий байцаагчтай зөвшилцөн агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг нь барилгын асуудал эрхэлсэн сайд олгоно.

5.Барилгын техникийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид энэ дүрэмд "байцаагч" гэх/ нь тухайн мэргэжлээр мэргэшсэн байна.

6.Барилгын техникийн хяналтын асуудал эрхэлсэн агентлаг, байцаагчид нь үйл ажиллагаандаа

холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

7.Байцаагч нь Засгийн газраас загварлуулсан нэгэлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэгцэнэ.

8.Ерөнхий байцаагч нь аймаг, нийслэлд ажиллаж байгаа улсын байцаагчтай гэрээ байгуулан ажиллаж тэдгээрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргана. Хэрэв шаардлагатай бол тодорхой асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Хоёр.Барилгын техникийн улсын хяналтын чиглэл

9.Барилгын техникийн улсын хяналтыг Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан чиглэлээр хэрэгжүүлнэ.

Гурав.Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэг

10.Байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар тогтоосон улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

а/шинээр барьж буй барилгын даацын үндсэн бүтээцийн зураг төсөл, материал, эдэлхүүн, угсралтын ажил нь барилгын норм ба дүрмийн шаардлага хангаагүй болох нь тогтоогдвол ут бүтээцийг буулгаж дахин шинээр хийлгэх шийдвэр гаргах, бүрэлдэхүүнийг борлуулсан хураах зэрэг эрхээр хохирлыг төлүүлэх;

б/Барилга байгууламжийн хийц бүтээцэд хэрэглэгдэх материал, эдэлхүүн нь улсын стандарт, барилгын норм, дүрэм, зураг төслийн шаардлага хангаагүй бол уг зөрчлийг арилгатал үйлдвэрлэлийг зогсоох, бүрэлдэхүүнийг эзэмшигч этгээдийг торгох, шаардлагатай бол борлуулахаар бэлтгэсэн бүтээгдэхүүнийг устгах, борлуулсан бүтээгдэхүүний орлогыг хураах улсын төсөвт оруулах;

в/ өргөх байгуулламж дээр хүний амь нас хохирох, бие махбодь гэмтэх болон эд материалын ихээхэн хохирол учруулах ноцтой осол, аваарь гарч болзошгүй байгаа тохиолдолд түүнийг ажиллуулахыг хориглох;

г/өргөх байгууламжийн машинч, операторч нарын мэргэжлийн сургалтад хяналт тавих;

д/зураг төсөл боловсруулах, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй болон зөвшөөрлийн хугацаа дууссан нөхцөлд үйл ажиллагаа явуулсан этгээдийг торгох, борлуулсан орлогыг нь хураах улсын төсөвт оруулах;

е/үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангаагүй, чанарын баталгаажуулалт хийлгээгүй барилгын импортын материал, эдэлхүүнийг борлуулсан буюу хэрэглэсэн тохиолдолд бүрэлдэхүүнийг устгах, борлуулсан бүтээгдэхүүний орлогыг хураах улсын төсөвт оруулах.

11.Байцаагч нь барилга, хот байгуулалтын талаарх хууль тогтоомж, барилгын норм, дүрэм, улсын стандарт зөрчсөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэж бүрэлдэхүүнийг устгах, Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв.Бусад зүйл

12.Ашиглалтад байгаа болон бариргдаж буй барилга байгууламж, инженерийн шугам сүлжээнд нуралт, эвдрэл гарсан, өргөх байгууламжид ноцтой аваарь, хүний амь нас хохирсон буюу хүнд, бүлэг осол гарсан тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага нь барилгын техникийн улсын хяналтын алба, байцаагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

13.Барилгын техникийн улсын хяналтын алба, байцаагчийн шийдвэрийг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн хүлцэх мэдэгдэх үүрэгтэй.

14.Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг дээд шатны улсын байцаагч хянан шийдвэрлэнэ.

Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн шийдвэр үндэслэлгүй байвал түүнийг дээд шатны улсын байцаагч хүчингүй болгоно. Барилгын техникийн хяналтын ерөнхий байцаагчийн шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

15.Байцаагч нь энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 101 | Улаанбаатар хот

"Махны экспорт" төслийн тухай

"Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр", "Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Махны экспорт" төслийг зүйтэй гэж үзсүгэй.

2. Төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг жил бүрийн эцэст Засгийн газарт танилцуулж байхыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч. Содномцэрэндэд даалгасугай.

3. Махны үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийх, шинэ технологи нэвтрүүлэх, мах судлалыг хөгжүүлэх, Монгол малын махыг гадаад зах зээлд сурталчлах арга хэмжээг зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгө болон дотоодын хөрөнгийн эх үүсвэр олж хэрэгжүүлж байхыг Сангийн сайд Я. Очирсүх, Гадаад харилцааны сайд Н. Туяа, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч. Содномцэрэн нарт даалгасугай.

4. Аймгуудын махны нөөцийг зохистой ашиглах зорилгоор суурин болон нүүдлийн бага хүчин чадалтай мах боловсруулах үйлдвэр байгуулан ажиллуулах талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, малын зах, мал бордох талбайг засаж тохижуулах, шинээр барих, лабораторийн баазыг бэхжүүлэх зэргээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч. Содномцэрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж. НАРАНЦАЦРАЛТ

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч. СОДНОМЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 103 | Улаанбаатар хот

Бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний тухай

Бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд даалгах нь:

а/бэлгийн замын халдварт өвчний оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах оношлуур, эм, бэлгэвчээр төв, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг үе шат-тайгаар хангах арга хэмжээг авсугай;

б/Баянхонгор, Хэнтий, Дорнод аймгуудад бэлгийн замын халдварт болон үрэвсэлт өвчин нэмэгдэж байгаа шалтгааныг судлан тогтоох, оношлох, эмчлэн эрүүлжүүлэх мэргэжлийн хэсгийг 1999 оны III улиралд багтаан ажиллуулсугай;

в/улсын хэмжээнд бэлгийн замын халдварт өвчний түвшинг тогтоож, өвчний тархалтыг хязгаарлах арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй;

г/Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас орон нутаг, нийслэлд хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийн хүрээнд хийгдэж байгаа ажлыг бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх,

сэргийлэх ажилтай уялдуулан зохион байгуулсугай.

2.Бэлгийн замын халдварт өвчнөөс өөрийгөө болон гэр бүл, нийгмээ хамгаалах сэтгэл зүйг хэвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг хүн амын дунд зохион байгуулахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын сайд С.Сонин, Гэгээрлийн сайд А.Баттер нарт даалгасугай.

3.Бэлгийн замын халдварт өвчний тархалтыг таслан зогсоох зорилгоор эмчилгээ, оношилгоо, сэргийлэх болон сурталчилгааны арга хэмжээнд зориулан 77.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

4.Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх талаар хийх ажлын үндсэн чиглэлийг боловсруулан, түүнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2000 оны төсөвт тусган Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлсүгэй;

б/бэлгийн замын халдварт өвчин цаашид нэмэгдэх хандлагатай байгааг харгалзан эдгээр өвчнийг илрүүлэх, эмчлэх мэргэжлийн хэсгийг өвчлөлийн түвшин өндөр байгаа сумдад ажиллуулж, өвчтөнийг эрүүлжүүлэх арга хэмжээ авсугай.

5.Энэ тогтоолын 4 дүгээр зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга нарт зөвлөсүгэй.

6.Бэлгийн замын халдварт өвчний бууруулах талаар Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын яамнаас хэрэгжүүлж буй хөтөлбөр, олон улсын байгууллага болон гадаад орны төслүүдийн хэрэгжилтийн явцыг шалган дүнг Засгийн газарт танилцуулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Батбаярт даалгасугай.

Монгол Улсын
ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Эрүүл мэнд, нийгмийн
хамгааллын сайд С.СОНИН

Сангийн сайд Я.ОЧИРСҮХ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 65 **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай Монгол улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ” 1998 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

Нэг: “нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг хавсралтаар шинэчлэн батална.

Хоёр: Энэ журмын биелэлтэд байнга хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлогын газар (Л.Дашдорж), Үндэсний татварын ерөнхий газар (Ж. Баасандаш), Гаалийн ерөнхий газар (Т. Лхагва)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав: Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол улсын Сангийн сайдын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 258 тоот тушаалаар батлагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Я. ОЧИРСҮХ

Сангийн сайдын 1999 оны 65 дугаар тушаалын хавсралт

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫГ БУЦААН ОЛГОХ ТУСГАЙ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) төлөгчөөр бүртгэгдэгдэх, төсөвт НӨАТ-ын төлбөр хийсэн аж ахуйн нэгж, байгууллагаас төсөвт илүү төлсөн НӨАТ-ыг буцаан олгох сан (цаашид “Тусгай сан” гэх)-гийн хөрөнгийг бүрдүүлэх, уг сангаас НӨАТ-ыг буцаан олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Төсөвт илүү төлөгдсөн НӨАТ-ын тооцоог хянан шалгах ажлыг Үндэсний татварын ерөнхий газар (УТЕГ), түүний харьяа аймаг, нийслэл, дүүргийн татварын албад хариуцан гүйцэтгэнэ.

1.3.Төсөвт илүү төлөгдсөн НӨАТ-ыг буцаан олголтыг Сангийн яам хариуцан гүйцэтгэх бөгөөд энэхүү журмын биелэлтэд мөн хяналт тавьж ажиллана.

Хоёр. Тусгай санг бүрдүүлэх

2.1.НӨАТ-ын тухай хуулийн 11.7-д заасны дагуу тусгай санг Монгол банкин дахь улсын төвлөрсөн төсвийн орлогын 3401000 тоот дансанд байгуулна.

2.2.Тусгай сангийн хөрөнгийг төсвийн орлогын гүйцэтгэлд оруулж тооцохгүй.

Гурав. Тусгай сангийн хөрөнгийг зарцуулах

3.1.Тусгай сангийн хөрөнгийг төсөвт илүү төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвараас бусад татварын өрөнд суутгасан хэмжээгээр холбогдох төсөв рүү шилжүүлэх, илүү төлөлтийг татвар төлөгчид буцаан олгоход зарцуулна.

3.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг буцаан авахаар татвар төлөгчөөс тавьсан хүсэлтийг харьяалах татварын алба хүлээж аваад НӨАТ-ын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасны дагуу зохицуулагт хийнэ.

3.3. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн 11.4.2-д заасны дагуу бусад татварын өрөнд суутган тооцож байгаа нэмгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийг тусгай сангаас уг суутгалыг хийж буй татварын албаны харьяалагдах төсөв рүү шилжүүлнэ.

3.4.Орон нутгийн татварын албад бусад татварын өрөнд суутган тооцсон илүү төлөлтийг татвар төлөгч нэг бүрийн нэрээр гаргаж Үндэсний татварын ерөнхий газрын нэмэгдсэн өртгийн албан татварын тасагт ирүүлнэ. Үндэсний татварын ерөнхий газар орон нутгийн татварын албадаас ирсэн мэдээлийг энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу нэгтгэн гаргаж Сангийн яаманд сар бүр ирүүлнэ.

3.5.Зохицуулалт хийсний дараа тухайн татвар төлөгч төсөөс татварын буцаан олголт авахаар байвал харьяалах татварын алба ажлын 10 өдөрт багтаан хяналт шалгалт хийж буцаан олголтын хэмжээг магадлан тогтооно.

3.6.Хэрэв илүү төлөлтийг буцаан олгох үндэслэлтэй бол хяналт шалгалт хийсэн татварын байцаагчид холбогдох баримт /акт, засварласан тайлан, нэхэмжлэх хуудас/-ыг үйлдэн баталгаажуулна. Шалгалтаар баталгаажсан илүү төлөлтийг шалгалт дуусснаас хойш ажлын 6 өдрийн дотор тухайн татварын газар, хэлтсийн дарга болон хяналт шалгалтын хэлтэс, тасгийн дарга нар нягтлан шалгаж, баталгаажуулсны үндэсэн дээр буцаан олгогдох илүү төлөлтийг татвар төлөгч нэг бүрийн нэрээр гаргаж, Үндэсний татварын ерөнхий газрын нэмэгдсэн өртгийн албан татварын тасагт хүргүүлнэ.

3.7. Үндэсний татварын ерөнхий газрын Нэмэгдсэн өртгийн албан татварын тасаг нь харьяалах татварын албадаас ирүүлсэн буцаан олгох илүү төлөлтийн мэдээлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан татвар төлөгч бүрээр нь хянан үзэж, төсөөс буцаан олгох НӨАТ-ын нэгдсэн товчоог энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу гаргаж, тусгай сангаас буцаан олголт шилжүүлэх хүсэлтээ Сангийн яаманд тухай бүр албан бичгээр хүргүүлж байна.

3.8.Сангийн яам нь энэ журмын 3.4,3.7-д заасны дагуу Үндэсний татварын ерөнхий газрын Нэмэгдсэн өртгийн тасгаас ирүүлсэн жагсаалт, хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор бусад татварын өрөнд суутган тооцсон илүү төлөлтийг холбогдох төсвийн дансанд, илүү төлөгдсөн НӨАТ-ыг татвар төлөгчийн харилцах дансанд тус тус шууд шилжүүлнэ. Хэрэв улсын төвлөрсөн төсөвт тухайн орон нутгийн төсөөс төлөх ёр байгаа бол бусад татварын өрөнд суутган тооцсон илүү төлөлтийг уг өрөнд суутган тооцож болно.

3.9.Төсөвт илүү төлөгдсөн НӨАТ-ыг татвар төлөгчөөс уг татвараг төсөвт шилжүүлсэн зөвхөн тэр банк болон харилцах дансанд шилжүүлнэ.

3.10.Сангийн яам нь бусад татварын өрөнд суутгаж орон нутгийн төсөвт төлсөн болон татвар төлөгчдөд буцаан олгосон НӨАТ-ын илүү төлөлтийн талаархи баримт, мэдээллийг Үндэсний татварын ерөнхий газрын нэмэгдсэн өртгийн татварын тасагаст тухай бүр албан ёсоор хүргүүлж байна.

3.11.Төсөөс буцаан олгох нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоо, баримтын үнэн зөвийг татвар төлөгч болон холбогдох татварын алба хариуцна.

3.12.Тусгай сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

Дөрөв. Хяналт, шалгалт

4.1.Нэмэгдсэн өртгийн албан татварыг төсөөс их хэмжээгээр буцаан авдаг татвар төлөгчийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөр, тооцоог татварын алба газар дээр нь шалгаж байна.

4.2.Төсөөс буцаан авах нэмэгдсэн өртгийн албан татварын тооцоог хуурамчаар үйлдэх, будлиантуулах замаар улсад хохирол учруулсан татвар төлөгчдөд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНГИЙН ЯАМ

"Нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 1-р хавсралт

Батлав. ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .....

... оны ... дугаар сард нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтөөс бусад татварын өрөнд суутгасан суутгалын жагсаалт

д/д	Татварын газар, хэлтсийн нэр	суутгалын дүн /төгрөг/	суутгалыг шилжүүлэх төсвийн		
			нэр	харилцагч банкны нэр	дансны дугаар

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТАСГИЙН ДАРГА .....

... оны ... дугаар сарын ..

"Нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын 2-р хавсралт

Батлав. ҮНДЭСНИЙ ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА .....

... оны ... дугаар сард буцаан олгогдох нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийн жагсаалт

д/д	Татвар төлөгчийн нэр	Бүртгэлийн дугаар	Харилцагч банкны нэр	Дансны дугаар	Буцаан олгох НӨАТ-ын хэмжээ (төгрөгөөр)

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТАСГИЙН ДАРГА .....

... оны ... дугаар сарын ..

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны наймдугаар сарын 25 №39 (118)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

365. Элчин сайдыг томилох тухай Дугаар 139 739
366. Ч. Дашзэвэгт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 140 740
367. Ч. Ганбаатарт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай Дугаар 142 740
368. Зарим шүүхийн ерөнхий шүүгчийн тухай Дугаар 144 740
369. Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай Дугаар 145 740

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

370.Журам батлах тухай Дугаар 104 745
371.Хөтөлбөр батлах тухай Дугаар 105 748
372.Төлөвлөгөө батлах тухай Дугаар 107 756
373.Нэрэмжит болгох тухай Дугаар 109 763
374.Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 110 763

Гурав. Яам, агентлагийн акт

375. Журам батлах тухай (Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын тушаал) Дугаар А/72 766

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 139 Улаанбаатар хот

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсаас Ливан Улсад суух Онц Алтангэрэлийг тохоон томилсугай.

бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Булгаагийн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 **оны 8 дугаар сарын 5-ны өдөр** — Дугаар 140 — Улаанбаатар хот

Ч. Дашзэвэгт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Дүрслэх урлагийн байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажилласан, эх орны болон иргэний сэдэвтэй хөшөө дурсгал, хот чимэглэлийн олон уран баримлыг мэргэжлийн өндөр түвшинд туурвин бүтээж, залуу үеийнхэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх, уран баримлын урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж уран барималч Чимидийн Дашзэвэгт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 6-ны өдөр — Дугаар 142 — Улаанбаатар хот

Ч. Ганбаатарт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээх тухай

Уул уурхайн салбарт үр бүтээлтэй ажиллаж алтны шинэ уурхайнуудыг байгуулан удирдаж, үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэн, Засгийн газрын "Алт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баянголын алтны уурхайн дарга Чойжингийн Ганбаатарт Монгол Улсын гавьяат уурхайчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 144 — Улаанбаатар хот

Зарим шүүхийн ерөнхий шүүгчийн тухай

1. Монгол Улсын "Шүүхийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаатай холбогдуулан Бамбарын Баасанхүү Говь-Алтай аймгийн Шүүхийн ерөнхий шүүгчийн, Дамдинжамцын Буянтогтохыг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Тухайн аймаг, сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийг томилогдох хүртэл "Шүүхийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлийн 7.27 дугаар зүйлийн 1.29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тухайн шүүхийн ерөнхий шүүгчийг орлож байхыг дээрх шүүгч нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 9-ний өдөр — Дугаар 145 — Улаанбаатар хот

Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай

1939 оны Халх голын байлдаанд биечлэн оролцож эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үйл хэрэгт оруулсан гавьяаг нь үнэлж хавсралтад дурдсан ахмад дайчдыг одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
1999 оны 145 дугаар зарлигийн
хавсралт

ОДОНГООР ШАГНАГДСАН АХМАД ДАЙЧДЫН НЭР

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1.Дашийн Дариймаа -Архангай аймаг
2.Сономын Самбуу - Архангай аймаг
3.Раднаагийн Ханд -Архангай аймаг
4.Пунцагийн Цогзол -Архангай аймаг
5.Жанцангийн Чунаг -Архангай аймаг
6.Сумъяагийн Жүгдэр -Баянхонгор аймаг
7.Тогоочийн Дамбаа -Булган аймаг
8.Дорлигийн Дашзэвэг -Булган аймаг
9.Ундрахын Дашхүү -Говь-Алтай аймаг
10.Нүрэмийн Шархүү -Говь-Алтай аймаг
11.Омоошийн Цагаадай -Дархан-уул аймаг
12.Луузангийн Цэд-Очир -Дархан-уул аймаг
13.Гэндэнгийн Гэлэгмолом -Дорноговь аймаг
14.Намбарын Гал -Дундговь аймаг
15.Цээбумын Гэнэн -Дундговь аймаг
16.Тулгын Дамбий -Дундговь аймаг
17.Халтайн Лувсандавга -Дундговь аймаг
18.Пагамжавын Батдорж -Завхан аймаг
19.Ламжавын Лувсанбалдан -Завхан аймаг
20.Ламжавын Жамъянгачаа -Орхон аймаг
21.Жаргалантын Лувсан -Орхон аймаг
22.Борын Дамбадаржаа -Өвөрхангай аймаг
23.Гэндэнгийн Пүрэв -Өвөрхангай аймаг
24.Цэдэнсамбын Сүхцоодол -Өвөрхангай аймаг
25.Жигмэдийн Сэдбазар -Өвөрхангай аймаг
26.Юндэнгийн Содномдавга -Өвөрхангай аймаг
27.Пүрэвийн Туваандорж -Өвөрхангай аймаг
28.Мишигийн Аюуржамц -Өмнөговь аймаг
29.Хишигтийн Цултэм -Өмнөговь аймаг
30.Равдангийн Шарав -Өмнөговь аймаг
31.Гомбожавын Дамдинпүрэв -Төв аймаг
32.Ламжавын Лувсанжүрмэд -Төв аймаг
33.Аюушийн Нанжид -Төв аймаг
34.Гомбын Пүрэв -Төв аймаг
35.Гонгорын Хэнгэрэг -Төв аймаг
36.Гонсын Цэдэв -Төв аймаг
37.Эвлээгийн Бадрах -Увс аймаг
38.Дэдэвийн Ням -Ховд аймаг
39.Пунцагийн Норов -Ховд аймаг
40.Шаравын Осор -Ховд аймаг
41.Дамдингийн Балдандорж -Хөвсгөл аймаг
42.Дэлгэрийн Даваа -Хөвсгөл аймаг
43. Найдангийн (Замбалгарав) Чойжамц -Хөвсгөл аймаг
44. Дамдингийн Дорж -Хэнтий аймаг
45. Пунцагхоролын Жамбал -Хэнтий аймаг
46. Бизлэгийн Чоймбол -Хэнтий аймаг
47. Өлзийн Дашхүү -Баянгол дүүрэг
48. Жамсрангийн Дэндэв -Баянгол дүүрэг
49. Сүрэнхоролын Давгасүрэн -Баянгол дүүрэг
50. Сосорбарамын Зундуй -Баянгол дүүрэг
51. Чүлтэмийн Тогтох -Баянгол дүүрэг
52. Тогтохын Шагдар -Баянгол дүүрэг
53. Тогоочийн Шархүү -Баянгол дүүрэг
54. Шаравын Дамдин -Баянзүрх дүүрэг
55. Найдангийн Дэмбэрэлдорж -Баянзүрх дүүрэг
56. Гэлэгийн Паламдорж -Баянзүрх дүүрэг
57. Надмидын Сандуй -Баянзүрх дүүрэг
58. Батмөнхийн Санги -Баянзүрх дүүрэг
59. Гаанжуурын Чоймпо -Баянзүрх дүүрэг
60. Дүгэрийн Ядамцоо. -Баянзүрх дүүрэг
61. Дамбийн Ойдов -Налайх дүүрэг
62. Сугарын Авир -Сонгинохайрхан дүүрэг
63. Цогтын Аминдаваа -Сонгинохайрхан дүүрэг
64. Гомбын Батмөнх -Сонгинохайрхан дүүрэг
65. Дэндэвийн Ёндонжамц -Сонгинохайрхан дүүрэг
66. Доржпаламын Гомбосүрэн -Сүхбаатар дүүрэг
67. Ишцоогийн Дэмбэрэл -Сүхбаатар дүүрэг
68. Шануумаагийн Лувсанжамц -Сүхбаатар дүүрэг
69. Сүхийн Мягмар -Сүхбаатар дүүрэг
70. Навааны Найданжав -Сүхбаатар дүүрэг
71. Сумаадын Цэдэндамба -Сүхбаатар дүүрэг
72. Гомбын Чойжамц -Сүхбаатар дүүрэг
73. Рэнцэнгийн Ванчиг -Хан-Уул дүүрэг
74. Лувсангийн Даваа -Хан-Уул дүүрэг
75. Норжингийн Пүрэв -Хан-Уул дүүрэг
76. Буянгийн Балдандаваа -Чингэлтэй дүүрэг
77. Дүгэрийн Батбаяр -Чингэлтэй дүүрэг
78. Цогтын Гэндэндаржаа -Чингэлтэй дүүрэг
79. Бадрахын Дававаням -Чингэлтэй дүүрэг
80. Дамдингийн Лувсанбазар -Чингэлтэй дүүрэг
81. Гэндэндоржийн Пагма -Чингэлтэй дүүрэг
82. Чогдовын Гомбо -Сүхбаатар аймаг
83. Сономын Навааншарав -Сүхбаатар аймаг

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Зундуйваанчигийн Дамдинсүрэн -Архангай аймаг
2. Дэндэвийн Дондогдорж -Архангай аймаг
3. Баясгалангийн Жагдал -Архангай аймаг
4. Гэндэнгийн Жалцавхүү -Архангай аймаг
5. Сунаагийн Жамъянсүрэн -Архангай аймаг
6. Дашийн Загд -Архангай аймаг
7. Раднаагийн Лувсангомбосүрэн -Архангай аймаг
8. Дашийн Лодойсамбуу -Архангай аймаг
9. Жагарын Раднаа -Архангай аймаг
10. Бодийн Раднаа -Архангай аймаг
11. Пүрэвийн Самбуу -Архангай аймаг
12. Ванчинжавын Чимэдбазар -Архангай аймаг
13. Намжилын Барамсай -Баянхонгор аймаг
14. Долиогийн Балжинням -Баянхонгор аймаг
15. Задийн Гэлгээ -Баянхонгор аймаг
16. Лхагваагийн Дамдин -Баянхонгор аймаг
17. Цэрэнваанчигийн Ёл -Баянхонгор аймаг
18. Сономын Санги -Баянхонгор аймаг
19. Хөнхөний Баймолда -Баян-Өлгий аймаг
20. Жамъяншаравын Авирмэд -Булган аймаг
21. Жанцангийн Давгасүрэн -Булган аймаг
22. Мижидийн Жанчив -Булган аймаг
23. Цээлхээгийн Зана -Булган аймаг
24. Дашийн Сүрэнхорлоо -Булган аймаг
25. Хоролын Цэрэндорж -Булган аймаг
26. Хишигийн Шаравдорж -Булган аймаг
27. Буньяагийн Баатархүү -Говь-Алтай аймаг
28. Мижидийн Дашбалжир -Говь-Алтай аймаг
29. Мөнхийн Дорж -Говь-Алтай аймаг
30. Өлзийн Загдхүү -Говь-Алтай аймаг
31. Рэгзэнгийн Лувсанбат -Говь-Алтай аймаг
32. Худгаагийн Сугар -Говь-Алтай аймаг
33. Жигжиджавын Пүрэв -Говь-Алтай аймаг
34. Гомбожавын Бадам -Дархан-Уул аймаг
35. Цэдэнгийн Баавгай -Дархан-Уул аймаг
36. Жамсрангийн Гомбожав -Дархан-Уул аймаг
37. Загдын Дамдин -Дархан-Уул аймаг
38. Баяртын Дүгэржав -Дархан-Уул аймаг
39. Цогтын Даваа -Дархан-Уул аймаг
40. Мижидийн Доржшовгор -Дархан-Уул аймаг
41. Ширчингийн Лхам -Дархан-Уул аймаг
42. Хорхойн Хэрмэн -Дархан-Уул аймаг
43. Жамбалын Юндэндорж -Дархан-Уул аймаг
44. Очирын Балдармаа -Дорнод аймаг
45. Батжаргалын Дугаржав -Дорнод аймаг
46. Буджавын Жаргал -Дорнод аймаг
47. Пэлжидийн Норжин -Дорнод аймаг
48. Гончигийн Хандам -Дорнод аймаг
49. Цэдэнгийн Ханд -Дорнод аймаг
50. Дугарын Чүлтэмжамбаа -Дорнод аймаг
51. Аюурзанын Дүгэрсүрэн -Дорноговь аймаг
52. Долгорын Банзрагч -Дундговь аймаг
53. Сүндэвийн Бэгз -Дундговь аймаг
54. Гомбын Дампил -Дундговь аймаг
55. Түдэвийн Дамдиндорж -Дундговь аймаг
56. Дэжидийн Жамсранжав -Дундговь аймаг
57. Борын Жамъян -Дундговь аймаг
58. Чимэдрашийн Жигмэд -Дундговь аймаг
59. Яндарын Ишбалдан -Дундговь аймаг
60. Даариймаагийн Лхам -Дундговь аймаг
61. Дэмчигийн Лувсанцэрэн -Дундговь аймаг
62. Цэрмаагийн Содном -Дундговь аймаг
63. Минжүүрийн Содномпунцаг -Дундговь аймаг
64. Лувсандоржийн Тогтох -Дундговь аймаг
65. Бадрахын Сүрэнхор -Дундговь аймаг
66. Солийн Цэдэнбалжир -Дундговь аймаг
67. Лувсандоржийн Цэнджав -Дундговь аймаг
68. Чимэдийн Цогтбаатар -Дундговь аймаг
69. Сосорын Цэгмид -Дундговь аймаг
70. Долгорын Чимэд -Дундговь аймаг
71. Мандалын Артхүү -Завхан аймаг
72. Мачийн Батхуяг -Завхан аймаг
73. Раднаабудийн Дашдаваа -Завхан аймаг
74. Цэдэнжавын Магад -Завхан аймаг
75. Луузангийн Молом -Завхан аймаг
76. Буянбуугийн Намсрай -Завхан аймаг
77. Анардын Содном -Завхан аймаг
78. Төмөрийн Цэндхүү -Завхан аймаг
79. Цагааны Чойжил -Завхан аймаг
80. Бизьяагийн Будхүү -Орхон аймаг
81. Сономын Бадмаваанчиг -Орхон аймаг

82. Бавуугийн Гомбо -Орхон аймаг
83. Цэдэвийн Гомбожав -Орхон аймаг
84. Пүрэвсүрэнгийн Жадамбаа -Орхон аймаг
85. Түмэнбаярын Саяаннямбуу -Орхон аймаг
86. Сайнбаярын Ширнэн -Орхон аймаг
87. Цогтын Агваанцэрэн -Өмнөговь аймаг
88. Долгорын Дампил -Өмнөговь аймаг
89. Нямдоржийн Дэлгэр -Өмнөговь аймаг
90. Будын Дашдорж -Өмнөговь аймаг
91. Сэрээгийн Жамъян -Өмнөговь аймаг
92. Бунийн Жагваралдорж -Өмнөговь аймаг
93. Цэвэлийн Занахүү -Өмнөговь аймаг
94. Шарын Лувсанжамц -Өмнөговь аймаг
95. Цэвэлмаагийн Лувсанрагва -Өмнөговь аймаг
96. Цэсмаагийн Намид -Өмнөговь аймаг
97. Цэейин Намжил -Өмнөговь аймаг
98. Долгоржавын Өлзийт -Өмнөговь аймаг
99. Тогоочийн Цэдэсүрэн -Өмнөговь аймаг
100. Думбаагийн Цэгмэд -Өмнөговь аймаг
101. Данзангийн Банзрагч -Өвөрхангай аймаг
102. Бат-Очирын Гэнэн -Өвөрхангай аймаг
103. Цэрэндоржийн Дашрэнчин -Өвөрхангай аймаг
104. Банзрагчийн Жадамбаа -Өвөрхангай аймаг
105. Дашдоржийн Мөнхөө -Өвөрхангай аймаг
106. Амирдаагийн Нацагдорж -Өвөрхангай аймаг
107. Галсангийн Нямдорж -Өвөрхангай аймаг
108. Сэрээнэндоржийн Очирбат -Өвөрхангай аймаг
109. Будгивийн Цэдэн-Иш -Өвөрхангай аймаг
110. Шаравын Цэдэн-Иш -Өвөрхангай аймаг
111. Очирын Чимэдцэрэн -Өвөрхангай аймаг
112. Дамдингийн Юндэндорж -Өвөрхангай аймаг
113. Цэндийн Аюуш -Төв аймаг
114. Чойжилын Агваазагд -Төв аймаг
115. Дамдингийн Бат-Очир -Төв аймаг
116. Сэрээнэнгийн Балдан -Төв аймаг
117. Лхамын Гомбожав -Төв аймаг
118. Санжаагийн Дашдондог -Төв аймаг
119. Чүлтэмийн Ёндон -Төв аймаг
120. Лэгцэгийн Зундуй -Төв аймаг
121. Далайн Луузан -Төв аймаг
122. Бүтэнжавын Лувсандорж -Төв аймаг
123. Дугарын Нанзад -Төв аймаг
124. Чүлтэмийн Рэнцэнноров -Төв аймаг
125. Цагааны Самбуу -Төв аймаг
126. Цэдэнгийн Сундаваа -Төв аймаг
127. Батцогтын Халзан -Төв аймаг
128. Цэндийн Цэрэн-Очир -Төв аймаг
129. Ономын Цэдэн -Төв аймаг
130. Сэтгээгэрийн Чимэд -Төв аймаг
131. Уртнасангийн Чойсүрэн -Төв аймаг
132. Хандын Шонхор -Төв аймаг
133. Пунцагийн Шонхор -Төв аймаг
134. Занын Баяст -Увс аймаг
135. Авирмэдийн Гончиг -Увс аймаг
136. Адиагийн Жанчиг -Увс аймаг
137. Шархүүгийн Хөхөө -Увс аймаг
138. Асейны Алимхаан -Ховд аймаг
139. Жигмэдийн Дашзэвэг -Ховд аймаг
140. Жамъянгийн Лхайсүрэн -Ховд аймаг
141. Магнайн Лувсанжамц -Ховд аймаг
142. Гончигийн Олцоо -Ховд аймаг
143. Жигмэдийн Содном -Ховд аймаг
144. Жанчингийн Сэрчин -Ховд аймаг
145. Данхлайн Сэрээгэр -Ховд аймаг
146. Далайн Бийгээ -Хөвсгөл аймаг
147. Рэнчингийн Дамдинбазар -Хөвсгөл аймаг
148. Базарын Дамба -Хөвсгөл аймаг
149. Чойсүрэнгийн Дашням -Хөвсгөл аймаг
150. Гончигийн Дашзэвэг -Хөвсгөл аймаг
151. Гуржавын Дугаржав -Хөвсгөл аймаг
152. Сүрэнгийн Жамбалжав -Хөвсгөл аймаг
153. Чойжамцын Ичинхорлоо -Хөвсгөл аймаг
154. Буянхишигийн Миеэсүрэн -Хөвсгөл аймаг
155. Дамдингийн Норсмоо -Хөвсгөл аймаг
156. Далхын Пүрэвжав -Хөвсгөл аймаг
157. Баатарын Пүрэв -Хөвсгөл аймаг
158. Цэрэнгийн Самбуу -Хөвсгөл аймаг
159. Дамбын Санжжав -Хөвсгөл аймаг
160. Банзрагчийн Сэнгээ -Хөвсгөл аймаг
161. Сүрэнгийн Чүлтэм -Хөвсгөл аймаг
162. Алхын Ядамдорж -Хөвсгөл аймаг
163. Гончигийн Буджав -Хэнтий аймаг
164. Шаравын Гүнчиншарав -Хэнтий аймаг
165. Жамбаагийн Даржаа -Хэнтий аймаг
166. Омбожавын Дулам -Хэнтий аймаг
167. Гончигийн Доржпалам -Хэнтий аймаг
168. Төгсийн Жамц -Хэнтий аймаг
169. Хоролын Цэгмэд -Хэнтий аймаг
170. Тамзавын Лувсанжамц -Хэнтий аймаг
171. Цэрэндэжидийн Лувсандорж -Хэнтий аймаг
172. Мэндийн Лувсан -Хэнтий аймаг
173. Дагвын Лувсанжамц -Хэнтий аймаг
174. Балдангийн Лувсанцэрэн -Хэнтий аймаг
175. Үрэлбаагийн Самдан -Хэнтий аймаг
176. Майдарын Цэндням -Хэнтий аймаг
177. Банзрагчийн Цэрэндорж -Хэнтий аймаг

178. Содномын Шагдарсүрэн -Хэнтий аймаг
179. Жүржгийн Авир -Баянзүрх дүүрэг
180. Чулууны Авирмэд -Баянзүрх дүүрэг
181. Лувсангийн Баянжаргал -Баянзүрх дүүрэг
182. Бандийн Банзрагч -Баянзүрх дүүрэг
183. Самбуугийн Балжинням -Баянзүрх дүүрэг
184. Ваанчигийн Гочоо -Баянзүрх дүүрэг
185. Батын Гончиг -Баянзүрх дүүрэг
186. Шүрэнбын Дарьсүрэн -Баянзүрх дүүрэг
187. Лосолын Далхаа -Баянзүрх дүүрэг
188. Чанаравын Дамба -Баянзүрх дүүрэг
189. Гаваагийн Лувсан -Баянзүрх дүүрэг
190. Намсрайн Жаргал -Баянзүрх дүүрэг
191. Дамирангийн Жамъян -Баянзүрх дүүрэг
192. Алексей Александрович Рудов -Баянзүрх дүүрэг
193. Гомбодоржийн Самбаа -Баянзүрх дүүрэг
194. Тосойн Төмөр -Баянзүрх дүүрэг
195. Пэлжээгийн Түмэндэмбэрэл -Баянзүрх дүүрэг
196. Даваагийн Цэрэнжамжил -Баянзүрх дүүрэг
197. Доржийн Бямба -Баянгол дүүрэг
198. Пүрэвжалын Балжинням -Баянгол дүүрэг
199. Сүхийн Бадарчин -Баянгол дүүрэг
200. Жанцангийн Бэгз -Баянгол дүүрэг
201. Ишийн Гомбосүрэн -Баянгол дүүрэг
202. Рэнцэнжавын Дамбаджаа -Баянгол дүүрэг
203. Доржгэвийн Дамдин -Баянгол дүүрэг
204. Лхагвасүрэнгийн Дэмбэрэл -Баянгол дүүрэг
205. Дамдинжавын Дашчоймбол -Баянгол дүүрэг
206. Балдангийн Жунай -Баянгол дүүрэг
207. Ёндонгийн Жамбаа -Баянгол дүүрэг
208. Жагчалын Жамц -Баянгол дүүрэг
209. Гэндэнгийн Занабазар -Баянгол дүүрэг
210. Навааны Лхамсүрэн -Баянгол дүүрэг
211. Жигжидийн Лхамсүрэн -Баянгол дүүрэг
212. Долгорын Магсар -Баянгол дүүрэг
213. Дамбийнямын Мишиг -Баянгол дүүрэг
214. Сандагийн Мухлай -Баянгол дүүрэг
215. Борын Намжил -Баянгол дүүрэг
216. Сангарагчаагийн Оюунхүү -Баянгол дүүрэг
217. Раашийн Пүрэв -Баянгол дүүрэг
218. Яринпилийн Санжжав -Баянгол дүүрэг
219. Лувсангийн Цэнд -Баянгол дүүрэг
220. Галсандоржийн Чагнаадорж -Баянгол дүүрэг
221. Махранзын Чимэдсамбуу -Баянгол дүүрэг
222. Уртнасангийн Чойжилжав -Баянгол дүүрэг
223. Равдангийн Чойжинсамбуу -Баянгол дүүрэг
224. Жигжидийн Шарав -Баянгол дүүрэг
225. Дамдинжавын Шарав -Баянгол дүүрэг
226. Цэрэндуламын Намдаг -Налайх дүүрэг
227. Цогтын Галсан -Сонгинохайрхан дүүрэг
228. Авирмэдийн Дүдэн -Сонгинохайрхан дүүрэг
229. Жамцын Жамбалдорж -Сонгинохайрхан дүүрэг
230. Загдын Жамбал -Сонгинохайрхан дүүрэг
231. Сүрэнгийн Ламжав -Сонгинохайрхан дүүрэг
232. Буянтын Минжүүр -Сонгинохайрхан дүүрэг
233. Шагдарын Пунцаг -Сонгинохайрхан дүүрэг
234. Мижидийн Санжаажамсран -Сонгинохайрхан дүүрэг
235. Доржийн Хорол -Сонгинохайрхан дүүрэг
236. Батын Цэвэлмаа -Сонгинохайрхан дүүрэг
237. Пүрэвийн Чуван -Сонгинохайрхан дүүрэг
238. Чимэдийн Шүүмар -Сонгинохайрхан дүүрэг
239. Загдын Бадам -Сүхбаатар дүүрэг
240. Равдангийн Гонгор -Сүхбаатар дүүрэг
241. Довдонгийн Дашням -Сүхбаатар дүүрэг
242. Гомбосүрэнгийн Диваанамсан -Сүхбаатар дүүрэг
243. Аюурын Дагва -Сүхбаатар дүүрэг
244. Дэндэвийн Жанчивдорж -Сүхбаатар дүүрэг
245. Зундуйн Жамба -Сүхбаатар дүүрэг
246. Чойжинжавын Жамъянсүрэн -Сүхбаатар дүүрэг
247. Баасангийн Жамц -Сүхбаатар дүүрэг
248. Цэмбэлийн Лхамсүрэн -Сүхбаатар дүүрэг
249. Балдангийн Мятав -Сүхбаатар дүүрэг
250. Хандын Найдан -Сүхбаатар дүүрэг
251. Даваасүрэнгийн Содномдаржаа -Сүхбаатар дүүрэг
252. Дамдинжавын Сүрэнхорлоо -Сүхбаатар дүүрэг
253. Пунцагийн Цэдэнсодном -Сүхбаатар дүүрэг
254. Дэндэвийн Шагдарсүрэн -Сүхбаатар дүүрэг
255. Даваагийн Аюуш -Хан-Уул дүүрэг
256. Жамъянсүрэнгийн Даш -Хан-Уул дүүрэг
257. Алтангэрэлийн Долгорсүрэн -Хан-Уул дүүрэг
258. Цогтын Жигжав -Хан-Уул дүүрэг
259. Юмжавын Намсрайжав -Хан-Уул дүүрэг

260.Самбын Намсрай	-Хан-Уул дүүрэг
261.Дамдин-Очирын Нямаа	-Хан-Уул дүүрэг
262. Эрэнгийн Самбуу	-Хан-Уул дүүрэг
263.Биньягийн Хуурзана	-Чингэлтэй дүүрэг
264.Цагаадайн Бадарч	-Чингэлтэй дүүрэг
265.Дамбын Дамдинжав	-Чингэлтэй дүүрэг
266.Сажинбатын Лхамсүрэн	-Чингэлтэй дүүрэг
267.Хишигтийн Намсрайжав	-Чингэлтэй дүүрэг
268.Долгорын Равжин	-Чингэлтэй дүүрэг
269.Түмэнгийн Сайнхүү	-Чингэлтэй дүүрэг
270.ШархүүгийнСагил	-Чингэлтэй дүүрэг
271.Мөнхийн Соорбурам	-Чингэлтэй дүүрэг
272.Санжмятавын Сундуйжав	-Чингэлтэй дүүрэг
273.Шонхорын Цэнд	-Чингэлтэй дүүрэг
274.Дамдинрагчаагийн Чойжилсүрэн	-Чингэлтэй дүүрэг
275.Бодьгэрэлийн Чогсомжав	-Чингэлтэй дүүрэг
276.Жамсрангийн Чойжил	-Чингэлтэй дүүрэг
277.Даваагийн Чүлтэм	-Чингэлтэй дүүрэг
278.Сангижамцын Чойгов	-Чингэлтэй дүүрэг
279.Норовын Шар	-Чингэлтэй дүүрэг
280.Очирын Гомбодорж	-Сүхбаатар аймаг
281.Дашдэндэвийн Ёндон	-Сүхбаатар аймаг
282.Лхамсүрэнгийн Шарав	-Сүхбаатар аймаг
283.Бадамын Шаравсамбуу	-Сүхбаатар аймаг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | **Дугаар 104** | **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенци, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протоколд нэгдэн орсон талын хүлээсэн үүргийг биелүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралтын ёсоор батлалсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.НАРАНЦАЦРАЛТ

Байгаль орчны сайд С.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 1999 оны 104 дүгээр тогтоолын хавсралт

ОЗОН ЗАДАЛДАГ БОДИСЫГ ИМПОРТЛОХ, АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгох /цаашид "зөвшөөрөл олгох" гэнэ/-д болон тэдгээрт хяналт тавих, үйл ажиллагааг нь зохицуулахад энэ журмыг дагаж мөрдөнө.

2.Зөвшөөрөл олгогч, авагч талууд Монгол Улсын нэгдэн орсон "Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенци, "Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протокол" болон холбогдох бусад гэрээ, хэлэлцээрийг чанд биелүүлэх үүрэгтэй.

Хоёр.Озон задалдаг бодисыг импортлох, худалдах, ашиглахад тавих хяналт

3.Тухайн жилд импортлох озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүний дээд хязгаарыг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Байгаль орчны яам тогтооно. Энэхүү дээд хязгаар нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, озон задалдаг бодисыг бууруулах дэлхий нийтийн стратегийн бодлого, чиг хандлагатай нийцсэн байвал зохино.

4.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах зөвшөөрлийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн тавьсан хүсэлт болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн Байгаль орчны яам олгоно.

5.Зөвшөөрөл олгохыг хүссэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үзүүлэлт, материалыг хүсэлтдээ тусгах буюу хавсаргана:

а/озон задалдаг бодисын нэршил /олон улсын нийтлэг нэр, химийн томъёо/, олон улсын бүртгэлийн дугаар, бараа тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу ангилсан код;

б/тухайн бодисыг хэрэглэх зориулалт, физик, химийн өвөрмөц шинж чанар, үйлдвэрлэсэн болон нийлүүлсэн улс болон пүүсийн нэр, тээвэрлэх, хадгалах, худалдаалах тухай мэдээлэл;

в/нийлүүлэгч талтай хийсэн гэрээ, хэлэлцээрийн нотариатаар батлуулсан хувь;

г/эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын санал, дүгнэлт.

6.Тухайн бодис, бүтээгдэхүүнээс гарч болох осол, эндэгдлийн тухай мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг импортлогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

7.Байгаль орчны яам иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, материал, дүгнэлт, саналыг хянан үзэж, 7 хоногт багтаан зохих шийдвэрээ гаргах буюу хариу өгнө.

8.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтыг гаалийн байгууллага хэрэгжүүлэх бөгөөд тухайн жилд импортлосон озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүний тухай мэдээллийг дэлгэрэнгүй нэр төрлөөр нь гарган жил бүрийн 12 дугаар сард багтаан Байгаль орчны яаманд өгнө.

9.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг хадгалах, ашиглах, худалдах үйл ажиллагаанд тавих орон нутгийн хяналтыг тухайн шатны Засаг дарга, байгаль орчны хяналтын байцаагч хэрэгжүүлнэ.

Гурав. Зөвшөөрөл олгоход тавих шаардлага, хориглох үйл ажиллагаа

10.Үйлдвэрлэгчийн чанарын баталгаажуулалт бүхий озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлнэ.

11.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох зөвшөөрлийг олгохдоо дараахь шаардлагыг харгалзан үзнэ:

а/бүрдүүлсэн бичиг баримт нь элдэв засваргүй эх хувь байх;

б/зөвшөөрөлд заагдсан нэр төрөл, тоо хэмжээг чанд баримталж чадах эсэх;

в/Монреалын Протоколын хавсралтын А-ийн I, П бүлэг, хавсралт В-ийн П, Ш бүлэг, хавсралт Е-ийн I бүлэгт орсон бөгөөд импортлож болох озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүн нь зөвхөн өөрийн орны болон тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэгцээг хангахад зориулсан байгаа эсэх.

12.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уг бодисыг ашиглах буюу дотоодын хэрэглэгчдэд худалдаж болно.

13.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлогч, ашиглагч нь Монреалын Протоколын жагсаалтад орсон бодисыг үйл ажиллагааныхаа явцад ууршуулах, агаарт алдахаас сэргийлэх, хамгаалах баталгаагаар хангагдсан байна.

4.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүн импортлогч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

а/зохих журмын дагуу авсан зөвшөөрөлгүйгээр уг бодис, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх;

б/Монреалын Протоколд нэгдэж ороогүй оронд озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг реэкспортлох;

в/энэ журамд өөрөөр заагаагүй бол Монреалын Протоколын хавсралт А-ийн I,П бүлэг, хавсралт В-ийн I, П, Ш бүлэг, хавсралт С-ийн П бүлэгт орсон бодисыг агуулсан шинэ болон дахин ашиглагдсан бүтээгдэхүүнийг бөөнөөр, эсвэл жижиглэнгээр худалдах зорилгоор импортлох.

Дөрөв. Хүлээх хариуцлага, нөхөн төлбөр, маргаан шийдвэрлэх

15.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, ашиглахад тавих шаардлага, журам, технологийн горимыг зөрчиж, хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас байгаль орчинд хохирол учруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, нөхөн төлбөр ногдуулна.

16.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн бодис, бүтээгдэхүүнийг импортлох, ашиглахтай холбогдон гарсан маргааныг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

ОЗОН ЗАДАЛДАГ БОДИСЫГ ИМПОРТЛОХ, ХУДАЛДАХ,АШИГЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ МАЯГТ

19..оны ... дугаар
сарын ... –ны өдөр

Дугаар...

.....аймаг/нийслэлийн.....
.....сум, дүүрэг, хорооны харьяат .....
.....
.....
.....(хаана ямар ажилтай) .....
...../төрлийн үйлдвэрлэл,
үйлчилгээ/.....эрхлэх.....тоот
(гэрчилгээ, үнэмлэх, зөвшөөрөл г.м)-тэй .....
овогтой .....-ны.....нь .....
.....
.....зориулалтаар.....
.....
.....(озон задлагч бодисын
нэр төө, хэмжээ)-ийг .....
.....эрхтэй тул зөвшөөрлийг .... оны ... сарын
.....-нээс .....(жил, сар, хоног)-ийн хугацаатай олгов.

Зөвшөөрөл олгосон: .....
(байгууллага, албан тушаал, нэр)

Тамга. Тэмдэг

Гарын үсэг

Хянасан: .....
(байгууллага, албан тушаал, нэр)

Гарын үсэг.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 30-ны өдөр | **Дугаар 105** | **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Хүн амын сүү, цагаан идээний хангамжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Цагаан хувьсгал" Үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын, уг хөтөлбөрийг төв, орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагдугай.

2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд холбогдох яам, агентлаг, аж ахуйн нэгжүүдийг татан оролцуулж, иргэд, үйлдвэр, аж ахуй, арилжааны банк, гадаадын зээл, тусламж зэрэг хөрөнгийн эх үүсвэрийг ашиглах замаар шийдвэрлэж байхыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Сангийн сайд Я.Очирсүх, Гадаад харилцааны сайд Н.Туяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг үндэсний зөвлөлд тайлагнаж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Үндэсний зөвлөлийн дарга Ч.Содномцэрэн нарт тус тус даалгасугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Хөдөө аж ахуй,
үйлдвэрийн сайд **Ч. СОДНОМЦЭРЭН**

Засгийн газрын 1999 оны 105 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ЦАГААН ХУВЬСГАЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Сүү, цагаан идээний үйлдвэрлэл, хангамжийн өнөөгийн түвшин

Сүүлийн жилүүдэд мал сүргийн тоо өсч байгаагийн хэрээр сүү, цагаан идээ бэлтгэх боломж нөөц нэмэгдэж байна. Мал хувийн өмчид шилжиж эдийн засгийн чөлөөт зах зээлийн орчин бий болсноор малчид, мал бүхий иргэд малынхаа саалийг ашиглаж сүү, цагаан идээгээ борлуулж, ашиг орлогоо нэмэгдүүлэх таатай нөхцөл бүрдэж эхэллээ.

Үндэсний уламжлалт технологиор бэлтгэсэн цагаан идээний зах зээл бий болон өргөжиж байгаа боловч орон нутагт саавал зохих малыг саалинд бүрэн хамруулж чадахгүй байгаагаас сүүний их нөөц алдаж байна. Сүү, цагаан идээ бэлтгэх, боловсруулах, борлуулах ажил урсгал байдалтай байна.

Саалийн механикжсан фермүүд задарч сүүг жилийн турш бэлтгэн нийлүүлэх технологи алдагдаж, сүүний үүлдрийн үхрийн тоо, ашиг шим буурснаас аймаг, нийслэл, төв суурин газрын хүн амын сүүний хангамжид бэрхшээл учирч байна.

Байгаа нөөцийг зохистой ашиглан сүү, цагаан идээгээр хүн амыг хангах талаар төр, засгийн чиглэсэн зорилготой бодлого, зохицуулалт шаардагдаж байна.

2.Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүчний хангамж нэмэгдэж, мал сүргийн өсөлт тогтворжиж байгаад тулгуурлан малын сүүний ашиглалтыг сайжруулан, боловсруулалтын түвшинг дээшлүүлж сүү, цагаан идээний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд уялдуулах, энэ чиглэлээр төр, засгаас явуулах бодлогыг тодорхойлох;

Хүнсний тухай хууль, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн хүн амыг хүнсний аюулгүй бүтээгдэхүүнээр хангах, хоол, хүнсний бүтцэд сүү, цагаан идээний эзлэх хувийн жинг нэмэгдүүлж, улмаар физиологийн хэрэгцээг амин дэм, бичил мах бодиор баялаг хоол хүнсээр хангах зорилтыг хэрэгжүүлэхэд оршино.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.Хөтөлбөрийн зорилго

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн дотоод нөөц бололцоог дайчлан ашиглаж, сүү, цагаан идээний үйлдвэрлэл эрхэлж ирсэн уламжлалыг сэргээх, боловсруулах жижиг үйлдвэрийг хөгжүүлэх, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх тогтолцоо бүрдүүлэх замаар хүн амын сүү, цагаан идээний хангамжийг сайжруулах, малчид, хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэн орон нутагт ажлын байр шинээр бий болгоход хөтөлбөрийн зорилго оршино.

4.Хөтөлбөрийн зорилт

Нэгдүгээр зорилт-бэлчээрийн мал аж ахуй дахь сүүний нөөцөд тулгуурлан уламжлалт цагаан идээ, хатаасан болон өтгөрүүлсэн сүү, зарим төрлийн хатуу бяслаг, уургийн бэлдмэл зэрэг удаан хадгалагдах бүтээгдэхүүн үйлдвэрлэх, цөцгийн тос үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг орон нутагт хөгжүүлж, төвлөрсөн зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх орчинг бүрдүүлэх;

Хоёрдугаар зорилт-нийслэл, аймгийн

төв. бусад суурин газрын ойролцоо сүү үйлдвэрлэлийн эрчимжсэн аж ахуйг сэргээх, шинээр байгуулан хөгжүүлэх, сүү, цагаан идээ үйлдвэрлэлийн чиглэлээр дагнасан хувийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллуулж хүн амын сүү, цагаан идээний хангамжийг дээшлүүлэх;

Гуравдугаар зорилт-сүү, цагаан идээ үйлдвэрлэх чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийг нийслэл, бусад суурин газарт байгуулан хөгжүүлэх, сүүний нэмэгдэл уураг, казейн, казейнатууд, гүүний хатаасан сүү, уургийн бэлдмэл зэрэг бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломжийг бүрдүүлэх.

Гурав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, шийдвэрлэх асуудал

5.Нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а/аймгийн төв, сум болон бусад суурин газрын ажил эрхлээгүй, эсхүл цөөн малтай иргэдээр ажиллах хүч дутагдалтай айл өрхийн малыг саалгах ажлыг нутгийн захиргааны байгууллагын зүгээс зохион байгуулж саалинд хамрагдах малын тоог нэмэгдүүлэх;

б/сүү, цагаан идээг зах зээлд тогтвортой нийлүүлж байгаа иргэдийг урамшуулж, зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих;

в/мал бүхий иргэд, аж ахуйн нэгж хоршиж сүү, цагаан идээ үйлдвэрлэх, хадгалах, тээвэрдэх, борлуулах ажлыг хамтран гүйцэтгэхийг бүх шатны нутгийн захиргааны байгуулага дэмжиж ажиллах;

г/аж ахуйн нэгж, хувь хүн цөцгийн тосны үйлдвэрлэл эрхлэж байсан үйлдвэрлэлийн барилга, тоног төхөөрөмжийг сэргээн засварлаж ашиглах, зарим тоног төхөөрөмжийг дотоодлоо үйлдвэрлэхийг дэмжих;

д/сүү, цагаан идээ боловсруулах, үйлдвэрлэх чиглэлээр мэргэшсэн ажилчин, мэргэжилтэн бэлтгэн ажиллуулах замаар цөцгийн тос, цагаан идээний үйлдвэрлэлийг сэргээх, шинээр бий болгох;

е/өрх айл, фермерийн аж ахуйд цөцгийн тос, цагаан идээний үйлдвэрлэл эрхлэхэд шаардагдах сав суулга, баглаа боодол, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэх болон импортоор олж нийлүүлэх аж ахуйн нэгжийг шалгаруулж дэмжих;

ж/сумдад нүүдлийн, бага оврын төхөөрөмж ашиглан өтгөрүүлсэн болон хуурай сүү үйлдвэрлэх ажлыг зохион байгуулах;

з/гүү, ингэний болон сарлаг, бог малын сүү боловсруулах төрөлжсөн үйлдвэр, сувиллын газар байгуулж ажиллуулах бизнес төсөл шалгаруулж хэрэгжүүлэх;

и/сүү, цагаан идээ судалсан чиглэлээр ажилладаг эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааг оновчтой хорших, тэдгээрийн судалгаа, туршилтын ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх;

к/алслагдсан нутагт бэлтгэсэн цагаан идээг зах зээлд нийлүүлэх уян хатан тогтолцоог иргэд, өрх, хот айл-сум, аймгийн худалдааны аж ахуй-төв, суурин газрын зах, дэлгүүр-хэрэглэгч гэсэн хэлбэрээр шатлан зохион байгуулж хэрэгжүүлэх;

л/бүтээгдэхүүний чанарыг хамгаалах зориулалт бүхий мөсөн болон зохиомол хөргөлттэй зоориор хангах үйл ажиллагааг дэмжих.

6.Хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а/аймаг, нийслэл, томоохон төв суурингийн ойролцоо нутагт сүүний эрчимжсэн аж ахуй эрхлэх зориулалттай бүс нутгийн хил заагийг тогтоож, саалийн чиглэлийн фермерийн аж ахуй, фермер дундын хоршоонд хадлан, бэлчээр, тариалангийн эдэлбэр газрыг эзэмшүүлэх;

б/үйл ажиллагаагаа амжилттай явуулж

байгаа өрхийн аж ахуйд тэргүүн ээлжинд аж ахуй, зохион байгуулалтын хувьд бэжүүлэх дэмжлэг үзүүлэх;

в/гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл тусламжийг ашиглах замаар аймаг, нийслэл, томоохон төв суурингийн ойролцоо сүүний чиглэлийн үүлдрийн 25-50 үнээтэй саалийн фермерийн аж ахуйг шинээр байгуулах чиглэл баримтлан төсөл шалгаруулан хэрэгжүүлэх;

г/саалийн фермерийн аж ахуйд хар тарлан, алатау, шар тарлан зэрэг сүүний үүлдрийн үхэр үржүүлж нэг үнээнээс жилд 2500-гаас доошгүй литр сүү ашиглах сонирхлыг татварын бодлогоор дэмжих асуудлыг боловсруулж Улсын Их Хуралд оруулах;

д/шинэ техник, технологи нэвтрүүлэх замаар тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж сүүний үйлдвэрлэлийг жилийн турш жигд явуулах нөхцөлийг бий болгох;

е/сум, аймгийн төвийн айл өрх сүүний үүлдрийн ямаа үржүүлэхийг дэмжих;

ж/хот орчмын фермерийн аж ахуй дундын хөргөлтийн цэгүүдийг сэргээн ажиллуулах, шинээр байгуулах;

з/аймаг, нийслэл, томоохон төв сууринд сүү, цагаан идээ худалдаалах төрөлжсөн зах, дэлгүүр, үйлчилгээний цэг, цагаан хоолны гуанз ажиллуулах;

и/сүүний үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ жижиг, дунд оврын үйлдвэр, цехүүд байгуулахыг дэмжих;

к/фермерийн аж ахуйд сүүг ариутгах, хатаах, анхан шатны боловсруулалт хийх, бяслаг, цөцгий үйлдвэрлэх тоног төхөөрөмж нийлүүлэх замаар олон улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг дэмжих;

7.Гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан үйл ажиллагаа **явуулна:**

а/аймаг, нийслэл, томоохон төв суурин газруудад ажиллаж байгаад ашиглалтгүй болсон сүү боловсруулах үйлдвэр, цехийг сэргээх, тэдгээрт шинэ технологи нэвтрүүлэхэд туслах;

б/аймаг, нийслэл, томоохон төв суурин газруудад одоо ажиллаж байгаа сүү боловсруулах жижиг үйлдвэрийн үйл ажиллагааг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжиж, сургалт-үйлдвэрлэлийн загвар үйлдвэр болгон ажиллуулах, цашид жижиг үйлдвэр байгуулах чиглэл баримтлах;

в/өтгөрүүлсэн болон хатаасан сүү, нэгдсэн уураг, төрөл бүрийн казейнат үйлдвэрлэн экспортод гаргах боломжийг бүрдүүлэх;

г/хүүхдийн сүүн тэжээл, сувиллын бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх;

д/томоохон төв суурин газрын хүнсний үйлдвэрлэлийн баазад тулгуурлан зарим төрлийн зөөлөн бяслаг, бага тослогтой цөцгийн тос, ариутгасан сүү, удаан хадгалагдах тараг, аарц, зөөхий үйлдвэрлэх технологи нэвтрүүлэх;

е/үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар орон нутагт сүү боловсруулах шинэ технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;

ж/сүүний үйлдвэрлэлийн томоохон аж ахуйд сүүг ариутгах, хэсэглэн савлах технологи нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

з/импортын болон дотоодын зах зээлд борлуулж байгаа сүү, цөцгийн тос, цагаан идээ, тэдгээрийг орлох бүтээгдэхүүнд тавих чанар, эрүүл ахуй, ариун цэврийн хяналтыг хүчтэй болгох.

Дөрөв.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг

8.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам гүйцэтгэнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны гүйцэтгэх үүрэг нь:

а/энэ хөтөлбөрийн биелэлтийг хангах ажлыг Засгийн газрын бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулж, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах;

б/сүүний эрчимжсэн аж ахуй эрхэлдэг фермерүүдэд төлбөр, албан татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх;

в/сүү, цөцгийн тос, цагаан идээ бэлтгэх зорилгоор фермерийн аж ахуй эрхлэх, жижиг, дунд үйлдвэрийг сэргээж шинэчлэх, шинээр байгуулахад чиглэсэн бизнес төслүүдийг шалгаруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх;

г/аймаг, нийслэл, томоохон төв, суурин газарт сүү, цагаан идээ, цөцгийн тосны загвар үйлдвэрүүд бий болгож сургалт, сурталчилгааны түшиц болгон ажиллуулахад зээл, хөрөнгө оруулалт, мэргэжил арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

д/хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдох зарим арга хэмжээг олон улсын төсөл, зээл, тусламжид хамруулах ажлыг зохион байгуулах.

9.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хөдөө аж ахуйн хэрэгжүүлэгч агентлагийн гүйцэтгэх үүрэг:

а/хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны төсөл боловсруулж, холбогдох байгууллагуудтай хамтран хөрөнгийн эх үүсвэр олж хэрэгжүүлэх;

б/сүү, цагаан идээ үйлдвэрлэгчдийг мэдээллийн сүлжээнд хамруулах, сүү, цагаан идээ үйлдвэрлэлийн мэдээг орон нутгаас авч нэгтгэн дүгнэх, холбогдох байгууллага, хэрэглэгчдэд мэдээлэх;

в/үржлийн сайн чанарын хээлтэгч, хээлтүүлэгч малтай болох, гүн мөлдөөсөн үр, хөврөл үр ашиглах зэрэг биотехнологийн арга нэвтрүүлэхэд фермерүүдэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх;

г/сүүний эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн мал сүргийг бруцеллёз, лейкоз, сүрьеэ зэрэг зооантропонози өвчнөөс эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

10.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын гүйцэтгэх үүрэг:

а/"Цагаан хувьсгал" дэд хөтөлбөрийг орон нуттийнхаа онцлогтой уялдуулан боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

б/аймаг, нийслэл, томоохон төв суурин газрын хүн амын сүү, цагаан идээний хангамжийг сайжруулахад саалийн эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх зориулалт бүхий бүс нутгийн хил заагийг тогтоох;

в/"Цагаан хувьсгал" хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг төлөвлөж санхүүжүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

г/малыг саалинд хамруулах ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулахтай уялдуулан зохион байгуулж хэрэгжүүлэх;

д/сүү, цагаан идээ бэлтгэх, боловсруулахад иргэдийг сургах, энэ ажилд гарч байгаа арга барил, олдлыг дэмжин сурталчилах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

17.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн дийлэнх нь үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч байгууллага, иргэдийн хувийн хөрөнгө байна

18.Туршилтын болон загвар фермерийн аж ахуй, боловсруулах жижиг, дунд үйлдвэр байгуулах, сэргээх, дэвшилттэй шинэ технологи нэвтрүүлэх зэрэг зарим арга хэмжээнд санхүүгийн дараахь эх үүсвэрийг ашиглана:

а/иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;

б/ хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

в/ жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

г/ ядуурлыг бууруулах сан;

е/ ажлын байр нэмэгдүүлэх төсөл;

д/ "Улаанбаатар" сан;

ж/ төрийн бус байгууллагын хандив, тусламж

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат, шалгуур

19.Энэхүү хөтөлбөрийг 1999-2004 оныг дуустал 6 жилийн хугацаанд 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Үе шат бүрт хийх ажил, хүрэх түвшинг дор дурдсан шалгууруар дүгнэнэ:

Нэгдүгээр үе шат: 1999-2000 оныг хамарна. Энэ үе шатанд:

а/орон нутагт малын сүүний нөөцийг бүрэн ашиглах хөдөлгөөн өрнүүлж, уламжлалт цагаан идээний үйлдвэрлэл эрчимтэй сэргэн хөгжих зохион байгуулалтын арга хэмжээ авч, үйл ажиллагааг эхлүүлнэ;

б/нийслэл, томоохон хотуудын ойролцоо сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй хөгжих үндэс болсон бүс нутгийн хил заагийг тогтоох эхлэл тавигдана;

в/сүүний эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд бэлчээр, хадлангийн газрыг эзэмшүүлэх ажлыг эхэлнэ. Одоо хэлбэршиж байгаа фермерүүдийг дэмжих замаар зохистой хэмжээ, бүтэц бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлэхийн хамт өрхийн аж ахуйнуудыг фермерийн хэмжээнд хүргэх бэлтгэлийг хангана;

г/төрөл бүрийн малын сүү боловсруулах, савлах загвар үйлдвэр, цехийг Улаанбаатар хот болон зарим аймаг, сумын төвд байгуулж эхэлнэ;

д/хөтөлбөрийн хүрээнд дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх төслийн баримт бичгүүдийг боловсруулж шийдвэрлүүлэхийн зэрэгцээ санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдсэн төслийг хэрэгжүүлж эхлэнэ;

е/хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон шинжлэх ухаан, техникийн зарим төсөл захиалж судалгааны ажил эхэлнэ.

Хоёрдугаар үе шат: 2001-2004 оныг хамарна. Энэ үе шатанд:

а/бэлчээрийн мал аж ахуйгаас бэлтгэх уламжлалт цагаан идээний үйлдвэрлэл нэмэгдэж, экологийн цэвэр, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлнэ;

б/сүү, цагаан идээний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор шинэ техник, технологийг нутагшуулах, цагаан идээ боловсруулах хялбар хийцийн тоног төхөөрөмж дотоддоо үйлдвэрлэх эхлэл тавигдана;

в/сүүний чиглэлийн фермерийн аж ахуйг татвар, хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих эрх зүйн орчинг бүрдүүлэх баримт бичгийн төслүүд боловсрогдож батлагдсан байна;

г/саалийн эрчимжсэн фермерийн аж ахуйнууд төлөвшин хөгжихийн хамт механикжилт, цахилгаанжилтын түвшин дээшилж жилийн турш сүү бэлтгэх нөхцөл бүрдэнэ;

д/хадлан, тэжээл бэлтгэх, тариалан эрхлэх, сүү, цагаан идээ боловсруулах, худалдан борлуулах чиглэлээр фермер дундын хоршоог дэмжиж хөгжүүлнэ;

е/сүү боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулж хатаасан болон өтгөрүүлсэн сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ;

ж/сүү, цагаан идээний чанар, эрүүл ахуй, ариун цэврт хяналт тавих эрүүл ахуйн хяналтын нэгдсэн сүлжээ бий болно;

з/малыг бруцеллёз, лейкоз, сүрьеэ өвчнөөс эрүүлжүүлэх, урьчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжинэ;

и/хатаасан болон өтгөрүүлсэн сүүгээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, казейнат, гүүний саам, үнээний тослоггүй хатаамал сүү зэрэг бүтээгдэхүүнийг экспортод гаргах боломж бүрдүүлнэ.

Найм. Хөтөлборийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

20.Ойрын жилүүдэд гарах шууд үр дүн:

а/малыг саалинд хамааруулах хүрээ өргөжиж, сүү бэлтгэлийн хэмжээ нэмэгдэнэ;

б/хот суурингийн ойролцоо бүсэд сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуйн суурь тавигдаж цаашдын хөгжлийн гараа бий болно;

в/сүү, цагаан идээний боловсруулалт, борлуулалтын түвшин дээшилж, хүн амын хүнсний хангамжид ахиц гарна;

г/хот, хөдөөд сүү, цагаан идээ боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүд буй болно;

д/хүн амы г хүнсний аюулгүй сүү, цагаан идээгээр хангах, эрүүл ахуй, ариун цэврийн хяналт сайжирна.

21.Шууд бус үр дүн:

а/төв, орон нутагт ажлын байр нэмэгдэж хүн амын ядуурлын түвшинг бууруулахад нөлөө үзүүлнэ;

б/хүн амын, ялангуяа малчдын мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд түлхэц болно;

в/хоол хүнсний бүтцэд сүү, цагаан идээний эзлэх хувь нэмэгдсэнээр хүн амын эрүүл мэндэд таатай нөлөө үзүүлнэ.

Засгийн газрын 1999 оны 105 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"ЦАГААН ХУВЬСГАЛ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд	-Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн албаны дарга;
Орлогч дарга:	-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга	-Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны дарга;
Гишүүд:	-Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, хамтын ажиллагааны газрын дарга;	-Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын дарга;
	-Байгаль орчны яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга;	-Хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны Мал эмнэлгийн улсын ерөнхий байцаагч;
	-Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад харилцааны албаны дарга;	-Сүү үйлдвэрлэгчид, боловсруулагчдын холбооны нарийн бичгийн дарга /тохиролцсоноор/;
	-Сангийн яамны Төсвийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн;	-"Хүнс тех" корпорацийн эрдэмтэн нарийн бичгийн дарга.
	-Үндэсний татварын ерөнхий газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга;	Нарийн бичгийн дарга -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөө аж ахуйн газрын дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 6 дугаар сарын 30-ны өдөр **Дугаар 107** **Улаанбаатар хот**

Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны болон эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Газрын шинэтгэлийг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтын ёсоор батлагдсугай.

2. Уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд С. Мэндсайхан, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч. Содномцэрэн, Хууль зүйн сайд Л. Цог, төлөвлөгөөний биелэлтийг орон нутагтаа шуурхай зохион байгуулан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, үр дүнг жил бүрийн 12 дугаар сард багтааж Засгийн газарт танилцуулж байхыг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Н. Батбаярт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж. НАРАНЦАЦРАЛТ**

Байгаль орчны сайд **С. МЭНДСАЙХАН**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд **Ч. СОДНОМЦЭРЭН**

Засгийн газрын 1999 оны 107 дугаар тогтоолын хавсралт

ГАЗРЫН ШИНЭТГЭЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Авах арга хэмжээ	Хариуцах этэн	Хугацаа	Гарах үр дүн
1	2	3	4
Нэг. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар			
1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг хязгаарласан зэрэг газрын эрх зүйн талаархи зөрчилтэй хуулийн заалт, тогтоол, журмын жагсаалт гарган, тэдгээрийг өөрчлөх санал боловсруулж, эрх бүхий байгууллагад оруулж шийдвэрлүүлэх	Хууль зүйн яам, Байгаль орчны яам	1999-2000 он	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг өргөтгөх, бүртгэх, хамгаалах арга хэмжээний үр дүнд газрын эрх баталгаажиж, газарт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдэнэ
2. Газар эзэмшүүлэх, ашиглуулах ажлын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:	Хууль зүйн яам, Байгаль орчны яам	1999 оны ХП сар	Газар эзэмших, ашиглах эрх баталгаажиж үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх, экологийн тэнцвэрийг хадгалан тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ.
а/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрхийг бүртгэж баталгаажуулах, газрын мэдээллийн санг бий болгон, түүнийг эрхлэх ажлын эрх зүйн үндсийг бүрдүүлэх;			
б/газрын тухай хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт оруулах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, газрын эрэлт хэрэгцээг эдийн засгийн аргаар зохицуулах хөшүүргийг боловсронгуй болгох;	Газар зохион байгуулах алба, нийслэлийн Засаг дарга	1999 он	Газрын эзэмшил, ашиглалттай холбоотойгоор гарсан маргааныг шийдвэрлэх, санал, гомдлыг барагдуулах шат дамжлага цөөрнө

1	2	3	4
в/хөөр буюу түүнээс дээш иргэн, хуулийн этгээд газар зээмших, ашиглахаар хүсэлт гаргасан нөхцөлд газрыг зээмшүүлэх, ашиглуулах эрх олгон, газрыг байгуулахад мөрдөх төсөл боловсруулж, шийдвэрлүүлэх;			
г/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар зээмших, ашиглах эрх олгох, үүнтэй холбогдсон санал, гомдлыг шийдвэрлэх, шат дамжлагыг цөөлөх, давхардлыг арилгах талаар санөл боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;			
д/газрын талаар гарсан маргааныг хянан шийдвэрлэх, хууль зөрчсөний улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох.	Хууль зүйн яам, Байгаль орчны яам,Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн Засаг дарга	1999-2000 он	Газрын хууль тогтоомжийг зөрчих явдал багасна.
3.Газрын төлбөрийн тухай хуулийг боловсронгуй болгож батлуулах, ашиг малтмалын тухай болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг зөрчимжүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагатай тооцоо харилцаагаа чангатгах арга хэмжээ авах.	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, Байгаль орчны яам	1999-2000 он	Газрын төлбөр төлөлтийг сайжруулснаар газрын талаар авах арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэх, зээмшигч, ашиглагчийн зүгээс газарт зөвийг ёсоор хандах хандлагыг дээшлүүлэх хөшүүрэг болно.
4.Газар зээмших эрхийг барьцаалах, худалдах зэргээр шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх	Байгаль орчны яам, Хуульзүйн яам	1999-2000 он	Газар зээмших, ашиглах эрх шилжих нөхцөл бүрдсэнээр газрын түрээсийн зах зээл жам ёсоор хөгжих бололцоотой болно.
5. Ашиг малтмалын тухай хуулийн зарим заалтыг Газрын тухай, Газрын хэвлийн тухай хуулиудтай нийцүүлэх	Хууль зүйн яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, Байгаль орчны яам	1999-2000 он	Газар зээмшүүлэн ашиглуулах эрхийг давхардуулан олгодог үйл ажиллагаа зогсоно.

1	2	3	4
Хоёр. Газрын менежментийг боловсронгуй болгох талаар			
6.Засгийн газраас хэрэгжүүлж байгаа агентлагуудын бүтцийн өөрчлөлтийн бодлогын хүрээнд газрын холбогдолтой чиг үүрэг хэрэгжүүлдэг яамд, агентлагуудын асуудлыг тусгайлан авч үзэж, эдгээр чиг үүргүүдийг нэгтгэн Газрын шинэтгэлийн хороо байгуулах тухай санал боловсруулж Улсын Их Хуралд оруулах	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	1999 оны XI сар	Газар эзэмших, ашиглах эрх олгох, түүнийг бүртгэж баталгаажуулах, газрын менежмент, хайгуул-судалгаа, зураглал, кадастр, мэдээллийн санг эрхлэх чиг үүргүүд нь хоорондоо уялдаа холбоотой явагдах, гарч байгаа шийдвэр нь давхардал, зөрчилгүй болох, төрийн газар өмчлөх эрх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх үр өгөөжтэй, хөнгөн шуурхай хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Газрын чиглэлийн байгууллагуудын боловсон хүчний чадавхи, техник, тоног төхөөрөмжийн хангамж дээшлэж, тэдгээрийн зүгээс холбогдох чиг үүргээ мэргэжлийн өндөр түвшинд үр ашигтай эрхлэн явуулах нөхцөл бүрдэнэ.
7. Төв, орон нутгийн газар зохион байгуулалтын албадын тогтолцоог боловсронгуй болгох, менежментийн чадавхийг дээшлүүлэх	Байгаль орчны яам, аймаг, нийслэлийн Засаг дарга	1999-2000 он	Төв, орон нутагт газрын шинэтгэлийг хэрэгжүүлэх менежментийн чадавхи дээшилнэ.
8.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах эрх хэрэгжих нөхцөлийг сайжруулах, бүртгэж баталгаажуулахтай холбогдсон хууль тогтоомж, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Байгаль орчны яам, аймаг, нийслэлийн Засаг дарга	1999-2000 он	-"-
9.Бололцоотой бүс нутагт нийтээр дундаа эзэмшиж, ашигладаг бэлчээрийн газрыг хуулийн хүрээнд хэсэг, бүлгийн болон айл өрхийн түвшинд дүнд нь эзэмшүүлэх, ашиглуулах эрх олгох, гэрээ байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудын туслалцаатайгаар туршиж, нэвтрүүлэх	Газар зохион байгуулах алба, аймаг, нийслэлийн Засаг дарга	1999-2000 он	Хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг гэрээлэн эзэмшүүлэх, ашиглуулах хүрээнд газар эзэмшигч, ашиглагчдын сонирхлыг нь төрүүлэхэд чиглэсэн доорхи асуудлыг шийдвэрлэнэ:

1	2	3	4
19.Газрын төлбөрийн орлогын 30 хүртэл хувийг жил бүр улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэн авч газрын мэргэжлийн байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх, газрыг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээнд зарцуулах асуудлыг шийдвэрлүүлэх	Байгаль орчны яам, Сангийн яам	1999-2000 он	Газрын менежментийн үйл ажиллагаа, газар зохион байгуулалтын арга хэмжээ, газрыг нөхөн сэргээх, хамгаалахад шаардагдах санхүүгийн тогтвортой эх үүсвэртэй болно.
20.Геодези зураг зүйн ажлын хүрээнд дараахь чиглэлээр асуудал боловсруулж холбогдох байгууллагад тавих: а/улсын геодезийн сүлжээний шинэчлэлд зориулан улсын төсвийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 30 гаруй цэг бүхий GPS-ын сүлжээний хэмжилтийн үр дүнг боловсруулах, газрын шинэтгэлийг эрчимжүүлэх ажилд шаардагдах дэвсгэр зургаар хангах; б/монгол орны нутаг дэвсгэрийн геофизикийн орон зайг илэрхийлж чадах референц-эллипсоид сонгох ажлыг хийхэд шаардагдах программ хангамжийг санхүүжүүлэх; в/геодези, зураг зүйн улсын фондод байгаа зураг, мэдээллийг компьютерт оруулах, байр зүйн болон бусад зургийг тоон загварт шилжүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, программ хангамж, сургалтын зардлыг санхүүжүүлэх; г/фотограмметрийн үйлдвэрлэлийг тоон технологид шилжүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, программ хангамж, сургалтын зардлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.	Дэд бүтцийн хөгжлийн яам	1999 оны IX сар	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | **Дугаар 109** | **Улаанбаатар хот**

Нэрэмжит болгох тухай

Гэгээрлийн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Шинжлэх ухааны академи болон Өвөрхангай, Завхан, Хөвсгөл, Булган, Увс, Баян-өлгий, Баянхонгор аймгийн Засаг дарга нарын саналыг үндэслэн нэр бүхий төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнүүдийн дурсгалыг мөнхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Өвөрхангай аймгийн Богд сумын дунд сургуулийг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт яруу найрагч Цэвэгмидийн Гайтавыг; Завхан аймгийн төв номын санг Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт яруу найрагч Бэгзийн Явуухулангийн; Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын дунд сургуулийг Монгол Улсын Ардын жүжигчин, Төрийн шагналт кино найруулагч Дэжидийн Жигжидийн; Булган аймгийн Булган сумын 10 жилийн 2 дугаар дунд сургуулийг Чин ван Мижиддоржийн Ханддоржийн; Увс аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Хүний гавьяат эмч Халтарын Дэлгэгийн; Баян-өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг Монгол Улсын Хөдөлмөрийн баатар Арены Зайтины; Баянхонгор аймгийн "Номун далай" погоолбор сургуулийг Төрийн шагналт химич, доктор Банзарын Доржпаламын; Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийг Монгол Улсын Хүний гавьяат эмч Намжилын Гэндэнжамцын нэрэмжит тус тус болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Гэгээрлийн сайд **А.БАТТӨР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | **Дугаар 110** | **Улаанбаатар хот**

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор батлагдсан "Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт"-д дор дурдсан нэмэлт оруулсугай:

111.

Дурсгалын нэр:	БҮСНИЙ ЧИМЭГЛЭЛ
Зохиогч:	тодорхойгүй
Хэдийд бүтээгдсэн:	XП-XШ зуун
Хадгалагдаж байгаа газар:	Монгол банкны Эрдэнэсийн сан
Дурсгалын шинж байдал:	Алт, 32 ширхэг, жин 118.000 мг
Дансны дугаар:	"Түүх, соёлын дурсгалт хосгүй үнэт зүйлс" гэсэн тусгай данс

112.

Дурсгалын нэр:	ХҮЗҮҮНИЙ ЧИМЭГЛЭЛ
Зохиогч:	тодорхойгүй
Хэдийд бүтээгдсэн:	м.э.ө IУ-Ш зуун
Хадгалагдаж байгаа газар:	Монгол банкны Эрдэнэсийн сан
Дурсгалын шинж байдал:	Цоолбор, алт, 72200 мг
Дансны дугаар:	"Түүх, соёлын дурсгалт хосгүй үнэт зүйлс" гэсэн тусгай данс

113.

Дурсгалын нэр:	ҮСНИЙ ХАВЧААР
Зохиогч:	тодорхойгүй
Хэдийд бүтээгдсэн:	м.э.ө IУ-Ш зуун
Хадгалагдаж байгаа газар:	Монгол банкны Эрдэнэсийн сан
Дурсгалын шинж байдал:	Аргалын толгой

бүхий 2ш, Жижигхэн ногоон нэг шиггтээтэй, жин 76840 мг

Дансны дугаар: "Түүх, соёлын дурсгалт хосгүй үнэт зүйлс" гэсэн тусгай данс

114.
Дурсгалын нэр: МОРИНЫ ХУДАРГАНЫ ЧИМЭГЛЭЛ
Зохиогч: тодорхойгүй
Хэдийд бүтээгдсэн: м.э.ө IY-Ш зуун
Хадгалагдаж байгаа газар: Монгол банкны Эрдэнэсийн сан
Дурсгалын шинж байдал: Алтан чимэглэл 39ш, жин 82660 мг
Дансны дугаар: "Түүх, соёлын дурсгалт хосгүй үнэт зүйлс" гэсэн тусгай данс

115.
Дурсгалын нэр: АЛТАН ЧИМЭГ
Зохиогч: тодорхойгүй
Хэдийд бүтээгдсэн: м.э. Ш-IY зуун
Хадгалагдаж байгаа газар: Монгол банкны Эрдэнэсийн сан
Дурсгалын шинж байдал: Хүний дүрс, үсэг бүхий нимгэн жижиг дугариг алт, шиггтээгүй, жин 1250 мг
Дансны дугаар: "Түүх, соёлын дурсгалт хосгүй үнэт зүйлс" гэсэн тусгай данс

116.
Дурсгалын нэр: КУЛЬТЕГИНИЙ ТОЛГОЙ
Зохиогч: тодорхойгүй
Хэдийд бүтээгдсэн: 732 он
Хадгалагдаж байгаа газар: ШУА-ийн Түүхийн хүрээлэн
Дурсгалын шинж байдал: Саарал өнгийн гантиг чулуу, өндөр нь 43см, өргөн нь 21см, зузаан нь 20см, таван талт титэмтэй голд нь бүргэдийн дүрстэй, титмээрээ ташуу хугарсныг наасан.

117.
Дурсгалын нэр: ОЧИРДАРА
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: XYП-XYШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Очирдарын дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 98x70x70см
Дансны дугаар: 370

118.
Дурсгалын нэр: МАЙДАР (босоо)
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: XYП-XYШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Очирдарын дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 80x27x27см
Дансны дугаар: 373

119.
Дурсгалын нэр: МАЙДАР (босоо)
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: XYП-XYШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Очирдарын дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 76x24x24см
Дансны дугаар: 390

142.
Дурсгалын нэр: СОСОРБАРАМ
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: XYП-XYШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Очирдарын дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал, эрэнаа рүжин нь чулуун шиггтээтэй, 33x20x20см
Дансны дугаар: 444 (371)

121.
Дурсгалын нэр: ЧОЙЖИЙ ЖАНЦАН БОГД
Зохиогч: Г.Занабазар

Хэдийд бүтээгдсэн: ХҮП-ХҮШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Очирдарын дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 35х16х16см
Дансны дугаар: 378

122.
Дурсгалын нэр: ЛХАМЖ ДҮЙНХОР
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: ХҮП-ХҮШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Очирдарын дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал, 33х17х6см
Дансны дугаар: 464

123.
Дурсгалын нэр: ОЧИРДАРА
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: ХҮП-ХҮШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Зуугийн дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал, 88х39х28см
Дансны дугаар: 635

124.
Дурсгалын нэр: БОГД ЛАМ
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: ХҮП-ХҮШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Гандан дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 39х26х26см

125.
Дурсгалын нэр: БОГД
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: ХҮП-ХҮШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Гандан дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 23х12х12см
Дансны дугаар: 76

126.
Дурсгалын нэр: ӨНДӨР ГЭГЭЭН
Зохиогч: тодорхойгүй
Хэдийд бүтээгдсэн: ХҮШ-ХIХ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Гандан дуган
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 100х70х40см
Дансны дугаар: 67

127.
Дурсгалын нэр: ОСОРГОЧОО
Зохиогч: Нэр нь үл мэдэгдэх бүтээлч
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн Гандан дуган
Хэдийд бүтээгдсэн: 1414 он
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 47х35х25см

128.
Дурсгалын нэр: 11 ТЭРГҮҮНТ АРЬЯАБАЛ
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: ХҮП-ХҮШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн номын сан
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 46х9,5х9,5см
Дансны дугаар: Д-5

129.
Дурсгалын нэр: БУРХАН БАГШ
Зохиогч: Г.Занабазар
Хэдийд бүтээгдсэн: ХҮП-ХҮШ зуун
Хадгалагдаж байгаа газар: Гандантэгчэнлин хийдийн номын сан
Дурсгалын шинж байдал: Гууль цутгамал, алт шармал 31х25х19см
Дансны дугаар: Д-71

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Гэгээрлийн сайд **А.БАТТӨР**

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 5 дугаар 11-ний өдөр | Дугаар А/72 хот | Улаанбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын засгийн газрын 1998 оны 145 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1."Тэргүүний хоршоо" шалгаруулах журмыг хавсралтын ёсоор батална.

2."Тэргүүний хоршоо"-гоор шалгаруулахаар тодорхойлж ирүүлсэн материалыг журмын дагуу судлан дүгнэлт гаргаж Төрийн нарийн бичгийн даргын Зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэхийг Салбарын бодлого зохицуулалтын газар /н. БАЛГАНСҮРЭН/-т даалгасугай.

САЙД С. СОДНОМЦЭРЭН

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын А/72 тоот тушаалын хавсралт

ТЭРГҮҮНИЙ ХОРШОО ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 145 тоот тогтоолыг үндэслэн "Тэргүүний хоршоо"-г шалгаруулахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Журам нь "Хоршооны тухай хууль"-ийн дагуу зохион байгуулагдсан, Хоршоодын холбооны гишүүн аж ахуйн нэгжид хамаарна.

1.3.Журмын 2-ын 1-д заасан нөхцөлийг хангасан 6 хүртэлх хоршоог жил бүр "Тэргүүний хоршоо"-гоор шалгаруулж шагнаж урамшуулна.

1.4."Тэргүүний хоршоо"-г шалгаруулахдаа ил тод, шударга, ардчилсан зарчмыг баримтална. Шаардлагатай гэж үзвэл тодорхой хүрээнд санал асуулга явуулж болно.

Хоёр. "Тэргүүний хоршоо"-нд тодорхойлох үндэслэл

2.1."Тэргүүний хоршоо"-г тодорхойлох үндэслэн шалгуур нь Олон улсын Хоршооллолын Манчестрийн Их хурлаас гаргасан хоршооллын хөдөлгөөний 21-р зуунд баримтлах үндэсэн 7 зарчим /журмын 1 дүгээр хавсралт/-ын хэрэг-жилт байх бөгөөд дор дурьдсан нөхцөлийг хангасан байна:

2.1.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу татвар, хураамжийг цаг хугацаанд нь төлсөн байх;

2.1.2.Банк, санхүүгийн болон бусад байгууллагуудад өр төлбөр, хугацаа хэтэрсэн зээл, найдваргүй авлагагүй байх.

2.1.3.Шинээр ажлын байр бий болгосон байх;

2.1.4.Үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалт, тэр нь өгөөжтэй байх

2.1.5.Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлттэй байх.

2.2.Журмын 2.1.3, 2.1.4, 2.1.5-т заасан үзүүлэлтүүд нь хөдөө аж ахуй, эд хэрэглэгч, хадгаламж зээлийн хоршоонд хамаарахгүй.

Гурав. Шалгаруулах ажлын зохион байгуулалт

3.1.Хоршоодын холбоод тус бүр "Тэргүүний хоршоо"-гоор тодорхойлох үндэслэлийг хангасан гэж үзэж байгаа 3 хүртэлх хоршооны холбогдох материалыг бүрдүүлж тухайн оны 12 дугаар сарын 1-ны дотор Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яаманд хүргүүлнэ.

3.2."Тэргүүний хоршоо"-гоор шалгаруулахаар тодорхойлохдоо дор дурьдсан материалыг бүрдүүлнэ:

3.2.1. Хоршооны танилцуулга;

3.2.2.Сүүлийн 2 жилийн санхүү, удирдлагын зарим үзүүлэлт; /2дугаар хавсралт/

3.2.3. Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын тодорхойлолт;

3.2.4.Холбогдох Хоршоодын холбооны тодорхойлолт;

3.2.5.Татварын албаны тодорхойлолт.

3.2.6.Шинээр бий болсон ажлын байры тодорхойлолтыг сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас авсан байна.

3.3.Журмын 3.2.6-д заасан заалт нь зөвхөн үйлдвэрлэл, үйлчилгээний хоршоонд хамаарна.

3.4.Хоршоодын холбоодоос ирүүлсэн материалыг Хөдөө аж ахуй үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг судлан үзэж дүгнэлт гарган Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлнэ.

3.5.Хоршоодын холбоод нь "Тэргүүний хоршоо" шалгаруулах тухай зар мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулна.

Дөрөв. "Тэргүүний хоршоо" шалгаруулах хугацаа, үзүүлэх урамшуулал

4.1."Тэргүүний хоршоо"-нд олгох шагнал, урамшуулалыг Монгол Улсад анхны хоршоо байгуулагдсан 12-р сарын 16-ны өдөр гардуулна.

4.2."Тэргүүний хоршоо"-нд Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны хүндэтгэлийн гэрчилгээ, 100.0 мянган төгрөгний үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулна.

"Тэргүүний хоршоо" шалгаруулах журмын 1 дүгээр хавсралт

ОЛОН УЛСЫН ХОРШООЛЛЫН МАНЧЕСТРИЙН ИХ ХУРЛААС ГАРГАСАН ХОРШООЛЛЫН ХӨДӨЛГӨӨНИЙ 21-Р ЗУУНД БАРИМТЛАХ ҮНДСЭН 7 ЗАРЧИМ

1. Сайн дураар чөлөөтэй гишүүнээр элсэх:

Хоршоо нь арьс өнгө, хүйс, нийгмийн гарал, улс төрийн үзэл баримтлал, шашин шүтлэг зэргээр ялгаврлан гадуурхахгүй, хоршооны гишүүний үүрэг, хариуцлагыг хүлээн зөвшөөрсөн, хоршооны үр шимийг хүртэх чадвартай хүн бүр чөлөөтэй элсэж блолох сайн дурын байгууллага юм.

2. Гишүүдийн ардчилсан хяналт:

Хоршоо нь бодлого боловсруулах, шийдвэр гаргахад гишүүд нь идэвхтэй оролцог хамтын хяналтын ардчилсан байгуулага мөн. Хоршооны удирдлагад сонгогдсон эрэгтэй, эмэгтэй гишүүд нь бусад гишүүдийн өмнө тайлагнана. Анхан шатны хоршоодод нэг гишүүн нэг санал өгөх эрхтэй бөгөөд бусад шатны хоршоо энэхүү ардчилсан зарчмыг баримтлан байгуулагддаг.

3.Гишүүдийн эдийн засгийн оролцоо:

Гишүүд нь хоршооны санд шударгаар хувь нэмэр оруулах ба ардчилсан зарчмын үндэсэн дээр хяналт тавина. Хамтын хөрөнгийн нэг хэсэг нь хоршооны өмч байдаг. Хоршооны гишүүнээр элсэх нөхцөлд заагдсан тохиолдолд гишүүд нь хувь нийлүүлэн хөрөнгийн тодорхой хувьтай тэнцэх нөхөөр авдаг. Гишүүд нь хоршооны хуримтлалыг дараах зорилгуудыг бүхэлд нь буюу хэсэгчилэн хэрэгжүүлэхэд зориулж хуваарилдаг:

а/Хуримтлагдсан хөрөнгийн тодорхой хэсэг нь хоршооны өмч болно.

б/Нөөц хөрөнгө хуримтлуулах замаар хоршоог хөгжүүлэх.

в/Хоршооны үйл ажиллагаанд оролцсон байдлыг харгалзан гишүүдэд ашиг болгон өгөх.

г/Гишүүдийн зөвшөөрсөн бусад үйл ажиллагааг дэмжих.

4. Бүрэн эрхт бие даасан байдал:

Хоршоо нь өөрсдөдөө туслах, хамтын хяналт бүхий бие даасан байгуулага мөн. Хоршоо нь Засгийн газар зэрэг бусад байгуулагаруудтай хамтран ажиллах буюу гадны эх үүсвэрээр хөрөнгө нэмэгдүүлэх тохиолдолд гишүүдийн хамтын ардчилсан хяналтыг хангаж, хоршоолы бие даасан байдал хадгалагдан үлдэх нөхцөлийг хангана.

5. Боловсрол, сургалт, мэдээлэл

Хоршоод нь гишүүд, хоршооны удирдах ажилтан, менежер, ажилчдад хоршооны хөгжилд үр ашигтай хувь нэмэр оруулах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тэдгээрийн боловсролыг дээшлүүлж, төрөл бүрийн сургалтанд хамруулна. Хоршоо нь олон нийт, ялангуяа залуучууд болон удирдах хүмүүст хоршооны мөн чанар, түүний ашиг тусын талаар мэдээлдэг.

6. Хоршоо хоорондын хамтын ажиллагаа:

Хоршоод нь орон нутаг, үндэстэн, бүс нутаг, олон улсын түвшинд хамтран ажиллах замаар хоршооллын хөдөлгөөнийг бэхжүүлэн, гишүүддээ илүү үр ашигтай үйлчлэхийг эрмэлздэг.

7. Бүлгийн ашиг сонирхол:

Хоршоод нь гишүүдийнхээ баталсан бодлогыг хэрэгжүүлэх замаар бүлгийн /хоршооны/ тогтвортой хөгжлийг хангахын төлөө ажилладаг.

"Тэргүүний хоршоо" шалгаруулах
журмын 2 дугаар хавсралт

"ТЭРГҮҮНИЙ ХОРШОО"-ГООР ТОДОРХОЙЛЖ БАЙГАА ..... ХОРШООНЫ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Д/Д	Үзүүлэлт	Онууд		Тайлбар
		19 ...	19 ...	
1	Хөрөнгө оруулалт А. Богино хугацаат хөрөнгө оруулалт Б. Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө			
2	Хөдөлмөрийн бүтээмж А. Нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн Б. Нийт ажиллагсдын тоо			
3	Өр төлбөр А. Өглөг Б. Орлогын татварын өглөг В. Цалингийн өглөг Г. Бусад татварын өглөг Д. НД Шимтгэлийн өглөг			
4	Найдваргүй авлага			
5	Хугацаа хэтэрсэн зээл			
6	Нийт борлуулалт			
7	Нийт ашиг			

Үзүүлэлтийг:

Гаргасан:

Хоршооны дарга

.....

Хянаж баталсан:

Хоршоодын холбоо

Ерөнхий ня-бо

.....

* Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны есдүгээр сарын 2 №40 (119)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоол

376. Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг томилох тухай Дугаар 57 769

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

377. Эх, нярайн халдвараас сэргийлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 114 770

378. Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай Дугаар 115 770

379. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 116 771

380. Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай Дугаар 118 771

381. Ховд аймгийн Алтайн чанад дахь бүс нуттийн хөгжлийн талаар авах арга хэмжээний тухай Дугаар 120 771

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын1-ний өдөр Дугаар 57 Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 1 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, нууц санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их хурлаас ТОГТООХ нь:

1. Сономцэрэнгийн Мэндсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдаар;

Шаравдоржийн Түвдэндоржийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдаар;

Гаваагийн Батхүүг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Дэд бүтцийн хөгжлийн сайдаар;

Ням-Осорын Туяаг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдаар;

Авирмэдийн Баттөрийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гэгээрлийн сайдаар;

Янсанжавын Очирсүхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдаар;

Чойнзонгийн Содномцэрэнг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдаар;

Содовын Сониныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдаар тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 1999 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Дарга Р. ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 14-ний өдөр | **Дугаар 114** | **Улаанбаатар хот**

Эх,нярайн халдвараас сэргийлэх зарим арга хэмжээний тухай

Нийслэлийн амаржих газруудын ачаалал, нягтрал нэмэгдэж, эх, нярайн халдвар буурахгүй байгаа харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Зэвсэгт хүчний Клиникийн төв эмнэлгийн амбулатори байрлаж байгаа барилгыг челөөлж төрөхийн зориулалтаар ашиглах арга хэмжээ авахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин, Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндорж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгасугай.

2.Эх, нялхсын эрдэм шинжилгээний төвийн статус, үйлчилгээний хүрээг шинэчлэн тогтоож, нийслэлийн эмнэлгүүдийн ачааллыг жигдрүүлэх, байршлыг оновчтой болгох замаар эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт даалгасугай.

3.Амаржих газруудад ариутгал, халдваргүйтгэл, халдварын эсрэг дэглэмийг чанд сахиулах, түүнд тавих хяналтыг сайжруулахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Ж.НАРАНЦАЦРАЛТ**

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд **С.СОНИН**

Батлан хамгаалахын сайд **Ш.ТҮВДЭНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 28-ны өдөр | **Дугаар 115** | **Улаанбаатар хот**

Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай

Төрийн цэргийн бодлогын зааltыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын хооронд байгуулах санамж бичиг"-ийн төслийг зарчмын хувьд зөвшөөрч, уг санамж бичгийг эцэслэн тохирч гарын үсэг зурах эрхийг Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Туяад олгосугай.

2.Батлан хамгаалахын сайдын үүрэг гүйцэтгэгч Ш.Түвдэндорж, Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Туяа нарт даалгах нь:

а/энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсаас сайн дурын үндсэн дээр оролцох хүмүүсийг бүртгэж сонголт хийх замаар НҮБ-тай байгуулсан хэлэлцээр, НҮБ-ын практик, холбогдох нөхцөлүүдийн дагуу тэдний энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах арга хэмжээ авсугай;

б/НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд манай талаас оролцох мэргэжилтнүүдийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, олон улсын хамтын ажиллагаа, дотоод нөөц боломжоонд түшиглэн энхийг сахиулагчдын багийн бэлтгэх ажлыг зохион байгуулсугай.

3.Монгол Улсын иргэдийг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцуулахтай холбогдсон асуудлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохицуулж байхыг Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Н.Туяад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч **Н.ТУЯА**

Батлан хамгаалахын сайдын үүрэг гүйцэтгэгч **Ш.ТҮВДЭНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 116 **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн багц хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 264 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн "е" заалтыг "Эрүүл мэндийн газар" гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Н.ТУЯА

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын үүрэг гүйцэтгэгч С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 7 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 118 **Улаанбаатар хот**

Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад:

"40.	"Стандарт, хэмжилзүйн тэргүүний ажилтан"	Сангийн сайд

гэсэн хэсэг нэмсүгэй.

2.Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Очирсүхэд даалгах нь:

а/"Стандарт, хэмжилзүйн тэргүүний ажилтан" тэмдгийг Засгийн газрын 1997 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн нийтлэг тодорхойлолтод нийцүүлэн хийлгэсүгэй;

б/"Стандарт, хэмжилзүйн тэргүүний ажилтан" тэмдгийг олгох журмыг боловсруулан батлуулж мөрдүүлсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч бөгөөд Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Н.ТУЯА

Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.ОЧИРСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 120 **Улаанбаатар хот**

Ховд аймгийн Алтайн чанад дахь бүс нутгийн хөгжлийн талаар авах арга хэмжээний тухай

Алтайн нуруунд чанад дахь Ховд аймгийн Алтай, Булган, Үенч сумд аймгийн төвөөс алслагдсан, нийгэм, эдийн засгийн хувьд хоцрогдсон, хүн амын амьжиргаа доройтон, хил орчмын стратегийн бүс нутаг эзгүйрч байгаар харгалзан эдгээр сумдын хөгжлийг түргэтгэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Алтайн чанад дахь Булган, Алтай, Үенч сумдын хөгжлийн талаар авах зарим арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор батална.

2.Алтайн чанад дахь бүс нутгийг хөгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөв, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлд тусган хөнгөлөлттэй зээл, тусгай зориулалтын сангийн хөрөнгийг ашиглах замаар хугацаанд нь шийдвэрлэж ажиллахыг холбогдох сайд, Ховд аймгийн Засаг дарга Л.Галбадрахад тус тус даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 1999 оны 120 дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН АЛТАЙН ЧАНАД ДАХЬ БҮС НУТГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Авах арга хэмжээ	Хэмжих нэгж	Хүчин чадал	Шаардагдах хөрөнгө, сая.төг	Эхлэх, дуусах хугацаа	Хариуцах яам
1	Булган, Үенч голын аль нэгд бага оврын усан цахилгаан станц барих асуудлыг судалж шийдвэрлэх	-	ТЭЗҮ-ээр тодорхойлно	980	2001-2003	Дэд бүтцийн хөгжлийн яам
2	Үенч сумын Олонбулагийн нүүрсний уурхайг байнгын ашиглалтад оруулах	тонн	жилд 20-30 мян.	110	2000-2001	Дэд бүтцийн хөгжлийн яам
3	Бүс нутгийн гуриглын хэрэгцээг хангах үндэслэл тооцоо гаргах, хөрөнгө санхүүгийн хувьд дэмжих	-	ТЭЗҮ-ээр тодорхойлно	190	2000-2001	Сангийн яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам
4	Булган сумын төвөөс хилийн боомт хүртэл хатуу хучилттай зам тавих	км	70	210	2001-2002	Дэд бүтцийн хөгжлийн яам
5	Алтай сумын соёлын төвийн барилгыг барьж дуусгах	-	-	62	2000	Гэгээрлийн яам
6	Бүс нутгийн байгалийн нөөц баялагт тулгуурласан жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх	-	-	-	2000-2003	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам
7	Бүс нутгийн экологи-эдийн засгийн цогц үнэлгээ хийх	-	-	-	2000-2001	Байгаль орчны яам
8	Байгалийн гамшигт нэрвэгдэж малгүй болсон айл өрхийг малжуулах арга хэмжээ авах	-	-	-	2000-2001	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам, Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газар

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны есдүгээр сарын 3 №41 (120)

Гарчиг

Яам, агентлагийн акт

382. Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай (Монгол Улсын Хууль зүйн сайдын тушаал) Дугаар 95 773

383. Журмууд батлах тухай (Монгол Улсын Гэгээрлийн сайдын тушаал) Дугаар 130 775

384. Журам батлах тухай (Монгол Улсын Төрийн өмчийн хорооны дарга, Монголын хөрөнгийн биржийн захирлын хамтарсан тушаал) Дугаар 223/880 783

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 95 Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүн, журам батлах тухай

Нотариатын тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 2, 13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1."Нотариатчийг сонгон шалгаруулах мэргэжлийн, орон тооны бус комиссын бүрэлдэхүүн"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Нотариатчийг сонгон шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн батлуулсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн сайдын 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 145 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Л. ЦОГ

Хууль зүйн сайдын 1999 оны 95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Нотариатчийг сонгон шалгаруулах мэргэжлийн, орон тооны бус комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга: - Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д. Сугар

Гишүүн:
- Хууль зүйн яамны Эрх зүйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М. Төрбаяр
- Хууль зүйн яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга Д. Одбаяр
- Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч А. Оюунчимэг
- Нотариатчдын танхимын төлөөлөн удирдах Зөвлөлийн гишүүн Н. Алтанцэцэг
- "Отгон тэнгэр" Дээд сургуулийн сургалт хариуцсан дэд захирал Д. Наранчимэг

Нарийн бичгийн дарга: - Хууль зүйн яамны өмгөөлөл, нотариат хариуцсан мэргэжилтэн Д. Солонго

Хууль зүйн сайдын 1999 оны 95 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

НОТАРИАТЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Нотариатчийг сонгон шалгаруулах ажлыг Нотариатчдын танхим мэргэжлийн, орон тооны бус комисстой хамтран зохион байгуулна.

2.Сонгон шалгаруулалтыг жилд 1 удаа явуулах ба Хууль зүйн сайдын болон Нотариатчдын танхимын саналыг үндэслэн уг хугацааг өөрчилж болно. Нөхөн сонгон шалгаруулалт үүнд хамаарахгүй.

3.Сонгон шалгаруулалтыг нээлттэй явуулах ба шалгаруулалт эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд зарлана.

4.Нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан иргэн дараахь баримт, бичиг бүрдүүлнэ:

1/нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх тухай бичгээр гаргасан хүсэлт;

2/биеийн байцаалт /1 дүгээр маягтаар/;

3/хууль зүйн дээд боловсролын диплом, нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;

4/нотариатын үйл ажиллагаа явуулах боломж бүхий ажлын байртайг тодорхойлсон баримт.

5.Өмгөөлөгч нотариатын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргавал энэ журмын "Нэг"-ийн "4"-т заасан баримт, бичгээс гадна Нотариатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 4-т заасан шаардлага хангасан тухай баримтыг хамтад нь ирүүлнэ.

6.Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан иргэний баримт, бичгийг хүлээн авах ажлыг шалгаруулалт эхлэхээс 7 хоногийн өмнө дуусгавар болгоно.

Хоёр. Сонгон шалгаруулалт

7.Нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцож буй иргэний онолын болон мэргэжлийн мэдлэгийн түвшинг сорилго /тест/-оор болон аман ярилцлага авах хэлбэрээр тогтооно.

8.Онолын болон мэргэжлийн мэдлэгийн түвшин тогтоох сорилго, аман ярилцлагын 75-аас дээш хувийг зөв хариулсан иргэнийг тухайн сорилгод тэнцсэн гэж үзнэ.

9.Аман ярилцлагыг комиссын гишүүдээс шалгаруулалтад оролцогч тус бүрт асуулт тавьж хариулт авах хэлбэрээр явуулна.

10.Тухайн иргэнийг нотариатчаар ажиллах хүсэлт гаргасан тойргийн нь нэр дээр авсан онооны дараалалтай нь харгалзан сонгон шалгаруулна.

11.Сонгон шалгаруулалтад оролцож тэнцсэн боловч ажиллах хүсэлт гаргасан тухайн тойргийн нотариатчийн тооны хязгаарт багтаагүй иргэн өөр тойрогт ажиллах эсэх талаарх саналаа мэргэжлийн, орон тооны бус комисст гаргаж болно.

12.Мэргэжлийн орон тооны бус комисс тухайн иргэнийг өөр тойрогт ажиллуулах боломж бий эсэхийг судалж, энэ тухай шийдвэр гаргана.

Гурав. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх талаар шийдвэр гаргах

13.Сонгон шалгаруулалтад оролцож тэнцсэн иргэнд Нотариатын тухай хуулийн 13 дугаар зүйлийн "1"-д заасны дагуу 3 сараас доошгүй хугацаагаар нотариатын ажлын дадлага хийсний дараа нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн сайд олгоно.

14.Дор дурьдсан үндэслэлээр нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохоос татгалзаж болно. Үүнд:

1/тухайн иргэний авсан сорилгын оноо болон ярилцлагын дүн энэ журмын хоёрын "8"-т заасан шалгуурт хүрээгүй;

2/сонгон шалгаруулалтад тэнцсэн боловч ажиллах хүсэлт гаргасан тойргийнхоо нотариатчийн тооны хязгаарт багтаагүй бөгөөд өөр тойрогт ажиллах талаар санал гаргаагүй, эсвэл санал гаргасан боловч түүнийг ажиллуулах боломжгүй /тухайн тойргийн орон тоо гүйцсэнээс/ талаар мэргэжлийн, орон тооны бус комиссын шийдвэр гарсан;

3/нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцох үед өөр ажил эрхэлж байсан иргэн сонгон шалгаруулалтад тэнцсэн бол шалгаруулалтын дүн гарснаас хойш 1,5 сарын дотор уг ажлаас чөлөөлөгдсөн тухай холбогдох байгуулагын шийдвэрийг мэргэжлийн орон тооны бус коммист ирүүлэх ба дээрхи хугацаанд ирүүлээгүй;

4/ял шийтгэлтэй, эрүүгийн гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа болон шүүхэд иргэний хэргийн хариуцагчаар татагдсан этгээд, түүнчлэн өмнө нь эрхэлж байсан ажлаасаа ёс зүйн зөрчил гаргасан болон ажлын шаардлага хангаагүйн улмаас халагдсан эсвэл эрх нь бүр буюу түр хугацаагаар хасагдсан иргэн;

15.Мэргэжлийн, орон тооны бус комисс сонгон шалгаруулалт явуулахтай холбогдуулан дараахь эрх, үүрэгтэй байна. Үүнд:

1/нотариатын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан иргэн Нотариатын тухай хуульд заасан шалгуур хангаж байгаа эсэхийг судалж, тогтоох;

2/нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан иргэнийг сонгон шалгаруулалтад оролцуулах эсэх тухай шийдвэрийг энэ журмын "Хоёр"-ын 5-д заасан хугацаанаас хойш 3 хоногийн дотор гаргах;

3/нотариатчийн сонгон шалгаруулалт явуулах товыг тогтоох;

4/сонгон шалгаруулалтад оролцох иргэний онолын болон мэргэжлийн мэдлэгийн түвшинг тогтоох сорилын асуултыг боловсруулж, нууцлалыг хадгалах;

5/сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэнд нотариатчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай саналыг Хууль зүйн сайдад оруулах.

16.Мэргэжлийн, орон тооны бус комиссоос сонгон шалгаруулалтад оролцуулахыг зөвшөөрсөн шийдвэр гармагц тухайн иргэн комиссын үйл ажиллагааны зардалд /сорилгын асуулт боловсруулах, олшруулах болон бичиг хэргийн бусад зардал/ зориулан 5 мянган төгрөгийг Монголын Нотариатчдын танхимын Монгол Шуудан банкин дахь 2119042 тоот дансанд тушаана.

МОНГОЛ УЛСЫН ЗӨГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 6 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 130** **Улаанбаатар хот**

Журмууд батлах тухай

Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5; 15 дугаар зүйлийн 3; 19 дүгээр зүйлийн 2; 21 дүгээр зүйлийн 7; Дээд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дугаар заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1."Боловсролын байгууллагад гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт зохион байгуулах журам" –ыг нэгдүгээр хавсралтын ёсоор, "Цэцэрлэг, сургуулийн багш нарын зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм"-ийг хоёрдугаар хавсралтын ёсоор "Ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн сургуулийн суралцагчийн үлгэрчилсэн дүрэм"-ийг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус батлагдсугай.

2.Боловсролын байгууллагад гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт зохион байгуулах журмыг нийт багш, суралцагч, эцэг эхэд танилцуулан зохиох бэлтгэлийг хангаж, 1999-2000 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөн ажиллахыг аймаг, нийслэлийн Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, соёлын төв, ерөнхий боловсролын сургуулийн захирэл, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Боловсролын байгууллагад гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт зохион байгуулах журмын хэрэгжилтийг зохицуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С. Алтангэрэл), хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар (Л. Баттулга), энэхүү журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын хөгжлийн сургууль (Б. Жадамба), журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавьж ажиллахыг Гэгээрлийн улсын хяналтын алба (Н. Пүрэвжав)-д тус тус даалгасугай.

4.Эдгээр журмууд гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан, боловсрлоын сайдын 1995 оны 258 дугаар тушаалаар батлсан "Ерөнхий боловсролын сургуульд үнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт зохион байгуулах журам", 1995 оны 228 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлсан "Цэцэрлэг, сургуулийн сурган хүмүүжүүлэх зөвлөлийн дүрэм", 209 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлсан "Ерөнхий боловсролын сургууль, техникийн болон мэргэжлийн дунд сургуулийн сурагчийн дүрэм", 207 дугаар тушаалаар батлсан "Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын заах аргын нэгдлийн ажлын үндсэн чиглэл"-г тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД **А. БАТТӨР**

Гэгээрлийн сайдын 1999 оны 130 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ГҮНЗГИЙРҮҮЛСЭН БОЛОН ТӨРӨЛЖҮҮЛСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Суралцагчийн авъяас, ур чадвараа хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмших, өөрсдийгөө нээж илрүүлэх талаар тэдний боловсролын эрэлт, хэрэгцээг нь хангахад чиглэсэн үйлчилгээг бий болгох зорилгоор боловсролын сургалтын байгуулагад гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Суралцагчийн авъяас, чадварыг хөгжүүлэх, оюуны өндөр чадавхитай, үндэсний зохион бүтээгч, инженер, судлаач, сэтгэгчид төрөх суурийг зөв тавих зорилгоор онолын төвшин өндөртэй математик, физик, хими, биологийн шинжлэх ухааны тодорхой нэг чиглэлээр боловсролын тухайн төвшинд харгалзуулан тусгайлан боловсруулсан академик тал нь давамгайлсан агуулгыг танхмын хичээлийн хэлбэрээр зохион байгуулж эзэмшүүлэх сургалтыг гүнзгийрүүлсэн сургалт гэнэ. Гүнзгийрүүлсэн сургалт нь суралцагчдын авъяаст суурилна.

1.3 Гүнзгийрүүлсэн сургалтыг дээр нэр дурьдсан шинжлэх ухааны чиглэлээр ерөнхий боловсролын сургуульд судалж буй нэг буюу хэд хэдэн үндсэн хичээлийн агуулга, арга зүйг өргөжүүлэн гүнзгийрүүлэх замаар зохион байгуулна.

1.4.Суралцагчид авъяас сонирхолоо хөгжүүлж, ажил мэргэжлийн чиг баримжаа, амьдрах арга ухаан эзэмших, бие даан суралцахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор хэрэглээний түвшин өндөртэй байгаль, нийгэм, хэл, техник технологийн шинжлэх ухаан, соёл урлаг, спорт, ажил мэргэжлийн тодорхой төрлөөр боловсролын тухайн төвшинд харгалзуулан тусгайлан боловсруулсан прагматик тал нь давамгайлсан агуулгыг танхимын хичээлийн хэлбэрээр зохион байгуулж эзэмшүүлэх сургалтыг төрөлжүүлсэн сургалт гэнэ. Төрөлжүүлсэн сургалт нь суралцагчдын авъяас, сонирхол, хэрэгцээнд суурилна.

1.5 Төрөлжүүлсэн сургалтыг байгаль, нийгэм, хэл, техник технологийн шинжлэх ухаан, урлаг, спорт, ажил мэргэжлийн чиглэлээр ерөнхий боловсролын сургуульд судалж буй төрөл хичээлүүдийн агуулга, арга зүйг өргөжүүлэн гүнзгийрүүлэх замаар зохион байгуулна.

1.6 Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтаар бага, дунд боловсролын сургалтын агуулгын стандартыг суралцагчдад заавал бүрэн эзэмшүүлэхийн зэрэгцээ стандартаас илүү агуулга эзэмшүүлнэ.

1.7 Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтыг суралцагчдын авъяас билэг, сонирхол, эрэлт хэрэгцээг судалж оношлон тогтоосны үндсэн дээр энэ төрлийн сургалт эрхлэхэд тавигдах шаардлагыг бүрэн хангасан нөхцөлд зохион байгуулна.

1.8 Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт нь тогтоогдсон агуулгыг эзэмшүүлэх тусгай хэрэглэгдэхүүн, сургалтын шинэ төрөл хэлбэр, арга технологитой байж болно. Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үр дүнгийн хяналт нь боловсролын эрхэм зорилго, боловсролын тогтолцооны шинэчлэлийн стратегийн зорилтууд, сургалтын технологийн шинэчлэлийн бодлоготой нягт уялдсан байна.

1.9 Суралцагчдын авъяас билгийг багаас нь тодруулж хөгжүүлэх зорилгоор тэдний сонирхолд тулгуурлан сэтгэн бодох үйл ажиллагаа, спорт биеийн тамир, урлаг, уран сайхны авъяас билгийг дэмжих болон ажил мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэхэд чиглэсэн хичээлээс гадуурхи сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг бусад хэлбэрээр холбогдох байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулж болно.

ХОЁР. Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн Сургалтын зохион байгуулалт

2.1 Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтыг улс, аймаг нийслэлийн хэмжээнд үйлчлэх тодорхой чиглэлээр гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалттай бие даасан ерөнхий боловсролын сургууль болон сум дүүргийн хэмжээнд үйлчлэх гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалттай анги бүлэг (анги гэдгийн доор I-X анги, бүлэг гэдгийн доор аль нэг ангийн а, б, в гэх мэт бүлгүүдийг ойлгоно.) бүхий ерөнхий боловсролын сургуулийн хэлбэрээр тус тус зохион байгуулна.

2.2 Эцэг эх, асран хамгаалагч, суралцагчийн хүсэлт, захиргааны санаачилгаар ерөнхий боловсролын сургуулийн аль ч ангиас гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт зохион байгуулж болно.

2.3 Төрөлжүүлсэн сургалт явуулахад сурагчдын тоо нь тогтоосон норм норматив (25-30 хүүхэд) хүрэхгүй байгаа тохиолдолд шаардлагатай гэж үзвэл урлаг, спорт, техник технологи, ажил мэргэжлийн чиглэлээр сурагчдын саналыг үндэслэн хэд хэдэн ангиас холимог бүлэг байгуулах буюу аль ч чиглэлээр аль нэг ангийн хэд хэдэн бүлгээс тухайн хичээлийн цаг дээр шинэ бүлэг байгуулан хичээлийн хуваарийг зохицуулах замаар төрөлжүүлсэн сургалтыг зохион байгуулж болно.

2.4 Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалттай сургуулиуд нь элсэлтээ өөрсдийн боловсруулсан журмын дагуу үйлчлэх хүрээндээ ил тод шударгаар зохион байгуулна.

2.5 Их сургуулийн бүрэлдэхүүн болон харъяалалд гүнзгийрүүлсэн буюу төрөлжүүлсэн сургалттай ерөнхий боловсролын ахлах сургуулиуд байж болох бөгөөд эдгээр сургууль нь улсын хэмжээнд үйлчлэх сургуулиуд байна.

2.6 Үндсэн (орос, англи) гадаад хэл дээр сургалтаа явуулдаг сургууль нь нэг жилийн гадаад хэлний бэлтгэл анги хичээллүүлж болно.

2.7 Монгол улсад гадаадын хамтарсан буюу дагнасан хэлбэртэй (цаашид хамтарсан буюу дагнасан сургууль гэнэ) ерөнхий боловсролын сургууль нь гүнзгийрүүлсэн буюу төрөлжүүлсэн сургалт зохион байгуулвал сургуулийн дүрэм, хамтын ажиллагааны гэрээ, сургалтын төлөвлөгөө нь Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвшөөрөгдсөн байна.

2.8 Хамтарсан буюу дагнасан сургууль ба улс, аймаг нийслэлийн хэмжээнд үйлчлэх гүнзгийрүүлсэн буюу төрөлжүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль байгуулах түүнчлэн сум, дүүргийн хэмжээнд үйлчлэх ерөнхий боловсролын сургуулльд гүнзгийрүүлсэн ба төрөлжүүлсэн сургалттай анги, бүлэг нээж хичээллүүлэх асуудлыг сургуулийн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн энэхүү журам болон "Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх журам"-ын дагуу тус тус шийдвэрлэнэ.

2.9. Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүл-

сэн сургалтыг хичээлийн жилийн эхнээс зохион байгуулах ба хичээлийн жилийн дундуур гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт шинээр нээж зохион байгуулахыг зөвшөөрөхгүй.

2.10 Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт явуулахыг дараахь шаардлага хангасан тохиолдолд зөвшөөрнө.

а/Гадаад хэлний төрөлжүүлсэн сургалтыг 15-аас дээшгүй хүүхэдтэйгээр зориулалтын лаборатори, кабинетэд зохион байгуулах нөхцөлийг хангасан байх;

б/улс, аймаг, нийслэлийн төвшинд үйлчилгээ үзүүлдэг сургуулийн суралцагчид гэрээсээ шууд сургуульдаа ирэх боломжгүй нөхцөлд дотуур байртай байх; (Тухайн сургууль шаардлагатай гэж үзвэл дотуур байртай байж болно.)

в/гүнзгийрүүлсэн ба төрөлжүүлсэн сургалт явуулах сургалтын байгууллага нь энэ төрлийн сургалтын агуулгыг эзэмших таатай орчныг бүрдүүлэхүйц барилга байгууламж, тоног төхөөрөмж, суралцагч бүрт хүрэлцэхүйц багаж хэрэгсэл, сурах бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнтэй байх;

г/гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт явуулах сургууль нь энэ төрлийн сургалт явуулах орон тооны багштай байна. Гүнзгийрүүлэн судлах хичээлийг заах багш нь тухайн хичээлийг зохих төвшинд зохион явуулах мэргэжлийн өндөр ур чадвартай, мэргэшлийн зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй буюу боловсролын докторын зэрэгтэй байх, төрөлжүүлэн судлах хичээлийг заах багш нь мэргэжлийн дадлага туршлага сайтай, мэргэшлийн зөвлөх, тэргүүлэх, заах аргач зэрэгтэй, боловсролын магистр, докторын зэрэгтэй байх;

2.11.Төрийн өмчийн сургуулиуд гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтай холбогдон үүсэх нэмэгдэл зардлыг эцэг, эх, асран хамгаалагчаас авах төлбөрөөр нөхөж болно.

2.12.Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр сургалтын нэмэгдэл зардалд улсын хэмжээнд мөрдөж буй сургалтын төлөвлөгөөний нийт цагаас илүү заасан цагийн хөлс, зайлшгүй хэрэглэгдэх тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав суулга, бодис урвалж, нэмж ашиглах сурах бичиг, гарын авлагад зарцуулах зардлыг ойлгоно. Төлберийн хэмжээг нарийн задаргаа бүхий эдийн засгийн тооцоог үндэслэн сургуулийн удирдах зөвлөл тодорхойлж батална. Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтын төлбөрийг ашгийн төлөө эх үүсвэр болгохыг хориглох бөгөөд нэг жилийн төлберийн хэмжээ нь тухайн хичээлийн жилд нэг суралцагчид ногдох хувьсах зардлаас хэтрэхгүй байна.

Гурав. Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтын агуулга

3.1.Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтын агуулга нь бага, дунд боловсролын агуулгын стандартыг бүрэн хангасан, гүнзгийрүүлсэн ба төрөлжүүлсэн сургалтын зорилгод нийцсэн, сурал-цагчдын нас, бие, сэтгэцийн онцлогт тохируулан тэдний хөгжлийг тасралтгүй хангасан байна.

3.2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөний тогтвортой хэсгийн агуулгын стандартыг хангахад зориулагдсан тухайн нэг хичээл буюу төрөл хичээлүүдийн цаг дээр сургуулиас зохицуулах хичээлийн цагийг нэмж гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтын сургалтын төлөвлөгөөг анги, бүлэг бүрээр боловсруулна. Шаардлагатай гэж үзвэл сургалтын төлөвлөгөөний тогтвортой хэсгийн хичээлүүдийн цагийг хасахгүйгээр долоо хоногийн нийт цагийг 26-33 хүртэл нэмж болно. Танхимын болон танхимаас гадуурх суралцагчийн долоо хоногийн нийт ачаалал нь тэдний наснаас хамааран 38-52 хичээлийн цаг буюу 25-35 астрономын цагаас илүүгүй байна.

3.3. Гүнзгийрүүлсэн ба төрөлжүүлсэн сургалтын агуулгын чиглэл бүрээр тухайн сургуулийн боловсруулсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг багш нарын зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн сургуулийн удирдах зөвлөл батлана.

3.4. Хамтарсан ба дагнасан сургууль болон улсын хэмжээнд үйлчлэх гүнзгийрүүлсэн буюу төрөлжүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагын санал дүгнэлтэд үндэслэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл өгнө. Аймаг нийслэл, сум, дүүргийн хэмжээнд үйлчлэх гүнзгийрүүлсэн ба төрөлжүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр нь аймаг, нийслэлийн боловсрол, соёлын төвөөр зөвшөөрөгдсөн байна.

3.5.Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтыг "сонгох" сурах бичгээр хангах асуудлыг тухайн сургууль хариуцна. Үүсгэн байгуулагч санаачлагаараа сонгох сурах бичиг нь сургуулийн багш нарын зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн гаргасан удирдах зөвлөлийн шийдвэрээр зөвшөөрөгдсөн байна. Сонгох сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан ашиглалтын хураамж авах буюу эцэг эхийн эрэлтийн үндсэн дээр суралцагчдад худалдаж болно. Удирдах зөвлөлөөр зөвшөөрөг-дөөгүй сурах бичиг, гарын авлагыг суралцагчдад хүчээр худалдахыг хориглоно.

3.6.Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт явуулж буй сургалтын байгууллага нь сургалтын ажлыг зохион байгуулах өвөрмөц арга технологийг бий болгох зорилгоор судалгаа шинжилгээний ажил явуулж болно. Энэ тухай тайлангаа хичээлийн жил бүрийн боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгуулагад гарган сургууль нь судалгаа шинжилгээний арга зүй, сургалтын технологийн нууцыг зохих хууль, тогтоомжийн дагуу хадгалах, нээлт, бүтээлийн эрхээ хамгаалах эрхтэй.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он № 41 (120)

Гэгээрлийн сайдын 1999 оны 130 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Цэцэрлэг, сургуулийн багш нарын зөвлөл (цаашид зөвлөл гэнэ) нь цэцэрлэг, сургуулийн болон сургалтын технологийн хөгжил, түүнтэй холбогдсон байгууллагын дотоод харилцааг зохицуулах асуудлыг шинжлэн мэргэжлийн санал дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий цэцэрлэг, сургуулийн өөрийн удирдлагын мэргэжлийн зөвлөх байгууллага мөн.

1.2 Зөвлөл нь үйл ажиллагаандаа тэрээс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай багц хууль, Бага, дунд боловсролын хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллана.

1.3 Зөвлөлийн бүрэлдэхүүнд захирал, эрхлэгч, багш нар орно. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн даргатай байна. Зөвлөлийн дарга нь сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, нарийн бичгийн дарга нь хичээлийн эрхлэгч, цэцэрлэгийн арга зүйч байна.

1.4 Зөвлөлийн хурлыг нэг хичээлийн жилд 4-өөс доошгүй удаа хийнэ. Шаардлагатай үед өөлжит бус хурал хийж болно.

1.5 Гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэй үед зөвлөлийн хурлыг хүчин төгөлдөрт тооцно. Хэлэлцэж буй асуудлаасаа хамаарч ил буюу далд хэлбэрээр санал хураана, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар шийдвэрлэнэ.

1.6 Зөвлөлийн хуралд хэлэлцэх асуудлаасаа хамааран орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагчдын төлөөллийг зөвлөх эрхтэйгээр оролцуулж болно.

1.7 Зөвлөлийн хуралдааны талаар тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, тэмдэглэл хөтөлсөн хүн гарын үсэг зурна. Тэмдэглэл нь цэцэрлэг, сургуулийн албан хэрэгт хадгалагдана.

1.8 Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаараа санал дүгнэлт, зөвлөмж гаргана. Эдгээр нь сургууль, цэцэрлэгийн удирдах зөвлөлийн шийдвэр болон сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар баталгаажна.

1.9 Зөвлөл нь удирдах зөвлөл, сургуулийн захиралын шийдвэр санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа туслан хэрэгжүүлнэ.

1.10.Зөвлөл і [illegible] ажиллагаагаа хэрэгжүүлэхэд туслах мэргэжлийн чиглэлээр буюу сонирхолын үндэсэн дээр байгууллагдсан заах аргын нэгдлүүдийг ажиллуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл тодорхой нэхцөл бүрдсэн тохиолдолд тэнхим, секц, сэтгэл оношлогооны алба зэрэг нэгжүүдийг ажиллуулж болно.

1.11.Цэцэрлэг, сургууль нь энэхүү үлгэрчилсэн журамд нийцүүлэн өөрийн дотоод журамтай байж болно.

Хоёр. Зөвлөлийн эрх үүрэг

2.1. Зөвлөл нь доор дурьдсан эрхтэй:

а/ Цэцэрлэг, сургуулийн хөгжлийг тодорхойлох, сургалтын ажлын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургуулийн материаллаг болон сэтгэл зүйн орчинг сайжруулах, хамт олны нийгмийн асуудал, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар санал дэвшүүлэх;

б/Багш, суралцагчийг үнэлж дүгнэх, удирдах дээд байгууллагын шагналд тодорхойлохоор нэр дэвшүүлж, санал гаргах;

в/Сургалтын явцад хийх болон анги дэвших, шалгалтын нэр, агуулга, арга хэлбэр, хугацааг хэлэлцэн товлох, улсын шалгалтын комисст нэр дэвшүүлэх;

г/Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтын сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, элсэлтийн журмын төслийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргах;

д/ Суралцагчдыг анги дэвшүүлэх болон алгасуулан суралцуулах, улируулах, сууль төгсгөх, сургуулиас хасах хөөх мэргэжлийн санал, зөвлөмж гаргах;

е/ Цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтны ажлын тайланг хэлэлцэж, ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх;

ё/ Боловсролын хуульд заасан үүргээ хангалттүй биелүүлж, боловсрол, мэргэжил, ёс суртахууныг доголдож, сургалтын ажилд тэнцэхгүй байгаа багшийг ажлаас чөлөөлөх талаар мэргэжлийн үндэсэлэн гаргах, боловсролын хууль тогтоомж зөрчигчдэд хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг холбогдох байгууллага, хүмүүст тавьж шийдвэрлүүлэх.

2.2. Зөвлөл нь доор дурьдсан үүрэгтэй:

а/ Бага, дунд боловсролын хуульд заасны дагуу дараах асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах;

- Цэцэрлэг, сургуулийн дүрэм
- Заах аргын нэгдлийн журам
- Эцэг эх, сурагчдын байгууллагын дүрэм
- Сурагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлж дүгнэх дотоод журам
- Гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр
- Хичээлээс гадуурхи сургалтын ажлын хөтөлбөр, зохион байгуулах хэлбэр
- Багш нарын ажлыг үнэлж дүгнэх, мэргэшлийн зэрэг олгох дотоод журам
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх төлөвлөгөө, хөтөлбөр

б/ Зөвлөл нь дараах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

- Бага, дунд боловсролын стандарт хангах, сургалтын технологийн горимыг сахиулах, багш нарын боловсрол, мэргэжлийг дээшлүүлэх талаар сургуулийн захиргаанд туслах, хамтран ажиллах
- Хичээлийн шинэ жилийн бэлтгэл, сургалтын ажлын тайлан зэргийг хэлэлцэн үнэлж зөвлөх
- Сургалтын дэвшилтэд технологийг багш нарын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах
- Заах аргын нэгдлийн үйл ажиллагааг зохицуулах
- Сургууль дээр ардчиллыг хөгжүүлж, сурагч, багш нарт хүмүүнлэг, иргэний, нээлттэй нийгмийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх
- Сургууль, сурагчид, гэр бүл, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүчин чармайлтыг нэгтгэж, тэдний хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх
- Сурагчдын өөрийн удирдлагад мэргэжлийн туслалцаа үзүүлэх

Гэгээрлийн сайдын 1999 оны 130 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1.Ерөнхий боловсролын сургууль, техни-кийн болон мэргэжлийн сургуулийн сурал-цагч сургалтын ажилдаа энэхүү дүрмийг мөрдөнө.

1.2.Эрүүл чийрэг бие бялдар, оюуны зохих чадавхитай, хуулийг дээдлэн сахидаг, хүмүүнлэг ёс суртахуун, гоо зүйн мэдрэмж, таашаал олж, бие даан сурч амьдрах чадвартай иргэн болон төлөвшихийн төлөө хичээнгүйлэн суралцана.

1.3.Хүн төрөлхтний болон өөрийн ард түмний дэвшилтэд зан заншил, өв уламжлалаас байнга суралцаж, хүмүүнлэг ёсыг эрхэмлэнэ.

1.4.Багш, эцэг эх, ахмад хүмүүс, найз нөхдөө хүндэтгэж тэдний зөвлөлгөө, сургамжийг сонсоно.

1.5.Хууль ёсыг хүндэтгэн биелүүлж соггуруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах зэрэг нийгмийн сөрөг үйлийг цээрлэнэ.

1.6.Бие бялдараа байнга чийрэгжүүлэн ариун цэвэр, өдрийн дэглэмээ баримтлан чөлөөт цагаа зөв, зохистой ашиглаж, биеэ дайчлан өөрийгөө тасралтгүй хөгжүүлнэ.

1.7.Сургуулийн дотоод журмыг чанд биелүүлнэ.

1.8.Сурагчаг нь Боловсролын тухай хуулийн 38-ын 1-д заасан эрхийг эдэлж, 38-ын 2-т заасан үүргийг биелүүлнэ.

1.9.Сургууль нь энэхүү үлгэрчилсэн журамд нийцүүлэн боловсруулсан өөрийн дотоод журамтай байж болно.

Хоёр. Сурч, амьдрах орчиндоо мөрдөх дэг

2.1. Суралцагчийн хичээлд ирэхдээ баримтлах дэг:

а/ Хичээлд ирэхдээ цэвэр үзэмж-тэй хувцаслаж, тухайн өдрийн хичээлийн бэлтгэлийг бүрэн хангаж, хичээлийн хонх дуугарахаас 5 доошгүй минутын өмнө ирсэн байна.

б/ Хичээлийн хонх дуугармагц хичээллэх анги, танхимдаа орж суудлаа эзэлнэ.

в/ Суралцагч ямар нэгэн шалт-гаанаар хичээлд ирээгүй бол энэ тухай шалтгаанаа ангийн багшдаа мэдээлж, шаардлагатай магадлагаагаар ирүүлнэ.

2.2. Суралцагчийн хичээл, сургууль дээр баримтлах дэг

а/ Хүндэтгэх шалтгаанаар ээлжит хи-чээлд орох боломжгүй бол энэ тухайгаа сургуулийн дотоод журамд заасны дагуу холбогдох хүмүүст мэдэгдэн зөвшөөрөл авна.

б/ Завсарлагаанаар хичээлээс хо-жимдох, хичээлийн явцад ангиас гарах тохиолдолд хичээл зааж буй багшаас зөвшөөрөл авна.

в/ Хичээлд анхааралтай, идэвхи-тэй оролцож, багш болон нөхөдтэйгөө хамтран ажиллаж, хичээлийн агуулгыг бүрэн эзэмшихийн төлөө чармайна.

г/ Сургуулийн болон ангийн эд хог-шил, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг зөв, ариг гамтай хэрэглэнэ. Сургуульдаа дүрэмт хувцас өмсөнө.

д/ Сурах бичиг, ном, дэвтэр, хичээ-лийн хэрэглэлээ цэвэр гамтай эзэмшиж, сургуулийн номын сангаас авсан ном, сурах бичгийг хугацаанд нь бүрэн бүтэн буцааж өгнө.

е/ Өөрийн авъяас сонирхол, хэрэг-цээнд тулгуурлан хичээлээс гадуурхи дугуйлан, секцэд суралцаж, сургуулийн захиргаа, суралцагчдын байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд сургуулиас баталсан хуваарийн дагуу идэвхитэй оролцоно

2.3. Суралцагчийн гэртээ баримтлах дэг:

а/ Өдөр бүр хичээлээ давтаж, гэрийн даалгаврыг чанартай, бүрэн гүйцэтгэж, бие даан суралцах арга барилаа тасралтгүй хөгжүүлнэ.

Б/ Эцэг эх, эмээ өвөө, ах эгч, дүү нараа хүндэтгэн шаардлагатай бол тэднээс дэмжлэг тусламж авч, сурч мэдсэн шинэ зүйлийнхээ тухай тогтмол ярилцаж, дүү нараа асран хамгаалж, тэдэнд зөв үлгэр дууриал үзүүлж, гэрийн ажилд туслана.

в/ Сургууль, багшаас эцэг эхэд хандсан буюу эцэг эхээс сургуульд хандсан асуудлыг зөв, шуурхай танил-цуулна.

2.4. Суралцагчийн гудамж, талбай, олон нийтийн газарт баримтлах дэг:

а/ Гудамж, талбай, олон нийтийн газарт хууль ёсыг хүндэтгэн биелүүлж, нийгмийн хэв журмыг чанд сахина.

б/ Хараал хэлэх, хуурч мэхлэх, бусдын юмыг зөвшөөрөлгүй авахыг цээрлэнэ.

в/ Нийтийн эзэмшлийн хөрөнгө болох хөшөө дурсгал, орон сууц, нийтийн тээврийн хэрэгсэл, цэцэрлэгт хүрээлэн, талбай, зүлэг, модыг бохирдуулж, гэмтээхгүй байна.

г/ Гудамжинд замын хөдөлгөөний дүрмийг баримтлан нийтийн тээврийн хэрэгслээр зөв зорчино.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ДАРГА, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1999 оны 7 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 223/880** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 90 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1."Монголын хөрөнгийн биржээр дамжуулан төрийн эзэмшлийн үнэт цаасыг хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан цэнхэр тасалбар болон бэлэн мөнгөөр арилжих тухай журам"-ыг хавсралтаар батлуулсугай.

2.Энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллахыг Төрийн өмчийн хорооны Том аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын газрын дарга Ц. НАНЗАДДОРЖ, Хөрөнгийн биржийн дэд захирал Н. АМАРСАНАА, Ц. СОДХҮҮ нарт даалгасугай.

3.Энэхүү журмыг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хууль зүйн яаманд бүртгүүлж олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлахыг Төрийн өмчийн хорооны Том аж ахуйн нэгжүүдийн хувьчлалын газрын дарга Ц. НАНЗАДДОРЖИД даалгасугай.

Төрийн өмчийн хорооны дарга **Д. ЗОРИГТ**

Хөрөнгийн биржийн захирал **О. БАТБИЛЭГ**

Төрийн өмчийн хорооны дарга, Хөрөнгийн биржийн захирлын 1999 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 223/880 дугаар хамтарсан тушаалын хавсралт

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖЭЭР ДАМЖУУЛАН ТӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ҮНЭТ ЦААСЫГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРХИЙН БИЧГИЙН БАТАЛГААЖУУЛСАН ЦЭНХЭР ТАСАЛБАР БОЛОН БЭЛЭН МӨНГӨӨР АРИЛЖИХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан улсын үйлдвэрийн газар болон Монголын хөрөнгийн биржид /цаашид МХБ гэх/ бүртгэлтэй хувьцаат компанийн /цаашид компани гэх/ төрийн эзэмшлийн үнэт цаасыг хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан цэнхэр тасалбар /цаашид ХОЭБ гэх/ болон бэлэн мөнгөөр МХБ-ээр арилжахад үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Төрийн өмчийн хороо компанийн үнэт цаасыг МХБ-ээр арилжих тухай тогтоол гаргана. Тогтоолд худалдах үнэт цаасны тоо ширхэг, нэгж үнэт цаасыг худалдах доод үнийг тодорхой тусгана.

3. ХОЭБ-ийн нэрлэсэн үнийн дүнг ХОЭБ-ийн бичилт хийх тухайн өдрийн МХБ-ийн ТОР-75 индексийг бэлэн мөнгөний арилжаа эхлэх үеийн индекстэй харьцуулсан дүнгээр индексжүүлнэ.

4. ХОЭБ-ийг өв залгамжлуулах, эрх шилжүүлэхэд үүсэх харилцааг Монгол улсын холбогдох хуулийн дагуу зохицуулна.

5. Харилцагчдын захиалга хүлээн авах, арилжаа явуулах, төлбөр тооцоо хийхэд үүсэх харилцааг энэ журамд өөрөөр заагаагүй, бол холбогдох бусад хууль эрхийн актаар зохицуулна.

6. Арилжааны мэдээллийг арилжаа эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд Төрийн өмчийн хороо мэдээлнэ. Мэдээлэлд тухайн компанийн

дэлгэрэнгүй танилцуулга, худалдах үнэт цаасны тоо, нэгж үнэт цаасыг худалдах доод үнэ, ХОЭБ-ээр үнэт цаас худалдан авах захиалга авч эхлэх, дуусах хугацаа, бичилт хийх өдөр, арилжаа эхлэх болон дуусах хугацаа, арилжааны хэлбэрийг тодорхой тусгасан байна.

Хоёр. Үнэт цаасыг бүртгэх, захиалга авах

7. Улсын үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах тухай Төрийн өмчийн хорооны тогтоол, компанийн хувьцааг үнэт цааст тооцох тухай Үнэт цаасны хорооны тогтоолуудыг үндэслэн үнэт цаасыг МХБ бүртгэн авна.

8. Төрийн өмчийн хороо МХБ-ийн төлөөрсөн хадгаламжид данстай байх бөгөөд төрийн эзэмшлийн үнэт цаасыг Төрийн өмчийн дансанд хадгална.

9. Төрийн өмчийн хорооны тотоолд заагдсан үнэт цаасны тоо ширхэг, доод үнэ нь үнэт цаасыг зарах захиалга болно.

10. Харилцагчид арилжаанд оролцохын тулд МХБ-ийн төлөөрсөн хадгаламжид данс нээлгэсэн байна.

11. ХОЭБ-ийн индексжүүлсэн үнийн дүнг тусгай кодоор бүртгэн харилцагчид тус бүрээр төлөөрсөн хадгаламжид хадгална.

12. Харилцагч үнэт цаас худалдан авах тухай захиалгаа анх зуучлуулсан МХБ-ийн гишүүн үнэт цаасны компаниар дамжуулан өгнө. Холболтын данс нээлгүүлж арилжааны оролцохгүй.

Гурав. Үнэт цаасны арилжаа, түүний төлбөр тооцоо

13. Харилцагчаас ирүүлсэн захиалгыг үндэслэн МХБ-ийн Төлбөр тооцоо хадгаламжийн алба ХОЭБ-ийн индексжсэн үнийн дүнтэй тэнцэх үнэт цаасыг нэрлэсэн үнээр тооцон бичилт хийнэ. Бичилтээр ХОЭБ-ийн үнийн дүн төрийн өмчийн дансанд, үнэт цаас харилцагчдын дансанд тус тус шилжинэ.

14. Харилцагчийн дансанд ХОЭБ-ийн үнийн дүнгээс үлдсэн, хувьцаа худалдан авч хүрэхгүй үлдэгдэл нэгж дээр харилцагч мөнгө нэмж хувьцаа худалдан авч болно. Энэ тохиолдолд бэлэн мөнгө, ХОЭБ-ийн дүнь тус бүртээ өөрийн кодоор төрийн өмчийн дансанд шилжинэ.

15. Төрийн өмчийн дансан дахь ХОЭБ-ийн дүнг устгаж, бэлэн мөнгийг Хорооны харилцах дансанд шилжүүлнэ.

16. Бичилтийг программын тусламжтай гүйцэтгэж, гүйлгээ хийгдсэн бүх дансны хуулгыг гаргана.

Дөрөв. Бусад зүйл

17. Арилжааны тухай мэдээлэл, дансны хуулга, холбогдох судалгааг МХБ Төрийн өмчийн хороонд ажлын 2 өдрийн дотор гаргаж өгнө.

18. ХОЭБ-ээр хувьцаа худалдан авсан харилцагчаас арилжааны шимтгэл авахгүй.

19. ХОЭБ-ээр хувьцаа арилжсан үнийн дүнгийн 0,3%-тай тэнцэх шимтгэлийг Төрийн өмчийн хороо МХБ-д төлнө.

20. Бэлэн мөнгөөр арилжсан хувьцааны үнийн дүнгийн 1%-тай тэнцэх шимтгэлийг МХБ нь үйл ажиллагааны зардалд тооцон Төрийн өмчийн данснаас суутган авна.

21. Төрийн өмчийн хорооноос ХОЭБ-ээр бүртгэсэн үнэт цаасны эзэмшигчийн нэрсийн жагсаалт, тэдгээрийн эзэмшиж буй үнэт цаасны тоо ширхэг, тэдгээрийн эзэмшиж буй үнэт цаасны нийт дүнгийн 5 хувиас дээш эзэмшиж буй этгээдийн нэрсийн жагсаалтыг тухайн сарын эцэст гаргаж өгнө.

22. Төрийн өмчийн хувьцааг бэлэн мөнгөөр худалдан авах харилцагч нийтэд зарласан арилжааны мэдээлэлд заасан МХБ-ийн банкууд дахь харилцах дансанд мөнгөө төлөрүүлнэ.

23. МХБ нь бэлэн мөнгөөр арилжсан хувьцааны 7 хоног тутмын орлогыг дараагийн долоо хоногийн ажлын 2 хоногт багтаан Төрийн өмчийн хорооны банкин дахь харилцах дансанд шилжүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 327806,
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны есдүгээр сарын 15 №42 (121)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

385. Стандартчилал, хэмжилзүйн зарим чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай Дугаар 121 785

386. Журам, дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 122 786

387. Үндэсний хороо байгуулах тухай Дугаар 123 796

388. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газраас баримтлах бодлогыг батлах тухай Дугаар 124 798

Хоёр. Яам, агентлагийн акт

389. Комисс, тусгай зөвшөөрөл олгох журам батлах тухай (Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын сайдын тушаал) Дугаар А/95 801

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 121 Улаанбаатар хот

Стандартчилал, хэмжилзүйн зарим чиг үүргийг Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Стандартчилал, хэмжилзүйн чиглэлээр сургалт явуулах, мэдээлэл арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөлгөө өгөх чиг үүргийг гэрээний үндсэн дээр төрөөс нэмэгдэл зардал гаргахгүйгээр Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.ОЧИРСҮХ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он № 42 (121)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 122** **Улаанбаатар хот**

Журам, дүрэм батлах, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 126 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 140 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ажлын цагийг нэгтгэн бодох журам"-ыг 1 дүгээр хавсралтын, "Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрэм"-ийг 2 дугаар хавсралтын, "Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм"-ийг 3 дугаар хавсралтын, "Нийгмийн хамгааллын улсын хяналтын дүрэм"-ийг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус батлуулсугай.

2. Засгийн газрын 1994 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 171 дүгээр тогтоолоор батлагдсан "Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм"-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

а/1 дүгээр зүйлд "...хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох..." гэснийг "...хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх..." гэж, 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг "Хүн амын нягтрал, аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл, эмнэлэг үйлчилгээний материаллаг бааз, нарийн мэргэжлийн эмч нарын хангамж зэрэгтэй уялдуулан суманд эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс байгуулан ажиллуулж болно" гэж өөрчлөн найруулах;

б/16 дугаар зүйлийн "в" заалтад "...үйлдвэрлэлийн осол..." гэсний дараа "...хурц хордлого..." гэж нэмэх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 92 дугаар тогтоол, "Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 193 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Эрүүл мэнд, нийгмийн Хамгаллын сайдын үүрэг гүйцэтгэгч **С.СОНИН**

Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ЦАГИЙГ НЭГТГЭН БОДОХ ЖУРАМ

1. Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан өдрийн болон долоо хоногийн ажлын цагийг баримтлах боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны ажлын цагийг нэгтгэн бодоход энэ журмыг мөрдөнө.

2. Ажил, үйлдвэрлэлийн онцлогийг харгалзан тодорхой хугацаанд буюу оргил ачааллын /тухайлбал ургац хураах, хадлан тэжээл бэлтгэх, мал нядлах, хээрийн нөхцөлд нүүдэллэн явж худаг ус гаргах, засварлах, ашигт малтмал ашиглах, хайгуулийн эмч нарын хангамж зэрэгтэй уялдуулан суманд эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс байгуулан ажиллуулж болно" гэж өөрчлөн найруулах;

б/16 дугаар зүйлийн "в" заалтад "...үйлдвэрлэлийн осол..." гэсний дараа "...хурц хордлого..." гэж нэмэх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 92 дугаар тогтоол, "Хөдөлмөрийн улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 193 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Эрүүл мэнд, нийгмийн Хамгаллын сайдын үүрэг гүйцэтгэгч **С.СОНИН**

Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ЦАГИЙГ НЭГТГЭН БОДОХ ЖУРАМ

1. Ажил, үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан өдрийн болон долоо хоногийн ажлын цагийг баримтлах боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны ажлын цагийг нэгтгэн бодоход энэ журмыг мөрдөнө.

2. Ажил, үйлдвэрлэлийн онцлогийг харгалзан тодорхой хугацаанд буюу оргил ачааллын /тухайлбал ургац хураах, хадлан тэжээл бэлтгэх, мал нядлах, хээрийн нөхцөлд нүүдэллэн явж худаг ус гаргах, засварлах, ашигт малтмал ашиглах, хайгуулийн ажил хийх, зам засах, барилгын үгсралт, засварын ажил хийх, богино хугацаанд их хэмжээний ажлын захиалга биелүүлэх болон эдгээртэй адилтгаж болох цаг үеийн, улирлын чанартай ажил эрхлэх/ үед ажлын өдрийн үргэлжлэлийг уртасган тогтоож, Хөдөлмөрийн тухай хуулийн 70.2-т зааснаас хэтрүүлэн ажилласан ажлын цагийг оргил ачааллын бус үед ажилтныг нөхөн амраах замаар зохицуулахад ажлын цагийг нэгтгэн бодох журмыг хэрэглэнэ.

3. Ажлын цагийг нэгтгэн бодож тооцох асуудлыг хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд тусгана.

4. Ажлын цагийг нэгтгэн бодож тооцох хугацаа, ажлын өдрийн үргэлжлэх цагийг тухайн ажил олгогчийн тушаалд тодорхой дурдсан байна.

5. Оргил ачааллын үед ажлын өдрийн үргэлжлэлийг 12-оос илүүгүй цагаар тогтоно.

6. Оргил ачааллын үед жинхэнэ ажилласан цагийг тооцохдоо тухайн хугацаанд жинхэнэ ажилласан өдрийн тоог ажлын өдрийг уртасган тогтоосон цагаар үржүүлж тодорхойлно.

Нэгдүгээр жишээ: "Д" компанийн захирлын тушаалд оргил ачааллын хугацааг 8 сарын 15-ны өдрөөс 10 сарын 1-ний өдрийн хооронд байхаар зааж ажлын өдрийн үргэлжлэлийг 12 цагаар тогтоосон гэвэл уг хугацаанд жинхэнэ ажилласан цаг нь /46өдөр*12цаг=522цаг/ 522 болно.

7.Оргил ачааллын үед ажлын цагийг хэтрүүлэн ажилласан цагийг тодорхойлохдоо жинхэнэ ажилласан цагийн нийт дүнгээс тухайн хугацааны өрдийн ажлын үргэлжлэлээр тооцсон ажлын цагийг хасна.

Хоёрдугаар жишээ: Нэгдүгээр жишээнд ажилтан "А" 8 дугаар сард ажлын 12 өдөр, 9 дүгээр сард ажлын 22 өдөр, бүгд 34 өдөр ажилласан байх ба ердийн ажлын өдрийн үргэлжлэл /8цаг/-ээр тооцоход тооцоот хугацааны ажлын цаг нь /34өдөр*8цаг=272 цаг/ 272 болно. Тэгвэл тооцоот хугацаанд буюу ажлын цагийг нэгтгэн бодоход хэтрүүлэн ажилласан бүх цаг нь /522цаг-272цаг= 250цаг/ 250 болно.

8. Тооцоот хугацааны ажлын цагийн фондоос хэтрүүлэн ажилласан цагийг оргил ачааллын бус үед дараахь байдлаар зохицуулна:

а/ ачаалал багатай үед ажлын өдрийн үргэлжлэлийг богиносгох;

б/ долоо хоногийн ажлын өдрийн тоог цөөрүүлэх;

в/ээлжийн амралт дээр нь нэмэгдэл амралт олгох;

г/ сул зогсолт гарвал өмнөх хугацаанд хэтрүүлэн ажилласан цагт нь тооцож нөхөн амраж болно.

9. Тооцоот хугацааны ажлын цагийн фондоос хэтрүүлэн ажилласан цагаа бүтнээр, эсвэл тодорхой хэсгийг нь биеэр нөхөн амралгүйгээр ажиллах хүсэлтээ албан ёсоор гаргасан ажилтныг ажил олгогч ажиллуулж болно.

10.Тооцоот хугацааны ажлын цагийн фондоос хэтрүүлэн ажилласан цагийг энэ журмын 8-д зааснаар нөхөн амруулахаар зохицуулж чадаагүй, 9-д дурдсанаар биеэр нөхөн амруулаагүй тохиолдолд хэтрүүлэн ажилласан цагт ногдох цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу цагийн тарифт цалинг 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлэн тооцож олгоно. Хөдөлмөрийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр тогтооно.

Гуравдугаар жишээ: Хоёрдугаар жишээнд дурдсан ажилтан "А" мэргэжлийн 4 дүгээр зэрэгтэй, мэргэжлийн зэргийн цагийн тарифт цалин нь 426 төгрөг ба түүний тооцоот хугацаанд ажлын цагаас хэтрүүлэн ажилласан 250 цагийн 40 цагийг ажлын өдрийн үргэлжлэлийг богиносгох, 70 цагийг долоо хоногийн ажлын өдрийг цөөрүүлэх, 60 цагийг нэмэгдэл амралт олгох хэлбэрээр зохицуулаад 250цаг-(40+70+60)=80цаг/ үлдсэн 80 цагийн цалин хөлсийг тухайн ажилтны мэргэжлийн зэргийн цагийн тарифт цалинг 1.5 дахин нэмэгдүүлэн олгох тохиолдолд түүнд 80цаг*/426төг*1.5/=51144 төгрөг олгоно. Энэ тооцоог урьдчилгаа цалин хөлс олгоогүй тохиолдлыг сонгож хийсэн болно.

11. Ажлын цагийг нэгтгэн бодох журмыг мөрдөж байгаа үед нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол Хөдөлмөрийн тухай хуулийн 52,53 дугаар зүйлд зааснаар цалин хөлсийг олгоно.

12. Ажлын цагийг нэгтгэн бодох журмыг мөрдөж ажилласан бол ажлын цагийн тооцоог тухайн ажлын жилд нь багтаан хийнэ.

Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН ТАСЛАХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Монгол Улсын хуульд шүүх хянан шийдвэрлэхээр зааснаас бусад хөдөлмөрийн ганцаарчилсан маргааныг хөдөлмөрийн маргаан таслах орон тооны бус комиссоор хянан шийдвэрлэхэд энэ дүрмийг мөрдөнө.

2.Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан аж ахуйн нэгж, байгууллагын дэргэд хөдөлмөрийн маргаан таслах комисс /цаашид "комисс" гэнэ/ байгуулж ажиллуулна

3.Комисс нь Хөдөлмөрийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

4.Хөдөлмөрийн маргааныг комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Комиссын хурлаас шийдвэр гаргана. Хурлын явцын тухай тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлийг хавсралтад заасны дагуу хөтөлнө.

Хоёр. Комиссын бүрэлдэхүүн, зохион байгуулалт

5.Комисс нь ажил олгогчийн болон ажилтны эрх ашгийг төлөөлөн хамгаалах үүрэг хүлээсэн үйлдвэрчний эвлэлийн, Үйлдвэрчний эвлэл байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон төлөөлөгдөөс бүрдэнэ.

6.Ажил олгогчийн болон ажилтны төлөөлөгчдийн тоо нь тэнцүү байна.

7.Комиссын бүрэлдэхүүнд орох ҮЭ-ийн болон ажилтны төлөөлөгчийг тухайн байгууллагуудын нийт ажилтны хурлаас олонхийн саналаар сонгоно. Ажил олгогчийн төлөөлөгчийг ажил олгогчийн шийдвэрээр томилно. Нийт ажилтны хурлын болон ажил олгогчийн шийдвэрт төлөөлөгчдийг ямар хугацаагаар сонгосон буюу томилсон тухай тэмдэглэсэн байна.

8.Талуудын төлөөлөгчид нь комиссын үйл ажиллагаанд тэгш эрх, үүрэгтэй оролцох бөгөөд тал тус бүр өөрийн ахлагчийг сонгоно.

9.Комиссын бүрэлдэхүүнд орох өөрчлөлтийг энэ дүрмийн 7 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Гурав. Хөдөлмөрийн маргааны талаар өргөдөл гаргах, маргааныг хянан хэлэлцэх үйл ажиллагаа

10.Ажилтан нь хөдөлмөрийн харилцаатай холбогдсон маргааны талаар зохих үндэслэл бүхий өргөдлөө хууль тогтоомжид заасан хугацаанд комисст гаргана.

11.Хөдөлмөрийн маргааны тухай өргөдлийг холбогдох бусад материалын хамт ажилтны төлөөлөгчдийн ахлагч хүлээн авч бүртгэнэ. Комисс нь өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор маргааныг хянаж шийдвэрлэнэ.

12.Хөдөлмөрийн маргаанд холбогдох материалыг нарийвчлан шалгаж, комиссын хуралд оруулах бэлтгэлийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах хүнийг комиссын бүрэлдэхүүнд орсон талуудын ахлагч нь өөрийн гишүүдээс томилно.

13.Комисс нь хөдөлмөрийн маргаантай холбогдох материалыг эрх зүйн талаас нь шалгах, түүний үндэслэлийг тогтоох ажилд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажил олгогчоос шаардлагатай баримт бичиг, тооцоо, тайлбарыг гаргуулан авах эрх эдэлнэ.

14.Комиссын хурлыг шаардлагатай үед зарлан хуралдуулах бөгөөд хурлын дарга, нарийн бичгийн даргын үүргийг хоёр талын төлөөлөгчид зэлжлэн гүйцэтгэнэ. Хурлын дарга болон нарийн бичгийн даргын үүргийг

нэг талын төлөөлөгчид нэгэн зэрэг гүйцэтгэж болохгүй.

15.Комиссын хуралд өргөдөл гаргасан ажилтныг биеэр байлцуулан маргааныг шийдвэрлэнэ. Өргөдөл гаргасан ажилтны хүсэлтийн дагуу түүнийг байлцуулахгүйгээр маргааныг хянан шийдвэрлэж болно. Өргөдөл гаргасан ажилтан комиссын хуралд оролцохоо мэдэгдээд хүндэтгэн үзэх шалтгаанаар ирээгүй тохиолдолд маргааныг хянан шийдвэрлэх ажлыг дараагийн хурал хүртэл хойшлуулна. Өргөдөл гаргасан ажилтан комиссын хуралд оролцохоо мэдэгдээд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй тохиолдолд өргөдлийг хэлэлцэхгүй-гээр маргааныг хэрэгсэхгүй болгож болно.

16.Комиссын хуралд маргалдагч талууд /ажил олгогчийн уг асуудалд холбогдох албан тушаалтан, өргөдөл гаргасан ажилтан/-аас гадна тухайн маргаантай холбогдсон асуудлыг шалгахад оролцон ажил олгогчийн холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулж болно.

17.Комиссын хурлыг нийт гишүүдийн болон тал тус бүрийг төлөөлөх гишүүдийн 75-аас доошгүй хувь нь оролцох тохиолдолд хуралдуулна.

18.Хуралдаанд оролцсон комиссын гишүүдийн олонхийн саналаар комиссын шийдвэр гарах бөгөөд уг шийдвэрийг үүрэг хүлээсэн тал тэмдэглэлд заасан хугацаанд заавал биелүүлнэ. Комиссоос хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг ажил олгогч заавал биелүүлэх үүрэгтэй.

19.Комиссын хурлын шийдвэрт хуралдаанд оролцсон комиссын бүх гишүүд, хурлын тэмдэглэлд тухайн хурлын дарга, нарийн бичгийн дарга тус тус гарын үсэг зурна. Хэрэв комиссын хурлаар асуудлыг санал нэгтэй шийдвэрлэж чадахгүйд хүрвэл тэмдэглэлд хоёр талын төлөөлөгчдийн санал зөрүүтэй асуудлыг тодорхой тэмдэглэнэ.

20.Комиссын хурлын шийдвэрийг маргалдагч талуудад албан ёсоор танилцуулж, шийдвэрийн хувийг өгнө.

21.Комиссын шийдвэрийг ажил ологч болон өргөдөл гаргасан ажилтан эс зөвшөөрсөн, эсхүл комиссын гишүүд нэгдсэн тохиролцоонд хүрээгүй, тэрчлэн шийдвэрийн дагуу үүрэг хүлээсэн тал үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 127.1-д заасны дагуу шүүхэд давж заалдана.

Хөдөлмөрийн маргаан таслах комиссын дүрмийн хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН МАРГААН ТАСЛАХ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

...оны ... дугаар
сарын ...-ны өдөр **Дугаар...**

..... дэргэдэх
(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)
хөдөлмөрийн маргаан таслах комиссын хурлаар ҮЭ-ийн байгууллага /ажилтан/-ын төлөөлөгч..... ажил олгогчийн төлөөлөгч ..... нарын бүрэлдэхүүнтэйгээр өргөдөл гаргасан ажилтан.....,гэрч..... нарыг оролцуулан ..... нарын хооронд гарсан ..... тухай хөдөлмөрийн маргааныг хэлэлцэв.

Хурлын даргаар ....., нарийн бичгийн даргаар..... ажиллав. /Комиссын бүрэлдэхүүнээс зарим гишүүдийг уг хуралдаанд оролцуулахаас маргалдагч этгээдүүд татгалзсан санал, хүсэлт гаргасан бол санал, хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай комиссын хурлын тэмдэглэлд (энэ хэсэгт) тэмдэглэнэ/.....

.....

Хурлын дарга .....-аас гарсан маргааны тухай танилцуулав.

Маргааны товч агуулга: .....

.....

Ажил олгогчийн тайлбар: .....

.....

Өргөдөл гаргасан ажилтны тайлбар:.....

.....

Гэрчийн тодорхойлолт:.....

.....

Гомдлыг шалгасан мэргэжлийн хүмүүсийн дүгнэлт:

.....

.....

Санал:

а/ажилтны төлөөлөгчдийн:.....

.....

б/ажил олгогчийн төлөөлөгчдийн:.....

.....

Комиссын шийдвэр:.....

.....

заалтыг үндэслэн хоёр тал санал тохиролцсоны дагуу.....

.....

тухай маргааныг.....

.....

.....шийдвэрлэв.

/Шийдвэрийг биелүүлэх болон шүүхэд өргөдөл гаргах хугацаа, санал тохироогүй байдлыг тодорхой зааж өгнө/.

ХУРЛЫН ДАРГА.....

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА.....

Энэхүү тэмдэглэлд хурлыг даргалсан талын төлөөлөгчдийн байгууллагын тамга буюу тэмдэг дарна.

Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Хөдөлмөрийн улсын хяналтын зорилго нь өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол түс улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн стандартын биелэлтийг хангуулахад оршино.

2.Хөдөлмөрийн улсын хяналтыг Хөдөлмөрийн хяналтын улсын ерөнхий байцаагч, хөдөлмөрийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын тохируулагч агентлаг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын албаны хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын ахлах байцаагч, улсын байцаагч хэрэгжүүлнэ. Шаардлагатай бол зарим яам, агентлагт хөдөлмөрийн улсын байцаагч ажиллуулж болно.

3.Хөдөлмөрийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын тохируулагч агентлагийн дарга нь хөдөлмөрийн улсын ерөнхий байцаагч байна.Хөдөлмөрийн улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4.Хөдөлмөрийн хяналтын улсын албаны хөдөлмөрийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг хөдөлмөрийн улсын ерөнхий байцаагч томилж, чөлөөлөх бөгөөд улсын ахлах байцаагч болон улсын байцаагчийн эрхийг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн олгоно.

5.Яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэгт ажиллах хөдөлмөрийн улсын байцаагчийг тухайн салбарын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн олгоно.

6.Хөдөлмөрийн улсын байцаагч нь эдийн засагч, инженер-эдийн засагч, инженер, хуульч мэргэжилтэй; хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч нь хөдөлмөрийн эрүүл ахуйч мэргэжилтэй байна. Хөдөлмөрийн улсын байцаагч, хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч /цашид хөдөлмөрийн улсын байцаагч гэнэ/ нь тухайн асуудлаар мэргэшсэн, хянан шалгах ажлын зохих туршлагатай байна.

7.Хөдөлмөрийн хяналтын улсын алба, хөдөлмөрийн улсын байцаагч нь үйл ажилла-гаандаа холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, хөдөлмөрийн стандартууд болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

8.Хөдөлмөрийн улсын байцаагч нь зохих журмын дагуу үйлдсэн үнэмлэх, дугаар бүхий тэмдэг, албан шаардлага, дүгнэлт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

9.Хөдөлмөрийн улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хяналт шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх асуудлыг хөдөлмөрийн хяналтын улсын алба хариуцан хэрэгжүүлнэ.

Хоёр.Хөдөлмөрийн улсын хяналтын чиглэл

10.Хөдөлмөрийн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ Хөдөлмөрийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдож Засгийн газар болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилт;

б/ хөдөлмөрийн харилцааны талаарх-и Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцийн биелэлт;

в/ хамтын гэрээ, хэлэлцээрийг байгуулах, бүртгэх, хэрэгжүүлэх талаарх-и хууль тогтоомжийн биелэлт, хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулалт;

г/ хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажил гүйцэтгэх, даусгавар болох, цуцлах болон хөдөлмөрийн ганцаарчилсан маргааны шийдвэрлэлт;

д/ цалин хөлс, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, олговор, нөхөн төлбөрийн холбогдолтой хууль тогтоомж, бусад шийдвэрийн хэрэгжилт;

е/ ажил, амралтын цаг, ээлжийн амралт зохицуулалт;

ж/ иргэдийн хөдөлмөр эрхлэлт, үүний дотор эмэгтэйчүүд,ахмад настан, насанд хүрээгүй, тахир дутуу, одой болон насанд хүрээгүй хүн, гадаадын иргэд, гадаадын байгууллагад ажил-

лаж байгаа иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаархи хууль тогтоомж, бусад шийдвэрийн хэрэгжилт;

з/ хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлагатай холбогдсон шийдвэрийн мөрдөлт, хэрэгжилт;

и/ хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, алба, ажилтны ажил үүргийн биелэлт;

к/ ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл болон техникийн аюулгүй ажиллагаа нь улсын стандартын шаардлагад нийцэж байгаа байдал, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, судалгааны талаархи шийдвэрийн хэрэгжилт;

л/ үйлдвэрлэлийн барилга байгууламж барих, шинэчлэх, өргөтгөх зураг төсөл болон техникийн нөхцөл нь дагаж мөрдөж байгаа стандартын шаардлагад нийцэж байгаа байдал, холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагаас зөвшөөрөл авсан байдал;

м/ машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны шаардлага, техникийн паспортын хөтлөлт, холбогдох мэргэжлийн байгууллагаас олгосон зөвшөөрөл;

н/ өргөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолойд мэргэжлийн байгууллагаар туршилт, тохируулга, баталгаажуулалт хийлгэсэн байдал;

о/ ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангамж, баталгаажуулалт, тэдгээрийг ариутгаж, цэвэрлэж, засварласан байдал;

п/ химийн хорт болон тэсрэх, цацраг болон биологийн идэвхт бодисын ашиглалт, хамгаалалт;

р/ хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд олгох өстой хор саармагжуулах хангамж, үйлдвэрлэлийн ахуйн байдыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилт;

с/ үйлдвэрлэлийн технологи, материал, түүхий эд, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон ажлын байрны бусад хүчин зүйл нь ажилтны эрүүл мэндэд нөлөөлж буй байдал;

т/ мэргэжлээс шалтгаалсан болон ердийн өвчний өвчлөлт, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулсан байдал;

у/ үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын судалгаа, бүртгэл.

11.Хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ. Төрийн захиргааны хяналтыг хэрэгжүүлж буй хөдөлмөрийн улсын байцаагч нь хяналт шалгалтыг шаардлагатай гэж үзвэл удирдамжгүйгээр өөрийн санаачилгаар гүйцэтгэж болно.

Гурав.Хөдөлмөрийн улсын байцаагчийн үүрэг, эрх

12.Хөдөлмөрийн улсын байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/ энэ дүрмийн 10, 11 дүгээр зүйлд заасан чиглэлийн дагуу хөдөлмөрийн улсын хяналтыг зохион байгуулж явуулах;

б/ үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламжийн зураг төслийг зохиох, барьж байгуулах болон шинэчлэх, өргөтгөх, ашиглалтад хүлээн авах, технологийн тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийхэд оролцож дүгнэлт гаргах;

в/ үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэсэн актыг хянах, хүний амь нас хохироосон бүюу хүнд, бүлэг ослыг газар дээр нь тусгайлан судалж дүгнэлт гаргах, ослын үршигийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

г/ хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн стандартын хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргах;

д/ хяналт шалгалтын дүнг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, ажилтанд танилцуулж холбогдох баримт бичгийг бүрдүүлэх;

е/ хяналт шалгалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, технологийн нууцыг чанд хадгалах;

ж/ хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх, байгууллага, албан тушаалтны хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх;

з/ гаргасан акт, дүгнэлт, албан шаардлагын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

и/ хяналт шалгалтын ажлын тайлан,

үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогын мэдээг байгууллага, аж ахуйн нэгжээр нэгтгэх, мэдээлэх.

13.Хөдөлмөрийн улсын байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/ аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн нөхцөл, машин, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь ажилтны амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулж байгаа буюу учруулж болзошгүй нь зохих ёсоор нотлогдвол зөрчлийг арилгах арга хэмжээ авах, түүнчлэн осол аюул гарч болох тохиолдолд холбогдох аж ахуйн нэгж, Байгууллага, түүний нэгжийн үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд түр болон бүрмөсөн зогсоох;

б/ хөдөлмөрийн нөхцөл болон стандартын шаардлагыг хангаагүй ажлын тусгай хувцас, бие хамгаалах хэрэгслийг ажилтанд олгохыг хориглох;

в/ ноцтой аюул осол гарсан, хүний амь, эрүүл мэнд хохирсон, учруулсан хохирол нь нийгэмд хор аюул ихтэй бол шалгалтын акт, материалыг эрх бүхий байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;

г/ хийж байгаа хяналт шалгалтын асуудлаар болон хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар амаар буюу бичгээр тайлбар авах, дүрс болон ярианы бичлэг хийх;

д/ холбогдох байгууллагын удирдлагатай тохиролцсоны үндсэн дээр зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, шинжээчийг томилуулан ажиллуулах талаар холбогдох байгууллагын эрх баригчид хүсэлт гаргах;

е/ энэхүү дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх;

ж/ хяналт шалгалтаар илэрсэн дутагдал зөрчлийг арилгах талаар байгууллага, албан тушаалтанд хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг хангуулах;

з/ хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн стандартыг зөрчиж гаргасан ажил олгогчийн шийдвэрийг түдгэлзүүлэх;

и/ материал, бодис, түүхий эдээс сорьц авах замаар шинжилгээ, судалгаа хийх;

к/ хөдөлмөрийн улсын байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн болон илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, гэм буруутай этгээдэд Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай хуулиуд болон холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн захиргааны хариуцлага хүлээлгэх;

л/ хууль тогтоомжид заасан бусад эрх.

14.Хөдөлмөрийн улсын байцаагч нь хяналт тавьж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас шууд буюу шууд бус хэлбэрээр цалин урамшуулал авч болохгүй.

Дөрөв.Бусад зүйл

15.Хөдөлмөрийн улсын хяналтын алба, хөдөлмөрийн улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хүгацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

16.Хөдөлмөрийн улсын байцаагчийг байгууллага, аж ахуйн нэгжийн хүсэлтээр хяналт шалгалт, туршилтын болон осол, хурц хордлогыг судлах, дүгнэлт гаргах ажилд оролцуулсан тохиолдолд холбогдох зардлыг хүсэлт гаргасан байгууллага хариуцна.

17.Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж,албан тушаалтан байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно.

Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

18.Хөдөлмөрийн улсын байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 1999 оны 122 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Нийгмийн хамгааллын улсын хяналтын зорилт нь нийгмийн халамжийн багц хууль, нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, нийгмийн хамгааллын бүх төрлийн арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулсан төсөв, зээл, тусламж, төслийн хөрөнгийн зарцуулалтын байдалд хөндлөнгийн хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд оршино.

2.Нийгмийн хамгааллын улсын хяналтыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын тохируулагч агентлагийн болон түүнийн асуудлыг хариуцсан аймаг, нийслэл, сум, дүүргийн улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

3.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын асуудал эрхэлсэн агентлагийн нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч, байцаагчийг агентлагийн дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор нийгмийн хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн олгоно.

5.Аймаг, нийслэл, сум, дүүрэгт ажиллах нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг нийгмийн хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн олгоно.

6.Ажлын онцлог болон, шаардлагыг харгалзан зарим яам, газар, агентлагт нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч ажиллуулж болно. Иймхүү ажиллах байцаагчийг тухайн байгууллагын эрх баригч томилж, чөлөөлөх бөгөөд түүнд улсын байцаагчийн эрхийг нийгмийн хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн олгоно.

7.Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь дээд боловсролтой, эдийн засагч, санхүүч, нягтлан бодогч, инженер-эдийн засагч, хүний их эмчийн мэргэжилтэй, тухайн мэргэжлээр мэргэшсэн байна.

8.Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчид нь үйл ажиллагааандаа холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

9.Нийгмийн хамгааллын хяналтын улсын ерөнхий болон ахлах байцаагч, байцаагч (цаашид "байцаагч" гэнэ) нь батлагдсан загвар бүхий үнэмлэх, хувийн дугаартай тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Нийгмийн хамгааллын улсын хяналтын чиглэл

10.Нийгмийн хамгааллын улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/ нийгмийн халамжийн хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт;

б/ нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт;

в/ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах чиглэлээр гарсан шийдвэрийн хэрэгжилт;

г/ иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын холбогдох шийдвэрийн хэрэгжилт;

д/ нийгмийн даатгалын болон халамжийн сангийн бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, мэдээ, тайлан гаргасан байдал, үр дүн;

е/ нийгмийн даатгал, халамж, асрамж үйлчилгээ, хөдөлмөр зохицуулалт, ядуурлыг бууруулах асуудал хариуцсан байгууллагуудын үйл ажиллагаат хянан шалгаж, хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, мэдээ тайлан гаргасан байдал, үнэлэлт, дүгнэлт;

ж/ нийгмийн хамгааллын холбогдолтой арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулагдсан төсвийн болон зээл, тусламж, хандивын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдал, хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;

з/ аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо, түүний гүйцэтгэл, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

и/ эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын үйл ажиллагаанд хяналт тавих, тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтыг дахин магадлах.

Гурав.Нийгмийн хамгаалллын хяналтын улсын байцаагчийн бүрэн эрх

11.Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Нийгмийн халамжийн тухай хуулиудаар тогтоосон нийтлэг бүрэн эрхээс гадна нийгмийн хамгаалллын хяналтын улсын байцаагч нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ нийгмийн хамгаалллын арга хэмжээнд зориулагдсан бүх төрлийн сан, зээл, тусламж, хандив, төслийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хөндлөнгийн хяналт тавих;

б/ нийгмийн даатгалын санг бүрдүүлж буй бүх төрлийн шимтгэл, хураамжийн тооцоог хянан шалгаж илэрсэн зөрчлийг арилгах;

в/ хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх, нууцыг хадгалах;

г/ зориулалтын бус зүйлд зарцуулсан хөрөнгийг буруутай эздээр төлүүлэх, акт тогтоож гүйцэтгэлийг хангах;

д/ эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын ажилд хяналт тавьж дахин магадлагаа хийж дүгнэлт гаргах;

е/ хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, илрүүлсэн зөрчил дутагдал, тогтоосон акт төлбөрийн үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

ж/ шалгалтын дүн, акт, материалыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрх бариг, няттлан бодогчид танилцуулж гарын үсэг зуруулж тэмдэг дарж баталгаажуулах;

з/ албан үүргээ гүйцэтгэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орж, хяналт шалгалтын ажилд шаардлагатай бичиг баримтыг холбогдох албан тушаалтны зөвшөөрлөөр гаргуулан авч, няттлан шалгах;

и/ шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын явцад санхүүгийн баримтыг няттлан шалгах, хөрөнгийн тооллого хийх;

к/ нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сан, бусад зээл, тусламж, төслийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан бол акт тогтоож улсын төсвийн орлого болгох;

л/ нийгмийн даатгалын шимтгэлээ тогтоосон хугацаанд төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох, шимтгэл, алдангийг тэдгээрийн хөрөнгөөс дайчлан гаргуулах, төлүүлэх саналыг агентлагт тавьж шийдвэрлүүлэх;

м/ хууль тогтоожийн заалтыг зөрчиж үндэслэлгүй тогтоосон тэтгэвэр, тэтгэмж, нөхөн төлбөр, хөнгөлөлтийг түр буюу бүрмөсөн зогсоох, нөхөн олгуулах;

н/ буруутай болох нь нотлогдсон эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг цуцлах, өөрчлөх;

о/ хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар, албан шаардлага өгч биелэлтийг хангуулах, хариу авах;

п/ энэ дүрэмд заасан үүргээ хэрэгжүүлэх явцад гарсан шийдвэр гаргах шаардлагатай асуудлыг орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

12.Нийгмийн хамгаалллын хяналтын улсын байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн болон илэрсэн зөрчлийг арилгах талаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллага болон гэм буруутай этгээдэд Төрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Нийгмийн халамжийн тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийн заалтыг үндэслэн захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв.Бусад зүйл

13.Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын хяналтын алба, улсын байцаагчийн тавьсан шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хугацаанд нь биелүүлж хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

14.Шалгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан байцаагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо 10 хоногийн дотор хяналт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн хугацаанд шийдвэрлэж хариу өгнө. Гомдол гаргагч уг шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

15.Энэхүү дүрмийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гаргасан санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу хянан шийдвэрлэж байна.

16.Байцаагч нь үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 123** **Улаанбаатар хот**

Үндэсний хороо байгуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 138 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасныг үндэслэн ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгуллагатай зөвшилцсөнөөр Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгуллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо /орон тооны бус/-г Засгийн газрын дэргэд байгуулсугай.

2."Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны дүрэм"-ийг хавсралтын ёсоор батална сугай.

3.Засгийн газрын дэргэд Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо байгуулагдан ажиллах болсонтой холбогдуулан түүний үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны төсөвт жил бүр тусгаж байхыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Эрүүл мэнд, нийгмийн Хамгааллын сайдын үүрэг гүйцэтгэгч **С.СОНИН**

Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч **Я.ОЧИРСҮХ**

Засгийн газрын 1999 оны 123 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо /цаашид "Үндэсний хороо" гэнэ/-ны үйл ажиллагааны үндэсн зорилго нь хөдөлмөрийн асуудлаар төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд нөлөөлөх, эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар үндэсний хэмжээнд зөвлөлдөх, нийгмийн зөвшлийн тогтолцоог хөгжүүлэх, иргэдийн хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон эдийн засаг, нийгмийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хүрээнд үүссэн хамтын маргааныг зохицуулах, үндэсний хэлэлцээрийг байгуулах, хэлэлцээрийн биелэлтэд хяналт тавихад оршино.

2.Үндэсний хороо нь Засгийн газар, ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгуллагын төлөөлөл бүхий үндэсний зөвлөлдөх /орон тооны бус/ байгуллага мөн.

3.Үндэсний хороо нь Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, бусад хууль тогтоомж, Монгол улсын олон улсын гэрээ, энэ дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгонс.

4.Үндэсний хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Аль нэг талын төлөөлөгчид бүгд эсрэг санал өгч цөөнх болсон тохиолдолд үндэслэлээ тайлбарлан дахин санал хураалгах эрх эдэлнэ.

5.Үндэсний хороо нь тогтоосон журмаар хийлгэсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6.Үндэсний хорооны үйл ажиллагааны зардлыг Засгийн газар тогтоож улсын төсөвт тусгана.

Хэёр. Үндэсний хорооны бүрэлдэхүүн

7.Үндэсний хороо нь Засгийн газар, Ажил олгогчийн болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлэн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий нийт 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.

8.Үндэсний хорооны дарга, дэд дарга, бүрэлдэхүүнийг Хөдөлмөрийн тухай Хуулийн 138.4-т заасны дагуу томилно.

9.Үндэсний хорооны дарга нь хөдөлмөрийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн байна.

10.Үндэсний хороо нь ажлын онцлог, шаардлагыг харгалзан салбар хороо, түр болон байнгын ажлын хэсгийг байгуулан ажиллуулж болно.

Гурав. Үндэсний хорооны үйл ажиллагааны чиглэл

11.Үндэсний хорооны үйл ажиллагаа дарга удирдах бөгөөд гурван талын төлөөлөлтэй, орон тооны бус ажлын албатай байж болно.

12.Хөдөлмөрийн асуудлаархи төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах асуудлын төслийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад оруулна.

13.Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар ажилладаг өөрийн салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагаа мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

14.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн асуудлаар зөвлөлгөөн, сургалт зохион байгуулах, олон улсын туршлага судлах, хэлэлцээр байгуулан хэрэгжүүлэх асуудлаар зөвлөгөө өгнө.

15.Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээр байгуулж, биелэлтийг хангуулна.

16.Засгийн газар, Ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн улсын хэмжээний байгууллагуудын хооронд гурван талт хамтын ажиллагаа хөгжүүлэх асуудлаар санал боловсруулж холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

17.Үндэсний хороо нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар, Ажил олгогчийн болон ажилтны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллагад зөвлөмж гаргана.

18.Хорооны бүрэн эрхийн хүрээний асуудлаар мэргэжилтэн, шинжээч ажиллуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудаас шаардлагатай мэдээлэл, тайлбар, лавлагаа гаргуулж авах, холбогдох байгууллагын төлөөлөгчдийг урьж хуралдаанд оролцуулж болно.

Дөрөв. Үндэсний хорооны хуралдаан

19.Үндэсний хорооны хуралдаанд талууд төлөөлөгчөө бүрэн оролцуулах үүрэг хүлээнэ. Хуралдааныг нийт гишүүдийн болон тал тус бүрийг төлөөлөх гишүүдийн 60-аас доошгүй хувь оролцсон тохиолдолд хуралдуулна.

20.Үндэсний хороо 3 сард нэг удаа хуралдана. Хуралдааныг Үндэсний хорооны дарга, дэд дарга зарлан хуралдуулна.

Шаардлагатай үед аль нэг талын санаачилснаар ээлжит бус хуралдааныг хийж болно.

21.Үндэсний хорооны хуралдаанаас шийдвэр, зөвлөмж гаргаж түүнд ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн улсын хэмжээний байгууллагын тал тус бүрээс эрх олгосон нэг төлөөлөгч зөвшөөрөн гарын үсэг зурах бөгөөд Үндэсний хорооны дарга гарын үсэг зурж батална.

Тав. Үндэсний хорооны бүрэн эрх

22.Үндэсний хороо нь Хөдөлмөрийн тухай хуулийн 138.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 124** **Улаанбаатар хот**

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газраас баримтлах бодлогыг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газраас баримтлах бодлогыг хавсралтын ёсоор батлэсугай.

2.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газраас баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг батлагдсан төсөвтөө багтаан зохион байгуулахыг Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын үүрэг гүйцэтгэгч С.Сонин, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Засгийн газрын 1996 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоол, "Залуучууд, спортын байгууллагын зохион байгуулалтын тухай" Засгийн газрын 1994 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Эрүүл мэнд, нийгмийн Хамгаллын сайдын үүрэг гүйцэтгэгч **С.СОНИН**

Засгийн газрын 1999 оны 124 дүгээр тогтоолын хавсралт

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ЗАСГИЙН ГАЗРААС БАРИМТЛАХ БОДЛОГО

Нийтлэг үндэслэл

Биеийн тамирыг хөгжүүлэх бодлогын үндэс нь хүн амын эрүүл мэндийг бэхжүүлэх, өсвөр залуу үеийг эрүүл чийрэг өсгөх, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, ажиллах чадавхи, эрч хүчийг нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэн биеийн тамир хөгжих таатай орчин бүрдүүлэхэд хувь хүний хөгжлийг хангахад оршино.

Спортыг хөгжүүлэх бодлогын үндэс нь тамирчдын ур чадварыг сайжруулах, сургалт дасгалжуулалтыг шинжлэх ухааны үндэсэн дээр явуулж түүний үр өгөөжийг дээшлүүлж, өндөр зэрэгтэй тамирчдыг бэлтгэж олимпийн тоглолт, тив дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргах, улмаар улс орноо олон улсын тавцанд сурталчлах, олимпийн үзэл санааг хөгжүүлэхэд чиглэгдэнэ.

Нэг. Биеийн тамирын талаар

1.Биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгох хөдөлгөөн өрнүүлнэ.

1.Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тогтмол үнэлж, судлах тогтолцоог бүрдүүлэх, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хүн амын бие бялдрын хөгжлийг сайжруулан чийрэгжүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, бие махбодийн чадавхыг нөхөн сэргээхэд ергөнөөр ашиглахад чиглүүлнэ.

2.Чийрэгжүүлэх болон эмчилгээний хөдөлгөөний жорыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

3.Рашаан сувилал, амралтын газруудын материаллаг баазыг өргөжүүлэх улмаар биеийн тамир, чийрэгжүүлэлтийн дасгал хөдөлгөөнөөр нөхөн сэргээх, эмчлэн эрүүлжүүлэх ажлын хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

4.Хүн амд бие бялдрын хүмүүжил олгох тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах ажиллагааг өргөжүүлнэ.

II.Биеийн тамирыг хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаат идэвхжүүлнэ.

5.Биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт эрүүл мэнд-бие бялдрын чийрэгжүүлэлтийн арга зүй, өөрийн эрүүл мэндийг хянах тухай сэдвүүдийг оруулах, биеийн тамир, спортоор хичээллэгчдэд мэргэжлийн арга зүйн зөвлөмж, туслалцаа үзүүлэх мэдлэг,чадвар, дадлага олгох чиглэлээр их, дээд сургуулиудтай хамтран ажиллана.

6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын эрүүл мэнд-биеийн тамирын хичээлийн ахуулга, арга зүйг хүүхэд, сурагчдад нас биений онцлогт тохируулан өөрчлөн шинэчлэх, тэднийг биеийн тамир, спортын сонирхсон төрлөөр сонгон сурадцаж бие бялдраа чийрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.Нийтийн биеийн тамирын үйл ажиллагаат биеийн тамир болон спортоор бие даан хичээллэгчдийн өсөлт, хүн амын өвчлөл болон хөдөлмөрийн чадвар түр алдалтыг бууруулсан үзүүлэлт, биеийн тамир-чийрэгжүүлэлтийн материаллаг баазыг бэхжүүлсэн, сургалт сурталчилгааны ажлыг сайжруулсан байдалтай холбон дүгнэж байх зарчмыг баримтална.

8.Иргэдийг биеийн тамир, спортоор бие даан хичээллэх, бие бялдраа чийрэгжүүлэх мэдлэг, чадвар, дадлагатай болгох сургалт сурталчилгааны ажлыг боловсронгуй болгоно.

Ш.Биеийн тамирын сургалт сурталчилгаат эрчимжүүлнэ.

9.Хүн амын дунд нийтийг хамарсан биеийн тамирын үүлзалт өдөрлөг, наадам, уралдаант үзлэг, спартакиад зэрэг арга хэмжээг тогтмол зохион явуулна.

10.Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамирын талаархи эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээг өргөтгөж, тэргүүн туршлага,дэвшилтэт арга хэлбэрийг хөгжүүлэн нэвтрүүлэхийг чухалчилна.

11.Төрийн болон төрийн бус байгууллагууд өөрийн хүч хөрөнгө, үүсгэл санаачилгаар биеийн тамирын заал, талбай, эрүүл мэнд-чийрэгжилтийн танхим барьж байгуулах ажлыг хөхиүлэн дэмжиж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

12.Бие бялдрын соёл, биеийн тамирын ач холбогдлыг радио, телевиз, сонин хэвлэлээр сурталчлах ажлыг өргөжүүлнэ.

Хоёр.Спортыг хөгжүүлэх талаар

I. Спорт хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

13.Хүн амын бие бялдрын хөгжил, орон нутгийн уламжлал, байгаль цаг агаарын онцлог, боловсон хүчний чадавхи, материаллаг баазаа түшиглэн үндэсний болон орчин үеийн спортын төрлийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж дэмжинэ.

14.Спортыг клубийн системээр хөгжүүлж байгаа арга хэлбэрийг туушталн дэмжиж, энэ талаархи хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.

15.Уралдаан тэмцээний ангилал тогтоож мөрдүүлэх замаар уралдаан тэмцээн зохион байгуулж буй хүрэмд өөрчлөлт оруулна.

16.Олимп, дэлхий, тивийн наадам, олон улсын тэмцээнд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах үндэсний нормативыг олон жилийн уламжлал, тив, дэлхийн тэмцээнд үзүүлж байгаа амжилтын түвшинтэй харьцуулан боловсруулж мөрдөнө.

17.Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг спортын материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглүүлж, хөдөө орон нутагт биеийн тамирын заал, талбай, эрүүл мэнд-чийрэгжүүлэлтийн танхим барих ажлын эхлэлийг тавина.

II.Тамирчдыг хөгжүүлэх, амжилтыг ахиулах үйл ажиллагаат бүх талаар дэмжинэ.

18.Биеийн тамир,спортын гүнзгийрүүлсэн буюу төрөлжүүлсэн сургалттай сургууль болон анги бүлэг хичээллүүлэх замаар тамирчдын залуу халааг бэлтгэх сургалтын тасралтгүй систем бий болгох асуудлыг холбогдох яамтай хамтран шийдвэрлэнэ.

19.Спортын холбоод, тамирчид, дасгалжуулагч нарын үйл ажиллагааны рейтинг тогтоох системийг бий болгон тэдний ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

20.Спорт, биеийн тамирын дасгал сургууль монгол хүний биед хэрхэн нөлөөлж буйг шинжлэх ухааны үндэстэй судалж дүгнэлт өгөх, улмаар тамирчдын спортын амжилтыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт дасгалжуулалт, спортын сэтгэл зүй, эмнэлэг биологи, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлж, түүний материаллаг баазыг бэхжүүлнэ.

21.Дасгалжуулагч, биеийн тамирын багш, биеийн тамир- чийрэгжүүлэлтийн арга зүйч зэрэг мэргэжлээр боловсон хүчин бэлтгэх, эдгээр мэргэжлээр дипломын дараахь сургалтын системийг бий болгох арга хэмжээ авна.

Гурав.Биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох талаар

I.Биеийн тамир, спортын байгууллагын тогтолцоог сайжруулна.

22.Биеийн тамир, спортын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төв байгууллагаар дамжуулан Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар Засгийн газраас баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн хамтын ажиллагааг өргүүлэх замаар бодлогын биелэлтийг хангуулна.

23. Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төв байгууллагын зүгээс спортын холбоод, клубүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, хувийн хэвшлийн биеийн тамир-чийрэгжүүлэлтийн төвүүд, спортын клубүүдийг бий болгон хөгжүүлэхэд түлхүү анхаарч нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

24.Олон улсын биеийн тамир, спортын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг бүх талаар өргежүүлнэ.

II.Биеийн тамир, спортыг хөгжүүлэхэд зарцуулж байгаа хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлнэ.

25.Төсвийн хөрөнгийн зарцуулалтыг оновчтой зохион байгуулж, үр өгөөжийг дээшлүүлэх, биеийн тамир, спортыг хүн амын хэрэгцээ, сонирхол болон орчин үеийн сургалт, дасгалжуулалтын шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бий болгохыг чухалчилна.

26.Хүн амыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд биеийн тамир, спортыг чухал хэрэглүүр болгоход анхаарч, биеийн тамир, спортын арга хэмжээнд төсвөөс зарцуулах хөрөнгийн хэмжээг жил бүр нэмэгдүүлэх чиглэл баримталж оновчтой зарцуулна.

27.Биеийн тамир, спортын байгууллагуудын материаллаг баазыг цаашид зориулалтын дагуу ашиглах нөхцөлөөр хувьчлах арга хэмжээ авна.

28.Ивээн тэтгэгч байгууллагуудыг сурталчлах ажлыг өргөжүүлж, тэдний үйл ажиллагааны үр дүнг харгалзан урамшуулдаг механизмтай болох улмаар биеийн тамир, спортыг ивээн тэтгэгч байгууллагын эгнээг өргөжүүлэх, байнгын ивээн тэтгэгчдийг бий болгох замаар "Биеийн тамир, спортын хөгжлийг дэмжих сан" ажиллуулна.

29.ҮЭ-ийн байгууллагуудтай хамтран ажиллагсдын дунд биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тэдний чөлөөт цаг, ажиллах чадварыг дээшлүүлэхэд шаардагдах хөрөнгийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хамтын гэрээнд тусгуулан хэрэгжүүлэх арга хэлбэрийг нэвтрүүлнэ.

30.Биеийн тамир, спортын хувцас, хэрэглэлийн үйлдвэрлэл, хангамж эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад арга зүй, мэргэжлийн болон санхүүгийн туслалцаа дэмжлэг үзүүлнэ.

31.Өөрийн улсад дэлхий, тив, олон улсын биеийн тамир, спортын томоохон арга хэмжээг гадаад, дотоодын биеийн тамир, спортын байгууллагуудтай хамтран зохион байгуулах зэргээр хөрөнгийн эх үүсвэр бий болгоход түлхүү анхаарна.

32.Дотоод,гадаадын биеийн тамир, спортын байгууллагуудын дэмжлэг, туслажаар удирдах ажилтан болон дасгалжуулагч, шүүгчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж, гадаад орнуудад боловсон хүчин сургаж, бэлтгэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он № 42 (121)

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар А/95** **Улаанбаатар хот**

Комисс , тусгай зөвшөөрөл олгох журам батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн хуулийн 12, 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1.Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Комиссын дүрмийг хоёрдугаар, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох журмыг гуравдугаар, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загварыг дөрөвдүгээр, Эм ханган нийлүүлэх байгууллагад олгох зөвшөөрлийн гэрчилгээний загварыг тавдугаар хавсралтын ёсоор тус тус батлсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А. Зангад/-д үүрэг болгосугай.

3.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ хэвлүүлэх зардлыг яамны төсвөөс гаргахыг Засгийн газрын VIII байрын захиргааны дарга /Д. Төмөрбаатар/-д даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1996 оны А/303 тоот тушаалыг хүчингүй болгосугай.

САЙД **С. СОНИН**

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1999 оны А/95 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

А. Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны комисс:

Комиссын дарга:	-ЭМНХЯ-ны Мэдээлэл хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга
Нарийн бичгийн дарга:	-ЭМНХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын уламжлалт болон хувийн эмнэлэг хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	-ЭМНХЯ-ны Стратегийн удирдлага төлөвлөлтийн газрын эрүүл мэндийн багийн ахлагч -Эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын албаны дарга -Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төвийн дэд захирал -Эрүүл ахуй,халдвар судлалын хяналтын албаны дарга

Б. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга:	-Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн Дарга:	-Нийслэлийн эрүүл мэндийн газрын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	-Нийслэлийн ЭАХСХ газрын дарга -Эм, биобэлдмэлийн чанарын хяналтын албаны орлогч дарга -Нийслэлийн эрүүл мэндийн газрын эм, биобэлдмэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагч -Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн

В. Аймгийн Засаг даргын Тамгын газрын комиссын бүрэлдэхүүн:

Комиссын дарга	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн Бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн	-Аймгийн Нийгмийн эрүүл Мэндийн төвийн статистикч эмч

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он № 42 (121)

Гишүүд: -Аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн захирал
-Аймгийн эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч
-Аймгийн Эм, биобэлдмэлийн чанарын хяналтын улсын байцаагч
-Аймгийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын улсын байцаагч

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1999 оны А/95 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ КОМИССЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комисс /цаашид"комисс"гэнэ/ нь зориулалтын барилга байгууламж, техник хэрэгсэл, мэргэжлийн боловсон хүчин бүхий өмчийн аль ч хэлбэрийн байгууллагад эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл /цаашид "зөвшөөрөл" гэнэ/ олгох асуудлыг хянан шийдвэрлэх үүрэгтэй ажиллана.

2.Комисс 6 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд шаардлагатай гэж үзвэл 3 хүртэл хүнийг хэлэлцэх асуудлын хүрээнд нэмэн оролцуулж болно.

3.Комисс нь Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын энэхүү тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг мөрдлөгө болгон ажиллана.

4.Хурлыг комиссын дарга, түүний эзгүйд нарийн бичгийн дарга зохион байгуулна.

5.Комиссын хурлыг сард нэгээс доошгүй хийх бөгөөд хуралд хэлэлцэх асуудлын материалыг нарийн бичгийн дарга хүлээн авна. Хурлын болон шийдвэрлэсэн тухай тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж комиссын даргаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

6.Комисс шийдвэрлэх боломжтой гэж үзсэн материалыг сайдын зөвлөлд танилцуулж, сайдын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийг олгоно.

Хоёр. Комиссын бүрэн эрх

А/ Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны комисс:

1.Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагад зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох;

2.Нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын комиссын үйл ажиллагаатай холбогдсон маргаантай асуудлыг хянан шийдвэрлэх;

3.Нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын комиссоос тайлан мэдээ, бусад холбогдох судалгаат шаардлагатай гаргуулах;

4.Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох нийслэл, аймгийн комиссын үйл ажиллагаанд хяналт тавих.

5.Гадаад улстай тусгай гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллах эрүүл мэндийн байгууллагын асуудлыг шийдвэрлэх.

6.Эрүүл мэндийн байгууллагуудын талаар ирсэн мэдээлэл, өргөдөл, гомдлыг холбогдох хяналтын албадаар шалгуулах.

Б/ Нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын комисс:

1.Тухайн дэвсгэр, нутгийн түвшинд ажиллах эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох.

2.Орон нутгийн түвшинд шийдвэрлэх боломжгүй асуудлыг Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны комисст шилжүүлэх.

3.Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны комисст оруулж шийдвэрлүүлэхээс бусад орон нутагт мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэхийг хүссэн байгууллага, иргэдийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.

4.Үйл ажиллагааныхаа тайлан мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яаманд ирүүлэх.

5.Нийслэл, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын үйлдвэрлэл, эмчилгээ, үйлчилгээтэй холбогдсон хөдөлмөрчдийн санал, гомдлыг хүлээн авч барагдуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны А/95 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Энэхүү журмыг өмчийн аль ч хэлбэрийн байгуулагад эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл /цаашид "зөвшөөрөл" гэнэ/ олгохоД дагаж мөрдөнө.

2.Эрүүл мэндийн байгууллага нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны болон нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх комиссоос мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлснээр үйлдвэрлэл эрхэлж, эмчлэх, сувилах, оношлох, эм барих, урьдчилан сэргийлэх тусламж, үйлчилгээ эрхлэн явуулах эрхтэй болно.

3.Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны болон нийслэл, аймгийн Засаг даргын Тамгын газрын комиссын зөвшөөрөлгүйгээр эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, олгосон зөвшөөрлийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

4.Тухайн эмнэлгийн удирдлага, үйл ажиллагаа, явуулах чиглэл өөрчлөгдөх тохиолдол бүрт зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт хийлгэнэ.

5.Эрүүл мэндийн байгууллага нь эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авааруй мэргэжилтнүүдийг ажилд авахыг хориглоно.

Хоёр. Зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

1.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулахыг хүссэн байгуулагa, хүмүүс нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам болон нийслэл, аймгийн эрүүл мэндийн байгуулагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комисст Эрүүл мэндийн хуулийн 12 дугаар зүйлийн 3-т заасан баримт бичиг, 19 дүгээр зүйлд заасан байгуулагын дүрэм зэргийг бүрдүүлж ирүүлнэ.

2.Эмчилгээ үйлчилгээ явуулах барилга байгууламжийн эрүүл ахуйн шаардлага, оношлогоо эмчилгээний болон холбогдох тоног төхөөрөмж, түүний аюулгүй ажиллагааны баталгааг мэргэжлийн хяналтын албаар гаргуулсан байна.

3.Комисс нь өргөдөл, холбогдох материалыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

4.Зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг тухайн байгуулагa эс зөвшөөрвөл гомдлоо Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, шүүхэд гаргаж болно.

5.Комисс нь тухайн байгуулагад өгсөн зөвшөөрлөө тусгай гэрчилгээ олгож баталгаажуулна. Гэрчилгээ авахаас өмнө байгуулага нь Монгол улсын төмдэгтийн хураамжийн хуулийн заалтын дагуу зохих хураамж төлнө.

6.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах байгуулагад ажиллах мэргэжилтнүүд эрүүл мэндийн магадлан итгэмжлэх байгуулагаас эмчлэх, сувилах, эм барих мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байхаа зохино.

7.Эрүүл мэндийн байгуулагууд гадаадын иргэдтэй хамтран ажиллах хүсэлт гаргавал Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 9-т заасны дагуу шийдвэрлэгдэнэ.

Гурав. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах байгуулагад тавих шаардлага

1.Эм хангамжийн байгуулага нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1998 оны А/181, А/269, А/281 дүгээр тушаалаар батлагдсан шаардлагыг биелүүлсэн байна.

2.Эрүүл мэндийн байгуулагад ажиллах шүдний техникч, багз эмч, эм найруулагч, сувилагч, уламжлалт анагаах ухааны дунд мэргэжлийн дипломын боловсролтой мэргэжилтнүүд нь заавал тухайн чиглэлийн их эмч, эм зүйч нарын хяналтын дор ажилана.

3.Нарийн мэргэжлийн чиглэлээр ажиллах амбулатори нь тухайн мэргэжлийн онцлогоос шалтгаалан тавигдах эрүүл ахуйн шаадлагыг биелүүлсэн байна.

4.Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрүүл мэндийн байгуулагa нь эм, биобэлдмэл эмчилгээний чанарын хяналтын албаны санал дүгнэлтийг гаргуулсан байна.

5.Эрүүл мэндийн байгуулагад эмнэлгийн тусламж үйлчилгээ явуулах технологи, стандартын шаардлагын дагуу зөвшөөрөл олгоно.

6.Эрүүл мэндийн байгуулагууд зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа дараахь материалыг бүрдүүлнэ.

а/ өргөдөл буюу үүсгэн байгуулагчдын шийдвэр;

б/ байгуулагын дүрэм;

в/ эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүн, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл;

г/ тоног төхөөрөмжийн жагсаалт;

д/эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны дүгнэлт;

е/ ЭББЭЧХА-ны дүгнэлт;

ё/ санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа;

ж/ хамтын ажиллагааны гэрээ /гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгуулага/

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын
сайдын 1999 оны А/95 дугаар
тушаалын тавдугаар хавсралт

ЭМ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ

6 x 4

___ Он ___ сар ___ өдөр дугаар____

Байгууллагын нэр _____

Эрхлэгчийн нэр _____

Эрхлэх ажил _____

_____

Мэдээ үзсэн эмэн тухай хуудсыг бөглөн
гүйцэтгэсэн чадварлаг эмчийн
_____ /эрхлэгчийн гарын үсэг/

___оны	___-р сарын	___ өдөр	хүртэл сунгав	Гарын үсэг	_____
___оны	___-р сарын	___ өдөр	хүртэл сунгав	Гарын үсэг	_____
___оны	___-р сарын	___ өдөр	хүртэл сунгав	Гарын үсэг	_____
___оны	___-р сарын	___ өдөр	хүртэл сунгав	Гарын үсэг	_____
___оны	___-р сарын	___ өдөр	хүртэл сунгав	Гарын үсэг	_____

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын
сайдын 1999 оны А/95 дугаар
тушаалын дөрөвдүгээр хавсралт

МОНГОЛ УЛС
(Mongolia)

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яам
(Ministry of Health and Social Welfare)

6 x 4

___ Он ___ сар ___ өдөр
(Date) (Month) (Day)

Байгууллагын нэр _____
(Name of Organization)

Захирал, эрхлэгчийн нэр _____
(Name of Director or Head)

Эрхлэх ажил _____
(Duties and responsibilities)

_____

Тусгай тэмдэглэл: Энэхүү үзлэгийн хугацаанд зөвхөн
үйлдэхийг зөвшөөрсөн газарт.

Remarks: The medical service is to be carried out only on the defined locality

___оны (Year)	___р сарын (month)	___ өдөр (day)	хүртэл (till)	сунгав (extended)	Гарын үсэг (Signature) _____
___оны (Year)	___р сарын (month)	___ өдөр (day)	хүртэл (till)	сунгав (extended)	Гарын үсэг (Signature) _____
___оны (Year)	___р сарын (month)	___ өдөр (day)	хүртэл (till)	сунгав (extended)	Гарын үсэг (Signature) _____
___оны (Year)	___р сарын (month)	___ өдөр (day)	хүртэл (till)	сунгав (extended)	Гарын үсэг (Signature) _____
___оны (Year)	___р сарын (month)	___ өдөр (day)	хүртэл (till)	сунгав (extended)	Гарын үсэг (Signature) _____

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгийнийн эрхлэл

Улаанбаатар-12
Төрийн ордон

Утас 329612
Факс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ ж, ахуйг
эрхлэх газрын харьяа хэлтэс
үйлдвэрт хэвлэв

Утас 327806,
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны есдүгээр сарын 22 №43 (122)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

390. Нафис Садикийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 146 805
391. Гадаадын зарим иргэдийг одон, медалиар шагнах тухай Дугаар 147 806
392. Зарим багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 148 806
393. Зарим багш нарыг одон, медалиар шагнах тухай Дугаар 149 807

Хоёр. Яам, агентлагийн акт

394. Журам батлах тухай (Монгол Улсын Байгаль орчны сайдын тушаал) Дугаар 77 808
395. Журам, жагсаалт, ангилал батлах тухай (Монгол Улсын Байгаль орчны сайд, Хөдөө аж ахуй, Үйлдвэрийн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын хамтарсан тушаал) Дугаар 86/А/86/А/164 809

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 146 Улаанбаатар хот

Нафис Садикийг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улсад эх нялхсын эрүүл мэндийг эрхэмлэн Нафис Садикийг "Алтан гадас" хамгаалах, хүн ам зүйн боловсон хүчин одонгоор шагнасугай.

Бэлтгэх, үндэсний статистикийн албыг бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж НҮБ-ын Хүн амын сангийн гүйцэтгэх

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 147 **Улаанбаатар хот**

Гадаадын зарим иргэдийг одон, медалиар шагнах тухай

Халх голын байлдаанд биечлэн оролцож, Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үйл хэрэгт оруулсан гавьяаг нь үнэлж дор дурдсан гадаадын зарим иргэдийг одон, медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Тихон Григорьевич Буряк - Оросын Холбооны Улс
2. Антон Дмитриевич Якименко - Оросын Холбооны Улс
3. Прокофий Николаевич Редкозубов - Украйн Улс
4. Жүгдэрийн Өлзийхутаг - Украйн Улс
5. Гавриил Спиридонович Бояр – Украйн Улс
6. Сергей Афанасьевич Булавко - Казакстан Улс

НАЙРАМДАЛ МЕДАЛИАР:

1. Иван Михайлович Карпенко - Оросын Холбооны Улс
2. Георгий Фомич Приймук – Оросын Холбооны Улс
3. Иван Романович Чухно - Оросын Холбооны Улс
4. Михаил Петрович Волыйкин - Оросын Холбооны Улс
5. Алексей Ионович Сидельников - Оросын Холбооны Улс
6. Павел Алексеевич Мельников - Оросын Холбооны Улс
7. Иван Николаевич Вахрамеев - Оросын Холбооны Улс
8. Иван Иванович Котов - Оросын Холбооны Улс
9. Павел Григорьевич Соловьёв - Оросын Холбооны Улс
10. Михайл Иванович Чесноков - Оросын Холбооны Улс
11. Евгений Степанович Мезин - Оросын Холбооны Улс
12. Александр Васильевич Горицкий - Оросын Холбооны Улс
13. Григорий Дмитриевич Козловцев - Оросын Холбооны Улс
14. Билла Усманович Бакиров - Оросын Холбооны Улс
15. Иван Васильевич Афанасенко - Украйн Улс
16. Семен Филиппович Волик - Украйн Улс
17. Михаил Дмитриевич Давыдов - Украйн Улс
18. Георгий Демьянович Останин - Украйн Улс
19. Александра Михайловна Беломестных - Украйн Улс
20. Иван Алексеевич Митряев - Украйн Улс

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 31-ний өдөр Дугаар 148 **Улаанбаатар хот**

Зарим багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, өсвөр, залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн дор дурдсан багш нарт Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

1. Дагдангийн Батчулуун - МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн гадаад хэлний тэнхмийн эрхлэгч
2. Цогтын Лантуу - Нийслэлийн 29 дүгээр сургуулийн багш
1. Раашийн Маабазар - Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх боловсрол, соёлын төвийн захирал
2. Нацагдоржийн Түмэн-Өлзий - Говьсүмбэр аймгийн 10 жилийн 1 дүгээр сургуулийн монгол хэл-уран зохиолын багш
3. Дамбын Шагдар - УБИС-ийн математик сургалтын технологийн тэнхмийн эрхлэгч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 8 дугаар сарын 31-ний өдөр Дугаар 149 **Улаанбаатар хот**

Зарим багш нарыг одон, медалиар шагнах тухай

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа их, дээд ерөнхий боловсролын сургууль, лицей, цэцэрлэгийн дор дурдсан багш, сурган хүмүүжүүлэгчдийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1.Дамбийн Бүрэнхишиг - Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын дунд сургуулийн химибиологийн багш

2.Пүрэвийн Ганхуяг - Нийслэлийн Баянгол дүүргийн "Оюуны ундраа" цогцолбор сургуулийн захирал

3.Ишийн Дашням - МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн багш

4.Сүхрагчаагийн Нямзагд - Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш

5.Самбын Өвөө - Нөлайх дахь техникийн лицейн багш

6.Чүлтэмийн Самдан - Дорно дахины гүн ухааны дээд сургуулийн монгол бичгийн багш

7.Нанзадын Цэнд - Нийслэлийн "Цэцээ гүн" менежментийн сургуулийн захирал

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1.Бэгзийн Амирд - Завхан аймгийн ахмад багш

2.Дамдингийн Баатар - Нийслэлийн 10 жилийн 5 дугаар дунд сургуулийн аж ахуйн эрхлэгч

3.Норовын Бадамжав - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 10 жилийн "Ирээдүй-2" цогцолбор сургуулийн бага ангийн багш

4.Мөнхийн Балдорж - Ахмад багш

5.Дамдингийн Бямбаа - Завхан аймгийн Улиастай сумын 10 жилийн 2 дугаар сургуулийн биеийн тамирын багш

6.Зундүйн Галхүү - Говь-Алтай аймгийн Бугат сумын дунд сургуулийн захирал

7.Хасбатын Дабааньм- Нийслэлийн 10 жилийн 5 дугаар дунд сургуулийн химийн багш

8.Чимидийн Дагшигдорж - Техникийн их сургуулийн Барилгын инженерийн сургуулийн архитектурын тэнхимийн эрхлэгч

9.Гүнчингийн Дашган - Нийслэлийн 10 жилийн 24 дүгээр сургуулийн захирал

10.Чадраабалын Дашзэвэг - МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн газар зүйн тэнхимийн эрхлэгч

11.Пүрэвжавын Доржсүрэн - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 10 жилийн 3 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

12.Банзрагчийн Намсрай - Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 10 жилийн "Ирээдүй-2" цогцолбор сургуулийн захирал

13.Нэрэндоогийн Нэргүй - Гэгээрлийн яамны стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

14.Батаагийн Нямаа- Техникийн их сургуулийн Барилгын инженерийн сургуулийн багш

15.Рэнцэнгийн Пүрэв - Нийслэлийн Баянзүрх дүүргийн ахмад багш

16.Магсарын Рэнчин-Очир - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын дунд сургуулийн захирал

17.Төмөрчөдөрийн Төрбат - Хүмүүнлэгийн ухааны сургуулийн дэд захирал

18.Норовын Уртнасан - Гэгээрлийн яамны хамтын ажиллагааны хэлтсийн дарга

19.Гүнчингийн Цолмон-Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын дунд сургуулийн захирал

20.Бадамын Цэрэнжав - МУИС-ийн Ховд аймаг дахь салбар сургуулийн математикийн тэнхимийн багш

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Бандийн Адъяа - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн монгол хэл-уран зохиолын багш

2.Тогтохын Баасандулам - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн математикийн багш

3.Лувсангийн Буянт - Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн цогцолбор сургуулийн физикийн багш

4.Сангийн Дагдан - Нийслэлийн Багаханган дүүргийн 8 жилийн 94 дүгээр сургуулийн захирал

5.Гомбосүрэнгийн Ичинноров - Хүмүүнлэгийн ухааны сургуулийн орос хэл-уран зохиолын тэнхимийн багш

6.Цэндийн Лхагвасүрэн - Нийслэлийн Налайх дүүргийн 10 жилийн "Голомт" цогцолбор сургуулийн түүх-газар зүйн багш

7.Жамъяншаравын Лхагвасүрэн - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 10 жилийн 1 дүгээр дунд сургуулийн багш

8.Дэмбэрэлийн Наранцэцэг - Архангай аймгийн Ихтамир сумын дунд сургуулийн бага ангийн багш

9.Дэмбэрэлийн Норовсамбуу - Сэлэнгэ аймгийн Сант сумын дунд сургуулийн бага ангийн багш

10.Дагваүүгийн Нямсүрэн - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын дунд сургуулийн багш

11.Довчингийн Сумъяа - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

12.Даржаагийн Цэрэнжамц - Нийслэлийн 10 жилийн 5 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

13.Бадарчийн Цэвсүрэн - Орхон аймгийн 10 жилийн 1 дүгээр сургуулийн физикийн багш

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он № 43 (122)
МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ
1999 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 77 Улаанбаатар хот

Журам батлах тухай

ТУШААХ нь:

1.Байгаль орчны холбогдолтой хэрэг зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авах, мэдээлэгчийг урамшуулах журмыг хавсралтын ёсоор батална.

2.Энэхүү журмыг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын ерөнхий байцаагч, Аймаг, нийслэлийн байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч, Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаадын дарга нарт тус тус даалгасугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан "Мэдээлэгчийг урамшуулах журам батлах тухай" Байгаль орчны хяналтын улсын хороо /хуучин нэрээр/-ны даргын 1992 оны А/38 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.МЭНДСАЙХАН

Байгаль орчны сайдын 1999 оны 77 дугаар тушаалын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОЛБОГДОЛТОЙ ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ, МЭДЭЭЛЭГЧИЙГ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг зөрчсөн аливаа үйлдлийг шуурхай илрүүлэн богино хугацаанд арилгахад болон цаашид зөрчил гаргуулахгүй байхад иргэдийн оролцоо, идэвхтэй үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих үүднээс иргэдийн мэдээллийг хүлээн авах, барагдуулах, зөрчлийн талаар үнэн зөв мэдээлэл өгсөн, уг зөрчлийг илрүүлсэн иргэн /цаашид "мэдээлэгч" гэх/-д урамшуулал олгоход энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Мэдээллийг хүлээж авах

2. Мэдээллийг БОЯ, БОХА, Байгаль орчны хяналтын улсын ерөнхий байцаагч, аймгийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын албад, нийслэлийн БОХГ, Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаад, аймаг, нийслэл, сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийн нэр дээр ирүүлнэ.

3. Мэдээллийг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн бус байгууллагад ирүүлж болно. Ирүүлсэн мэдээллийг хүлээн авсан төрийн бус байгууллага нь энэ журмын "Хоёрын 2"-д заасан байгууллага, албан тушаалтанд шилжүүлж шийдвэрлүүлнэ.

4. Мэдээлэлд мэдээлэгч, зөрчил илрүүлэгч, зөрчлийг үйлдэхэд байлцсан гэрчийн эгтээд, зөрчил гаргагч нарын овог нэр, хаяг, ажлын газар, эрхэлдэг ажил, утасны дугаар, тэдэнтэй холбоо барих арга зам, зөрчил гаргагч нь тээврийн хэрэгсэл ашигласан бол түүний марк, дугаар, өнгө, түүнчлэн зөрчлийн хэлбэр, түүнээс учирсан хохирол, хууль бус үйлдэлдээ ашигласан багаж хэрэгсэл зэргийг тодорхой тусгасан байвал зохино.

5.Монгол улсын болон гадаад улсын иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, аль ч улсын иргэн биш харьяалалгүй хүмүүс энэхүү журмын дагуу мэдээлэл өгч болно.

6. Аливаа мэдээлэл нь ам дамжсан яриа, сургаар сонссон буюу тодорхой иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр хүндийг гутаха зорилготой, хувийн өш хонзонгийн чанартай худал ташаа байж болохгүй.

7.Иргэдийн мэдээлэл болон мэдээлэгчийн нэр, хаягийг чандлан нууцална.

Гурав. Мэдээллийг хянан шийдвэрлэх

8.Иргэдийн мэдээллийг энэ журмын "Хоёрын 2"-т заасан байгууллагын удирдлага байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчид шилжүүлэн шуурхай шалгуулж барагдуулах арга хэмжээ авна.

9.Мэдээлэлд дурдсан зөрчлийг уг мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн хугацаанд багтаан шалгаж байгаль орчны бүх шатны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хэмжээнд

шийдвэрлэсэн бол уг зөрчлийг барагдуулсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан мэдээлэгчид хариу өгнө. Тухайн зөрчлийг хууль хяналтын байгууллагаар шалгуулах шаардлагатай бол энэ талаар мэдээлэгчид мэдэгдэх ба уг зөрчил эцэслэн шийдвэрлэгдсэний дараа мэдээлэгчид эцсийн хариу өгнө.

10.Мэдээлэгч болон зөрчил гаргагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны хяналтын бүх шатны улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шийдвэрийг зөвшөөрөхгүй бол гомдлоо тэдний удирдлага, улмаар шүүхэд гаргаж болно.

11.Мэдээлэлд дурдсан зүйл нь тодорхойгүй буюу бүрэн ташаа болох нь тогтоогдсон бол түүнээс үүдэн гарах гэм бурууг тухайн мэдээлэгч хариуцна.

Дөрөв. Мэдээлэгчийг урамшуулах

12. Аливаа зөрчлийг илрүүлсэн буюу ноцтой зөрчлийн талаар цаг үеэ олсон, үнэн зөв, тодорхой мэдээлэл ирүүлсэн иргэнд тухайн зөрчлийн хэлбэр, шинж байдал, үр дагавар, учирсан хохирол зэргийг харгалзан мөнгөн урамшуулал олгоно.

13. Мэдээлэлд дурдсан зөрчил дутагдал нь хөдөлшгүй баримтаар нотлогдож эцэслэн шийдвэрлэгдсэн тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, төлбөрийн орлого нь зохих дансанд төлөгдсөний дараа уг торгууль, төлбөрийн орлогын 15 хувиар тооцож мөнгөн урамшууллыг мэдээлэгчид олгоно.

14. Энэ журамд дурьдсан урамшуулал нь байгаль орчны хяналтын орон тооны бүх шатны байцаагч, байгаль хамгаалагчдад хамаарахгүй.

15.Энэ журамд заасан урамшууллыг Ан агнуурын тухай хуулийн 28 дугаар зүйлд дурдсан урамшуулалтай давхардуулан олгохгүй.

16.Мэдээлэгчийг урамшуулахад шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс гаргана:

16/1. Засгийн газрын 1996 оны 54 дүгээр тогтоолыг үндэслэн "Нийтлэг журам батлах тухай" Сангийн сайдын мөн оны 175 дугаар тушаалаар батлагдсан журамд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааны орлогын хувь;

16/2. Байгаль хамгаалах сангаас энэ арга хэмжээнд зориулан гаргасан хөрөнгө;

16/3. Ан агнуурын хуулийн 28 дугаар зүйлд заасан зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын 15 хувь;

16/4. Мэдээлэгчийг урамшуулахад зориулан тухайн байгууллагын төсөвтөө тусгасан хөрөнгө болон бусад нэмэгдэл эх үүсвэрээр олсон хөрөнгө.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Дугаар 86/А/86/А/164 **Улаанбаатар хот**

Журам, жагсаалт, ангилал батлах тухай

Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5 дугаар заалт, Байгалийн үргамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дүгээр заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 4 дүгээр заалт болон 6 дугаар зүйлийн 1 дүгээр хэсгийн 3 дахь заалт, 8 дугаар зүйлийн 6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. "Монгол Улсад үргамал хамгаалах бодис турших, бүртгэх, устгах журам"-ыг 1 дүгээр, "Монгол Улсад 1999-2000 онд хэрэглэх үргамал хамгаалах бодисын жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2.Энэхүү тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын ерөнхий байцаагч Ц.Дамдин, ХАА-н улсын хяналтын албаны Ургамал хамгаалал, хорио цээрийн улсын ерөнхий байцаагч Ж.Цэрмаа, Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны улсын ерөнхий байцаагч Н.Сайжаа нарт даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД С.МЭНДСАЙХАН

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД Ч.СОДНОМЦЭРЭН

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С. СОНИН

Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын 1999 оны 86/А/86/А/164 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСАД УРГАМАЛ ХАМГААЛАХ БОДИСЫГ ТУРШИХ, БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол улсын нутаг дэвсгэрт ургамал хамгаалах бодисыг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хэрэглэх, үйлдвэрлэлээс хасах, шаардлага хангахгүй бодисыг устгах асуудлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтан, тариалангийн талбайн хог ургамалтай тэмцэхэд хэрэглэгддэг химийн болон биологийн бэлдмэлүүдийг "Ургамал хамгаалах бодис" гэнэ.

1.3. Хөдөө аж ахуйд хэрэглэх ургамал хамгаалах бодисын зохистой хугацаа, тунг нарийвчлан тогтоохыг "Ургамал хамгаалах бодисыг турших" гэнэ.

1.4.ХААУХАлба эрүүл ахуйн болон байгаль орчны хяналтын Албадтай хамтран аливаа бодисын үйлчлэл, чанарын туршилт явуулж, гаргасан дүгнэлтийг үндэслэн тухайн бодисыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд хэрэглэх зөвшөөрөл олгохыг "Ургамал хамгаалах бодисыг улсын бүртгэлд бүртгэх" гэнэ.

1.5.Ургамал хамгаалах бодисын жагсаалтаас хасагдсан, технологийн болон хадгалалтын буруугаас ашиглалтын шаардлага хангахгүй болсон бодисыг хэрэглээнээс хасч, зохих журмын дагуу зайлуулахыг "Ургамал хамгаалах бодисыг устгах" гэнэ.

1.6.Улсын бүртгэлд орсон ургамал хамгаалах бодисын жагсаалтыг Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагаат зохицуулах үндэсний зөвлөл /цаашид Зөвлөл гэх/-ийн дүгнэлтийг үндэслэн Байгаль орчны Сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын Сайд, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн Сайдын хамтарсан тушаалаар жил бүр шинэчлэн батална.

Хоёр. Ургамал хамгаалах бодис туршихад тавих шаардлага

2.1. Шинээр хэрэглэх бодисын туршилт явуулах арга, хугацаа, нөхцөлийг Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба тогтооно.

2.2. Ургамал хамгаалах бодисыг турших ажлыг ургамал хамгаалал хорио цээрийн улсын байцаагчийн хяналтын дор эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ.

2.3. Ургамал хамгаалах бодисын туршилтын ажлын явцын болон үр дүнгийн дэлгэрэнгүй тайланг туршигч аж ахуйн нэгж, байгууллага нь туршилт явуулж эхэлснээс хойш нэгээс зургаан сарын дотор Хөдөө аж ахуйн улсын хяналтын албанд өгч байна.

2.4.Ургамал хамгаалах бодисыг туршигч аж ахуйн нэгж, байгууллага нь бодисыг хэрэглэх зохистой хугацаа, тун хэмжээг хээрийн болон лабораторийн туршлагад үндэслэн тогтооно.

2.5.Ургамал хамгаалах бодисыг турших явцад ус, хөрс, таримал бэлэн бүтээгдхүүнд байх үлдэгдэл бодисын хэмжээг Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба тогтоож, дүгнэлт гаргана. /Маягт №3. Ургамал хамгаалах бодисын талаархи эрүүл ахуйн дүгнэлт./

Гурав. Ургамал хамгаалах бодисыг улсын бүртгэлд бүртгэхэд тавих шаардлага

3.1. Ургамал хамгаалах бодисыг дараах нөхцөлийг хангасан тохиолдолд улсын бүртгэлд бүртгэнэ:

- тухайн бодис нь олон улсын ургамал хамгаалалд хэрэглэх бодисуудын жагсаалт болон ангилалд орсон байх,
- тухайн бэлдмэлийн үйлчлэх бодис, найрлага нарийвчлан тогтоогдсон байх,
- бэлдмэлийг хэрэглэх тунгийн хязгаар, сөрөг нөлөө, үйлчлэлийн чанар нь лабораторийн болон талбайн сорилтоор нотлогдсон байх,
- бодисыг үйлдвэрлэх нөхцөл нь олон улсын үйлдвэрлэлийн практикт тавигддаг эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх,
- импортоор авах бодис нь олон улсын хэрэглээнд зөвшөөрөгдсөн, үйлдвэрлэгч улсад бүртгэгдэж хоёроос доошгүй удаа хөдөө аж ахуйд туршигдсан буюу хэрэглэгдсэн байх,

3.2. Монгол улсад хэрэглэх бодисын жагсаалтад болон ангилалд орсон ургамал хамгаалах бодисыг импортлоход Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Хөдөө аж ахуйн улсын хяналтын албанаас урьдчилан зөвшөөрөл авсан байна. /Маягт №1. Ургамал хамгаалах бодис импортлох зөвшөөрөл./

Дөрөв. Ургамал хамгаалах бодисыг улсын бүртгэлд бүртгэх

4.1. Энэхүү журмын 2 болон 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан ургамал хамгаалах бодисыг Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба, Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн, улсын бүртгэлд бүртгэнэ.

4.2. Ургамал хамгаалах бодисын жагсаалтад шинээр оруулах бодисын талаар шаардагдах материал бүрдүүлэн Зөвлөлд хэлэлцүүлж, баталгаажуулах асуудлыг Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба хариуцан гүйцэтгэнэ.

4.3. Улсын бүртгэлд бүртгэх бодисын талаар дараахь материалыг импортлогч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрдүүлж, Хөдөө аж ахуйн улсын хяналтын албанд оруулна. Үүнд:

- тухайн бодисын сорилт, туршилтын дүнгийн дэлгэрэнгүй тайлан.

- тухайн бодисыг дотоодод үйлдвэрлэсэн бол түүнийг үйлдвэрлэх технологийн заавар, улсын стандарт буюу техникийн нөхцөл.

- уг бодисын найрлага, үйлчлэх бодисын нэр, түүний бэлдмэлд эзлэх хувь, хоруу чанарын үзүүлэлтүүд.

- тухайн бодисыг хэрэглэх заавар /Монгол хэл дээр/

- ургамал хамгаалах бодисыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдөл. /Маягт №2. Улсын бүртгэлд ургамал хамгаалах бодис оруулах бүртгэл./

4.4. Гадаадаас импортлох болон дотоодод үйлдвэрлэсэн бодис хэрэглэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сорилт, туршилтад хүрэлцэхүйц хэмжээний бодисыг сорилт, туршилт явуулах байгууллагад хүргүүлнэ.

4.5. Ургамал хамгаалах бодисыг үйлдвэрлэлд хэрэглэх зааврыг Ургамал хамгаалллын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага батална.

4.6. Ургамал хамгаалах бодисыг улсын бүргэлд бүртгэхэд Улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно. /Маягт №4. Ургамал хамгаалах бодисын бүртгэлийн гэрчилгээ./

4.7. Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба нь бүртгэлийн гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

Тав. Ургамал хамгаалах бодисыг улсын бүртгэлээс хасах

5.1. Ургамал хамгаалах бодисыг Улсын бүртгэлээс хасах асуудлыг Хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны болон Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Байгаль орчны яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яам хамтран шийдвэрлэнэ.

5.2. Тухайн бодисыг улсын бүртгэлээс дор дурдсан нөхцөлд хасна. Үүнд:

- хэрэглээний явцад бодисын физик, химийн чанар, үйлчлэл нь үйлдвэрлэлийн шаардлагад нийцэхгүй болсон,

- тухайн бодис нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон,

- хүн болон халуун цуст амьтад, байгаль, ургамалд сөрөг нөлөөтэй болох нь тогтоогдсон,

- олон улсын байгууллагаас хэрэглэхийг хориглосон.

Зургаа. Ургамал хамгаалах бодисыг хэрэглээнд гаргах

6.1. Ургамал хамгаалах бодисыг улсын бүртгэлд бүртгэгдэж, гэрчилгээ олгосон өдрөөс хэрэглээнд гаргахыг зөвшөөрнө.

6.2. Ургамал хамгаалах бодисыг хэрэглээнд гаргахдаа түүнийг хэрэглэх заавар, физик, химийн шинж, үйлчлэх бодисын агууламж, хэлбэр, хоруу чанарын үзүүлэлт /УТ50/, херс, ус, бүтээгдэхүүнд байж болох үлдцийн дээд хэмжээ, хадгалах хугацаа зэргийг тодорхойлсон баримт бичгийг бүрдүүлсэн байна.

6.3. Ургамал хамгаалах бодисыг хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг Байгаль орчны Сайдын 1998 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан "Химийн хорт бодисын хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт, устгалын тухай журам"-ын дагуу гүйцэтгэнэ.

Маягт №1

Хөдөө аж ахуйн хяналтын улсын алба

УРГАМАЛ ХАМГААЛАХ БОДИС ИМПОРТЛОХ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар

Монгол Улсын ургамал хамгаалах бодисыг турших, бүртгэх журмын дагуу импортлон оруулахыг зөвшөөрөв.

Ургамал хамгаалах бодисын тодорхойлолт

Ердийн ба худалдааны нэр	Зориулалт	Үйлчлэх бодисын нэр	Хэмжээ

Зөвшөөрөл олгосон: Ургамал хамгаалал, хорио цээрийн
Улсын ерөнхий байцаагч

Хянасан: Байгаль орчны хяналтын
Улсын ерөнхий байцаагч

Эрүүл ахуй, халдвар судлалын
Улсын ерөнхий байцаагч

Маягт №2

Улсын бүртгэлд ургамал хамгаалах бодис оруулах өргөдөл

199 оны -р сарын ны өдөр

Улаанбаатар хот

---------- -ийг төлөөлж

/компани, байгууллагын нэр/

---------- би

дараахь
ургамал хамгаалах бодисыг улсын бүртгэлд оруулахыг хүсэж байна. Үүнд:

1.

2.

3.

4.

Дээрхи бодисууд нь тус орны нөхцөлд ... удаа туршигдаж, ургамал хамгаалалын арга хэмжээнд хэрэглэхэд хөдөө аж ахуй, байгаль орчин болон эрүүл ахуйн шаардлага хангасан, өндөр үйлчлэлтэй болох нь тогтоогдсон болно.

Дээрхи бодисуудын үйлчлэл, шинж чанарын талаархи мэргэжлийн байгууллагын дүгнэлт, санал, бодисуудын танилцуулгыг хавсаргав.

---------- компани/ байгууллага, аж ахуйн нэгжийн
захирал/ дарга/ -----

МАЯГТ №3

УРГАМАЛ ХАМГААЛАХ БОДИСЫН ТАЛААРХИ ЭРҮҮЛ АХУЙН ДҮГНЭЛТ

Үйлдвэрлэгч, импортлогч байгууллагын нэр ----------

Бодисын нэр /ердийн/ ----------
Худалдааны нэр ----------
Бодисын нэр, төрөл ----------
Бодисын хэлбэр ----------
Бодисын хоруу чанарын ангилал ----------
Хэмжээ ----------
Савлагаа ----------

Бодисын нэр	Он, сар, өдөр	Усанд Агуулагдсан үлдэгдэл хэмжээ /харгалзах нэгжээр/	Хөрсөнд Агуулагдсан үлдэгдэл хэмжээ /харгалзах нэгжээр/	Бүтээгдэхүүнд Агуулагдсан үлдэгдэл хэмжээ /харгалзах нэгжээр/

Эрүүл ахуйн хяналтын хоёроос доошгүй удаагийн шинжилгээгээр бодисын үлдэгдэл хэмжээ нь олон улсын болон манай улсын холбогдох стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа тул уг бодисыг Ургамал хамгаалах бодисын Улсын бүртгэлд хамруулахад Эрүүл ахуйн хяналтын албанаас татгалзах зүйлгүй болно.

ЭАХСХ-ын Албаны дарга, Улсын ерөнхий
байцаагч ----------

МАЯГТ №4

СОЁМБО

УРГАМАЛ ХАМГААЛАХ БОДИСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

CERTIFICATE FOR PESTICIDE OF PLANT PROTECTION

№----

---------- -аас ----------хүртэл хүчинтэй.
Valid from ----------

Бүртгүүлэгч /үйлдвэрлэгч/ ----------
Name of applicant /manufacture/ ----------

Дараах ургамал хамгаалах бодист бүртгэлийн гэрчилгээ олгов.
The following pesticide of plant protection is hereby granted.

The pesticide of plant protection for full Registration.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН: Ургамал хамгаалал, хорио цээрийн улсын ерөнхий байцаагч ----------
ХЯНАСАН: Химийн хорт бодисын үйл ажиллагаат Зохицуулах зөвлөлийн орлогч дарга ----------

Худалдааны нэр ----------
Trade name
Ердийн нэр ----------
Common name
Үйлчлэх бодисын агуулламж ----------
Content of active ingredient
Бодисын төрөл ----------
Type of pesticide
Бодисын хэлбэр ----------
Type of formulation
Хоруу чанарын ангилал ----------
Classification of toxicity /WHO/

ХЭРЭГЛЭХ АРГА, ХУРЭЭ

Таримал Crops	Хөнөөлт Организм Pests	Тун, кг/л/га Rate	Хэрэглэх Арга Method of application

Огноо ----------
Date

2/ Улсын Их Хурлын 1999 оны намрын чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тухай;

3/ Газрын кадастрын тухай хуулийн төсөл;

4/Цахилгааны тухай хуулийн төсөл;

5/ Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл;

6/ Иргэний бүртгэлийн тухай хуулийн төсөл;

7/ Хүнсний тухай хуулийн төсөл;

8/ Харуул хамгаалалтын тухай хуулийн төсөл;

9/ Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10/ Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

11/ Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

12/ Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/

13/ Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн төсөл;

14/ Улсын төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн төсөл;

15/ Сонгуулийн хуулийн төсөл;

16/ Улс төрийн намуудын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17/ Монгол Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18/ Эрүүгийн хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

19/ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

20/ Иргэний хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

21/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

22/ Шүүхийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

23/ Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

24/ Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

25/ Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

2. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар 1999 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсний дараа энэ захирамжаар тогтоосон дараалалд зохих нэмэлт, өөрчлөлт оруулахаар тогтоосугай.

3. Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлмэгц дараалал харгалзахгүйгээр хэлэлцэн шийдвэрлэхээр тогтоосугай.

4. Энэхүү захирамжид дурдсан асуудлуудыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангахыг Байгын хороодын дарга нарт даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр Дугаар 151 Улаанбаатар хот

Д.Амбасэлмаа, Л.Хаянхирваа нарт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын радио, телевиззэд мэргэжлийн өндөр ур чадвар гарган олон жил үр бүтээлтэй ажиллаж, нэвтрүүлгийн чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

1. Дүгэрийн Амбасэлмаа - Монголын Радио, телевизийн ахмад сэтгүүлч

2.Лувсанцэрэнгийн Хаянхирваа-Монголын радиогийн дуу, хөгжим бичлэгийн найруулагч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр Дугаар 152 **Улаанбаатар хот**

Монголын радиогийн зарим ажилтныг одон, медалиар шагнах тухай

Монголын радиод олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Зундуйн Дорж - Монголын радиогийн сурвалжлагч

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Самбуугийн Бараанасан - Монголын радиогийн Архангай аймаг дахь сурвалжлагч
2. Алт-Очирын Доржсүрэн - Монголын радиогийн хариуцлагатай редактор
3. Мятавын Цагаан - Монголын радиогийн "Нүүдэлчдийн дуу хоолой" студийн захирал

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Лодонгаваагийн Батсүх - Монголын Радиогийн боловсон хүчин
2. Лхагвасүрэнгийн Лхагвадулам - Монголын радиогийн хариуцлагатай редактор
3. Бямбажавын Хүрэлбаатар - Монголын радиогийн тоймч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сэмжидийн Батцоо - Монголын радиогийн бичээч
2. Дашдэндэвийн Сарангэрэл - Монголын радиогийн "Хөх тэнгэр" радио станцын найруулагч
3. Тувааншавын Төмөрбаатар - Монголын радиогийн техникч
4. Цогтын Эрдэнэчулуун - Монголын радиогийн ахлах редактор

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр Дугаар 153 **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

1. "Батлан хамгаалах тухай Монгол Улсын хууль"-ийн 20 дугаар зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн "Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам"-ыг хавсралтын ёсоор батлагдсугай.

2. Энэхүү журмыг 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Батлан хамгаалахын сайд /Ш.Түвдэндорж/, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга /Ц.Дашзэвэг/, Хилийн цэргийн удирдах газрын дарга /Д.Базарсад/, Дотоодын цэргийн дарга /Д.Мөрөн/ нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалах яам /Ш.Түвдэндорж/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 08-ны өдөр Дугаар 154 **Улаанбаатар хот**

Элчин сайд томилох тухай

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ирланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэдэнжавын Сүхбаатарыг тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 126 | Улаанбаатар хот

Комиссын бүрэлдэхүүнийг батлах тухай

Улсын Их хурлын 1995 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас тогтоох нь:

1."Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах улсын комиссын бүрэлдэхүүнийг 1 дугээр хавсралтын, улсын комиссын ажилтах чиг үүргийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батална.

2. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан ажиллаж, монгол бичгийн сургалтыг эрчимжүүлэхэд шаардагдах зардлыг 2000 оны төсвийн төсөлд тусгахыг Улсын комиссын дарга, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я. Очирсүхэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р. АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Я. ОЧИРСҮХ

ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ А. БАТТӨР

Засгийн газрын 1999 оны 126 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: -Сангийн сайд

Орлогч дарга: -Гэгээрлийн сайдын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:
-Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч;
-Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгч;
-Батлан хамгаалахын сайдын үүрэг гүйцэтгэгч;
-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч;
-Соёл урлагийн газрын дарга;
-Үндэсний телевизийн дарга;
-Үндэсний радиогийн дарга;
-Үндэсний архивын газрын дарга;
-"Монгол бичгийн төлөө" нийгэмлэгийн дэд тэргүүн /өөртэй нь зөвшилцсөнөөр/;
-"Үндэсний монгол бичиг сэргээх сан"-гийн ерөнхийлөгч /өөртэй нь зөвшилцсөнөөр/;
-"Боловсролыг дэмжих сан"-гийн ерөнхийлөгч /өөртэй нь зөвшилцсөнөөр/.

Нарийн бичгийн дарга: -Гэгээрлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга.

Засгийн газрын 1999 оны 126 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

1."Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийн зорилтыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах.

2.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, үндэсний хөтөлбөрт тодотгол, өөрчлөлт оруулах саналыг бэлтгэн Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх.

3.Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг Улсын Их Хуралд жил бүр мэдээлж байх.

4.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг холбогдох байгууллагын төсөвт тусгуулах арга хэмжээ авч

биелэлтэд хяналт тавих.

5.Аймаг, нийслэлд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах салбар комиссыг байгуулж ажиллуулах, арга зүйн удирдлагаар хангах.

6.Үндэсний хөтөлбөрийг радио, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчлах.

7.Иргэдийн монгол бичиг сурах идэвх, санаачилгыг өрнүүлж эдийн засгийн урамшууллын хөшүүрэг бий болгох.

8.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн захиргаа болон олон улсын байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 25-ны өдөр | **Дугаар 129** | **Улаанбаатар хот**

Үндэсний хөтөлбөр батлах тухай

Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн конвенци болон Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протоколд нэгдэн орсон Талын хүлээсэн үүргийг биелүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ НЬ:**

1."Озоны үе давхаргыг хамгаалах Үндэсний хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор батлагдсугай.

2."Озоны үе давхаргыг хамгаалах үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах, уг асуудлаар яам, салбар хооронд зохицуулалт хийх үүрэг бүхий Озоны үндэсний хороо байгуулж ажиллахыг Байгаль орчны сайдын үүрэг гүйцэтгэгч С.Мэндсайханд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **С.МЭНДСАЙХАН**

Засгийн газрын 1999 оны 129 дүгээр тогтоолын хавсралт

ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Хүн төрөлхтөн химийн олон төрлийн үйлдвэрлэлэл эрхэлж, химийн олон төрлийн бодисуудыг аж амьдралдаа хэрэглэх болсноор озон задалдаг бодисыг үлэмж хэмжээгээр ялгаруулан агаар мандал дахь озоны давхарга хомсдох, улмаар нарны хэт ягаан туяаны хор хөнөөлд дэлхийн шим мандлын амьтан, ургамал, хүн ам их хэмжээгээр нэрвэгдэх аюулд тулгараад байна.

2.Монгол улс хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг хандлага болсон тогтвортой хөгжлийн чиг баримжаагаар байгаль орчныг тэтгэх даацандаа нийцүүлэн нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх бодлого баримталж байна.

3. Озоны давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенци, Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын Протокол болон тэдгээрт оруулсан 1990 оны Лондонгийн, 1992 оны Копенгагений нэмэлтүүдэд монгол улс нэгдэн орсон тул манай улс дээрх Конвенци, Протоколын албан ёсны Тал болсон болно.

4.Монгол улс озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттай бууруулж, улмаар бүрэн хязгаарлах нь дэлхийн хүн амын эрүүл мэнд, байгаль орчны таатай нөхцөлийг хадгалан хамгаалах чухал үйл хэрэг болохыг хүлээн зөвшөөрч, түүнийг хэрэгжүүлэх олон улсын хүчин чармайлтыг бүрэн дэмжин хувь нэмрээ оруулах зорилт тавин ажиллаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, үе шат

5.Зорилго

Хөтөлбөрийн зорилго нь озоны давхаргыг задалдаг бодисын хэрэглээг үе шаттай бууруулж улмаар бүрмөсөн хязгаарлах, ашиглагдаж буй озон задалдаг бодисыг озоны давхаргыг үл задлах бодисоор орлуулахад оршино.

Үндэсний хөтөлбөр нь Венийн Конвенци,

Монреалын Протоколоор Монгол улсын хүлээсэн үүргийг биелүүлэхэд бүрэн чиглэгдэнэ.

6.Үе шат

Хөтөлбөрийг дор дурдсан үе шаттай хэрэгжүүлнэ:

а/нэг дэх үе шат: 2005 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 1997-1998 оны дундаж түвшнээс 50 хувь бууруулах;

б/хоёр дахь үе шат: 2007 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 85 хувь бууруулах;

в/гурав дахь үе шат: 2010 оны 1 дүгээр сарын 1 хүртэл Монреалын Протоколын хавсралт А-ийн I бүлгийн хлорт фторт нүүрсөрөгчийн хэрэглээг бүрмөсөн хязгаарлах;

г/дөрөв дэх үе шат: 2015 оны 1 дүгээр сарын 1 хүр-тэл Монреалын Протоколын хавсралт С-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг 1999 оны түвшнээс 90 хувь бууруулах;

д/тав дахь үе шат: 2030 оны 1 дүгээр сарын 1 хүр-тэл Монреалын Протоколын хавсралт С-ийн I бүлгийн хлорт фторт нүүрстөрөгчийн хэрэглээг бүрмөсөн хязгаарлах.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

7.Озоны давхаргыг хамгаалах асуудлыг Байгаль орчны сайдын дэргэд ажилах озоны асуудлаарх Үндэсний хороо удирдан зохицуулна. Үндэсний хорооны бүрэлдэхүүнд нь Хөдөө аж ахуй, үйлдвэрийн, Дэд бүтцийн хөгжлийн болон, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яам, Үндэсний статистикийн газар, Гаалийн ерөнхий газар, Шинжлэх ухааны академи зэрэг төр, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөлөгчид орно.

8.Озоны асуудлаархи үндэсний хороо нь озоны давхаргыг хамгаалах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж, озон задалдаг бодисын импорт, худалдаа, хэрэглээнд хяналт тавьж, тухайн асуудлаар эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

9.Озоны асуудлаархи үндэсний хорооны ажлын алба доорхи үүргийг гүйцэтгэнэ:

а/хөтөлбөрт заасан үйл ажиллагаг зохион байгуулж явуулах;

б/үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлыг олон улсын эрх бүхий байгууллагад тавьж, түүнийг хэрэгжүүлэх талаар технологи, санхүүгийн дэмжлэг, тусламж авах;

в/озоны давхаргын шинжилгээ судалгаа, ажиглалт, хэмжилтийн ажлын чиглэл, хүрээг тогтоох, тэдгээрийг хариуцан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хэрэгжилтийг зохин байгуулах, хяналт тавих;

г/озоны давхаргын өөрчлөлтөөс шалтгаалан хэт ягаан туяанаас шим мандалд үзүүлэх нөлөөллийг судлах ажлыг эрчимжүүлэх, энэ чиглэлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах;

д/озоны давхаргыг шинжлэн судлах, хамгаалахтай холбоотой шинжлэх ухаан, нийгэм, эдийн засаг, худалдааны болон эрх зүйн мэдээллийг олон улсын эрх бүхий байгууллага, гадаад улстай солилцох, дотоодын сонирхсон байгууллагуудад түгээх, сурталчлах;

е/озоны үе давхаргын талаарх Конвенци, Протоколын болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан гаргаж улирал бүр эрхэлсэн сайдад, жил бүрийн 1 дүгээр сард Засгийн газарт, гэрээ, хэлэлцээрт заасан хугацааанд нь олон улсын байгууллагад тайлагнах;

ж/озоны давхаргыг задалдаг бодис хэрэглэдэг үйлдвэрлэл, үйлчилгээний байгуллага болон салбарын хэрэглээг бууруулах, өөр бодисоор орлуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхэд нь туслах, биелэлтэд хяналт тавих;

з/озон задалдаг бодис хэрэглэдэг үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтнуудад зориулж сургалт семинар зохион байгуулах.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хөтөлбөрийн зорилгыг дор дурдсан үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

10. Зохион байгуулалтын талаар

а/озоны давхаргыг хамгаалах эрх зүйн үндэс бүрдүүлэх;

б/Монреалын Протоколын 1997 оны нэмэлтэд нэгдэн орох;

в/Байгаль орчны сайдын дэргэд Озоны асуудлаархи үндэсний хороо болон түүний ажлын албыг байгуулж ажиллуулах;

г/озоны давхаргыг задалдаг бодис импортлогч, ашиглагч нарын үндэсний нийгэмлэг болон бусад холбогдох төрийн бус байгууллагын үйл ажиллагаг дэмжих, тэдгээртэй хамтран ажиллах;

д/озоны давхаргыг шинжлэн судлах, хамгаалах төрийн болон төрийн бус байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр төсөл боловсруулан

Олон улсын байгууллагад тавьж хэрэгжүүлэх;

е/озоны давхаргыг судлах, хамгаалах болон озон задалдаг бодисыг импортлогч, ашиглагч байгууллагын мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, семинар зохион явуулах;

ж/озоны давхаргыг задалдаг бодис ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад олгох зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох;

з/озон задалдаг бодисын хяналт-шинжилгээний үндэсний тогтолцоог бий болгох;

и/озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисын ялгаралтыг бууруулах,өөр бодис, технологиор орлуулах талаар олон нийтэд мэдээллийн бүх хэрэгслээр сурталчилгаа явуулах.

11.Судалгаа хэмжилтийн талаар

а/хийн мандал дахь озоны ерөнхий агуулламж, түүний босоо тархалтын орон зай, цаг хугацааны өөрчлөлтийг хэмжих байгнын харуул байгуулан ажиллуулах;

б/газрын гадаргаас завсрын мандал, давхраат мандал хүртэлх агаарын температурын хуваарилалтыг нарийвчлан судлах;

в/газрын гадаргад ирж байгаа нарны цацрагийн долгионы бүрэлдэхүүн хийгээд амьд организмд нөлөөлөх хэт ягаан туяаны хэмжилт, судалгааны ажлыг зохион байгуулах;

г/цаг уурын ажиглалт хэмжилтийн өндөр нарийвчлалтай багаж техөөрөмжөөр үүр амьсгалын өөрчлөлтийг судлах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхлэх.

12. Мэдээллэн солилцооны талаар

Озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисын хэрэглээг багасгах, улмаар бүрмөсөн хязгаарлах зорилгоор олон улсын байгууллага, гадаад орон, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагатай дараахь мэдээлэл өгөгдлийг солилцоно:

а/судалгаа явуулах шаардлага бүхий озоны давхаргыг задалдаг бодисын ялгаралын тухай өгөгдөл;

б/озоны ерөнхий агуулламж, түүний босоо чиглэл дэх хуваарилалтын тодорхой хугацааны өөрчлөлт хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн тухай шинжилгээ судалгааны үр дүн, мэдээлэл;

в/шинжилгээ, судалгааны ажлын үр дүнгийн үнэлгээ, цаашдын судалгааны зөвлөмж;

г/ озон задалдаг бодисын ялгаралтыг бууруулах болон орлуулах бодис, технологийн талаархи судалгаа шинжилгээний ажлын мэдээлэл, тайлан;

д/озон задалдаг бодисын үйлдвэрлэл, хэрэглээ, цаашдын хандлага, импорт, экспортын тухай мэдээлэл;

е/озоны давхаргыг хамгаалахтай холбогдсон үндэсний хууль тогтоомж, удирдлага, зохицуулалтын талаарх мэдээлэл;

ж/озоны давхаргыг хамгаалахтай холбогдсон лицэнз, патент олгох нөхцөл, аргын тухай мэдээлэл.

13.Олон улсын хамтын ажиллагаа

Озоны давхаргыг хамгаалах, озон задалдаг бодисыг багасгах, бүрмөсөн хязгаарлах, озон хомсдуулдаг бодисын хэрэглээг өөр бодисоор орлуулан солих шинэ техник, технологи нэвтрүүлэх, озоны судалгаа шинжилгээ явуулах талаар олон улсын хамтын нийгэмлэгтэй харилцаа холбоогоо хөгжүүлж, түншлэлийн үр ашигтай хэлбэрээр хамтран ажиллана:

а/ОХУ, АНУ, Канад, Австрали, Япон, ХБНГУ, БНХАУ, Франц зэрэг улс орнуудтай озоны давхаргын судалгаа шинжилгээ хамтран хийж, тандан судалгааны мэдээллэл хүлээн авах, солилцох, озон задалдаг бодисын мэдээлэл солилцох, орлуулагч бодисын мэдээлэл авах, шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

б/озон задалдаг бодисын тооллого бүртгэл хийх, хөргех системийн менежментийг сайжруулах зэрэг чиглэлээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Хөгжлийн хөтөлбөр, Үйлдвэр, хөгжлийн байгууллага, Озоны асуудлаарх олон талын сан, Дэлхийн экологийн сан зэрэг байгууллагатай хамтран ажиллах;

в/озоны давхаргыг шинжлэн судлах, байнгын хяналт-шинжилгээ хийх, мэдээллийн сан, сүлжээ байгуулах, боловсон хүчин бэлтгэх чиглэлээр Дэлхийн цаг уурын байгууллага, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай үр ашигтай хамтын ажиллагаа улам бүр хөгжүүлэх;

г/гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран озон задалдаг бодисын хэрэглээг өөрчлөх, орлуулагчаар солих, байгууллага, аж ахуйн нэгжийн мэргэжлийн хүмүүст сургалт явуулах, сонирхсон байгууллага, хүмүүст мэдээлэл сурталчилгаа явуулах төсөл боловсруулж хэрэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

14.Хөтөлбөрт заасан үйл ажиллагааг доорхи санхүүгийн эх үүсвэрээр хэрэгжүүлнэ:

а/озон хомсдуулдаг бодисын тооллого болон хяналт шалгалтыг байгаль хамгаалахад зориулсан улсын төвлөрсөн болон орон нутгийн жил бүрийн төсөөөс санхүүжүүлнэ;

б/үйлдвэр, үйлчилгээний хэвийн ажиллагаг хангах, байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэх болон түүний эд, материал ашиглахад зориулан үйлдвэр, аж

ахуйн нэгж, байгууллагаас төлөвлесөн хөрөнгө.

в/хандивлагч орон, гадаад, дотоодын байгууллагын тусламжийн хөрөнгө.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт, үр дүн

15.Хяналт шалгалт: Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих ажлыг Озоны асуудлаарх үндэсний хороо эрхлэн гүйцэтгэнэ.

16.Үр дүн

Озоны давхаргыг задалдаг бодисыг бүрэн хязгаарлах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

а/озоны асуудлыг эрхлэх үндэсний удирдлага, зохицуулалтын тогтолцоо бүрэлдэн тогтож, озоны шинжилгээ судалгаа, байнгын ажиглалт хэмжилтийн тогтолцоо бий болно;

б/монголын хүн ам, байгаль орчныг хэт ягаан туяаны нөлөөллөөс хамгаалах стратеги боловсруулах үндэслэл бүрдэж эхэлнэ;

в/озоны талаархи эрх зүй, шинжлэх ухаан, техник, технологийн чиглэлийн дотоод, гадаадын мэдээллийн солилцоо тогтмолжино;

г/Монгол улс Венийн Конвенци, Монреалын Протоколоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлнэ;

д/үүр амьсгалын өвчлөлт болон хэт ягаан туяаны нөлөөлөлд бага автах хүнс тэжээлийн болон техникийн үргамал, тэжээмэл амьтан үржүүлэхэд шаардагдах мэдээллийн нэмэгдэл эх сурвалжтай болно;

е/озоны давхаргыг үл задлах бодис хэрэглэх, байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэхэд олон улсын дэмжлэг хүлээж, зохих тусламж авах бололцоо бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 130** **Улаанбаатар хот**

Хөшөө барих тухай

"XXI зууныг угтаж хэрэгжүүлэх Үндэсний Еренхий хөтөлбөр санаачлах тухай" Монгол Улсын Еренхийлөгчийн 1999 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 114 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1.Нийслэлийн Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дэх Тасганы овоон дээр Монгол угсаатны 2000 жилийн дурсгалын хөшөөг барьж байгуулах саналыг дэмжиж, төслийн хэрэгжүүлэгчээр Гэгээрлийн яамыг батална.

2.Хөшөөг 1999-2000 онд багтаан барих ажлыг тодорхой төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг Гэгээрлийн сайдын үүрэг гүйцэтгэгч А.Баттөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт тус тус даалгасугай.

3.Хөшөөг барихад шаардагдах нийт хөрөнгийн 60 хувь (72 сая төгрөг)-ийг улсын төсвөөс санхүүжүүлэхийг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Очирсүх,үлдэх хөрөнгийг байгуулагч, аж ахуйн нэгж, иргэдийн хандиваар бүрдүүлэхийг Гэгээрлийн сайдын үүрэг гүйцэтгэгч А.Баттөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **А.БАТТӨР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 132** **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. Монгол оронд Ардчилсан хөдөлгөөн үүсч, хөгжсөний 10 жилийн ойд бэлтгэх, түүнийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд зориулан төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлаас 108,83 (нэг зуун

найман сая найман зуун гучин мянган) сая төгрөг гаргахыг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

2.Уг көрөнгийг хавсралтад дурдсан арга хэмжээнд зарцуулахыг Гэгээрлийн сайдын үүрэг гүйцэтгэгч, Монгол оронд Ардчилсан хөдөлгөөн үүсэхийн 10 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах Засгийн газрын комиссын дарга А.Баттөрд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Я.ОЧИРСҮХ

ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ А.БАТТӨР

Засгийн газрын 1999 оны
132 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ ОРОНД АРДЧИЛСАН ХӨДӨЛГӨӨН ҮҮСЧ ХӨГЖСӨНИЙ 10 ЖИЛИЙН ОЙД БЭЛТГЭХ, ТҮҮНИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

1.Нийт аймаг, сумдад ардчиллын үнэ зүйлсийг сурталчлах сургалт зохио байгуулах.

2.Сэтгүүл зүйн бүх төрлөөр Ардчилса хөдөлгөөний тухай зохион бичлэгий үралдаан зарлаж дүгнэх.

3.Телевиз, радиогийн клип, ролик бэлтгэж нэвтрүүлэх.

4.Монголын Ардчилсан Холбооны байран Ардчилсан хөдөлгөөний музей зохио байгуулах.

5."Ардчилалд суралцсан 10 жил" баримтат кино бүтээх.

6."Монгол дахь Ардчилсан хөдөлгөөний түүх" ном хэвлүүлэх.

7."Ардчилал 10" гэрэл зургийн цомо бэлтгэх.

8.Ардчилсан хөдөлгөөний анхдагчий үнэмлэхийн загварыг батлуулж, үнэмлэхий хэвлүүлэх, олгох.

9.Ардчилсан хөдөлгөөнтэй холбоото түүхэн баримт материалыг цуглуулж, архив шилжүүлэх.

10.Ойн баярын хурал, хүндэтгэлий концерт, үндэсний бөхийн барилдаан зохио байгуулах.

11.Гурван үеийнхний уулзалт зохио байгуулах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 133 Улаанбаатар хот

Жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1.Хувьчлагдах барилга байгууламжийн жагсаалтыг хавсралтын ёсоор батлсугай.

2.Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу жагсаалтад дурдагдсан барилга байгууламжийг түрээсийн гэрээгээр эзэмшиж байгаа түрээслэгчдэд төргүүн эзэлжинд санал болгож, тогтоосон хугацаанд барилгын үнийг төлөөгүй тохиолдолд нийтийн дуудлага худалдаагаар худалдахыг Төрийн өмчийн хорооны дарга Д.Зориггод үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "1997 оноос эхлэн хувьчлагдах зарим объектын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 26 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаас "22.БЭД.15.30-52. Бизнес ХХК. Шүдний эмнэлэг." гэсэн хэсэг, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаас "25.Баянзүрх дүүрэг, 15 дугаар хороолол Хүнсний үйлдвэрийн барааны 6-р дэлгүүрийн барилга. Хүнсний барааны 6-р дэлгүүр Баянцээл ХХК, Шим ХХК, Хотон ХХК, худалдаа", "29.Хан-уул дүүрэг, 19 дүгээр хорооллын үйлчилгээний төвийн барилга. Орхон ХХК, Жаргалант ХХК" гэсэн хэсгийг, "Хөтөлберт өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1998 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 199 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаас "4.Баянзүрх дүүрэг. 3 дугаар хороо. ОСНАА-н 5 дугаар конторын харьяа нийтийн бие засах газар", "12.Сүхбаатар дүүрэг. 1 дүгээр хороо. ОСНАА-н 1 дүгээр конторын харьяа нийтийн бие засах газар", "14.Сүхбаатар дүүрэг. 8 дугаар хороо. Спорт сургалтын төвийн барилга" гэсэн хэсгийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Я.ОЧИРСҮХ

Засгийн газрын 1999 оны
133 дугаар тогтоолын хавсралт

ХУВЬЧЛАГДАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

№	Хувьчлах төрийн өмчийн байрны байршил	Түрээслэж буй аж ахуйн нэгж	Түрээслэж буй талбайн хэмжээ
1	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дахь нийтийн бие засах газрын барилга	"Гал трейд" ХХК	50,0 м²
2	Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нутаг дахь нийтийн бие засах газрын барилга	"Хүннү" ХХК	40,6 м²
3	Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дахь нийтийн бие засах газрын барилга	"Эрхэт трейд" ХХК	52,0 м²
4	Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооллын нийтийн бие засах газрын барилга	"Рашаантбулган" ХХК	47,26 м²
5	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дахь нийтийн бие засах газрын барилга	"ЭН-ЖИ" ХХК	50,0 м²
6	Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дахь "Спорт сүргалтын төв"-ийн Б хэсэг	"Монгол спорт" ХХК	647,8 м²
7	Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дахь Ажилчин залуучуудын ээлжийн сургуулийн барилга	"Соёл эрдэм" дээд сургууль	570,0 м²
8	Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны 15 дугаар хорооллын 30 дугаар байры 52 тоот	"Бизнес-дент" ХХК	81,3 м²
9	Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны нутаг дахь "Баруун сэлбэ" хорооллын үйлчилгээний төвийн "И" блок	"Аж богд трейд" ХХК, "Мөнгөн тахь ХХК, "Космос" ХХК	816,0 м²
10	Хан-уул дүүргийн Төв цэнгэлдэх хүрээлэнгийн арын павильоны 1 дүгээр барилга	"Говийн од групп" ХХК	670,0 м²
11	Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны нутаг дахь хүнсний барааны 6 дугаар дэлгүүр	Баянцээл ХХК	2363,5 м²
12	Хан-уул дүүргийн 2 дугаар хо- рооны нутаг дахь Нэхмэлийн 7 ду-гаар байры 2 дугаар орцны 1 ду-гээр давхрын номын дэлгүүрийн байр	"Долоон нар" Бүх гишүүд нь бүрэн хариуц-лагатай нөхөрлөл	112,0 м²
13	Баянгол дүүргийн 4 дүгээр хо-роо, 4 давхар тоосгон барилга	"Монгол түлхүүр" ХХК	5183,0 м²
14	Хан-уул дүүргийн 19 дүгээр хорооллын үйлчилгээний төвийн гутал засвар, хувцас захиалга	"Орхон" ХХК "Жаргалант" ХХК	718,4 м²

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 7 дугаар сарын 21-ний өдөр — **Дугаар А/187** — **Улаанбаатар хот**

Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол улсын Эрүүл мэндийн багц хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хорооны 1999 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолын холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ нь:**

1.Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нутгийн захиргааны хэрэгжүүлэгч агентлаг "Эрүүл мэндийн газар" байгуулсугай.

2. Эрүүл ахуй, халдвар судлал, эм биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын байцаагчид, эрүүл зүйн химич, нян судлалын лабораторийг орон тоо, төсвийн хамт Мэргэжлийн хяналтын албанд шилжүүлэн"Эрүүл мэндийн хяналтын хэлтэс"-ийг байгуулан ажиллуулсугай.

3. Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрмийг нэгдүгээр, Нэгдсэн эмнэлгийн

үлгэрчилсэн дүрмийг хоёрдугаар, Сумын эмнэлгийн үлгэрчилсэн дүрмийг гуравдугаар, Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн үлгэрчилсэн дүрмийг дөрөвдүгээр хавсралтын ёсоор батлагдсугай.

4. Энэхүү тушаалыг энэ оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж, дүнг мөн сарын 20-ны дотор тус яаманд ирүүлэхийг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

5.Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ш.Энхбат/, Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба /Н.Сайжаа/, Эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын алба /А.Дамдинсүрэн/-д, явцад нь үнэлэлт өгч, дүнг энэ оны 9 дүгээр сарын 15-ны дотор Сайдын зөвлөлд танилцуулахыг Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /П.Алтанхуяг/-т тус тус даалгасугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай" ЭМНХ-ын сайдын 1997 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн А/287 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД С.СОНИН

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн А/187 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Үйл ажиллагааны чиглэл

1. Аймгийн Эрүүл мэндийн газар нь төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан эрүүл мэндийн бодлогыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий нутгийн захиргааны хэрэгжүүлэгч агентлагийн эрх, үүрэгтэйгээр ажиллана.

2. Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар гарсан Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм, заавар, стандартыг мөрдлөг болгон тэдгээрийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

3. Эрүүл мэндийн үндэсний бодлогыг удирдлага болгон орон нутгийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний зорилт, стратеги, төрүүлэх чиглэлийг тодорхойлж, хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламжийг оновчтой зохион байгуулах зарчим баримтална.

4. Нутаг дэвсгэрийнх түвшинд хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгнө.

5. Нутаг дэвсгэрийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стратеги, төрүүлэх чиглэлд нийцүүлэн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хөрөнгийг аль болох үр өгөөжтэй ашиглах зарчим баримтална.

6. Нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжлийн удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагааны нэгдсэн бодлого, чиглэлээр ханган ажиллана.

7. Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих үйл ажиллагаандаа хүн амыг өвчлөхөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг давуутай хөгжүүлэх бодлого, чиглэл баримтлан ажиллана.

8. Эрүүл мэндийн газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд салбар дундын зохицуулалт хийж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх, эрүүл мэндийг хамгаалахад нутгийн захиргаа, эрүүл мэндийн бус салбар, олон нийтийн байгууллага, хүн амыг идэвхитэй оролцуулан ажиллана.

9. Эрүүл мэндийн газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хэрэгцээг тодорхойлох, бэлтгэх, давтан сургах, хуваарилах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудлыг хариуцна.

10. Эрүүл мэндийн газар нь нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, түргэн тусламжийн авто машины ашиглалт, хяналт, нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулна.

Хоёр. Эрүүл мэндийн газрын удирдлага, зохион байгуулалт, эрх, үүрэг

1. Эрүүл мэндийн газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд эрүүл мэндийн асуудлаар төрийн захиргааны төв байгууллагаас батлсан бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх, зохицуулах, хянах чиг үүрэгтэй нутгийн захиргааны хэрэгжүүлэх агентлагийн хэлбэрээр ажиллана.

2.Эрүүл мэндийн газрын даргыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргатай зөвшилцөн аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

3. Эрүүл мэндийн газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бодлогын хэрэжилтийг зохицуулах, хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа боловсронгуй болгох, санхүү, эд материалын хөрөнгө нөөцийг тулгамдсан асуудалд оновчтой хуваарилах, хяналт тавих асуудлыг хариуцаж, аймгийн Засаг дарга, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдад тайлагнана.

4. Эрүүл мэндийн газар нь удирдлагын алба, нийгмийн эрүүл мэндийн алба гэсэн үндсэн нэгжүүдтэйгээр ажиллаж, нэгдсэн эмнэлэг,

сум, өрхийн эмнэлэг, багийн бага эмчийн салбарыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана. Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын болон өрхийн эмнэлэг нь аж ахуй, санхүүгийн хувьд бие даан ажиллана.

5. Эрүүл мэндийн үндэсний бодлого болон орон нутгийн эрүүл мэндийн тэргүүлэх чиглэлүүд, тулгамдсан асуудлуудад нийцүүлэн нутгийн захиргааны, олон нийтийн байгууллага, бусад салбар, хамт олон, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн байгууллагуудтай хамтран зорилтоо тодорхойлно.

6. Эрүүл мэндийн газар нь нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний байдал, хөрөнгө, зардлын тайлан, статистик мэдээллийг нэгтгэн гаргаж, дүгнэлт хийж холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

7. Эрүүл мэндийн газар нь Монгол улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн гуравдугаар зүйлийн нэг дэх хэсгийн дагуу улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжин, аж ахуй санхүүгийн хувьд бие даан ажиллах бө "Эрүүл мэндийн газар" гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

8. Эрүүл мэндийн газрын удирдлагын алба нь эмнэлгийн тусламж-үйлчилгээ, хувийн эмнэлэг, эдийн засаг-санхүү, нягтлан бодох бүртгэл, боловсон хүчин, эрүүл мэндийн статистик мэдээллийн асуудал хариуцсан их, бага эмч, компьютерийн мэдээлэл боловсруулах оператор зэрэг мэргэжилтнүүдтэй байна.

9. Эрүүл мэндийн газар нь орлогч даргатай байх ба орлогч дарга нь Нийгмийн эрүүл мэндийн албаны ерөр тутмын үйл ажиллагаат удирдан явуулна.

10. Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн алба нь мэргэжлийн өвчин судлагч эмч, халдвар судлагч их, бага эмч, ариутгагч, халдваргүйжүүлэгч эмч, мэргэжил-тэн, эрүүл мэндийн боловсрол, сурталт сурталчилгааны арга зүйч, бие бялдар чийрэгжүүлэлт, нөхөн үржихүй, өсвөр үеийн эрүүл мэнд, дархлаажуулалтын хөтөлбөр хариуцан болон өрхийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцан эмч нартай байна.

11. Нийгмийн эрүүл мэндийн алба нь нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ зохион явуулна.

12. Эрүүл мэндийн газар нь дор дурдсан эрхтэй. Үүнд:

12.1Нутаг дэвсгэрийн хэмжээнд төрийн болон холимог өмчийн, хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчдээс хүн амд үзүүлж буй нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээнд үнэлэгт өгч, цаашдын зорилт чиглэлээ тодорхойлох, мэргэжлийн удирдлагаар хангах, шалган зааварлах;

12.2. Сум, өрх, багийн эмнэлгүүдийн үйл ажиллагаат шалган зааварлаж, мэргэжлийн зөвлөгөө, үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих;

12.3. Эрүүл мэндийн байгууллагуудад гарсан шинэ бүтээл, тэргүүн туршлага, дэвшилтэт технологид экспертийн дүгнэлт гаргах, санал өгөх, тэргүүний хүмүүсийг шагнаж урамшуулах, аймгийн болон төр засгийн дээд байгууллагын шагналд тодорхойлох;

12.4 Өөрийн орны болон гадада орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх.

13. Эрүүл мэндийн газар нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

13.1 Эрүүл мэндийн талаар орон нутагт баримтлах зорилт, стратеги боловсруулахад байгууллага, хамт олон, олон нийтийг татан оролцуулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнийн шинэ хандлага, чиглэлийн талаар ойлголтыг төлөвшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх;

13.2 Хүн амын эрүүл мэндийг сайжруулах бэхжүүлэх арга хэмжээний хэтийн төсөөлөл, жилийн төсөв, төлөвлөгөөг боловсруулах;

13.3 Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стратеги, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн хөрөнгийг аль болох үр өгөөжтэй зарцуулах зарчим баримталж, төрийн болон холимог өмчийн, хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчидтэйгэрээ байгуулах замаар улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас өгөх санхүүжлтийн хуваарийг боловсруулах;

13.4 Нийгмийн эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрхийн акт, норм, норматив, стандарт, мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын акт, шаардлагыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах;

13.5 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж,мэргэжил,арга зүйн удирдлагаар хангах, халдварт болон халдварт бус өвчний мэдээ, тайланг нэгтгэн дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

13.6 Халдварт өвчний эсрэг хүн амыг дархлаажуулах, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихийн бодлого, чиглэл, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, сургалт, сурталчилгаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд явуулах;

13.7 Биеийн тамир, чийрэгжүүлэтийн үйл ажиллагаа дэмжин хэрэгжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, биеийн тамирын дасгал, хөдөлгөөнөөр нөхөн сэргээх талаар сургалт, сурталчилгаа явуулах;

13.8 Сумын эмнэлгийн үйл ажиллагааны мэдээ, тайланга нэгтгэн үнэлэгт, дүгнэгт

өгөн ажиллах ба холбогдох байгууллагуудад хугацаанд нь мэдээлж, өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн А/187 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Үйл ажиллагааны үндсэн чиглэл

1. Нэгдсэн эмнэлэг нь аймгийн хэмжээнд хүн амд эмнэлгийн анхан шатны болон үндсэн мэргэжлийн тусламж үзүүлж, нутаг дэвсгэрийн хэмжээнд эмнэлгийн байгууллагуудыг мэргэжлийн арга зүй, удирдлагаар ханган ажиллана.

2. Нэгдсэн эмнэлэг нь хэдэөгийн хүн амд эмнэлгийн анхдагч болон хоёрдогч лавлагаа тусламжийг үзүүлнэ.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх үүрэг

1. Нэгдсэн эмнэлгийн дарғыг Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх удирдах зөвлөлийн санал болгосноор Эрүүл мэндийн газрын дарғын тушаалаар томилж, чөлөөлнө. Нэгдсэн эмнэлгийн дарга нь нутаг дэвсгэрийн хэмжээнд эмнэлгийн тусламжийн асуудлыг мэргэжлийн хувьд удирдан зохион байгуулж, Эрүүл мэндийн газрын даргад тайлагнана.

2. Нэгдсэн эмнэлэг нь нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн зорилт, тэргүүлэх чиглэлтэй уялдуулан тусламж үйлчилгээг үзүүлэхдээ дотор /арьсны өвчтөн эмчлэх тодорхой тооны ортой/, мэс засал, гэмтэл, нүд, чих, хамар хоолой зэрэг өвчнийг эмчлэх тодорхой тооны ортой/, хүүхэд, төрөх эмэгтэйчүүд, мэдрэл-сэтгэцийн эмгэг, уламжлалт эмчилгээ, халдварт, сүрьеэ, бэлгийн замын халдварын, сэхээн амьдруулах-эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн зэрэг стационарын тасгууд болон поликлиникийн үндсэн мэргэжлийн кабинетууд, эмгэг судлал, шүүх эмнэлэг, статистик мэдээлэл, түргэн тусламжийн албаа зэрэг нэгжүүдийг зохион байгуулж ажиллана. Нэгдсэн эмнэлэг нь аж ахуйн үйлчилгээ /гал тогоо, угаалга, ариутгал, туслах аж ахуй, автограаш гэх мэт/-ний болон инженер-техник, эдийн засаг-санхүүгийн зэрэг нэгжүүдийг зохион байгуулан ажиллуулж болно.

3. Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогчийг эмч нарын саналыг, өрөнхий сувилагчийг сувилагч нарын саналыг тус тус үндэслэн нэгдсэн эмнэлгийн дарга томилж, чөлөөлнө.

4. Нэгдсэн эмнэлгийн тасаг, нэгжүүдийг нэгдсэн эмнэлгийн дарын тушаалаар томилогдсон эрхлэгчид удирдана.

5.Нэгдсэн эмнэлэг нь аж ахуй, санхүүгийн хувьд бие дааж ажилаж, банкинд төсвийн болон эрүүл мэндийнэ даатгалын санхүүжилтийн тусгай харилцах данстай байх ба "Нэгдсэн эмнэлэг" гэсэн албан бичгийн хэвлэмэл нүүр, тэмдэг хэрэглэнэ.

6.Нэгдсэн эмнэлэг нь дор дурдсан эрхтэй байна. Үүнд:

Хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулахтай холбогдсон асуудлыг мэргэжлийн дээд шатны буюу нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагад тавих;

6.1. Өөрийн эмнэлгийн эмч мэргэжилтнийг солилцуулан ажиллуулах, тодорхой ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх, дотоод, гадаадад туршлага судлуулах, мэргэжлийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

6.2. Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт эмнэлгийн байгууллагуудын эмчилгээ, үйлчилгээний чанарын түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх.

7. Нэгдсэн эмнэлэг нь дараахь үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

7.1. Хүн амд эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, хэдөөгийн хүн амд анхдагч болон хоёрдогч лавлагаат тусламжийг үзүүлэх;

7.2. Оношлох, эмчлэх үйл ажиллагаандаа чанарын стандартын шаардлагыг хангаж, улмаар магадлан итгэмжлэл авах;

7.3. Нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллагуудыг мэрэгжлийн удирдлагаар хангах, эдгээр байгууллагуудад ажиллаж байгаа эмч эмнэлгийн ажилтны мэргэжлийн ур чадварыг сайжруулах бодлого, чиглэл, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;

7.4. Өөрийн эмнэлгийн үйл ажитллагааны мэдээ тайланг нэгтгэн үнэлэлт дүгнэлт өгөн ажиллах ба холбогдох байгууллагуудад хугацаанд нь мэдээлж, өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангаж байх;

7.5.Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, мэргэжлийн дээд шатны буюу нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын шийдвэр, мэргэжлийн хяналтын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

7.6.Аймгийн төвийн хүн амд 24 цагаар, сумдын хүн амд алсын дуудлагаар эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх;

7.7. Хэдөөгийн хүн амд тодорхой хугацаанд төлөвлөгөөний дагуу эмнэлгийн нарийн мэргэжлийн иж бүрдмэл тусламжийн явуулынүйлчилгээ зохион байгуулах;

7.8.Иргэд, эмнэлэг, хуулийн байгууллагын хэрэгцээ, шаардлагын дагуу эмэг судалшүүх эмнэлгийн магадлагаа дүгнэгт гаргах.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он № 44 (123)

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн А/187 тоот тушаалын гуравдугаар хавсралт

СУМЫН ЭМНЭЛГИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Үйл ажиллаганы үндсэн чиглэл

1.Сумын хүн амд эмнэлгийн анхан шатны болон ерөнхий мэргэжлийн туламж үзүүлэн сумын хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

2.Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Сумын эмнэлэг, хөдөөгийн багийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламжийг Багийн хүний эмчийн салбар тус тус гүйцэтгэнэ. Харьцангуй олон хүн амтай, байршлын хувьд боломжтой сумын эмнэлгийг зэргэлдээ сумдад анхдагч лавлагаа тусламж үзүүлэх чиглэлээр зохион байгуулж болно.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх, үүрэг

1. Сумын эмнэлэг нь сумын хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хэсэг, жирэмсний амаржуулах болон өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх хэсэг, эмийн сангаас бүрдэнэ.

2. Сумын эмнэлгийн эрхлэгчийг аймгийн Эрүүл амэндийн газрын даргатай зөвшилцөн сумын Засаг дарга томилж, чөлөөлөнө. Сумын эмнэлгийн дотоод дүрмийг сумын Засаг даргаар батлуулж мөрдүүлнэ.

3.Сумын эмнэлэг нь аж ахуй, санхүүгийн хувьд бие даан ажиллаж, банкинд төсвийн болон эрүүл мэндийнэ даатгалын санхүүжилтийн тусгай харилцах данстай байх ба "Сумын эмнэлэг" гэсэн тэмдэг, албан бичгийн нүүр хэрэглэнэ.

4.Сумын эмнэлгийн эрхлэгч нь дор дурдсан үндсэн эрхтэй байна. Үүнд:

4.1.Хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйчлгээтэй холбогдсон асуудлыг мэргэжлийн дээд шатны буюу нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагад тавих;

4.2.Эрүүл мэндийн асуудлаар тодорхой шаардлагыг иргэд, сумын бусад байгууллагуудад тавьж, биелэлтийг гаргуулах;

4.3.Эмч, эмнэлгийн ажилчдыг шагнах буюу дээд байгууллагын шагналд тодорхойлох, мэргэжлийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах, ажилд шинээр авах, ажлаас чөлөөлөх;

5.Сумын эмнэлгийн эрхлэгч дараахь үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

5.1.Сумын эмнэлгийн хэтийн хөгжил, жил бүрийн төсөв, төлөвлөгөө болон бусад асуудлыг боловсруулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газарт оруулан шийдвэрлүүлэх;

5.2.Нийт ажиллагсдын /багийн хүний эмчийн салбарт ажиллагсдыг оролцуулан/ ажил үүргийн хуваарийг батлан мөрдүүлж, өдөр тутмын удирдлага зааварчилгаар хангаж, ажлын үр дүнд нь хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгөх;

5.3.Сумын хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг удирдан зохион байгуулж, сум багийн нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, тэдний мэргэжил мэдлэгийнг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжүүлэх, эрүүл мэндийн сайн дурын туслагч нарт сургалт явуулан, тэдний ажлыг удирдан зохицуулах;

5.4.Сумын хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй таагүй хүчин зүйлийг судлан дүгнэлт хийх, хүн амыг өвлөхөөс урьдчилан сэргийлэх зэрэг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг сумын хэмжээнд удирдан зохион байгуулж, төр захиргаа, олон нийт, бусад салбар, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

5.5.Эмнэлгийн байгууллагын үйл ажилагааны мэдээ, тайланг нэгтгэн үнэлэлт, дүгнэлт өгөх ба холбогдох байгууллагуудад хугацаанд нь мэдээлж, өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

5.6.Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, мэргэжлийн дээд шатны буюу нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын шийдвэр, мэргэжлийн хяналтын байцаагчийн шаардлагыг биелүүлэх;

5.7.Эрүүл мэндээ хамгаалж, бэхжүүлэхэд сумын хамт олны идэвхи оролцоог өрнүүлэх, сумын эмнэлгийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, сумын ард иргэдийг татан оролцуулахад анхаарч ажиллах.

6.Багийн хүний эмчийн салбарт ажиллах эмчийг Сумын эмнэлгийн эрхлэгч, багийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр Сумын засаг дарга томилж, чөлөөлнө.

7.Багийн хүний эмчийн салбар нь тухайн багийн хүн амд эрүүл мэндийн анхдагч болон эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж, жирэмсэн эх, бага насны хүүхэд, архаг өвчтэй хүмүүс, настны эрүүл мэндэд хяналт тавьж, багийн хүн амыг эрүүл байх, элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх арга дадлыг сургах, эрүүл мэндийн сайн дурын туслагчидтай хамтран нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах үүрэг гүйцэтгэнэ.

8.Багийн хүний эмч нь Багийн хүний эмчийн салбар гэсэн тэмдэг хэрэглэх ба Сумын эмнэлгээс яаралтай тусламж дуудах, хүнд өвчтөнийг сумын төвд хүргэхэд иргэдээс унаа дайчлах болон бусад туслалцаа авах, Багийн засаг дарга ба иргэдэд эрүүл мэндийн асуудлаар тодорхой шаардлага тавих зэрэг эрх эдэлнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын
1999 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн
А/187 тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ДҮРЭМ

Нэг. Үйл ажиллагааны чиглэл

1. Мэргэжлийн хяналтын албаны Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн зорилт нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хүний эрүүл мэндэд нөлөөлөх байгаль, нийгэм, орчны сөрөг хүчин зүйлээс хамгаалах, өвчин эмгэгээс сэргийлэх, эмнэлгийн баталгаатай тусламж, чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлүүлэхтэй холбогдсон хууль тогтоомж, стандарт, улсын хяналтын дүрмүүд, норм нормативын хэрэгжилтэд хяналт тавихад оршино.

2. Мэргэжлийн хяналтын албаны Эрүүл мэндийн хяналтын хэлтэс /цаашид "эрүүл мэндийн хяналтын хэлтэс" гэнэ/ нь нутаг дэвсгэрийн хэмжээнд орчин, хүнс, хүүхэд, хөдөлмөрийн эрүүл ахуй, халдвар судлалын дүгнэлт гаргах, лабораторийн хяналт хийх, техникийн нөхцөл, стандартад урьдчилсан хяналт хийх үйлчилгээ үзүүлнэ.

3. Хүн амд эмнэлгийн чанартай тусламж үзүүлж, улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

Хоёр. Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн удирдлага, зохион байгуулалт, эрх, үүрэг

1. Эрүүл мэндийн хяналтын хэлтэс нь аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэргэжлийн хяналтын албаны бүтцэд ажилах ба орчин, хүнс, хүүхэд, хил, хөдөлмөрийн эрүүл ахуй, халдвар судлал, эм, биобэлдмэл эмчилгээний чанарын байцаагчид, химич, нян судлагч, лаборант зэрэг холбогдох мэргэжилтнүүдтэй байна.

2. Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга нь эрүүл ахуй, халдвар судлалын улсын ахлах байцаагч байх ба хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

3. Аймгийн эрүүл ахуй, халдвар судлалын улсын ахлах байцаагчийг Эрүүл ахуй, халдвар судлалын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор аймгийн Засаг дарга томилж, чөлөөлөх ба эрхийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд олгоно.

4. Эрүүл ахуй, халдвар судлалын байцаагч нь эрүүл мэндийн хяналтын зорилго, чиглэлд тусгагдсан асуудлуудыг хэрэгжүүлэх, хяналтын ажлын үр дүнг нутаг дэвсгэрийн хэмжээнд хариуцаж, аймгийн Засаг дарга, улсын хяналтын ерөнхий байцаагчдад ажлаа тайлагнана.

5. Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга нь Мэргэжлийн хяналтын албаны захиргааны зөвлөлийн гишүүн байна.

6. Эрүүл мэндийн хяналтын хэлтэс нь орон нуттийн төсөөр санхүүжнэ. Хяналт, үйлчилгээ тусламж, лабораторийн шинжилгээ, уналт, томилолтод шаардлагатай жилийн төсвийг боловсруулж, Мэргэжлийн хяналтын албаны даргаар батлуулан хэрэгжүүлнэ.

7. Мэргэжлийн хяналтын албаны дарга нь эрүүл мэндийн хяналтын хэлтсийн үйл ажиллагаанд хяналт тавих, ажлын байр, унаа, лабораторийн тоног төхөөрөмжөөр хангах, боловсон хүчнийг сургах, тогтвор суурьшилтай ажиллуулах, шагнал урамшилд тодорхойлох, ажиллагчдын нийгмийн асуудлаар авах арга хэмжээг шийдвэрлэх байна.

8. Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчид нь Засгийн газраас загварлыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, албан шаардлага, акт, дүгнэлт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

9. Эрүүл мэндийн хяналтын хэлтэс нь дор дурдсан эрхтэй. Үүнд:

9.1. Нутаг дэвсгэрийн нийт байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, ёмчийн хэлбэр харгалзахгүйгээр хяналт хийж, шаардлага тавих;

9.2. Холбогдох хууль тогтоомж зөрчсөн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд захиргааны хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгүүлэх асуудлыг холбогдох байгууллагад оруулах;

9.3. Холбогдох журмын дагуу үнэ төлбөргүйгээр сорьц авч, шинжлэх;

9.4. Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

10. Эрүүл мэндийн хяналтын хэлтэс нь дараахь үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

10.1. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, чанарын баталгаатай эмээр хангах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавих;

10.2. Монгол улсын нутаг дэвсгэр дээр хэрэгжиж байгаа холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

10.3. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүний эрүүл аюулгүй орчинд ажиллаж, амьдрах хэвийн нөхцөлийг хангуулах, чанарын баталгаатай эмээр хангах, эмнэлгийн чанартай тусламж авах талаар нутгийн захиргаа, төр, олон нийтийн байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах;

10.4. Эрүүл ахуй, халдвар судлалын урьдчилсан болон байнгын хяналтыг хийх;

10.5. Хот суурин, барилга байгууламж, аж ахуйн нэгжийг байгуулах ерөнхий төлөвлөгөө, барилга байгууламжийн болон технологийн зураг төсөл зохиох, газар сонгох, тэдгээрийг барьж байгуулах, ашиглалтад оруулах, шинэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх техникийн нөхцөл стандартад урьдчилсан хяналт хийх;

10.6. Байгалийн голомтот болон гоц аюулт халдварт өвчин, бусад улсаас дамжин орох, нэвтрэхээс хамгаалах хилийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг хил, гааль, стандарт, мал эмнэлэг, ургамал хорио цээрийн албадтай хамтран хийх;

10.7. Халдвар, гоц аюулт халдварт өвчин, олон улсын хөл хориот өвчин гарч тархаж байгаа нөхцөл, шалтгааныг илрүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

10.8. Хордлого, халдвар, осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

10.9. Үйлдвэр, аж ахуйн газрыг шинээр барьж байгуулах, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлд хяналт тавих;

10.10. Орчны бохирдолтыг эрүүл мэндийн байдалтай уялдуулан судалж, эрүүлжүүлэх арга хэмжээ авч байгаа байдалд хяналт тавих;

10.11. Хүнс, худалдаа, нийтийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг хүмүүсийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байдалд хяналт тавих;

10.12. Шинэ бүтээгдэхүүн, бодис бэлдмэл, материал, техник, технологи нь хүн амын эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаад судалгаа, тандалт хийж, хяналт тавих;

10.13. Импортлох, экспортлох болон хүн амын хэрэглээний бараа бүтээгдэхүүн, бодис, бэлдмэл, материал, технологи нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөхөөс урьдчилан сэргийлж, өвчин үүсгэгч нян, нянгийн өсөвөр, химийн хорт бодисын импортлолт, ашиглалт, хэрэглээ, устгалын байдалд хяналт тавих;

10.14. Ус ашиглалтын байгууллагаас чанарын шаардлага хангасан унд, ахуйн усаар хүн амыг хангаж байгаа байдалд хяналт тавих;

10.15. Тамхи, архины хор хөнөөлөөс сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

10.16. Хүн амд үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж байгаа эсэхэд хяналт тавих;

10.17. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл, хангалт, борлуулалт, тээвэрлэлт, хадгалалт, баталгаажилтын байдалд хяналт тавих;

10.18. Импортын болон эх орны эм, биобэлдмэл, эмийн түүхий эдийн баталгаажилтад хяналт тавих;

10.19. Мансуурах ба сэтгэц нөлөөт болон хүчтэй үйлчилгээтэй эмийн зарцуулалт, хэрэглээ, эмийн жорын мөрдөлтөд хяналт тавих;

10.20. Эмч, эмнэлгийн ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавьж, мэргэжлийн алдаа, хүний амь нас эрүүл мэндтэй холбоотой гарсан санал гомдлыг хянан шийдвэрлэх;

10.21. Эрүүл ахуй, халдвар судлал, эм биобэлдмэл, эмчилгээний чанарын асуудлаар иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн санал, гомдлыг шалгаж дүгнэлт гаргах;

10.22. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрүүлж газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны аравдугаар сарын 7 №45 (124)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

407. З.Тэрбишид Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 160 832
408. Э.Сүхээд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 161 832
409. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 162 832
410. Х.Гэлэгжамцад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 163 832
411. Ж.Норолхоод Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 164 833
412. Зарим хүмүүсийг одонгоор шагнах тухай Дугаар 165 833

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

413. УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай Дугаар 134 833
414. "Далай ашиглах тухай" хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 136 834
415. Төлбөрийн хэмжээг тогтоох тухай Дугаар 137 836
416. Шинжлэх ухааны зарим байгууллагын бүтцийн өөрчлөлтийн тухай Дугаар 138 836
417. Үлгэрчилсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 139 837
418. Мал тооллого явуулах товыг тогтоох тухай Дугаар 140 837

Гурав. Яам, агентлагийн акт

419. Журам батлах тухай (Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал) Дугаар 213 838

Залруулга

"Төрийн мэдээлэл " сэтгүүлийн 1999 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн №34-д нийтлэгдсэн, Улсын Их Хурлаас 1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр батлагдсан " Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай " хуулийн 40-р зүйлийн гарчиг нь техникийн алдааны улмаас "Тусгай хэрэгсэл хэрэглэх" гэж 39-р зүйлийн гарчигтай давхардан бичигдсэн байх тул уг зүйлийн гарчигийг "Тусгай хэрэгсэл" гэж залруулна уу.

Улсын Их Хурлын Тамгын газар
1999-9-30

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 160** **Улаанбаатар хот**

З.Тэрбишид Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад олон жил, үр бүтээлтэй ажиллан, монгол ардын болон зохиолын дуунуудыг чадварлаг дуулж, хүүхэд багачуудад ардын урлагийг өвлүүлэн сургах, хөдөөгийн хөдөлмөрчдөд урлаг соёлоор үйлчлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Говь-Алтай аймгийн ардын дуу, бүжгийн "Алтай" чуулгын гоцлол дуучин Загджавын Тэрбишид Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 161** **Улаанбаатар хот**

Э.Сүхээд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Дүрслэх урлагийн салбарт олон жил үр бүтээлтэй хөдөлмөрлөж, хөрөг, байгалийн болон сэдэвт уран зургуудыг мэргэжлийн өндөр ур чадвар гарган туурвиж, монголын дүрслэх урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Увс аймгийн урчуудын салбарын эрхлэгч, зураач Эрэнгийн Сүхээд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр **Дугаар 162** **Улаанбаатар хот**

Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус баримтлан, Улсын дээд шүүхийн 1999 оны 269 дүгээр тогтоолыг үндэслэн **ЗАРЛИГ болгох нь:**

1. Чимидлхамын Ганбатыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

2. Чимидлхамын Ганбатыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Энэ зарлигийг 1999 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр **Дугаар 163** **Улаанбаатар хот**

Х.Гэлэгжамцад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил идэвх санаачлага, үр бүтээлтэй ажиллаж, оношлогоо, эмчилгээний дэвшилтэт шинэ аргуудыг нэвтрүүлэн, дотрын нарийн мэргэжлийн тусламжийг чанаржуулах, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Анагаах ухааны их сургуулийн Бөөр судлалын тэнхмийн эрхлэгч Хайдавын Гэлэгжамцад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр **Дугаар 164** **Улаанбаатар хот**

Ж.Норолхоод Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монголын кино урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллан, олон арван баримтат болон уран сайхны киног мэргэжлийн өндөр ур чадвар гарган туурвиж, монголын кино урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэн "Монгол кино" нэгтгэлийн баримтат киноны найруулагч Жадамбын Норолхоод Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр **Дугаар 165** **Улаанбаатар хот**

Зарим хүмүүсийг одонгоор шагнах тухай

Төввэр, биеийн тамир, спорт, урлаг, радио, эрчим хүч, эрүүл мэнд, барилга, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, татварын алба, олон нийтийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан байгаа дор дурдсан хүмүүсийг одонгоор шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1.Лувсанжамцын Бадарч - Монголын радиогийн ахмад найруулагч

2. Хас-Очирын Батдорж - Ахмад төввэрчин

3. Дашдаваагийн Даржаа - Улаанбаатар хотын Дулааны шугам сүлжээний газрын ахлах инженер

4. Тогмидын Зандан-Увс аймгийн Өмнөговь сумын ахмадын хорооны дарга

5. Дэжээгийн Төмөр - Хөвсгөл аймгийн ахмадын хорооны дарга

6. Аюушжавын Цэвээн - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн өндөр настан, улсын мэргэн харваач

7. Цэндийн Цэнд-Аюуш - Ахмад жүжигчин

8. Дамбын Шоовдор - Завхан аймгийн ахмадын хорооны дарга

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР

1.Лувсангийн Бямбасүрэн - Нийслэлийн "Заяа" хувийн эмнэлгийн ерөнхий эмч

2. Ламжавын Дашцэрэн - "Монголын цахилгаан холбоо"ХК-ийн ахмадын хорооны дарга

3. Пунцагийн Дувжир - Өвөрхангай аймгийн Сант сумын өндөр настан

4. Дэлгэрийн Дүндүү - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Баян-Уул" ХК-ийн ажилтан

5. Дамбийнямын Жагдаг - Хөшин урлагийн театрын зохион байгуулагч

6. Намсрайн Жанчив - УБТЗ-ийн ахмадын хорооны дарга

7. Цэрэндэжидийн Жамцхүү - Завхан аймгийн Улиастай сумын "Даян-Уул" ХХК-ийн эмч

8. Бадарчийн Мэнд-Амар - Өвөрхангай аймгийн ахмадын хорооны дарга

9. Тавхийн Самбуу - Хүндийн ерөлтийн улсын шигшээ багын дасгалжуулагч

10. Сүмбээгийн Сүхээ - Нийслэлийн ОСНАА-н 1 дүгээр конторын дарга

11. Батын Халтар - Увс аймгийн Өлгий сумын татварын албаны байцаагч

12. Гомбын Цэрэндорж - Нийслэлийн "Бадмаараг" ХЭАА-н архитекторч

13. Номхоны Шүрхүү - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын өндөр настан

14. Батчулууны Ядамсүрэн - Дархан-Уул аймгийн "Дархан орд харш" ХХК-ийн ажилтан

15. Дэндэвийн Янжин - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ахмадын хорооны зохион байгуулагч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 8 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 134** **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай

"Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай" Монгол Улсын Их Хурлын 1999 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасныь:

а/Улсын Их Хурлын 1999 оны 29 дүгээр тогтоолын хавсралтад заасан бөгөөд шилжүүлэх хугацаанд хувьчлагдсанаас бусад эд хөрөнгийг 1997 оны төрийн өмчийн тооллогын бүртгэлийн хамт аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх ажлыг 1999 оны 10 дугаар сарын 1-ний дотор багтаан зохион байгуулсугай;

б/аймаг, нийслэлийн өмчлөлд шилжүүлэх эд хөрөнгийг хүлээлцэх ажлын хэсэгт Төрийн өмчийн хороо, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас холбогдох хүмүүсийг томилон ажиллуулж хөрөнгийн бүртгэл, тооллогын баримт болон хувьчлалын бэлтгэл ажлыг хангах явцад бүрдүүлсэн материалыг эд хөрөнгийн хамт актаар хүлээлцсүгэй;

в/төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчлөлд шилжиж байгаа эд хөрөнгийг дутуу шилжүүлэх, өмч хөрөнгийг нуун дарагдуулах, хөрөнгө шилжүүлж байх явцад үрэгдүүлэх, шамшигдуулах зэрэг хууль бус үйлдэл гаргуулахгүй байх бүх талын арга хэмжээ авч, зөрчил дутагдал гаргасан тохиолдолд бүрүүсий этгээдтэй хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажилласугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулан шийдвэрлүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Төрийн өмчөөс аймаг, нийслэлд өмч шилжүүлэх ажлын хэсэгт төвөөс ажиллах хүмүүсийн томилолтын зардлыг хянаж, санхүүжүүлэхийг Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Очирсүхэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

САНГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **Я.ОЧИРСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр **Дугаар 136** **Улаанбаатар хот**

“Далай ашиглах тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Далай ашиглах тухай Монгол Улсын хуулийн гуравдугаар бүлгийн 9 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1.Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн боомтыг Дэд бүтцийн хөгжлийн яамыг түшиглэн одоогийн орон тоо, төсөвт багтаан байгуулахыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүүд даалгасугай.

2.“Хөлөг онгоц бүртгэх журам”-ыг хавсралтын ёсоор батлсугай.

3. Далай ашиглах тухай хуулийг тус тусын эрхлэх ажлын хүрээний дагуу хэрэгжүүлэхийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн, Дэд бүтцийн хөгжлийн сайд Г. Батхүү, Гадаад харилцааны сайд Н.Туяа нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД **Ч.СОДНОМЦЭРЭН**

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД **Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 1999 оны 136 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХӨЛӨГ ОНГОЦЫГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын Төрийн далбаа мандуулан гадаад их далайд хөвөх хөлөг онгоцыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

2.Монгол Улсын Төрийн далбаа мандуулан гадаад их далайд хөвөх хөлөг онгоцыг бүртгэхэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, далайн хуудалдааны боомтын талаархи олон улсын конвенци болон бусад эрх зүйн баримт бичиг, энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Хөлөг онгоц бүртгэх, бүртгүүлэх

3.Хөлөг онгоцны бүртгэлийг (цаашид "бүртгэл" гэнэ) хөлөг онгоцны бүртгэлийн боомт (цаашид "бүртгэлийн боомт" гэнэ) хөтөлж, хяналт тавина.

4.Хөлөг онгоц бүртгүүлэх иргэн, хуулийн этгээд бүртгүүлэх өргөдлөө холбогдох хавсаргалтын хамт бүртгэлийн боомтод гаргана.

5.Өргөдөлд дараахь баримтыг хавсаргасан байна:

а/хөлөг онгоц олон улсын Регистрийн шаардлага хангаж байгаа тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

б/ хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүний жагсаалт олон улсын конвенцид нийцэж буйг баталсан мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

в/хөлөг онгоцны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал олон улсын конвенцийн шаардлагад нийцэж буйг баталсан мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

г/хөлөг онгоц олон улсын конвенцийн шаардлагад нийцсэн холбооны тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

д/эзэхүү жүрмын гуравт заасан хөлөг онгоцны бүртгэлд тусгахад шаардагатай баримт бичгийг бүрдүүлсэн байна.

Гурав. Хөлөг онгоцны бүртгэл

6. Бүртгэлд дараахь зүйлийг тусгана:

а/хөлөг онгоцны нэр, түүнчлэн өмнө байсан нэр (урьдах бүртгэлд нь заагдсан тохиолдолд);

б)хөлөг онгоцны албан ёсны дугаар, таних тэмдэг;

в)хөлөг онгоцыг үйлдвэрлэсэн он, сар, өдөр, үйлдвэрлэгчийн нэр;

г)өмчлөгч, эзэмшигчийн нэр, хаяг, харьяалал, иргэн, хуулийн этгээд эсэх;

д)хөлөг онгоцны өмчлөгч, эзэмшигчид нэгээс илүү тохиолдолд тэдгээрийн нийлүүлсэн оролцооны байдал;

е)хөлөг онгоцыг бербоут чартераар (баггүй түрээслэх) эзэмшиж буй талын нэр, хаяг болон харьяалал;

ж)хөлөг онгоцоор худалдаа, тээврийн болон бусад үйл ажиллагаа явуулах талын нэр, хаяг болон харьяалал;

з)хөлөг онгоцны урьдах бүртгэлийг хүчингүйд тооцсон он, сар, өдөр (хөлөг онгоцыг бүртгэхээс өмнө бүртгэлийн боомт нь урьдах бүртгэл хүчингүй болсон эсэхийг албан ёсоор шалгасан байна);

и)хөлөг онгоцны олон улсын даацын гэрчилгээний бүрдүүлэлт;

к)хууль тогтоомжийн дагуу тодорхойлогдсон хөлөг онгоцны барьцаа эсвэл бусад баталгаа (ипотека).

7.Бүртгэлд дараахь байдлаар эзэмшигдэж байгаа хөлөг онгоцны талаар нэмэлт тэмдэглэл хийнэ:

а/50-иас дээш хувийг иргэн, хуулийн этгээд эзэмшиж буй тохиолдолд энэ тухай;

б/Монгол Улсын иргэн, эсвэл итгэмжлэгдсэн статустай хүнээр төлөөлүүлсэн бол энэ тухай;

в/манай улсад өөрийн хууль ёсны төлөөлөгчтэй гадаадын компани эзэмшиж байгаа бол энэ тухай.

Дөрөв. Бүртгэлийн гэрчилгээ олгох

8.Бүртгэлийн боомт нь бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцонд "Бүртгэлийн гэрчилгээ" олгоно.

9.Бүртгэлийн гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

а/гэрчилгээний дугаар;

б/хөлөг онгоцны техникийн үзүүлэлт, загвар, нэр, таних тэмдэг;

в/хөлөг онгоцны цэвэр даац;

г/өмчлөгч, эзэмшигчийн нэр;

д/бүртгэлийн гэрчилгээний үйлчлэх хугацаа;

е/бүртгэсэн бүртгэлийн боомт;

ж/гэрчилгээ олгосон он, сар, өдөр;

з/гэрчилгээний хугацаат сунгасан он, сар, өдөр.

10. Бүртгэлийн гэрчилгээний хугацаа нэг жил байна. Гэрчилгээний хугацаа дуусмагц хөлөг онгоц эзэмшигч, өмчлөгч нь бүртгэлийн боомтод мэдэгдэж гэрчилгээний хугацаагаг сунгуулна.

11.Бүртгэлийн боомт гэрчилгээг ажлын 30 хоногт олгоно.

12.Хөлөг онгоцны гол шинж чанар, загвар, даац эсвэл хөлөг онгоцны нэр зэрэг бүртгэлд тусгагдсан зүйлс өөрчлөгдсөн тохиолдолд хөлөг онгоц өмчлөгч, эзэмшигч нь бүртгэлийн боомтод мэдэгдэнэ. Бүртгэлийн боомт нь энэ өөрчлөлтийг тусган бүртгэлийн гэрчилгээг шинэчлэн олгоно.

13.Хөлөг онгоц өмчлөгч, эзэмшигч нь бүртгэлийн гэрчилгээг бусдад дамжуулан хэрэглэх, барьцаалахыг хориглоно.

Тав.Бүртгэлээс хасах

14.Бүртгэлийн боомт гэрчилгээг бүртгэлээс хасна.

15.Хөлөг онгоцыг "Далай ашиглах тухай" хуулийн 11 дүгээр зүйлийн 4-т зааснаас гадна дор дурдсан тохиолдолд бүртгэлээс хасна:

а)хөлөг онгоц нь гадаадын бүртгэлд давхар бүртгэгдсэн байвал (бербоут чартерын гэрээгээр хөлслөгдсөнөөс бусад үед);

б)хөлөг онгоц сүйрсэн бол.

16.Бүртгэлийн боомт нь хөлөг онгоцыг бүртгэлээс хассан тухайгаа хөлөг онгоц өмчлөгч, эзэмшигчид ажлын 5 хоногт мэдэгдэнэ.

17.Хөлөг онгоц өмчлөгч, эзэмшигч нь бүртгэлийн боомт хөлөг онгоцыг шалтгаангүйгээр бүртгэхгүй байх, бүртгэлээс хассан тухай шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр **Дугаар 137** **Улаанбаатар хот**

Төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1. 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь тэдгээрийн ажил, үйлдвэрлэлийн онцлогт харшлахгүй тохиолдолд ажил, албан тушаалынхаа гурав, түүнээс дээш хувийн орон тоонд тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр улсын төсөвт төлөх төлбөр нь хөдөлмөрийн хөлсний нэг сард ногдох доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй байхаар тогтоосугай.

2.Төлбөрийн хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлж, тахир дутуу буюу одой хүний нийгмийн хамгаалллын арга хэмжээнд зарцуулах журам баталж, мөрдүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүх, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын сайд С.Сонин нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

САНГИЙН САЙД **Я.ОЧИРСҮХ**

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД **С.СОНИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр **Дугаар 138** **Улаанбаатар хот**

Шинжлэх ухааны зарим байгууллагын бүтцийн өөрчлөлтийн тухай

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 6, 13 дугаар зүйлийн холбогдох заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн шинжлэх ухааны үндэслэлийг судлан боловсруулах үүрэг бүхий Үндэсний хөгжлийн хүрээлэнг Шинжлэх ухааны академийн харьяанд байгуулсугай.

2.Шинжлэх ухааны академийн Геоэкологийн хүрээлэнгийн газар зүй болон хөрс судлалын салбарыг Газар зүйн хүрээлэн, Биологийн хүрээлэнгийн ботаникийн салбарыг Ботаникийн хүрээлэн, Түүхийн хүрээлэнгийн олон улс судлалын төв, Зүүн хойд Ази судлалын төвийг нэгтгэж Олон улс судлалын хүрээлэн, Баян-өлгий аймаг дахь нийгмийн шинжлэх ухааны төвийг Баян-өлгий аймаг дахь Нийгэм, эдийн засгийн судалгааны төв болгон одоогийн орон тоонд нь багтаан тус тус өөрчлөн байгуулсугай.

3. Анагаах ухааны хүрээлэн, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Эх, нялхсын эрдэм шинжилгээний төвийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны харьяанд шилжүүлсүгэй.

4.Батлан хамгаалах яамны Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнг Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн болгон Батлан хамгаалахын их сургуулийн харьяанд ажиллуулсугай.

5.Энэ тогтоолоор бүтэц, зохион байгуулалтад нь өөрчлөлт орсон эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн тогтоох, судалгааны ажлын чиглэл нь давхардаж байгаа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн зарим нэгжийг шилжүүлж зохистой бүтэц бүй болгох арга хэмжээ авахыг Гэгээрлийн сайд А.Баттөрд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

ГЭГЭЭРЛИЙН САЙД **А.БАТТӨР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Дугаар 139 **Улаанбаатар хот**

Үлгэрчилсэн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

Засгийн газрын 1998 оны 165 дугаар тогтоолоор батлагдсан "Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл /корпораци/-ийн үлгэрчилсэн дүрэм"-ийн 12 дугаар зүйлд дараахь нэмэлт, өөрчлөлт оруулсугай:

1."а" заалтыг "удирдах зөвлөлийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулах бөгөөд холбогдох чиглэлийн жамнаас 2, шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төрийн өмчийн хороо, Шинжлэх ухааны академиас тус бүр 1 төлөөлөлтэй байх" гэж өөрчлөн найруулах;

2."в" заалтын "удирдах зөвлөлийн даргыг" гэсний дараа "...Шинжлэх ухааны академи болон холбогдох чиглэлийн яамтай зөвшилцөн" гэж, мөн заалтын "...олонхийн саналаар" гэсний дараа "4 жилийн хугацаагаар сонгоно. Удирдах зөвлөлийн дарга нь хууль тогтоомж зөрчсөн нь нотлогдсон, эсхүл огцрох хүсэлтээ гаргасан тохиолдолд түүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно. Нэр дэвшигч олонхийн санал авч чадаагүй тохиолдолд дахин нэр дэвшүүлэх замаар асуудлыг шийдвэрлэх" гэж тус тус нэмэх;

3."д" заалтыг "дараахь асуудлыг удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж олонхийн саналаар шийдвэр гаргана:

-нэгдлийн гүйцэтгэх захирлыг сонгох;

-нэгдлийн дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

-нэгдлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн төсвийн хуваарилалтыг батлах;

-нэгдлийн зохион байгуулалтын бүтэц, цалингийн сан, урамшлын жүрмыг тогтоох;

-нэгдлийн үйл ажиллагааны болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;

-нэгдлийг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг батлах" гэж өөрчлөн найруулах.

4."ж" заалтын "Шинжлэх ухааны академи" гэснийг "удирдах зөвлөл" гэж өөрчлөх;

5."к" заалтыг "удирдах зөвлөл гүйцэтгэх захирлыг 4 жилийн хугацаагаар сонгох бөгөөд хариуцсан ажил, үүргээ хангалттүй биелүүлсэн тохиолдолд хугацаанаас нь өмнө түүнийг огцруулах" гэж өөрчлөн найруулах;

6."л" заалтыг "захирлыг сонгон шалгаруулахдаа эрдэм шинжилгээний ажлын дадлага, туршлага, эрдмийн зэрэг, цолын байдал, бизнес, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх мэдлэг, чадвар зэрэг шалгууралт гадна түүний харьяалагдах орон нутгийн татвар, цагдаа, шүүхийн байгууллагын тодорхойлолтыг харгалзах" гэж өөрчлөн найруулах;

7."м" заалтыг "гүйцэтгэх захирал нь удирдах зөвлөлийн даргатай эрдэм шинжилгээний ажил, үйлдвэрлэл, аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааны талаар гэрээ байгуулан ажиллах бөгөөд уг гэрээнд захирлын хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс, урамшуулал, ажлын хариуцлага, эрх, үүргийг тусгана. Энэхүү гэрээг баталгаажуулахын өмнө удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн байна" гэж өөрчлөн найруулах.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

ГЭГЭЭРЛИЙН САЙД **А.БАТТӨР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 140 **Улаанбаатар хот**

Мал тооллого явуулах товыг тогтоох тухай

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

Улсын мал тооллогыг жил бүрийн 12 дугаар сарын 15-22-ны өдөр багтаан явуулж, өмчийн бүх хэлбэрийн мал, тэжээвэр амьтдыг тооллогод бүрэн хамруулан, улсын хэмжээгээр нэг зэрэг тоолж байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

САНГИЙН САЙД **Я.ОЧИРСУХ**

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 8 дугаар сарын 06-ны өдөр **Дугаар 213** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Монгол улсын Автотээвэрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Автотээвэрийн хэрэгслээр нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг хавсралтаар батална.

2. Энэхүү журам батлагдан гарсантай холбогдуулан улс хоорондын нийтийн тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай Автотээвэрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь заалтанд заасан эрхийг Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автотээвэрийн газарт шилжүүлсүгэй.

3. Энэхүү журам батлагдаж байгаатай холбогдуулан Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1998 оны 16 дугаар тушаалын Нийтлэг журам хавсралтын 7 дахь заалтыг хүчингүй болгосугай.

4. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б.Батжав/, Автотээвэрийн газрын дарга /П.Ориг/ нарт үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **Г.БАТХҮҮ**

ДБХ-ийн сайдын 1999 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 213 дугаар тушаалын хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР НИЙТИЙН ТЭЭВЭР, ШУУДАН ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь автотээвэрээр үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, тээвэрийн зах зээлд чөлөөтэй өрсөлдөх орчин бий болгох, дангаар нөөрхох явдлыг хязгаарлах, олон улс түүний дотор хөрш зэрэгцэлдээ орнуудтай тогтоосон тээвэрийн харилцааг өргөжүүлэх, автотээвэрийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн шаардлагыг хангахад төрийн хяналт зохицуулалтыг хүчтэй болгох үүднээс Монгол улсын нутаг дэвсгэрт автотээвэрийн хэрэгслээр нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл /цаашид "Тусгай зөвшөөрөл" гэнэ/-ийг олгох, түүнийг өзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Тусгай зөвшөөрлийг Монгол улсын Автотээвэрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг үндэслэн боловсруулсан энэхүү журам, Автотээвэрийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрмийн шаардлагыг хангасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр олгоно.

3. Тусгай зөвшөөрөл нь тээвэрлэлтийн анги бүрээс дор дурдсан ялгаатай байна. Үүнд:

а. Улс хоорондын нийтийн тээвэрлэлт

б. Хот хоорондын нийтийн тээвэрлэлт

в. Орон нутгийн тээвэрлэлт

г. Хотын дотор болон хот хоорондын тээвэрлэлт

4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгох тусгай зөвшөөрлийн хамт тэдгээрийн автотээвэрийн хэрэгсэл бурт тээвэрлэлтийн ангилалын ялгаа бүрээр өнгийг нь дор дурдснаар ялган зөвшөөрлийн карт олгоно. Үүнд:

- Улс хоорондын тээвэрлэлтэнд - улаан
- Хот хоорондын тээвэрлэлтэнд - шар
- Орон нутгийн тээвэрлэлтэнд - цэнхэр
- Хотын дотор болон хот орчмын тээвэрлэлтэнд - ногоон

5. Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг улс хооронд, хот хооронд Автотээвэрийн асуудал эрхэлсэн төв байгууллага, аймаг хооронд, орон нутаг, хотын дотоохи болон хот орчимд тухайн аймаг, сумын Засаг дарга олгоно.

6. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь тусгай зөвшөөрлийг авахдаа Монгол улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн дагуу зохих хураамжийг төлөх ба тусгай зөвшөөрөл олгохтой холбогдож гарсан үйлчилгээний хөлсийг эрх бүхий байгууллага болон эзэмшигчийн хооронд хийсэн гэрээгээр зохицуулна.

Хоёр. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага

7. Тусгай зөвшөөрлийг дараахи шаардлага хангасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгоно. Үүнд:

а. Нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь улсын бүртгэлийн гэрчилгээтэй байх ба шинээр нийтийн тээврийн ажил эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу бичиг, баримтаа бүрдүүлсэн байх;

б. Зорчигч тээвэрлэх тээврийн хэрэгслийг тогтоосон журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн, тээврийн хэрэгслийн болон жолоочтой холбогдох хууль ёсны татвар, хураамж, даатгалыг бүрэн төлсөн байх;

в. Нийтийн тээврийн ажил эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь зорчигчдын ая тухтай, осол зөрчилгүй зорчих нөхцөл бүрдүүлсэн, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах шаардлага"-ыг бүрэн хангасан тээврийн хэрэгсэлтэй байх;

г. Нийтийн тээврийн ажил эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь тээврийн ажил үйлчилгээ, техникийн талаар гарсан хууль тогтоомжийн мэдлэг дадлага бүхий удирдлагатай байхын зэрэгцүүлэн санхүү эдийн засгийн чадавхтай байх;

д. Зорчигч тээвэрлэлт гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь аялалын чиглэл, зогсох буудал, үйлчилгээний цагийн хуваарь, тээвэрлэлтийн тоо хэмжээ, тээврийн хөлсний үнэ тарифын талаар тээвэрлэлтийг зохицуулах эрх бүхий байгууллагатай тохиролцсон гэрээтэй байх;

е. Жолооч үйлчлэгч, зорчигчдыг тээврийн замд амрах хооллох, хоноглох байр, буудал болон техникийн түргэн тусламж зэрэг нөмгөдэл үйлчилгээний асуудлыг шийдсэн байх;

8. Нийтийн тээврийн ажил эрхлэхийг сонирхогч аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь тусгай зөвшөөрөл авахыг хүссэн өргөдлийг энэхүү журмын 2, 3, 4, 5, 6 дугаар хавсралтад дурьдсан үзүүлэлтийн хамт гаргаж, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад гаргана.

Гурав. Тусгай зөвшөөрөл олгох

9. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь зөвшөөрөл авахыг хүссэн сонирхогчдын өргөдөл, түүнд хавсаргасан баримт, материалыг хянан үзэж зөвшөөрөл олгох шаардлага хангасан эсэхийг тогтооно.

10. Эрх бүхий байгууллага нь өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

11. Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь шаардлагатай гэж үзвэл сонирхогчийн өргөдөл түүнд хавсаргасан баримтуудын талаар дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн шинжээчийг томилон ажиллуулж болно.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг дуусгавар болгох, цуцлах үндэслэл

12. Нийтийн тээврийн ажил эрхлэх зөвшөөрлийг 1-2 жүртэл жилээр олгоно.

13. Тусгай зөвшөөрөл нь олгосон өдрөөс эхлэн заасан хугацаанд хүчинтэй байх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс түүний хугацааг сунгуулах тухай өргөдөл гаргаагүй бол анх товлосон он, сар, өдрийн дараагийн ажлын өдөр болмогц дуусгавар болгоно.

Зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ гаргана.

14. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аж ахуйн нэгж, байгууллага хийсэн ажлын тайлан, статистика мэдээг хугацаанд нь өгсөн байдал, Автотээврийн улсын байцаагчаас өгсөн дүгнэлтийг харгалзан үзнэ.

15. Дараах тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг товлосноос өмнө дуусгавар болгосонд тооцно. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан
- Тусгай зөвшөөрөл авсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд зөвшөөрөлд заасан ажил үйлчилгээг эрхлээгүй
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс эрх бүхий байгууллага уг зөвшөөрлийг данган цуцалсан
- Тусгай зөвшөөрөлд заасныг өөр төрлийн үйл ажиллагаа явуулсан, зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн

16. Зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон нөхцөлд уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

Тав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

17. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллагатай байгуулсан гэрээний дагуу эрх, үүрэг эдэлнэ.

18. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү журамд заасан нөхцөл, шаардлагыг биелүүлж, тусгай зөвшөөрөлд заагдсан үйл ажиллагаагаа эрхлэх

19. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг өөрчлөх шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагатай зөвшилцөнө.

20. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас тогтоосон загвар үзүүлэлтээр өөрийн үйл ажиллагааны талаар тодорхой мэдээллийг гарган өгч байх

21. Тусгай зөвшөөрлийг олгох түүний хугацааг дуусгавар болгох, цуцлахтай холбогдсон гомдлыг Засгийн газрын тээврийн хяналт шалгалтын асуудал эрхэлсэн тохируулагч агентлаг болон шүүхэд гаргаж болно.

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 213 дугаар тушаалаар батлагдсан журмын 1 дүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар . . .

Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автотээврийн газрын даргын 199 . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн . . . дугаар тушаалыг үндэслэн . . . . . аймаг (хот)-ийн . . . . . сум (дүүрэг)-ийн харьяалалтай . . . . . оноосон нэртэй . . . . . -д Автотээврийн хэрэгсэлээр нийтийн тээвэр, шуудан тээвэрлэлтийн үйлчилгээг эрхлэх Тусгай зөвшөөрлийг 199 . . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрөөс . . . . . жилийн хугацаатайгаар олгов.

АВТОТЭЭВРИЙН ГАЗАР

Дэд дарга /. . . . . /

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Гэрээ, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан баримт бичгийн нэр, он, сар, өдөр	Нэмэлт өөрчлөлтийг зөвшөөрсөн шийдвэрийн дугаар, он, сар, өдөр	Нэмэлт өөрчлөлтийн агуулга

Зөвшөөрлийн хугацаа сунгасан тэмдэглэл

Автотээврийн газрын даргын .....оны .....дугаар тушаалаар зөвшөөрлийг .....оны .....дугаар сарын ...ны өдөр хүртэл сунгав.

ДАРГА П.ОРИГ

Автотээврийн газрын даргын .....оны .....дугаар тушаалаар зөвшөөрлийг .....оны .....дугаар сарын ...ны өдөр хүртэл сунгав.

ДАРГА П.ОРИГ

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 213 дугаар тушаалаар батлагдсан журмын 2 дугаар хавсралт

..... аж ахуйн нэгж, байгууллагын
ажил үйлчилгээний хэмжээ, санхүү эдийн засгийн чадавхи

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Өмнөх жилийн гүйцэтгэл	Тухайн жилийн төсөл
1	Тээвэрлэх ачаа	мян.тн		
2	Ачаа эргэлт	мян.ткм		
3	Зорчигчдын тоо	мян.хүн		
4	Зорчигч эргэлт	мян.хкм		
5	Ажил үйлчилгээний орлого	мян.төг		
6	Ашиг	-*-		
7	Орлогын татвар	-*-		
8	Дундаж тариф	төг		
9	Өр	мян.төг		
10	Авлага	-*-		
11	Банкны зээл	-*-		
12	Бэлэн мөнгө	-*-		
13	Дансны үлдэгдэл	-*-		
14	Дүрмийн сан	-*-		
15	Үндсэн хөрөнгө	-*-		
16	Үүнээс: Тээврийн хэрэгсэл	-*-		
17	Үүнээс: Тоног төхөөрөмж	-*-		
18	Үүнээс: Байшин барилга	-*-		
19	Эргэлтийн хөрөнгө	-*-		
20	Ажиллагсадын тоо			
21	Үүнээс: Жолооч			
22	Үүнээс: Засварчин			
23	Үүнээс: Кондуктор			
24	Үүнээс: Бусад			

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 213 дугаар тушаалаар батлагдсан журмын 3 дугаар хавсралт

..... аж ахуйн нэгж, байгууллагын
үйлдвэрлэлийн болон тээвэрлэлтийн хүчин чадал

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Үйлдвэрлэлийн нийт талбай	м	
2	Үүнээс: Техникийн үйлчилгээ засварын байр	-*-	
3	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн битүү зогсоол	-*-	
4	Үүнээс: Автотээврийн хэрэгслийн ил зогсоол	-*-	
5	Суурилуулсан тоног төхөөрөмжийн хүч чадал	кв/цаг	
6	Автотээврийн хэрэгслийн тоо	ш	
7	Үүнээс: Ачааны	-*-	
8	Үүнээс: Автобус	-*-	
9	Үүнээс: Суудлын	-*-	
10	Үүнээс: Тусгай зориулалттай	-*-	
11	Дундаж даац, багтаамж	тн, хүн	

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 213 дугаар тушаалаар батлагдсан журмын 4 дүгээр хавсралт

..... аж ахуйн нэгж, байгууллага,
иргэний автотээврийн хэрэгслийн жагсаалт

д/д	Автотээврийн хэрэгслийн марк	Улсын дугаар	Техникийн хяналтын үзлэгт орсон гэрчилгээний дугаар, хугацаа

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 213 дугаар тушаалаар батлагдсан журмын 5 дугаар хавсралт

..... аж ахуйн нэгж,
байгууллагын тодорхойлолт

1. Аж ахуйн нэгж, байгууллагын байршил.....
.....
.....
харъяалал.....
2. Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны зориулалт.....
.....
үйлчилгээний чиглэл.....
.....
хамрах хүрээ.....
3. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригч, эзний овог, нэр, төрсөн он, сар, өдөр, нас, эр, эм, ам бүл.....
.....
.....
.....
4. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчийн паспортын дугаар.....
үндсэн засаг захиргаа.....
5. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчийн гэрийн хаяг.....
.....
утас, факсны дугаар.....

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 213 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар хавсралт

..... аж ахуйн нэгж,
байгууллагын боловсон хүчний чадавхи

№	Ажил, мэргэжлийн ангилал		Тоо	Ажилласан жил			Мэргэжлийн зэрэг				Боловсрол		
				5 хүртэл	6-15	16-аас дээш	1-2	3-4	5	6	дээд	түүгай	дунд
1	Инженер техникийн ажилтан	Удирдлагын менежмент											
		Инженер механикч											
		Механик, техникч											
		Эдийн засагч ня-бо											
		Бусад											
2	Жолооч /ангилаар/	Б											
		С											
		Д											
		Е											
3	Мэргэжлийн ажилтан	Автозасварчин											
		Цахилгаанчин											
		Гагнуурчин											
		Моторчин											
		Бусад											
4	Кондуктор												

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны аравдугаар сарын 14 №46 (125)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

420. Гэрээ соёрхон батлах тухай 843

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

421. 1999 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай **Дугаар 58** 844

422. Шүүгчийн орон тоо батлах тухай **Дугаар 59** 846

423. Ажлын хэсэг байгуулах тухай **Дугаар 60** 846

424. Хуулийн төсөл буцаах тухай **Дугаар 62** 847

Гурав. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

425. Дүрэм батлах тухай **Дугаар 141** 847

426. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай **Дугаар 142** 851

427. Ерөнхий боловсролын сургуулийн болон дотуур байрны нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай **Дугаар 144** 851

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 1999 оны 6 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн тухай Хөгжлийн Зээлийн Гэрээг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 7-ны өдөр Дугаар 58 Улаанбаатар хот

1999 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1.Улсын Их Хурлын 1999 оны намрын ээлжит чуулганаар дараахь асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай:

Нэг. Төрийн байгуулалтын чиглэлээр:

1/Монголын Үндэсний радио, телевизийн тухай хуулийн төсөл; Монголын мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай хуулийн төсөл;

2/Улс төрийн намуудын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

3/Сонгуулийн хуулийн төсөл;

4/Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7/Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл;

8/Түүхт ойнуудыг тэмдэглэн енгөрүүлэх тухай тогтоолын төсөл;

9/Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10/Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

11/Төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл.

Хоёр. Эдийн засгийн чиглэлээр:

12/Санхүүгийн түрээсийн тухай хуулийн төсөл;

13/Аж ахуйн үйл ажиллагааны бүртгэл, тусгай зөвшөөрлийн тухай хуулийн төсөл;

14/а.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал;

б.Монгол Улсын нутагшилт байршил, хөгжлийн ерөнхий төсөл;

15/Газар хувьчлах тухай хуулийн төсөл;

16/Иргэний хувийн өмчийн газрын тухай хуулийн төсөл;

17/Аялал жуулчлалын тухай хуулийн төсөл;

18/Үнэт цаасны тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

19/Эдийн засгийн чөлөөт бүсийн ерөнхий хуулийн төсөл ;

20/Гадаадын зээл тусламжийг авах, зохицуулах тухай хуулийн төсөл ;

21/Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

22/Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

23/Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

24/Цахилгааны тухай хуулийн төсөл;

25/Дулааны тухай хуулийн төсөл;

26/Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн төсөл;

27/Бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл;

28/Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

29/Автозамын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

30/Худалдааны тухай хуулийн төсөл;

31/Аж үйлдвэрийн тухай хуулийн төсөл;

32/ Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 2000 оны үндсэн чиглэл, Төрөөс 2000 онд баримтлах мөнгөний бодлого.

Гурав. Төсвийн чиглэлээр:

33/Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

34/Үнэлгээний үйл ажиллагааны тухай хуулийн төсөл;

35/Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төсөл;

36/Орлогын албан татвараас чөлөөлөх хөнгөлөх тухай хуулийн төсөл;

37/Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох бүлэг барааны жагсаалтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл. Хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;

38/Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай хуулийн төсөл;

39/1998 оны улсын төсвийн гүйцэтгэл;

40/Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

41/Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

42/Татварын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

43/Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх зарим арга хэмжээний тухай.

Дөрөв. Нийгмийн бодлогын чиглэлээр:

44/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

45/Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

46/Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

47/Жирэмслэх, үр тогтохоос мэс заслын аргаар сэргийлэх, жирэмслэлтийг хожуу хугацаанд таслах тухай хуулийн төсөл;

48/Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн төсөл;

49/Дархлаажуулалтын тухай хуулийн төсөл;

50/Донорын тухай хуулийн төсөл;

51/Нийгмийн даатгалын санхаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

52/Боловсролын даатгалын тухай хуулийн төсөл ;

53/Хөдөлмөрийн арбитрын дүрмийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

54/Эх хэлний тухай хуулийн төсөл;

55/Боловсролын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

56/Конвенцид нэгдэн орох тухай /Эрдэм шинжилгээний ажилтны эрх зүйн байдлын тухай, Багшийн эрх зүйн байдлын тухай/.

Тав. Аюулгүй байдал, гадаад бодлогын чиглэлээр:

57/Дипломат албаны тухай хуулийн төсөл;

58/Төрийн ордны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;

59/Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

60/Төрийн нууцын жагсаалтыг батлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

61/Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн төсөл.

Зургаа. Хууль зүйн чиглэлээр:

62/Захирагааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмын тухай хуулийн төсөл;

63/Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ;

64/Зар сурталчилгааны тухай хуулийн төсөл;

65/Хувийн мөрдөлт, хамгаалалтын тухай хуулийн төсөл;

66/Эрүүгийн хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

67/Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

68/Иргэний хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

69/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл;

70/Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

71/Шүүхийн тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

72/Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

73/Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

74/Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

75/Өршөөл үзүүлэх тухай хуулийн төсөл;

76/Шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагааны тухай хуулийн төсөл;

77/Авилгалтай тэмцэх байгууллагын тухай хуулийн төсөл, түүнтэй холбогдон гарах бусад шийдвэрийн төсөл;

78/Галт зэвсгийн тухай хуулийн төсөл;

79/Гадаад худалдааны арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

80/Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Долоо. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн асуудлаар:

81/Халиун бүгын үндэсний хөтөлбөр;

82/Газрын кадастрын тухай хуулийн төсөл;

83/Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

84/Химийн хорт бодисоос хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

85/Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

86/Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

87/Хаягдал ус зайлуулах, түүнд төлбөр ногдуулах тухай хуулийн төсөл;

88/Хүнсний тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

89/Амьтны аймгийн тухай хуулийн төсөл;

90/Ан агнуурын тухай хуулийн төсөл /шинэчилсэн найруулга/;

91/Аюултай хог хаягдлыг зайлуулахад зөвшөөрөл олгох тухай хуулийн төсөл;

92/Байгалийн нөөц ашиглаган төлбөрийн орлогоос нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг тогтоох тухай хуулийн төсөл;

93/Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай тогтоолын төсөл;

94/Ой мод боловсруулах салбарын үйлдвэрийг сэргээх, тухайн чиглэлээр байгуулагдсан хот, тосгоны хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хөтөлбөр батлах тухай тогтоолын төсөл;

95/ Бусад.

2.Улсын Их Хуралд өмнө өргөн мэдүүлсэн бөгөөд Байнгын хороо, чуулганы хуралдаанаар хэлэлцэж эхэлсэн хуулиудын төслийг намрын чуулганаар хэлэлцэх бэлтгэл хангахыг Байнгын хороодын дарга нарт даалгасугай.

3.Улсын Их Хурлын 1999 оны намрын чуулганаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн Засгийн газраас санаачлах хуулиудын төслийг даруй өргөн мэдүүлэхийг Засгийн газар /Р.Амаржаргал/-т даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 59** **Улаанбаатар хот**

Шүүгчийн орон тоо батлах тухай

Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

1.Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн орон тоог өренхий шүүгч 1, шүүгч 3-аар батлуулсугай.

2.Нийслэлийн шүүхийн шүүгчийн орон тоог 3-аар, нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй, Багануур-Багахаганг дүүргийн шүүхийн шүүгчийн орон тоог түс бүр 1-ээр нэмэгдүүлэн батлуулсугай.

3.Энэ тогтоолыг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 60** **Улаанбаатар хот**

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь**:

1.Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 1999 оны 6 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн тухай Хөгжлийн Зээлийн Гэрээний хэрэгжилтэд яналт тавих ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:
Ц.Ганхуяг - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:
Н.Алтанхуяг - Улсын Их Хурлын гишүүн
С.Баярцогт - Улсын Их Хурлын гишүүн
О.Дашбалбар - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Нямдорж - Улсын Их Хурлын гишүүн
Ч.Улаан - Улсын Их Хурлын гишүүн
Я.Эрхэмбаяр - Улсын Их Хурлын гишүүн

2.Хөгжлийн Зээлийн Гэрээний хэрэгжилтэд яналт тавих үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлын үр дүнг 2000 оны 6 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд танилцуулахыг ажлын хэсэг /Ц.Ганхуяг/-т даалгасугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 62 **Улаанбаатар хот**

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Монгол Улсын Засгийн газраас 1997 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Иргэн хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхлэх тухай" хуулийн төслийн эхний хэлэлцүүлгийн явцад хууль санаачлагч уг төслийг татан авах санал гаргасныг харгалзан хууль санаачлагчид буцаах нь зүйтэй гэж үзсүгэй.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр Дугаар 141 **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ нь:**

1."Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын дүрэм"-ийг хавсралтын ёсоор батлуулсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар тогтоолын нэгдүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

САНГИЙН САЙД **Я.ОЧИРСҮХ**

Засгийн газрын 1999 оны 141 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Монгол Улсын Гаалийн ерөнхий газар /цаашид "Ерөнхий газар" гэнэ/ нь төрийн хууль тогтоомж, стандартыг сахиулах замаар улс орны хэмжээнд гаалийн бодлогыг хэрэгжүүлэх Засгийн газрын тохируулагч агентлаг мөн.

2.Ерөнхий газрын үндсэн зорилго нь:

а/гадаад худалдааны үйл ажиллагааны явцад үндэсний эдийн засагт хор хохирол учруулж болзошгүй үйл ажиллагааг таслан зогсоож, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах;

б/Монгол Улсын хуулиар тогтоосон гадаад худалдаатай холбогдох албан татварыг ногдуулан хураах, улсын төсөвт төвлөрүүлэх;

в/гадаад худалдааны үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд туслалцаа, зөвлөлгөө, үйлчилгээ үзүүлэхэд оршино.

3.Ерөнхий газар нь Монгол Улсын Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллаж, өөрийн хариуцах үүрэгт ажлын талаар Засгийн газар болон Сангийн сайдад шууд

харьцаж тайлагнана.

4.Ерөнхий газар нь Гаалийн тухай болон Гаалийн тарифын тухай хууль, гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах Монгол Улсын бусад хууль тогтоомж, Засгийн газар, Сангийн сайдын шийдвэр, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

5.Ерөнхий газар нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Ерөнхий газрыг байгуулах, татан буулгах

6.Монгол Улсын Гаалийн ерөнхий газрыг байгуулах, татан буулгах асуудал нь Монгол Улсын Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, Гаалийн тухай хуульд үндэслэн Улсын Их Хурлын зохих шийдвэрээр зохицуулагдана.

Гурав.Ерөнхий газрын удирдлагын бүтэц, ажлын зохион байгуулалт

7.Ерөнхий газрын удирдлагын бүтэц нь дарга, хоёр дэд даргаас бүрдэнэ.

8.Гаалийн удирдах төв байгууллагын даргыг Монгол Улсын Засгийн газар, дэд дарга нарыг Ерөнхий газрын даргын санал, Төрийн захиргааны албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Сангийн сайд томилж, чөлөөлнө.

9.Ерөнхий газрын дарга нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Засгийн газар болон Сангийн сайдад ажлаа хариуцан тайлагнана.

10.Ерөнхий газрын дарга Сангийн сайдтай үр дүнгийн тухай ерөнхий гэрээ байгуулж, тус газрын зорилт, чиг үүргийг ханган биелүүлэх ажлыг бүрэн хариуцна.

11.Ерөнхий газрын дарга гаалийн хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргаж, биелэлтийг хангуулна.

12.Ерөнхий газрын дарга нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаалийн боловсон хүчний бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж, түүнд зөвлөх үүрэг бүхий Захиргааны зөвлөлийг байгуулна.

Ерөнхий газрын дарга Захиргааны зөвлөлийг удирдаж, түүний бүрэлдэхүүн, ажиллах журмыг батална.

13.Захиргааны зөвлөлөөр дор дурдсан асуудлыг хэлэлцэнэ:

а/гаалийн боловсон хүчний бодлого;

б/гаалийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтныг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл ногдуулах, урамшуулах;

в/гаалийн улсын байцаагчдын байршил, хөдөлгөөн;

г/гаалийн улсын байцаагчийн эрх олгох, эрхийг түдгэлзүүлэх;

д/гаалийн боловсон хүчинтэй холбогдсон бусад асуудал.

14.Ерөнхий газрын даргын зөвшөөрснөөр Захиргааны зөвлөлөөр хэлэлцэх зарим асуудлыг Төрийн албаны салбар зөвлөлд хэлэлцэн, дүгнэлт гаргуулна.

15.Ерөнхий газар нь гаалийн байгууллагын зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэн зохион байгуулахтай холбогдсон асуудлыг хэлэлцэж, уг асуудлын хамрах хүрээ, онцлогоос хамааран зөвлөмж, санал, дүгнэлт, шийдвэр гаргах Мэргэжлийн зөвлөлтэй байна.

Ерөнхий газрын дарга нь Мэргэжлийн зөвлөлийг удирдаж, хуралдааны дэгийг тогтоох бөгөөд түүний бүрэлдэхүүн, нарийн бичгийн даргыг батална.

16.Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагааны зарчим нь асуудлыг хэлэлцэхдээ гишүүн бүрийн саналыг тусгаж, ердийн олонхийн саналаар шийдвэрлэсэн байх явдал юм.

Мэргэжлийн зөвлөлийн гишүүн нь аливаа асуудлыг хэлэлцэхэд хариуцсан ажил, үүргийнхээ дагуу өөрийн байр, сууриа тодорхойлон, санал, дүгнэлтээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

17.Ерөнхий газрын даргын түр эзгүйд түүний ажлыг дэд дарга нарын нэг орлон гүйцэтгэнэ.

Ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэх байгаа дэд дарга нь Гаалийн тухай хуулиар Ерөнхий газрын даргад олгосон бодлогын болон боловсон хүчнийхээс бусад бүрэн эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, хариуцлагыг хүлээнэ.

Дөрөв.Ерөнхий газрын үүрэг

18.Ерөнхий газар дор дурдсан үүргийг гүйцэтгэнэ:

а/Газлийн тухай болон Газлийн тарифын тухай хуулиар тодорхойлогдсон үндсэн үүрэг;

б/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар болон Сангийн сайдын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах;

в/газлийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцийн хэрэгжилтийг зохион байгуулах;

г/газлийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах;

д/газлийн байгуллагын хөгжлийн хэтийн төлөв (стратегийн төлөвлөгөө)-ийг тодорхойлж, хэрэгжүүлэх;

е/газлийн хяналт, удирдлага, зохицуулалтын оновчтой тогтолцоог бий болгож, газлийн бүрдүүлэлтийг боловсронгуй болгох;

ж/газлийн байгуллагыг мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, тэдгээрийн мэргэшил, мэдлэг, чадварыг байнга дээшлүүлэн, газлийн улсын байцаагчдад ёс зүйн өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх;

з/газлийн байгуллагын хэвийн үйл ажиллагааг явуулах нөхцөлийг бүрдүүлж, материаллаг баазыг бэхжүүлэх;

и/газлийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, газлийн зуучлагч, газлийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч, газлийн тусгай болон баталгаат бүс, татваргүй барааны дэлгүүрийн үйл ажиллагаанд давхар хяналт тавих;

к/гадаадын зээл, тусламжийн барааны борлуулалтын болон гадаадын өрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд давхар хяналт тавих;

л/газлийн хяналт, шалгалт, бүрдүүлэлт, татварын ногдуулалт, барагдуулалт, тайлан гаргах, газлийн зөрчилтэй холбогдон газлийн байгуулагад хэрэглэгдэх маягт, тооцоот хуудас болон бусад баримт бичгийг боловсруулан баталж, мөрдөх;

м/"Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн эталоныг хөтлөж, Дэлхийн газлийн байгууллагаас баталсан нэмэлт, өөрчлөлтийг нэвтрүүлэх, холбогдох яам, газрын дүгнэлтийг үндэслэн барааны ангилал, үндэсний кодыг боловсронгуй болгох;

н/газлийн байгуллагын болон газлийн улсын байцаагчийн шийдвэр, газлийн ажилтны ёс зүй, үйл ажиллагааны талаар гарсан өргөдөл, гомдлыг зохих журмын дагуу хянан шийдвэрлэх;

о/шинжлэх ухаан, боловсрол, хэвлэл мэдээллийн болон бусад байгууллагуудтай хамтран газлийн хууль тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах, сургах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг энэ талаар зохих мэдлэгтэй болгох;

п/газлийн байгуллагын өмч, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, төсвийн хөрөнгийг зүй зохистой зарцуулах.

Тав.Ерөнхий газрын эрх

19.Ерөнхий газар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/Газлийн тухай болон Газлийн тарифын тухай хуулиар тогтоосон бүрэн эрх;

б/газлийн асуудлаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, тэдгээрийг боловсронгуй болгох болон хэрэгжилтийн талаар санал, дүгнэлт гаргах;

в/тарифын болон тарифын бус хязгаарлалт, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох барааны талаар санал боловсруулах;

г/газлийн асуудлаар олон улсын болон хоёр талын гэрээ, хэлэлцээрийн төсөл боловсруулах, тэдгээрт болон олон улсын конвенцид нэгдэн орох асуудлыг судалж, эрх бүхий байгууллагад санал оруулах;

д/Ерөнхий газар болон дэргэдэх байгуулла-гуудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах;

е/газлийн улсын байцаагчийн мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэн, тэдгээрт мэргэшлийн зэрэг олгох журмыг тогтоох;

2.Ерөнхий боловсролын сургуулийн болон сурагчдын дотуур байрны цахилгаан, дулаан, ус, тээврийн зардлыг тухайн сургуулийн байршил, хэв шинжийг харгалзан төсвөөс санхүүжүүлж байсугай.

3.Ерөнхий боловсролын сургуулийн болон сурагчдын дотуур байрны нэг сурагчид
ногдох хувьсах зардлын хэмжээг үндэслэн сургуулийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж байхыг төсвийн захирагч нарт даалгасугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Ерөнхий боловсролын сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардлын хэмжээ тогтоох тухай" Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 91 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

ГЭГЭЭРЛИЙН САЙД **А.БАТТӨР**

САНГИЙН САЙД **Я.ОЧИРСҮХ**

Засгийн газрын 1999 оны 144 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ТӨВ, НИЙСЛЭЛИЙН СУРГУУЛИУДЫН НЭГ СУРАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

	Аймгийн төв, нийслэлийн сургуулийн нэг сурагчид ногдох хувьсах зардал (төгрөгөөр)			Нэг сурагчид ногдох хувьсах зардлаас цалин, нэмэгдэл хөлс, шимтгэлд ногдох хэмжээ (хувиар)		
	Бага анги	Дунд анги	Ахлах анги	Бага анги	Дунд анги	Ахлах анги
Архангай	44494	54191	60658	92.6	93.9	94.6
Баян-өлгий	47412	59090	61800	90.6	92.5	92.8
Баянхонгор	44766	54463	60930	92.0	93.5	94.2
Булган	44494	54191	60658	92.6	93.9	94.6
Говь-алтай	45220	54917	61384	91.1	92.7	93.5
Дорноговь	44544	54945	60708	92.5	93.9	94.5
Дорнод	44766	54463	60930	92.0	93.5	94.2
Дундговь	44150	53847	60314	93.3	94.5	95.1
Завхан	45220	54917	61384	91.1	92.7	93.5
Өвөрхангай	44150	53847	60314	93.3	94.5	95.1
Өмнөговь	44716	55117	60880	92.1	93.6	94.2
Сүхбаатар	44766	55167	60930	92.0	93.5	94.2
Сэлэнгэ	44214	53911	60378	93.2	94.4	95.0

Төв	43961	53658	60125	93.7	94.9	95.4
Увс	45536	55937	61700	90.5	92.3	93.0
Ховд	45536	55937	61700	90.5	92.3	93.0
Хөвсгөл	44802	54499	60966	92.0	93.4	94.1
Хэнтий	44372	54069	60536	92.9	94.1	94.8
Дархан	43820	53517	59984	93.5	94.6	95.2
Улаанбаатар	42723	52420	58887	95.9	96.6	97.0
Орхон	43928	53625	60092	93.2	94.5	95.0
Говьсүмбэр	44033	53730	60197	93.6	94.7	95.3
Бусад	42723	52420	58887	95.9	96.6	97.0

Засгийн газрын 1999 оны 144 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

АЙМГИЙН ТӨВ, НИЙСЛЭЛИЙНХЭЭС БУСАД СУРГУУЛИУДЫН НЭГ СУРАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР

Аймгийн төв, нийслэлд байрладаг	Аймгийн төвөөс алслагдсан байдал			Сумын төвөөс алслагдсан байдал		Бие эрхтний бөлөн сулын хаана согогтой хүүхэд сурдаг тусгай сургууль
	50 хүртэлх км	50-150 км	150-иас дээш км	30 хүртэлх км-т орших багийн бага сургууль	30-аас дээш км-т орших багийн бага сургууль болон Говьсүмбэр аймгийн Баянтэлийн сургууль	
I бүс	II бүс	III бүс	IV бүс	V бүс	VI бүс	VII бүс
1.0	1.016	1.048	1.083	1.121	1.300	2.955

ТАЙЛБАР: Нийслэлийн Багахангай, Налайх, Гачуурт, Жаргалант, Сонгино, Биокомбинат, Төрхурах, Гавьжийн шанд дахь сургуулиуд 2 дугаар бүсэд хамаарна.

Засгийн газрын 1999 оны 144 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ДОТУУР БАЙРАНД АМЬДАРДАГ НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

№	Аймаг, хотын нэр	Нэг хүүхдэд шаардагдах хувьсах зардлын хэмжээ (төгрөгөөр)
1	Архангай	105575
2	Баян-өлгий	105180
3	Баянхонгор	105160
4	Булган	105443
5	Говь-алтай	106047
6	Дорноговь	106325
7	Дорнод	105112
8	Дундговь	105682
9	Завхан	105570
10	Өвөрхангай	106003
11	Өмнөговь	106091
12	Сүхбаатар	105399
13	Сэлэнгэ	105760
14	Төв	106237
15	Увс	105000
16	Ховд	105891
17	Хөвсгөл	105375
18	Хэнтий	105477
19	Дархан	105920
20	Улаанбаатар	106671
21	Орхон	105048
22	Говьсүмбэр	105730

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны аравдугаар сарын 26 №47 (126)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

428. Монгол Улсын Хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (1999-10-14-ний хууль) 856

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

429. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 63 856
430. Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай Дугаар 64 856
431. Орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 65 858
432. Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Дугаар 66 858
433. Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 67 858

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

434. Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 166 858
435. Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 167 859
436. Д.Пунцагийг Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчээс чөлөөлөх тухай Дугаар 168 859
437. Д.Пунцагийг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай Дугаар 169 859
438. М.Довчинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 170 859
439. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 171 860
440. Зарим аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 172 860
441. Сум дундын зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 173 860

Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

442. Дүрэм батлах тухай Дугаар 146 861
443. Хөтөлбөр батлах тухай Дугаар 147 864
444. Өрхийн эмнэлэг байгуулан ажиллуулах тухай Дугаар 149 869
445. Дүрэм батлах тухай Дугаар 150 872

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 65** **Улаанбаатар хот**

Орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 1999 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх тухай хуулийн төслийг тодорхой аж ахуйн нэгжийн хувьд тусгайлсан байдлаар хууль гаргаж татвараас чөлөөлөх, хөнгөлөх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 66** **Улаанбаатар хот**

Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: нэмэгдүүлсүгэй.

Төрийн өндөр албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10 хувиар

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 67** **Улаанбаатар хот**

Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 1999 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслийн агуулга нь үзэл баримтлалтайгаа зөрчилдсөн, хуулиар зохицуулах харилцааг Засгийн газрын эрх зүйн актаар зохицуулахаар тусгасан зэрэг хуульд тавигдах ерөнхий шаардлага хангаагүй байх тул уг төслийг хууль санаачлагчид буцаасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр **Дугаар 166** **Улаанбаатар хот**

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 51 дүгээр зүйлийн 1-ийн 1, 2, 4 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Дашдоржийн Дэмбэрэлцэрэнг Улсын дээд шүүхийн шүүгчийн, тэтгэвэрт гарах насанд хүрсэн Цэрэнгийн Сайнбаярыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, дээд шатны шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Ламжавын Ганболдыг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Содномтүнрэвийн Будыг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Дугаар 167 **Улаанбаатар хот**

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 15, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ламжавын Ганболдыг Өмнөговь аймгийн шүүхийн шүүгчийн, Содномтүнрэвийн Будыг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгчийн, Нямын Амарзаяаг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Арвинбуянгийн Энхбаатарыг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Дугаар 168 **Улаанбаатар хот**

Д.Пунцагийг Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох болсонтой холбогдуулан Дуламын Пунцагийг Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Дугаар 169 **Улаанбаатар хот**

Д.Пунцагийг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Дуламын Пунцагийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 170 **Улаанбаатар хот**

М.Довчинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад олон жил идэвх санаачилга, ур бүтээлтэй ажиллаж, морин хуурыг чадварлаг эзэмшин, олон арван дан болон найрал дуу, бүжиг, жүжгийн хөгжим туурвиж, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Ховд аймгийн Хөгжимт драмын театрын хөгжимчин Мижидийн Довчинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

газрын тохируулагч агентлагийн даргын санал болгосноор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

5.Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагааг улсын ерөнхий байцаагч, улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

6.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагаатай нь холбогдуулан улсын ахлах байцаагч, улсын байцаагчдын үйл ажиллагаанд зөвхөн улсын ерөнхий байцаагч хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгнө. Энэ асуудлаар улсын ерөнхий байцаагчтай улсын байцаагчид гэрээтэй ажилланэ.

7.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид энэ дүрэмд "байцаагч" гэх/ нь үйл ажиллагаандаа Иргэний нисэхийн тухай хууль, олон улсын иргэний нисэхийн байгууллагын Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтад заасан нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах стандарт, журам, заавар, зөвлөмж, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

8.Байцаагч нь үндсэн мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, уг мэргэжлээрээ тэргүүлэх хэмжээнд мэргэшсэн байхын дээр нислэг-техникийн хэргийг тухайн чиглэлээр шинжлэн шалгах тусгай сургалтад заавал хамрагдсан байна.

9.Байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон акт, шийтгэвэр, торгууль, дүгнэлт, албан шаардлагын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.Байцаагч хариуцсан чиглэлээрээ нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагаат хэрэгжүүлэхдээ Иргэний нисэхийн тухай хуулийн 8.3-т заасан албан тушаалтны адил тусгай дүрэмт хувцас хэрэглэх бөгөөд нислэгийн осол, сүйрэл гарсан газарт олон улсын стандартын шаардлагыг хангасан, элдэв хорт нөлөөллөөс найдвартай хамгаалж чадах ажлын тусгай хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хэрэглэнэ. Эдгээр тусгай хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглах, ээмшихтэй холбогдсон харилцааг зохицуулах дүрэм, журмыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь улсын ерөнхий байцаагч хяналт тавина.

11.Нислэг-техникийн хэрэг зөрчлийг арилгах талаар байцаагчаас тодорхойлсон арга хэмжээний заалтыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр иргэний нисэхийн холбогдох бүх байгууллага болон иргэн өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.

12.Нислэг-техникийн албаны үйл ажилагааны зардлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулж батлуулна.

Хоёр.Нислэг-техникийн хэргийн шинжлэн шалгалт хийх

13.Олон улс болон орон нутагт нислэг үйлдэж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт нислэгийн ноцтой хэрэг /осол, сүйрэл/ гарсан тохиолдолд түүнийг шинжлэн шалгах үйл ажиллагааг байцаагч гүйцэтгэн акт тогтооно.

14. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад

улсад бүртгэлтэй агаарын хөлөгт нислэгийн ноцтой хэрэг /осол, сүйрэл/ гарсан тохиолдолд олон улсын гэрээ, журам, стандартад заасны дагуу байцаагчид оролцох буюу эзэмшигчийн хүсэлтээр шинжлэн шалгах үйл ажиллагааг явуулна.

15.Нислэгийн осол сүйрлийг шинжлэн шалгах комиссыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно. Комиссын бүрэлдэхүүнд нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор мэргэжлийн чиглэлийг харгалзан цаг уурын болон бусад шаардлагатай мэргэжлийн хүмүүс, байцаагчийг оруулна. Комиссын бүрэлдэхүүнд осол сүйрэлд орсон агаарын хөлгийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч оролцохгүй бөгөөд улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрсөн тохиолдолд зөвхөн ажиллагчаар байлцана.

16.Нислэг-техникийн хэрэг гарах урьдчилсан нөхцөл бүрдсэн, эвдрэл гэмтэл, нислэгийн зөрчил гарсан тохиолдолд иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эдгээр хэргийг шинжлэн шалгах эрх олгон томилсон комиссын актыг улсын ерөнхий байцаагч хянаж, батална.

17.Шаардлагатай гэж үзвэл нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр гадаадын болон Монгол Улсын мэргэжлийн байгууллага, шинжээчдийг оролцуулж болно. Үүнтэй холбогдон гарах зардлыг Иргэний нисэхийн тухай хуулийн 29.4-т заасны дагуу тухайн агаарын хөлгийг эзэмшигчид хариуцна.

18.Гарч болзошгүй нислэг-техникийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын ерөнхий байцаагч дараахь чиглэлээр хяналт, шалгалтыг зохион байгуулж болно:

а/Иргэний нисэхийн тухай хууль болон Монгол Улсын олон улсын гэрээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хэрэгжүүлж байгаа байдалд;

б/иргэний нисэхийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэд тусгай зөвшөөрөл /лицензи/, гэрчилгээ авсан байдалд;

в/олон улсын болон орон нутгийн агаарын зайн нислэг хөдөлгөөний ажүлгүй байдалд;

г/нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагч, инженер техникийн бүрэлдэхүүний мэргэжлийн түвшин, чадвар, сургалтын байдалд;

д/Монгол Улсын агаарын зайд хууль бусаар нэвтэрсэн агаарын хөлөгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд холбогдох бусад байгууллагатай хамтран шалгах үйл ажиллагаанд.

Гурав.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын байцаагчийн үүрэг,эрх

19.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ерөнхий байцаагч, улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан захиргааны хяналтын улсын байцаагчийн нийтлэг үүрэг эрхээс гадна Иргэний нисэхийн тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлд заасан тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

20.Байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/энэ дүрмийн 13-18 дугаар зүйлд заасан чиглэлээр шинжлэн шалгах ажлыг хэрэгжүүлнэ;

б/гарч болзошгүй нислэг-техникийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Иргэний нисэхийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмыг мөрдөж буй байдал болон акт, албан шаардлагын биелэлтэд хяналт тавина.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Хилийн суман, харуулд алба хааж байгаа офицер, ахлагч хүнсний хангамж үнэгүй эдэлнэ. Энэхүү хүнсний хангамжийн хэмжээг Засгийн газар тогтооно" гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 63** **Улаанбаатар хот**

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Р.Гончигдоржийн өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэж, төрийн тусгай хамгаалалтын зэрэглэлтэй холбоотой асуудлыг иж бүрэн, цогц байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж уг хуулийн төслийг санаачлагчид нь буцаасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 64** **Улаанбаатар хот**

Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтын ёсоор батлалсугай.

2.Нийгмийн салбар дахь хувьчлалыг зохицуулсан хууль батлагдах хүртэл эрүүл мэнд, боловсрол, соёл урлагийн байгууллагуудыг хувьчлах асуудлыг түр түдгэлзүүлж байх нь зүйтэй гэж үзсүгэй.

3.Энэ жагсаалтын долоо дахь бүлэгт дурдсан улсын үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хэсгийг хувьчлах асуудлыг тэдгээрийг хувьчлах бэлтгэл ханган дсаны үндсэн дээр Улсын Их Хурал тухай бүр шийдвэрлэж байхаар тогтоосугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын 1999 оны 64 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧӨӨС ХУВЬЧИЛЖ ҮЛ БОЛОХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Нэг.Төрийн байгууллага

1.Төрийн байгууллагуудын үл хөдлөх эд хөрөнгө;

2.Цэргийн болон түсгай зориулалттай барилга байгууламж, инженерийн техөөрөмж, байлдааны зэвсэг техник, тоног төхөөрөмж;

3.Батлан хамгаалах салбарын цэргийн анги;

4.Монгол Улс дахь гадаад улсын дипломат байгууллагуудын болон олон улсын байгууллагын ажилтнуудын ажиллаж, амьдарч байгаа байр, сууц;

5.Гадаад улс дахь Монгол Улсын төрийн байгууллагуудын байр, сууц.

Хоёр.Дэд бүтцийн салбар

1.Цахилгааны үндсэн сүлжээнд хамрагдах цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилга байгууламж;
2.Хэрэглэгчдийн эзэмшлийн байгууламж хүртэлх цэвэр усны хангамжийн гүний худаг, хэрэглэгчдийн эзэмшлийн байгууламж хүртэлх ариутгах татуургын барилга байгууламж;
3.Улсын геодези зураг зүйн газрын Аэрогеодезийн үйлдвэр, зураг зүйн үйлдвэр, Геодези зураг зүйн нэгдсэн сан;
4.Төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлтийн болон үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, төмөр замын удирдлага зохицуулалтын тоног төхөөрөмж, засварын болон зам, шугам, холбоо, дохиоллын сүлжээ;
5.Нислэгийн хөдөлгөөнийг удирдах, аюулгүй байдлыг хангах барилга байгууламж, онгоц хөөрөх зурвас, нийтийн хэрэгцээний аэродром;
6.Нийтийн хэрэгцээний авто зам, гүүр;
7.Хэрэглэгчдийн эзэмшлийн байгууламж хүртэлх дулааны шугам, насос станц, дулаан хуваарилах төв;
8.Улсын болон анхдагч эталон;
9.Холбооны /цахилгаан шуудан/ үндсэн сүлжээний тоног төхөөрөмж, барилга, байгууламж;
10.Сансрын холбооны газрын станц;
11.Олон улсын АТС.

Гурав. Хүнс, хөдөө аж ахуйн салбар

1.Улсын аюулгүйн нөөц;
2.Төрийн өмчийн мэдэлд байгаа үржлийн цөм сүргийн мал;
3.Малын удмын сангийн үндэсний төв;
4.Мал эмнэлгийн био бэлдмэлийг үйлдвэрлэх, хэрэглэхэд хяналт тавих улсын нэгдсэн лаборатори;
5.Улсын геологийн фонд;
6.Геологийн төв лаборатори;
7.Геологийн судалгааны товчоо;
8.Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори;
9.Аймгийн мал эмнэлэг, үржлийн алба;
10.Биокомбинат.

Дөрөв. Байгаль орчны салбар

1.Ус, цаг уурын хүрээлэн;
2.Цаг уурын мэдээлэл, тооцооллын төв, ус, цаг уурын мэдээллийн улсын фонд;
3.Багаж, хэмжил зүйн товчоо;
4.Байгаль орчны шинжилгээний төв лаборатори;
5.Аймаг, хотын ус, цаг уур, орчны шинжилгээний төв;
6.Нислэгийн цаг уурын төв;
7.Ус, цаг уур орчны шинжилгээний улсын сүлжээнд ордог өртөө, харуул, лаборатори;
8.Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа;
9.Ойн хайгуул, төслийн төв.

Тав. Соёл, боловсролын салбар

1.Шинжлэх ухааны сууль судалгааны хүрээлэн, Их сургуулиуд;
2.Түүх, соёлын холбогдолтой эд хөрөнгө,
3.Баримтат киноны сан.

Зургаа. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар

1.Халдвартын клиникийн эмнэлэг;
2.Сүрьеэгийн клиникийн эмнэлэг;
3.Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төв;
4.Арьсны өвчин судлалын төв;
5.Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлэг;
6.Хавдар судлалын төв;
7.Улсын шүүх эмнэлэг, эмгэг анатомын товчоо;
8.Цус сэлбэлт судлалын төв;
9.Улсын асрамжийн газар.

Долоо.Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хэсэг

1."Говь" /ХК/
2."НИК" /ХК/
3."Худалдаа хөгжлийн банк" /ХК/
4."Монгол даатгал" /УҮГ/
5."МИАТ" /УҮГ/
6."Эрдэнэт" /УҮГ/
7."Монголросцветмет" /ХХК/
8."Монголын цахилгаан холбоо" /ХК/
9.Хөрөнгийн бирж /УҮГ/
10."АПУ" /ХК/
11."Хадгаламж банк" /УҮГ/
12."Сэргээн босголтын банк" /УҮГ/
13.Хар төмөрлөгийн үйлдвэр /УҮГ/
14.Цемент шохойн үйлдвэр /УҮГ/
15.Тушиг даатгал /УҮГ/
16.Мах боловсруулах үйлдвэр /Багахангай, УҮГ/
17."Монгол-Болгар Гео" /ХХК/
18.Монгол-Амикаль /ХХК/

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 65** **Улаанбаатар хот**

Орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 1999 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Орлогын албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх тухай хуулийн төслийг тодорхой аж ахуйн нэгжийн хувьд тусгайлсан байдлаар хууль гаргаж татвараас чөлөөлөх, хөнгөлөх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид буцаасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 66** **Улаанбаатар хот**

Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: нэмэгдүүлсүгэй.

Төрийн өндөр албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10 хувиар

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 67** **Улаанбаатар хот**

Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 1999 оны 6 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслийн агуулга нь үзэл баримтлалтайгаа зөрчилдсөн, хуулиар зохицуулах харилцааг Засгийн газрын эрх зүйн актаар зохицуулахаар тусгасан зэрэг хуульд тавигдах ерөнхий шаардлага хангаагүй байх тул уг төслийг хууль санаачлагчид буцаасугай.

ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр **Дугаар 166** **Улаанбаатар хот**

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 51 дүгээр зүйлийн 1-ийн 1, 2, 4 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Дашдоржийн Дэмбэрэлцэрэнг Улсын дээд шүүхийн шүүгчийн, тэтгэвэрт гарах насанд хүрсэн Цэрэнгийн Сайнбаярыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, дээд шатны шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Ламжавын Ганболдыг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Содномтүнрэвийн Будыг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр **Дугаар 167** **Улаанбаатар хот**

Зарим хүмүүсийг шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 15, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ламжавын Ганболдыг Өмнөговь аймгийн шүүхийн шүүгчийн, Содномтүнрэвийн Будыг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгчийн, Нямын Амарзаяаг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Арвинбуянгийн Энхбаатарыг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр **Дугаар 168** **Улаанбаатар хот**

Д.Пунцагийг Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох болсонтой холбогдуулан Дуламын Пунцагийг Орхон аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 08-ны өдөр **Дугаар 169** **Улаанбаатар хот**

Д.Пунцагийг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Дуламын Пунцагийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 170** **Улаанбаатар хот**

М.Довчинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Урлагийн байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, морин хуурыг чадварлаг эзэмшин, олон арван дан болон найрал дуу, бүжиг, жүжгийн хөгжим туурвиж, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Ховд аймгийн Хөгжимт драмын театрын хөгжимчин Мижидийн Довчинд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 171** **Улаанбаатар хот**

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1-ийн 1, 2, 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр ажилд шилжих болсонтой холбогдуулан Зодогийн Нацагийг Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгчийн, Лувсангийн Баяраа Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн, Бадарчийн Бямбахорлоог Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дамдинжамцын Буянтогтохыг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, өөрөө хүсэлт гаргасан Цэнд-Аюушийн Ичинхорлоог Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Чойжилын Алтанцоожийг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн, тэтгэвэрт гарах насанд хүрсэн Содномдалжирын Цоодолыг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 172** **Улаанбаатар хот**

Зарим аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн дор дурдсан хүмүүсийг аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай. Үүнд:

1. Райханы Асхабилыг Баян-Өлгий аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
2. Ламжавын Цэдэндамбыг Баянхонгор аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
3. Бамбарын Баасанхүүг Говь-Алтай аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
4. Тэрбишийн Энхтуяаг Дорнод аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
5. Зодогийн Нацагийг Орхон аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
6. Пагамын Адъяасүрэнг Өвөрхангай аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
7. Цэвээгмидийн Сумъяаг Өмнөговь аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
8. Дамдинсүрэнгийн Гансүхийг Сүхбаатар аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
9. Лувсангийн Баяраа Сэлэнгэ аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр;
10. Цэрэндоржийн Рашзэвгийг Төв аймгийн шүүхийн ерөнхий шүүгчээр.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 173** **Улаанбаатар хот**

Сум дундын зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн дор дурдсан хүмүүсийг холбогдох аймгийн сум дундын шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай. Үүнд:

1. Силамын Сайраныг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр;
2. Дамдинсүрэнгийн Нацагийг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр;
3. Данзангийн Сарантуяаг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр;

4. Намхайн Цогоог Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн ерөнхий шүүгчээр;

5. Гун-Аагийн Сүрэнг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр;

6. Бадарчийн Бямбахорлоог Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр;

7. Жамбалын Мөнхтуяаг Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчээр;

8. Дамдинжамцын Буянтогтохыг Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр;

9. Жаргалын Сүрэнжавыг Увс аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр;

10. Сандагийн Цэцэгмааг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 146** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Иргэний нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах албаны дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хяналтын дүрмүүд батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 211 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

ДЭД БҮТЦИЙН
ХӨГЖЛИЙН САЙД Г.БАТХҮҮ

Засгийн газрын 1999 оны
146 дугаар тогтоолын хавсралт

НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ХЭРГИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах алба /цаашид "нислэг-техникийн алба" гэх/-ны үйл ажиллагаа нь нислэг-техникийн хэрэг болон нислэг-техникийн хэргийн урьдчилсан нөхцөл үүссэн тухай асуудлыг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх, тэдгээрийн үүссэн шалтгааныг гарсан хохирлын хэмжээг харгалзахгүйгээр үнэн зөвөөр тогтоон Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэж, хэрэг зөрчил цаашид давтагдахгүй байх, таслан зогсооход чиглэгдсэн арга хэмжээг тодорхойлоход оршино.

2. Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагааг Засгийн газрын тохируулагч агентлаг-Дэд бүтцийн улсын хяналтын албаны бүтцэд байгаа Нислэг-техникийн алба хийж гүйцэтгэнэ.

3. Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ерөнхий байцаагчийг Засгийн

газрын тохируулагч агентлагийн даргын санал болгосноор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газраас олгоно.

4.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

5.Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагаат улсын ерөнхий байцаагч, улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

6.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагаатай нь холбогдуулан улсын ахлах байцаагч, улсын байцаагчдын үйл ажиллагаанд зөвхөн улсын ерөнхий байцаагч хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгнө. Энэ асуудлаар улсын ерөнхий байцаагчтай улсын байцаагчид гэрээтэй ажиллана.

7.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид энэ дүрэмд "байцаагч" гэх/ нь үйл ажиллагаандаа Иргэний нисэхийн тухай хууль, олон улсын иргэний нисэхийн байгууллагын Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтад заасан нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах стандарт, журам, заавар, зөвлөмж, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

8.Байцаагч нь үндсэн мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, уг мэргэжлээрээ тэргүүлэх хэмжээнд мэргэшсэн байхын дээр нислэг-техникийн хэргийг тухайн чиглэлээр шинжлэн шалгах тусгай сургалтад заавал хамрагдсан байна.

9.Байцаагч нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон акт, шийтгэвэр, торгууль, дүгнэлт, албан шаардлагын хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.Байцаагч хариуцсан чиглэлээрээ нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ Иргэний нисэхийн тухай хуулийн 8.3-т заасан албан тушаалтны адил тусгай дүрэмт хувцас хэрэглэх бөгөөд нислэгийн осол, сүйрэл гарсан газарт олон улсын стандартын шаардлагыг хангасан, элдэв хорт нөлөөллөөс найдвартай хамгаалж чадах ажлын тусгай хувцас, багаж хэрэгсэл, тоног техөөремж хэрэглэнэ. Эдгээр тусгай хувцас, багаж хэрэгсэл, тоног техөөремж ашиглах, ээмшихтэй холбогдсон харилцааг зохицуулах дүрэм, журмыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь улсын ерөнхий байцаагч хяналт тавина.

11.Нислэг-техникийн хэрэг зөрчлийг арилгах талаар байцаагчаас тодорхойлсон арга хэмжээний заалтыг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр иргэний нисэхийн холбогдох бүх байгууллага болон иргэн өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.

12.Нислэг-техникийн албаны үйл ажиллагааны зардлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулж батлуулна.

Хоёр.Нислэг-техникийн хэргийн шинжлэн шалгалт хийх

13.Олон улс болон орон нутагт нислэг үйлдэж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт нислэгийн ноцтой хэрэг /осол, сүйрэл/ гарсан тохиолдолд түүнийг шинжлэн шалгах үйл ажиллагааг байцаагч гүйцэтгэн акт тогтооно.

14. Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад

улсад бүртгэлтэй агаарын хөлөгт нислэгийн ноцтой хэрэг /осол, сүйрэл/ гарсан тохиолдолд олон улсын гэрээ, журам, стандартад заасны дагуу байцаагчид оролцох буюу эзэмшигчийн хүсэлтээр шинжлэн шалгах үйл ажиллагааг явуулна.

15.Нислэгийн осол сүйрлийг шинжлэн шалгах комиссыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно. Комиссын бүрэлдэхүүнд нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор мэргэжлийн чиглэлийг харгалзан цаг уурын болон бусад шаардлагатай мэргэжлийн хүмүүс, байцаагчийг оруулна. Комиссын бүрэлдэхүүнд осол сүйрэлд орсон агаарын хөлгийн өмчлөгч, эзэмшигч, ашиглагч оролцохгүй бөгөөд улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрсөн тохиолдолд зөвхөн ажиглагчаар байлцана.

16.Нислэг-техникийн хэрэг гарах урьдчилсан нөхцөл бүрдсэн, эвдрэл гэмтэл, нислэгийн зөрчил гарсан тохиолдолд иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эдгээр хэргийг шинжлэн шалгах эрх олгон томилсон комиссын актыг улсын ерөнхий байцаагч хянаж, батална.

17.Шаардлагатай гэж үзвэл нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах үйл ажиллагаанд улсын ерөнхий байцаагчийн шийдвэрээр гадаадын болон Монгол Улсын мэргэжлийн байгууллага, шинжээчдийг оролцуулж болно. Үүнтэй холбогдон гарах зардлыг Иргэний нисэхийн тухай хуулийн 29.4-т заасны дагуу тухайн агаарын хөлгийг эзэмшигчид хариуцна.

18.Гарч болзошгүй нислэг-техникийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын ерөнхий байцаагч дараахь чиглэлээр хяналт, шалгалтыг зохион байгуулж болно:

а/Иргэний нисэхийн тухай хууль болон Монгол Улсын олон улсын гэрээг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хэрэгжүүлж байгаа байдалд;

б/иргэний нисэхийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэд тусгай зөвшөөрөл /лицензи/, гэрчилгээ авсан байдалд;

в/олон улсын болон орон нутгийн агаарын зайн нислэг хөдөлгөөний аюулгүй байдалд;

г/нисэх бүрэлдэхүүн, нислэгийн удирдагч, инженер техникийн бүрэлдэхүүний мэргэжлийн түвшин, чадвар, сургалтын байдалд;

д/Монгол Улсын агаарын зайд хууль бусаар нэвтэрсэн агаарын хөлөгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд холбогдох бусад байгууллагатай хамтран шалгах үйл ажиллагаанд.

Гурав.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын байцаагчийн үүрэг,эрх

19.Нислэг-техникийн хэргийг шинжлэн шалгах улсын ерөнхий байцаагч, улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан захиргааны хяналтын улсын байцаагчийн нийтлэг үүрэг эрхээс гадна Иргэний нисэхийн тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлд заасан тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

20.Байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/энэ дүрмийн 13-18 дугаар зүйлд заасан чиглэлээр шинжлэн шалгах ажлыг хэрэгжүүлнэ;

б/гарч болзошгүй нислэг-техникийн хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Иргэний нисэхийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмыг мөрдөж буй байдал болон акт, албан шаардлагын биелэлтэд хяналт тавина.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 147** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Сум, суурин газрын дулаан хангамжийн хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор батлсугай.

2.Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тухайн жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламжийг ашиглах замаар шийдвэрлэж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Гадаад харилцааны сайд Н.Туяа, Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД **Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 1999 оны 147 дугаар тогтоолын хавсралт

СУМ, СУУРИН ГАЗРЫН ДУЛААН ХАНГАМЖИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Одоогийн байдал

Монгол Улсад дулаан хангамжийн системийг барилга байгууламжийг халаах, агааржуулалтын системийг дулаанаар хангах, хэрэгцээний халуун усыг бэлтгэх, төрөл бүрийн технологийн зориулалтаар тус тус ашиглаж байна.

Дулаан хангамж нь доорхи хүчин зүйлээс шууд шалтгаалж байна:

а/барилга, байгууламжийн дулаан тусгаарлалт:Барилгын дулаан тусгаарлалт нь тухайн барилгын нэгж талбай, эзлэхүүнд ноогдох дулааны тоо, хэмжээнд нөлөөлдөг гол үзүүлэлт юм. Шинээр төлөвлөж байгаа болон шинэчлэн засварлаж буй барилгын дулааны алдагдлыг гадна хананд 30-60 Вт/м^2, хучилтаар 28-58 Вт/м^2 байсныг 2-3 дахин багасгаж төлөвлөхөөр шийдвэрлээд байна;

б/дулааны эх үүсвэр: сум, суурин газруудад БЗУИ100, НР18, Братск, Минск, Энергия маркийн одоо ашиглагдаж байгаа зуухнууд нь дулааны нөөц ихтэй, ашигт үйлийн коэффициент багатайгаас үйлдвэрлэсэн дулааны өөрийн өртөг өндөр байна;

в/дулааны шугам сүлжээ: төвлөрсөн дулаан хангамжинд өнөөдөр зөвхөн ган хоолойг хэрэглэж, тэдгээрийг эрдэс хөвөнгөөр дулаалан угсармал, цутгамал бетонон болон тоосгон ханатай сувагт угсарч байна. Эдгээрийн дулааны алдагдал 15-30 хувьд хүрч байна. Дулаалагданд ашиглаж буй эрдэс хөвөн нь чийглэгдэх, норох үедээ дулаан тусгаарлах чадвар нь эрс буурдаг учир өнөөгийн шаардлагыг хангахгүй байна;

г/халаалтын систем: өнөөгийн байдлаар нэг ба хоёр хоолойт халаалтын системд радиатор, конвектор, хавиргат яндан зэрэг халаах хэрэгслийг ашиглаж байна. Энэ систем нь хэрэглэгчид хэрэглээгээ тохируулах боломжгүй байна;

д/дулааны тоолуур: өнөөдрийг хүртэл дулааны эрчим хүч хэрэглэсний төлбөр тооцоог хийхдээ бодит хэрэглээг хэмжих тоолуурын заалтыг үндэслэх бус тухайн барилгын талбай, эзлэхүүн зэргийг үндэслэж байгаа нь хэрэглэгч нь дулаанаа хэмнэх, ариг гамтай зарцуулахад анхаарал тавих ямар ч сонирхолгүй болгож байна.

2.Хөтөлбөрийн шаардлага

Хүмүүсийн ажиллаж амьдрах тав тухтай нөхцөлийг хангах, биеэ даан хөгжих боломжтой хямд халаалтыг бий болгох нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Хөгжингүй орнуудад дулаан хангамжийн системийг автоматаар тохируулан программчилан удирдаж байна. Иймд дулаан хангамжийн найдвартай, ашигт үйлийн коэффициент өндөртэй, электронон удирдлага, тохируулга бүхий технологитой эх үүсвэртэй болох, төлбөр тооцооны систем нь хэрэглэгчид дулаанаа хэмнэх хөшүүрэгтэй байх шаардлагатай байна.

Зах зээлийн нөхцөлд дулаан хангамжийн системийг хямд хөрөнгө оруулалтаар

байгуулж сум, суурин газрын дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт

3.Хөтөлбөрийн зорилго:

Энэ хөтөлбөрийн зорилго нь сум, суурин газруудад ертөг зардал багатай, найдвартай, хүмүүс тав тухтай ажиллаж, амьдрах боломж бүхий дулаан хангамжийн системийг бий болгох, дулааны үйлдвэрлэлийг зах хэлэлийн харилцаанд үр ашигтай ажилладаг, байгаль орчинд сөрөг нөлөө багатай болгох явдал мөн.

4.Хөтөлбөрийн зорилт:

Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтуудаар хэрэгжүүлнэ:

а/хэдөөгийн сум, суурин газрын дулааны хэрэглээний болон дулаан хангамжийн системийн өнөөгийн түвшинг тогтоох;

б/дулааны эх үүсвэрт ашигт үйлийн коэффициент нь 70 хувиас багагүй халаалтын тогоог ашиглаж болгож,

дулааны үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;

в/дулаан хангамж, халаалтын системд тэргүүний техник технологийг хэрэглэх;

г/тухайн сум, суурин газрын дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлэхдээ тэргүүний техник, технологитой шинэ эх үүсвэр суурилуулах, одоо байгаа барилгыг дулаалах арга замаар шийдвэрлэх;

д/сум, суурин газар бүрийн дулааны бодит үнийг зуухны ашигт үйлийн коэффициент, түлшний орд газрын байрлал, цахилгаан эрчим хүчний үнэ, усны чанар зэргээс хамааруулан тогтоож, дулааны үйлдвэрлэл, хэрэглээний зарцуулалтыг тоолуураар хэмжиж, төлбөрийг бодит хэрэглээтэй уялдуулдаг болгож, дулааны үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх;

е/дулааны үйлдвэрлэлд сэргээгдэх эрчим хүчийг өргөн ашиглаж болгох.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

5. Хөтөлбөрийг дараахь хугацаанд хэрэгжүүлнэ:

а/эхний үе шат 1999-2000 онд;

б/хоёр дахь үе шат 2001-2005 онд;

в/гурав дахь үе шат 2006-2010 онд.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

6.1999-2000 онд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а/хэдөөгийн сум, суурин газрын дулаан хангамжийн системийн өнөөгийн техник технологи, хэрэглээ, дулааны эх үүсвэрээс агаарын бохирдолтод үзүүлж буй нөлөөлөл, эдийн засгийн байдалд судалгаа тооцоо хийж үнэлэлт, дүгнэлт өгч түвшинг тогтооно. Одоогийн байдлыг үндэслэн тухайн сум, суурин газрын дулаан хангамжийн системийг сэргээх, шинэчлэх зураг төслийг боловсруулна;

б/тухайн орон нутагт тохирсон дулааны эх үүсвэр гаргах техникийг зохион бүтээх, барилгад дулааны алдагдал багатай материал хэрэглэх, шинэ технологийг нэвтрүүлэх, энэ чиглэлээр судалгааны ажилд холбогдох эрдэм шинжилгээний байгууллага, хамтлагийг зохион байгуулж оролцуулна. Өөрийн орны зохион бүтээгчдийн бий болгосон бага хүчин чадлын зуухыг 18 сум, суурин газарт суурилуулж халаалтын нэг улирал хэмжилт, судалгаа хийж хүчин чадал, техникийн үзүүлэлтийг албан ёсоор тогтоож стандартжуулж, баталгаажуулна (Бага хүчин чадлын зуух суурилуулах сум, суурин газрын жагсаалт, дулаан хангамжийн одоогийн байдал"-ыг хавсаргав);

в/2000 онд хэдөөгийн сум суурин газрын эмнэлгийн халаалтын системийг шинэчлэх ажлыг эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.

7.2001-2005 онд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а/хамгийн бага зардал, өртөгтэй дулаан үйлдвэрлэх системийг хэдөөгийн сум, суурин газрын Засаг даргын Тамгын газар, цаг үеийн ажиллагсад станц, харуулууд, нэгдүгээр үе шатанд хамрагдсанаас бусад сум, суурин газар болон зарим төсвийн байгууллагын халаалтын системийг шинэчлэх;

б/дулаан хангамжийн системийн дулаан зөөгч усыг цэвэрлэх, халаалтын системд автоматжуулалт нэвтрүүлэх, халаалтын тохируулга хийх бололцоотой хаалт арматур, яндан хоолойн дулаалга зэрэг шинэ технологийг нэвтрүүлэх;

в/хэрэгцээний халуун усны системийг өвөл, зунгүй ажилладаг болгож зуны улиралд нарны эрчим хүчээр халаадаг хосолсон систем бий болгох;

г/төрөл бүрийн дулааны эх үүсвэрүүдэд судалгаа, туршилт хийсний үндсэн дээр тухайн орон нутгийн түлш, усанд тохирсон, агаарыг бага бохирдуулдаг зуухны сонголт хийж нэвтрүүлэх;

д/тулшний эх үүсвэрээс ихээхэн алслагдсан болон дулааны өртөг нь хэт өндөр газарт барилгуудыг дулаалах арга хэмжээг холбогдох тооцоо судалгааг хийсний үндсэн дээр хэрэгжүүлэх;

е/төвийн эрчим хүчний системд холбогдсон төв суурин газруудад шөнийн цагт эрчим хүчийг нөөцлөх замаар дулаанаар хангах судалгаа тооцоо хийж турших.

8.2006-2010 онд дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а/дулааны хэрэглээний төлбөр тооцоог тоолуурын заалтыг үндэслэн бодитоор хийдэг болгох;

б/дулаан хангамжийн системийг иж бүрэн автоматжуулж, хэрэглэгч өөрийн хэрэглээг тохируулдаг, үйлдвэрлэгч үүнтэй уялдуулан үйлдвэрлэлээ зохицуулдаг системийг бий болгосноор дулааны үйлдвэрлэлийг ашигтай ажилладаг болгох.

Тав.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

9.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүргийг Дэд бүтцийн хөгжлийн яам гүйцэтгэх ба хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

Дэд бүтцийн хөгжлийн яам нь хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгийн талаар жил бүрийн 1 дүгээр улиралд Засгийн газарт тайлагнана.

10.Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

а/хөдөөгийн сум, суурин газрын (21 аймагт) дулаан хангамжийн системийн өнөөгийн техник, технологи, хэрэглээ, агаарын бохирдолтод үзүүлж буй нөлөөлөл, эдийн засгийн байдалд судалгаа тооцоо хийж, өнөөгийн түвшинг тогтоох, зуухны хүчин чадал, техникийн үзүүлэлтийг баталгаажуулж стандартжуулан сум, суурин газарт суурилуулах, барилга байгууламж, орон сууцыг дулаалахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр;

б/дулаан хангамжийн системийн үйл ажиллагаа сайжруулах, зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх байгаль орчинд халгүй техник, технологи нэвтрүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламжаар;

в/үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн халаалтын техник, технало-гийг шинэчлэх, засвар үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг тухайн хэрэглэгчийн хөрөнгөөр тус тус санхүүжүүлнэ.

Зургаа.Хөтөлбөрийн үр дүн

11.Хөтөлбөрийг тодорхой дэс дараалалтай, үе шатаар хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

а/нэгдүгээр үе шатны ажлын дараа хөтөлбөрийн хавсралтад байгаа сум, суурин газрын дулаан хангамж сайжирч, цаашид гүйцэтгэх ажлын чиглэл, шаардагдах хөрөнгө, зардлын нарийвчилсан тооцоо боловсрогдоно;

б/хоёрдугаар үе шатны ажлын дараа тухайн орон нутгийн байгаль цаг уур, түлш, дулааны хэрэглээнд тохирсон хамгийн хямд, байгаль орчинд сөрөг нөлөө багатай дулаан хангамжийн системтэй болсноор төсөвт байгууллагуудын дулаанд зарцуулж буй зардал багасч, хүмүүсийн ажиллах амьдрах нөхцөл сайжирна;

в/гуравдугаар үе шатны ажил хэрэгжсэний дараа хөдөөгийн хүн амын ажиллаж амьдрах нөхцөл сайжирч, соёлын түвшин дээшлэх бөгөөд ялимгаар тэдний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө багасч, нийгмийн хамгаалал дээшилнэ. Сумдын дулаан хангамж нь алдагдалтай үйлдвэрлэлийн салбар байхаа больж зах зээлийн нөхцөлд ашигтай ажилладаг болно. Түлш олборлох, тээвэрлэх болон ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багасна.

БАГА ХҮЧИН ЧАДЛЫН ЗУУХ СУУРИЛУУЛАХ СУМ, СУУРИН ГАЗРЫН ЖАГСААЛТ, ДУЛААН ХАНГАМЖИЙН ОДООГИЙН БАЙДАЛ

№	Аймгийн нэр	Сумын нэр	Ашиглалтад орсон он	Сурагчдын тоо	Хүчин чадал		Халаалт хэдэн онд зогссон	Тайлбар
					Хичээлийн	Дотуур байр		
1	Архангай	Тариат сум, 10 жилийн сургууль	1990	551	440	150	Үгүй	Одоо ажиллаж байгаа үүрэн зуух цаашид найдвартай ажиллах боломж муутай
2	Булган	Хангал сум, 8 жилийн сургууль	1992	551	320	75	1994	Сумын төвийн нэгдсэн халаалт зогссон тул сургууль халаалттүй болсон
3	Баян-өлгий	Цэнгэл сум, 10 жилийн сургууль	1993	760	440	100	1980	Сумын төвийн нэгдсэн халаалт зогссон тул сургууль халаалттүй болсон
4	Булган	Бугат сум, 8 жилийн сургууль						
5	Өмнөговь	Цогт-овоо сум, 8 жилийн сургууль	1961	520	320	175	1997	Сумын төвийн нэгдсэн халаалт зогссон тул сургууль халаалттүй болсон
6	Ховд	Мянгад сум, 10 жилийн сургууль	1975	589	440		1996	
7	Дорноговь	Хатанбулаг сум, 8 жилийн сургууль	1986	318	320		1991	Сумын төвийн нэгдсэн халаалт зогссон тул сургууль халаалттүй болсон
8	Дундговь	Дэлгэрцогт сум, 8 жилийн сургууль	1989	318	320	75	1994	Сумын төвийн нэгдсэн халаалт зогссон тул сургууль халаалттүй болсон
9	Завхан	Тэс сум, 10 жилийн сургууль	1983	894	320/2	75	1991	Сумын төвийн нэгдсэн халаалт зогссон тул сургууль халаалттүй болсон

10	Өверхангай	Өлзийт сум, 10 жилийн сургууль	1964	460	340	57	1995	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
11	Өмнөговь	Мандал-овоо сум, 8 жилийн сургууль	1985	370	320	75	1995	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
12	Сүхбаатар	Дариганга сум, 8 жилийн сургууль	1965	400	260	50	1996	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
13	Сэлэнгэ	Сүхбаатар сум, 4 дүгээр 10 жилийн сургууль	1960	679	320		1990	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
14	Төв	Баянцагаан сум, 8 жилийн сургууль	1987	381	280	80	1993	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
15	Увс	Өндөрхангай сум, 8 жилийн сургууль	1989	381	320	75	1991	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
16	Ховд	Мөст сум, 10 жилийн сургууль	1988	821	360	120	1996	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
17	Хөвсгөл	Бүрэнтогтох сум, 10 жилийн сургууль	1970	606	160	200	1995	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон
18	Хэнтий	Биндэр сум, 10 жилийн сургууль	1982	691	420	80	1991	Сумын төвийн нэгдсэн хаалалт зогссон тул сургуууль хаалалттүй болсон

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 149 **Улаанбаатар хот**

Өрхийн эмнэлэг байгуулан ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн гэрээг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүн амд ойртуулах зорилгоор Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд "Өрхийн эмнэлэг"-ийг бие даалган тухайн жилд эрүүл мэндийн салбарт батлагдсан төсөвтөө багтаан 1999 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн дэс дараатайгаар байгуулан ажиллуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд тус тус даалгасугай.

2.Улаанбаатар хот, аймгийн төвүүдэд 1999-2002 онд байгуулах өрхийн эмнэлгийн тоог 1 дүгээр хавсралтын, "Өрхийн эмнэлгийн үлгэрчилсэн дүрэм"-ийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус батлагсугай.

3.Өрхийн эмнэлгийн санхүүжилтэд мөрдөгдөх "Нэг иргэнээр тооцсон зардлын төлбөр"-ийн хэмжээг жил бүр тогтоон мөрдүүлж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

ГЭГЭЭРЛИЙН САЙД БӨГӨӨД ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ А.БАТТӨР

Засгийн газрын 1999 оны 149 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛААНБААТАР ХОТ, АЙМГИЙН ТӨВҮҮДЭД 1999-2002 ОНД БАЙГУУЛАХ ӨРХИЙН ЭМНЭЛГҮҮДИЙН ТОО

№	Аймаг, дүүргийн нэр	Өрхийн эмнэлгийн тоо				
		Бүгд	1999	2000	2001	2002
1	Архангай	4			4	
2	Баян-өлгий	5				5
3	Баянхонгор	5			5	
4	Булган	4				4
5	Говь-алтай	4			4	
6	Говьсүмбэр	2			2	
7	Дархан-уул	15			8	7
8	Дорноговь	4	4			
9	Дорнод	6			6	
10	Дундговь	3				3
11	Завхан	5				5
12	Орхон	13			5	8
13	Өвөрхангай	4				4
14	Өмнөговь	3			3	
15	Сүхбаатар	3				3
16	Сэлэнгэ	5				5
17	Төв	5				5
18	Увс	5				5
19	Ховд	7	7			
20	Хөвсгөл	8	8			
21	Хэнтий	3			3	
22	Нийслэлийн Сүхбаатар дүүрэг	19	19			
23	Баянзүрх дүүрэг	23	23			
24	Чингэлтэй дүүрэг	20		20		
25	Хан-уул дүүрэг	12		12		
26	Сонгинохайрхан дүүрэг	27			27	
27	Баянгол дүүрэг	25			25	
	Бүгд	239	61	32	92	54

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 150** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор батлалсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 227 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД БӨГӨӨД ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАТХҮҮ

Засгийн газрын 1999 оны 150 дугаар тогтоолын хавсралт

ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ЧАНАРТ ТАВИХ УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналт (цаашид "улсын хяналт" гэнэ)-ын зорилго нь иргэн, хуулийн этгээдээс таримал ургамлын үр, сортын талаархи хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврын биелэлтийг хангуулахад оршино.

2.Улсын хяналтыг таримал ургамлын үр, сортын хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид "байцаагч" гэнэ) хэрэгжүүлнэ.

3.Таримал ургамлын үр, сортын хяналтын улсын ерөнхий байцаагчийг агентлагийн даргын санал болгосноор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлөх бөгөөд улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар олгоно.

4.Таримал ургамлын үр, сортын хяналтын асуудал эрхэлсэн агентлаг болон аймаг, нийслэлд ажиллах таримал ургамлын үр, сортын хяналтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг улсын ерөнхий байцаагчтай зөвшилцөн агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг нь хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд олгоно.

5.Таримал ургамлын үр, сортын хяналтын улсын байцаагч нь үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

6.Байцаагч нь Засгийн газраас загварыг нь

баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр.Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналтын чиглэл

7.Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/үр шинжилгээний лабораториудын шинжилгээний ажлын чанар;

б/тариалангийн бүсүүдэд хийгдэж буй сорт сорилтын ажлын арга зүй, технологийн мөрдөлт;

в/иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн торгон болон сортын үрийн чанар;

г/иргэн, хуулийн этгээдийн худалдан борлуулах, бусдад шилжүүлэх болон импортолсон үрийн чанар;

д/эрлийз үр болон хүнсний ногооны үр үржүүлгийн технологийн мөрдөлт, сорьцын хяналт;

е/иргэн, хуулийн этгээдээс улсын үрийн нөөцийн санд бэлтгэн нийлүүлж байгаа үрийн чанар;

ж/улсын үрийн нөөцийн сангийн үр бэлтгэлт, хадгалалтын технологийн мөрдөлт;

з/иргэн, хуулийн этгээдийн тариалах үрийн чанар;

и/үрийг тариалалтад бэлтгэх, үр ариутгах ажлын технологи, зохион байгуулалтын байдал.

Гурав.Байцаагчийн бүрэн эрх

8.Байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар олгосон нийтлэг үүргээс гадна дор дурдсан үүрэгтэй:

а/энэ дүрмийн 2 дугаар зүйлд заасан чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулах;

б/үр, сортын талаархи Монгол Улсын олон улсын гэрээ,конвенци, бусад эрхийн актын хэрэгжилтэд хяналт тавих;

в/хяналт, шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэл, технологийн нууцыг чанд хадгалах;

г/хууль тогтоомжийг чанд сахиж, хөндлөнгийн нөлөөнд автахгүй байх, хяналт, шалгалтад хамрагдаж байгаа этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх;

д/хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах.

9.Байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар тогтоосон улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхээс гадна дор дурдсан бүрэн эрх эдэлнэ:

а/албан үүргээ гүйцэтгэж яваа үедээ үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа ажлын байр, талбайд саадгүй нэвтрэн орох, шинжилгээний дээж авах;

б/тариалах үрийн чанарын шинжилгээний бичиг баримтыг шаардах, үрийг шинжлүүлэх;

в/үр ариутгалын ажлын технологи, зохион байгуулалтыг хянах, ариутгасан үрийг тариалалтаас өөр зориулалтаар ашиглахыг хориглох;

г/хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүнийг арилгах талаар иргэн, хуулийн этгээдэд хугацаатай албан шаардлага, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

д/хяналт шалгалтын ажилд шаардлагатай

мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгуулага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулах;

е/өөрийн гаргасан шийдвэрээ баталгаажуулах зорилгоор үр шинжилгээний лабораториор үр, суулгацын чанарыг шалгуулсны төлбөрийг бууруулах этгээдээр төлүүлэх;

ж/хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хууль заасан захиргааны шийтгэл ногдуулах.

Дөрөв. Хариуцлага хүлээлгэх

10.Таримал ургамлын үр, сортын тухай хууль, Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналтын дүрэм болон таримал ургамлын үр, сортын талаар гарсан шийдвэрийг зөрчсөн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй этгээдэд түүний учруулсан хохирлын хэмжээг харгалзан холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

11.Дор дурдсан зөрчил гаргасан этгээдэд байцаагч Таримал ургамлын үр, сортын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

а/эрлийз үр, хүнсний ногооны үр үржүүлгийн технологи, сорт сорилтын батлагдсан арга зүйг зөрчсөн;

б/үрийн чанарын шинжилгээ, баталгаагүй үр худалдан борлуулсан, бусдад шилжүүлсэн, импортоор оруулсан, шинжилгээний дүгнэлт болон бусад бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн, засварласан;

в/улсын үрийн нөөцийн санд тарих үрийн чанарын шаардлага хангаагүй үр бэлтгэн нийлүүлсэн, хүлээн авсан, үрийн талбайдаа сортын хяналт хийлгээгүй;

г/тарих үрийг үрийн шинжилгээнд хамруулаагүй;

д/мал, тэжээвэр амьтан, техникээр үр, суулгацын материал гэмтээсэн, сортын чанар алдагдуулсан.

Тав. Бусад зүйл

12.Таримал ургамлын үр, сортын чанарт тавих улсын хяналтын байцаагчийн албан шаардлагыг иргэн, хуулийн этгээд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

13.Шалгуулсан иргэн, хуулийн этгээдийн зүгээс шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хуульд заасан хугацааны дотор холбогдох газарт гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

14.Байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны аравдугаар сарын 29 №48 (127)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

446. Хүнсний тухай (1999-10-7-ны хууль) 875
447. Хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (1999-10-7-ны хууль) 881

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

448. Хүнсний тухай хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 61 882
449. Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 68 882
450. Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 69 883
451. Санал хураах комисс байгуулах тухай Дугаар 72 883
452. Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай Дугаар 73 883
453. Байнгын хорооны даргыг сонгох тухай Дугаар 74 884
454. Засгийн газрын гишүүн, хууль зүйн сайдыг томилох тухай Дугаар 75 884
455. Л.Цогийг ажлаас чөлөөлөх тухай Дугаар 76 884

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

456. Д.Батсайханыг Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчээр томилох тухай Дугаар 174 884
457. Журам батлах тухай Дугаар 175 885
458. Ж.Чойжанцанг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 176 885

Дөрөв. Яам, агентлагийн акт

459. Дүрэм, журам батлах тухай (Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайдын тушаал) Дугаар 220 886

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 7-ны өдөр — Улаанбаатар хот

ХҮНСНИЙ ТУХАЙ
/шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хүн амын хүнсний хэрэгцээ, аюулгүй байдлыг хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдон

төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хүнсний тухай хууль тогтоомж

2.1.Хүнсний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."хүнс" гэж хүний бие махбодийн өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах шим тэжээл бүхий хүнсний түүхий эд, бэлдэц, хоол, идээ, ундаа, ундны усыг;

3.1.2."хүнсний аюулгүй байдал" гэж хүнсэнд чанар, эрүүл ахуйн зохистой хэм хэмжээ хангагдсан байхыг;

3.1.3."хүнсний эрүүл ахуй" гэж хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ явуулах явцад хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг;

3.1.4."хүнсний нэмэлт" гэж хүнсийг өвөрмөц чанартай болгох зориулалтаар технологийн дагуу хэрэглэдэг бодис, хольцыг;

3.1.5."зориулалтын хүнс" гэж хүний эрхэлж байгаа хөдөлмөр, бие махбодийн онцлогт тохируулан, эсхүл эмчилгээний зориулалтаар тусгайлан бэлтгэсэн хүнсийг;

3.1.6."стратегийн хүнс" гэж монгол хүн хүнсэндээ хэрэглэж дадсан, хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай мах, буудай, тарианы үр, давс, ундны усыг;

3.1.7."хүнсийг баяжуулах" гэж хүний эрүүл мэндэд чухал шаардлагатай тухайн бүтээгдэхүүнд агуулагддаггүй, эсхүл боловсруулалтын явцад алдагддаг амин дэм, амин хүчил болон бичил бодисуудыг тусгай технологи, стандартын дагуу нэмэхийг;

3.1.8."хүнсний аюулгүйн үзүүлэлт" гэж хүнсэн дэх нян, мөөгөнцөр, тэдгээрийн хор, физик, химийн бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээг;

3.1.9."хүнсний аюулгүйн анхан шатны үзүүлэлт" гэж мэдрэхүйгээр буюу түргэвчилсэн шинжилгээний аргаар тодорхойлогдох эрүүл ахуйн хэм хэмжээг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

4.1.Улсын Их Хурал хүнсний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.хүн амын хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.1.2.стратегийн хүнс үйлдвэрлэдэг үйлдвэрлэгчдийг Засгийн газрын саналыг үндэслэн төрийн санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих;

4.1.3.улсын нөөцийн хүнсний нэр төрлийг тогтоох,өөрчлөх.

5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

5.1. Засгийн газар хүнсний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.улсын нөөцийн хүнсийг бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, зарцуулах, нөхөн сэлбэх журмыг тогтоох, шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгаж шийдвэрлүүлэх;

5.1.2.хүн амын үндны усны хайгуул хийх, усны нөөц, уст цэгийг нэмэгдүүлэх, ус цэнгэгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

5.1.3.хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, хүнсийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын журам тогтоох;

5.1.4.хүн амын үндны усны эх үүсвэр, усан хангамжийн байгууламжийг хамгаалалтад байлгах,түүнд хяналт тавих журам тогтоох;

5.1.5.стратегийн хүнсний үйлдвэрлэлд улсын захиалга өгөх, хөнгөлөлттэй зээл олгох;

5.1.6.өргөн хэрэглээний хүнсийг баяжуулах үйлдвэрлэлийг дэмжих;

5.1.7.хүн амын хүнсний бодит хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа болон зориулалтын хүнс хэрэглэгчийн хоолны нормын хангалтад судалгаа, дүгнэлт хийж, жил тутам Улсын Их Хуралд мэдээлэх;

5.1.8.тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэх хүнсний үйлдвэрлэл эрхлэх зөвшөөрлийг хуульд заасны дагуу олгох;

5.1.9.хүнсний аюулгүй байдалд тавих хяналтын дүрмийг батлах.

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

6 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

6.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.хүнсний хангамж, аюулгүй байдлыг харгалзан тухайн жилд импортлох, экспортлох мал, стратегийн хүнсний нэр төрөл, хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх;

6.1.2.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх технологи болон үргамал, амьтны гаралтай түүхий эдийн ариун цэвэр, эрүүл ахуйн нийтлэг журам, хэм хэмжээ, шаардлагыг тогтоох;

6.1.3.тусгай зөвшөөрөлтэй үйлдвэрлэх хүнсний үйлдвэрлэл эрхлэх хүсэлтийг зохих журмын дагуу хянаж, саналаа Засгийн газарт оруулах;

6.1.4.хүнсний тэжээллэг чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, уламжлалт болон дэвшилтэт технологийг нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.

6.2.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.2.1.хүнс, түүний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч этгээдээс хүнсний эрүүл ахуй, ариун цэвэр, аюулгүй байдлыг хангах талаар мөрдөх нийтлэг журам, заавар, үзүүлэлтийг батлах;

6.2.2.хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрт хэрэглэж байгаа пестицид, эм, даавар, бордоо, химийн бусад бодис, хүнд металлын үлдэгдэл, цацраг идэвхт бодис, бичил биетэн, хүнсний нэмэлт, бусад хольцын эрүүл ахуйн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоож, үндэсний стандартад тусгах;

6.2.3.хүнсийг баяжуулахад шаардлагатай бичил бодисын зохистой хэмжээг тогтоох.

7 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

7.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэрийнхээ хүн амын хүнсний аюулгүй байдлын талаархи бодлого, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

7.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1.нутаг дэвсгэрийнхээ хүн амын хүнсний аюулгүй байдлын талаархи бодлого, хөтөлбөр боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэх;

7.2.2.нутаг дэвсгэрийнхээ хүн амын хүнсний аюулгүй байдлын талаархи бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, хүн амын хэрэгцээний бодит гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах, холбогдох асуудлыг зохих байгууллагад уламжлах;

7.2.3.иргэн, хуулийн этгээд хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх нөхцөлийг бүрдүүлэхэд тусламж дэмжлэг үзүүлэх;

7.2.4.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа орчинд хүнсэнд бохирдолт үүсгэх нөлөө бухий үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн хориглох;

7.2.5.хүн амыг ундны усаар хангах ажлыг зохион байгуулж, ундны усны эх булаг, сан, ус түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад байгуулламжийн аюсигалт, хамгаалалтад хяналт тавих.

7.3.Аймаг, нийслэл нь хүнсний тодорхой хэмжээний нөөцтэй байж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хүнсний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдал

8 дугаар зүйл. Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийн эрх

8.1.Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээд дараахь эрхтэй:

8.1.1.бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийх эрх бүхий лабораторийг сонгох;

8.1.2.үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдуулан гаргасан дүгнэлт, авсан арга хэмжээний талаар улсын байцаагчаас тайлбар шаардах, тайлбар өгөх, гомдол гаргах.

9 дүгээр зүйл. Хүнсний үйлдвэрлэл,үйлчилгээ эрхлэгч этгээдийн үүрэг, түүнд тавигдах шаардлага, хориглох зүйл

9.1.Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээд дор дурдсан үүрэгтэй:

9.1.1.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээг технологи, стандарт, эрүүл ахуйн шаардлагын дагуу эрхлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах;

9.1.2.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээд үйл ажиллагаагаа эхлэхийн өмнө болон үйл ажиллагаа явуулах явцдаа энэ хуулийн 9.1.1-д заасан шаардлага хангасан тухай мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулсан байх;

9.1.3.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа этгээд нь хэрэгтэгчийн шаардлагаар түүнд энэ хуулийн 9.2.1; 9.2.3; 9.6-д заасан баримт бичгийг үзүүлэх.

9.2.Мал, амьтны болон ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээд дор дурдсан шаардлага хангана:

9.2.1.мал, амьтны болон ургамлын гаралтай хүнсний түүхий эдийг бэлтгэхдээ тухайн нутаг дэвсгэрийн мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн эрх бүхий байгууллагаар магадлан шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргуулсан байх;

9.2.2.хүнсний үйлдвэрлэлийн дотоодын хяналтын лаборатори магадлан шинжилгээ хийх тохиолдолд зохих зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байх;

9.2.3.шинээр үйлдвэрлэж байгаа хүнсийг стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан тухай мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулсны дараа борлуулах;

9.2.4.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах бичил биетэн, химийн бодис, эм, даавар, шавьж мэрэгчийн устгалын хор, цацраг идэвхт бодисыг эрүүл ахуй, халдвар судлал, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн мэргэжлийн хяналтын зохих байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулан,тогтоосон журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх;

9.2.5.хүнс үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх зориулалттай машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав, баглаа боодол, ариутгал цэвэрлэгээний бодис нь чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байх;

9.2.6.хүнсийг чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын дагуу савлаж, шошголох, түүнд тэжээллэг чанар, найрлага, хэрэглэх арга, хадгалах хугацаа, анхааруулгыг заах;

9.2.7.хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэх, тоног төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллагуудтай зөвшилцсөн зураг төсөл, дүгнэлтийн дагуу гүйцэтгэх.

9.3.Иргэн, хуулийн этгээд хүнсний бүтээгдэхүүн импортлохдоо дор дурдсан шаардлага хангана:

9.3.1.бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтүүд нь олон улсын болон үндэсний стандартад нийцсэн байх;

9.3.2.мал, амьтан, шувууны болон түүний мах,өөх, дотор мах, дайвар бүтээгдэхүүн, загас, бусад түүхий эд, өндөг,ургамал, үр, ургамлын гаралтай түүхий эд, зориулалтын хүнс, согтууруулах ундааг импортлохдоо холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагад ажлын 20 өдөрт багтаан мэдэгдэж, тухайн экспортлогч орны эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ болон гэрээг үндэслэн урьдчилан зөвшөөрөл авсан байх;

9.3.3.хүнсний бүтээгдэхүүний дээжид эрүүл ахуйн аюулгүй байдлын шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх.

9.4.Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээд дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.4.1.аюулгүй байдлын шаардлага хангасан тухай мэргэжлийн хяналтын байгууллагаас олгогдсон дүгнэлтгүйгээр хүнсийг нийтэд борлуулах, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах;

9.4.2.бохирдолтын хэмжээ эрүүл ахуй, аюулгүй байдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн хүнсийг үйлдвэрлэх, борлуулах;

9.4.3.мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн лабораториор халдваргүй болохыг нь баталгаажуулаагүй мал, амьтан, тэдгээрээс гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, үр, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн борлуулах.

9.5.Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний технологич нь мэргэжлийн байна.

9.6.Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх иргэн нь эрүүл мэндийн үзлэгт орж, магадлагаа гаргуулсан байна.

10 дугаар зүйл.Улсын хүнсний нөөц

10.1.Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, гоц аюулт халдварт өвчин, гэнэтийн бусад аюул учирч хүнсний хангамжийн ноцтой бэрхшээл тохиолдсон нөхцөлд болон цэргийн дайчилгаанд хэрэглэх зорилгоор улсын нөөцийн хүнсийг

бүрдүүлнэ.

10.2.Улсын нөөцийн хүнсэнд тураг мах, борц, нөөш, амьтны болон үргамлын гаралтай тос, буудай, тарианы үр, гурил, төрөл бүрийн будаа, ёотон, цай, хатаамал сүү, давс, этилийн спирт хамаарна.

10.3.Улсын нөөцийн хүнсний хөдөлгөөн, чанарын талаар Засгийн газар жил бүр Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мэдээлж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт, түүний тогтолцоо

11 дүгээр зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт

11.1.Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг хүнс бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, савлах, тээвэрлэх, борлуулах болон хаягдал ашиглах шатанд хүнсний аюулгүй байдлын шаардлага хангахад чиглүүлнэ.

11.2.Хүнсний аюулгүй байдалд тавих хяналт дараахь хүрээг хамарна:

11.2.1.хүнсний бохирдолтын зөвшөөрөгдөх хэмжээ, заавал мөрдөх стандартын хэрэгжилт;

11.2.2.хүнсний үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, орчны эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага;

11.2.3.импортын хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын үзүүлэлт, шаардлагын мөрдөлт;

11.2.4.мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хот суурин газарт оруулах, нядлах болон түүгээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үед тавигдах мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага, түүний хэрэгжилт;

11.2.5.үр, ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх үед тавигдах ургамлын хорио цээрийн шаардлага түүний хэрэгжилт.

12 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд тавих улсын хяналтын тогтолцоо

12.1. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутагт хяналтын албад эрхлэн зохион байгуулна.

12.2. Хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг Төрийн хяналт, шалгалтын тухай хууль[1] -ийн 21 дүгээр зүйлийн 2, 3, 4, 6 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.

12.3 Мэргэжлийн хяналтын байгууллага дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.3.1.хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлж, хүнсийг улсын хилээр нэвтрүүлэхэд зөвшөөрөл олгох;

12.3.2.аймаг, нийслэл, хилийн хяналтын албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд сургалт зохион байгуулах;

12.3.3.мэргэжлийн хяналтын боловсон хүчнийг давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

12.3.4.чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнс, түүний үйлдвэрлэлийн хэрэгслийг импортлох, экспортлохыг хориглох;

12.3.5.хүнсний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийг судалж, дүгнэлт гарган, авах арга хэмжээний талаар санал боловсруулж, холбогдох байгууллагад оруулах;

12.3.6. хүнсний аюулгүй байдлын талаар мэдээллийн сан бүрдүүлэх.

12.4.Байнгын ажиллагаатай хилийн боомтод хүнсний аюулгүйн үзүүлэлт, бусад боомтод хүнсний аюулгүйн анхан шатны үзүүлэлтийг тодорхойлох лаборатори бүхий хяналтын алба ажиллуулна.

13 дугаар зүйл. Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих улсын байцаагчийн бүрэн эрх

13.1.Хүнсний аюулгүй байдлын хяналтыг хүнсний үйлдвэрлэлийн техник, технологи, эрүүл ахуй, үр, ургамал, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн мэргэшсэн улсын

[1] Төрийн хяналт, шалгалтын тухай хууль-"Ардын эрх" сонины 1990 оны 90, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 4 дүгээрт тус тус нийтлэгдсэн.

байцаагч дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

13.1.1.эрүүл ахуй, халдвар судлалын улсын байцаагч нь хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн эрүүл мэнд, үйлдвэрлэл, үйлчилгээний байр, орчин, үйлдвэрлэлийн дамжлагын эгзэгтэй цэг, хэрэглэхэд бэлэн болсон хүнсний ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдал;

13.1.2.мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь зах зээлд борлогдож байгаа болон нийтийн хоолны газар, боловсруулах үйлдвэрт түүхий эдийн зориулалтаар ашиглаж байгаа мал, амьтан, түүний түүхий мах, өөх, дотор мах, дайвар бүтээгдэхүүн, загас, сүү, цагаан идээ, түүхий өндөг, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийн байр, орчин, үйлдвэрлэлийн дамжлагын эгзэгтэй цэгийн ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдал;

13.1.3.ургамлын хорио цээрийн улсын байцаагч нь төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, ургамлын гаралтай хүнсний бусад түүхий эд болон төмс, хүнсний ногооны зооль, агуулах, нийтийн хоолны газруудын ногоо хадгалах байр, төхөөрөмжийн ариун цэвэр, эрүүл ахуйн аюулгүй байдал;

13.1.4.хүнсний үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагч нь хүнс, түүний үйлдвэрлэлийн хэрэгслийг үйлдвэрлэх, тэдгээрээр үйлчлэхэд мөрдөх технологийн нийтлэг хэм хэмжээ, шаардлагын хэрэгжилт;

13.1.5.стандарт, хяналт баталгаажуулалтын улсын байцаагч нь хүнсний бүтээгдэхүүний техникийн баримт бичиг, үйлдвэрлэлийн зураг төслийг зохиох, боловсруулахаас эхлэн хүнсийг хэрэглэх хүртэлх үйлдвэрлэл, үйлчилгээний бүх үе шатан дахь улсын стандартын мөрдөлт.

13.2.Улсын байцаагч дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.2.1.хүнсний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэл-тийг хангуулах, гарсан зөрчлийг таслан зогсоох, арилгуулах, зөрчил гаргагчид хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх;

13.2.2.хүнсний гаралтай хордлого, хордлогот халдварын шалтгааныг тогтоох, таслан зогсоох, нийтэд шуурхай мэдээлэх;

13.2.3.энэ хуулийн 9.1.2, 9.2.4-т заасан дүгнэлтийг ажлын 5 өдөрт, нөөшилсөн хүнсний зүйлийн шинжилгээ, дүгнэлтийг ажлын 20 өдөрт тус тус багтаан гаргана.

13.3.Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих улсын байцаагч дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

13.3.1.аливаа иргэн, хуулийн этгээдийн хувийн ашиг сонирхлын үүдэнээс болон тэдгээрт давуу байдал олгосон шийдвэр гаргах;

13.3.2.шалгалтын явцад олж мэдсэн нууцыг задруулах;

13.3.3.бүрэн эрхээ урвуулан ашиглах, техник хэрэгслээ зориулалт бусаар ашиглах.

14 дүгээр зүйл. Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих хяналт, баталгаажуулалт

14.1.Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээдийн бүтээгдэхүүний дээжийн ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй байдалд эрүүл ахуй, халдвар судлал, мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн лаборатори магадлан шинжилгээ хийнэ.

14.2.Лабораторийн шинжилгээний үр дүнг үндэслэн улсын хяналтын ахлах болон ерөнхий байцаагч дүгнэлт гарган баталгаажуулна.

14.3.Хүнсний аюулгүй байдалд магадлан шинжилгээ хийх лабораторид стандартчилал, хэмжил зүйн төв байгууллага зохих журмын дагуу итгэмжлэл олгоно.

15 дугаар зүйл. Хүнсний ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих хөндлөнгийн хяналт

15.1.Лабораторийн итгэмжлэл авсан хуулийн этгээд хүнсний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавьж болно.

15.2.Хүнсний хөндлөнгийн хяналтын байгууллагад мэргэжлийн хяналтын байгууллага итгэмжлэл олгоно.

16. дугаар зүйл. Хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих дотоодын болон олон нийтийн хяналт

16.1.Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч этгээд нь эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтлэг шаардлагад нийцүүлэн технологийн горим, ариун цэврийн дүрмийг баталж,түүний стандарт, эрүүл ахуйн шаардлагын хэрэгжилтэд дотоодын хяналт тавина.

16.2.Иргэн, төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг төрийн захиргааны болон хяналтын эрх бүхий байгуулага, албан тушаалтанд мэдэгдэлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийг сэрэмжлүүлнэ

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

17 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

17.1.Хүнсний тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд улсын байцаагч буюу шүүгч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

17.1.1.энэ хуулийн 9.1.1, 9.1.3, 9.2.5, 9.2.6, 9.5, 9.6-г зөрчсөн бол иргэнийг 8000-15000, албан тушаалтныг 10000-20000, хуулийн этгээдийг 60000-150000 төгрөгөөр торгох;

17.1.2.энэ хуулийн 9.1.2, 9.2.1, 9.2.2, 9.2.3, 9.2.4-ийг зөрчсөн бол иргэнийг 15000-30000, албан тушаалтныг 20000-40000, хуулийн этгээдийг 150000-200000 төгрөгөөр торгох;

17.1.3.энэ хуулийн 9.2.7, 9.3, 9.4-ийг зөрчсөн бол иргэнийг 30000-50000, албан тушаалтныг 40000-60000, хуулийн этгээдийг 200000-250000 төгрөгөөр торгох;

17.1.4.хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулах нь лабораторийн шинжилгээгээр нотлогдсон хүнсийг хураан авч устгаж, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгох.

17.2.Зөрчил гаргасан этгээд энэ хуулийн 17.1.2-т заасан зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасаас үйлдвэрлэл, үйлчилгээг үргэлжлүүлэх нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж байгаа бол иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийн тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх эрхийг шүүгч зургаан сарын хугацаагаар хасна.

18 дугаар зүйл. Гомдол гаргах

18.1.Энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан шийтгэлийг үндэслэлгүй ногдуулсан гэж үзсэн иргэн, хуулийн этгээд зохих журмаар гомдол гаргаж болно.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Хүнсний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүнсний тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 74** **Улаанбаатар хот**

Байнгын хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, нууц санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ч.Отгонбаярыг батлуулсугай.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 75** **Улаанбаатар хот**

Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, нууц санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дашпунцагийн Ганболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдаар томилсугай.
2. Энэ тогтоолыг 1999 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 22-ны өдөр **Дугаар 76** **Улаанбаатар хот**

Л.Цогийг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэж, Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдыг томилсонтой холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Логийн Цогийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэхийг даусгавар болгосугай.
2. Энэ тогтоолыг 1999 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 174** **Улаанбаатар хот**

Д.Батсайханыг Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгчээр томилох тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг баримтлан, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Даваажавын Батсайханыг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 18-ны өдөр **Дугаар 175** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Тагнуулын байгууллагын тухай Монгол Улсын хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. "Тагнуулын ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн тагнуулын ажилтны тангараг өргөх журам"-ыг хавсралтын ёсоор батлагдсугай.

2. Энэхүү зарлигийг 1999 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
1999 оны 175 дугаар зарлигийн хавсралт

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА САЛБАР НЭГЖИЙН ТАГНУУЛЫН АЖИЛТНЫ ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ

1.Монгол Улсын иргэн Тагнуулын ерөнхий газар, түүний салбар нэгжид анх ажилд ороходоо Тагнуулын ерөнхий газрын тагнуулын ажилтны тангараг /цаашид Тангараг гэх/-ыг ёс төртэй өргөнө.

2.Тангараг өргөх ёслолыг Тагнуулын ерөнхий газар зохион байгуулна.

3.Тангаргийг тагнуулын ажилтнууд хамтаар болон ганцаар өргөж болно.

4.Тангараг өргөх ажилтнуудын нэрсийн жагсаалт, тангараг өргөх хугацааг Тагнуулын ерөнхий газрын дарга батална.

5.Тангараг өргөх ёслолын ажиллагааанд Тагнуулын ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын боловсон хүчний асуудал хариуцсан албан тушаалтан, тагнуулын ажилтнаар анх өрж байгаа ажилтныг шууд захирах албан тушаалтан болон бусад ажилтнууд оролцоно.

6.Тангараг өргөх ёслолын байр /газар/-ыг Тагнуулын ерөнхий газрын дарга тогтоож, Тагнуулын ерөнхий газрын боловсон хүчний асуудал эрхэлсэн албан тушаалтан, эсхүл Тагнуулын ерөнхий газрын даргын тусгайлан томилсон албан тушаалтан бэлтгэл ажлыг зохион байгуулж, тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдана.Тангараг өргөх ёслолын байр /газар/-ыг ёслол төгөлдөр тусгайлан бэлтгэж, Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбааг хүндэтгэлтэйгээр байрлуулна.

7.Тагнуулын ерөнхий газарт томилогдсон тангараг өргөх ажилтан ёслолын байр /газар/-нд тогтоосон цагт ирж, Монгол Улсын төрийн сүлд рүү харж цэх зогсоно. Хамтаар өргөх бол эгнэн зогсоно.

8.Ёслолын ажиллагааг удирдаж буй албан тушаалтан тангараг өргөх ёслолын ажиллагааг нээж, тагнуулын ажилтнаар томилогдсон ажилтнуудыг Тагнуулын ерөнхий газрын даргад танилцуулан, тангаргийн бичгиг тангараг өргөгч бүрт гардуулна.

9.Тангаргыг хамтаар өргөж байгаа үед тангараг өргөгчдийн насаар ахмад нь тагнуулын ажилтны тангаргыг цээжээр дээдлэн дуудаж, бусад нь дагалдана. Тангараг ганцаар өргөгч тангаргыг цээжээр дээдлэн дуудна. Тангараг өргөж байх үед уг ёслолд оролцогчид босож хүндэтгэнэ.

10.Тангаргийг дээдлэн дуудаж дуусаад тангараг өргөгч төрийн сүлдэнд мэхийн ёсолж хүндэтгээд, төрийн далбааны өмнө очиж зүүн өвдөг сөхрөн адис авна.

11.Тангараг өргөсөн ажилтан Тангаргын бичигт тангараг өргөсөн он, сар, өдөр, газар, овог нэрээ бичиж, гарын үсэг зурна.

12.Тангараг өргөсөн ажилтнууд тангаргын бичигт гарын үсэг зурж дууссаны дараа төрийн дуулал эгшиглэнэ.

13.Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Тагнуулын ерөнхий газрын дарга тангараг өргөсөн ажилтнуудад баяр хүргэж, ёслолын ажиллагаа хаана.

14.Тангаргын бичигийг тухайн ажилтны хувийн хэрэгт хадгална.

15.Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаар тодорхой тэмдэглэл хөтөлнө.

16.Тагнуулын ерөнхий газрын тагнуулын ажилтан төрийн бусад байгууллагад шилжин ажилласны дараа тагнуулын ажилтнаар эргэж томилогдвол тангараг дахин өргөхгүй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 176** **Улаанбаатар хот**

Ж.Чойжанцанг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

1. Монгол Улсын Үндсэн хуулийн тавинзургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болж байгаатай холбогдуулан Жамцын Чойжанцанг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Энэ зарлигийг 1999 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 8 дугаар сарын 24-ний өдөр **Дугаар 220** **Улаанбаатар хот**

Дүрэм, журам батлах тухай

Барилгын хууль гарсантай холбогдуулан барилга байгууламжийг ашиглалтад оруулах, барилгын угсралтын ажлыг эхлүүлэх харилцааг зохицуулах зорилгоор ТУШААХ нь:

1. "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг 1 дүгээр хавсралтаар, "Барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөөл олгох журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Дээрх дүрэм, журмыг батлагдсантай холбогдуулан Дэд бүтцийн хөгжлийн сайдын "Норм дүрэм батлах тухай" 1994 оны 141 тоот тушаалын "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм" /БНбД 3.01.01-94/, мөн 1995 оны "Дүрэм, журам батлах тухай" 170 тоот тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ **Г.БАТХҮҮ**

ДБХ-ийн сайдын 1999 оны 220 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ ДҮРЭМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү дүрмийг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр Монгол улсын нутаг дэвсгэрт шинээр барьсан, өргөтгөл шинэчлэлт, их засвар хийсэн инженерийн хийцтэй бүх төрлийн барилга байгууламж /цаашид барилга байгууламж гэнэ/-ийг иж бүрнээр нь эсвэл хэсэгчилэн байнгын ашиглалтад оруулахад мөрдөнө.

1.2. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын актад бүх гишүүдгарын үсгээ зурснаар тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулсанд тооцно.

1.3. Барьж дуусаагүй буюу дууссан боловч комисс ажиллаж ашиглалтад хүлээж аваагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно.

1.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс ажиллахын өмнө ажлын комисс ажиллана.

Хоёр. Комисс түүний бүрэлдэхүүн

2.1. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулахдаа өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүний ач холбогдол, үйлчлэх хүрээ, зориулалтын онцлогоос хамааруулан улсын болон ажлын комиссыг дор дурдснаар томилон ажиллуулна.

№	Хамрах барилга байгууламжийн төрөл	Улсын ба аймаг, нийслэлийн комиссын томилох албан тушаалтан	Улсын комиссын бүрэлдэхүүн	Аймаг, нийслэлийн комиссын бүрэлдэхүүн
1.	Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу гадаад дотоодын хөрөнгө оруулаттай, улсын болон олон улсын шинж чанартай, стратегийн ач холбогдол бүхий барилга байгууламжууд	Улсын комиссыг: Монгол улсын Засгийн газрын ерөнхий сайд Аймаг, нийслэлийн комиссыг: Барилгын техникийн хяналт хариуцсан агентлагийн дарга	Даргаар: Засгийн газрын гишүүн, ямны төрийн нарийн бичгийн дарга, агентлагын дарга Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.4, 2.5-т заасан байгууллагын төлөөлөгчид	Даргаар: Барилгын техник хяналтын улсын байцаагчид Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.6-т заасан байгууллагын төлөөлөгчид
2.	Хөрөнгийн эх үүсвэр хэрэглэхгүй үйлчлэх хүрээ нь улсын болон бүс нутгийн чанартай, улс орны эдийн засгийн ач холбогдолтой, технологийн нарийн горим бүхий барилга байгууламжууд	Улсын комиссыг: Барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Аймаг, нийслэлийн комиссыг: Барилгын техникийн хяналт хариуцсан агентлагийн дарга	Даргаар: ДБХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Барилгын техникийн хяналт хариуцсан агентлагийн дарга, Барилгын техникийн хяналтын улсын байцаагчид Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.4-т заасан шаардлагатай үед 2.5-т заасан байгууллагын төлөөлөгчид	Даргаар: Захиалагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.6-т үаасан байгууллагын төлөөлөгчид
3.	Хөрөнгийн эх үүсвэр хэрэглэхгүйгээр, үйлчлэх хүрээ нь орон нутгийн шинж чанартай барилга байгууламжууд	Улсын болон аймаг нийслэлийн комиссыг: Аймаг, нийслэлийн засаг дарга	Даргаар: аймаг нийслэлийн барилгын техникийн хяналтын улсын байцаагчид Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.4-т заасан шаардлагатай үед 2.5-т заасан байгууллагын төлөөлөгчид	Даргаар: Захиалагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.6-т заасан байгууллагын төлөөлөгчид
4.	Бүх төрлийн барилга байгууламжийн засварын ажил	Сум, дүүргийн засаг дарга	Даргаар: Сум, дүүргийн засаг дарын орлогч, Тамгын газрын дарга Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.6-т заасан байгууллагын төлөөлөгчид	Даргаар: Захиалагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан Гишүүдэд: Энэхүү дүрмийн 2.6-т заасан байгууллагын төлөөлөгчид

2.2. Улсын комисс ажиллах үед барилга байгууламжийн хувийн хэрэг, ажлын комиссын тэмдэглэл, (ажлын комиссын гишүүдийн гарын үсэг бүхий), түүний биелэлтийг гарган улсын комисст ажлын комиссын дарга танилцуулна.

2.3. Улсын комисс ажиллахаас өмнө ажлын комисс ажиллаж уг барилга байгууламжийн акт баримтыг ирж бүрдүүлэх, барилгын дутуу, чанаргүй ажлыг засуулж дуусгаад улсын комиссыг ажиллуулахад бэлтгэнэ.

2.4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын гишүүдэд дор дурьдсан байгууллагын төлөөлөгчид орно.

а)барилгын техникийн хяналт хариуцсан байгууллага

б)эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллага

в)байгаль орчны хяналтын байгууллага

г)зураг төслийн байгууллага

д)гал түймэртэй тэмцэх байгууллага

е)захиалагч байгууллага

Улсын комиссын бүрэлдэхүүнд ажлын комиссын дарга нь барилгын техникийн хяналтын болон захиалагч байгууллагын төлөөлөгчөөр орно.

2.5. Барилга байгууламжийн онцлог (зуух, даралтат сав, цахилгаан станц, өргөх байгууламж, төвлөрсөн инженерийн шугам сүлжээ, авто болон төмөр зам, тэсэрч дэлбэрэх материалын агуулах, холбоо дохиолол, усны болон иргэний хамгаалалтын байгууламж, үйлдвэрлэлийн технологийн шугам, тоног төхөөрөмж, өндөр нарийвчлал бүхий хэмжүүр, хэмжих хэрэгслэл, гүүр хонгил)-оос хамааруулан үйлдвэрлэл үйлчилгээний техник технологитой шууд холбогдох дараах хяналт шалгалтын байгууллагын төлөөлөгчдийг улсын комиссын бүрэлдэхүүнд оруулна.

а)стандартчилал, хэмжил зүйн байгууллага

б)иргэний хамгаалалтын байгууллага

в)геологи, уул уурхайн болон түлш, эрчим хүчний хяналтын байгууллага

г)авто ба төмөр зам, агаарын тээврийн хяналтын байгууллага

д)хөдөлмөр, нийгмийн хяналтын байгууллага

е)аймаг, нийслэлийн хот байгууллалтын алба

ё)барилгын захиалагч

2.6. Ажлын комиссын бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөлөгчид орно.

а)дулааны шугам сүлжээний байгууллага

б)холбоо, дохиоллын байгууллага

в)цахилгаан, эрчим хүчний байгууллага

г)ус сувгийн ашиглалтын байгууллага

д)орон сууц, нийтийн аж ахуйн байгууллага

е)барилга захиалагч байгууллага

ж)барилгын ерөнхий ба туслан гүйцэтгэгч байгууллага

з)архивын байгууллага

и)зураг төслийн байгууллага

Гурав. Комиссын үүрэг, эрх

3.1. Хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа байгаль орчинд хохирол учруулахгүй архитектур, хот байгуулалтын шаардлагад нийцсэн, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах үндсэн үүргийг улсын комисс хүлээнэ.

3.2. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын дарга нь гишүүдийн үнэлэлт, дүгнэлт, саналыг үндэслэн эцсийн шийдвэр гаргана.

Энэхүү шийдвэр нь барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн заалтын хүрээнд шийдэгдсэн байна.

3.3. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын болон ажлын комиссын гишүүд нь төлөөлж байгаа байгууллагынхаа чиглэлээр ажиллаж дараах үүргийг гүйцэтгэж дүгнэлт, саналаа комисст танилцуулна.

а)Барилга байгууламжийн үгсралт, тоног төхөөрөмж, инженерийн болон технологийн дамжлага, шугам сүлжээний ажил нь зураг төсөл барилга техникийн болон хөдөлмөр хамгаалал, гал, ариун цэвэр, эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах норм ба дүрэм, улсын стандарт, техникийн нөхцөлийн шаардлага хангасан эсэхийг нарийвчлан шалгаж үнэлэлт дүгнэлт өгөх.

б)суурилагдсан тоног төхөөрөмж, технологийн дамжлага, инженерийн шугам сүлжээнд хийгдсэн сорилт туршилт, тохируулга нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээ явуулахад бэлэн эсэхийг шалгах,

в)барилга байгууламжийн техникийн баримт бичгийн бүрдүүлэлт, архивлан хадгалах шаардлага, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгэх техникийн дүгнэлт зэргийг хийгдсэн ажилтай нь уялдуулан үзэх.

3.4.Комиссын гишүүд шаардлагатай гэж үзвэл барилга байгуулламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн тодорхой хэсэг буюу зангилаа /үзель/ далдлагдсан ажлуудаас сонгон авч задлан үзэж магадлан шалгах, мэргэжлийн шинжээч томилуулан судалгаа шинжилгээ хийлгүүлж дүгнэлт гаргуулах.

3.5. Үйлдвэрийн барилга байгууламжийг ашиглалтад оруулахдаа технологийн дамжлагат зүгшрүүлэлт бүрэн хийгдсэн эсэх, шаардлагатай гэж үзвэл бүтээгдэхүүн үйлдвэрлүүлж үзэх.

3.6.Барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний үгсралт, засварын ажил нь дутуу буюу чанаргүй барьсан, хууль тогтоомж, норм ба дүрмийн заалт шаардлага зөрчсөн бол татгалзах буюу тодорхой хугацаагаар хойшлуулах, нөцтой зөрчил илэрвэл өөрсдөө болон хууль хяналтын байгууллагаар шалгуулж шийдвэрлүүлэх.

3.7.Барилга байгууламж нь зураг төсөл, барилгын норм ба дүрмийн дагуу баригдсан боловч байнгын ашиглалтад оруулах үед хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахтай холбогдуулсан хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм,/БНбД/ шинэчлэгдсэн бол шинэ шаардлагын дагуу зохих арга хэмжээ автал ашиглалтад оруулахгүй байна.

3.8.Барилга байгууламжийг ашиглалтад оруулахтай холбогдсон шаардлагатай баримт бичиг, магадлагаат холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, хүмүүсээс гаргуулан авах.

3.9.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын ба ажлын комисс нь протокол(тэмдэглэл) гаргах бөгөөд онцын нөлөө багатай ажил, үүргийг гүйцэтгэгч, захиалагч байгууллагад хугацаа заан өгч барилга байгууламжийг ашиглахыг зөвшөөрч болно.

Мөн технологийн болон үйлдвэрлэл үйлчилгээний харилцан уялдаагүй барилга байгууламжийг хэсэгчлэн ашиглахыг улсын болон ажлын комисс шийдвэрлэж болно.

3.10.Энэхүү дүрмийн 1-р хавсралтаар үзүүлсэн актыг зөвхөн улсын комисс бүрдүүлж барилга байгууламжийг хүвийн хэрэгт оруулна.

3.11.Ажлын комисс ажиллаад гаргасан тэмдэглэлд заасан ажлууд нь шаардлага хангаагүй, хийгдээгүй, дутуу хийгдсэн бол улсын комисс ажиллахаас татгалзана.

4.Комисст оролцогч байгуллага, аж ахуй нэгжийн үүрэг

4.1.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисст оролцогч байгуллага, аж ахуй нэгж нь төлөөлөгчөө мэдэгдэлд заасан хугацаанд бэлэн байлгах үүрэг хүлээнэ.

4.2.Улсын болон ажлын комисс зарлан мэдээлэгч нь үг барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас 7 хоногийн өмнө комиссын мэдэгдэлийг тараана.

Хэрэв дурдсан хугацаанд төлөөлөгчөө ирүүлээгүй бол түүнээс гарах хохирлыг төлөөлөгчөө ирүүлээгүй байгуллага, аж ахуйн нэгж хариуцна.

Төлөөлөгчөө оролцуулж чадахгүй хүндэтгэх шалтгаан гарсан үед мэдэгдлийн дагуу хариуг комисст урьдчилан мэдэгдэнэ.

4.3.Улсын комисст төлөөлөгчөө оролцуулж байгаа хяналтын байгууллагуудаас оролцох хүмүүсийн зардлыг өөрсдөө (тохируулагч агентлаг) гаргана.

Хэрвээ 2 дах удаа комисс ажиллуулах нөхцөлд улсын комиссын гишүүдийн томилолтын бүх зардлыг улсын комисс зарлан

мэдээлсэн захиалагч байгууллага хариуцна.

4.4.Гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгж нь дараах үүрэгтэй.

а)Энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад дурдсан материалыг бүрдүүлэн баталгаажуулж (гарын үсэг, тамга тэмдэг гүйцэд бүрдэх, бичилт бүрэн байх) уг баримт бичгийн товьёг хийсэн байх.

б)Ерөнхий гүйцэтгэгч байгууллага нь ажлын комиссыг зохион байгуулах бөгөөд энэ үед өөрийн төлөөлөгчөөр барилгын баримт бичгийг эмхлэн хөтөлж бүрдүүлнэ.

в)Барилга байгууламж барих, шинэчлэх, засварлах явцад хяналтын албадаас шалгаад гаргасан акт, албан шаардлага, техникийн дүгнэлтийн биелэлтийг гаргасан байх.

4.5.Захиалагч байгууллага, аж ахуйн нэгж нь дараах үүрэгтэй.

а)Барилга байгууламжийг байнгын ашиглал-тад оруулах комиссыг зохион байгуулан ажиллуулах, шаардлагатай үед комисс томилсон байгууллагын дэмжлэг туслалцаа авах.

б)Захиалагч байгууллага нь улсын комиссыг зохион байгуулах бөгөөд өөрийн төлөөлөгчөөрөө ажлын комиссын тэмдэглэл, баримт бичгийг хянаж улсын комиссын мэдэгдэл тараах асуудлыг зохион байгуулна.

в)Барилга байгууламжийн ажлын явц, чанарт хяналтын байгууллагаас шалгаад өгсөн шаардлага, дүгнэлтийн биелэлтийг гаргаж далд ажлын гүйцэтгэлийг баталгаажуулсан байх.

г)Улсын комисс зохион байгуулахаас өмнө үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгэхэд шаардагдах техникийн дүгнэлтийг гаргуулсан байна.

4.6.Комисс ажиллуулахын өмнө доорх ажлуудыг гүйцэтгэсэн байна.

а)Барилга байгууламжид чанарын үнэлэлт дүгнэлт гаргах эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, ИТА-аас "Барилга ашиглалтын дүрэм"-ийн дагуу гаргасан техникийн дүгнэлтийг захиалагч байгууллага бүрдүүлж төв орон нутаг дахь барилгын техникийн хяналтын улсын байцаагчдад өгсөн байна.

Энэ нь уг барилга байгууламжид улсын бүртгэлийн гэрчилгээ олгох нөхцөл болно.

б)Комиссыг ажлаа чөлөөтэй гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангасан байхыг улсын болон ажлын комиссыг зохион байгуулсан захиалагч, гүйцэтгэгч хариуцна.

Тав. Комиссын хариуцлага

5.1. Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах мэргэжлийн болон удирдлагын талаар буруу дутмаг шийдвэр гаргаснаас болж учирсан хохирол зөрчлийн талаар комиссын дарга, гишүүд өөр өөрсдийн хариуцсан ажлын чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

5.2.Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлтэй үйл ажиллагааны талаарх гомдлыг хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

Дүрмийн 1 дүгээр хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ УЛСЫН КОМИССЫН АКТ

19...оны .....сарын ....өдөр № .....(хот, сум)

Нэг.

1.1. Барилга байгууламжийн байршил, хүчин чадал

1.2. Захиалагч, ашиглагч байгууллага, аж ахуйн нэгж

1.3. Ерөнхий ба туслан гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгж

1.4. Зураг төсөв боловсруулсан байгууллага, аж ахуйн нэгж

1.5.

шийдвэрээр зохион байгуулсан .... хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс нь уг барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай захиалагч байгууллагын

…..тоот мэдэгдлийн дагуу 19…. оны ….сарын …. өдрөөс …. өдөрт багтаан шинээр барьсан, өргөтгөл шинэчлэлт, их засварын ажил, холбогдох акт баримтуудыг шалган үзэж танилцав. (Комисс томилсон шийдвэрийг хавсаргав).

1.7. Энэхүү барилга байгууламж (шинээр барьсан, өргөтгөл шинэчлэлт, их засвар)-ийг (засварласан, өргөтгөсөн) эхэлсэн хугацаа

_____

Дууссан хугацаа _____

1.8. Барилга байгууламж (өргөтгөл шинэчлэлт, их засвар)-ийн зураг төсвийн дугаар (шифр)

_____

_____

Хоёр.

2.1. Энэхүү _____

_____

барилга байгууламж, холбогдох акт, баримтуудыг шалгаад ашиглалтад оруулах тухай улсын комиссоос ШИЙДВЭРЛЭСЭН нь:

2.2. Энэхүү барилга байгууламж нь зураг төсвийн дагуу бүрэн хийгдэж

_____

_____ зориулалтаар ашиглахад _____ гэж үзээд ашиглагч (захиалагч) байгууллага болох _____ мэдэлд 19…. оны …. сарын …. өдрөөс ашиглалт (үйлдвэрлэл-үйлчилгээ, оршин суух зэрэг) явуулахыг зөвшөөрөв.

2.3. Улсын комиссоос даалгах нь:

1. Захиалагч байгууллагад:

а)барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын акт, холбогдох баримтуудыг 2 хувь үйлдэж өнгөн хувийг архивт үлдэх хувийг ашиглагч байгууллагад …. хоногийн дотор багтаан шилжүүлэх.

б)үл хөдлөх хөрөнгийн албанд уг барилга байгууламжийг …. хоногийн дотор багтаан бүртгүүлэх.

в)барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг нээж баяжилт хийж байх.

г)барилга ашиглалтын дүрмийн дагуу барилгын хэвийн ашиглалтыг явуулж засвар арчлалтыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

2.4. Улсын комиссын тусгай тэмдэглэл (улсын комиссын хуралдааны протокол барилга, байгууламжийн баримт бичгийн жагсаалтыг хавсаргав.)

УЛСЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА

ГИШҮҮД:

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧ

ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧ

ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР СУДЛАЛЫН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧ

ЗУРАГ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧ

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ТӨЛӨӨЛӨГЧ

Тайлбар: Актын энэхүү асуултад хариулан бичиж актыг үйлдэх ба харин ийм маягт бөглөж комисс гарын үсэг зурахыг хориглоно.

АШИГЛАЛТАД ОРУУЛАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД БҮРДҮҮЛСЭН БАЙВАЛ ЗОХИХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Бүрдүүлж хөтөлсөн байх баримт бичиг	Баримт бичгийн он, сар, өдөр	Хувь
0	1	2	3
	а)Барилгын ажил эхлүүлэхийн өмнө бүрдүүлсэн байх бичиг баримтууд		
1.	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх эвсвөөрөл		
2.	Барилга хариуцах даамлыг томилох тушаал		
3.	Барилга барих газар олгосон тухай аймаг, нийслэлийн засаг даргын захирамж, эвсвөөрлийн бичиг		
4.	Техникийн нөхцөл бүрдүүлсэн тухай баримт бичгүүд (ус суваг, дулаан, цахилгаан, холбоо дохиолол)		
5.	Улаан шугам тавьсан акт түүнийг тавихад гаргасан зай хэмжээний зураг		
6.	Барилга барих газрын хөрсний шинжилгээний дүгнэлт		
7.	Ажлын иж бүрэн зураг төсөв		
8.	Захиалагч, ерөнхий гүйцэтгэгч байгуулагын хооронд хийсэн гэрээнүүд		
9.	Захиалагч байгуулагаас зураг төслийг хянаж эвсвөөрсөн, зураг гал, ариун цэвэр, архитектур, хот байгуулалтын байгуулагуудаар хяналт хийлгүүлж эвсвөөрөл авсан тухай тодорхойлолт		
	б)Барилга угсралтын ажлын явцад бүрдүүлсэн баримт бичиг		
10.	Улаан шугамыг шалгаж тэг, тэнхлэг татсан акт		
11.	Суурийн нүх ухсан акт		
12.	Суурь хийсэн акт		
13.	Ханын өргийн акт		
14.	Хана сууринд төмөр бетон бүс хийсэн акт		
15.	Төмөр бетон зурхэвч цутгасан акт		
16.	Хаалга цонхны ялуут суулгасан акт		
17.	Тоосгон хананд салхивч ба утааны суваг хийсэн акт		
18.	Газар хөдлөлтийн арга хэмжээний зориулалттай тусгай хийцийг гүйцэтгэсэн акт		
19.	Модон хучилт хийсэн акт		
20.	Хавтгай ба төмөр дээвэр хийсэн акт (дулаалга)		
21.	Угсармал төмөр бетон хучилт хийсэн акт		
22.	Угсармал төмөр бетон дам нуруу, багана угсарсан акт		
23.	Цутгамал төмөр бетон бутээцийн арматурласан акт		
24.	Цутгамал төмөр бетон бутээц хийсэн акт		
25.	Тагт, карнизын төмөр бетон хавтанг бэхэлсэн акт		
26.	Төмөр бутээцийг угсарч гагнасан акт		
27.	Дотор халаалтын системийг угсарсан, сорилтоор шалгасан акт		
28.	Дотор бохир усны системийг угсарсан, сорилтоор шалгасан акт		
29.	Гадна бохир усны системийг угсарсан, шалгасан акт		
30.	Дотор халуун хүйтэн усан хангамж, гал эсэргүүцэгч системийг угсарсан, сорилтоор шалгасан акт		
31.	Гадна дулаан, цэвэр усан хангамжийн системийг угсарсан, сорилтоор шалгасан акт		
32.	Халаалтын тогоо, түүний тоног төхөөрөмжүүдийг угсарсан, сорилтоор шалгасан акт		
33.	Дулааны зангилгаа, ус халаагчийг угсарсан акт		
34.	Барилгын салхивчийн системийг угсарч, сорилт хийсэн акт		
35.	Барилгын гадна цахилгааны шугамыг хийсэн акт		
36.	Дотор цахилгааны угсралтын ажил, туршилт хийж шалгасан акт		
37.	Радио телефоны дотор угсралт хийсэн, шалгасан акт		
38.	Радио, телефоны гадна холболтын монтаж хийсэн, шалгасан акт		
39.	Тоног төхөөрөмжийн суурь хийсэн ба тоног төхөөрөмжийг байрлуулж угсарсан акт		

40.	Тоног төхөөрөмжинд туршилт хийсэн акт (нэг бүрээр)		
41.	Тоног төхөөрөмжинд цахилгаан холболт газардуулга хийсэн акт (нэг бүрээр)		
42.	Тоног төхөөрөмжүүдэд контур газардуулга хийсэн, шалгасан акт		
43.	Барилгад аянга зайлуулагч хийсэн, туршсан акт		
44.	Шат үгсарсан акт		
45.	Уур, ус тусгаарлалтын ажил хийсэн, шалгасан акт		
46.	Хучилт, дээврийн дулаалгын ажлыг хийсэн акт		
47.	Гадна дотор будаг, заслалын ажил хийсэн акт		
48.	Барилга үгсралтын явцад өөрчилсөн бусад шийдвэрлэсэн асуудлуудад холбогдох баримт бичгүүд хуулбар буюу эх материал		
49.	Хүн ба тээш зөөврийн лифтийн тоног төхөөрөмжийг үгсарсан, шалгаж туршсан акт		
50.	Лифтийн цахилгаан холболтыг хийсэн, шалгасан акт		
51.	Лифтийг гүйцэтгэгч байгууллагаас хүлээлгэж өгсөн акт		
52.	Гадаад оронтой хийсэн гэрээ, хэлэлцээр, зээл тусламжаар хийгдсэн зүйлүүд		
	а)гэрээ хэлэлцээрт (контрактад) дурдсанаар бүрэн бүтэн чанар үзэмжтэй хийгдсэн эсэх тодорхойлолт		
	б)тоног төхөөрөмж, эд хогшил, машин механизм нь зураг төсөл, контрактад заагдсанаар бүрэн тоо ширхэгээр зөв байрлагдаж үгсрагдсан болон үгсрагдахгүй бүрэн бүтэн тоо ширхэгээр бүгд ирсэн эсэх тухай жагсаалт		
	в)гэрээ хэлэлцээрт зураг төсөвт заагдсанаас хасагдаж хийгдэхгүй болсон мөн хийгээгүй зүйлийн жагсаалт		
	г)цаашдын ашиглалтад зориулагдаж ирсэн сэлбэг түлхүүр, багаж хэрэгслийн жагсаалт		
53.	Удирдах ба зураг төсвийн болон хяналт шалгалтын байгууллагуудаас шалгаад өгсөн акт, шаардлага, түүний биелэлтийн хувиуд		
54.	Зураг төслөөс өөрчлөх хийсэн зүйлийн жагсаалт, түүнийг хаанаас хэн өөрчилсөн тодорхойлолтууд		
55.	Инженерийн шугам сүлжээ болон даацын үндсэн бүтээцийн гүйцэтгэлийн зураг		
56.	Барилгын ажлын өдөр тутмын тэмдэглэл Тайлбар: 1. Энэ жагсаалтыг барилга байгууламжийг хүлээлгэн өгөхдөө 2 хувь бэлтгэсэн байна. 2.Барилгын өдөр тутмын тэмдэглэлийг архивт хадгалах хувьд хавсаргана.		
57.	Гадна зам талбай, тохижилт хийсэн акт		

Тайлбар: 1.Ажил гүйцэтгэсэн тухай акт нь ажил гүйцэтгэх, хүлээн авах тухай барилгын норм дүрэмд заасны дагуу үйлдэгдсэн байна.
2.Энэ жагсаалтыг барилга байгууламжийг хүлээлгэн өгөхдөө 2 хувь бэлтгэсэн байна.
3.Барилгын ажлын өдөр тутмын тэмдэглэлийг архивт хадгалах хувьд хавсаргана.
4.Барилгын ажилтай холбоотой бусад зураг, акт баримт бичгийг энэхүү жагсаалтад нэмж оруулна.

Дээд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 220 дугаар тушаалын 2 дугаар хавсралт дараагийн дугаарт нийтлэгдэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арваннэгдүгээр сарын 4 №49 (128)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Хууль

460. Иргэний бүртгэлийн тухай (1999-10-14-ний хууль) 894
461. Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-10-14-ний хууль) 909
462. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-10-14-ний хууль) 909
463. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (1999-10-14-ний хууль) 909
464. Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (1999-10-14-ний хууль) 910
465. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (1999-10-14-ний хууль) 910

Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол

466. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 71 912

Гурав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

467. Ц.Амарсайханыг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай Дугаар 178 912

Дөрөв. Яам, агентлагийн акт

468. Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 220 дугаар тушаалын 2 дугаар хавсралт 912

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний бүртгэл болон түүнийг эрхлэх байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомж

2.1.Иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомж нь Иргэний хууль[1], Гэр бүлийн тухай хууль[2], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Иргэний бүртгэлийн үйл ажиллагааны зарчим

3.1.Иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, бусдын нөлөөнд үл автах, иргэний хувийн нууцыг чандлан хамгаалах зарчмыг баримтална.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."иргэний бүртгэл" гэж иргэний эрх, үүрэг үүсэх,өөрчлөгдөх, дуусгавар болгохтой холбогдох энэ хуульд заасан үйл ажиллагаа;

4.1.2."иргэний бүртгэл, мэдээллийн систем" гэж Монгол Улсын иргэн бүрт олгосон регистрийн дугаарыг үндэслэн Монгол Улсын хүн амыг бүртгэл, мэдээллийн нэгдсэн үзүүлэлтэд хамруулахтай холбогдсон цогцолбор үйл ажиллагаа.

5 дугаар зүйл. Иргэний бүртгэл, түүнийг хөтлөх

5.1.Иргэний бүртгэл нь гэр бүлийн байдлын, хүн амын өрхийн, иргэний үнэмлэхэд үндэслэх гадаад паспортын, шаардлагатай хөдөлгөөний болон гадаадын иргэний бүртгэлээс тус тус бүрдэнэ.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан бүртгэлийг хөтлөх төрийн захиргааны байгууллага бүртгэлийн дэвтэр болон маягтад шаардлагатай бичилт хийж, түүний үндэслэн дээр холбогдох үнэмлэх, гэрчилгээ, лавлагаа олгох замаар иргэний бүртгэлийг хөтөлнө.

5.3.Иргэний бүртгэлийг монгол хэл дээр хөтөлнө.

6 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн байгууллагын тогтолцоо

6.1.Тус улсын нутаг дэвсгэрт иргэний бүртгэлийн үйл ажиллагаат хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв эрхлэн зохион байгуулна.

6.2.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албаны даргыг Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвийн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

6.3.Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албад иргэний бүртгэлийн үйл ажиллагаат нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, сум, дүүргийн иргэний бүртгэлийн ажилтанг арга зүйн удирдлагаар хангаж, тайлан, мэдээг гарган зохих журмын дагуу Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлнэ.

6.4.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар иргэний бүртгэлийг эрхлэн хөтөлж, холбогдох тайлан, мэдээг гарган зохих журмын дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл мэдээллийн албанд хүргүүлнэ.

6.5.Хүн амын анхан шатны бүртгэл болох хүн амын өрхийн бүртгэлийн дэвтрийг тухайн дэвсгэр нутгийн баг, хорооны Засаг дарга хариуцан хөтөлнө.

6.6.Хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар нь тогтоосон журмын дагуу иргэний бүртгэлийн үйл ажиллагаат эрхлэн явуулж, холбогдох тайлан, мэдээг гаргаж зохих журмын дагуу Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд хүргүүлнэ.

6.7.Иргэний бүртгэл мэдээллийн улсын төв болон аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл, мэдээллийн албад нь үйл

[1] Иргэний хууль.- "Ардын эрх" сонины 1 дүгээр оны 257, 258, 1995 оны 1, 2, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дүгээрт тус тус нийтлэгдсэн.

[2] Гэр бүлийн тухай хууль.- "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

ажиллагааныхаа орлогоор санхүүжинэ.

7 дугаар зүйл. Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн чиг үүрэг

7.1.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, Монгол Улсад оршин суух үнэмлэх, иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээ олгох, хүчингүй болгохтой холбогдсон бодлого хэрэгжүүлэх;

7.1.2.Монгол Улсын иргэний бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, цахим тоолуурт хадгалах ажлыг зохион байгуулах;

7.1.3.Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суугаа гадаадын иргэн, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүний нэгдсэн тоо бүртгэлийг хөтлөх;

7.1.4.иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

7.1.5.иргэний баримтын архивын санг бүрдүүлэх, хөтлөх, хадгалах;

7.1.6.иргэний бүртгэл, мэдээллийн улсын нэгдсэн сүлжээг эрхлэн хөтлөх;

7.1.7.иргэний бүртгэлтэй холбогдсон мэдээлэл, лавлагаагаар иргэд, байгууллагад хүсэлтийнх нь дагуу үйлчлэх;

7.1.8.төв, орон нутгийн бүртгэлийн ажилтнуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь хянан шалгах;

7.1.9.иргэний хаягийн нэгдсэн ангиллыг эрхлэн хөтлөх:

7.1.10.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

8 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн ажилтан, түүний эрх, үүрэг

8.1.Иргэний бүртгэлийн ажилтнаар хууль, хүн ам зүй болон эдийн засгийн зохих боловсролтой, бүртгэлийн ажлын дадлагатай иргэнийг ажиллуулна.

8.2.Иргэний бүртгэлийн ажилтан дараахь эрх эдэлнэ:

8.2.1.бүртгэл хийхэд зайлшгүй шаардлагатай баримт бичгийг иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах:

8.2.2.жинхэнэ мөн эсэх нь эргэлзээтэй бол уг баримт бичгийг магадлан шинжлүүлэх;

8.2.3.иргэний бүртгэлийн журам зөрчсөн байгууллага, хүмүүст хууль тогтоомжийн дагуу хариуцлага ногдуулах.

8.3.Иргэний бүртгэлийн ажилтан дараахь үүрэг хүлээнэ:

8.3.1.бүртгэл үйлдэхэд шаардлагатай баримт бичгийн бүрдэл, тэдгээрийн үнэн зөвийг шалгах;

8.3.2.бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн үнэн зөв хөтлөх, тайлан мэдээг нэгтгэж гаргах;

8.3.3.албан үүрэгээ гүйцэтгэх явцад олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулахгүй байх;

8.3.4.иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг шаардлагатай үед явуулын журмаар хөтлөх.

8.4.Энэ хуулийн 8.3.4-т дурдсан бүртгэл хөтлөхөд шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс гаргана.

8.5.Иргэний бүртгэлийн ажилтан өөртөө, эсхүл гэр бүлийнхээ гишүүн, төрөл садныхаа хүнтэй холбогдсон бүртгэл хөтлөхийг хориглоно. Энэ тохиолдолд уг бүртгэлийг сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын, эсхүл дипломат төлөөлөгчийн болон консулын газрын өөр ажилтан хөтөлнө.

9 дүгээр зүйл. Иргэний бүртгэлийн дэвтэр, маягт, үнэмлэх, гэрчилгээ

9.1.Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн дэвтэр, маягт, гэрчилгээний загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.2.Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт нэг бүр нь сери, дугаартай болон иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээ нь тухайн жилдээ үл давхардах дугаартай байна.

10 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн хураамж

10.1.Иргэний бүртгэл хийх, иргэний үнэмлэх, гэр бүлийн байдлын гэрчилгээ олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ түүнээс хөнгөлөх, чөлөөлөх нөхцөлийг Тэмдэгтийн хураамжийн хуулиар[1] тогтооно.

[1] Тэмдэгтийн хураамжийн хууль.- "Ардын эрх" сонины 1993 оны 116, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны 4-5 дугаарт тус тус нийтлэгдсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БАЙДЛЫН БОЛОН ХҮН АМЬН ӨРХИЙН БҮРТГЭЛ

11 дүгээр зүйл. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн төрөл

11.1.Иргэний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх, ашиг сонирхол, төрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор иргэний гэр бүлийн байдлын улсын бүртгэлийг хөтөлнө.

11.2.Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлнь дараахь төрөлтэй байна:

11.2.1.төрсний;

11.2.2.гэрлэлтийн;

11.2.3.гэрлэлт цуцалсны;

11.2.4.гэрлэлт сэргээсний;

11.2.5.үрчлэлтийн;

11.2.6.эцэг, эх тогтоосон тухай;

11.2.7.овог, эцгийн нэр, нэр өөрчилсний;

11.2.8.нас барсны.

11.3.Энэ хуулийн 11.2-т заасан бүртгэл хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

11.4.Хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хөтлөх бүртгэлийн заавруг хууль зүйн болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

12 дугаар зүйл.Төрснийбүртгэх

12.1.Эцэг, эх хэрэв эцэг эх нь хоёулаа удаан хугацаагаар эмнэлэгт эмчлүүлэх буюу хорих газарт ял эдэлж байгаа зэрэг аргагүй шалтгааны улмаас бүртгүүлэх боломжгүй бол тэдний төрөл садны хүн буюу хүүхэд байгаа эмнэлэгийн байгууллагын эрх бүхий ажилтан хүүхдийг төрснөөс хойш тев суурин газарт 15 хоног, алслагдсан сум, багт 30 хоногийн дотор иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлнэ.

12.2.Хүүхдийн эцэг, эхийн оршин суугаа, эсхүл хүүхдийн өөрийнх нь төрсөн газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан дараахь баримт бичгийг үндэслэн хүүхдийг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэнэ:

12.2.1.хүүхэд төрсөн тухай эмнэлгийн магадлагаа, эрүүл мэндийн дэвтэр, эсхүл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас эмнэлгийн магадлагаа авах боломжгүй нөхцөлд төрсөн бол хөндлөнгийн гэрчийн тодорхойлолт;

12.2.2.эцэг,эхийн иргэний үнэмлэх;

12.2.3.эцэг, эхийн гэрлэлтийн гэрчилгээ.

12.3.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эхээс төрсөн хүүхдийг бүртгүүлэх тохиолдолд энэ хуулийн 12.2.3-т заасан гэрчилгээг шаардахгүй.

12.4.Хэрэв эцэг, эх нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр хүрэлцэн ирж хүүхдээ бүртгүүлэх боломжгүй бол иргэний бүртгэлийн ажилтан гэрт нь буюу өөр газар очиж бүртгэж болно.

12.5.Эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй олдмол хүүхдийг асрамжлан авсан хүн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын эрх бүхий ажилтан тухайн хүүхэд олдсон өдрөөс хойш 2 хоногийн дотор цагдаагийн байгууллагад тэмдэглүүлж, түүнийг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлэх өргөдлөө /өргөдөлд хүүхдийн хүйс, хэрэв мэдэж байвал түүний нэр, төрсөн газар, он, сар, өөрийн оршин суугаа газар, хүүхэд олдсон нөхцөл байдлыг дурдсан байна/ тухайн хүүхэд олдсон газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргаж, дараахь баримт бичгийг хавсаргана:

12.5.1.цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

12.5.2.олдмол хүүхдийн нас, хүйсийг тогтоосон тухай эмнэлгийн байгууллагын тодорхойлолт.

12.6.Энэ хуулийн 12.5-д дурдсан өргөдлийг хүлээн авсан иргэний бүртгэлийн ажилтан хүүхэд олдсон он, сар, өдөр, цаг, газар болон нөхцөл байдал, хүүхдийн нас, хүйсийн тухай тэмдэглэл үйлдэж хүүхдийг асрамжлан авсан хүн, эсхүл хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагын эрх бүхий ажилтнаар гарын үсэг зуруулж бүртгэлд хавсаргана.

12.7.Эцэг нь нас барснаас хойш 10 сарын дотор төрсөн хүүхдийг төрсний бүртгэлд бүртгэхдээ энэ нь нас барсны гэрчилгээг

үндэслэн нас барагчийн овог, нэрээр бүртгэж болно.

12.8.Гэрлэлтийг цуцалсан, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцсоноос хойш 10 сарын дотор төрсөн хүүхдийг бүртгэхдээ эцэг, эхийн хамтран гаргасан өргөдөл, эсхүл шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

12.9.Энэ хуулийн 12.2, 12.5-д заасан ба-римт бичгийг хавсаргасан өргөдлийг хүлээн авмагц иргэний бүртгэлийн ажилтан хүүхэд төрснийг бүртгэж гэрчилгээ олгоно.

12.10.Ихэр хүүхдийг тус тусад нь бүртгэж, дараалсан дугаартай гэрчилгээ олгоно.

12.11.Төрсний гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

12.11.1.хүүхдийн овог, эцгийн нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, газар;

12.11.2.эцэг, эхийн овог, эцгийн нэр, нэр;

12.11.3.төрсний бүртгэл үйлдсэн газрын нэр, гэрчилгээний болон регистрийн дугаар;

12.11.4.төрсний бүртгэл үйлдсэн он, сар, өдөр, албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

12.11.5.төрсний гэрчилгээ олгосон он, сар, өдөр.

12.12.Нэгээс дээш настай хүүхдийг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлэх тухай хүсэлтийг хүүхдийн эцэг, эхийн, эсхүл хүүхдийн оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргаж дараахь баримт бичгийн аль нэгийг хавсаргана:

12.12.1.хүүхэд төрсөн тухай эмнэлгийн магадлагаа;

12.12.2.энэ хуулийн 12.12.1-д заасан магадлагаа байхгүй бол хүүхэд төрсөн үйл явдлыг тогтоосон тухай шүүхийн шийдвэр.

12.13.Төрснийг нь бүртгэхээс өмнө нас барсан хүүхдийн төрсөн болон нас барсныг иргэний бүртгэлийн ажилтан эмнэлгийн магадлагааг үндэслэн тус тусад нь бүртгэнэ.

12.14.Гадаадад оршин суугаа Монгол Улсын харьяат иргэнээс төрсөн хүүхдийг эцэг, эхийн нь хүсэлтийг үндэслэн хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар хүүхэд төрснөөс хойш 30 хоногийн дотор бүртгэнэ.

12.15.Эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат, эсхүл харьяалалгүй хүн бол тэдний дундаас тус улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхдийг эцэг, эхийн хүсэлтийг үндэслэн энэ зүйлд заасан журмын дагуу бүртгэнэ.

12.16.Эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат бол тэдний дундаас гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхдийг эцэг, эхийн харилцан тохиролцсоноор бүртгэнэ.

12.17.Эцэг, эх нь хоёулаа, эсхүл тэдний хэн нэг нь Монгол Улсын харьяат бол тэдгээрийн гадаад улсын нутаг дэвсгэр дээр төрсөн хүүхдийн тухайн оронд олгосон төрсний гэрчилгээг үндэслэн түүнийг иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэн, гадаад оронд олгосон төрсний гэрчилгээн дээр тэмдэглэл хийж гэрчилгээг сольж олгоно.

12.18.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс төрсөн хүүхдийг энэ зүйлд заасан журмын дагуу бүртгэж төрсний гэрчилгээ олгож болно.

13 дугаар зүйл.Гэрлэлтийн бүртгэл

13.1.Гэр бүлийн тухай хуульд заасан насанд хүрсэн гэрлэхийг хүсэгчид хэн нэгнийхээ, эсхүл хамтран оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гэрлэлтээ бүртгүүлнэ. Гэрлэхийг хүсэгчид хүсвэл гэрлэлтийг ёс тертэй бүртгэж болно.

13.2.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэх тухай өргөдлөө /өргөдөлд гэрлэхийг хүсэгчдийн овог, эцгийн нэр, нэр, оршин суугаа газрын хаяг, төрсөн он, сар, өдөр зэргийг дурдсан байна/ хамтран гаргаж, дараахь баримт бичгийг хавсаргана:

13.2.1.гэрлэхийг хүсэгчдийн иргэний үнэмлэх;

13.2.2.эрүүл мэндийн тодорхойлолт;

13.2.3.гэрлэхийг хүсэгч нэг нь өмнө гэрлэж байсан бол гэрлэлтээ цуцлуулсан тухай холбогдох байгууллагын шийдвэрийн хуулбар буюу архивын лавлагаа;

13.2.4.Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн дагуу насанд хүрээгүй хүнийг эрх зүйн бүрэн чадамжтай гэж зарласан нөхцөлд шүүхийн шийдвэрийн хуулбар.

13.3.Иргэний бүртгэлийн ажилтан гэрлэлтийг бүртгэхдээ гэрлэхийг хүсэгчдийг биеэр байлцуулна. Гэрлэхийг хүсэгчдийн хүсэлтээр насанд хүрсэн гэрч, төрөл садангийн хүнийг оролцуулж болно.

13.4.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хүрэл-

цэн ирж чадахгүй хүмүүс өөрсдөө хүсвэл тэдний гэрлэсний иргэний бүртгэлийн ажилтан гэрт нь буюу өөр газар бүртгэж болно.

13.5.Гэр бүлийн тухай хуульд заасан гэрлэхэд харшлах шалтгаан байгаа талаар хангалттай нотлох баримт байгаа бол иргэний бүртгэлийн ажилтан гэрлэлтийг бүртгэхээс татгалзаж болно.

13.6.Тус улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй, эсхүл гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс хоорондоо гэрлэсний Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хууль[1]-ийн 11[1] дүгээр зүйлд заасан байгууллага эрхлэн бүртгэнэ.

13.7.Монгол Улсын харьяат иргэн гадаадын иргэнтэй, эсхүл гадаадын иргэд хоорондоо тус улсын нутаг дэвсгэр дээр гэрлэж бүртгүүлэхдээ энэ хуулийн 13.2-т заасан баримт бичгээс гадна тэдгээрийн өргөдлийн нотариатаар гэрчлүүлсэн орчуулгын хуулбар, тухайн гадаадын иргэнийг харьяалсан улсын дипломат төлөөлөгчийн болон консулын, эсхүл тухайн орны иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн газраас гаргасан тодорхойлолтыг хавсаргана.

Тодорхойлолтод гэрлэхийг хүсэгчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, газар, байнга оршин суугаа газрын хаяг, гэрлэлтийн байдлыг бичсэн байна.

13.8.Энэ хуулийн 13.6-д заасны дагуу гэрлэлтээ бүртгүүлсэн гэрлэгчид иргэний бүртгэлийн ажилтан бүртгэлийн баримт бичгийг орчуулуулан танилцуулж болно.

13.9.Энэ хуулийн 13.2, 13.7-д заасан баримт бичгийг хавсаргасан өргөдлийг хүлээн авмагц иргэний бүртгэлийн ажилтан гэрлэснийг 30 хоногийн дотор бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрлэлтийн гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

13.9.1.гэрлэгчдийн харьяалал, овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр;

13.9.2.гэр бүл болсон он, сар, өдөр;

13.9.3.гэрлэлтээ бүртгүүлсэн он, сар, өдөр

13.9.4.бүртгэл үйлдсэн газрын нэр, гэрчилгээний дугаар;

13.9.5.бүртгэл үйлдсэн албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг.

13.10.Гэрлэгчид хоёулаа Монгол Улсын харьяат бөгөөд тэдгээр нь гадаад улсын хууль тогтоомжийн дагуу гэрлэсэн бол тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээг үндэслэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэж, гэрчилгээг сольж олгоно.

13.11.Гадаадад оршин суугаа Монгол Улсын харьяат иргэд хоорондоо, эсхүл гэрлэхийг хүсэгчдийн хэн нэг нь Монгол Улсын харьяат нөгөө нь гадаад улсын харьяат иргэн гэрлэсэн бол хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар 30 хоногийн дотор бүртгэж болно.

13.12.Гэрлэгчдийн хэн нэг нь Монгол Улсын харьяат иргэн, нөгөө нь гадаад улсын харьяат бөгөөд тэдгээр нь гадаад улсын хууль тогтоомжийн дагуу гэрлэж бүртгүүлсэн нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлаагүй бол тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ, түүний нотариатаар гэрчлүүлсэн орчуулгыг үндэслэн Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11[1] дүгээр зүйлд заасан байгууллага иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэж, гэрчилгээг сольж олгож болно.

14 дүгээр зүйл. Гэрлэлт цуцалсны бүртгэл

14.1.Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 10 хоногийн дотор иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлнэ.

14.2.Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэд оршин суугаа газрынхаа, эсхүл гэрлэлтээ бүртгүүлсэн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гэрлэлтээ цуцлуулсныг бүртгүүлэх тухай өргөдлөө гаргаж дараахь баримт бичгийг хавсаргана:

14.2.1.шүүхийн шийдвэрийн хуулбар;

14.2.2.гэрлэлтийн гэрчилгээ, эсхүл архивын лавлагааны материал.

14.3.Захиргааны журмаар гэрлэлтээ цуц-

[1] Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль "Ардын эрх" сонины 1994 оны 7, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 2 дугаарт тус тус нийтлэгдсэн.

луулахаар харилцан зөвшөөрсөн, төрсөн, үрчлэн авсан 18 хүртэлх насны хүүхэдгүй бөгөөд, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид өргөдлөө /өргөдөлд гэрлэгчидийн овог, эцгийн нэр, нэр, гэрлэлтийн гэрчилгээний дугаар болон гэрлэлтээ цуцлуулах талаар харилцан зөвшөөрсөн, төрсөн болон үрчлэн авсан 18 хүртэлх насны хүүхэдгүй тухайгаа дурдсан байна/ оршин суугаа газрынхаа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хамтран гаргаж, дараахь баримт бичгийг хавсаргана:

14.3.1.гэрлэлтийн гэрчилгээ;

14.3.2.арван найм хүртэлх насны хүүхэдгүй тухай оршин суугаа газрынхаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;

14.3.3.улсын тэмдэгтийн хураамж төлсөн тасалбар.

14.4.Захиргааны журмаар гэрлэлтийг цуцлахад гэрлэгчидийг биечлэн байлцуулна. Хэрэв гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас уг ажиллагаанд оролцох боломжгүй бол өөрийнхөө байхгүйд гэрлэлт цуцлахыг зөвшөөрөх нотариатаар гэрчлүүлсэн өргөдлийг нь үндэслэн 30 хоногийн дотор гэрлэлтийг цуцалж иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэнэ.

14.5.Гэрлэгчдийн хэн нэгийг нь шүүхээс нас барсан, эсхүл эрх зүйн чадамжгүй гэж тооцсон, 3-аас дээш жил хорих ял эдлэхээр шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон бол нөгөө тал нь гэрлэлтээ цуцлуулахаар өргөдлөө /өргөдөлд гэрлэгчидийн овог, эцгийн нэр, нэр, гэрлэлтээ цуцлуулах болсон шалтгаан, эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон нөхөр, эхнэрийн асран хамгаалагчийн оршин суугаа газрын хаяг зэргийг дурдсан байна/ оршин суугаа газрынхаа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргаж дараахь баримт бичгийг аль нэгийг хавсаргана:

14.5.1.нөхөр, эхнэрийн хэн нэгийг нас барсанд тооцсон тухай шүүхийн шийдвэр;

14.5.2.нөхөр, эхнэрийн хэн нэгийг эрх зүйн чадамжгүй гэж тооцох тухай шүүхийн шийдвэр;

14.5.3.нөхөр, эхнэрийн хэн нэг нь 3-аас дээш жил хорих ял эдлэх бол энэ тухай шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолын хуулбар

14.6.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан энэ хуулийн 14.2, 14.3, 14.5-д заасан баримт бичгийг хавсаргасан өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн гэрлэлт цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрлэлтийг цуцалсан гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

14.6.1.гэрлэлтээ цуцлуулсан нөхөр, эхнэрийн харьяалал, овог, эцгийн нэр, нэр;

14.6.2.гэрлэлт дуусгавар болсон хугацаа;

14.6.3.гэрлэлтийг цуцалсан байгууллагын нэр, он, сар, өдөр;

14.6.4.бүртгэл үйлдсэн газрын нэр, албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг.

14.7.Гэрлэлт цуцалсны бүртгэлийг гэрлэлт бүртгэснээс өөр газар бүртгэсэн бол иргэний бүртгэлийн ажилтан уг бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг холбогдох аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл мэдээллийн алба, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд тус тус явуулна.

14.8.Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэрлэлтээ цуцлуулах асуудлаа Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Гэр бүлийн тухай Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

14.9.Гэрлэгчдийн хэн нэг нь Монгол Улсын харьяат иргэн нөгөө нь гадаад улсын харьяат иргэн бөгөөд тэдгээр нь гадаад улсын хууль тогтоомжийн дагуу гэрлэлтээ цуцлуулсан нь Монгол Улсын хууль тогтоомжид харшлахгүй бол тухайн орны эрх бүхий байгууллагаас олгосон баримт бичиг, түүний нотариатаар гэрчлүүлсэн орчуулгыг үндэслэн иргэний бүртгэлийн ажилтан иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэж, гэрлэлтийг цуцалсны гэрчилгээ олгож болно.

15 дугаар зүйл. Гэрлэлт сэргээсэн тухай бүртгэл

15.1.Нөхөр, эхнэр хамтран гэрлэлтээ сэргээсэн тухай бүртгүүлнэ.

15.2.Нөхөр, эхнэр хамтран гэрлэлтээ сэргээх тухай өргөдлөө оршин суугаа газрынхаа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргах бөгөөд дараахь баримт бичгийн аль нэгийг хавсаргана:

15.2.1.иргэнийг сураггүй алга болсонд тооцсон, эсхүл нас барсан гэж зарласан шийдвэр хүчингүй болсон тухай шүүхийн шийдвэрийн

хуулбар;

15.2.2.гэрлэлт цуцалсан шийдвэрийг хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийн хуулбар;

15.2.3.захиргааны журмаар гэрлэлтийг цуцалсан тухай гэрчилгээ.

15.3.Иргэний бүртгэлийн ажилтан гэрлэлт сэргээснийг бүртгэхдээ иргэний баримтын төв архиваас нөхөр буюу эхнэр нь өөр хүнтэй гэрлээгүйг лавлаж тодруулсны дараа гэрлэлтийг сэргээсэн тухай бүртгэж, гэрлэлтийн гэрчилгээг шинээр бичиж олгоно.

16 дугаар зүйл. Үрчлэлтийн бүртгэл

16.1.Үрчлэн авагч нь хүүхдийг үрчлэн авсан тухайгаа иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгүүлнэ.

16.2.Үрчлэн авагч, хүүхэд үрчлэн авах тухай өргөдлөө /өргөдөлд хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон үрчлэн авагчийн овог, эцгийн нэр, нэр, оршин суугаа газрын хаяг, шаардлагатай бол аль улсын харьяат болохыг дурдсан байна/ хүүхдийн оршин сууж байгаа буюу урьд оршин сууж байсан газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргах бөгөөд өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

16.2.1.гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээ:

16.2.2.хүүхдийн төрсний гэрчилгээ;

16.2.3.үрчлэн авагч болон үрчлүүлж байгаа эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн иргэний үнэмлэх;

16.2.4.асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүүхэд бол тухайн байгууллагын зөвшөөрөл.

16.3.Гадаадын иргэн Монгол Улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харьяалалгүй хүүхдийг үрчлэн авах тухай нотариатаар гэрчлүүлсэн хүсэлтээ нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, орон нутагт аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл мэдээллийн албанд тус тус бичгээр гаргана.

16.4.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай гадаадын иргэнээс гаргасан хүсэлтийг хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар энэ хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

16.5.Монгол Улсын харьяат болон тус улсын нутаг дэвсгэр дээр оршин суугаа харьяалалгүй хүүхдийг үрчлэн авах журам болон гадаадын иргэнээс бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

16.6.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар, дипломат төлөөлөгчийн болон консулын газар энэ хуулийн 16.2, 16.5-д заасан баримт бичгийг хүлээн авч хүүхэд үрчилсэн тухай бүртгэж, төрсний гэрчилгээг шинээр бичиж, үрчлэн авсан эцэг, эхэд олгоно. Хүүхдээ үрчлүүлсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхэд үрчлүүлсний гэрчилгээ олгоно. Хүүхэд үрчлүүлсний гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

16.6.1.хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, хүйс, төрсөн газар;

16.6.2.үрчилж авсан болон үрчлүүлсэн эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн овог, эцгийн нэр, нэр;

16.6.3.үрчилсний бүртгэл үйлдсэн газрын нэр, гэрчилгээний дугаар;

16.6.4.үрчилсний бүртгэл үйлдсэн он сар, өдөр, албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг.

16.7.Үрчилсний бүртгэлийг хүүхдийн төрснийг бүртгэснээс өөр газар бүртгэсэн бол иргэний бүртгэлийн ажилтан уг бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг хүүхдийн төрснийг бүртгэсэн сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлнэ.

16.8.Энэ хуулийн 16.2, 16.3, 16.4-д заасан байгууллага шаардлагатай тохиолдолд хүүхэд үрчилсэн тухай тодорхойлолт гаргаж өгч болно.

16.9.Үрчлэлтийг хүчингүй болсонд тооцсон тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн иргэний бүртгэлийн ажилтан уг бүртгэлд өөрчлөлт оруулж төрсний гэрчилгээг нь сэргээж, төрсөн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид олгоно.

17 дугаар зүйл. Эцэг тогтоосон тухай бүртгэл

17.1.Эцэг тогтоосныг эцэг, эхийн хамтран гаргасан өргөдөл, эсхүл эх нь нас барсан, шүүхээс нас барсан буюу эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон, эх байх эрхээ хасуулсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон бол эцгийн дангаараа гаргасан хүсэлтээр, түүнчлэн эцэг тогтоосон тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг тус тус үндэслэн бүртгэнэ.

17.2.Хүүхдийн эцгийг шүүхээс тогтоосныг бүртгүүлэх тухай өргөдлөө хүүхдийн эх, эсхүл эцэг, 16 нас хүрсэн хүүхэд өөрөө оршин суугаа газрынхаа, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхдийн оршин суугаа болон урьд сууж байсан газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргаж шүүхийн шийдвэрийг хавсаргана.

17.3.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн хүүхдийн эцгийг тогтоосныг эцэг, эхийн хамтран гаргасан өргөдлийг /өргөдөлд хүүхдийн эцэг мөн болохоо хүлээн зөвшөөрч байгаа иргэний овог, эцгийн нэр, нэр төрсөн он, сар, өдөр, иргэний харьяалал, оршин суугаа газрын хаяг, хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, газар, эцэг тогтоосны дараа хүүхдийн овог, эцгийн нэр, өөрчлөгдөх эсэхийг дурдсан байна/ үндэслэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд бүртгэнэ.

17.4.Хүүхдийн эх нь нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тус тооцогдсон, эх байх эрхээ хасуулсан бол эхтэй нь гэрлэлтээ бүртгүүлээгүй хүүхдийн эцэг дангаараа өргөдлөө /өргөдөлд хүүхдийн эцэг мөн болохоо хүлээн зөвшөөрч байгаа иргэний овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг, хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, хүйс, төрсөн он, сар, өдөр, эцэг тогтоосны дараа хүүхдийн овог, эцгийн нэр өөрчлегдөх эсэхийг дурдсан байна/ оршин суугаа газрынхаа, эсхүл хүүхдийн оршин суугаа болон урьд сууж байсан газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт гаргаж дараахь баримт бичгийн аль нэгийг хавсаргана:

17.4.1.хүүхдийн эх нас барсан тухай гэрчилгээ;

17.4.2.хүүхдийн эхийг эрх зүйн чадамжгүй гэж тооцсон шүүхийн шийдвэр буюу түүний хуулбар;

17.4.3.хүүхдийн эхийн эх байх эрхийг нь хассан шүүхийн шийдвэр буюу түүний хуулбар;

17.4.4.хүүхдийн эхийг сураггүй алга болсонд тооцсон тухай шүүхийн шийдвэр буюу түүний хуулбар.

17.5.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан энэ хуулийн 17-д заасан баримт бичгийг хүлээн авч эцэг тогтоосныг бүртгэж, төрсний гэрчилгээг шинэчлэн олгоно.

17.6.Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнтэй холбогдсон эцэг тогтоосныг бүртгэхдээ энэ хуулийн 17-д заасныг баримтална.

17.7.Хүүхдийн эхийг тогтоосныг бүртгэхдээ энэ хуулийн 17.4-д заасан журмыг баримтална.

18 дугаар зүйл. Овог,эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл

18.1.Иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчилснийг өргөдөл гаргагчийн оршин суугаа, эсхүл оршин байгаа болон төрсний бүртгэсэн газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газар Засаг даргын захирамжийг үндэслэн бүртгэнэ.

18.2.Бага насны болон шүүхээс эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчлөх асуудлыг түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлөөр бүртгэнэ.

18.3.Насанд хүрээгүй хүний овог, эцгийн нэр, нэр өөрчлөх тохиолдолд түүний зөвшөөрлийг бичгээр авна.

18.4.Иргэн овог, эцгийн нэр, нэрээ өөрчлөх тухай өргөдлөө /өргөдөлд өргөдөл гаргагчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн байдал, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн овог, эцгийн нэр, нэр, өргөдөл гаргагчийн сонгож авсан овог, эцгийн нэр, нэр, тэдгээрийг өөрчлөх болсон үндэслэл зэргийг дурдсан байна/ гаргаж дараахь баримт бичгийг хавсаргана:

18.4.1.төрсний гэрчилгээ;

18.4.2.иргэний үнэмлэхийн хуулбар;

18.4.3. арван зургаан нас хүрээгүй хүн бол төрсний гэрчилгээний хуулбар;

18.4.4. арван зургаа ба түүнээс дээш насны хүүхдийн бичгээр гаргасан зөвшөөрөл;

18.4.5.өргөдөл гаргагч гэр бүлтэй бол гэрлэлтийн гэрчилгээ;

18.4.6.ял шийтгэлгүй тухай цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

18.4.7.гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгосон тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг;

18.4.8.улсын тэмдэгтийн хураамж төлсөн тасалбар.

18.5.Иргэний нэр өөрчилснийг бүртгэхдээ түүний нэрээр овоглодог хүүхдийн эцгийн нэрийг нэг адил өөрчилнө.

18.6.Гадаадын иргэнтэй гэр бүл болсон Монгол Улсын харьяат эмэгтэй хүнийг нөхрийнх нь овгоор бүртгэж болно.

18.7.Иргэний овог, эцгийн нэр, нэрийг 1-ээс илүүгүй удаа өөрчлөхийг зөвшөөрнө. Иргэн урьдын овог, эцгийн нэр, нэрээ авахаар өргөдөл гаргаж болно.

18.8.Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хориглол, хорих ял эдэлж байсан хүний овог, эцгийн нэр, нэр өөрчлөхийг хориглоно.

18.9.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар энэ хуулийн 18.4-т заасан баримт бичгийг хүлээн авч иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчилснийг 30 хоногийн дотор бүртгэн, иргэний баримт бичгийг шинэчилж, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний гэрчилгээг олгоно. Хүндэтгэн үзэх шалтгаан байгаа бол сум, дүүргийн Засаг дарга тухайн өргөдлийг хянан шийдвэрлэх хугацааг 30 хоногоор сунгаж болно. Овог, эцгийн нэр, нэр өөрчилсний гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

18.9.1.овог, эцгийн нэр, нэрээ өөрчлөгчийн төрсөн он, сар, өдөр;

18.9.2.овог, эцгийн нэр, нэр;

18.9.3.сум, дүүргийн Засаг даргын захирамжийн он, сар, өдөр, дугаар, шинэчилсэн овог, эцгийн нэр, нэр;

18.9.4.бүртгэл үйлдсэн он, сар, өдөр, гэрчилгээний дугаар;

18.9.5.бүртгэл үйлдсэн газрын нэр, албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

18.10.Иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.11.Боловсролын болон нийгмийн даатгалын байгууллага овог, эцгийн нэр, нэр өөрчилсөн тухай гэрчилгээг үндэслэн диплом, үнэмлэх, нийгмийн даатгалын болон эрүүл мэнд, тэтгэврийн дэвтрийг сольж олгож болно.

19 дүгээр зүйл.Нас барсны бүртгэл

19.1.Иргэний нас барсныг түүний эцэг, эх, нөхөр, эхнэр, 18 нас хүрсэн хүүхэд, төрөл садан, бусад хүн, ажиллаж, суралцаж, эмчлүүлж, сувилуулж, цэргийн алба хааж байсан байгууллагын захиргаа төв суурин газарт 5 хоног, орон нутагт 10 хоног, тодорхой биш шалтгаанаар нас барсан бүюу цогцос олдсон тохиолдолд цагдаагийн байгууллага төв суурин газар болон орон нутагт 10 хоногт нас барагчийн оршин суух байсан, эсхүл нас барсан, цогцос олдсон газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлнэ.

19.2.Иргэн нас барсан тухай бүртгэл нь түүний оршин суух байсан газраас өөр газар бүртгэгдсэн бол иргэний бүртгэлийн ажилтан уг бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг нас барагчийн харьяалагдах сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт явуулна.

19.3.Иргэний нас барсныг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар дараахь баримт бичгийн аль нэгийг үндэслэн бүртгэнэ:

19.3.1.нас барсан тухай эмнэлгийн магадлагаа, нас барагчийг оршуулсан тухай тодорхойлолт;

19.3.2.Тухайн иргэнийг нас барсан тухай зарласан шүүхийн шийдвэр буюу түүний хуулбар;

19.3.3.нас барсан шалтгааны талаар гарсан шүүх эмнэлгийн дүгнэлт.

19.4.Шүүхийн шийдвэрээр иргэнийг нас барсан гэж зарласан бол түүний төрөл садан, ажиллаж, суралцаж, эмчлүүлж, сувилуулж байсан байгууллагын захиргаа, бусад хүн шийдвэр гаргасан шүүхийн оршин байгаа газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт бүртгүүлнэ.

19.5.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар энэ хуулийн 19.3-т заасан баримт бичгийг хүлээн авч иргэний нас барсныг бүртгэж, гэрчилгээ олгоно. Гэрчилгээнд дараахь зүйлийг тусгана:

19.5.1.нас барагчийн нас барсан он, сар, өдөр, газар;

19.5.2.нас барагчийн овог, эцгийн нэр, нэр, төрсөн он, сар, өдөр, газар;

19.5.3.иргэний харьяалал, оршин сууж байсан газрын хаяг;

19.5.4.нас барсныг бүртгэсэн албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

19.5.5.гэрчилгээ олгосон он, сар, өдөр.

19.6.Цагдаагийн болон шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад гэмт хэрэг үйлдсэний улмаас цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан буюу хорих газар ял эдэлж байгаа хүн нас барсан бол нас барагчийн оршин сууж байсан газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт, хэрэв оршин сууж байсан газар нь тодорхойгүй бол тухайн цагдаагийн буюу хорих байгууллагын оршин байгаа газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт, цаазаар авах ялыг гүйцэтгэсэн бол Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвд 10 хоногийн дотор тус тус бүртгүүлж, нас барсны гэрчилгээг нас барагчийн төрөл саданд нь хүргүүлнэ.

19.7.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр, эсхүл тус улсын агаарын болон бусад хөлөг осолдсоны улмаас нас барсан гэж үзэх үндэстэй үед алга болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Иргэний хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нас барсан гэж зарласныг бүртгэж болно.

19.8.Монгол Улсын харьяат иргэн гадаад улсын нутаг дэвсгэр дээр нас барсан бол хилийн чанад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар энэ хуулийн 19-д заасны дагуу бүртгэнэ.

20 дугаар зүйл. Хүйс өөрчлөгдсөнийг бүртгэх

20.1.Монгол Улсын иргэн эмнэлгийн журмаар хүйсээ солиулсан, эсхүл байгалийн жамаар нэг хүйс нь давамгайлсан бол энэ тухай эмнэлгийн магадлагааг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэхийг шинэчлэн олгож болно.

21 дүгээр зүйл. Хүн амын өрхийн бүртгэл

21.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль[1]-ийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8-д заасны дагуу баг, хорооны Засаг дарга нь өрх, хүн амын тооллого явуулж, бүртгэл судалгаа хөтлөн шаардлагатай үед тодорхойлолт олгож болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ, ҮНДЭСНИЙ ГАДААД ПАСПОРТЫН БОЛОН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ

22 дугаар зүйл.Иргэний үнэмлэх

22.1.Монгол Улсын иргэний үнэмлэх нь тус улсын иргэн мөн болохыг батлан гэрчлэх баримт бичиг болно. Монгол Улсын иргэний үнэмлэх батлагдсан загвартай байна.

22.2.Монгол Улсын иргэний үнэмлэхийн загвар, тодорхойлолт болон дүрмийг Монгол Улсын Засгийн газар батална.

22.3.Иргэний үнэмлэхийг 16 нас хүрсэн иргэнд шинээр, 25, 45 насны иргэдэд сольж, 45-аас дээш насны иргэдэд хугацаагүй олгоно.

22.4.Монгол Улсын харьяат 16 нас хүрсэн иргэн оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт иргэний үнэмлэх авах тухай өргөдлөө гаргаж, дараахь баримт бичгийн аль нэгийг хавсаргана:

22.4.1.төрсний гэрчилгээ;

22.4.2.Монгол Улсын харьяат болгосон болон иргэний харьяаллыг сэргээн тогтоосон

[1] Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль.- "Ардын эрх" сонины 1992 оны 126, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 4, 5 дугаарт тус тус нийтлэгдсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг.

22.5.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар энэ хуулийн 22.4-т заасан баримт бичгийг хүлээн авч 30 хоногийн дотор иргэний үнэмлэх олгоно. Монгол Улсын харьяат 16-аас дээш насны бүх хүн иргэний үнэмлэхтэй байна.

22.6.Оршин суух тодорхой хаяггүй Монгол Улсын харьяат иргэнд цагдаагийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэн тухайн цагдаагийн байгууллага оршин байгаа нутаг дэвсгэрийн сум, дүүргийн Засаг даргын тамгын газар иргэний үнэмлэх олгож болно.

22.7.Иргэний үнэмлэхийг бусдад шилжүүлэх, барьцаалах, санаатайгаар гэмтээхийг хориглоно.

23 дугаар зүйл.Үндэсний гадаад паспорт, буцах үнэмлэх, хүчхдийн үнэмлэх

23.1.Үндэсний гадаад паспорт, Монгол Улсад буцах үнэмлэх, хүчхдийн үнэмлэх нь Монгол Улсын иргэнийг гадаад улсад зорчин явааг батлан гэрчлэх баримт бичиг болно.

23.2.Үндэсний гадаад паспорт нь дипломат, албан, энгийн гэсэн ангилалтай байна.

23.3.Дипломат, албан паспорт болон түүнд хавсаргах хүчхдийн үнэмлэхийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны тэн байгууллага, энгийн гадаад паспорт болон түүнд хавсаргах хүчхдийн үнэмлэхийг нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, орон нутагт аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл мэдээллийн алба тус тус олгож, хугацааг сунгах, хүчингүй болгох, нэгдсэн бүртгэл хөтлөх ажлыг эрхэлнэ.

23.4.Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газар шаардлагатай тохиолдолд дипломат, албан, энгийн гадаад паспорт, Монгол Улсад буцах үнэмлэх, хүчхдийн үнэмлэх олгох, хугацааг сунгах, хүчингүй болгох эрхтэй.

23.5.Үндэсний гадаад паспорт олгох, эзэмших, хадгалах журмыг Монгол Улсын Засгийн газар тогтооно.

24 дүгээр зүйл. Оршин суух үнэмлэх

24.1.Монгол Улсын эрх бүхий байгууллагаас олгосон Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн дагуу цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад оршин суух үнэмлэхийг Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв олгоно.

25 дугаар зүйл. Иргэн түр болон бүрмөсөн шилжин суурьших

25.1.Иргэн байнга оршин сууж байгаа засаг захиргааны нэг нэгжээсээ нөгөөд 180 хоногоос дээш хугацаагаар оршин суухыг бүрмөсөн шилжин суурьших, 180 хоног ба түүнээс доош хугацаагаар оршин суухыг түр шилжин суурьших гэнэ.

26 дугаар зүйл. Шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх

26.1.Иргэнийг аймгаас аймагт, аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар эрхэлнэ.

26.2.Иргэнийг аймаг болон нийслэлийн дотор шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулж бүртгэх, мэдээлэх ажлыг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, мэдээлэх ажлыг хариуцна.

26.3.Дараахь баримт бичгийг үндэслэн иргэний шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэнэ:

26.3.1.Монгол Улсын иргэний үнэмлэх:

26.3.2.Монгол Улсын иргэн 16 нас хүрээгүй бол төрсний гэрчилгээ;

26.3.3.гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн бол энгийн гадаад паспорт;

26.3.4.хорих газраас суллагдсан хүн бол шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагаас олгосон магадлагаа;

26.3.5.иргэнийг тухайн хувь хүн мөн болохыг гэрчлэх бусад баримт бичиг;

26.3.6.гадаадын иргэн бол тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон паспорт, иргэний үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичиг;

26.3.7.батлан хамгаалах болон цагдаагийн байгууллагын алба хаагч бол томилогдсон тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

26.3.8.оршин сууж байсан нутаг дэвсгэрийн сум, дүүрэг, хорооны хүн амын бүртгэлээс хасуулсан тухай тодорхойлолт.

26.4.Иргэн аливаа засаг захиргааны нэгжид 180 хоногоос дээш хугацаагаар оршин суух-

даа 10 хоногийн дотор холбогдох сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт оршин суугаа газрынхаа хаягийн бүртгэлийг иргэний үнэмлэхэд тэмдэглүүлнэ.

26.5.Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугаа цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шилжин суурьших тохиолдолд энэ хуулийн 36-д заасан журмыг баримтална.

26.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмыг Засгийн газар тогтооно.

27 дугаар зүйл. Гадаадад цагаачлан гарсан Монгол Улсын иргэний бүртгэл

27.1.Гадаадад цагаачлан гарсан Монгол Улсын иргэний нэгдсэн бүртгэлийг Монгол Улсын Иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль[1]-ийн 6 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан байгууллага эрхлэн хөтөлнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ИРГЭНИЙ БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

28 дугаар зүйл. Монгол Улсын иргэний регистрийн дугаар

28.1.Монгол Улсын харьяат иргэн бүр регистрийн дугаартай байна.

28.2.Регистрийн дугаар нь Монгол Улсын иргэний үнэмлэх, эсхүл түүнийг орлох баримт бичиг, энгийн гадаад паспорт болон иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээ, хадгаламж, даатгалын дэвтэр, жолоодох эрхийн үнэмлэх зэрэг баримт бичигт бичигдэнэ.

29 дүгээр зүйл. Иргэний бүртгэл, мэдээллийн сан

29.1.Иргэний бүртгэл, мэдээллийн сан дараахь мэдээллийг агуулна:

29.1.1.Монгол Улсын нийт иргэний;

29.1.2.төрсний;

29.1.3.гэрлэсний, гэрлэлт сэргээсний;

29.1.4.гэрлэлт цуцлуулсны;

29.1.5.овог, эцгийн нэр, нэр өөрчилсний;

29.1.6.эцэг тогтоосны;

29.1.7.үрчилсний;

29.1.8.нас барсны;

29.1.9.иргэний үнэмлэх авсан, хүчингүй болгосон;

29.1.10.энгийн гадаад паспорт авсан, хүчингүй болгосон;

29.1.11.шилжин ирсэн, явсан;

29.1.12.Монгол Улсын харьяатаас гарсан,харьяат болсон;

29.1.13.Монгол Улсад байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний;

29.1.14.Монгол Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэний.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан иргэний бүртгэл, мэдээллийн санг /цаашид ИБМ-ийн сан гэх/ Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв хөтөлнө.

29.3.ИБМ-ийн сан үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байна.

29.4.Төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар өөрийн чиг үүрэгтэй холбоотой мэдээллийн сантай байж болно.

29.5.ИБМ-ийн санг зохих журмын дагуу Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс зөвшөөрөл авсан эрх бүхий албан тушаалтан ажиллуулж болно.

29.6.ИБМ-ийн санг ажлын шаардлагаар ашиглах үүрэг бүхий байгууллага зөвхөн өөрт холбогдох мэдээллийг ашиглана.

29.7.Бусад мэдээллийг ашиглах шаардлагатай бол Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс зөвшөөрөл авна.

29.8.ИБМ-ийн сангийн мэдээллийг ашиглагч

[1] Монгол улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль. -Ардын эрх" сонины 1994 оны 7, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 2 дугаарт тус тус нийтлэгдсэн.

байгууллага нь хувь хүнтэй болон нийт мэдээлэлтэй холбоотой нууцыг хадгалах үүрэгтэй.

29.9.ИБМ-ийн сангийн баримт бичгийн нэг хувийг иргэний баримтын төв архивт, хоёр дахь хувийг аймаг, нийслэлийн иргэнийбаримтын архивт тус тус хадгална.

29.10.ИБМ-ийн сангийн мэдээллийг зориулалтын бусаар ашиглах, хуулбарлахыг хориглоно.

29.11.ИБМ-ийн сан төрийн өмч байна.

30 дугаар зүйл. Иргэний бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулах

30.1.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл мэдээллийн алба иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд орсон нэмэлт, өөрчлөлтийг үндэслэн ИБМ-ийн санд хадгалагдаж байгаа мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

ИРГЭНИЙ БҮРТГЭЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ИРГЭНИЙ БАРИМТ БИЧГИЙГ ДАХИН ОЛГОХ

31 дүгээр зүйл. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах

31.1.Иргэний бүртгэлийн ажилтан дор дурдсан үндэслэлээр иргэний гэр бүлийн байдлын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулна:

31.1.1 үрчлэлтийг бүртгэсэн бүртгэл;

31.1.2.эцэг тогтоосныг бүртгэсэн бүртгэл;

31.1.3.иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчилснийг бүртгэсэн бүртгэл;

31.1.4.шүүхийн шийдвэр;

31.1.5.олдсон цогцсыг цагдаагийн байгууллагаас хэн болохыг нь тодруулан тогтоосон баримт бичиг.

31.2.Иргэний бүртгэлд мэдээлэл бүрэн бус, үг үсгийн алдаатай тусгагдсан бол энэ талаар сум, дүүргийн Засаг даргын дүгнэлтийг үндэслэн эрх бүхий ажилтан иргэний бүртгэлд өөрчлөлт оруулж болно.

31.3.Иргэний бүртгэлд орсон нэмэлт, өөрчлөлтийн бичилтийг үндэслэн иргэний бүртгэлийн ажилтан иргэний баримт бичгийг шинэчлэн иргэнд олгоно.

32 дугаар зүйл. Иргэний баримт бичгийг дахин олгох

32.1.Иргэний баримт бичгийг иргэний биечлэн гаргасан өргөдлөөр, насанд хүрээгүй хүний төрсний гэрчилгээг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч буюу хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагын өргөдлөөр, нас барсан тухай гэрчилгээг холбогдох иргэний өргөдлөөр бүртгэлийг анх хөтөлсөн, эсхүл тухайн иргэний оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргын тамгын газар дахин олгож болно.

32.2.Баримт бичгийг дор дурдсан тохиолдолд дахин олгоно:

32.2.1.баримт бичгийг гээсэн, үрэгдүүлсэн бол, энэ тухай холбогдох байгууллагын тодорхойлолт, зарыг үндэслэн;

32.2.2.Хүндэтгэн үзэх шалтгаанаар хууль ёсны баримт бичиг болж чадахгүй /урагдсан, үг үсэг нь мэдэгдэхгүй болсон зэрэг/;

32.2.3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль[1]-ийн 151 дүгээр зүйлд заасан ёсоор шүүхийн шийдвэр гарсан.

32.3.Сум, дүүргийн Засаг даргын тамгын газар эцэг, эх байх эрхээ хасуулсан хүнд хүүхдийн төрсний, гэрлэлтээ цуцлуулсан, эсхүл гэрлэлт нь хүчин төгөлдөр бус гэж шүүхээр тооцогдсон хүмүүст гэрлэлтийн гэрчилгээг тус тус дахин олгохгүй.

32.4.Энэ хуулийн 32.3-д заасан хүмүүсийн өргөдлөөр сум, дүүргийн Засаг даргын тамгын газар хүүхэд төрсөн, эсхүл гэрлэлтээ бүртгүүлж байсан тухай тодорхойлолт олгож болно.

33 дугаар зүйл. Хүн амын өрхийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах

33.1.Баг, хорооны Засаг дарга иргэний бүртгэлийн ажилтнаас олгосон үнэмлэх, гэрчилгээ, тодорхойлолтыг үндэслэн хүн амын өрхийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

[1] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль.- "Ардын эрх" сонины 1994 оны 130-133, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 8-рт тус тус нийтлэгдсэн.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ
ИРГЭНИЙ БҮРТГЭЛД ХИЙСЭН БИЧИЛТИЙГ СЭРГЭЭН ТОГТООХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

34 дүгээр зүйл. Иргэний бүртгэлд хийсэн бичилтийг сэргээн тогтоох

34.1.Иргэний бүртгэлийн ажилтан шүүхийн, эсхүл сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэний бүртгэлд хийсэн бичилтийг сэргээн тогтооно.

34.2.Иргэний бүртгэлд анхны болон сэргээн тогтоосон бичилт байхгүй талаар сум, дүүргийн Засаг даргын тамгын газраас өгсөн баримтыг үндэслэн иргэн эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогоолгох өргөдлөө шүүхэд гаргана.

34.3.Иргэний бүртгэлийн сэргээн тогтоосон бичилтийг үндэслэн иргэний бүртгэлийн ажилтан иргэний үнэмлэх, иргэний гэр бүлийн байдлын гэрчилгээ, тодорхойлолт олгоно.

35 дугаар зүйл.Иргэний бүртгэлд хийсэн бичилтийг хүчингүй болгох

35.1.Иргэний бүртгэлийн ажилтан иргэний бүртгэлд хийсэн бичилтийг хүчингүй болгох тухай шүүхийн, эсхүл сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэний бүртгэлд хийсэн бичилтийг хүчингүй болгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ
ГАДААДЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛ

36 дугаар зүйл. Гадаадын иргэний бүртгэл

36.1.Монгол Улсад төрийн болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллагын урилгаар ирсэн зорчигчоос бусад гадаадын иргэнийг урьж ирүүлсэн иргэн, хуулийн этгээд тэдгээрийг ирсэн өдрөөс нь хойш 10 хоногийн дотор нийслэлд Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд, орон нутагт аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албанд бүртгүүлнэ.

36.2.Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, мөн хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэн, тэдгээрийн гэр бүлийн гишүүнийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Монгол Улсад ирсэн өдрөөс хойш 10 хоногийн дотор бүртгүүлнэ.

36.3.Монгол Улсад албан ёсны зөвшөөрөлтэй гадаадын хөрөнгө оруулалттай болон гадаадын компани, гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт ажиллахаар ирсэн гадаадын иргэн эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн дагуу нийслэлд Иргэний бүртгэл мэдээллийн улсын төвд, орон нутагт аймгийн Засаг даргын дэргэдэх иргэний бүртгэл, мэдээллийн албанд 10 хоногийн дотор бүртгүүлнэ.

36.4.Гадаадын иргэн, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг бүртгэх, мэдээлэх журмыг Засгийн газар тогтооно.

36.5.Хуульд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт оршин суугаа цагаач гадаадын иргэн өөр засаг захиргааны нэгжид шилжин суурьших бол оршин сууж байсан нутаг дэвсгэрийн аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл мэдээллийн албаны бүртгэлээс хасуулж, очсон газрын аймгийнхаа Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албанд 7 хоногийн дотор бүртгүүлж, оршин суух үнэмлэхдээ тэмдэглэл хийлгэнэ.

36.6.Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэр бүлийнхээ байдал, хөдөлмөр эрхлэлтийн талаархи хөдөлгөөн, өөрчлөлтийг 7 хоногийн дотор оршин суугаа аймгийнхаа Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албанд мэдэгдэнэ.

36.7.Монгол Улсад албан болон хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн байнга оршин суугаа газраасаа өөр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэрт 7 хоногоос дээш хугацаагаар хувийн хэргээр зорчих тохиолдолд очсон аймгийнхаа Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн албанд бүртгүүлнэ.

36.8.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв Монгол Улсад удаан хугацаагаар хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгогдсон гадаадын иргэний бүртгэл хөтөлж, тэдгээ-

рийн паспортод оршин суух хаягийн тэмдэглэл хийнэ.

36.9.Монгол Улсад зорчигч, дамжин өнгөрөгч, хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр зорчигч гадаадын иргэний бүртгэлийг Хилийн цэргийн удирдах газар, хяналтыг Засгийн газрын эрх олгосон төрийн захиргааны байгууллага зохион байгуулж холбогдох байгууллагыг мэдээллээр хангана.

36.10.Гадаадын иргэнтэй холбоотой бүх төрлийн мэдээг холбогдох төрийн захиргааны байгууллагууд Гадаадын иргэдийн асуудал эрхлэх эвлэлд тогтоосон хугацаанд ирүүлж байна.

36.11.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв нь Монгол Улсад орж ирсэн, гарч явсан болон дамжин өнгөрсөн гадаадын иргэдийн мэдээг улсын хил хамгаалалтын байгууллагаас тогтоосон маягтаар сар бүр авч, гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж байна.

36.12.Цагдаагийн төв байгууллага нь тус улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн, ял шийтгүүлсэн, ял шийтгэлээд тооцогдож байгаа, Монгол Улсаас албадан гаргагдсан болон олон улсын эрх бүхий байгууллагаас аливаа улс оронд орохыг хориглосон, эрэн сурвалжлагдаж байгаа гадаадын иргэний тухай мэдээг холбогдох байгууллагад өгч байна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

37 дугаар зүйл. Архивын баримт бичиг

37.1.Иргэний баримтын төв архивын үндсэн баримт нь хүүхэд төрсөн, үрчлэн авсан, гэрлэсэн, гэрлэснийг цуцалсан, гэрлэлт сэргээсэн, эцэг тогтоосон, иргэний овог, эцгийн нэр, нэр өөрчилсөн, нас барсныг улсын бүртгэлд бүртгэсэн, хаягийн өөрчлөлт, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар олгосон бүртгэлийн дэвтрээс бүрдэнэ.

37.2.Иргэний баримтын төв архивын баримтын хадгалалт, хамгаалалт, нөхөн бүрдүүлэлт, ашиглалттай холбогдсон харилцааг Архивын тухай хууль[1]-иар зохицуулна.

38 дугаар зүйл. Иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

38.1.Иргэний бүртгэлтэй холбогдсон хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврыг тус улсын нутаг дэвсгэрт байгаа нийт иргэн, байгууллага хэрхэн сахин биелүүлж байгаад Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

38.2.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, сум, дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч тус тус ажиллана.

38.3.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга нь улсын ерөнхий байцаагч, аймагт иргэний бүртгэлийн ажилтан улсын ахлах байцаагч байна.

38.4.Иргэний бүртгэл, мэдээллийн улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

38.5.Энэ хуулийн 38.2-т заасан улсын байцаагч нь иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрчигчид захиргааны хариуцлага хүлээлгэх эрх эдэлнэ.

38.6.Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь батлагдсан хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

39 дүгээр зүйл. Иргэний бүртгэлийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

39.1.Иргэний бүртгэлийн ажилтны хууль бус үйл ажиллагааны улмаас Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрх хохирсон бол учирсан гэм хорыг хууль тогтоомжид заасны дагуу арилгана.

39.2.Иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрчсөн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

40 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэх

40.1.Иргэний бүртгэлтэй холбогдсон маргааныг шүүх шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

---

[1] "Архивын тухай хууль"- "Ардын эрх" сонины 1998 оны 29; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1998 оны 2 дугаарт тус тус нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх заалтад "26\" гэсний дараа "27, мөн хуулийн 27 дугаар зүйлд "Монгол Улсын иргэний" гэсний дараа "үнэмлэх", "паспорт" гэсний дараа "иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг" гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн гарчигийн "паспорт" гэснийг "иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт,иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Захиргааны хариуцлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь заалтын "27" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлд "7/иргэний бүх төрлийн бүртгэлийн ажлыг нэгтгэн зохион байгуулж, удирдах." гэсэн 7 дахь заалт нэмсүгэй.

2 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн "7" дахь заалтын дугаарыг "8" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"26 дугаар зүйл.Гадаадын иргэнийг бүртгэх

Монгол Улсад зорчигч, түр болон удаан хугацаагаар оршин суугч гадаадын иргэнийг бүртгэхдээ Иргэний бүртгэлийн тухай хуулийн 36 дугаар зүйлийг баримтална."

2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "цагдаагийн төв байгууллагаас" гэснийг "Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвөөс" гэж, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "цагдаагийн байгууллагад" гэснийг "Иргэний бүртгэл, мэдээллийн албанд" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийн "цагдаагийн байгууллагад" гэснийг "аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба", мөн зүйлийн 7, 8 дахь хэсэг болон 8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "цагдаагийн байгууллага" гэснийг аймгийн Засаг даргын дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алба" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Д.ГАНБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Улаанбаатар хот**

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд дор дурдсан агуулгатай 4.3; 8.2; 8.5; 8.6; 8.7; 10.3 гэсэн хэсэг тус тус нэмсүгэй:

1/ 4.3:

"4.3.Гадаад улсын шүүх, түүнийг орлосон байгууллагын шийдвэрээр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Монгол Улсын иргэнийг цагаатгуулах, цагаатгагдсан хүмүүст тухайн улсын хууль тогтоомжийн дагуу олгогдох нөхөх олговрыг шилжүүлэн авах асуудлыг тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу Засгийн газар эрхлэн шийдвэрлэнэ. Гадаад улсаас нэхэмжлэн авсан нөхөх олговрыг улс төрийн хэлмэгдэгсдэд олгож байгаа нөхөх олговорт зориулан зарцуулна."

2/ 8.2; 8.5; 8.6; 8.7:

"8.2.Улс төрийн хэрэгт холбогдуулан мөрдөн байцаалт явуулж эрүүгийн хуулийн өөр зүйл ангиар ял шийтгэсэн тохиолдолд иргэний болон цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, орон нутгийн салбар комиссын өргөдөл, гомдол, саналыг үндэслэн Монгол улсын дээд шүүх холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, уг этгээдийг цагаатгах, эсхүл хилс хэрэгт ял шийтгүүлсэн нь тогтоогдоогүй бол гомдлыг хэрэгсэхгүй болгох тухай шийдвэрийн аль нэгийг гаргаж болно.

8.5.Улс төрийн хэрэгт холбогдуулан барив-чилж, мөрдөгдсөн хүмүүсийн мөрдөн байцаалтын архивын хэрэг нь Улсын аюулгүй байдлыг хангах газрын архивт байгаа боловч шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол нь байхгүй тохиолдолд иргэний болон цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, орон нутгийн салбар комиссын өргөдөл, гомдол, саналыг үндэслэн Монгол Улсын ерөнхий прокурорын газар хэрэг үүсгэн Улсын аюулгүй байдлыг хангах газраар шалгуулан цагаатгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

8.6.Улс төрийн хэрэгт холбогдуулан шалгасан мөрдөн байцаалтын архивын хэрэг, шүү-

хийн таслан шийдвэрлэх тогтоол байхгүй боловч аль нэг архивын материал, бүртгэл судалгаа, картын санд бүртгэгдсэн /улс хөрөнгө хураах, битүүмжилсэн бүртгэл судалгаа, төр, засгийн илтгэл, мэдээлэлд хэлмэгдсэн гэх хүний талаар дурдагдсан/ материалаар Монгол Улсын ерөнхий прокурорын газар хэрэг үүсгэн, Улсын аюулгүй байдлыг хангах газраар шалгуулан хэргийг хянаж шийдвэрлэнэ.

8.7.Улс төрийн хэрэгт холбогдуулан баривчилж, мөрдөн байцаалт явуулсан тухай ямар нэг баримт, нотлогоо Улсын аюулгүй байдлыг хангах газрын архивт байхгүй боловч улс төрийн хэрэгт баривчлагдсан тухай орон нутгийн хүмүүс баттай гэрчилж байгаа тохиолдолд иргэний болон цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, орон нутгийн салбар комиссын өгөгдөл, гомдол, саналыг үндэслэн Монгол Улсын ерөнхий прокурорын газар хэрэг үүсгэн, Улсын аюулгүй байдлыг хангах газраар шалгуулан хэргийг хянаж шийдвэрлэнэ."

3/ 10.3:

"10.3.Энэ зүйлийн нөхөх олговрыг нэхэмжлэх эрхтэй этгээд энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангаж байх хугацаандаа, эсхүл шүүхэд нэхэмжлэлээ гаргасны дараа нас барсан бол түүний эрх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн[1], 28 дугаар зүйл, Иргэний хуулийн[2] 19, 398, 401 дүгээр зүйлд заасны дагуу хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид шилжинэ."

2 дугаар зүйл.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 5.1.1.г. дэх заалтын "55-69" гэсний дараа ",137" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 4.2; 13.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 4.2:

"4.2.Гадаад улсын шүүхээр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн Монгол Улсын иргэний цагаатгуулах, түүнд нөхөх олговор олгох асуудлыг тухайн шүүхийг харьяалах улсын хууль тогтоомж болон тухайн улстай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулна. Монгол Улсын иргэнийг улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүүлснээ цагаатгасан гадаад улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг Монгол Улсын ижил төстэй байгууллагын шийдвэртэй адилтган үзэж нөхөх олговор олгох асуудлыг энэ хуулийн дагуу шийдвэрлэнэ."

2/ 13.1:

"13.1.Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд нэг сая төгрөгийн, бусад хэлмэгдэгчид 500000 төгрөгийн нэг удаагийн нөхөх олговор олгоно."

4 дүгээр зүйл.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн "8.2; 8.3; 8.4; 8.5" гэсэн дугаарыг "8.3; 8.4; 8.8; 8.9." гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 14 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

---

[1] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. "Ардын эрх" сонин. 1994 оны 130, 131, 132, 133, "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1994 оны 8 дугаарт тус тус нийтлэгдсэн.

[2] Иргэний хууль "Ардын эрх" сонины 1994 оны 257, 258, 1995 оны 1, 2; "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дүгээрт тус тус нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 71** **Улаанбаатар хот**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан гарах нэмэгдэл зардлыг 2000 оны улсын төвлөрсөн төсөвт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газар /Р.Амаржаргал/-т даалгасугай.

ДЭД ДАРГА Д.ГАНБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 25-ны өдөр **Дугаар 178** **Улаанбаатар хот**

Ц.Амарсайханыг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилох тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Цэндийн Амарсайханыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 220 дугаар тушаалын 2 дугаар хавсралт*

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫГ ЭХЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол улсын нутаг дэвсгэр дээр шинээр барих болон өргөтгөл шинэчлэлт, их засвар хийх инженерийн хийцтэй бүх төрлийн барилга байгууламжийн барилга

* Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1999 оны 220 дугаар тушаал, 1 дүгээр хавсралтын хамт <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн №48-д нийтлэгдсэн.

үгсралтын ажлыг эхлэх, үргэжлүүлэхэд эрх бүхий байгууллагаас хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр барилгын захиалагчид зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2. Барилга үгсралтын ажил эхлэн гүйцэтгэх буюу үргэжлүүлэн гүйцэтгэх зөвшөөрлийг тухайн аймаг, нийслэлийн барилгын техник хяналтын улсын байцаагч олгоно.

1.3. Барилга үгсралтын ажил эхлэх гэдэгт шинээр баригдаж эхэлж байгаа, барилга үгсралтын ажлыг үргэлжүүлэх гэдэгт өмнө нь үгсралтын ажил хийгдэж байгаад тодорхой хугацаагаар зогсоож, цаашид үргэлжилж хийгдэх үгсралтын ажлыг ойлгоно.

1.4. Энэхүү зөвшөөрлийг олгоход ямар нэг төлбөр хураамж авахыг хориглоно.

Хоёр. Зөвшөөрөл түүний үйлчлэх хугацаа

2.1. Энэ зөвшөөрөл нь барилга үгсралтын ажлыг иж бүрнээр нь юм уу эсвэл хэсэгчилэн гүйцэтгэх гэсэн 2 төрөлтэй байна.

2.2. Барилга үгсратын ажил нь зөвшөөрлийн хугацаанд дуусаагүй тохиолдолд захиалагч хариуцан улсын байцаагчид хүсэлт тавьж хугацаа дуусснаас хойш 7 хоногийн дотор сунгуулах үүрэгтэй.

2.3. Хэрэв барилга үгсралтын ажил гүйцэтгэх зөвшөөрөл авсан өдрөөс хойш нэг жилийн хугацаанд ажил нь эхлээгүй буюу үгсралтын ажил зогссон тохиолдолд захиалагч хариуцан зөвшөөрлийг шинээр авна.

2.4.Барилга үгсралтын ажлын явцад гүйцэтгэгч нь өөрчлөгдвөл 14 хоногт багтаан захиалагч нь шинэчилсэн зөвшөөрөл авна.

Гурав. Зөвшөөрөл олгох журам

3.1. Барилга үгсралтын ажлыг эхлэх, үргэлжүүлэх зөвшөөрөл авахдаа захиалагч нь дор дурдсан баримт бичиг, материалыг бүрэн бүрдүүлж жагсаалтын хамт улсын байцаагчид ирүүлнэ. Үүнд:

-Зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл (нэгдүгээр хавсралтад заагдсан маягтаар)

-Зураг төслийн болон барилгын гүйцэтгэгч байгууллага, аж ахуйн нэгжийн тухайн ажлыг эрхлэх тусгай зөвшөөрөл (лицензэ)-ийн гэрчилгээ

-Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгвээс газар олгосон шийдвэр, авсан техникийн нөхцөлүүд

-Чанар нь холбогдох байгууллагаар хянагдаж шалгагдсан зураг төслийн баримт бичиг, зураг төсөл хийсэн гэрээ

-Барилга үгсралтын ажилд захиалагчийн техникийн хяналт тавьж, ил далд ажлын актыг баталгаажуулах мэргэжлийн хүнийг томилсон шийдвэр болон зохиогчийн хяналт хийлгэх талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээ

-Барилга үгсралтын ажилыг гүйцэтгэх гэрээ, барилга үгсралтын ажлыг хариуцан бариулах инженерийг томилсон гүйцэтгэгч байгууллагын шийдвэр, мэргэжлийн батламж

3.2. Энэ журмын 3.1-д заасан баримт бичиг, материалаас гадна улсын байцаагч нь захиалагчаас дор дурдсан нэмэгдэл материалыг шаардлагатай үед гаргуулан авч болно.

-Байгаль цаг уур, газар хөдлөл, инженер-

геологийн төвөгтэй нөхцөлд баригдаж буй барилга объектын ажлыг удирдан гүйцэтгэх даамалын талаар мэргэжлээ дээшлүүлсэн буюу уг ажлыг удирдан гүйцэтгүүлэх баталгаа.

-Барилга угсралтын ажилд захиалагчийн техникийн хяналтыг хийж ил далд ажлын актыг баталгаажуулах ажлыг хөндлөнгийнх байгуул-лага, аж ахуйн нэгжээр хийлгэх үед тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн ажлын чанарын шалгалтыг гүйцэтгэх эрхийн бичиг, байгуулсан гэрээ, ажиллах хүнийг томилсон шийдвэр

3.3. Гүйцэтгэгч нь Барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгогдоогүй объектод ажил гүйцэтгэхийг хориглоно.

3.4. Улсын байцаагч нь захиалагчаас бүрэн бүрдүүлж ирүүлсэн баримт бичиг, материалыг нэг долоо хоногоос хэтрэхгүй хугацаанд үзэж танилцан, барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгох, эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ. Улсын байцаагч энэхүү дүрмийн 3.1, 3.2-т заасан баримт материалууд зохих шаардлага хангасан, уг ажилыг гүйцэтгэх чадвартай бол зөвшөөрлийг олгоно. Дутуу материал ирүүлсэн хугацааг тооцохгүй.

3.5.Улсын байцаагчаас барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохоор шийдсэн үед 2 дугаар хавсралт маягтаар зөвшөөрлийг гарын үсэг, тэмдэгэйгээр захиалагчид олгоно. Зөвшөөрлийг 3 хувь үйлдэж 2 хувийг захиалагчид өгнө.

3.6.Зөвшөөрөл олгох боломжгүй бол улсын байцаагчаас ямар шалтгаан, үндэслээр татгалзсан тухайгаа тайлбарласан хариуг захиалагчид албан бичгээр өгнө.

3.7.Захиалагч нь улсын байцаагчаас олгосон барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн нэг хувийг барилга объектын талбайн контрт нүдэнд харагдах, ил газар байрлуулна.

3.8.Захиалагч нь барилга, объектын ажлын явцад гарсан өөрчлөлт (гүйцэтгэгч, даамал солигдох, захиалагчийн техникийн болон зохиогчийн хяналт тавигч өөрчлөгдөх, гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэгч эрхийн хугацаа дуусах, зураг төслийн шийдэлд томоохон өөрчлөлт орох зэрэг)-ийг цаг тухайд нь зөвшөөрөл олгосон газарт мэдэгдэж зөвшөөрөлд өөрчлөлт хийлгэж байх үүрэгтэй.

3.9. Улсын байцаагчид нь Барилга угсралтын ажил эхлүүлэх, үргэлжүүлэн барих зөвшөөрөл олгосон тухай бүр энэ талаарх мэдээг 7 хоногийн дотор ДБУХА-нд ирүүлнэ.

3.10. Улсын байцаагчид нь барилга угсралтын ажил эхлүүлэх үргэлжлүүлэн барих зөвшөөрөл хүссэн материалтай танилцах явцад шаардлагатай гэж үзвэл ДБУХА-тай хамтран шийдвэрлэж болно.

Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

4.1.Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх зөвшөөрлийг олгохтой холбогдож гарсан санал, гомдлыг дээд шатны барилгын техникийн хяналтын улсын байцаагч хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл маргааныг шүүх шийдвэрлэнэ.

4.3. Барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авах, гүйцэтгэхтэй холбогдсон эрх үүргээ биелүүлээгүй барилгын захилагч, гүйцэтгэгчид барилгын техникийн улсын хяналтын дүрмийн дагуу зохих хариуцлага хүлээлгэнэ.

Барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох журмын нэгдүгээр хавсралт

ӨРГӨДӨЛ

Барилга байгууламжийн нэр, хүчин чадал _____

_____

Барилга барих газар олгосон байгууллагын нэр, шийдвэрийн он, сар, өдөр, дугаар _____

_____

Уг барилга байгууламжийн зураг төслийг боловсруулсан байгууллага, тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа _____

Зураг төсөл, техникийн баримт бичгийн иж бүрдэл _____

_____

ГҮЙЦЭТГЭГЧИЙН : Нэр, Харилцах утас _____

Харилцах банк, дансны дугаар _____

Тусгай зөвшөөрөл авсан ажлын нэр, төрөл, тоо _____

_____

_____

Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа _____

Зөвшөөрлийг олгосон он, сар, өдөр, дугаар _____

Эрүл ахуй, гал, байгаль орчны зэрэг хяналтын байгууллагаас гаргасан дүгнэлтийн товч утга, техникийн нөхцөл олгосон байгууллага тэдгээрийн шийдвэрийн он, сар, өдөр дугаар

_____

_____

_____

Барилга бариулах даамалын талаарх мэдээлэл _____

_____

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний сар, өдөр, дугаар _____

_____

Зохиогчийн овог нэр, ажлын хаяг, утасны дугаар _____

_____

Хяналт хийлгэхээр зохиогчтой байгуулсан гэрээниий он, сар, өдөр

Дугаар _____

Нэр, хаяг, харилцах утас _____

Захиалагчийн төлөөлөгчийн талаарх мэдээлэл _____

_____

Захиалагчийн харилцах банк, дансны дугаар _____

Иймд барилга угсралтын ажлыг иж бүрдлээр буюу хэсэгчилсэн ажлуудаар аль нь болохыг бичнэ

19... он ... -р сарын ..... ны өдрөөс 19 .... Оны ....-р сарын ....-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэх зөвшөөрөл олгоно уу. /Барилга угсралтын ажлыг хэсэгчлэн гүйцэтгэх бол ажлын төрлийг нэр заан бичнэ/

Тус өргөдөлд дурдагдсан болон түүнд орох бүх өөрчлөлт, бусад холбогдох асуудлыг захиалагч бүрэн хариуцна. Энэ талаар гарсан ямар нэг асуудлыг тухайн үед нь зөвшөөрөл олгосон газарт тухай бүрд мэдэгдэж байх болно.

ЗАХИАЛАГЧ

_____

Албан тушаал, овог нэр, гарын үсэг

Барилга угсралтын ажлыг эхлэх,
үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох
журмын хоёрдугаар хавсралт

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫГ ЭХЛЭХ, ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ

19..... оны .....дугаар
сарын .....-ны өдөр № .....

Барилга байгууламж, түүний туслах барилгуудын нэр төрөл, хүчин чадал

Захиалагчийн нэр ----------
Газар олголтын Байршил _____

Гүйцэтгэгчийн нэр, хаяг _____
Зохиогч байгууллага, зургийн шифр _____
Техникийн хяналт гүйцэтгэгчийн нэр, хаяг _____
_____
_____

Улсын байцаагчид дуусах үед нь заавал танилцуулж байх үндсэн үе шатны ажлууд _____
_____
_____

Онцгойлон заах нөхцөл _____
_____

Барилга угсралтын ажлыг эхлэх зөвшөөрөл олгосон ажлын нэр
_____
_____

Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа _____

Зөвшөөрөл олгосон байгууллага, улсын
байцаагчийн овог нэр, хаяг, гарын
үсэг, тэмдэг _____

Зөвшөөрөл сунгасан ажлын нэр төрөл _____
_____

Хугацаа сунгасан байгууллага, улсын
байцаагчийн овог нэр, хаяг, гарын
үсэг, тэмдэг _____

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв. ☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арваннэгдүгээр сарын 11 №50 (129)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

469. Ш.Дашцэрэнд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай — Дугаар 179 — 917
470. Ц.Базаргочоод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай — Дугаар 180 — 917
471. Ж.Хатанбаатарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай — Дугаар 181 — 918
472. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай — Дугаар 182 — 918
473. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай — Дугаар 183 — 921

Хоёр. Яам, агентлагийн акт

474. Журам батлах тухай (Монгол Улсын Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын тушаал) — Дугаар А/84 — 921

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 26-ны өдөр — **Дугаар 179** — **Улаанбаатар хот**

Ш.Дашцэрэнд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээх тухай

Авто тээврийн байгууллагад идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, Улаанбаатар хотын тээврийн үйлчилгээг олон жил чадварлаг удирдан зохион байгуулж, нийслэлийн автобусны зорчигч үйлчилгээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улаанбаатар хотын нийтийн зорчигч тээврийн "Автобус-1" компаний захирал Шагдарын Дашцэрэнд Монгол Улсын гавьяат тээвэрчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 26-ны өдөр — **Дугаар 180** — **Улаанбаатар хот**

Ц.Базаргочоод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд багш, удирдах ажилтнаар олон жил үр бүтээлтэй ажиллаж, багш нарын заах арга, ур чадвар, мэргэжлийн төвшин, заадаг хичээлийнхээ чанар үр дүнг дээшлүүлэх, өсөрийн залуу үеийг сурган хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн 10 жилийн нэгдүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч Цэгмидийн Базаргочоод Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 181** **Улаанбаатар хот**

Ж.Хатанбаатарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн байгууллагад санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, элэгний эмгэг эмчлэх монгол эмнэлгийг байгуулан, эмчилгээ, оношлогооны уламжлалт арга нэвтрүүлж, эм бэлдмэлийг үйлдвэрийн аргаар бэлтгэх, монголын уламжлалт анагаах ухааныг сэргээн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн Засаг даргын дэргэдэх Элэгний эмгэг эмчлэх Монгол Эмнэлэг төвийн захирал, их эмч Жамбалын Хатанбаатарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 182** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Нийслэлийн төр захиргаа, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1.Самбуугийн Батдэлгэр - Нийслэлийн Ус суваг, ашиглалтын газрын слесарьч
2.Цэвэгийн Батнасан – Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг дарга
3.Түдэвийн Билэгт – Нийслэлийн Хянан шалгах хорооны дарга
4.Равжаагийн Буяндэлгэр – Нийслэлийн Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга
5.Эрдэнийн Гомбожав – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны дарга бөгөөд ерөнхий менежер
6.Лувсаншаравын Дамдинсүрэн – Нийслэлийн Налайх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүдэгчдийн дарга
7.Лхамсүрэнгийн Доржсүрэн – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтсийн цэрэг, иргэний хамгаалалтын штабын дарга, хурандаа
8.Чулууны Намжилдорж – Нийслэлийн "Нийслэл өргөө холдинг" ХК-ийн ерөнхий инженер
9.Осорын Эрдэнэбаатар – Нийслэлийн Ус суваг, ашиглалтын газрын дарга

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1.Рэгзээгийн Амарсайхан – Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг дарга
2.Уламбаярын Аюуш – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч
3.Шаравын Баасанжав – Нийслэлийн дулааны шугам сүлжээний газрын дарга
4.Чойжамцын Баасандорж – Нийслэлийн Ус суваг, ашиглалтын газрын цэвэрлэх байгууламжийн хэлтсийн дарга
5.Доржцэвээний Баасанхүү - Нийслэлийн зам засварын "АСБИ" ХХК-ийн дэд захирал

6.Баярын Бадамдорж – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Статистик мэдээлэл, судалгааны албаны мэргэжилтэн
7.Ичинхүүгийн Батдорж – Нийслэлийн "Автобус-2" компаний боловсон хүчний эрхлэгч
8.Дашбалын Бархас – Нийслэлийн Багануур дүүргийн Цагдаагийн хэлтсийн дарга
9.Дашзэвэгийн Баярсүрэн – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын автобаазын жолооч
10.Аюурзанын Бямбадорж – Нийслэлийн дулааны шугам сүлжээний газрын инженер
11.Гочоогийн Болд – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны мэргэжлийн хяналтын хэлтсийн байцаагч
12.Пүрэвбазарын Вандан – Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны Засаг дарга
13.Цэдэндамбын Ванчиг – Нийслэлийн "Зураг урлал" ХХК-ийн захирал
14.Пүрэвдоржийн Ганбаатар – Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн засаг дарга
15.Дашнямын Гонгор – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хэлтсийн дарга
16.Цэдэнжавын Даваадорж – Нийслэлийн Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
17.Сүнстийн Дамдин – Нийслэлийн халаалтын зуухны ашиглалтын төвийн механикч
18.Балдандоржийн Далай – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн
19.Содномжамцын Дагийсүрэн – Нийслэлийн иргэдэд үйлчлэх "Буян" компанийн захирал
20.Чимэдцээгийн Доржготов – Улаанбаатар хотын Тээвэр зохицуулалтын газрын хэлтсийн дарга
21.Жамбажавын Дүгэрсүрэн – "Улаанбаатар таймс" сонины газрын орлогч эрхлэгч
22.Шаравын Дэдээбазар – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх нийтлэг үйлчилгээний газрын слесарьч
23.Цэдэн-Ишийн Жамбааньндаг – Нийслэлийн Ахмадын хорооны дарга
24.Чойжилийн Жигжидсүрэн – Нийслэлийн "Спорт цогцолбор" улсын үйлдвэрийн газрын захирал
25.Сандуйн Идшинноров – Монголын түүхийн музейн захирал
26.Цэндийн Идэрборгил – Нийслэлийн Мал эмнэлгийн газрын тасгийн дарга
27.Содовсүрэнгийн Нармандах – Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг дарга
28.Батын Намхайнямбуу – "Улаанбаатар" банкны ерөнхий захирал
29.Жанлавын Наранцацралт – Монголын үндэсний ардчилсан намын дарга
30.Цэгмидийн Наранцэцэг – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтсийн зохион байгуулагч
31.Цэрэндоржийн Нацагдорж – Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны Засаг дарга
32.Чимэдбальдирын Нямрэнцэн – Нийслэлийн зам засварын "Хүчит зам" ХХК-ийн ерөнхий механикч
33.Гүндийн Нямсамбуу – Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын газрын дарга
34.Сэмбээжавын Мөнхжаргал – Нийслэлийн "Ээрмэл" ХХК-ийн ерөнхий захирал
35.Цэнгийн Мягмар – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтсийн зохион байгуулагч
36.Түмэнгийн Мижиддорж – Улаанбаатар хотын Төв номын сангийн захирал
37.Халзангийн Самбаа – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын боловсон хүчний эрхлэгч
38.Намсрайжавын Сандагсүрэн – Нийслэлийн "Зураг урлал" ХХК-ийн зураач
39.Дашнямын Содномзундуй – Улаанбаатар хотын Биеийн тамир, спортын хорооны дарга
40.Очиртовуугийн Соёлт – Нийслэлийн "UBS" телевизийн найруулагч
41.Самбуугийн Пүрэвдорж – Улаанбаатар хотын Биеийн тамир, спортын хорооны мэргэжилтэн
42.Цэрэндоржийн Пэрэнлэймаа – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны

мэргэжлийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

43.Очирхүрээгийн Тунгалаг – Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга

44.Гүнтэвийн Өлзий – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны хот тохижилтын хэлтсийн дарга

45.Дамбын Хулганаа – Нийслэлийн Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

46.Хундангийн Цэсүрэн – Нийслэлийн Эрүүл мэндийн 6 дугаар төвийн их эмч

47.Дэмбэрэлийн Энхбаяр – Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

48.Миеэгомбын Энхболд – Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч

49.Чойжамцын Энэбиш – Элэгний эмгэг эмчлэх монгол эмнэлэг төвийн их эмч

50.Пуйдарын Янсан – Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн байцаагч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Авирмэдийн Алимаа – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

2.Ичинхорлоогийн Амараа – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

3.Гомбын Баатарнум – "Улаанбаатар таймс" сонины сурвалжлагч

4.Чоймпогийн Бат – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

5.Цогтын Батбаяр – Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг дарга

6.Будантайн Батболд – Нийслэлийн "Цэцэрлэгжилт" компанийн цэцэрлэгчин

7.Жанцангийн Батсүх – Нийслэлийн "Улаанбаатар зам засвар" компанийн замчин

8.Пүрэвдоржийн Батхүлэг – Нийслэлийн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны Засаг дарга

9.Чилхаасүрэнгийн Баянчимэг – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Статистик мэдээлэл, судалгааны албаны дарга

10.Цэдэн-Ишийн Болдсайхан – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга бөгөөд Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

11.Шагдарын Ванганжил – Нийслэлийн Налайх дүүргийн 3 дугаар хорооны Засаг дарга

12.Гомбодоржийн Дангаасүрэн – Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн туслах

13.Цэрэннадмидын Долоонжин – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төсвийн эдийн засагч

14.Ванчинжавын Жанцансамбуу – Нийслэлийн сүхбаатар дүүргийн хөдөлмөр зохицуулалтын албаны дарга

15.Гелгээгийн Золбоо – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

16.Дугаржавын Ира – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын статистик мэдээлэл, судалгааны албаны операторч

17.Вандүйн Ичинхорлоо – Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч

18.Бямбасүрэнгийн Лхагва – Нийслэлийн Багануур дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга

19.Долгорын Лувсанданзан – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны хот байгууламж, инженерийн байгууламжийн хэлтсийн дарга

20.Өлзий-Утасын Магсаржав – Нийслэлийн "Цэцэрлэгжилт" компанийн захирал

21.Лхүндэвийн Найдан – Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн санхүүгийн хяналт шалгалтын тасгийн дарга

22.Жадамбаагийн Наранцэцэг – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч

23.Гончигцэрэнгийн Нацагням – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн

24.Уртнасангийн Сумъяа – Улаанбаатар хотын Иргэдийг үйлчлэх "Буян" компанийн жолооч

25.Хасын Төлеухан – Улаанбаатар хотын Цахилгаан шугам сүлжээний газрын инженер
26.Хоролын Төмөр – Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
27.Чултэмдоржийн Цэрэндэжид – Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулагч
28.Бадрахын Чимэд – Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны мэргэжилтэн
29.Довдонгийн Эрдэнэ-Очир – Нийслэлийн Орон сууц, нийтийн аж ахуйн 2 дугаар конторын машинч

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Дугаар 183 **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай

1.Монгол улсаас Люксембургийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг тохоон томилсугай.
2.Өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан Жагваралын Ганибалыг Люксембургийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Дугаар А/84 **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

"Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль", "Малын чанар, үржлийн ажлыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийн зорим заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:
1. "Гойд ашиг шимт мал шалгаруулах журам"-ыг хавсралтаар батлалсугай.
2. "Гойд ашиг шимт мал шалгаруулах ажлыг жил бүр улсын хэмжээнд зохион байгуулан дүгнэж байхыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөдөө аж ахуйн газар /Д. НЭРГҮЙ/, аймаг, нийслэлийн Хөдөө аж ахуйн газарт, журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөө аж ахуйн улсын хяналтын алба /Ц. ХОРЛООБААТАР/-нд даалгасугай.
3. Энэ журам гарсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 1993 оны А/97 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Ч. СОДНОМЦЭРЭН

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын
1999 оны А/84-р тушаалын 1 дүгээр хавсралт

ГОЙД АШИГ ШИМТ МАЛ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжин урамшуулах, гойд ашиг шимт мал шалгаруулан үржүүлгийн тодорхой чиглэлээр ашиглаж сүргийн чанар сайжруулах, удмын сан хамгаалахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Шалгаруулах ажлыг зохион байгуулах

2.1. Гойд ашиг шимт мал шалгаруулах ажлыг жил бүр сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсын хэмжээнд зохион байгуулж явуулна.
2.2. Гойд ашиг шимт мал шалгаруулах ажлыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт уг ажлыг хариуцахаар томилогдсон ажлын хэсэг, улсын хэмжээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг /цаашид Хөдөө аж ахуйн газар гэнэ/

хариуцан гүйцэтгэнэ.

2.3. Аймаг, сум, дүүргийн хэмжээнд гойд ашиг шимт мал шалгаруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг мал эмнэлэг, үржлийн албаны мэргэжилтэн, Засаг даргын тамгын газрын ажилтан, мал үржүүлэгчдийн болон ивээн тэтгэгчдийн төлөөлийг оролцуулан тухайн шатны Засаг дарга томилно.

2.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхлэгч мэргэжилтэн, хуулийн этгээд харъяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд мал сүрэгт хяналтын хэмжилт, судалгаа явуулж ашиг шим арвинтай үржлийн малыг шилж бүртгэн шалгаруулах бэлтгэлийг хангасан байна.

2.5.Гойд ашиг шимт малыг сум, дүүрэгт дор дурдсан хугацаанд шалгаруулна.

а/ ноосны гарцаар шалгаруулах тэмээг 5,6 дугаар сард, хонийг 6,7 дугаар сард,

б/ ноолуурын гарцаар ямааг 4,5 дугаар сард,

в/ амьдын жингээр шарлгаруулах бүх төрлийн малыг 10 дугаар сарын сүүлчийн 10 хоногт,

г/ сүүн ашиг шимээр шалгаруулах малыг тухайн саалийн жилд өгсөн саамын нийт дүнгээр малын төрөл тус бүрийн саалийн жил, улирлын эцэст,

2.6. Сум, дүүрэг, аймаг, нийслэлд гойд ашиг шимт мал шалгаруулах ажлыг малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаатай хамтруулан ашиг шимийн тухайн чиглэл тус бүрээр мал нэг бүрт үнэлгээ өгөх хэлбэрээр зохион байгуулна. Мал шалгаруулах өдөр, байршлын товыг 15-аас доошгүй хоногийн өмнө уг ажлыг зохион байгуулах ажлын хэсэг зарлан мэдээлнэ.

2.7. Аймаг, нийслэлийн хэмжээнд гойд ашиг шимт малыг нэгдсэн байдлаар шалгаруулахаар бол сум, дүүргээс ирүүлэн нэгдсэн дүн, тодорхойлтыг үндэслэн 11 дүгээр сард шалгаруулна.

2.8. Улсад шалгаруулах гойд ашиг шимт малын тухай дор дурдсан тодорхойлолт, бичиг баримтыг аймаг, нийслэлийн мал аж ахуйн мэргэжлийн алба бүрдүүлж 12 дугаар сарын 10-ны дотор Хөдөө аж ахуйн газарт ирүүлнэ.

а/ улсад шалгаруулахаар тодорхойлогдож байгаа малын гарваль, удам угсаа, ашиг шим, үр төлийн чанар болон гойд ашиг шим чанарын үндсэн үзүүлэлт энэ журмын 1 дүгээр хавсралт хүснэгтээр

в/ уг малын 13х18 буюу 18х24 хэмжээний фото зураг хальсны хамт эсвэл дүрс бичлэг,

г/ уг малд хяналтын хэмжилт хийсэн мал зүйч мэргэжилтний дүгнэлт болон аймаг, нийслэлд шалгаруулсан дүн, эрүүл болохыг нотолсон мал эмнэлгийн албаны гаргасан тодорхойлолт.

2.9. Аймаг нийслэлийн мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхлэх байгууллага албанаас ирүүлсэн баримт тодрхойлолтыг үндэслэн Хөдөө аж ахуйн газар ивээн тэтгэгч байгууллагатай хамтран гойд ашиг шимт малыг улсад шалгаруулна.

Гурав. Улсад шалгаруулах малд тавих шаардлага

3.1. Малын төрөл, үүлдэр, үүлдрийн хэсэг тус бүрээс энэ журмын 2 дугаар хавсралтад заасан ашиг шимийн чиглэлээр хэзлтэгч, хэзлтүүлэгч тус бүр нэгийг улсад шалгаруулна.

3.2. Улсад шалгарах гойд ашиг шимт мал нь ашиг шимийн гоц ялгарах үзүүлэлтээрээ тухайн үүлдэр, үүлдрийн хэсгийн дархан болон торгон ангийн стандартын шаардлагаас 15-аас доошгүй хувиар илүү байх бөгөөд галибар, бие цогцосын хувьд ангилалтын зааврын дагуу баллын үнэлгээгээр үнэлэгдсэн байна.

3.3. Амьдын жин, ноос, ноолуурын гарцаар тэмээг 6, үхрийг 5, хонь, ямааг 4, гахайг 2 настайд нь, сүүний гарцаар гарцаар үнээг 6, ингийг 8 настайд тус тус улсад шалгаруулна.

3.4. Улсад шалгарах мал нь ангилалтын шаардлагын дагуу хувийн дүгаар тавигдсан, үржлийн бүртгэл, гэрчилгээтэй байх бөгөөд хяналтын саам, хяналтын жинлэлт, хяргалт, самналтын дүн нь мал үржлийн албаны шаардлагын дагуу бүртгэгдсэн байна.

Эдгээр нь шалгаруулалтын аль ч шатанд харгалзах үндсэн баримт болно.

3.5. Сүүний гарцаар шалгарах гүү, ингэ, сүүний болон сүү-махны үүлдрийн үнээ нь төллөбөл зохих насандаа төллөж, төл нь мэнд бойжсон байх бөгөөд саамын гарц нь саалийн дараалсан хоёр жил бүртгэгдсэн байна.

3.6. Халдварт болон паразит өвчнөөс эрүүл болох нь мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээгээр нотлогдсон байна.

Дөрөв. Малын эзэд, мэргэжилтэн нарын шагнал

4.1. Сум, дүүрэг, аймаг, нийслэлд шалгарсан гойд ашиг шимт малын эзэд, уг малыг илрүүлэн шалгаруулсан мэргэжилтэн нарт олгох шагналын хэмжээг тухайн шатны засаг дарга тогтоож, шаардагдах зардал, хөрөнгийг шийдвэрлэнэ.

4.2. Улсад шалгарсан гойд ашиг шимт малын эзэн, илрүүлэн шалгаруулсан мэргэжилтэнд дор дурдсан хэмжээний мөнгөн шагналыг малын толгой дутамд тооцож нэг удаа олгоно.

Олгох шагнал /мянган төгрөг/

Малын төрөл	Малын эзэнд	Мэргэжилтэнд
Тэмээ	100.0	50.0
Ухэр, сарлаг	120.0	60.0
Хонь ямаа	50.0	30.0
Гахай	30.0	20.0

4.3. Улсад шалгарсан гойд ашиг шимт малын эзэнд диплом олгох бөгөөд дээр заасан мөнгөн шагналын зардлыг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу Хөдөө аж ахуйн газар, Ивээн тэтгэгч үйлдвэр, байгууллагууд хариуцна.

Тав. Гойд ашиг шимт малын удмын санг хамгаалах, үржилд ашиглах

5.1. Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэгт шалгарсан гойд ашиг шимт малыг тухайн нутаг дэвсгэрийн мал эмнэлэг, үржлийн албаны хяналтанд авч, үржлийн бүртгэлд бүртгэн селекцийн тодорхой чиглэлээр ашиглана.

5.2. Улсад шалгарсан хээлтүүлэгчийн үр, төлийг үржлийн зориулалтаар худалдан борлуулах, зохиомол хээлтүүлэгт ашиглах, үр, хөврөл үрийг нь генийн сан хадгалах чиглэлээр давуу эрх эдлэх боломжийг улсын үржлийн албаа бүрдүүлнэ.

5.3. Гойд ашиг шимт малыг зохих хууль тогтоомжийн дагуу даатгуулна.

5.4. Гойд ашиг шимт малыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр суртачлах, тэдгээртэй холбоотой хуанли, зураг хуудас, сэтгүүл, товхимол хэвлүүлж түгээх , мэдээлэхэд тухайн шатны Засаг даргын тамгын газар, мал эмнэлэг, үржлийн албаа, ивээн тэтгэгч байгууллага давуу эрхтэй байна.

Жүрмын нэгдүгээр хавсралт

Улсад шалгарах гойд ашиг шимт малын тодорхойлолт.

№	малын төрөл	үүлдэр	хувийн дугаар	нас	хүйс	эмэгтэй жин /кг/	ангь	ашиг шимийн үзүүлэлт			гарааль					Харицуачийн хэнг. овог нэр	
								нооц нооцтуур. грамм/мин	сүүний гарц л	тослог %	эцэг		эх			малчин	малчийн эм
											жин кг	ангь	сүүний гарц л	тослог %	ангь		

Комиссын дарга .....

гишүүд .....

Улсад шалгаруулах малын тоо, ивээн тэтгэх байгууллага

№	Малын төрөл	Үүлдэр, үүлдрийн хэсэг	Шалгаруулах малын тоо					Ивээн тэтгэх байгууллага
			Хээлтүүлэгч		Хээлтэгч			
			Биеийн жингээр	Ноос, ноолуу-раар	Биеийн жин-гээр	Ноос, ноолуу-раар	Сүүний гар-цаар	
1	Тэмээ	Монгол	1	1	1	1	1	Монгол-Амикал, Говь ХК
2	Үхэр	Монгол	1		1		1	"Монгол мах" ассоциаци
		Сарлаг	1		1		1	
		Хар тарлан					1	Хөдөө аж ахуйн газар, "Сүү" компани, Сүү үйлдвэрлэгчдийн холбоо
		Талын улаан					1	
		Алатау	1		1		1	
		Симменталь	1		1		1	
		Дорнод монгол	1		1			"Монгол мах" ассоциаци
		Сэлэнгэ	1		1			
3	Хонь	Монгол	1	1	1	1		Улаанбаатар хивс Монгол нэхмэл "Сор" компани Ээрмэл, Монноос, Ноос, ноолуурын холбоо
		Баяд	1	1	1	1		
		Байдраг	1	1	1	1		
		Говь-Алтай	1	1	1	1		
		Үзэмчин	1		1			
		Торгууд	1	1	1	1		
		Керей	1		1			
		Хангай	1	1	1	1		
		Орхон	1	1	1	1		
		Талын цагаан	1	1	1	1		
		Ерөө	1	1	1	1		
4	Ямаа	Монгол	1	1	1	1		Монгол-Амикал, Говь ХК
		Уулын бор	1	1	1	1		
		Говь гурван сайхан	1	1	1	1		
		Өнжүүл	1	1	1	1		
5	Гахай	Нутгийн	1		1			Мах импекс

Тайлбар: "Сүмбэр" үүлдрийн хуц нэгийг хурганы арьсны чанараар шалгаруулна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 327806,
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арваннэгдүгээр сарын 18 **№51 (130)**

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

475. Б. Цэрэнбалтавыг Улсын Ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох тухай **Дугаар 186** 925

Хоёр. Яам, агентлагийн акт

476. Журам батлах тухай (Монгол Улсын Дэд бүтцийн хөгжлийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан тушаал) **Дугаар 239/183** 925

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 186 **Улаанбаатар хот**

Б. Цэрэнбалтавыг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг, "Прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг түс түс баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Бат-Очирын Цэрэнбалтавыг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалд томилсугай.

2. Энэ зарлигийг 1999 оны 11 дүгээр сарын 6-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД, ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1999 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр Дугаар 239/183 **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Монгол Улсын Автотээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Жолоочийн мэргэжлийн шалгалт авах, үнэмлэх олгох журам"-ыг 2 дугаар хавсралтаар, "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын замын хөдөлгөөн, түүний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж" хичээлийн хөтөлбөрийг 3 дугаар хавсралтаар, "Жолоодлогын дадлага" хичээлийн хөтөлбөрийг 4 дүгээр хавсралтаар, "Техникийн анхны мэдэгдэхүүн" хичээлийн хөтөлбөрийг 5 дугаар хавсралтаар түс түс батлсугай.

2. Энэхүү журмуудыг хэрэгжүүлж ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Б. Батжав/, Автотээврийн газрын дарга /П. Ориг/, Гэгээрлийн яамын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /С. Алтангэрэл/ нарт үүрэг болгосугай.

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД Г. БАТХҮҮ

ГЭГЭЭРЛИЙН САЙД А. БАТТӨР

Дэд бүтцийн хөгжлийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх /цаашид "жолооч бэлтгэх" гэх/ сургалт эрхлэх эвшээрэл олгох, жолооч бэлтгэх сургалтын ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг Монгол Улсын "Автотээврийн тухай хууль" "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2. Мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах, жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагааны чанарт хяналт тавих үүрэг бүхий Төв эвлелийг Дэд бүтцийн хөгжлийн сайд, Гэгээрлийн сайд хамтран батлана.

3. Төв эвлэл нь ДБХЯ, ГЯ, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын алба болон мэргэжлийн олон нийтийн байгууллагын төлөөлөлтэй байна. Төв эвлэлийн дарга нь Автотээврийн асуудал эрхэлсэн Төв байгууллагын төлөөлөл байх бөгөөд түүнийг Дэд бүтцийн хөгжлийн сайд, Гэгээрлийн сайд эвшилцэн томилно. Нарийн бичгийн дарга орон тооны байна.

4. Мэргэжлийн шалгалтыг Төв эвлэл /цаашид "Эвлэл" гэх/-өөс томилсон мэргэжлийн шалгалтын комисс авна. Мэргэжлийн шалгалт өгөх хүмүүсийн тоо олон бол мэргэжлийн шалгалт авах хэд хэдэн комисс байж болно. Мэргэжлийн шалгалтын явцад Эвлэл, түүнээс эрх олгосон байгууллага, албан тушаалтан хяналт тавих эрхтэй.

5. Жолооч бэлтгэх сургалтын зорилго, сургалтын агуулга, хөтөлбөр нь иргэн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

6. Сургалт явуулах материаллаг бааз, мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан, сургалт явуулах эвшээрэл авсан байгууллага, аж ахуйн нэгж зохих хууль тогтоомжид нийцүүлэн жолооч бэлтгэх сургалт явуулна.

7. Жолооч бэлтгэх сургалт явуулах үйл ажиллагаа нь уг сургалт явуулах байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр болно.

8. Эрүүл мэндийн шаардлага хангасан, сургалтыг төгсөх үедээ 18 нас хүрэх иргэн жолооч бэлтгэх сургалтад хамрагдах эрхтэй.

9. Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөний улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан бөгөөд хугацаа нь дуусаагүй хүмүүсийг жолооч бэлтгэх сургалтад элсүүлэхгүй.

10. Жолооч бэлтгэх сургалтад хамрагдсан сонсогч согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нь тогтоогдсон бол уг сургалтаас хасна.

11. Сургалт явуулах этгээд нь сонсогч, багш нар болон холбогдох байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд хоёр талын хүлээх үүрэг хариуцлагыг тусгана.

12. Жолооч бэлтгэх үндсэн сургалтыг 9 дүгээр сарын 1-ээс дараа жилийн 7 дугаар сарын 1-ний хооронд явуулна.

13. Жолооч бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд Төв эвлэл, түүнээс эрх олгосон байгууллага хяналт тавина.

14. Жолооч бэлтгэх сургалтын жолоодлогын дадлагын талбай түүний элементүүдэд тавих нэгдсэн шаардлагыг ДБХЯ, ГЯ хамтран батлана.

15. Энэ журмын мөрдөлттэй холбогдсон маргааныг Дэд бүтцийн Улсын хяналтын алба, Гэгээрлийн Улсын хяналтын алба хамтран шалгаж шийдвэрлэнэ.

Хоёр. Жолооч бэлтгэх сургалт эрхлэх эвшээрэл олгоход тавих шаардлага

16. Жолооч бэлтгэх сургалт эрхлэх эвшээрлийг доорх шаардлагыг хангасан тохиолдолд олгоно. Үүнд:

а) Сургалт явуулах этгээд нь зохих норм, дүрэм, эрүүл ахуйн шаардлагыг хангасан, эвшээрэл хүчинтэй байх хугацаанд тогтвортой байх зориулалтын хичээлийн танхимтай, зохих үзүүлэнтэй /Хавсралт 1/ байна.

Хичээлийн танхим нь хүрэлцэхүйц тооны сандал, ширээ, самбартай байна.

б/ Зохих шаардлага хангасан оврын хязгаарлалт бүхий хонгил, хурд авах, зогсоох шулуун зам, туг сүлжих зам, ухрах талбай, хажуугийн зогсоол, гүвээ эстакат бүхий жолоодлогын талбайтай байна.

в/ Жолоодлогын дадлагад зориулсан зохих ангиллын өөрийн өмчлөлийн буюу эзэмшлийн тээврийн хэрэгсэлтэй байна.

г/ Энэ журмын 35 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан багшлах бүрэлдэхүүнтэй байна.

17. Жолоодлогын дадлагын тээврийн хэрэгсэл нь тухайн жолоодлогын талбайн элементүүдийн хэмжээнд тохирсон байна. Гэхдээ бүруу талдаа жолооны хүрдтэй автомат /автобуснаас бусад/ болон 4-өөс доош шаттай хурдны хайрцагтай, түүнчлэн "В" ангилалд вагон хэлбэртэй /УАЗ-452 г.м./ тээврийн хэрэгсэл, "Д" ангилалд нийт урт нь 8 метрээс доош автобус дээр дадлага хийлгэхийг хориглоно.

18. Жолооч бэлтгэх сургалтыг жолоодлогын дадлагын нэг тээврийн хэрэгсэлд 7 хүртэл сонсогч, анги дүүргэлтийг 28 хүртэл сонсогчтой байхаар зохион байгуулна.

Гурав. Сургалт эрхлэх эвшээрэл олгох

19. Жолооч бэлтгэх сургалт зохион байгуулах сонирхолтой, энэхүү журмын 16, 17, 18 дугаар зүйлүүдэд тавьсан шаардлагыг хангасан байгууллага, аж ахуйн нэгж сургалт эрхлэх эвшээрэл авахын тулд батлагдсан загварын дагуу үйлдсэн өргөдлээ /хавсралт 2/ тухайн аймаг, нийслэлийн засаг даргад ирүүлнэ. Өргөдөлд дор дурьдсан материалуудыг хавсаргана. Үүнд:

а) Сургалт явуулах байгууллага, нэгжийн танилцуулга;

б/ Хичээлийн танхимыг бэлэн болгосон тухай танилцуулга, өөрийн барилга байгууламжгүй бол зохих журмын дагуу хийсэн түрээсийн гэрээ;

в/ Замын хөдөлгөөний дүрмийн үзүүлэнгийн жагсаалт;

г/ Техникийн хичээлийн үзүүлэнгийн жагсаалт;

д/ Замын хөдөлгөөний дүрмийн дагуу тоноглосон өөрийн эзэмшлийн жолоодлогын дадлагын тээврийн хэрэгсэлтэй эрх бүхий байгууллагын нотлох баримт, тээврийн хэрэгслийн тодорхойлолт (марк, енгэ, нэмэгдэл техееремжүүд /толь, дөрөө, бүс, туг, бичлэг/);

е/ Багш нарын анкет;

ё/ Орлогын татварын тооцоо хийсэн тухай татварын байгууллагын тодорхойлолт;

ж/ Тээврийн хэрэгсэл, жолоодлогын талбай, замын хөдөлгөөний дүрмийн болон техникийн хичээлийн үзүүлэн ,зохих шаардлага хангаж буй тухай аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон комиссын дүгнэлт;

з/ Хичээлийн танхим сургалт явуулах эрүүл ахуйн шаардлага хангасан тухай холбогдох байгууллагын дүгнэлт;

20. Өргөдөл ирүүлсэн этгээд нь сургалтын төлбөр урьдчилан авсан нь тогтоогдсон бол сургалт эрхлэх эвшээрэл олгохгүй.

21. Эрх бүхий байгууллага өргөдөл хүлээж авснаас хойш ажлын 10 хоногийн дотор сургалт эрхлэх эвшээрэл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Бүрдэл болсон баримт бичгийг бичиг хэргээр бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүлээн авсанд тооцно.

22. Өргөдлийг хүлээж аваад сургалт явуулах нөхцөл бүрдсэн гэж үзвэл сургалт эрхлэхийг эвшээрснийг гэрчилсэн баримт бичиг /Хавсралт 3/ олгоно.

23. Жолооч бэлтгэх сургалт эрхлэх эвшээрэл авсан этгээд жолооч бэлтгэх сургалт явуулах бүрдэл сургалтын нөхцөлө шалгуулж эвшээрлээ баталгаажуулна.

Сургалт явуулах эвшээрэл авсны дараа анх өргөдөл өгсөн материалд /сургалтын машинаас бусад/ өөрчлөлт оруулах шаардлага гарсан бол энэ тухай эвшээрэл

олгосон байгууллагад ажлын 5 хоногийн /сургалтын машины хувьд 24 цагийн/ дотор бичгээр мэдэгдэж, эвшөөрлийн баримт бичигт өөрчлөлт хийлгэнэ.

Дөрөв. Жолооч бэлтгэх сургалтын зохион байгуулалт

24. Жолооч бэлтгэх сургалтын элсэлтийг уг сургалт явуулах байгууллагаа зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийг чанд баримтлана.

25. Жолооч бэлтгэх сургалтын үндсэн агуулга нь замын хөдөлгөөн, түүний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж /цаашид "хууль тогтоомж" гэх/, жолоодлогын дадлага гэсэн хэсгээс тогтоно. Жолоодлогын дадлага олгох сургалт нь ганцаарчилсан хэлбэртэй байна.

26. Жолооч бэлтгэх сургалт монгол хэл дээр явагдана.

27. Мэргэжлийн шалгалтад тэнцээгүй, эсвэл мэргэжлийн шалгалтад орохоор дэвшигдээгүй хүмүүс дутуу мэдлэгээ гүйцээх зорилгоор давтан сургалтад дахин хамрагдаж болно.

28. Жолоодлогын дадлагын хичээлээр дараах чадварыг эзэмшүүлсэн байна. Үүнд:

- өгсүүр болон уруу газар зогсож байгаа тээврийн хэрэгслийг байрнаас нь хөдөлгөх;
- ухрах үйлдэл хийж зогсоолд байрлуулах;
- хязгаарлагдмал хэсэгт саадыг тойрон гарах, эргэх, ухрах үйлдлүүдийг хийх;
- хурд авах ба зогсоох үйлдлийг зөв гүйцэтгэх;
- замын зорчих хэсгээр зөв байрлаж явах;
- баруун, зүүн гар тийш болон буцаж эргэх үйлдлүүдийг зөв гүйцэтгэх;
- хөдөлгөөний чиг өөрчлөх, замын уулзварт буцаж эргэх үйлдлүүдийг зөв гүйцэтгэх;
- хөдөлгөөний үед орчны байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, хурд тохируулж явах;
- ар талаа харах толийг ашиглах;
- гэрэлтүүлэх болон урьдчилан анхааруулах дохио, хянах хэрэгслүүд, нэмэгдэл төхөөрөмжүүдийг ажиллуулах;
- шулуун замд болон зөвшөөрөгдсөн гэрлээр эргэх үед гарцаар гарч явааа явган зорчигчийг урьдчилан өнгөрүүлэх;
- гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах эрх бүхий зохицуулагчийн дохиог биелүүлэх;
- замын тэмдэг, тэмдэгтэлийн заалтыг ойлгох, биелүүлэх;
- хоорондын болон хажуугийн зайг тохируулах;
- гүйцэж түрүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэх;
- зогсоолын талбайд тээврийн хэрэгслийг зөв байрлуулах;
- шөнийн жолоодлогын дадлага;

29. Хууль тогтоомжийн хичээлийн хөтөлбөрийг Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, жолоочид хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлага, хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс, жолоочийн мэдвэл зохих бусад эрхийн актын хүрээнд боловсруулна.

30. "Техникийн анхны мэдэгдэхүүн" хичээл нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын талаар тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлага, тэдгээртэй холбогдсон хялбар гэмтлийг тодорхойлох, засварлах анхны мэдэгдэхүүн олгох зорилготой.

"В" ангиллын жолооч бэлтгэх сургалтанд хамрагдсан сонсогч өөрөө хүсвэл техникийн анхны мэдэгдэхүүний хичээлийг үзэхгүй байж болно.

31. "В", "С" ангиллын үнэмлэхтэй хүн өөр ангиллын үнэмлэх авахаар сургалтад хамрагдсан бол жолоодлогын дадлагын болон уг машины техникийн онцлогтой холбоотой хичээл заана.

32. Тээврийн хэрэгсэл жолоодох В ангиллаас С ангилалд, В болон С-ээс Д-д, С-ээс Е-д

Д-ээс Е-д, Е-ээс Д-д ангилалд шилжихийг хүссэн хүмүүс тухайн ангилалд хамаарах богино сургалтанд суралцана.

33. Ангилалд шилжихийг хүссэн хүмүүс дор дурдсан шаардлагыг хангасан байна.

а/ Жолоочоор нэг жилээс доошгүй хугацаагаар тасралтгүй ажилласан байх

б/ Эрүүл мэндийн хувьд тэнцсэн байх

в/ Дээрхи хугацаанд зам тээврийн осол зөрчил гаргаагүй байх

34. Давтан сургалтад давтан хамрагдах хүмүүсийн нэрс, холбогдох материалыг энэ журмын 41 дүгээр зүйлд заасан байгууллагад ирүүлж, зөвшөөрөл авсны дараа эхлэнэ.

35. Хууль тогтоомж заах багш нь жолоодох эрхийн үнэмлэхтэй, 3-ас доошгүй жил тээврийн хэрэгсэл жолоодсон, тусгай дунд буюу түүнээс дээш төвшний боловсролтой, Замын цагдаагийн албанаас олгосон багшлах эрхийн үнэмлэхтэй байна.

36. Хууль тогтоомжийн болон жолоодлогын дадлагын багш өөр байгууллагад шилжин багшлах бол өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

37. Сургалтыг хангалттүй зохион байгуулсан, дадлага чадвар дутсанаас сонсогчид хангалттүй дүн үзүүлсэн болон сургалттай холбоотой ёс зүйн зөрчил гаргасан багшийн багшлах эрхийг эрх олгосон байгууллага цуцалж болно.

38. Жолоодлогын дадлагыг жолоодлогын талбайд багшийн удирдлагын дор хийх бөгөөд сонсогчид замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгтэй, жолоодлогын зохих дадлагатай болсны дараа Замын цагдаагийн албанаас зөвшөөрсөн хугацаа, чиглэлийн дагуу замын хөдөлгөөний дадлага хийнэ.

39. Сургалтын эцэст жолоодлогын дадлагыг 80,0 хувиас дээш хангасан сонсогчдод тухайн байгууллага хууль тогтоомж ба жолоодлогын дадлагын шалгалт авч, тэнцсэн тохиолдолд мэргэжлийн шалгалтад орох эрх олгоно.

40. Жолооч бэлтгэх сургалтын явцад "Эмнэлгийн анхны тусламж" сэдвээр лекц оруулна /Хавсралт 4/.

41. Жолооч бэлтгэх сургалт явуулах этгээд элсэгчдийн овог нэр, регистрийн дугаар, сургалт эхлүүлсэн тухай шийдвэрээ сургалт эхэлснээс хойш Улаанбаатар хотод 7, орон нутагт 14 хоногийн дотор Төв зөвлөл буюу түүний эрх олгосон байгууллагад ирүүлнэ.

Тав. Тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох мэргэжлийн шалгалт

42. Мэргэжлийн шалгалт нь хууль тогтоомжийн, жолоодлогын гэсэн хоёр хэсэгтэй байх ба хууль тогтоомжийн хэсэг нь "Хууль тогтоомж"-ийн хичээлийн хөтөлбөрөөр эзэмшвэл зохих мэдлэг чадварыг, жолоодлогын хэсэг нь энэхүү журмын 28 дугаар зүйлд заасан чадварыг тус тус шалгахад чиглэнэ.

43. Зөвшөөрөлгүйгээр сургалт эрхэлсэн, элсэгчдийн тухай тушаал ирүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгжийн сонсогчдоос мэргэжлийн шалгалт авахгүй.

44. Зөвлөл мэргэжлийн шалгалтын дүнг нэгтгэн сургалт эрхэлж буй байгууллага бүрээр хэвлэлээр нийтэд мэдээлж байна.

Зургаа. Бусад зүйл

45. Зөвшөөрөл олгох байгууллагад мэдэгдэж, дүгнэлт гаргуулалгүйгээр сургалт эрхлэх зөвшөөрөл авахад байсан анхны нөхцлөө өөрчилсөн бол тухайн байгууллагын сургалт эрхлэх зөвшөөрлийг тухайн зөвшөөрөл олгосон байгууллага хүчингүй болгоно.

46. Зөвшөөрөлгүйгээр жолооч бэлтгэх сургалт явуулсан, жолооч бэлтгэх сургалтыг чанаргүй зохион байгуулснаас сонсогчдод учирсан хохирлыг уг сургалтыг зохион байгуулсан сургууль, курс хариуцна.

Харин энэ нь сонсогчийн буруутай бол хохирлыг тухайн сонсогч хариуцна.

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 тоот тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх" журмын нэгдүгээр хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ХИЧЭЭЛИЙН ТАНХИМД БАЙХ ҮЗҮҮЛЭН ТАНИУЛАХ МАТЕРИАЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Үзүүлэн материал, тоног төхөөрөмж
1.	Замын хөдөлгөөний ауулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн шаардлагыг харуулсан самбарууд
2.	Замын тэмдэг, тэмдэглэл зурж тайлбарласан самбарууд
3.	Тээврийн хэрэгслийн уулзвар нэвтрэх журам, тайлбарлах макет, соронзон самбар
4.	Хөдөлгөөний аюулгүй байдлын үндэстэй холбоотой үзүүлэн самбар
5.	Оршин буй хот, суурингийн замын бүдүүвч
6.	Сургалтын техник хэрэгсэл
7.	Тухайн төрлийн тээврийн хэрэгслийн хөдөлгүүр, хуч дамжуулах болон явах анги, цахилгаан тоноглол, тоормос, жолооны механизм болон бусад шаардлагатай эд анги, механизм, тэдгээрийн зүсэлт хийж, ажиллагааг харуулсан макет, үзүүлэн, материалууд

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 тоот тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх" журмын хөрдүгаар хавсралт

.....

/тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт явуулахад

.....

эвшээрел олгох эрх бүхий байгууллагын нэр/-д

ӨРГӨДӨЛ

... оны ... дугаар
сарын ...-ны өдөр

.....

/Сургалт эрхлэх байгууллагын нэр, үлсын бүртгэлийн дугаар, хаяг/

.....

.....

зохих нөхцлийг бүрдүүлэн тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт явуулах хүсэлтэй байгааг харгалзан сургалт эрхлэх эвшээрел олгоно уу.

Өргөдөл гаргасан:

тэмдэг .....

.....

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 тоот тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх" журмын гуравдугаар хавсралт

ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ ЭРХЛЭХ ЭВШЭЭРЭЛ

№

Дээд бүтцийн хөгжлийн сайд, Гэгээрлийн сайдын 1999 оны ... / ... тоот тушаалаар батлагдсан "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам"-д заасан шаардлагыг хангасан тул .....

.....

.....

..... -д ..... ангиллын тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалт явуулахыг эвшээрев.

Энэхүү эвшээрлийг сургалт эхлэх бүрд шалгуулж баталгаажуулна.

.....

/Эвшээрел олгосон байгууллагын нэр, албан тушаалтан/

...../ /

/гарын үсэг/

... оны ... -р сарын ... -ны өдөр

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 тоот тушаалаар батлагдсан "Төвөрийн хэрэгслийн жолооч бэлтгэх" журмын дөрөвдүгээр хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН "ЭМНЭЛГИЙН АНХНЫ ТУСЛАМЖ" ЛЕКЦИЙН АГУУЛГА

Судлах цаг:

1. Анхны тусламжийн сургалтын тухай ойлголт, ач холбогдол, жолоочийн хөдөлмөрийн эрүүл ахуй
2. Гэмтэсгэдэг үзүүлэх яаралтай тусламж, зохиомол амьсгал, зүрхний шууд бус массаж
3. Цус алдалтын үед үзүүлэх анхны тусламж, шархны тухай ойлголт, төрөл бүрийн боолт
4. Ясны хугарал түүнд үзүүлэх анхны тусламж, гэмтэлтэй хүмүүсийг тээвэрлэх
5. Бүх төрлийн хордлого түүнд үзүүлэх анхны тусламж
6. Хөлдөлт, түлэгдэлт, цахилгаанд цохиулах, усанд живэх, угаартах, хахах, бүтэх үед үзүүлэх анхны тусламж
7. Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх, зарим гоц болон халдварт өвчнүүдээс сэргийлэх, хорт зуршлын тухай

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 дугаар тушаалын хөрдүгаар хавсралт

ЖОЛООЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТ АВАХ, ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалт авах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх (цаашид "жолоочийн үнэмлэх" гэх) олгохтой холбогдсон харилцааг зохицуулах, хяналт тавихад оршино.
2. "Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам"-ын дагуу үйл ажиллагаа явуулсан сургууль, курсын төгсөлтийн шалгалтын материал үндэслэн сонсогч нэг бүрээс жолоочийн мэргэжлийн шалгалтыг төв зөвлөлөөс томилсон мэргэжлийн шалгалтын комисс авна. Орон нутгийн салбар комиссын гишүүдийг тухайн аймгийн Засаг дарга Төв зөвлөлтэй зөвшилцөн томилно. Харин орон нутгийн комиссын даргыг Төв зөвлөлөөс томилно.
3. Тээврийн хэрэгслийн төрөл, зориулалтаас хамааран А. В. С. Д. Е, трактор, өөрөө явдаг машин, механизм жолоодох эрхийн гэсэн ангилалтай байна.
4. Жолоочийн мэргэжлийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн шинээр жолоочийн эрх авч байгаа хүмүүст жолоочийн үнэмлэх, талон бичиж олгоно. Жолоочийн үнэмлэх, талоныг шинээр болон нөхөн олгох солих ажлыг Замын цагдаагийн албаа эрхэлнэ.
5. Сургалтын ажлыг зохион байгуулах, мэргэжлийн шалгалт авах комиссын бүрэлдэхүүний албан томилолттой холбогдох зардлыг жолооч бэлтгэх сургууль, курс хариуцна.
6. А, В ангиллын болон трактор, өөрөө явдаг машин, механизмын жолооч болохоор бие даан зохих бэлтгэл хийсэн иргэн өөрийн хүсэлтээр хууль тогтоомжийн шалгалтанд шууд орох эрхтэй. Уг шалгалтыг амжилттай өгсөн тохиолдолд түүнийг гэрчлэх баримт бичгийг Төв зөллөөс олгоно.

   Харин автын инженер, механикч мэргэжилтэй хүмүүс В, С ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох мэргэжлийн шалгалтанд шууд орж болно.
7. Мэргэжлийн шалгалт авахад баримтлах хэм хэмжээг тодорхойлсон зааврыг Төв зөвлөл батлан мөрдүүлнэ.
8. Энэ журмын мөрдөлттэй холбогдсон маргааныг Дэд бүтцийн Улсын хяналтын алба, Гэгээрлийн Улсын хяналтын алба хамтран шалгаж шийдвэрлэнэ.

Хоёр. Мэргэжлийн шалгалт авах, жолоочийн үнэмлэх олгох үйл ажиллагаа

9. Мэргэжлийн шалгалтын комиссын жолоодлогын дадлагын хэсгийг шалгах шалгагч нь тээврийн хэрэгслийн бүтэц зохион байгуулалт, хийцийн онцлог, ажиллах зарчим, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний зохион байгуулалтын үндэс, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, замын хөдөлгөөний дүрмийг сайн мэдэгч, тээврийн хэрэгсэл жолоодох дадлага туршлагатай, техникийн дээд боловсролтой хүн байна.

10. Мэргэжлийн шалгалтын комисс нь жолооч бэлтгэх тухайн сургууль, курсын сонсогч бүр дээр гаргасан тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн шалгалт авна.

11. Хүндэтгэн үзэх шалтгаанаар мэргэжлийн шалгалтанд орж чадаагүй сонсогчийн шалгалтанд нөхөн орохыг 3 сарын дотор Төв зөвлөл шийдвэрлэнэ.

12. Мэргэжлийн шалгалтандаа 3 удаа орж, тэнцээгүй хүмүүс дахин шалгалтанд орохын тулд давтан курст суралцсан байвал зохино.

13. Тээврийн хэрэгслийн жолоочийн мэргэжлийн шалгалтыг хууль тогтоомж болон жолоодлогын гэсэн 2 шаттайгаар явуулна. Хууль тогтоомжийн шалгалтыг эхэлж өгнө. Энэ шалгалтанд тэнцээгүй бол замын хөдөлгөөний жолоодлогын шалгалтанд оруулахгүй.

14. Хууль тогтоомжийн шалгалт өгч байгаа этгээд шалгалтын тестийг сонгож авах ба хүсвэл дүгнэсний дараа комиссын өмнө түлхүүртэй танилцаж, шалгагчийн тавьсан онооны бодит байдлыг хянаж болно.

15. Зохих шаардлага бүрдсэн үед хууль тогтоомжийн шалгалтыг төвлөрүүлэн авч болно.

16. Мэргэжлийн шалгалтанд тэнцсэн согсогчдод мэргэжлийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн жолоочийн үнэмлэх, талон бичиж олгоно.

17. Хууль тогтоомжийн шалгалтыг 20 асуулт бүхий тестээр 25 минутанд багтааж авна.

18. Жолоодлогын шалгалтыг тухайн шалгалт өгч буй ангиллын тээврийн хэрэгсэл дээр авна. Жолоодлогын шалгалт авах тээврийн хэрэгсэл тоормосны нэмэгдэл дереетэй, ар талдаа харах нэмэгдэл тольтой, замын хөдөлгөөний дүрэмд заасан техникийн шаардлагыг бүрэн хангасан байвал зохино. Жолоодлогын дадлагын шалгалтыг онооогоор дүгнэж, протокол хөтөлнө.

Жолоодлогын шалгалтыг тухайн ангиллын тээврийн хэрэгслийг жолоодох чадвар эзэмшсэн, хэвшиж дадсан байдлыг магадлахын тулд жолоодлогын талбайд болон суурин газрын замын хөдөлгөөнд оролцох байдал гэсэн 2 шаттайгаар дор дурьдсан үйлдлүүдийг хийлгэнэ. Үүнд:

а) Жолоодлогын талбайд

- Ухрах үйлдэл хийж зогсоолд тавих;
- Гүвээн дээр зогсож байгаа тээврийн хэрэгслээр өгсөх болон ухрах үйлдэл хийлгэх;
- Цуваа байрлалтай таван ширхэг туг сүлжих;
- Хажуугийн зогсоолд зөв байрлуулах;
- Оврын хязгаарлалт бүхий хонгилд ухрах;
- Хурд авах ба зогсох;

в/ Суурин газрын замын хөдөлгөөнд:

- Хязгаарлагдмал хэсэгт саадыг тойрон гарах, эргэх ухрах үйлдэл хийх;
- Замын зорчих хэсгээр зөв байрлаж явах;
- Баруун, зүүн гар тийш буцаж эргэх үйлдлийг зөв хийж буй эсэх;
- Хөдөлгөөний чиг өөрчлөх, замын уулзварт буцаж эргэх үйлдлийг зөв хийж буй эсэх;
- Хөдөлгөөний үед орчны байдлыг зөв үнэлж, хурд тохируулж явах
- ар талаа харах толийг зөв ашиглаж буй эсэх;
- гэрэлтүүлэг болон урьдчилан анхааруулах дохио, хянах хэрэгслүүд, нэмэгдэл төхөөрөмжүүдийг зөв ашиглаж буй эсэх;
- Хөдөлгөөний чиг өөрчлөх гэж байгаагаа урьдчилан анхааруулж буй байдал;
- шүлүүн замд мөн зөвшөөрөгдсөн гэрлэн дохиогоор эргэх үед гарцаар гарч яваа явган зорчигчийг урьдчилан өнгөрүүлэх дүрэм биелүүлж дадсан эсэх;
- гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах эрх бүхий зохицуулагчийн дохиог удирдлага болгож буй эсэх;
- замын тэмдэг, тэмдэглэлийн заалтыг биелүүлж байгаа эсэх;
- хоорондын болон хажуугийн зайг зөв барьж байгаа эсэх;
- гүйцэж түрүүлэх үйлдлийг зөв гүйцэтгэж байгаа эсэх;
- зогсоолын талбайд тээврийн хэрэгслээ зөв байрлуулж буй эсэх;
- Жолоодлогын талбай, замын хөдөлгөөний дадлагын шалгалтыг тус тусад нь дүгнэнэ.

Гурав. Үнэмлэх, талон нөхөн олгох

Жолоочийн үнэмлэх, талоноо үрэгдүүлсэн бол хүчингүйд тооцуулсны дараа хууль тогтоомжийн шалгалт өгч тэнцсэн тохиолдолд Замын цагдаагийн алба нөхөж олгоно.

19. Гэнэтийн аюул (гар түймэр, үер г.м)-ын улмаас үнэмлэх, талоноо үрэгдүүлбэл албан газар, орон нутгийн Цагдаагийн байгууллага (Гал түймэртэй тэмцэх албад)-ны тодорхойлолтыг үндэслэн шалгалтгүйгээр замын цагдаагийн албаа нөхөн олгоно.

20. Хууль дүрэм зөрчсөний улмаас талоноо 3 удаа цоолуулж хүчингүй болгосон жолоочоос хууль дурмийн шалгалт авч тэнцвэл талоныг нөхөж олгоно.

21. Энэ журмын 19, 20 дугаар зүйлүүдэд заасны дагуу нөхөн олгосон үнэмлэх дээр "нөхөв" тэмдэглэл хийнэ.

22. Талоноо 3 удаа цоолуулсан, мөн үнэмлэх талоноо үрэгдүүлсэн, хүчингүй болгосны улмаас шалгалтанд орж 3 удаа тэнцээгүй бол давтан курст суралцахыг шаардана.

23. Үнэмлэх, талон, эрүүл мэндийн тодорхойлолтыг эзэнд нь буюу итгэмжлэл бүхий хүнд биеийн байцаалт болох бичиг баримтыг шалган үзэж, гарын үсэг зуруулан он, сар, өдрийг тэмдэглэж олгоно.

Дөрөв. Гадаад орны жолоодох эрхийн үнэмлэхтэй хүмүүст Монгол Улсын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох

24. Тээврийн хэрэгсэл жолоодох гадаад орны эрхийн үнэмлэхтэй Монгол Улсын иргэнээс хууль, дүрмийн шалгалт авч, тэнцвэл үндэсний үнэмлэх, талоноор сольж олгоно. Монгол Улсын иргэд нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үндэсний үнэмлэх, талонтойгоор тээврийн хэрэгсэл жолоодно.

25. Монгол Улсад 3 сараас дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэний жолоочийн үнэмлэх, талоныг гэрээ хэлэлцээрээр ажиллаж байгаа байгууллагын хүсэлт тодорхойлолтыг үндэслэн, тухайн үнэмлэхэд нь заагдсан ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэхээр сольж олгоно. Вений конвенцид нэгдсэн орнуудаас олгосон жолоочийн олон улсын эрхийн үнэмлэхтэй, гадаадын иргэдийн үнэмлэхийг солиулах шаардлагагүй.

26. Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэнээс Монгол улсын жолоочийн үнэмлэх, талон авахыг хүсвэл ердийн журмаар шийдвэрлэнэ.

Тав. Жолоочийн үнэмлэх олгох, бүртгэл хөтлөх

27. Мэргэжлийн шалгалтанд тэнцсэн хүмүүст тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрх олгох тухай мэргэжлийн шалгалтын комиссын шийдвэр гаргана.

28. Замын цагдаагийн албаа мэргэжлийн шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн жолоочийн үнэмлэх, талон бичиж олгоно.

29. Урьд нь 1 дүгээр зэрэгтэй жолоочид В С Д Е, 2 дугаар зэрэгтэй жолоочид Е, 3 дугаар зэрэгтэй жолоочид В С ангилалтай дүйцүүлэн жолоочийн үнэмлэхийг шууд солино.

30. Шинээр жолооч болохоор мэргэжлийн шалгалтанд тэнцсэн хүмүүст дараах материалыг бүрдүүлсэн тохиолдолд үнэмлэх талон бичнэ. Үүнд:

- Мэргэжлийн шалгалтын комиссын шийдвэр
- Эрүүл мэндийн тодорхойлолт
- Жолоочийн үнэмлэх олгох хуудас
- өнгөт гэрэл зураг 4х6 3ш
- хичээлийн хөтөлбөр хангасан тухай тодорхойлолт, эсвэл өргөдөл
- үнэмлэх талоны үнэ төлсөн санхүүгийн баримт

31. Үнэмлэх, талоноо үргэдүүлсэн, талоноо гурван удаа цоолуулсан, эрх сэргээх хүмүүст дараах материалыг бүрдүүлсэн тохиолдолд үнэмлэх, талоныг нөхөн олгох буюу эрхийг сэргээнэ.

а/ Шалгалт өгч тэнцсэн тухай баримт

б/ Эрүүл мэндийн тодорхойлолт

в/ Зарлуулж хүчингүй болгосон тасалбар болон талон цоолуулсан, эрх хасагдсан тухай лавлагаа

г/ Үнэмлэх, талоны үнэ төлсөн санхүүгийн баримт

Зургаа. Бусад зүйл

32. Мэргэжлийн шалгалтын комисс шалгалттай холбогдолтой материалаа Замын цагдаагийн албанд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

33. Автотээврийн бодлогын чанартай асуудлуудыг боловсруулан хэрэгжүүлэх зорилгоор компьютерийн сүлжээнд холбогдож ямар ч үед бүх мэдээллийг саадгүй авах боломжоор Замын цагдаагийн албаа Автотээврийн асуудал эрхэлсэн Төв байгууллагыг бүрэн хангана.

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 дугаар тушаалын үүрэвдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН "ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН, ТҮҮНИЙ АЮЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ" ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Тэвврийн хэрэгслийн ангилал: Бүх ангилал
Судлах цаг: 50

Ерөнхий зүйл: Тэвврийн хэрэгслийн ангилал; хууль тогтоомжийн нэр томъёо, тэвврийн хэрэгслийн улсын бүртгэл, тэвврийн хэрэгслийн тооллого, техникийн улсын үзлэг, тэвврийн хэрэгсэл, түүний эд анги, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэхэд тавих шаардлага, тэвврийн хэрэгслийн улсын дугаар, таних тэмдэг, бичлэг, тэвврийн хэрэгслийг ашиглахад замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, иргэн аж ахуйн нэгж байгууллагын үүрэг.

Ашиглах материал:

Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль: 2, 3 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн 1 ба 2 дугаар заалт, 6 дугаар зүйлийн 1 дүгээр заалт, 9, 10, 14 дүгээр зүйл.

Автотээврийн тухай хууль: 3 дугаар зүйл. Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 2, 148-155, 156 дугаар заалтууд.

Хөдөлгөөнд оролцогчдын үүрэг: Жолооч, жолоодох эрх; жолоочийн үүрэг; жолоочид хориглох зүйлүүд; тээвэрлэгчийн эрх, үүрэг; явган ба тэвврийн хэрэгслээр зорчигчийн үүрэг

Ашиглах материал:

Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль: 11, 12, 13 дугаар зүйл.

Автотээврийн тухай хууль: 10 дугаар зүйл. Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 8-24 дугаар заалтууд.

Замын хөдөлгөөн зохицуулах дохио: Гэрэл дохио, нэмэгдэл гэрэл дохио; зохицуулагчийн дохио.

Ашиглах материал:

Автотээврийн тухай хууль: 10 дугаар зүйл. Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 8-24 дугаар заалтууд.

Замын хөдөлгөөн зохицуулах дохио: Гэрэл дохио, нэмэгдэл гэрэл дохио; зохицуулагчийн дохио.

Ашиглах материал:

Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 25-38 дугаар заалтууд.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний журам: Хөдөлгөөн эхлэх, хөдөлгөөний чиг өөрчлөх; ухрах, буцаж эргэх үйлдэл, анхаарууллах дохио; тээвэрийн хэрэгсэл байрлан явах журам; тээвэрийн хэрэгслийн хурд, хоорондын зай; уулзвар нэвтрэх, зохицуулдаг уулзвар нэвтрэх; зохицуулдаггүй уулзвар нэвтрэх; явган хүний гарц нэвтрэх; төмөр замын гарам нэвтрэх; гүйцэж түрүүлэх журам; гадна талын гэрэлтүүлэх хэрэгслийг хэрэглэх; түр буюу удаан зогсох; хороллын доторхи хөдөлгөөн; тууш замын хөдөлгөөн.

Ашиглах материал:

Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 39-105 дугаар заалтууд.

Замын тэмдэг, тэмдэглэл: Анхааруулах тэмдэг; хориглох тэмдэг; дарааллын тэмдэг; заах тэмдэг; мэдээлэх тэмдэг; нэмэлт тэмдэг, замын тэмдэглэл, хэвтээ тэмдэглэл; босоо тэмдэглэл.

Ашиглах материал:

Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн хавсралт.

Хөдөлгөөний онцлог нөхцөл: Уулын замаар явах; цувааагаар явах; жолоодлогын дадлага хийх; тээвэрийн хэрэгслийг чирэх;

Ашиглах материал:

Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 106-121 дүгээр заалтууд.

Хүн ба ачаа тээвэрлэх: Хүн тээвэрлэх; ачаа тээвэрлэх.

Ашиглах материал:

Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 133-144 дүгээр заалтууд.

Тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлага: Тоормосны систем; жолооны механизм; дугуй, хүч дамжуулах анги; гэрэлтүүлэх хэрэгсэл; бүхээг, тэвш, нэмэлт төхөөрөмж.

Ашиглах материал:

Монгол улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль: 10 дугаар зүйл.

Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 145-147 дугаар заалтууд.

Хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага: Хууль тогтоомж зөрчигдөд хүлээлгэх хариуцлага; Монгол улсын эрүүгийн хуульд заасан ял шийтгэл; Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хуульд заасан шийтгэл.

Ашиглах материал:

Монгол улсын Замын хөдөлгөөний ажүлгүй байдлын тухай хууль: 19 дүгээр зүйл.

Автотээврийн тухай хууль: 17, 2 заалт, 23 дугаар зүйлийн 23. 1. 1-ийн холбогдох заалт.

Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм: 7 дугаар заалт.

Монгол улсын эрүүгийн хууль: 260-266 дугаар зүйл.

Монгол улсын захиргааны хариуцлагын тухай хууль: 25 дугаар зүйл

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын үндэс: Зам тээврийн осол, урьдчилан сэргийлэх арга зам; хөдөлгөөний үед автомашинд үйлчлэх хүчнүүд хүндийн төв; төвөөс зугатах хүч автомашины тогтворжилт; автомашины туулах чадвар; автомашины шарвалт; автомашины хурд: хурдатгал, удаашралт; автомашины тоормозлолт, тоормозны зам; чиргүүлтэй автомашиныг жолоодох; цаг агаарын хүнд нөхцөлд автомашиныг жолоодох; автомашины хөдөлгөөнд зам нөлөөлөх; жолоочийн сэтгэл зүй физиологийн онцлог; жолоочийн сэтгэхүй; анхаарал түүний ангилал; ядаргаа түүний хэлбэрүүд, ядаргаанаас урьдчилан сэргийх арга.

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН "ЖОЛООДЛОГЫН ДАДЛАГА" ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Сургалтын цаг: **В ангилал: 48**
С ангилал: 54
ВС ангилал: 60

Нэг. Жолоодлогын талбайд хийх дадлага

1. Автомашины ерөнхий бүтэцтэй танилцах, ажилд бэлтгэх
2. Жолоочийн суудалд зөв суух, жолооны хүрдийг зөв барьж, залж сурах, хамгаалах бүс бүслэх, тайлах
3. Автомашиныг байрнаас хөдөлгөж, зам онон шулуун явж сурах /хурд авахуулах, бууруулан зогсоох үйлдэл гүйцэтгэх дасгал, араагт шат ахиулан хөнгөлөх болон бууруулан залгах, салгах; толинд харж баримжаа авч сурах; гар тоормос ажилуулах/
4. Автомашины хөдөлгөөний чиглэлийг өөрчлөн автомашин жолоодох дасгал /Зүүн гар тийш эргэх, саад тойрох, буцаж эргэх/, ухрах хөдөлгөөн хийх дасгал/ чигээрээ ухрах, зүүн баруун гар талаас ухрах, 45 градусаар ташуу ухрах/
5. Автомашинаар тойргийг тойрох үйлдэл хийж гүйцэтгэх дасгал
6. Туг сүлжих дасгал
7. Тонеллоор чигээрээ ба ухарч гарах дасгал гүйцэтгэх
8. Боксонд зүүн ба баруун талаас ухрах
9. Хязгаарлагдмал талбайд маневр хийж ухарч зогсох
10. Гүвээгээр өгсч гарах буух, гүвээний өгсүүрт конс түгжиж зогсох

Хоёр. Суурин газраас гадна хийх жолоодлого

1. Уулын налуу замд чигээрээ өгсөж ба уруудаж явах, зогсох, саад тойрох хөдөлгөөн хийх дасгал
2. Гуу жалгаар явах, саад тойрох
3. Төмөр бетон ба модон гүүрээр нэвтрэх
4. Хөдөлгөөн сийрэг замд шулуун явах, эргэх тойрох хөдөлгөөн хийх
5. Хаалттай, хаалттүй төмөр замын гарам нэвтрэх
6. Шөнийн жолоодлого

Гурав. Суурин газар хийх жолоодлого

1. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нягтрал ихтэй замаар явж гүйцэж түрүүлэх, байр эзлэх үйлдэл гүйцэтгэх, явган хүний гарц, нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн буудлаар явах ба удаан зогсох үйлдэл хийх
2. Зохицуулдаг уулзвар нэвтрэх
3. Зохицуулдаггүй уулзвар нэвтрэх
4. Төмөр замын гарам нэвтрэх

5. Гарцаар нэвтрэх
6. Тонеллоор нэвтрэх
7. Гүүрэн дээгүүр ба доогуур явах
8. Зам талбайд ухарч зогсох

Тайлбар: В ба С-ээс бусад ангиллын хувьд энэхүү хөтөлбөрийг үндэслэн тухайн ангиллын тээврийн хэрэгслийн онцлогийг тусгасан хөтөлбөрөөр сургалт явуулна. Уг хөтөлбөрийг Дэд бүтцийн хөгжлийн болон Гэгээрлийн яамны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрууд хамтран батална.

ДБХ-ийн сайд, Гэгээрлийн сайдын хамтарсан 1999 оны 239/183 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН "ТЕХНИКИЙН АНХНЫ МЭДЭГДЭХҮҮН" ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

Тээврийн хэрэгслийн ангилал: В ба С ангилал

Судлах цаг:
В ангилалд 20 /үүнээс дадлага 6 цаг/
ВС ангилалд 60 /үүнээс дадлага 12 цаг/

Нэг. Автомашины хөдөлгүүр

1. Автомашины хөдөлгүүр, ангилал
2. ДШХ-ийн механизмууд, зориулалт, ажиллагаа, ангилал
3. ДШХ-ийн тослох, хөргөх системүүд
4. Хөдөлгүүрийн тэжээлийн систем

Хоёр. Автомашины шасси

1. Автомашины ангилал, ерөнхий бүтэц
2. Авцуулах холбоо
3. Хурдны хайрцаг
4. Кардан дамжуулгын зориулалт, ерөнхий ойлголт
5. Ерөнхий дамжуулга, зориулалт
6. Хөтлөгдөх ба хөтлөх тэнхлэг
7. Резинэн дугуй
8. Гүүшингийн зориулалт, төрөл
9. Тоормосны зориулалт, ангилал, бүтэц
10. Тоормосны удирдлага, хүчлүүрүүд
11. Тоормосонд тохиолдох гэмтэл, түүнийг арилгах, тоормосны шингэн
12. Жолооны удирдлагын тухай. Жолооны механизм
13. Жолооны дамжуулга, хүчлүүр
14. Жолоонд тохиолдох гэмтэл, засвар үйлчилгээ

Гурав. Автомашины цахилгаан тоноглол

1. Цахилгаан техникийн тухай үндсэн ойлголт
2. Хянах шалгах хэрэгсэл, түүний зориулалт, хэмжүүр ба датчик
3. Гэрэлтүүлгийн систем, гэрлийн тусгалын тохиргоо
4. Нэмэлт техееремж, дуут дохио, шил алчуур, гал хамгаалагч

Тайлбар: В ба С-ээс бусад ангиллын хувьд энэхүү дүрмийг үндэслэн тухайн ангиллын тээврийн хэрэгслийн онцлогийг тусгасан хөтөлбөрөөр сургалт явуулна. Уг хөтөлбөрийг Дэд бүтцийн хөгжлийн болон Гэгээрлийн яамны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрууд хамтран батална.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арваннэгдүгээр сарын 29 №52 (131)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг

477. Жавзангийн Авирмэдэд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай Дугаар 188 937

478. Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай Дугаар 189 937

479. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 190 938

480. Зарим тариаланчдыг "Атарчдын алдар" медалиар шагнах тухай Дугаар 191 943

481. М. А. Винокуров, Н. М. Токарская нарыг шагнах тухай Дугаар 194 948

Хоёр. Яам, агентлагийн акт

482. Журам батлах тухай (Эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын албаны даргын тушаал) Дугаар 38 949

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 188** **Улаанбаатар хот**

Жавзангийн Авирмэдэд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээх тухай

Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хөрс боловсруулалт, тариалалт, ургац хураалтад дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн үйлдвэрлэлийг мэргэжлийн удирдлагаар хангах, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлэн Сэлэнгэ аймгийн Цагаannуур сумын "Баяндулаан -Уул" ХК-ийн захирал Жавзангийн Авирмэдэд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол хүртээж, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 189** **Улаанбаатар хот**

Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж хөрс боловсруулалт, тариалалт, ургац хураалтад дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн, үйлдвэрлэлийг мэргэжлийн удирдлагаар хангах, үр тариа, төмс, хүнсний ногооны тогтвортой ургац авах, хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад оруулж байгаа хувь нэмрийг үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

Монгол Улсын гавьяат агрономич цолоор:

1. Балчингийн Галаа - *Төв аймгийн Хөдөө аж ахуйн газрын харьяа агроларкийн эрхлэгч*
2. Дэмбэрэлийн Дамдинсүрэн - *Төв аймгийн Цэцэл сумын "Залуучууд" ХК-ийн агрономич*

Монгол Улсын Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цолоор:

1. Сандагийн Ганболд – *Сэлэнгэ аймгийн Ерөө сумын газар тариалангийн үйлдвэрлэлийн "Их шинэстэй" ХХК- ийн захирал*
2. Дашдоржийн Тунсаг – *Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХК-ийн менежер*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 190** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Газар тариалан, гурил тэжээлийн үйлдвэрлэл, тээврийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

Сүхбаатарын одонгоор:

Шаравын Гунгаадорж – Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:

1. Лхагважавын Базар – Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын "Оргил" ХК-ийн захирал
2. Хасын Батжаргал – Төв аймгийн Цээл сумын "Залуучууд" ХК-ийн трактористч
3. Байгуужингийн Баянтүмэн – Нийслэлийн "Агро-Амгалан" ХК-ийн ногоочин
4. Шаравдоржийн Бөөренхий – Нийслэлийн "Алтан тариа" ХК-ийн ерөнхий технологич
5. Мэндбаярын Бүргэд – Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Торгон үр" ХК-ийн бригадын дарга
6. Жадамбын Бямбаноров – Нийслэлийн "Ургамал ЗМ" компанийн ерөнхий захирал
7. Бэгзийн Дорж – Хөдөө аж ахуйн их сургуулийн декан
8. Жамсрангийн Дорж – Төв аймгийн Цээл сумын "Залуучууд" ХК-ийн трактористч-комбайнч
9. Гэндэнгийн Жалбаа – Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын "Шим" ХХК-ийн захирал
10. Даржаагийн Жамц – Байгаль орчны яамны Газар зохион байгуулалтын албаны ахлах мэргэжилтэн
11. Шаравдоржийн Жанчивдорж – Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Буудайн цацал" ХК-ийн ерөнхий инженер
12. Цэдэндоржийн Жаргалсайхан – Төв аймгийн Зам барилга засварын "Төв зам" ХК-ийн ерөнхий захирал
13. Гаанжуржавын Зориг – Сэлэнгэ аймгийн Сухбаатар сумын "Сэлэнгэ гурил тэжээл" ХК-ийн албаны дарга
14. Бандизүүгийн Лхагвасүрэн – Төв аймгийн Сүмбэр сумын "Өгөөж" ХХК-ийн трактористч
15. Батын Лхагвасүрэн – Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Ерөө" ХХК-ийн ерөнхий инженер
16. Лувсангийн Намжилдорж – Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын "Бүрэнбургалтай" ХХК-ийн агрономич
17. Даржаагийн Насанжаргал – Сэлэнгэ аймгийн Цагаannуур сумын "Номунхан" ХХК-ийн захирал
18. Гаргилын Нэргүй – Төв аймгийн Жаргалант сум дахь Улсын нөөцийн газрын салбарын эрхлэгч
19. Ламзавын Нямаа – Хэнтий аймгийн Мөрөн сумын ногоочин
20. Цэндийн Отгон – Увс аймгийн Тариалан сумын "Алтан дуулга" ХК-ийн ерөнхий агрономич
21. Цогбадрахын Оюунсүртал – Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХК-ийн гагнуурчин
22. Сүрэнхандын Пүрэв – Сэлэнгэ аймгийн Сант сумын "Цагаантолгой" ХХК-ийн трактористч-комбайнч
23. Жамбын Пүрэвдорж – Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын орлогч дарга
24. Дэчингийн Пүрвээ – Сэлэнгэ аймгийн Хушаат сумын "Орхон түшээ" ХХК-ийн трактористч-комбайнч
25. Дамдинжавын Санжмятав – Төв аймгийн Батсүмбэр сумын "Мөнгөн тэмдэгт" ХХК-ийн захирал
26. Рэнцэнгийн Содхүү - Монгол Улсын Их Хурлын гишүүн
27. Даваагийн Сүрэнжав – Булган аймгийн Хөдөө аж ахуйн газрын дарга
28. Балжингийн Тогообор – Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын "Бүрэнбургалтай" ХХК-ийн трактор-комбайны салааны ахлагч
29. Рээлхүмбийн Төмөрбаатар – Төв аймгийн Угтаалцайдам сумын "Угтаал Төв" ХК-ийн бригадын дарга
30. Эрдэнэ-Очирын Төмөрбаатар – Төв аймгийн Цээл сумын "Залуучууд" ХК-ийн трактористч
31. Лэгцэгпилийн Чагнаадорж – Нийслэлийн автотээврийн "22 дугаар баз" ХК-ийн захирал

"Алтан гадас" одонгоор:

1. Дамбийнямын Айлтгүй – Дорнод аймгийн Халхгол сумын "Булагдай" ХХК-ийн захирал
2. Аюушийн Алдар – Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын "Бүрэнбургалтай" ХХК-ийн трактористч-комбайнч
3. Мижидийн Баасанхүү - Төв аймгийн Жаргалант сумын "Загдал" ХК-ийн механикч
4. Луусангийн Баатар – Сэлэнгэ аймгийн Цагаannуур сумын "Товхонхан" ХК-ийн инженер

5. Цамбажавын Бадамжунай – Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Гурван борхууд" ХК-ийн трактөрч-комбайнч

6. Дашлэлжээгийн Бадамрэгзэн - Өвөрхангай аймгийн Хархорин сумын ногоочин

7. Содовын Балжинням – Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш

8. Пэрэнлэйн Батбаяр – Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын "Ургац" ХХК-ийн бригадын дарга

9. Лувсандоржийн Батжаргал - Өвөрхангай аймгийн Хархорин сумын "Хархорин" ХК-ийн ерөнхий инженер

10. Бажгарын Батменх – Нийслэлийн автотээврийн "22 дугаар баaз" ХК-ийн жолооч

11. Сономын Баяа – Увс аймгийн Баруунтуруун сумын "Жинст" ХК-ийн трактөрч-комбайнч

12. Дашдоржийн Баяр – Төв аймгийн Аргалант сумандхувиараа эрхлэх аж ахуйн эзэн

13. Авирмэдийн Баяраа – Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын "Таван үр" ХХК-ийн трактөрч-комбайнч

14. Дашзэвэгийн Баяраа – Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Алтан дуулга" ХК-ийн трактөрч-комбайнч

15. Ренчингийн Баярсайхан – Сэлэнгэ аймгийн Сухбаатар сумын "Гурил тэжээл" ХХК-ийн гүйцэтгэх захирал

16. Баатарын Будрагчаа – Увс аймгийн Баруунтуруун сумын "Улаан сан" ХХК-ийн трактөрч-комбайнч

17. Зүмбэрэлийн Вангүр – Төв аймгийн Аргалант сумын "Төв нөхөрлөл" ХХК-ийн ерөнхий агрономич

18. Дэндэвийн Вандан-Иш – Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Шанд тариа" ХК-ийн захирал

19. Хандын Галя – Хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны ахмад ажилтан

20. Манахүүгийн Ганбат – Төв аймгийн Цэзл сумын "Бугын ам" ХХК-ийн захирал

21. Вандансангийн Гомбо - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

22. Зохистын Гомбосүрэн – Хөвсгөл аймгийн Рашаант сумын "Улаан-Од" ХК-ийн трактөрч-комбайнч

23. Гарамдоржийн Гүнтэвсүрэн – Төв аймгийн Цэзл сумын "Залуучууд" ХК-ийн бригадын дарга

24. Гончигийн Даваадорж – Сэлэнгэ аймгийн Орхон сумын "Орхондалай" ХК-ийн үр тарианы бригадын дарга

25. Гочоогийн Даваадорж – Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн

26. Намжаагийн Дабааньм – Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Ерөө" ХХК-ийн трактөрч-комбайнч

27. Түвдэнгийн Дабааньм – Дархан-Уул аймгийн Зам гүүрийн засвар арчлалтын компанийн инженер

28. Гэндэнгийн Даваасүрэн – Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Гурван борхууд" ХК-ийн трактөрч-комбайнч

29. Жалбуугийн Даваасүрэн – Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Газрын Ундраа" ХК-ийн трактөрч-комбайнч

30. Одхүүгийн Дагвадорж – Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Ноён-Уул" ХХК-ийн захирал

31. Лхамын Дагвасүрэн – Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Буудайн цацал" ХК-ийн ахлах засварчин

32. Чулууны Дамба – Дундговь аймгийн Сайнцагаан сумын ногоочин

33. Даваагийн Дамбадаржаа – Нийслэлийн автотээврийн "22 дугаар баaз" ХК-ийн жолооч

34. Лодонгийн Дамдинжав – Байгаль орчны яамны Газар зохион байгуулалтын албаны мэргэжилтэн

35. Аюушийн Доржпалам – Булган аймгийн Хишиг-Өндөр сумын "Хишиг-Өндөр уул" ХХК-ийн трактөрч-комбайнч

36. Жадамбын Жийлаажав – Сэлэнгэ аймгийн Орхон сумын "Орхондалай" ХК-ийн трактөрч

37. Доржийн Жүгдэр – Булган аймгийн Булган сумын гурил тэжээлийн "Булган" ХК-ийн агрономич

38. Чойжилжавын Жүгдэр – Нийслэлийн автотээврийн "22 дугаар баaз" ХК-ийн жолооч

39. Гомбын Зундүй – Төв аймгийн Заамар сумын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн орлогч захирал

40. Дамдингийн Ламзав – Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын "Азын хийморь" ХХК-ийн захирал

41. Дамдинбазарын Магсаржалам – Төв аймгийн Үгтаалцайдам сумын "Хүүлэз" ХК-ийн бригадын дарга

42. Чимэдсорогчингийн Мөнгөн-Аюуш – Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Буудайн цацал" ХК-ийн трактөрч

43. Гомбосүрэнгийн Мятав – Булган аймгийн Хутаг-

Өндөр сумын "Бэрэнтулга" ХХК-ийн трактор-комбайнч

44. Халтарын Намсрайжав – Сэлэнгэ аймгийн Хушаат сумын "Орхон түшээ" ХХК-ийн зөвлөх мэргэжилтэн

45. Рааньжавын Намхай – Төв аймгийн Борнуур сумын сорилтын салбарын эрхлэгч

46. Пунцаг-Осорын Наранцогт – Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Товхонхан" ХК-ийн трактор-комбайнч

47. Балчингийн Норжин – Төв аймгийн Жаргалант сумын өндөр настан

48. Лхагвын Нямаа – Нийслэлийн автотээврийн "22 дугаар баз" ХК-ийн жолооч

49. Найдангийн Нямсүрэн – Нийслэлийн автотээврийн "22 дугаар баз" ХК-ийн жолооч

50. Мишигийн Оргил – Булган аймгийн Тэшиг сумын "Шинэ амжилт" ХХК-ийн инженер

51. Даваасүрэнгийн Оюунбат – Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХК-ийн трактор-комбайнч

52. Доржийн Өлзий – Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Өндөрхаан" ХК-ийн ногоочин

53. Санжаагийн Өлзийбаатар – Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХК-ийн трактор-комбайнч

54. Лувсанчимэдийн Пүрвээ – Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвийн мэргэжилтэн

55. Доржийн Пэрэнлэй – Төв аймгийн Баянцогт сумын Засат даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн мэргэжилтэн

56. Вандан-Ишийн Рагчаабазар – Төв аймгийн Сүмбэр сумын "Сүмбэр-Өлзий" ХК-ийн мэргэжилтэн

57. Чимидхүүгийн Роза – Төв аймгийн Сүмбэр сумын "Оргил" хувираа эрхлэх аж ахуйн эзэн

58. Дагваагийн Рэнцэнбал – Булган аймгийн Булган сумын гурил тэжээлийн "Булган" ХК-ийн мэргэжилтэн

59. Надмидын Рэнцэнсамбуу – Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн бригадын дарга

60. Сүрэнхүүгийн Саруул – Төв аймгийн Баянчандмань сумын ногоочин

61. Совдын Содномцэрэн – Төв аймгийн Сүмбэр сумын "Сүмбэр-Өлзий" ХК-ийн трактор

62. Очирхүүгийн Содноо – Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Ноён уул" ХХК-ийн дэд захирал

63. Совдын Сундуй – Булган аймгийн Орхон сумын "Орхонмандал" ХК-ийн трактор

64. Гонгорын Сүхбаатар – Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын "Гурил тэжээл" ХК-ийн токарьчин

65. Дондогийн Сүхбаатар – Төв аймгийн Аргалант сумын "Төв нөхөрлөл" ХК-ийн нярав

66. Тогоогийн Тогтох – Дархан-Уул аймгийн Зам түүрийн засвар арчлалтын компанийн захирал

67. Санжийн Төмөрпүрэв – Дорнод аймгийн Засат даргын Тамгын газрын газар тариалангийн асуудал эрхэлсэн түшмэл

68. Цэвээний Төмөрхүү - Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Үүжим хангай" ХК-ийн механикч

69. Гэндэнгийн Түвдэнсүрэн – Нийслэлийн автотээврийн "Тав" ХК-ийн жолооч

70. Адъяасүрэнгийн Түмэндэлгэр – Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Торгон үр" ХК-ийн трактор

71. Хонгорын Тэгшжаргал – Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын "Орхонбулаг" ХК-ийн трактор-комбайнч

72. Тогмидын Уламбаяр - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын "Үргэц" хувираа эрхлэх аж ахуйн эзэн

73. Наваашийн Хавдылахав – Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Өндөрхаан" ХК-ийн трактор-комбайнч

74. Ганбаатарын Хишгээ – Хөдөө аж ахуй, үйлдвэрийн ямаын мэргэжилтэн

75. Сэр-Одын Хуяг – Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын "Цүү тайж" ХХК-ийн трактор-комбайнч

76. Чилхаажавын Хүрэлтөмөр – Булган аймгийн Хутаг- Өндөр сумын "Гурван борхууд" ХК-ийн комбайнч

77. Шошийн Цагаанбулаг – Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ногоочин

78. Шагваагийн Цагаанхүү - Төв аймгийн Угтаалцайдам сумын "Хүүлээ" ХК-ийн ерөнхий инженер

79. Доржийн Цэвэлмаа – Дархан-Уул аймгийн "Дархан гурил тэжээл" ХК-ийн ажилчин

80. Санжаагийн Цэдэндамба – Дорнод аймгийн Баян-Уул сумын "Нэмнэ" ХХК-ийн трактор-комбайнч

81. Сэвжидийн Цэрэнбат – Төв аймгийн Сүмбэр сумын "Сүмбэр өгөөж" ХК-ийн трактор-комбайнч

82. Баянгийн Цэрэндорж – Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Ерөө" ХХК-ийн үтрэмийн механикч

83. Лувсангийн Цэрэннадмид – Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Салхит өндөр" ХХК-ийн агрономич

84. Сономын Цэрэнпил - Нийслэлийн автотээврийн "22 дугаар баз" ХК-ийн жолооч

85. Хуанбайн Чаймардан – Нийслэлийн "Дэвшил трейд" ХК-ийн агрономич

86. Цэрэндоржийн Чойнхор – Байгаль орчны яамны Газар зохион бүгуулалтын албаны техникч

87. Цэрмаагийн Шаравдорж – Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн газрын агрономич

88. Сандагийн Шижирбаатар – Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэтолгой" ХК-ийн гурилын үйлдвэрийн операторч

89. Ламзавын Шуурай – Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Гурамтай" ХК-ийн механикч

90. Батын Энэбиш – Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Өнөр булагтай" ХК-ийн захирал

91. Гүржавын Эрдэнэбат – Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн захирал

92. Загдын Ядам – Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны мэргэжилтэн

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1. Базаргүрийн Алтангэрэл – Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын "Шижир холдинг" ХХК-ийн трактерч-комбайнч

2. Дэмбэрэлийн Атарбаясгалан – Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын "Шижир холдинг" ХХК-ийн трактерч-комбайнч

3. Цэдэнжавын Аюурзана – Хэнтий аймгийн Биндэр сумын "Амжилт" ХХК-ийн захирал

4. Очирсүрэнгийн Аюуш – Булган аймгийн Хишиг-Өндөр сумын "Хишиг-Өндөр уул" ХХК-ийн трактерч-комбайнч

5. Лувсанпэрэнлэйн Баасанжав – Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Өндөрхаан" ХХК-ийн ногоочин

6. Түвдэннямын Баасанжав – Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын "Орхон булаг" ХХК-ийн трактерч

7. Лхагвадоржийн Баатар – Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХХК-ийн трактерч-комбайнч

8. Мягмарын Баатар – Төв аймгийн Лүн сумын "Алтан түрүү" ХХК-ийн трактерч-комбайнч

9. Аюурзанын Бадамгарав – Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Их шинэстэй" ХХК-ийн үтрэмийн эрхлэгч

10. Гүржавын Базаррагчаа – Дорнод аймгийн Халхгол сумын "Булагдай" ХХК-ийн жолооч

11. Догсронжавын Батцогт – Төв аймгийн Угтаалцайдам сумын "Угтаал төв" ХК-ийн трактерч-комбайнч

12. Доржийн Баянхишиг – Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын "Бүрэнбумбат" ХК-ийн трактерч-комбайнч

13. Жигжидийн Баяраа – Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Од хараа" ХХК-ийн агрономич

14. Сангидоржийн Баясгалан – Сэлэнгэ аймгийн Баянгол сумын "Түмэн эрхэт" ХХК-ийн трактерч-комбайнч

15. Дамбадаржаагийн Баян-Эрдэнэ – Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын "Бүрэнбургалтай" ХХК-ийн трактерч-комбайнч

16. Довдонгийн Болд – Нийслэлийн автотээврийн "22 дугаар баз" ХК-ийн жолооч

17. Дэндэвийн Болд – Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын дарга

18. Цэрэндоржийн Болдбаатар – Нийслэлийн автотээврийн "Тав" ХК-ийн жолооч

19. Винтовын Бохой – Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Торгон ур" ХК-ийн трактерч-комбайнч

20. Баянбараатын Булдууч - Сэлэнгэ аймгийн Хушаат сумын "Голын хараат" ХХК-ийн бригадын дарга

21. Чимэдцэрэнгийн Буянбэлгэр – Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Ерөө" ХХК-ийн трактерч-комбайнч

22. Доржийн Галбадрах – Сэлэнгэ аймгийн Хушаат сумын "Арвин бүгат" ХК-ийн трактерч-комбайнч

23. Юнгэрэнгийн Галсан - Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Хөдөө аж ахуйн газрын албаны дарга

24. Доржийн Ганбаатар – Сэлэнгэ аймгийн Түшиг сумын "Зэлтэр" ХК-ийн еренхий инженер

25. Зандраагийн Ганбаатар – Сэлэнгэ аймгийн Орхон сумын "Орхондалай" ХХК-ийн трактерч-комбайнч

26. Цэвээний Гантөмөр – Хэнтий аймгийн Дадал сумын "Тэнүүн тал" ХХК-ийн трактерч

27. Баттулгын Гонгор – Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Баялаг газар" ХХК – ийн трактерч-комбайнч

28. Сэдийн Даваалхүмбэ – Увс аймгийн Баруунтуруун сумын "Усжуулах" ХК-ийн захирал

29. Доржсүрэнгийн Даваасамбуу – Булган аймгийн Тэшиг сумын "Шинэ амжилт" ХХК-ийн үтрэмийн эрхлэгч

30. Балданцэрэнгийн Даваахүү - Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Алтан дуулга" ХХК-ийн механикжуулагч

31. Жамбалын Дамдиндорж – Төв аймгийн Цээл сумын "Залуучууд" ХК-ийн трактерч-комбайнч

32. Лувсаншаравын Дансран – Төв аймгийн Жаргалант сумын "Хөх булаг" ХК-ийн үтрэмийн эрхлэгч

33. Лхамсүрэнгийн Дансүрэн – Төв аймгийн Заамар сумын "Заамар" ХХК-ийн салааны ахлагч

34. Пунцагийн Дарь – Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш

35. Лхүндэвийн Дарьсүрэн – Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан

36. Санжидын Дашбалдан – Дархан-Уул аймгийн "Дархан гурил тэжээл" ХК-ийн механикч

37. Найдангийн Дашдондог – Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын "Гуа дов" ХХК-ийн захирал

38. Дэндэвийн Дашпил – Төв аймгийн Баянхангай сумын "Атар" ХК-ийн трактерч

39. Жамбалдоржийн Доржпалам – Увс аймгийн Баруунтуруун сумын "Улаан сан" ХК-ийн агрономич

40. Жамъянжавын Мөнхбаяр – Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Зүүн хараа" ХХК-ийн тракторч-комбайнч

41. Рагчаагийн Мэндбаяр – Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Номунхан" ХХК-ийн дэд захирал

42. Тувааны Нямдаваа – Хэнтий аймгийн Хэрлэн сумын "Өндөрхаан" ХХК-ийн механикч

43. Чойдонгийн Нямжав – Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын "Бүрэн тал" ХХК-ийн захирал

44. Бэгзийн Нямсүрэн – Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Уужим хангай" ХК-ийн тракторч-комбайнч

45. Равагийн Нямсүрэн – Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дэлгэрхаан багийн иргэн

46. Гэндэнгийн Оросоо – Нийслэлийн "Алтан тариа" ХК-ийн ажилчин

47. Майдаржавын Орших - Өвөрхангай аймгийн Хархорин сумын "Хаан тамга" ХК-ийн тракторч-комбайнч

48. Ядамсүрэнгийн Очирбат – Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Алтан дуулга" ХХК-ийн ерөнхий агрономич

49. Сүхээгийн Оюунбаатар – Төв аймгийн Сүмбэр сумын "Өгөөж" ХХК-ийн тракторч-комбайнч

50. Жамсрангийн Пүрвээ – Дархан-Уул аймгийн Хонгор сумын "Торгон үр" ХК-ийн тракторч-комбайнч

51. Замбын Пүрэв – Увс аймгийн Баруунтуруун сумын "Улаан сан" ХК-ийн жолооч

52. Санжаагийн Пүрэвдорж – Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Баяндулаан-Уул" ХК-ийн гагнуурчин

53. Чүлтэмийн Пэрэнлэй – Төв аймгийн Сүмбэр сумын "Өгөөж" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

54. Чулууны Сугаррагчаа - Увс аймгийн Баруунтуруун сумын "Шад трейд" ХХК-ийн тракторч-комбайнч

55. Балдангийн Сур – Төв аймгийн Уггаалцайдам сумын "Уггаал төв" ХХК-ийн үтрэмийн операторч

56. Балдандоржийн Тунгалаг – Нийслэлийн "Алтан тариа" ХК-ийн ажилчин

57. Далайн Түвдэндорж – Булган аймгийн Хутаг-Өндөр сумын "Гурван борхууд" ХК-ийн механикжүулагч

58. Ишжамцын Түвдэндорж – Төв аймгийн Баянхангай сумын "Атар" ХК-ийн инженер

59. Жанжингийн Цэвээн – Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын "Улаанчулуут" ХХК-ийн тракторч

60. Дашийн Цэрэнжав – Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Улсын хяналтын албаны байцаагч

61. Пүрэвжавын Цэцгээ – Хөвсгөл аймгийн Рашаант сумын "Улаан од" ХХК-ийн агротехникч

62. Мөнхийн Чимэд - Төв аймгийн Баянцогт сумын "Дэлгэрбаясах" ХХК-ийн механикч-жолооч

63. Өлзийбадрахын Чимэддорж – Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Атар трейд" ХХК-ийн захирал

64. Жамбын Чинбат – Төв аймгийн Эрдэнэсант сумын "Хорго хайрхан" ХК-ийн тракторч-комбайнч

65. Бямбажавын Чулуунбаатар – Төв аймгийн Борнуур сумын "Борнуур" ХК-ийн бригадын дарга

66. Лхаасүрэнгийн Чулуунбаатар – Нийслэлийн "Алтан тариа" ХК-ийн гагнуурчин

67. Сумъяагийн Эвийцагаан – Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын "Чагтай" ХХК-ийн тракторч-комбайнч

68. Гэндэнгийн Энхбат – Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХК-ийн үтрэмийн ажилчин

69. Ёндонгийн Эрдэнээ – Дархан-Уул аймгийн зам барилгын "Дарзам" ХК-ийн ажилчин

70. Очирбатын Эрдэнээ – Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын "Найрамдал" ХХК-ийн агрономич

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 191 Улаанбаатар хот

Зарим тариаланчдыг "Атарчдын алдар" медалиар шагнах тухай

Газар тариалангийн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа хавсралтад дурдсан тариаланчдыг "Атарчдын алдар" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 191 дүгээр зарлигийн хавсралт

"Атарчдын алдар" медалиар шагнагдсан хүмүүсийн нэр

1. Далхын Нямдорж – Архангай аймгийн Төвшрүүлэх сумын "Багахангай" ХХК-ийн трактороч
2. Цэдэндамбын Пүрэвжил - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын "Багахангай" ХХК-ийн инженер
3. Чагнаадоржийн Мандах - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын "Жинст" ХХК-ийн трактороч
4. Жагабайн Шамширав – Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ногоочин
5. Ёндонгийн Пүрэвдорж – Булган аймгийн "Гурван борхууд" ХК-ийн трактороч, комбайнч
6. Чойжамцын Шижирбаатар - Булган аймгийн "Гурван борхууд" ХК-ийн трактороч, комбайнч
7. Гомбосүрэнгийн Чойжинжав – Булган аймгийн Сэлэнгэ сумын ахмад тариаланч
8. Найдангийн Дамдинжав - Булган аймгийн Сэлэнгэ сумын ахмад тариаланч
9. Данзанжамцын Хишигсүрэн - Булган аймгийн Сэлэнгэ сумын ахмад тариаланч
10. Дашдаваагийн Чойжилсүрэн – Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХХК-ийн нярав
11. Нансалдоржийн Бадгай – Булган аймгийн Сэлэнгэ сумын "Ингэттолгой" ХХК-ийн трактороч,комбайнч
12. Чулууны Жанчидорж – Булган аймгийн Баяннуур сумын Засаг дарга
13. Пүрэвсүрэнгийн Дамба – Булган аймгийн Булган сумын Стандарт, хэмжил зүйн төвийн захирал
14. Доржийн Бямбатөгс – Говь-Алтай аймгийн Шарга сумын Баянгол багийн ногоочин
15. Аюурзанын Цогбадрах – Говь-Алтай аймгийн Шарга сумын Баянгол багийн агротехникч
16. Жамбалын Шаарийбуу – Говь-Алтай аймгийн Гуулин тосгоны "Агро Гуулин" хорооны эзэн
17. Лхамжавын Гантулга – Дорноговь аймгийн ерөнхий агрономич
18. Цэвээний Жадамбаа – Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын 4-р багийн малчин
19. Санжаагийн Бадарч - Дорнод аймгийн Цагаан-Овоо сумын ЗДТГ-ын нярав
20. Цэрэн-Осорын Лхагва - Өвөрхангай аймгийн "Хаан тамга" ХК-ийн трактороч комбайнч
21. Майдаржавын Орших - Өвөрхангай аймгийн "Хаан тамга" ХК-ийн трактороч комбайнч
22. Цэрэндоржийн Төмөрбаатар - Өвөрхангай аймгийн "Нарийн хүр" багийн үтрэмийн сахиул
23. Цэрэнгийн Аюурзана - Өвөрхангай аймгийн "Нарийн хүр" багийн үтрэмийн эрхлэгч
24. Ойдовын Сүрэндэлэг - Өвөрхангай аймгийн "Нарийн хүр" багийн трактороч комбайнч
25. Магнайн Даваадорж - Өвөрхангай аймгийн "Нарийн хүр" багийн трактороч-комбайнч
26. Цэвээний Лувсандорж - Өвөрхангай аймгийн "Вангийн-Овоо" багийн аж ахуйн нярав-механик
27. Доржсүрэнгийн Мяасүрэн - Өвөрхангай аймгийн "Вангийн овоо" багийн захирал
28. Дамдингийн Төмөрдөш- Өвөрхангай аймгийн "Есөн хөгжил" ХК-ийн салааны ахлагч
29. Бавуудоржийн Даваа- Өвөрхангай аймгийн "Есөн хөгжил" ХК-ийн трактороч
30. Цэгмэдийн Нямдорж- Сүхбаатар аймгийн Тамгын газрын агрономч
31. Чулууны Наваандэмбэрэл- Сэлэнгэ аймгийн "Ерөө" ХХК-ийн жолооч нярав
32. Цэдэндоржийн Наваан- Сэлэнгэ аймгийн "Ерөө Хайрхан буудай" ХХК-ийн захирал
33. Цамбын Хувцагаан- Сэлэнгэ аймгийн "Ерөө" ХХК-ийн жолооч
34. Гэндэнгийн Орших – Сэлэнгэ аймгийн "Ерөө" ХХК-ийн ня-бо
35. Мядагмаагийн Батсуурь- Сэлэнгэ аймгийн "Ерөө" ХХК-ийн трактороч, комбайнч
36. Лувсандагвын Хишигбуян- Сэлэнгэ аймгийн "Ерөө" ХХК-ийн трактороч, комбайнч
37. Жамцын Цогтсайхан- Сэлэнгэ аймгийн "Ерөө" ХХК-ийн трактороч, комбайнч
38. Далхаасүрэнгийн Ганбаатар- Сэлэнгэ аймгийн "Их Шинэстэй" ХХК-ийн трактороч комбайнч
39. Наранхүүгийн Даваасүрэн- Сэлэнгэ аймгийн "Их Шинэстэй" ХХК-ийн трактороч комбайнч
40. Батын Цэрэнсэд- Сэлэнгэ аймгийн "Их Шинэстэй" ХХК-ийн ахмад тариаланч

41. Цогдолын Даваахүү- Сэлэнгэ аймгийн "Их Шинэстэй" ХХК-ийн трактороч комбайнч

42. Цэдэндоржийн Жаргалсайхан- Сэлэнгэ аймгийн "Их Шинэстэй " ХХК-ийн трактороч комбайнч

43. Буурайн Жукбат- Сэлэнгэ аймгийн Мандал сум "Их мандал" ХХК-ийн захирал

44. Гомбожавын Баасандаш- Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Сүүтэй" ХХК-ийн трактороч

45. Чойжамцын Чадраа- Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Өгөөмөр" ХХК-ийн захирал

46. Авирмэдийн Ядмаа- Сэлэнгэ аймгийн Мандал сумын "Ноён уул" ХХК-ийн нярав

47. Рэнцэндоржийн Мөнхжаргал- Сэлэнгэ аймгийн "Товхон хан" ХХК-ийн тоо бүртгэгч

48. Нанзаддоржийн Балданмагсар- Сэлэнгэ аймгийн "Найрамдал" ХК-ийн тоо бүртгэгч, нүүлэгч

49. Додабайн Күпикей- Сэлэнгэ аймгийн "Бургалтай" ХХК-ийн үтрэмийн эрхлэгч

50. Адъяагийн Мөнх- Очир – Сэлэнгэ аймгийн "Бүрэн бумбат" ХХК-ийн трактороч

51. Баастын Батаа – Сэлэнгэ аймгийн "Бүрэн бумбат" ХК-ийн механик

52. Ойдовын Оюунцэцэг- Сэлэнгэ аймгийн "Бүрэн бумбат" ХХК-ийн үтрэмийн нүүлэгч

53. Ишжанцангийн Жавзмаа- Сэлэнгэ аймгийн "Бүрэн бумбат" ХХК-ийн нябо

54. Жадамбын Ёндон- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн трактороч

55. Зоригтын Бүрэндүүрэн- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн трактороч

56. Лавирангийн Аюуш- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн ахмад тариаланч

57. Ядамдоржийн Цэрэндорж- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн ахмад тариаланч

58. Минжүүрийн Чулуунбаатар- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн ахмад тариаланч

59. Жамбын Адъяасүрэн- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн ахмад тариаланч

60. Дагвын Жигжид- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн ахмад тариаланч

61. Өнөрийн Жанчив- Сэлэнгэ аймгийн "Бүрэнбургалтай" ХХК-ийн ахмад тариаланч

62. Доржготовын Ганбат- Сэлэнгэ аймгийн Баруунхараа "Шандын овоо" ХХК-ийн захирал

63. Чүлтэмийн Дамдиннямбуу- Сэлэнгэ аймгийн Баруунхараа СААН-н усжуулалтын инженер

64. Пүрэвийн Сампионоров- Сэлэнгэ аймгийн Баруунхараа СААН-н ногооч

65. Дашнямын Дамдиндорж- Сэлэнгэ аймгийн Баруунхараа СААН-н ахмад тариаланч

66. Лувсандашийн Мягмардорж- Сэлэнгэ аймгийн "Солонго" ХХК-ийн манаач

67. Доржийн Жигдэв- Сэлэнгэ аймгийн "Өрнөлт Сэлэнгэ" ХХК-ийн инженер

68. Цэвэгжавын Нямдорж- Сэлэнгэ аймгийн "Өрнөлт Сэлэнгэ" ХХК-ийн захирал

69. Дамбадаржаагийн Чимэдрэгзэн- Сэлэнгэ аймгийн "Өрнөлт Сэлэнгэ" ХХК-ийн трактороч

70. Сүрэнгийн Лхагваа- Сэлэнгэ аймгийн "Дэлгэрхараа" ХХК-ийн механик жолооч

71. Лувсанжамъянгийн Эрдэнэбаяр- Сэлэнгэ аймгийн "Аргандагат" ХХК-ийн ерөнхий захирал

72. Юмжилын Жигмэддорж- Сэлэнгэ аймгийн "Хүдэр ургач" ХХК-ийн бригадын дарга

73. Очиржанцангийн Оюунцэцэг- Сэлэнгэ аймгийн Тарвагатайн 1-р багийн засаг дарга

74. Бавуугийн Чулуунбат- Сэлэнгэ аймгийн "Хонгор овоо" нөхөрлөлийн дарга

75. Түдэвийн Баасанжав- Сэлэнгэ аймгийн "Есөн эрдэнэ" ХЭАА-н эзэн

76. Дорлигийн Бямбажав- Сэлэнгэ аймгийн "Наран" ХХК-ийн трактороч, бригадын дарга

77. Чагдагийн Аюур- Сэлэнгэ аймгийн "Ургагын төлөө" ХХК-ийн захирал

78. Даваагийн Гамбаа- Сэлэнгэ аймгийн "Энхтал" СААн бригадын дарга

79. Лхамзавын Бадарч- Сэлэнгэ аймгийн "Зэлтэр" ХХКийн үтрэмийн эрхлэгч

80. Гүрсэдийн Бадарч- Сэлэнгэ аймгийн "Зэлтэр" ХХКийн дэд захирал

81. Гончигийн Дампил – Сэлэнгэ аймгийн "Ундрагч" ХХК-ийн трактороч

82. Бакейн Тургэнбайн – Сэлэнгэ аймгийн "Бент" ХХКийн үтрэмийн сахиул

83. Бямбаагийн Цэдэндорж – Сэлэнгэ аймгийн "Ихбаялаг" ХХК-ийн тракторч-комбайнч

84. Самбуугийн Пүрэвсүрэн – Сэлэнгэ аймгийн "Улаанчулуун" ХХК-ийн механик

85. Цагааны Дамийжав – Сэлэнгэ аймгийн Баянхараат СААн төмрийн дархан

86. Дудууны Жудай – Сэлэнгэ аймгийн Баянхараат СААн тогооч

87. Содномын Өөдөс – Сэлэнгэ аймгийн Баянхараа: СААн үтрэмийн ажилчин

88. Загдсүрэнгийн Сүхээ – Сэлэнгэ аймгийн Баянхараат СААн бригадын дарга

89. Занасамбын Шарав – Сэлэнгэ аймгийн Баянхараат СААн механик

90. Батын Эрдэнэ – Сэлэнгэ аймгийн Баянхараат СААн бригадын дарга

91. Сономбазарын Анаамиш – Сэлэнгэ аймгийн "Орхондалай" ХК-ийн ерөнхий инженер

92. Бадарчийн Батаа – Сэлэнгэ аймгийн "Орхондалай" ХК-ийн трактор комбайнч

93. Цэвээний Даваадорж Сэлэнгэ аймгийн "Орхондалай" ХК–ийн агрономич

94. Өлзий-Утасны Жадамбаа – Сэлэнгэ аймгийн "Орхондалай" ХК-ийн засварчин

95. Ишдоржийн Нямгар – Сэлэнгэ аймгийн "Орхондалай" ХК-ийн тракторч

96. Дашийн Нямцэрэн – Сэлэнгэ аймгийн "Орхондалай" ХК-ийн тракторч

97. Должингийн Алгаа – Сэлэнгэ аймгийн Орхон САА-н тракторч

98. Чулууны Бадам – Сэлэнгэ аймгийн Орхон САА-н моторчин

99. Түдэвийн Гарвуу – Сэлэнгэ аймгийн Орхон САА-н моторчин

100. Сүх-Очирын Жууяар – Сэлэнгэ аймгийн Орхон САА-н дизельчин

101. Дашдэлэгийн Ишдорж – Сэлэнгэ аймгийн Орхон САА-н бригадын дарга

102. Цэдэн-Ишийн Лхагваа – Сэлэнгэ аймгийн "Орхон" САА-н бригадын дарга

103. Моломын Пүрэв- Сэлэнгэ аймгийн Орхон САА-н тракторч

104. Гончигийн Пүрэвдорж- Сэлэнгэ аймгийн Орхон САА-н тракторч

105. Дашдоржийн Санги- Сэлэнгэ аймгийн Орхон САА-н бригадын дарга

106. Шарав- Очирын Төмөрбаатар- Сэлэнгэ аймгийн Орхон САА-н тракторч

107. Сонингаравын Хасдорж- Сэлэнгэ аймгийн Орхон САА-н тракторч

108. Пүрэвийн Хорлоо- Сэлэнгэ аймгийн Орхон САА-н тракторч

109. Тогоочийн Дорживуу- Сэлэнгэ аймгийн Орхон САА-н механик

110. Вонфийн Баатар- Сэлэнгэ аймгийн Орхон сумын кино механикч

111. Балдангийн Батменх- Сэлэнгэ аймгийн Орхон сумын соёлын төвийн эрхлэгч

112. Шаравдоржийн Дервөлжин- Сэлэнгэ аймгийн Орхон сумын засаг дарга

113. Гончигсүрэнгийн Жанцанцорж- Сэлэнгэ аймгийн Орхон сумын 1 багийн засаг дарга

114. Пүрэвийн Эрдэнэбат- Сэлэнгэ аймгийн Орхон сумын ИТХ-ын дарга

115. Очирбатын Бичээхүү-Сэлэнгэ аймгийн "Багашанд" ХХК-ийн жолооч

116. Булгаагийн Булданаа- Сэлэнгэ аймгийн "Цэгээнхуст" ХХК-ийн үтрэмийн эрхлэгч

117. Төрбадрахын Цагаач- Сэлэнгэ аймгийн "Цэгээнхуст" ХХК-ийн комбайнч

118. Дэмидийн Ягаанцэцэг- Сэлэнгэ аймгийн Сорт сорилтын агрономч

119. Даваадоржийн Атарбаатар- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн үтрэмийн нормчин

120. Жадамбын Намсрай- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн үтрэмийн нормчин

121. Хандсүрэнгийн Цолмонбаатар- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн үтрэмийн нормчин

122. Цэрэнжавын Даваасүрэн- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн үтрэмийн нормчин

123. Цэндсүрэнгийн Дашням- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн үтрэмийн нормчин

124. Цэрэндамбын Лхагвасүрэн- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн трактор комбайнч

125. Цэдэндамбын Болд- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн тракторч

126. Доржийн Зундуй- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" ХК-ийн трактор механикч

127. Жаргалын Тогоохүү- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" САА-н трактор комбайнч

128. Ванчинсамбуугийн Балдандорж- Сэлэнгэ аймгийн "Зүүнбүрэн" сумын ахмад тариаланч

129. Билгүүнгэрэлийн Идэр-Арслан- Сэлэнгэ аймгийн "Идэр" ХЭАА-н эзэн

130. Мижиддоржийн Батцэнгэл- Сэлэнгэ аймгийн "Гэгээлэг" ХХК-ийн трактороч комбайнч

131. Лувсангийн Бишгарам- Сэлэнгэ аймгийн "Шижир Холдинг" ХХК-ийн үтрэмийн сахиул

132. Доржийн Билэгсайхан- Сэлэнгэ аймгийн "Гурил тэжээл" ХК-ийн цахилгаан цехийн дарга

133. Лувсансамдангийн Туяа- Сэлэнгэ аймгийн "Гурил тэжээл" ХК-ийн цехийн дарга

134. Самбуугийн Баасан- Сэлэнгэ аймгийн "Худэр" ТАА-н тракторч

135. Чимэдийн Дамдинпүрэв- Сэлэнгэ аймгийн "Худэр" ТАА-н тракторч

136. Луучийн Жаргал - Сэлэнгэ аймгийн "Худэр" ТАА-н үтрэмийн эрхлэгч

137. Лхамсүрэнгийн Монхор- Сэлэнгэ аймгийн "Худэр" ТАА-н тракторч

138. Дондогцэрэнгийн Энэбиш - Сэлэнгэ аймгийн "Худэр" ТАА-н тракторч, комбайнч

139. Сээтэнгийн Мятав - Сэлэнгэ аймгийн " Худэр" ТАА-н ахмад тариаланч

140. Сувдын Найдан - Сэлэнгэ аймгийн "Худэр" ХК-ийн эдийн засагч

141. Төмөрхуягийн Жамбалдорж - Сэлэнгэ аймгийн Худэр сумын трактөрч

142. Дансрангийн Лхамгарав - Сэлэнгэ аймгийн Худэр сумын татварын байцаагч

143. Чултэмийн Пүрэвсүрэн - Сэлэнгэ аймгийн "Азын хиймөрь" нөхөрлөлийн жолооч

144. Дамдингийн Батмөнх – Сэлэнгэ аймгийн "Арчандагатай" ХХК-ийн засварчин

145. Нарангийн Батхүү - Сэлэнгэ аймгийн "Минжхангай" ХК-ийн зоорын эрхлэгч

146. Долдойн Валя – Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ахмад тариаланч

147. Лувсанбалдангийн Ганхуяг - Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ахмад тариаланч

148. Лувсанцэрэнгийн Уртнасан – Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ЗДТГ-ын слесарь

149. Лодойн Дамдин – Сэлэнгэ аймгийн Сант сумын ахмад тариаланч

150. Лувсангомбын Отгондорж - Сэлэнгэ аймгийн Сант сумын ахмад тариаланч

151. Санжаагийн Баасан - Сэлэнгэ аймгийн Сант сумын ахмад тариаланч

152. Дагважамцын Загд - Сэлэнгэ аймгийн Сант сумын ахмад тариаланч

153. Гомбосүрэнгийн Доржпүрэв - Сэлэнгэ аймгийн Сант сумын ахмад тариаланч

154. Магнайн Энхбаяр - Сэлэнгэ аймгийн Сант сумын ахмад тариаланч

155. Санжжавын Лундаажанцан - Сэлэнгэ аймгийн Сант сумын тариаланч

156. Пүрэвжавын Баян - Сэлэнгэ аймгийн Сант сумын тариаланч

157. Сүрэнхандын Пүрвээ – Сэлэнгэ аймгийн "Цагаантолгой" ХК-ийн трактөрч

158. Даваагийн Баттувшин - Сэлэнгэ аймгийн "Цагаантолгой" ХК-ийн салааны ахлагч

159. Доржхандын Баяржаргал - Сэлэнгэ аймгийн "Цагаантолгой" ХК-ийн трактөрч

160. Долгорьчин Нямсүрэн - Сэлэнгэ аймгийн "Цагаантолгой" ХК-ийн трактөрч

161. Жамъяаншаравын Жаргалбат – Сэлэнгэ аймгийн "Цагаантолгой" ХК-ийн трактөрч

162. Бямбацоогийн Бямбасүрэн - Сэлэнгэ аймгийн "Цагаантолгой" ХК-ийн трактөрч

163. Гийхнарангийн Энхтөр - Сэлэнгэ аймгийн "Цагаантолгой" ХК-ийн трактөрч

164. Дэмбэрэлийн Готов – Төв аймгийн "Ширээт" ХК-ийн трактөрч-комбайнч

165. Балчиндоржийн Магсаржав – Төв аймгийн "Нөхөрлөл САА, ТАА" ХХК-ийн үтрэмийн эрхлэгч

166. Бадамгүрийн Нямдорж – Төв аймгийн Аргалант сумын ахмад тариаланч

167. Равдангийн Буянжаргал – Төв аймгийн Батсүмбэр САА-н трактөрч

168. Чулууны Гарваадай – Төв аймгийн Батсүмбэр САА-н трактөрч

169. Цэдэндамбын Гэндэн – Төв аймгийн Батсүмбэр САА-н бригадын дарга

170. Содномын Дуламжав – Төв аймгийн Батсүмбэр САА-н жолооч

171. Доржийн Ганболд – Төв аймгийн Баянцогт сумын тариаланч

172. Намжилын Чимэд – Төв аймгийн Баянчандмань сумын ногоочин

173. Баатарын Төмөрчөдөр – Төв аймгийн "Борнуур" ХК-ийн зоорийн эрхлэгч

174. Должингийн Балжирдэндэв – Төв аймгийн "Жаргалант" ХК-ийн трактөрч

175. Намжилжавын Өлзийбүрэн - Төв аймгийн "Жаргалант" САА-н орлогч нябо

176. Рэнцэнгийн Магсар – Төв аймгийн Заамар сумын ахмад тариаланч

177. Галсангийн Дэмбэрэл – Төв аймгийн "Алтан түрүү" ХХК-ийн трактөрч

178. Дагжидын Лхамжав – Төв аймгийн "Алтан түрүү" ХХК-ийн нярав

179. Лхамжавын Дорждагва – Төв аймгийн Өндөр ширээт сумын ахмад тариаланч

180. Лувсанцэрэнгийн Мэндсайхан - Төв аймгийн Өндөр ширээт сумын ахмад малчин

181. Гомбын Очирбат - Төв аймгийн Өндөр ширээт сумын ахмад малчин

182. Рэнцэндоржийн Бадамсүрэн - Төв аймгийн Өндөр ширээт сумын ахмад тариаланч

183. Самбын Өлзийхутаг – Төв аймгийн "Үгтаал төв" ХК-ийн тарктөрч-комбайнч

184. Чойдогийн Улаанхүү - Төв аймгийн "Үгтаал төв" ХК-ийн инженер механик

185. Цагааны Ганбаатар – Төв аймгийн Үгтаалцайдам сумын ахмад тариаланч

186. Баянбаагийн Шонхоон – Төв аймгийн Үгтаалцайдам сумын ахмад тариаланч

187. Жаргалын Гантөмөр – Төв аймгийн "Залуучууд" ХК-ийн трактөрч

188. Адъяагийн Оюунцэцэг – Төв аймгийн Эрдэнэсант сумын трактөрч

189. Бат-Очирын Цэрэндорж – Төв аймгийн "Буянт төв" ХК-ийн үтрэмийн эрхлэгч

190. Дүгэржавын Барьд – Төв аймгийн Зуунмод хотын

ахмад тариаланч

191. Санжжавын Данзанням – Төв аймгийн "Өгөөж" ХК-ийн жолооч

192. Жүмбэлгийн Батнасан – Увс аймгийн Баруунтуруун сумын "Туруун" ХК-ийн тарторч-комбайнч

193. Бадарчийн Дүүдэй - Увс аймгийн Баруунтуруун сумын "Туруун" ХК-ийн тарторч-комбайнч

194. Лувсангийн Маамхүү - Увс аймгийн Баруунтуруун сумын "Туруун" ХК-ийн тарторч-комбайнч

195. Доржийн Нямаа - Увс аймгийн Баруунтуруун сумын "Туруун" ХК-ийн тарторч-комбайнч

196. Авирмэдийн Бямбажав - Увс аймгийн Баруунтуруун сумын "Зүүнтуруун" ХК-ийн тарторч-комбайнч

197. Орсоогийн Эрдэнэгэрэл - Увс аймгийн Баруунтуруун сумын "Жинст" ХК-ийн бригадын дарга

198. Навиханы Есилхан – Ховд аймгийн Ховд сумын Улаанбураа багийн ногоочин

199. Шөнбайчийн Төкеш - Ховд аймгийн Ховд сумын Улаанбураа багийн ногоочин

200. Пүрэвжавын Дүрэнбат – Ховд аймгийн Дарви сумын Мөрөн багийн ахмад тариаланч

201. Гэсгэлэнгийн Сэмбэрүү - Ховд аймгийн Үенч сумын ногоочин

202. Хөхийн Шаадай – Ховд аймгийн Манхан сумын "Манай зам" компанийн тариаланч

203. Доржийн Батчулуун – Ховд аймгийн ХААИС-ийн Алтай бүсийн салбарын тэнхмийн эрхлэгч

204. Аюурзаны Хорлоо – Ховд аймгийн ХААИС-ийн Алтай бүсийн салбарын ЭША

205. Авканы Ховдвай - Ховд аймгийн ХААИС-ийн Алтай бүсийн салбарын ЭША

206. Гонгорын Баттогтох - Ховд аймгийн ХААИС-ийн Алтай бүсийн салбарын ЭША

207. Лоолийгийн Жийзаа - Ховд аймгийн ХААИС-ийн Алтай бүсийн салбарын ЭША

208. Шаравсамбуугийн Даваасүрэн - Ховд аймгийн ХААИС-ийн Алтай бүсийн салбарын ЭША

209. Дунжийн Энх-Амгалан – Хөвсгөл аймгийн "Артархи" ХК-ийн трактерч-комбайнч

210. Цэдэвийн Равдандорж - Хөвсгөл аймгийн "Артархи" ХК-ийн трактерч-комбайнч

211. Сүрэнгийн Түмэнбаяр – Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын тариаланч

212. Дамдингийн Бадамгарав - Хөвсгөл аймгийн Эрдэнэбүрэн сумын тариаланч

213. Дансрангийн Лхагважамц - Хөвсгөл аймгийн Тариалан сумын трактерч-комбайнч

214. Дарийн Баасанжав – Хөвсгөл аймгийн Тариалан сумын тариаланч

215. Намдингийн Дамдинсүрэн – Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Алтандуулга" ХК-ийн трактерч

216. Элдэв-Очирын Батмөнх - Хөвсгөл аймгийн Тариалан сумын "Алтандуулга" ХК-ийн трактерч

217. Зинагийн Дугарсүрэн – Хөвсгөл аймгийн Тариалан сумын тариаланч

218. Даваагийн Дашдорж - Хөвсгөл аймгийн Тариалан сумын трактерч-комбайнч

219. Гунгаагийн Пүрэвдорж - Хөвсгөл аймгийн Тариалан сумын трактерч-комбайнч

220. Лувсангийн Дарамжав – Хөвсгөл аймгийн Тосолцэнгэл сумын төвийн зооринй сахиул

221. Цагааны Батаа - Хөвсгөл аймгийн Тосолцэнгэл сумын төвийн ногоочин

222. Гарьдын Санжгарав - Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын төвийн ногоочин

223. Төмөрийн Төмөрхойлог - Хөвсгөл аймгийн Тосолцэнгэл сумын ногоочин

224. Рагчаагийн Гүржав – Хөвсгөл аймгийн Их-Уул сумын трактерч-комбайнч

225. Гонгорын Санжаа - Хөвсгөл аймгийн Их-Уул сумын трактерч-комбайнч

226. Дангиагийн Даваасүрэн - Хөвсгөл аймгийн Их-Уул сумын трактерч-комбайнч

227. Лунангийн Отряд - Хөвсгөл аймгийн Их-Уул сумын төвийн ногоочин

228. Бурмаагийн Дашравдан – Хөвсгөл аймгийн Рашаант сумын "Улаан-Од" ХК-ийн трактерч-комбайнч

229. Бямбын Жамбалдорж - Хөвсгөл аймгийн Рашаант сумын тариаланч

230. Батын Батчулуу – Хөвсгөл аймгийн Мөрөн сумын тариаланч

231. Ширэнжавын Магсаржав – Хэнтий аймгийн Хэрлэн Сумын ЗДТГ-ын байцаагч

232. Дашдондогийн Алтанхүяг – Хэнтий аймгийн Хэрлэн сумын ЗДТГ-ын байцаагч

233. Мядагмаагийн Гүрцэрэн – Хэнтий аймгийн Батширээт сумын Батжил нэгдлийн тариаланч

234. Аюушийн Бадамгарав - Хэнтий аймгийн Батширээт сумын Батжил нэгдлийн тариаланч

235. Алтангэрэлийн Жамбаа - Хэнтий аймгийн Батширээт сумын Батжил нэгдлийн тариаланч

236. Лувсангобын Дашзэвэг – Хэнтий аймгийн Өлзийт сумын тариаланч

237. Сэдэдийн Жанцан - Хэнтий аймгийн Өлзийт сумын тариаланч

238. Зинагийн Люда - Хэнтий аймгийн Өлзийт сумын тариаланч

239. Самбуугийн Дамдинсүрэн - Хэнтий аймгийн Өлзийт сумын тариаланч

240. Рэнцэнгийн Доржготов - Хэнтий аймгийн Өлзийт сумын нярбо

241. Цэвээний Шаарийбуу - Хэнтий аймгийн Өлзийт сумын багийн Засаг дарга

242. Хуатаны Каламан - Хэнтий аймгийн Өлзийт сумын тракторч-комбайнч

243. Гэндэнжамцын Ганболд - Хэнтий аймгийн Өлзийт сумын тариаланч

244. Гомбожавын Пүрэвжав - Хэнтий аймгийн Өлзийт сумын тариаланч

245. Лхамсүрэнгийн Доржготов - Хэнтий аймгийн Өлзийт сумын тариаланч

246. Тамжид-Ёндонгийн Саранцэцэг - Хэнтий аймгийн Өлзийт сумын "Атарчандгана" ХК-ийн тариаланч

247. Зундүйн Пүрэвтогоо – Хэнтий аймгийн Гурванбаян сумын "Буудайн цацал" ХК-ийн тариаланч

248. Цэрэнгийн Нямжав – Орхон аймгийн Жаргалант сумын сүүний аж ахуйн трактөрч

249. Дамдинсүрэнгийн Амгалан – Орхон аймгийн Жаргалант сумын "Бүтлийн Үндрага" ХХК-ийн трактөрч-комбайнч

250. Жамъянгийн Алтангэрэл – Орхон аймгийн жаргалант сумын ахмад тариаланч

251. Нацагдоржийн Адъяа - Орхон аймгийн Жаргалант сумын ахмад тариаланч

252. Далайн Дэмбэрэл – Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч

253. Оттоны Нинж - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч

254. Чулуунхүүгийн Баатаржав - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч

255. Онжилын Мандал - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч

256. Минжүүрийн Жуков - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч

257. Цэрэнгийн Даринчулуун - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч

258. Сундуйжавын Дарийма - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн тоо бүртгэгч

259. Баянбулагийн Гантөмөр - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн тракторч-комбайнч

260. Шавганцын Мундаг - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч-комбайнч

261. Цэрэн-Очирын Юра - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн ахмад тариаланч

262. Бадрахын Баатар - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн хэсгийн ахлагч

263. Хандын Цура - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн механик

264. Жанцангийн Чойбалсан - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч-комбайнч

265. Огнойн Рэвжин - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн трактөрч-комбайнч

266. Минжүүрийн Даваасамбуу - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн манаач

267. Дэмчигийн Чойбалсан - Дархан-Уул аймгийн "Торгон үр" ХК-ийн манаач

268. Радаагийн Бадарч - Дархан-Уул аймгийн "Уужим хангай" ХК-ийн трактөрч-комбайнч

269. Хишигийн Ганбат - Дархан-Уул аймгийн "Уужим хангай" ХК-ийн хэсгийн ахлагч

270. Чойнхорын Пүрэвжав - Дархан-Уул аймгийн "Уужим хангай" ХК-ийн механик

271. Дамдинхүүгийн Риймаа - Дархан-Уул аймгийн "Уужим хангай" ХК-ийн нярбо

272. Цэрэн-Очирын Янжмаа - Дархан-Уул аймгийн "Уужим хангай" ХК-ийн нүүлэгч

273. Балданжмцын Содномпунцаг – Дархан-Уул аймгийн Хонгор сумын Мэдээлэл сурталчилгааны албаны эламжийн байцаагч

274. Лувсангийн Сандагдорж – Дархан-Уул аймгийн Дархан ӨАА-н трактөрч- комбайнч

275. Норовын Цэрэндагва – Дархан-Уул аймгийн "Сөдөг" ХК-ийн трактөрч

276. Цэрэн-Очирын Волоож – Дархан-Уул аймгийн холбооны салбарын жижүүр

277. Батбилэгийн Мэнддаргал – Хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

278. Жамцын Даваасүрэн – Хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

279. Дэлгэгийн Сэлэнгэ – Хөдөө аж ахуйн хяналтын улсын албаны байцаагч

280. Дэмбэрэлийн Мандалсүрэн – Хөдөө аж ахуйн хяналты улсын албаны ахмад ажилтан

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 194** **Улаанбаатар хот**

М.А. Винокуров, Н. М. Токарская нарыг шагнах тухай

Монгол Улсад мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, хоёр орны дээд сургуулиудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Оросын Холбооны Улсын Эрхүү хотын Эдийн засгийн академийн захирал Михаил Алексеевич Винокуров-ыг "Алтан гадас" одонгоор, тэнхимийн эрхлэгч Нинель Михайловна Токарская-г "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

ЭМ, БИОБЭЛДМЭЛ, ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

1999 оны 10 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 38** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор батлагдсан "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам"-ын 5.1-ийг үндэслэн **ТУШААХ НЬ:**

1. Тус албаны чанарын хяналтын байцаагч нарын хяналтын дүрмээр олгогдсон эрхийн хэмжээнд захиргааны журмаар эм, эмнэлгийн багаж хэрэгслийг хураах, улсын орлого болгох, устгах журмыг нэгдүгээр хавсралтын ёсоор батална.

2. Захиргааны журмаар хураасан эм, эмнэлгийн багаж хэрэгслийг устгах, улсын орлого болгох, бусад байгууллагад шилжүүлэх асуудлыг захиргааны эрхлэлийн хурлаар оруулж шийдвэрлэж байсугай.

3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга Д. Цэндээхүүд үүрэг болгосугай.

ДАРГА **А. ДАМДИНСҮРЭН**

Эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын албаны даргын 1999 оны 38 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

ЭМ, БИОБЭЛДМЭЛ, ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ХЯНАЛТЫН АЛБАНААС ЗАХИРГААНЫ ЖУРМААР ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙГ ХУРААХ, УЛСЫН ОРЛОГО БОЛГОХ, УСТГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Захиргааны журмаар эм, эмнэлгийн хэрэгслийг хураах, улсын орлого болгох, устгахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2 Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолоор батлсан "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах нийтлэг журам"-ыг үндэс болгох ба олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр эмнэлэг, эмийн хангалтын үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, олон улсын болон гадаадын үйлдвэрийн газар, байгууллага, Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх, түр буюу урт хугацаагаар оршин сууж буй гадаадлын иргэн, харъяалалгүй хүмүүст энэхүү журам нэгэн адил үйлчилнэ.

Хоёр. Захиргааны журмаар эм, эмнэлгийн хэрэгслийг хураах

2.1 Эмийн хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлагыг зөрчсөнөөс эмийн чанар муудсан нь тогтоогдвол эмийг хураах

2.2 Эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаажилт хийгдээгүй эмийг зохих байгууллагаас зөвшөөрөлгүйгээр импортлосон, экспортлосон, хэрэглэж худалдаалж байгаа бол хураах

2.3 Төрийн захиргааны холбогдох төв байгууллагын зөвшөөрөлгүй эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл явуулсан, эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх үндсэн шаардлагыг хангаагүй үйлдвэр явуулсан /Эмийн тухай хуулийн 10.2/, Эмийн хуулийн 11 дүгээр зүйлийг зөрчсөн тохиолдолд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хураах

2.4 Хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчинд хор нөлөө учруулах эм, эмнэлгийн хэрэгслийг хураах

2.5 Зөрчлийг нуун дарагдуулахаас сэргийлж эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмжийг битүүмжилж бичиг баримтыг хураах

2.6 Эм, эмнэлгийн хэрэгслийг дээр дурдсан үндэслэлээр түс байгууллагын эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын улсын, ахлах, ерөнхий байцаагчид хураана.

2.7 Захиргааны журмаар хураагдаж буй эм, эмнэлгийн хэрэгслийн тээвэрлэлтийн зардлыг зөрчил гаргасан этгээд хариуцна.

2.8 Эм, эмнэлгийн хэрэгсдийг хураахад акт, тэмдэглэл үйлдэж, тооцооны хуудас бичиж нэг хувийг зөрчил гаргасан этгээдэд, үлдэх хувийг зөрчлийн хэрэгт хавсарган байгууллагын бүртгэлд авна.

2.9 Хураагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг байгууллагын захиргааны зөвлөлд оруулж эцэслэн шийдвэрлэх бөгөөд хураагдсан эм, эмнэлгийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, чанарын асуудлыг хураасан байцаагчид хариуцна.

2.10 Битүүмжлэн саатуулагдсан эм, хэрэгсэл, багаж төхөөрөмжийг тухайн байгууллага, иргэн өөрсдөө хариуцна.

2.11 Захиргааны зөвлөл нь энэхүү журам болон Засгийн газрын 1995 онд батлагдсан нийтлэг журмыг үндэс болгон хураасан эм, эмнэлгийн багаж тоног төхөөрөмж хэрэгслийг зориулалтаар нь ашиглуулахаар эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, үнэлэн улсын орлого болгох, устгах талаар зөвлөлдөн шийдвэрлэх хэрэгжилтэнд хяналт тавьж, бүртгэл тайлан мэдээг тодорхой гаргана.

2.12 Хураагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг захиргааны зөвлөлийн шийдвэргүйгээр борлуулах, бусдад шилжүүлэх, устгахыг хориглоно,

Гурав. Захиргааны журмаар хураагдсан эм, эмнэлгийн хэрэгсэл, хууль бус орлогыг улсын орлого болгох

3.1 Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эмийг борлуулж олсон орлогыг улсын төвлөрсөн төсвийн тусгай данснад оруулна.

3.2 Захиргааны зөрчлийн улмаас хураагдсан эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлийг чанарын баталгаажилт хийгээд эмчилгээ үйлчилгээнд хэрэглэх боломжтой гэж захиргааны зөвлөлөөс үзвэл түүнийг зах зээлийн тухайн үеийн ханшнаас 50 хувь хүртэл доогуур үнэлэн аль нэг эмнэлгийн байгууллагад шилжүүлэн орлогыг улсын орлогын данснад оруулах ба түүнд захиргаанаас хяналт тавина.

3.3 Хураагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг зөвхөн стационарт хэрэглүүлэх бөгөөд гадуур худалдаалахыг хатуу хориглоно

Дөрөв. Захиргааны журмаар хураагдсан эм, эмнэлгийн хэрэгслийг устгах

4.1 Хураагдсан эм, эмнэлгийн хэрэгсэл нь гадаад байдлаараа чанарын шаардлага хангахгүй болсон, чанарын баталгаажилт хийхэд тохирохгүй, хугацаа дууссан, Монгол улсын эмийн практикт урьд өмнө хэрэглэж байгаагүй, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, эм, биобэлдмэл "туршилтын", "худалдан борлуулж болохгүй" гэсэн анхааруулгатай эмүүдийг захиргааны зөвлөл тусгай комисс томилон ашиглах боломжгүйн тухай акт тогтоосны үндсэн дээр шаардлага хангасан газар, байранд устгуулна. Комисс нь эм, эмнэлгийн хэрэгслийг устгасан тухай акт тэмдэглэл үйлдэж зөвлөлд өгнө.

4.2 Хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд шууд хор нөлөө учруулах, түүнчлэн хадгалах, тээвэрлэх боломжгүй, түргэн мууддаг эм, биобэлдмэлийг зөрчлийг илрүүлсэн улсын эхлах байцаагчид зөрчил гаргасан эзтэздийг өөрийг нь, хэрвээ боломжгүй бол хөндлөнгийн хоёр гэрчийг байлцуулан шаардлага хангасан газар, байранд устгаж акт үйлдэн зөрчлийн хэрэгт хавсаргаж, зөвлөлд мэдэгдэнэ.

4.3 Эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг устгасантай холбогдон гарах зардлыг зөрчил гаргасан этгээдээр гаргуулна.

4.4 Шаардлага хангаагүй газар, байранд эм, эмнэлгийн хэрэгслийг устгахыг хориглоно.

Тав. Бусад зүйл

5.1 Энэхүү журмыг зөрчсөн эм, эмнэлгийн хэрэгсэл, бичиг баримт, хууль бус орлогыг хураасан, устгасан, хураагдсаныг борлуулсан, бусдад үндэслэлгүй шилжүүлсэн орлогыг түсгай данснаас өөр дансад оруулсан болон зарцуулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 329612
Төрийн ордон Индекс 14503

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арванхоёрдугаар сарын 3. №53 (132)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Их Хурлын тогтоол

483. Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах тухай журмыг батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай Дугаар 70 951

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

484. Авто замын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 151 954
485. Албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 153 955
486. Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай Дугаар 154 955
487. Гадаадын хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 155 959
488. Дүрэм батлах тухай Дугаар 156 959
489. Тэтгэвэр бодох, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 157 962

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр — **Дугаар 70** — **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах тухай журмыг батлах, зарим зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах тухай журмыг хавсралтын ёсоор батлалсугай.

2.Улсын Их Хурлын гишүүн албан ажлын шугамаар гадаад, дотоодын зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгалын зүйл өгөхөд нэг удаад 15000 хүртэл буюу улиралд 45000 хүртэл төгрөгийг төсөвлөн олгож байхаар тогтоосугай.

3.Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Их Хурал, Монголын Парламентын Булгэмийн албан ёсны айлчлалаар гадаад явахад орон тус бүрт 25000 төгрөг, танилцах аялалаар явахад орон тус бүрт 20000 төгрөгөөр тооцож тус тус бэлэг дурсгалын зүйл олгож байхаар тогтоосугай.

4.Улсын Их Хурлын гишүүний төсвийг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах асуудлыг энэ тогтоолоор батлагдсан журмын дагуу зохион байгуулан хэрэгжүүлэх, зочин төлөөлөгчид болон айлчлалд зориулсан бэлэг дурсгалын зүйлийг үндэсний соёл, урлагийн онцлогийг харуулсан хүндэтгэл ёслолын шинжийг агуулсан байхаар зохицуулж бэлтгэж байхыг Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Энэбиш/-т үүрэг болгосугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах, зарим зардлын хэмжээ тогтоох тухай" Улсын Их Хурлын 1997 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 15 дугаар тогтоолын 1, 3, 5, 6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

7.Энэ тогтоолыг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА — **Р.ГОНЧИГДОРЖ**

Улсын Их Хурлын 1999 оны
70 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ ТӨСӨВТ ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ТООЦОХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой төсөвтэй байна.

2.Улсын Их Хурлын гишүүн /цаашид "гишүүн" гэх/-ий төсөвт зардал нь тухайн гишүүний өөрийн төсөв болон нийтлэг арга хэмжээний зардлын төсөв гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

3.Гишүүний өөрийн төсөв нь дор дурдсан бүрэлдэхүүнтэй байна:

1/гишүүний үндсэн цалин;

2/албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл;

3/гишүүн сонгогдсон тойргоо ажиллах томилолтын зардал;

4/утас, холбооны зардал /албан өрөөний болон зөвшөөрөгдсөн пароль буюу кодоор хот хоорондын ярих/;

5/хотын дотор албаны унаа хэрэглэх зардал;

6/хэвлэл, мэдээлэл, сурталчилгааны холбогдолтой зардлын хөнгөлөлт;

7/гишүүний хувьд зохион байгуулах ёслол, хүндэтгэлийн арга хэмжээ /бэлэг дурсгалын зүйл, хүлээн авалт гэх мэт/-ний зардал;

8/гишүүний орон тооны ажилтны зардал;

9/холбогдох шийдвэрийн дагуу олгох бусад зардал.

4.Гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг арга хэмжээний зардалд дараахь зүйл ангийн зардал орно:

1/гишүүний нийгмийн даатгалын шимтгэл;

2/Улсын Их Хурлын шугамаар орон нутаг /сонгогдсон тойргоос өөр газарт томилолтоор явах/-т ажиллах томилолтын зардал;

3/Улсын Их Хурлын шугамаар зохиогдсон ёслол, хүндэтгэлийн зэрэг нийтлэг арга хэмжээний үнааны зардал;

4/бичиг хэрэг, шуудангийн зардал;

5/эд хогшил, тоног төхөөрөмж, сэлбэг, материал худалдан авах зардал;

6/тээгээвэр, тусламж, шагнал, урамшууллын зориулалттай зарим зардал;

7/гишүүний сонгогдсон тойргот нь ажиллах бие төлөөлөгчийн зардал;

8/Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон судалгаа, мэдээлэл, сурталчилгааны зардал;

9/холбогдох шийдвэрийн дагуу төсөвлөгдсөн бусад зардал.

5.Гишүүн нь төсөвт зардлаа өөрөө мэдэж зарцуулах бөгөөд санхүүгийн холбогдох баримт, тайлан, тооцоог тухай бүр үнэн зөв бүрдүүлж Улсын Их Хурлын Тамгын газрын /цаашид "Тамгын газар" гэх/санхүүд өгч байна.

6.Гишүүний төсвийн гүйцэтгэлийг тэдний бүрдүүлж өгсөн санхүүгийн баримтад тулгуурлан Тамгын газрын санхүү улирал бүр тооцон гаргаж, Төрийн байгуулалтын байнгын хороонд болон гишүүн тус бүрт танилцуулна.

Хоёр. Гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох журам

7.Гишүүний төсөвт зардлын хэмжээг мөрдөж буй жишиг, үнэ тарифыг баримтлан зардлын зүйл, анги тус бүрээр тооцон төлөвлөж Улсын Их Хурлын жил бүрийн төсөвт тусгана.

8.Гишүүний төсөвт зардлыг энэ журмын 3-т заасан зардлын зүйл, анги тус бүрээр дараахь байдлаар тооцон төлөвлөнө:

1/гишүүний үндсэн цалин, нэмэгдлийг мөрдөж буй шийдвэрийн дагуу;

2/гишүүний сонгогдсон тойргоо ажиллах томилолтын зардлыг гишүүн бүр жилд хоёр удаа, нэг удаад 20 хүртэл хоногийн хугацаатай ажиллахаар бодно. Энэхүү зардалд зам хоногийн зардал, тухайн тойргийн байршлын хол, ойроос харгалзан жилдээ дунджаар 6000 хүртэл км явах унааны хөлс, тухайн аймаг, орон нутагт очих, ирэх замын болон амь даатгалын зардлыг тус тус хамааруулна;

3/утас, холбооны зардлыг гишүүн бүрээр албан хэрэгцээний утасны хураамж болон өөрийнх нь эвшээрэгдсэн пароль буюу кодоор сонгогдсон тойрог, хот хооронд ярихад зохих тогтоогдсон лимитэд хэмжээ, тухайн үеийн үнэ, тарифыг үндэслэнэ. Сонгогдсон тойрог руу ярих утасны лимитийг нэг удаад дунджаар 8 минут, сард 4 удаа ярихаар бодож зардлыг төлөвлөнө;

4/гишүүн бүр бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулж хот дотор ажлын өдөрт дунджаар 30 километрээр тооцон жишгийн дагуу дуудлагын суудлын унаа хэрэглэнэ.

Хэрэв гишүүн тухайн сард хотын доторх унааны төсөөг хэмнэлттэй зарцуулсан бол хэмнэгдсэн төсвийг өөрт нь олгоно.

Дуудлагын унаа хэрэглэсэн тухай гүйцэтгэлийн баримтад тулгуурлан зардлын хэтрэлт, хэмнэлтийн тооцоог гаргаж тухайн гишүүнтэй тохиролцсоны дагуу дараа сарын 5-ны дотор багтаан хэмнэлтэд ногдох зардлын асуудлыг шийдвэрлэнэ;

5/гишүүн өөрийн явуулж буй үйл ажиллагааныхаа талаар тойргийн сонгогчид, олон түмэнд мэдээлэх, сурталчлах, зайлшгүй шаардлагатай мэдээлэл цуглуулах, сонирхсон зарим чухал ном, хэвлэлийг захиалан хэрэглэх зэрэгт нь дэмжлэг үзүүлэх зорилгоор улиралд нэг гишүүнд дунджаар 100000 төгрөгийн зардлыг тооцож төсөвлөн олгоно;

6/гишүүний орон тооны ажилтан болон бие төлөөлөгч, туслахын цалин, бусад нэмэгдэл, баталгаат мөрдөж буй шийдвэрийг үндэслэн тооцож төлөвлөнө. Тэдэнд дундаж норм болон өмнөх жилийн төсвийн гүйцэтгэл зэргийг баримтлан бичиг хэрэг, шуудан холбоо, тойроготоо ажиллах томилолтын зардлыг тооцон төлөвлэж олгож болно. Хэрэв гишүүн өөрөө хүсвэл орон тооны ажилтан авч ажиллуулахгүйгээр түүнд зориулан батлагдсан төсвийг судалгаа, сурталчилгаа, мэдээллийн материал бэлтгүүлэх зэрэг өөр зориулалтаар ашиглаж болно. Энэ талаар Тамгын газрын санхүүтэй урьдчилан тохиролцсон байна;

7/гишүүний хувьд зохион байгуулах ёслол, хүндэтгэлийн чанартай зарим арга хэмжээний зардлыг мөрдөж буй жишиг, зардлын норм хэмжээ, урьд онуудын дундаж гүйцэтгэл, холбогдох шийдвэрийн дагуу төлөвлөнө. Уг зардалд гишүүн гадаад, дотоодын төлөөлөгчийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн бэлэг дурсгалын зүйл өгөх, зоог барих зэрэг арга хэмжээтэй холбогдсон зардлыг хамруулан тооцно;

8/энэ журмын 4-т дурдсан нийтлэг арга хэмжээтэй холбогдсон зардлыг мөрдөж буй жишиг, урьд жилүүдийн дундаж гүйцэтгэл, инфляц, үнэ тарифын өөрчлөлт зэргийг харгалзан Тамгын газар төлөвлэж, хэрэгжилтийг зохион байгуулна.

Гурав. Гишүүний төсвийг зарцуулах, тайлагнах журам

9.Тамгын газрын санхүү нь гишүүний төсвийг гишүүн бүрийн нэрээр төсөвлөн, тэдний эвшээрэлтэйгээр зориулалтынх нь дагуу зарцуулж, хэрэгжилтийн явцыг тогтмол гаргаж тайлагнана.

10.Гишүүний төсөвт зардлыг улирал, сараар хуваарилж, тэдний хүсэлтийг үндэслэн зардлыг тухай бүрд нь олгоно. Харин урьд олгогдсон төсөв зардлын гүйцэтгэлийн тайланг Тамгын газрын санхүүтэй хамтран бүрэн гаргасны дараа

дараагийн улирал, сарын төсөвт зардлыг олгоно.

11.Гишүүний орон тооны ажилтны зардлыг Тамгын газраас шууд, харин гишүүний орон нутагт байгаа бие төлөөлөгчийн зардлыг нутаг дэвсгэрийнх нь харьяаллын дагуу холбогдох Засаг даргын Тамгын газраар нь дамжуулан санхүүжүүлж, тайланг нь гаргуулан авч байна.

12.Гишүүн болон бие төлөөлөгч, туслахууд нь өөрийн үйл ажиллагаанд зориулагдсан төсвийн зарцуулалтын тайлан, холбогдох санхүүгийн баримтыг зохих хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, тогтоосон журмын дагуу тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй.

13.Тамгын газрын санхүү гишүүн, бие төлөөлөгчдийн төсвийн зарцуулалтын гүйцэтгэлийг баримт, материалд тулгуурлан гаргаж, түүний хэтрэлт, хэмнэлтийг зардлын зүйл, анги тус бүрээр тооцон өөрсдөө нь мэдээлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

14.Төсөвт зардлаа хэтрүүлэн зарцуулсан нөхцөлд тухайн гишүүнээр илүү зарцуулсан зардлыг бүрэн төлүүлнэ. Улсын Их Хурлын гишүүний төсвийн цалингийн сангаас бусад зүйлийг хооронд нь шилжүүлэн зарцуулж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр **Дугаар 151** **Улаанбаатар хот**

Авто замын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Зам засвар, арчлалтын ажил эрхэлдэг хавсралтад заасан төрийн өмчийн үйлдвэрийн газруудыг нэгтгэн "Авто замын засвар, арчлалтын нэгттэл" /Төрийн өмчит үйлдвэрийн газар/-ийг байгуулсугай.

2. Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Төрийн өмчийн хорооны дарга Д.Зоригт нарт даалгах нь:

а/гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслүүдийн хүрээнд тухайн замын барилга, засвар, арчлалтын ажилд зориулан нийлүүлэгдсэн замын техник, тоног төхөөрөмжийг "Авто замын засвар, арчлалтын нэгттэл"-д шилжүүлэн ажиллуулсугай;

б/энэ оны 11 дүгээр сарын 1-ний дотор Авто замын засвар, арчлалтын нэгттэлийн дүрмийг боловсруулан Засгийн газарт оруулж батлуулсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улаанбаатар-Арвайхээрийн засмал замын барилгын ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1983 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 298 дугаар тогтоол "Зарим улсын үйлдвэрийн газрыг татан буулгах тухай" Засгийн газрын 1997 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 76 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Дэд бүтцийн хөгжлийн сайд **Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 1999 оны 151 дүгээр тогтоолын хавсралт

ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТЫН АЖИЛ ЭРХЭЛДЭГ ТӨРИЙН ӨМЧИЙН КОМПАНИУД

1."Хот орчмын зам засвар, ашиглалт, хангамжийн компани" /ХУГ/;

2.Төв аймгийн "Зам барилга, засвар арчлалтын компани" /ХУГ/;

3.Төв аймгийн Эрдэнэсант дахь "Зам засвар ашиглалт компани" /ХУГ/;

4.Өвөрхангай аймгийн "Зам барилга компани" /ХУГ/;

5.Сэлэнгэ аймаг дахь "Зам засвар арчлалтын компани" /ХУГ/;

6.Баруун чиглэлийн зам барилгын трест;

7.Говь-алтай аймгийн "Зам засвар арчлалтын компани" /ХУГ/;

8.Дорноговь аймгийн "Зам засвар арчлалтын компани" /ХУГ/;

9.Увс аймгийн "Зам засвар арчлалтын компани" /ХУГ/.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Дугаар 153 **Улаанбаатар хот**

Албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож, 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй:

Нийслэлийн дүүргийн Засаг дарга	45085-53434
Сумын Засаг дарга	41745-50094
Хорооны Засаг дарга	33396-40075
Багийн Засаг дарга	28387-35066

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Албан тушаалын цалингийн жишиг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 53 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд бөгөөд Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч **Ч.СОДНОМЦЭРЭН**

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд **С.СОНИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр Дугаар 154 **Улаанбаатар хот**

Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралтын, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралтын, Төрийн тусгай албаны албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралтын, Төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус шинэчлэн батлагдсугай.

2.Төрийн үйлчилгээний албаны албан хаагчдын цалингийн санг 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10 хувиар нэмэгдүүлсүгэй.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 52 дугаар тогтоолын 1, 2 дугаар зүйл, "Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод жишгийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 1998 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 213 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд бөгөөд Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ч.СОДНОМЦЭРЭН

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд **С.СОНИН**

Засгийн газрын 1999 оны 154 дүгээр тогтоолын
1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/ сард төгрөгөөр/

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл												
	ТЗ-1	ТЗ-2	ТЗ-3	ТЗ-4	ТЗ-5	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8	ТЗ-9	ТЗ-10	ТЗ-11	ТЗ-12	ТЗ-13
1	25715	27719	29722	31726	34064	36401	38740	41077	43415	45752	48257	50929	53768
2	26133	28136	30140	32144	34482	36819	39240	41745	44083	46420	49008	51764	54603
3	26550	28637	30557	32561	34899	37236	39741	42413	44750	47089	49760	52599	55438
4	27051	29138	30975	32979	35317	37571	40242	43080	45419	47757	50512	53517	56356
5	27552	29722	31392	33396	35734	38155	40743	43833	46170	48508	51263	54436	57274
6	28136	30140	31893	33897	36235	38656	41328	44584	46922	49259	52098	55438	58276
7	28721	30724	32394	34398	36736	39157	41912	45335	47673	50010	52933	56439	59278
8	29222	31226	32896	34899	37236	39658	42496	46003	48257	50762	53768	57441	60196
9	29722	31726	33396	35400	37738	40242	43080	46671	49008	51597	54687	58359	61115
10	30224	32144	33897	35734	38322	40910	43749	47339	49760	52432	55604	59278	61950
11	30724	32645	34398	36401	38906	41578	44417	48007	50595	53266	56439	60113	62785
12	31142	33145	34982	37070	39491	42580	45085	48675	51429	54101	57274	60948	63620
13	31559	33647	35566	37738	40159	43248	45920	49343	52182	54853	58026	61783	-
14	32061	34147	36235	38405	40827	43833	46754	50010	52933	55604	58777	62618	-
15	32561	34649	36903	38990	41494	44417	47589	50678	53684	56356	59529	-	-
16	32979	35149	37571	39575	42163	45001	48257	51347	54436	57024	60280	-	-
17	33312	35650	38155	40159	42747	45503	48925	51931	55103	57692	-	-	-
18	33647	36152	38740	40743	43331	46003	49594	52515	55771	58359	-	-	-
19	33980	36568	39324	41245	43915	46504	50178	52933	56439	-	-	-	-
20	34231	36986	39824	41745	44417	46922	50678	53517	57108	-	-	-	-
21	-	37403	40242	42163	44917	47339	51180	-	-	-	-	-	-
22	-	37738	40576	42580	45419	47757	51680	-	-	-	-	-	-
23	-	-	40910	42914	45836	48173	-	-	-	-	-	-	-
24	-	-	-	43248	46254	48508	-	-	-	-	-	-	-
25	-	-	-	43749	46671	48842	-	-	-	-	-	-	-

Засгийн газрын 1999 оны 154 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/ сард төгрөгөөр/

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	АА-11	АА-10	АА-9	АА-8	АА-7	АА-6	АА-5	АА-4	АА-3	АА-2	АА-1
1	32227	34064	36401	38740	41077	43415	45752	48257	50929	53601	56273
2	32728	34482	36819	39240	41745	44083	46420	49008	51680	54436	57191
3	33312	34899	37236	39741	42413	44750	47089	49760	52432	55271	58109
4	33980	35317	37571	40242	43080	45419	47757	50512	53183	56106	59000
5	34731	35734	38155	40743	43833	46170	48508	51263	53934	57024	60113
6	35484	36235	38656	41328	44584	46922	49259	52098	54853	57943	61115
7	36152	36736	39157	41912	45335	47673	50010	52933	55688	58944	62117
8	36819	37236	39658	42496	46003	48257	50762	53768	56439	59946	63118
9	37487	37738	40242	43080	46671	49008	51597	54687	57191	60948	64120
10	38155	38322	40910	43749	47339	49760	52432	55604	57943	61950	65122
11	38823	38906	41578	44417	48007	50595	53266	56439	58694	62785	66124
12	39408	39491	42580	45085	48675	51429	54101	57274	59445	63620	-
13	39992	40159	43248	45920	49343	52182	54853	58026	60196	-	-
14	40576	40827	43833	46754	50010	52933	55604	58777	60948	-	-
15	41077	41494	44417	47589	50678	53684	56356	59529	-	-	-
16	41578	42163	45001	48257	51347	54436	57024	60280	-	-	-
17	42079	42747	45503	48925	51931	55103	57692	-	-	-	-
18	42580	43331	46003	49594	52515	55771	58359	-	-	-	-
19	43080	43915	46504	50178	52933	56439	-	-	-	-	-
20	43498	44417	46922	50678	53517	57108	-	-	-	-	-
21	43915	44917	47339	51180	-	-	-	-	-	-	-
22	44250	45419	47757	51680	-	-	-	-	-	-	-
23	-	45836	48173	-	-	-	-	-	-	-	-
24	-	46254	48508	-	-	-	-	-	-	-	-
25	-	46671	48842	-	-	-	-	-	-	-	-

Засгийн газрын 1999 оны 154 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАНЫ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

/ сард төгрөгөөр/

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	23712	25715	27719	29722	31059	31726	32896	34064	36401	37070	37905	38740	41077	43415	45752	48257	50929	53768
2	24379	26382	28554	31559	32896	33396	34565	35734	37738	38573	39408	40242	42747	45252	47589	50261	52766	55771
3	25214	27217	29556	33396	34731	35233	36568	37905	39240	40576	41245	42079	44584	47255	49259	52264	54769	57775
4	26049	27886	30391	35233	36568	36903	38573	39908	40910	42079	43080	43749	46420	49092	50929	54269	56773	59778
5	26717	28721	31392	37070	38405	38740	39908	41745	42246	43582	44750	45419	48257	51096	52599	56273	58777	61783
6	27552	29389	32227	38906	40242	40576	41745	43415	43749	45085	46420	47255	50094	52933	54436	58276	60781	63620
7	28387	30224	33229	40910	42246	42580	43415	45085	45252	46587	48090	48759	51931	54936	56273	60280	62618	-
8	29054	30891	34064	-	-	43749	45085	46671	46754	48090	49426	50261	53517	57108	58359	-	-	-
9	29889	31726	35066	-	-	-	-	-	48173	49426	50595	51680	-	-	-	-	-	-
10	30724	32561	35901	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	31559	33396	36903	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	32394	34231	37738	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Засгийн газрын 1999 оны 154 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

/ сард төгрөгөөр/

Цалингийн жишгийн шатлал /ажилласан жилээр/	Албан тушаалын зэрэглэл													
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12	ТҮ-13	ТҮ-14
1-4	19800	21450	23100	24750	26950	29150	31350	33550	35750	38500	41250	45100	49500	55000
5-8	20900	22550	24200	25850	28127	30426	32626	34826	37026	39776	42636	46398	50600	56100
9-12	22000	23650	25300	26950	29304	31702	33902	36102	38302	41052	44022	47696	51700	57200
13-16	23100	24750	26400	28050	30481	32978	35178	37378	39578	42328	45408	48994	52800	58300
17-20	24200	25850	27500	29150	31658	34254	36454	38654	40854	43604	46794	50292	53900	59400
21-24	25300	26950	28600	30250	32835	35530	37730	39930	42130	44880	48180	51590	55000	60500
25 ба түүнээс дээш	26400	28050	29700	31350	34100	36850	39050	41250	43450	46200	49500	52800	56100	61600

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр **Дугаар 155** **Улаанбаатар хот**

Гадаадын хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх үйлчилгээг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг дахин бүртгэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг дээр 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн зарчмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Гадаад харилцааны сайд Н.Туяад даалгасугай.

2."Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн зарчмаар ажиллах болсонтой холбогдуулан гадаадын хөрөнгө оруулалтын асуудлаар хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл олгодог эрх бүхий албан тушаалтнуудаа Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг дээр байрлуулан ажиллуулахыг холбогдох сайд, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Холбогдох сайд нартай хамтран гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг дахин бүртгэх ажлыг 1999 оны 10 дугаар сарын 1-нээс 12 дугаар сарын 25-ны дотор багтаан зохион байгуулж үр дүнг Засгийн газарт 2000 оны 1 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахыг Гадаад харилцааны сайд Н.Туяад даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Гадаад харилцааны сайд **Н.ТУЯА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 156** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Авто тээврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Авто тээврийн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор батлсугай.

2.Авто тээврийн тухай хууль батлагдсантай холбогдуулан "Хот хоорондын ачаа тээвэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 17 дугаар тогтоол, "Авто тээврийн хэрэгслийн техникийн үзлэг тооллого явуулж байх тухай" Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 153 дугаар тогтоол, "Тээвэрчдийн нийгмийн баталгааг хангах, зам, тээврийн ажлыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1992 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 50 дугаар тогтоол, "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1994 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 183 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын хяналтын дүрмүүд батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 211 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гадаад харилцааны сайд бөгөөд Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч **Н.ТУЯА**

Дэд бүтцийн хөгжлийн сайд **Г.БАТХҮҮ**

Засгийн газрын 1999 оны 156 дугаар тогтоолын хавсралт

АВТО ТЭЭВРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Энэхүү дүрмийн зорилго нь Авто тээврийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, авто тээврийн ажил, үйлчилгээнд /цаашид "ажил үйлчилгээ" гэх/ тавих захиргааны хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

2.Авто тээврийн улсын хяналтыг улсын хэмжээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Дэд бүтцийн улсын хяналтын алба, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх мэргэжлийн хяналтын алба, орон нутгийн тээврийн бодлогын хэрэгжилтийг хянан зохицуулах үүрэг бүхий байгууллага болон авто тээврийн хяналтын талаар мэргэшсэн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ хэрэгжүүлнэ.

3.Дэд бүтцийн улсын хяналтын алба нь авто тээврийн ажил, үйлчилгээнд тавих хяналтыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах бөгөөд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4.Үйл ажиллагааных нь онцлогийг харгалзан төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлагт ажиллах улсын байцаагчийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн тээврийн бодлогын хэрэгжилтийг хянан зохицуулах үүрэг бүхий байгууллагад ажиллах улсын байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг дарга, улсын ерөнхий байцаагчтай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг нь авто тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

5.Авто тээврийн улсын хяналт нь улсын хэмжээнд авто тээврийн талаархи хууль тогтоомж, стандарт, эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмыг мөрдөж буй байдалд Авто тээврийн тухай хуульд заасан чиглэлийн дагуу захиргааны хяналтыг хэрэгжүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, авто тээврийн хэрэгслийн ашиглалтаас шалтгаалан тээвэрлэгч, хэрэглэгчдийн эрх ашгийг хохироосон зөрчлийг илрүүлж түүнийг арилгуулахад чиглэгдэнэ.

6.Авто тээврийн улсын хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, улсын байцаагч нь хяналт шалгалтын үйл ажиллагаандаа захиргааны хяналтын бусад байгууллага болон төрийн бус байгууллагын дэмжлэг туслалцааг авч ажиллана.

Хоёр.Авто тээврийн хяналтын улсын байцаагчийн бүрэн эрх

7.Дэд бүтцийн улсын хяналтын албанд авто тээврийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын албанд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, орон нутгийн тээврийн бодлогын хэрэгжилтийг хянаж зохицуулах үүрэг бүхий байгууллагад улсын байцаагч ажиллана.

8.Улсын байцаагчийг томилох, улсын байцаагчийн эрх олгоход тавигдах шаардлага, баримтлах журмыг авто тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нийтлэг үүргээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/Авто тээврийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан чиглэлээр хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

б/хяналт шалгалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, технологийн нууцыг чанд хамгаалах;

в/авто зам, гүүр болон шатахуун, тосолгооны материалын чанар нь авто тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн аюулгүй байдалд нөлөөлөх

зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад зөрчлийг арилгуулах албан шаардлага өгөх, энэ талаар дээд шатны болон захиргааны хяналтын байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж шалгуулах.

10.Улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 7, 9 дэх заалт, Авто тээврийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ:

а/хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам зөрчсөн, эсхүл илэрсэн зөрчлийг арилгуулах талаар улсын байцаагчийн өгсөн шаардлагыг биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд Автотээврийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу захиргааны хариуцлага ногдуулах;

б/авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа болон автотээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөл авсан байдал, тээвэрлэлтийн баримт бичиг, автотээврийн хэрэгслийг ашиглах болон тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, шалгалт авах, үнэмлэх олгох, техникийн хяналтын үзлэг, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох харилцааг зохицуулсан дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах.

Гурав. Бусад

11.Тээвэрлэлтийн гэрээгээр зохицуулснаас бусад нийтийн тээврийн үйлчилгээтэй холбогдон гаргасан гомдол, маргааныг улсын байцаагч хүлээн авч хянан шийдвэрлэнэ.

12.Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэн нь улсын байцаагч болон захиргааны хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын шийдвэрийг хугацаанд нь биелүүлж хариуг албан ёсоор өгнө. Тээврийн хэрэгслийн жолооч нь улсын байцаагчийн шаардлагаар холбогдох баримт бичгийг шалгуулах үүрэгтэй.

13.Зөрчил гаргасан этгээд өөрт ногдуулсан торгуулийг улсын байцаагчийн шийтгэвэрт заасан хугацаанд төлнө.

14.Шалгуулсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэн нь хяналт шалгалтыг хууль тогтоомж зөрчин хийсэн, эсхүл улсын байцаагчийн шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид буюу дээд шатны улсын байцаагчид гаргана.

Гомдлыг хүлээн авсан байгууллагын эрх баригч буюу улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нь түүнийг авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэнэ.

15.Улсын байцаагч нь хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохих хариуцлага хүлээнэ.

16.Улсын байцаагчийг дүрэмт хувцас, ялгах тэмдэг, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах автомашин, багаж хэрэгслээр хангах үүргийг тухайн улсын байцаагчийг ажиллуулж байгаа байгууллага хүлээнэ.

17.Улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэгний нэр төрөл, загвар, эдэлгээний хугацаа болон хяналт шалгалтын зориулалттай техник, хэрэгслийн жагсаалт болон тэдгээрийг хэрэглэх журмыг автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18.Авто тээврийн хяналт шалгалтын зориулалттай автомашин нь тусгай зориулалт, хийцийн гэрлэн болон дуут дохио, богино долгионы радио станц, чанга яригчаар тоноглогдсон, тээврийн замд явуулын шалгалт хийх боломж, нөхцөлийг хангасан байна.

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 1999 он № 53 (132)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 157 | Улаанбаатар хот

Тэтгэвэр бодох, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын хуулийн дагуу тогтоолгосон тэтгэврийг шинэчлэн бодох болон шинээр тэтгэвэр тогтооход баримтлах "Тэтгэвэр бодох, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүр"-ийг хавсралт ёсоор шинэчлэн батлалсугай.

2.Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд С.Сонинд даалгасугай:

а/тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг баримтлан иргэдийн анх тэтгэвэр тогтоолгосон цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг шинэчлэн тооцох замаар нийт тэтгэвэр авагчдын тэтгэврийг 1999 оны 11 дүгээр сард багтааж шинэчлэн тогтоон 1999 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгох;

б/тухайн тэтгэвэр авагчдын одоогийн авч буй тэтгэврийн хэмжээг бууруулахгүй байх;

в/нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 16000 төгрөгөөр,

хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 10000 төгрөгөөр тус тус тогтоох;

г/шинэ итгэлцүүрийг хэрэглэх журмыг батлан мөрдүүлэх.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үнэ тариф, амьжиргааны өртийн өөрчлөлт, тэтгэвэр бодох цалин, хөдөлмөрийн хөлсний хоорондын зохистой харьцааг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 73 дугаар тогтоол, "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 54 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р. АМАРЖАРГАЛ**

Гадаад харилцааны сайд бөгөөд Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч **Н.ТУЯА**

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайд **С.СОНИН**

Засгийн газрын 1999 оны 157 дугаар тогтоолын хавсралт

ТЭТГЭВЭР БОДОХ, ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГЫГ ТООЦОХОД ХЭРЭГЛЭХ ИТГЭЛЦҮҮР

№	Он	Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүр
1	1990 ба өмнөх онууд	60,0
2	1991	30,0
3	1992	11,0
4	1993	3,3
5	1994	2,5
6	1995	1,6
7	1996	1,4
8	1997	1,2
9	1998	1,1
10	1999	1,0

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<**Төрийн мэдээлэл**>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 Төрийн ордон
☎ 329612
Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арванхоёрдугаар сарын 4 №54 (133)

Гарчиг

Нэг. Монгол Улсын хууль

490. Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай (1999-12-1-ний хууль) 963

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

491. Зарим тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 162 964

492. Дүрэм шинэчлэн батлах тухай Дугаар 164 964

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1999 оны 12 дугаар сарын 1-ний өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН 2000 ОНЫ ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. **Улсын төвлөрсөн төсвийн 2000 оны орлогын нийт дүн, нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:**
/мянган төгрөг/

1.1.ОРЛОГО-БҮГД	**278.068.060.2**
1.1.1.Албан татварын орлого	**203.399.156.8**
1.1.1.а.орлогын албан татвар	29.613.071.6
1.1.1.б.нэмэгдсэн өртгийн албан татвар	74.463.455.1
1.1.1.в.онцгой албан татвар	30.061.720.0
1.1.1.г.автобензин, дизэлийн түлшний албан татвар	4.383.460.0
1.1.1.д.гаалийн албан татвар	19.499.745.5
1.1.1.е.бусад албан татвар	2.606.562.0
1.1.1.ж.нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	42.771.142.7
1.1.2.Татварын бус орлого	**57.752.903.3**
1.1.2.а.хувьцааны ногдол ашиг	10.767.105.5
1.1.2.б.бусад орлого	8.034.440.0
1.1.2.в.түрээсийн орлого	6.673.366.0
1.1.2.г.газрын төсны орлого	500.000.0
1.1.2.д.төсөвт байгууллагын өөрийн орлого	21.777.991.8
1.1.2.е.навигац /онгоолт/-ын орлого	10.000.000.0
1.1.3.Хөрөнгийн орлого	**8.916.000.0**
1.1.3.а.өмч хувьчлалын орлого	8.916.000.0
1.1.4.Гадаад тусламжийн орлого	8.000.000.0

2 дугаар зүйл.**Улсын төвлөрсөн төсвийн 2000 оны зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, нийтийн ерөнхий үйлчилгээний зардал, батлан хамгаалах арга хэмжээний зардал, төвлөрүүлэн захирагчийн санхүүжилт, тэтгэврийн даатгалын сан болон аймгийн төсөвт өгөх татаасын нийт хэмжээг дор дурдсанаар батална:**

2.1. ЗАРЛАГА-БҮГД	**391.588.620.1.**
2.1.1.цалингийн сан	32.887.852.3
2.1.2.хөрөнгө оруулалт	32.253.600.0
Үүнээс:-шинээр эхлэх барилга объектын нийт төсөвт өртөг	10.286.700.0
Үүний дотор: 2000 онд санхүүжүүлэх хэмжээ	8.057.800.0
2.1.3.нийтийн ерөнхий үйлчилгээний зардал	23.442.313.4
2.1.4.батлан хамгаалах арга хэмжээний зардал	25.149.465.7
2.1.5.Улсын Их Хурлын төсөв	1.851.727.6
2.1.6.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн төсөв	35.887.2
2.1.7.Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсөв	99.410.6
2.1.8.Монгол Улсын Ерөнхий сайдын төсөв	92.479.9
2.1.9.Монгол Улсын Үндэсн хуулийн цэцийн төсөв	32.811.5
2.1.10.Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсөв	73.861.3
2.1.11.Улсын дээд шүүхийн төсөв	116.987.1
2.1.12.ерөн нутгийн шүүхийн төсөв	1.356.603.4
2.1.13.прокурорын байгууллагын төсөв	1.099.544.7
2.1.14.Улсын аюулгүй байдлыг хангах газрын төсөв	1.793.944.9
2.1.15.тэтгэврийн даатгалын санд өгөх татаас	14.770.968.0
2.1.16.аймгийн төсөвт өгөх татаас	47.146.610.6

3 дугаар зүйл.**Улсын төвлөрсөн төсвөөс аймгийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар хуваарилан тогтоосугай:**

Архангай	2.686.282.3
Баян-Өлгий	2.759.011.8
Баянхонгор	2.945.540.2
Булган	2.205.783.2
Говь-Алтай	2.932.458.0
Дорноговь	2.023.331.1
Дорнод	2.552.100.0
Дундговь	1.714.371.4
Завхан	2.953.710.4
Өвөрхангай	2.695.785.5
Өмнөговь	2.019.418.4
Сүхбаатар	2.501.944.7
Сэлэнгэ	565.929.9
Төв	1.866.598.7
Увс	3.037.849.6

Ховд	2.967.057.6
Хөвсгөл	3.586.060.4
Хэнтий	2.566.458.3
Дархан-Уул	1.089.493.3
Орхон	856.789.0
Говь-Сүмбэр	620.636.7

4 дүгээр зүйл.Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 162** **Улаанбаатар хот**

Зарим тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Үйлдвэрлэл сэргэх боломжийг хангах зорилгоор дор дурдсан тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай:

1."Мал аж ахуйн зарим бүтээгдэхүүний бэлтгэлийн үнийг нэмэгдүүлэх тухай" Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн 288 дугаар тогтоол.

2."Жижиг үйлдвэр хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 37 дугаар тогтоол.

3."Зөвлөмж, хэлэлцээрийг хэрэгжүүлэх тухай" Засгийн газрын 1994 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 124 дүгээр тогтоол.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд **Ч.СОДНОМЦЭРЭН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 164** **Улаанбаатар хот**

Дүрэм шинэчлэн батлах тухай

Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор батлуулсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1996 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 72 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**

Хууль зүйн сайдын үүрэг гүйцэтгэгч **Л.ЦОГ**

Засгийн газрын 1999 оны 164 дүгээр тогтоолын хавсралт

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын зорилт нь архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, зааврын мөрдөлтөд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулахад оршино.

2.Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтыг улсын хэмжээнд архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч, аймаг, нийслэлийн улсын байцаагч хэрэгжүүлнэ.

3.Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Үндэсний архивын газрын дарга нь улсын ерөнхий байцаагч байна. Улсын ерөнхий байцаагчийг Хууль зүйн сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлөх бөгөөд ерөнхий байцаагчийн эрхийг мөн Засгийн газраас олгоно.

4.Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын ахлах байцаагч, байцаагчийг ерөнхий байцаагчийн санал болгосноор Хууль зүйн асуудал эрхэлсэн сайд томилж, чөлөөлнө.

5.Аймаг, нийслэлд ажиллах архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч нь аймаг, нийслэлийн архивын тасгийн /албаны/ дарга байна.

6.Аймаг, нийслэлийн архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчтай зөвшилцөн Засаг дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг Хууль зүйн сайд олгоно.

7.Эрхэлж буй үйл ажиллагааны онцлог байдлаас шалтгаалан зарим яам, шүүх, прокурор, гадаад харилцаа, батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн төв байгууллагын төрөлжсөн архивт архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч ажиллуулж болно. Улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагчтай зөвшилцөн яам, газрын дарга томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг нь Хууль зүйн сайд олгоно.

8.Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид энэ дүрэмд "байцаагч" гэх/ нь архив, албан хэрэг хөтлөлтийн асуудлаар мэргэшсэн байна.

9.Архив, албан хэрэг хөтлөлтийн байцаагч нь үндсэн мэргэжлээрээ улсад гурваас доошгүй жил ажилласан байна.

10.Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан Засгийн газрын агентлаг, байцаагч нь үйл ажиллагаандаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

11.Байцаагч нь Засгийн газраас загварыг нь батална үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон албан шаардлага, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

12.Аймаг, нийслэлд ажиллаж байгаа архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалган дүнг нэгтгэж дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан Засгийн газрын агентлаг хариуцан хэрэгжүүлнэ.

13.Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч нь тухайн жилийн ажлын тайлангаа жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан Засгийн газрын агентлагт ирүүлэх бөгөөд улсын ерөнхий байцаагч нэгтгэж, дүгнэнэ.

Хоёр. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын чиглэл

14.Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/Архивын тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн талаар Засгийн газраас гарсан шийдвэр, холбогдох бусад эрх зүйн актын биелэлт;

б/баримт бичгийн стандарт, түүний хэрэгжилт;

в/баримт бичгийн шийдвэрлэлтэд тавих хяналт, түүний биелэлтийн байдал;

г/хөтлөх хэргийн нэрийн жагсаалт, түүний дагуу хэрэг бүрдүүлсэн байдал;

д/компьютерт оруулсан баримт бичгийн боловсруулалт, ашиглалт, хадгалалтын байдал;

е/архивын хосгүй үнэт, үнэт баримтын хамгаалалтын хувь хийж, эх баримтаас тусад нь хадгалж буй байдал;

ж/архивт хадгалсан баримт, музей, номын сан, эрдэм шинжилгээний байгууллага дахь гар бичмэл, байгууллагын архивын баримтын хадгалалт болон хамгаалалтын нөхцөл, баримтын бүрэн бүтэн байдал, ашиглалт;

з/архивын баримтын нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалтын үйл ажиллагаа;

и/архивын баримтын тоо бүртгэл, эрдэм шинжилгээний лавлагаа мэдээлэл;

к/татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, хувьчлагдсан төрийн байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар баримтаа төрийн архивт шилжүүлсэн байдал;

л/архивын баримт нь байгалийн гамшиг, гал, усны болон гэнэтийн бусад аюул, гэмт халдлага, устэх үрэгдэж болзошгүй нөхцөллөөс найдвартай хамгаалагдсан эсэх.

ГУРАВ. Улсын байцаагчийн үүрэг, эрх

15.Байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулинд заасан улсын байцаагчийн нийтлэг үүргээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/энэ дүрмийн 14 дүгээр зүйлд заасан чиглэлийн дагуу улсын хяналтыг хэрэгжүүлэх;

б/хууль тогтоомжийг чанд сахих, албан үүрэгээ үнэнчээр гүйцэтгэх, байгууллага, албан тушаалтны хууль ёсны эрх ашиг, нэр төрийг хүндэтгэх;

в/хяналт шалгалтыг бүрэн гүйцэд хийж, тэрхэг буй дүгнэлт, бичсэн акт, албан шаардлага, ногдуулсан торгуулийн мэдэлслэлийн үнэн зөвийг бүрэн хариуцах;

г/хяналт шалгалт хийсэн ажлын тайлангаа энэ дүрмийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд ирүүлж байх;

д/нууцтай харьцах эрх бүхий улсын байцаагч нь улсын нууц хамгаалах талаар тогтоосон журмыг чанд сахин биелүүлж, үүсын нууцыг задруулахгүй байх.

16.Байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулинд заасан улсын байцаагчийн нийтлэг эрхээс гадна дор дурдсан эрх эдлэнэ:

а/байгууллагын удирдлагатай тохиролцон холбогдох албан тушаалтан, мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах;

б/хяналт шалгалт хийх обьектод саадгүй нэвтрэн орох, тухайн хяналт шалгалтын ажилд холбогдолтой мэдээ, судалгаа, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

в/архивын хөмрөгийн баримт хадгалалтын тохиромжгүй нөхцөлд байгаа нь тогтоогдвол зөрчлийг арилгах хүртэл тухайн архивын үйл ажилагаат түр зогсоох;

г/илэрсэн зөрчилд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байвал шалгалтын акт, материалыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

д/нууцын баримт бичгийн заавар, журмын хэрэгжилт, хадгалалт, хамгаалалтын байдлыг улсын ерөнхий байцаагч, эсхүл итгэмжлэгдсэн улсын ахлах байцаагч шалгаж зааварлаж шаардлагатай бол нууцын хамгаалалтыг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэх;

е/тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх талаархи Засгийн газрын шийдвэрийг зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх.

17.Байцаагч нь архив, албан хэрэг хөтлөлтийн талаархи хууль тогтоомж, дүрэм, журам, заавар зөрчсөн болон илэрсэн зөрчлийг арилгуулах талаар өгсөн шаардлагыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд Архивын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Бусад асуудал

18.Байцаагчийн шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан , иргэд хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгөх үүрэгтэй.

19.Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж албан тушаалтан, иргэн байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл дээд тоо уг шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргаж болно. Уг гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно.

20.Хууль тогтоомж зөрчсөн буюу энэ дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байцаагчид зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын харъяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 327806,
320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арванхоёрдугаар сарын 7 №55 (134)

Гарчиг

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

493. Б. Цэрэнбалтавт зэрэг дэв олгох тухай Дугаар 195 957

494. Магсаржавын Санждоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 196 958

495. Рэндэндэвийн Ойдовданзанд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай Дугаар 197 958

496. Шанжийн Доржжамбад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 198 958

497. Сэвжидийн Сэлэнгэд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 199 958

498. Арилдийн Шархүүд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 200 959

499. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 201 972

500. Зарим ахмад дайчныг одонгоор шагнах тухай Дугаар 202 972

501. Элчин сайдыг томилж, чөлөөлөх тухай Дугаар 203 972

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

502. Хөтөлбөр батлах тухай Дугаар 158 973

503. Хуралдааны дэг батлах тухай Дугаар 160 975

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 195** **Улаанбаатар хот**

Б. Цэрэнбалтавт зэрэг дэв олгох тухай

"Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 36 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг баримтлан зарлиг болгох нь:

1. Улсын ерөнхий прокурорын орлогч Бат-Очирын Цэрэнбалтавт "Төрийн хууль цаазын шадар зөвлөх"-ийн зэрэг дэв олгосугай.

2. Энэ зарлигийг 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 196** **Улаанбаатар хот**

Магсаржавын Санждоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Эрдэм шинжилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, монголын дундад ба шинэ үеийн түүхийн зарим зангилаа асуудлыг гүнзгийрүүлэн судалж, Монголын төр ёсны талаар эрдэм судлалын дорвитой бүтээлүүд туурвин улс орондоо түүхийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэх Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, төслийн удирдагч Магсаржавын Санждоржид Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 197** **Улаанбаатар хот**

Рэндэндэвийн Ойдовданзанд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээх тухай

Үндэсний статистикийн байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, статистикийн мэдээлэл, судалгааны ажлын боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг боловсронгуй болгох, бүртгэлийн ажлыг механикжуулан статистикийн албыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Үндэсний статистикийн газрын хүн амын тооллого, судалгааны товчооны мэргэжилтэн Рэндэндэвийн Ойдовданзанд Монгол Улсын гавьяат эдийн засагч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 198** **Улаанбаатар хот**

Шанжийн Доржхадамбад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэнд, анагаах ухааны боловсролын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, сэтгэцийн эмгэг судлалын албыг Монгол улсад төлөвшүүлэн хөгжүүлэх, эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламжийг боловсронгуй болгох, эрүүл мэндийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Сэтгэцийн эмгэг наркологийн төвийн зөвлөх их эмч Шанжийн Доржхадамбад Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 199** **Улаанбаатар хот**

Сэвжидийн Сэлэнгэд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, жүжиг кинонд олон арван өвөрмөц дүр бүтээж, тайз, дэлгэцийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Үндэсний жүжигийн академик театрын харьяа Очин үе" театрын жүжигчин Сэвжидийн Сэлэнгэд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 200** **Улаанбаатар хот**

Арилдийн Шархүүд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Их, дээд сургуульд багш, тэнхмийн эрхлэгчээр он удаан жил үр бүтээлтэй ажиллаж, гадаад хэлний сурах бичиг, толь олноор туурвиж, оюутнуудад гадаад хэлний гүн бат мэдлэг олгох, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн багш Арилдийн Шархүүд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 201** **Улаанбаатар хот**

Зарим хүнийг одон медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

Сүхбаатарын одонгоор:

Намсрайн Содном – Монгол Улсын их сургуулийн Цөмийн физикийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний төслийн удирдагч

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:

1. Жанцандоржийн Амгалан – Шинжлэх ухааны академийн Хими, хими-технологийн хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч

2. Лувсандэндэвийн Баасанжав – Монголын автомашин, мотоциклын спортын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга

3. Раднаагийн Бавуудорж – Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын физик, математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 5 дугаар дунд сургуулийн физикийн багш

4. Даваасамбуугийн Балжаа – Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дэс түшмэл

5. Лхамын Батсүх – Дундговь аймгийн Хөдөө аж ахуйн газрын үржлийн албаны дарга

6. Ширнэнгийн Баттулга – Төв аймгийн Батсүмбэр сумын Засаг дарга

7. Готовын Болдбаатар – Төр, засгийн Үйлчилгээний автобаазын ерөнхий инженер

8. Жанчивдоржийн Даваабал – Ховд аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн нөхөн үржихүй, эрүүл мэндийн хөтөлбөрийн зохицуулагч

9. Дамбын Данзандорж – Улсын Дээд шүүхийн шүүгч

10. Ламзавын Лингов – Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга

11. Доржсамбын Мөнхчулуун - Өмнөговь аймгийн нийгмийн эрүүл мэндийн төвийн сэхээн амьдруулагч их эмч

12. Дамчаагийн Нямдаваа – Техникийн их сургуулийн Дархан-Уул аймаг дахь Эрчим хүчний инженерийн сургуулийн багш

13. Санжаадамбын Сайнцог – Батлан хамгаалахад тусдах нийгэмлэгийн төв зөвлөлийн дарга

14. Даржаагийн Түмэндээ – Увс аймгийн Баруунтуруун сумын "Жинст" ХК-ийн агрономич

15. Эрхэмбаярын Цогт – Нийслэлийн ахмадын хорооны Хот, нийтийн ажилд туслах төвийн захирал

16. Навааншаравын Чулуунжав – Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газрын боловсон хүчний эрхлэгч

"Алтан гадас" одонгоор:

1. Баатарын Аварзэд - Үндэсний статистикийн газрын бизнесийн регистр, хяналтын хэлтсийн дарга

2. Пүрэвийн Алзахгүй – Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны "Сонгино" амралтын үйлчлэгч

3. Данжингийн Аюуш – Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

4. Доржийн Бадарч - Хэнтий аймгийн

Дэлгэрхаан сумын "Аварга тосон" рашаан сувиллын газрын бага эмч

5. Жамбалдоржийн Бадраа – МАХН-ын Сан, хөрөнгө эрхлэх газрын албаны дарга

6. Цэнджавын Бадрах - Үндэсний статистикийн газрын Хүн ам, орон сууцны тооллого, судалгааны газрын ахлах мэргэжилтэн

7. Дондогийн Балжинням – Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дотрын эмч

8. Жигмэдийн Балжинням – Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Хэнтий аймгийн зөвлөлийн дарга

9. Мижидсамбуугийн Батбаяр – Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн өндөр настан

10.Намсангийн Баттогтох – Увс аймгийн Баруунтуруун сумын "Зүүнтуруун" ХК-ийн гүйцэтгэх захирал

11.Хасын Батхуяг – Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын гадна талбайн үйлчлэгч

12.Рэнцэнгийн Буд – Дэд бүтцийн хөгжлийн яамны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын дарга

13.Бадарчийн Буриад – Говь-Алтай аймгийн Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын их эмч

14.Бадамдоржийн Ганбат – Улсын филармонийн уран сайхны удирдаач

15.Шоонуугийн Гомбосүрэн – Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 1 дүгээр багийн Засаг дарга

16.Данзангийн Дандарбаатар – Монголын архитектуруудын эвлэлийн дэд ерөнхийлөгч

17.Доржсүрэнгийн Данзансамбуу – Дундговь аймгийн Говь-Угтаал сумын хүн эмнэлгийн эрхлэгч

18.Лувсанхоролын Дашзэвгэ – Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Дундговь аймгийн зөвлөлийн дарга

19.Бэгзсүрэнгийн Дашцэрэн – Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын сантехникийн инженер

20.Дамдины Долгорсүрэн – Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны "Сонгино" амралтын ахлах тогооч

21.Дондовын Дунхорол – Төв аймгийн Стандартчилал, хэмжил зүйн төвийн захирал

22. Жамсрангийн Жамбалсүрэн – Нийслэлийн Чингэлтэй дүүргийн өндөр настан

23. Норовын Загдаа – Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2 дугаар багийн Засаг дарга

24. Дамбэрэлийн Коля – Дорнод аймгийн Стандартчилал, хэмжил зүйн төвийн улсын байцаагч

25. Магсарын Лантав – Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн түшмэл

26. Очирын Лхагварэнцэн – Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга

27. Нугамарын Мизамхан – Баян-Өлгий аймгийн Холбооны газрын сургалтын техникч

28. Гомбосүрэнгийн Наваантаяа – Нийслэлийн "Болдимпекс" ХХК-ийн захирал

29. Дашийн Нэхийт – Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Дорнод аймгийн зөвлөлийн жолооны багш

30. Үржингийн Нямдорж – Шинжлэх ухааны академийн Философи, социологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

31. Пунцагийн Ориг – Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлаг – Автотээвэрийн газрын дарга

32. Содын Очирбат – Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто замын газрын дарга

33. Батсүхийн Оюунчимэг – Төрийн захирга, удирдлагын хөгжлийн институтийн номын санч

34. Шонхорын Пүрэвсүх – МАХН-ын Төв байрны ерөнхий инженер

35. Дагвадоржийн Рагчаабазар – Архангай аймгийн прокурор

36. Шарын Ринчин – Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын хуралдаан зохион байгуулах хэсгийн ахлагч

37. Шаравдагвын Самдан - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчийн дарга

38. Хорлоогийн Сампилдэндэв – шинжлэх ухаан академийн Хэл шинжлэлийн хүрээлэнгийн захирал

39. Даваажавын Сосорбарам – МАХН-ын Сан, хөрөнгө эрхлэх газрын үйлдвэрлэл үйлчилгээний албаны дарга

40. Натарын Сумъяадорж – Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг дарга

41.Данзангийн Сүхбаатар – Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч

42.Санжидын Сүхээ – Төв аймгийн Баянцогт сумын Засаг дарга

43.Сейтийн Съезд- Нийслэлийн худалдаа үйлдвэрлэл, зуучлалын "Хасбүү" ХК-ийн Москва дахь төлөөлөгч

44.Долгоржавын Төмөрбаатар – Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан түшмэл

45.Самдангийн Төмөр-Өлзий – Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын Төрийн ордны гуанзны ерөнхий тогоочоо

46.Дорлигжавын Уртнасан – Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

47.Доржийн Ханджав- Улсын ерөнхий прокурорын газрын шалган зааварлах хэлтсийн хяналтын прокурор

48.Цэрэнцэгмидийн Хурц - Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын хангалтын инженер

49.Ядамын Цэвэлмаа – Нийслэлийн 40 дүгээр дунд сургуулийн багш

50.Цэгмидийн Цэвээнравдан – Увс аймгийн Хяргас сумын Засаг дарга

51.Жавын Цэдэв – Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн түшмэл

52.Жамсрангийн Цэрэв – Баян-Өлгий аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

53.Цамбын Цэрэн - Төр засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын ахлах нягтлан бодогч

54.Цэдмаагийн Цэрэндорж – Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийн статистикийн тэнхмийн багш

55.Шархүүгийн Цэцгээ – Төв аймгийн хөгжимт драмын театрын дуучин

56.Цэвэлбадамын Чимэдрэгзэн – Монгол Улсын Их Хурлын нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх

57.Нянгарын Чирдэгжав – Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Ховд аймгийн зөвлөлийн жолооны багш

58.Балдангийн Чойжамц – Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг дарга

59.Дампилын Чойжилсүрэн –Улсын нийгмийн халамжийн газрын дэд дарга

60.Жүгдэрийн Шагдарсүрэн – Нийслэлийн Багануур дүүргийн цахилгаан шугам сүлжээний газрын дарга

61.Гомбын Шар – Хэнтий аймгийн холбооны газрын цехийн дарга

62.Янгалагийн Шуурав – Төрийн захиргаа удирдлагын хөгжлийн институтийн хөтөлберийн эрхлэгч

63.Гэнэнгийн Элдэв-Очир – Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургуулийн статистикийн тэнхмийн эрхлэгч

Цэргийн гавьяаны одонгоор:

1. Балганжавын Ичинхорлоо – Нийслэлийн Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсийн хүүхдийн байцаагч, цагдаагийн хошууч

2. Нямжавын Одсүрэн – Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах ажилтан, цагдаагийн дэд хурандаа

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1. Дамбын Алтангэрэл – Төв аймгийн Зуунмод сумын өндөр настан

2. Хишигнямын Бадам – Булган аймгийн стандартчилал, хэмжил зүйн төвийн хэмжил зүйн улсын байцаагч

3. Чулуунбатын Ганхуяг – Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн жолооч

4. Жамбын Гунаасүрэн – Хөвсгөл аймгийн Тариалан сумын дунд сургуулийн монгол хэл – уран зохиолын багш

5. Мэндбаярын Гүрсэд – Төв аймгийн Зуунмод сумын өндөр настан

6. Ийшээгийн Дамиран – Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын орлогч

7. Баясгалангийн Дорлиг - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын аж ахуйн эрхлэгч

8. Пэрэнлэйн Лхагвасүрэн – Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Дорноговь аймгийн зөвлөлийн жолооны багш

9. Сангаагийн Сандагдорж – Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл

10. Цагааны Сувд - Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын нягтлан бодогч

11.Дугарын Төртогтох – Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Техник, спортын төвийн шүхрийн багш

12.Пүрэвийн Увш – Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн боловсролын удирдлагын хөтөлбөрийн эрхлэгч

13.Арвинбуянгийн Уртнасан – Баянхонгор аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн инженер

14.Сэдэдийн Хишигсүрэн – Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын ажилчин

15.Чүлтэмсүрэнгийн Цогбадрах - Үндэсний статистикийн газрын Мэдээлэл боловсруулах, программ хангамжийн газрын ахлах мэргэжилтэн

16.Шагдарсүрэнгийн Цэвэгсүрэн – Сүхбаатар аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

17.Дамчаабадгарын Цэнд – Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн Баянхонгор аймгийн зөвлөлийн жолооны ахлах багш

18. Янживын Цэрэндулам – Баянхо аймгийн Засаг даргын Тамгын газрын төлөвл санхүү, эдийн засгийн бодлогын хэлтсийн түшмэл

19. Самдангийн Цэцэгмаа – Шинжлэх уха академийн Палеонтологийн төвийн хэ Монгол – Японы хамтарсан экспедицийн а тогооч

20. Карпушевагийн Шура – Төрийн захи удирдлагын хөгжлийн институтийн үйлчлэгч

21. Даваасамбуугийн Энхтуяа – Тө захиргаа, удирдлагын хөгжлийн институ сургалтын диспетчер

22. Сэрээтэрийн Энхээ – Дундговь аймг Прокурорын туслах прокурор

23. Рэнцэгийн Эрдэнэбаатар – Тө захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн Б

24. Даваацэрэнгийн Эрдэнэцэцэг – засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх га ажилчин

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр **Дугаар 202** **Улаанба хот**

Зарим ахмад дайчныг одон шагнах тухай

Халх голын байдлаанд биечлэн оролцож, эх орондоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үйл хэрэгт оруулсан гавьяаг нь үнэлж дор дурдсан ахмад дайчдыг одонгоор шагнасугай.

Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор:

1. Дамдинсүрэнгийн Дарам – Увс аймаг

2. Нансалмаагийн Лувсанхайдав – Сэлэнгэ аймаг

Цэргийн гавьяаны одонгоор:

1. Цэвээний Найдан – Дундговь аймаг

2. Маньбазарын Соном – Сэлэнгэ аймаг

3. Ойдовын Наваан – Сэлэнгэ аймаг

4. Машийн Доноров – Увс аймаг

5. Рэгзэнгийн Лувсанцэрэн – Хэнтий ай

6. Даваасүрэнгийн Нямсүрэн – Ба дүүрэг

7. Хорлоогийн Лувсанбалдан - Чинг дүүрэг

8. Бадмаанямбуугийн Цогтбат - Чинг дүүрэг

9. Дашийн Чойжамц - Чингэлтэй дүүрэг

10. Цэрэнгийн Чимэдцэрэн - Чинг дүүрэг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр **Дугаар 203** **Улаанба хот**

Элчин сайдыг томилж, чөлөөлөх

1. Монгол Улсаас Данийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шүхэрийн Алтангэрэлийг тохоон томилсугай.

2. Өөр ажилд шилжсэнтэй холбогдуулан Жагваралын Ганибалыг Данийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин са үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

99 оны 10 дугаар
рын 6-ны өдөр

Дугаар 158

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны төлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол сын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Сэргээгдэх эрчим хүч ашиглан хөдөөг хилгаан эрчим хүчээр хангах "100 000 рны гэр" үндэсний хөтөлбөрийг эсралтын ёсоор батлсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ардагдах хөрөнгийн эх үүсвэрийг олох, нийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Дэд тцийн хөгжлийн сайд Г.Батхүү, Сангийн йд Я.Очирсүх, Гадаад харилцааны сайд Н.Туяа нарт даалгасугай.

3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийн явцыг жил бүрийн 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүүд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Р. АМАРЖАРГАЛ

ДЭД БҮТЦИЙН
ХӨГЖЛИЙН САЙД Г. БАТХҮҮ

Засгийн газрын 1999 оны 158 дугаар тогтоолын хавсралт

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ АШИГЛАН ХӨДӨӨГ ЦАХИЛГААНААР ХАНГАХ "100 000 НАРНЫ ГЭР" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий зүйл

XXI зуунд хүн төрөлхтөн байгалийн цэвэр чим хүчний шинэ сэргээгдэх эх үүсгүүр лох нар, салхи, ус, биомасс, гүний халуун ы эрчим хүчийг өргөн ашиглах "ЭРЧИМ ЧНИЙ ШИНЭ ХУВЬСГАЛ"-ын замд кмаар орж байна.

Дэлхийн хүн ам өсөхийн хирээр эрчим нний хэрэглээ жил бүр эрс нэмэгдэж байна. амжлалт аргаар эрчим хүчийг их жээгээр үйлдвэрлэснээс дэлхийн агаар ндал бохирдон, хүрээлэн байгаа орчин, уурт сөрөг нөлөө үзүүлэхэд хүрээд йгаа тедийгүй хүн төрөлхтөний үлэмж эг эрчим хүчээр хангагдаж чадаагүй ээр байна. Улс орон бүр эрчим хүчний жлийн бодлогоо төлөвлөхдөө эрчим хүч двэрлэх уламжлалт арга технологийг ам боловсронгуй болгохын хамт шинжлэх ваны тэргүүний ололт, амжилт болон повсронгуй арга, технологийг энэ тэргүүнд иглах, ялангуяа нар, салхи, ус, далайн ах түлхэх хүч зэрэг байгаль орчинд сөрөг өөө багатай эрчим хүчний цэвэр эх гүүрийг өргөн ашиглахыг зорьж байна. ний үр дүнд орчин үед сэргээгдэх эрчим ийг ашиглан цахилгаан эрчим хүчийг асар хэмжээгээр гарган авах технологи двэрлэлд өргөн нэвтэрч уламжлалт арга хнологитой өрсөлдөж эхэллээ.

Одоогийн байдлаар сэргээгдэх эрчим хүчийг ашиглах судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлэх талаар авч явуулсан арга хэмжээний үр дүнд нар, салхи, усны эрчим хүчийг өргөн ашиглах туршилт үйлдвэрлэлийн бааз манай улсад бүрдээд байна.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлага, үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт "Малчид зарим сум, суурин газрыг сэргээгдэх эрчим хүчээр хангах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ" гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын 1994 оны 198 дугаар тогтоолд "Усан цахилгаан станц байгуулах, нар салхиар ажилладаг жижиг оврын цахилгаан үүсгүүрээр хөдөөг хангахад зарцуулах хөрөнгийн гадаад, дотоод эх үүсвэрийг жил бүрийн тесөв, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх" зорилт тавьсан болно.

Монгол орон сэргээгдэх эрчим хүч, ялангуяа нарны эрчим хүчийг ашиглах арвин их нөөцтэй бөгөөд ижил өргөрөгт орших бусад орноос нарны цацрагийн хэмжээгээрээ харьцангуй их /жилд дунджаар 1400 кВт.ц/м^2/ байдаг бөгөөд жилийн аль ч улиралд нарны эрчим хүчийг ашиглахад нэн тохиромжтой юм.

Манай орны говь, хээрийн бүс бүхэлдээ салхины эрчим хүчний нөөц ихтэй район бөгөөд түүний нөөц нь 836, 8 тэрбум кВт.цаг байхын зэрэгцээ ашиглаж болох хугацаа нь жилдээ 3,5-4,6 мян.цаг байна.

Мөн түүнчлэн манай улсын гол, горхины олон жилийн дундаж урсац 34600 тэрбум $м^3$ (1098 $м^3$/с), эрчим хүчний нөөц 6200М Вт бөгөөд боловсруулах эрчим хүчний хэмжээ 56 тэрбум кВт.цаг-аар үнэлэгддэг.

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь хөдөөгийн нийт айл өрхийг 2000-2010 онд нарны цахилгаан үүсгүүрээр хангах, малчин айл өрх, сум, багийн төв, сургууль, эмнэлэг, аялал жуулчлалын бааз, соёл, ахуй үйлчилгээний байгууллага, хилийн сумангийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах зориулалт бүхий нар-салхи-усан цахилгаан станц хосолсон сэргээгдэх эрчим хүчний системийг дизель станцтай хослуулан ашиглах боломж бүхий цогцолборуудыг байгуулахад оршино.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээ

"100 000 нарны гэр" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх талаар Засгийн газар дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

а/ шаардагдах хөрөнгийг гадаадын урт хугацааны, хөнгөлөлттэй зээл, тусламжаас санхүүжүүлэх;

б/ сэргээгдэх эрчим хүчийг ашиглах судалгаа, шинжилгээ, зохион бүтээх ажил, туршилт үйлдвэрлэлийн арга хэмжээнд зориулж жил бүрийн улсын төсөвт зохих хэмжээний хөрөнгийг тусгаж байх;

в/ хөдөөгийн айл өрх, малчдаас цахилгаан үүсгүүрийн үнийн 50 хувийг шууд төлүүлж, үлдсэн 50 хувийг уг үүсгүүрийг хэрэглэгчидэд санхүүгийн түрээсээр өгч, 2-3 жилийн дотор төлүүлэх журам батлан мөрдүүлэх;

г/ цахилгаан үүсгүүр худалдан авахад зориулан малчдад хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн төлбөрийн механизмыг бүрдүүлэх зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хийх ажлууд

а/ хөдөөгийн айл өрхийн соёл, ахуйн нөхцөлийг сайжруулах зорилгоор гэрэлтүүлэг, радио, төлевизор, компьютер, холбооны хэрэгсэл ажиллуулахад шаардагдах цахилгааны хэрэгцээг хангах системийг үйлдвэрлэж тэдгээрийг өргөн ашиглах нөхцлийг бүрдүүлнэ;

б/ сэргээгдэх эх үүсгүүрийг ашиглах судалгаа, шинжилгээ, зохион бүтээх ажлыг эрчимжүүлэх, тэдгээрийг ашиглах тоног төхөөрөмж үйлдвэрлэх, өндөр технологи шилжүүлэн авах ажлыг зохион байгуулна;

в/ сум, багийн төв, сургууль, эмнэлэг, хөдөөгийн соёл, ахуй үйлчилгээний байгууллагууд, хилийн сумангийн цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах туршилтын цогцолборуудыг байгуулна;

г/ хүн, малыг усаар хангах, малын үс ноос хяргах, сүү цагаан идээ, арьс шир боловсруулах, хадлан тариалангийн талбайг усжуулах тоног төхөөрөмжийг цахилгаанаар хангахад зориулсан сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрүүдийг байгуулна.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

Хөдөөг эрчим хүчээр хангахад сэргээгдэх эрчим хүчний шинэ эх үүсгүүрүүдийг үр дүнтэй өргөн ашиглах Засгийн газрын бодлогыг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд хөдөөгийн иргэдийн ахуй нөхцөл дээшлэн, жижиг үйлдвэрлэл хөгжин, дэд бүтэц сайжирч, ажлын байр шинээр бий болно:

а/ 2000-2010 онд манай улсын нийт малчин айл өрх, бусад хэрэглэгчдийг жижиг оврын цахилгаан үүсгүүрээр хангана;

б/ хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр радио сонсох, төлевизор үзэх, компьютер, холбооны хэрэгсэл ашиглах боломжоор хангагдаж, үүний үр дүнд:

- төр засгийн бодлого, хууль тогтоомжийг олон түмэнд сурталчлах боломж бүй болж, цаг үеийн асуудалтай холбогдсон мэдээллийн хангамж үйлчилгээ сайжирна;

- танин мэдэхүй, соёл боловсрол, зах зээл, бизнесийн мэдээлэл хүлээн авах, дамжуулах, цуглуулах, боловсруулах боломж бүрдэж эдгээрийг дагалдан орон нутагт нийгмийн харилцаа улам боловсронгуй болох таатай нөхцөл бий болж хот, хөдөөгийн холбоо сайжран, хөдөөд хүн ам тогтвор суурьшилтай амьдарч ажиллах, жижиг үйлдвэрлэл хөгжих нөхцөл бүрдэн, ажлын байр шинээр бий болж, улмаар экспортын бүтээгдхүүний хэмжээ нэмэгдэх болно;

- бүх нийтийг хамарсан алсын сургалт ("Нээлттэй их сургууль", сургууль завсардсан болон эчнээ сурах, хүүхэд залуучуудад зориулсан төрөл бүрийн сургалт зэрэг) явуулах нөхцөл бүрдэнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үе шат

Хэрэгжих үе шат	I - УЕ 2000 он	П - УЕ 2001 – 2005 он	Ш - УЕ 2005 - 2010 он
Зорилт	"100000 нарны гэр" Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 5000 айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах	-Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүү-рийн үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлж, 2000–2005 онд нийт 50000 айл өрхийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрээр хангах -Эрчим хүчний төвлөрсөн системээс алслагдсан хэрэглэгчийг хангах нар-салхи-ус-дизель хосолсон цогцолборыг байгуулах	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүү-рээр манай орны нийт хөдөөгийн айл өрхийг хангаж сум, багийн төв, аялал жуулчлалын бааз, суурин газ-ryг цахилгаан-жуулах ажлыг өр-гөжүүлэх
Цахилгаан үүсгүүрийн тоо, чадал	5 000 ширхэг, 0.25 Мегаватт	45 000 ширхэг, 2.25 Мегаватт	50 000 ширхэг, 2.5 Мегаватт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 160** **Улаанбаатар хот**

Хуралдааны дэг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын хуралдааны дэгийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хуралдааны дэг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 28 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАРГАЛ**

ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **Л.ЦОГ**

Засгийн газрын 1999 оны 160 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ДЭГ

Засгийн газрын шийдвэрээр хэрэгжих аливаа арга хэмжээ нь Үндсэн хууль, Монголын Улсын үндэсний ашиг сонирхол, улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнолд хохирол учруулахгүй байхад бүхий гаригдэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ талаар авах нэмэлт арга хэмжээг Ерөнхий сайд хариуцан хэрэжүүлнэ.

Нэг. Ерөнхий зүйл

1. Монгол Улсын Засгийн газрын хуралдаан /цаашид "хуралдаан" гэнэ/-ыг хийхэд Монгол Улсын Засгийн газрын тухай хууль болон энэхүү дэгийг баримтална.

2. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6-д заасны дагуу хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлигт нийцсэн, гүйцэд боловсргосон, зохих тооцоо, холбогдох Засгийн газрын гишүүний санал /виз/-аар нотлогдсон бөгөөд хувилж олшруулах болон архивын нэгж болгон хадгалах шаардлагын дагуу материал нь бэлтгэгдсэн асуудлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүлээн авч хянан Хэрэг эрхлэх газрын дарга Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулж, түүний зөвшөөрснөөр хуралдаанаар хэлэлцүх асуудлын төлөвлөгөөнд оруулж, дараалал тогтооно.

3. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг санаачилсан Засгийн газрын гишүүн буюу аймаг, нийслэлийн Засаг дарга боловсруулсан тухайн асуудлын төсөл санал авахаар холбогдох байгууллагуудад өөрийн гарын үсэгтэй албан бичиг явуулна.

Төслийг хүлээн авсан өдрээс хойш ажлын 5 өдрөт багтаан санал өгөх бөгөөд түүнд зөвхөн Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга гарын үсэг зурсан байна. Энэ хугацаанд санал ирүүлээгүй бол зарчмын өөр саналгүйд тооцно.

Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэр нь тухайн яамны салбар, бодлогын хүрээнд онцын хамааралгүй бол Сангийн болон Хууль зүйн яамнаас бусад яамдаас санал авахгүй байж болно.

Асуудлыг санаачилсан Засгийн газрын гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нар шаардлагатай гэж үзвэл Ерөнхий сайдаас санал авна.

Засгийн газрын гишүүн орон нутагт ажилласан чиглэлийн дагуу авах арга хэмжээний талаар Засгийн газрын шийдвэр гаргах бол холбогдох яамдаас санал авсан байна.

4. Тогтоосон хугацаанд зохих жүрмын дагуу саналаа ирүүлээгүй бол энэ тухай Хэрэг эрхлэх газрын дарга хуралдаанд мэдээлнэ.

5. Холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналын боломжтой гэж үзсэнийг нь төсөлд тусган боловсруулж ирүүлэх бөгөөд хэрэв саналыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн, эсвэл зарим яамдаас санал аваагүй бол энэ тухай үндэслэлээ танилцуулгад тодорхой тусгасан байна.

Санал авах буюу өгөхөд Засгийн газрын гишүүний эзгүйд түүний үүргийг албан ёсоор хавсран гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн гарын үсэг зурна.

6. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудалд Ерөнхийлөгчөөс, бичгээр ирүүлсэн саналыг хуралдаан даргалагчаас танилцуулж, шийдвэрт хэрэхэн тусгагдсан талаар уг асуудлыг хэлэлцсэнээс хойш ажлын 7 өдрөт багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар холбогдох газарт эргэх мэдээлнэ.

Хуралдаанаар хэлэлцүүлэхээр боловсруулсан асуудлаар холбогдох төрийн бус байгууллагын санал авах буюу хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт гаргуулж болно

7. Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн, зохих тооцоо судалгаанд тулгуурлан үндэслэл сайтар боловсруулж холбогдох материалын хамт тухайн асуудлыг хэлэлцэх өдрөөс ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг яамны Төрийн нарийн бичгийн дарга хариуцна.

Хууль, Гэрээ, конвенцийн төсөл 10 хуудаснаас дээш бол материалыг яам өөрөө олшруулж, техникийн нөхцөлийг хангасан тохиолдолд сүлжээгээр буюу дискээр ирүүлнэ.

8. Хэрэг эрхлэх газар нь яамнаас ирүүлсэн асуудлыг хянахдаа түүний тооцоо, судалгааны үндэслэл, тухайн асуудлаар урьд гарсан шийдвэр болон үүнтэй холбоотой төсөл нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж үзнэ. Хэрэв боловсруулалт нь шаардлага хангаагүй буюу хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй гэж үзвэл тодорхой үндэслэл, тайлбарыг гарган Засгийн газрын холбогдох гишүүнд мэдэгдэнэ. Үндэсн дээр материалыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрөт багтаан Хэрэг эрхлэх газрын дарга дээд дарга нар албан ёсоор буцаажболно.

9. Яамны Төрийн нарийн бичгийн дарга тухайн сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг өмнөх сарын сүүлчийн долоо хоногт багтаан Хэрэг эрхлэх газарт ирүүлнэ. Яамнаас ирүүлсэн саналыг Танхимын үйл ажилласан дэмжих газар нэгтгэн биелэлтэд нь хяналт тавина.

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм, гишүүдийн оролцсон байдал, дэгийн хэрэгжилтийн судалгааг Танхимын үйл ажиллагаа

эмжих газар улирал тутам нэгтгэж Хэрэг эрхлэх азрын удирдлага болон танхимд танилцуулна.

10. Хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг Хэрэг эрхлэх газарт хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл нэмэлт, өөрчлөлт оруулах тухайн өрчлөлтийг, уг асуудлыг оруулсан Засгийн газрын гишүүн, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулж охирсны дараа хуралдааныг оруулна.

11. Засгийн газрын хуралдаанд эрхлэх үрээнийхээ асуудлыг Засгийн газрын гишүүн өөрөө ариуцан оруулж байна.

12. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн санаачлан боловсруулж, Засгийн азраас санал авахаар ирүүлсэн хууль, тогтоомжийн эсэлд өгөх Засгийн газрын саналыг тухайн суудлыг эрхэлсэн сайд, бусад байгууллагын аналыг авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар элэлцүүлнэ.

Засгийн газраас санаачлах хуулийн төслийг уль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн цэслэн хянаж хуралдаанд оруулна.

13. Хуулийн төслийг хэлэлцэхдээ уг уулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн азраас гарах шийдвэрийн төсөл, хэрэв хууль, асгийн газрын тогтоолоор яам, агентлагт дүрэм, урам гаргах эрх олгож байгаа бол тэдгээрийн эслийг Засгийн газрын хуралдаанд хамт оруулж айна.

Яам, агентлагаас батлах дүрэм, журмын өсөлд Засгийн газрын гишүүн санал өгөхгүй олговч хууль, Засгийн газрын шийдвэрийн төсөлд анал өгөхдөө тэдгээрийг харьцуулж үзнэ.

14. Төсвийн нэмэгдэл эх үүсвэр аардагдах асуудалд Сангийн сайдын саналыг авал авсан байх бөгөөд ямар эх үүсвэрээс ргахыг төсөлд тодорхой тусгана.

15. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд аардагдах хөрөнгийн эх үүсвэр нь тодорхойгүй үю эх үүсвэргүй хуулийн төслийг Улсын Их Хуралд өгөн мэдүүлэхгүй байна.

Хоёр. Хуралдааныг бэлтгэх

16. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын элөвлөгөө, материалыг Засгийн газрын гишүүдэд уг суудлыг хэлэлцэхээс ажлын 3-аас доошгүй оногийн өмнө танилцуулахаар гардуулна.

Засгийн газрын гишүүд хуралдаанаар элэлцэх асуудлын материалтай бүрэн танилцаж аналаа бэлтгэж ирнэ.

17. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх суудлын материалыг урьдчилан хүргүүлэх албан ушаалтны жагсаалтыг холбогдох хууль тогтоомжийг ндэслэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга эталж мөрдүүлнэ.

18. Хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газарт ирүүлсэн асуудлын материалыг ямнаас хүлээж авахдаа дараахь бүрдүүлэлтийг шалгаж үзнэ. Үүнд:

а/ хуулийн төсөл болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд Хууль зүйн сайдаас санал авсан эсэх;

б/ төсөв хөрөнгийн холбогдолтой асуудалд Сангийн сайдын санал авсан эсэх;

в/ бусад нийтлэг асуудалд Сангийн яам, Хууль зүйн яам болон холбогдох ямдын саналыг авсан байдал.

19. Хуралдаанд оруулан хэлэлцүүлэх асуудал /төсөл, танилцуулга/-ыг референт харъяалах газрын дарга өгсөн чиглэлийн дагуу хянан боловсруулж бэлэн болгоод долоо хоногийн 1-4 дэх өдрүүдэд Хэрэг эрхлэх газрын дэд дарга болон хуулийн эвлэхэд танилцуулж хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах эвшээрэл авна.

20. Хуралдаанд танилцуулах мэдээлэл, сонсгол нь /Засгийн газрын үйл ажиллагааны хэтөлбөр, төсөв, гэрээ, хэлэлцээрээс бусад/ 35 мөрөөр бичсэн 8 хуудаснаас, холбогдох танилцуулга 4 хуудаснаас илүүгүй байна.

21. Танхимын үйл ажиллагаар дэмжих газар нь дэд дарга, хуулийн эвлэхийн урьдчилан хянасан хуралдаанд оруулах материалыг хүлээн аваад хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гарган Хэрэг эрхлэх газрын даргад танилцуулна. Төлөвлөгөө гаргахдаа олон хүн оролцох шаардлагатай буюу боловсон хүчин, улсын төсөв, Үндэсэн чиглэл зэрэг асуудлыг эхний ээлжинд оруулж, Засгийн газрын нэг гишүүний эрхэлсэн асуудлыг хэлэлцүүлэх дуусгаад дараагийн гишүүний эрхэлсэн асуудлыг хэлэлцүүлэх зарчмыг баримтална.

22. Хэрэг эрхлэх газрын дарга төлөвлөгөө болон материалыг судалж Ерөнхий сайдад танилцуулж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дараллыг тохиролцон, баасан гаригийн 11 цагт багтаан олшруулж тараалгахаар Танхимын үйл ажиллагаар дэмжих газарт өгнө.

23. Танхимын үйл ажиллагаар дэмжих газар хуралдаанд оруулах асуудлуудын материалыг олшруулах ажлыг шуурхай зохион байгуулж долоо хоног бүрийн баасан гаригийн 15.00 цагт багтаан битүүмжилж, Засгийн газрын гишүүд болон холбогдох байгууллагад хуралдааны материалыг хүргэх бөгөөд сайдад өөрт нь эсвэл туслахад нь хүлээлгэн өгч цагаа бичүүлэн гарын үсэг зуруулна.

24. Нууц материалыг олшруулах ажлыг нууц хариуцсан ажилтан гүйцэтгэнэ.

25. Засгийн газрын хуралдаанд тогтмол суух хүний нэр, албан тушаалыг Хэрэг эрхлэх газрын дарга холбогдох хууль тогтоомжийг үндэслэн тогтооно.

26. Хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхэд Хэрэг эрхлэх газраас тухайн асуудлыг хариуцсан

референт оролцох бөгөөд уг асуудалд яамнаас орох ажилтан нь газар, хэлтсийн дарга буюу түүнээс дээш албан тушаалтай байна.

Хэлэлцэж байгаа асуудлын талаар зохих байгууллага нэгэнт зөвшөөрсөн санал албан ёсоор өгсөн байвал холбогдох хүмүүсийг хуралдааны оролцуулахгүй байж болно.

27. Хуралдаанаар асуудал хэлэлцэхэд яамнаас оролцох албан тушаалтныг тухайн асуудлыг хариуцсан референт Танхимын үйл ажиллагаагаа дэмжих газарт хуралдааны өмнөх өдөр мэдэгдэнэ.

Танхимын үйл ажиллагаагаа дэмжих газар хуралдаанд гаднаас орох хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хоёр хүнь үйлдэн төрийн ордны хамгаалалтын албаны ээлжийн ахлагчид өгч нэвтрэх хаалгануудад тавиулна.

28. Хуралдааны зохион байгуулалт, техникийн бэлтгэл, байрны нөхцөлийг Танхимын үйл ажиллагаагаа дэмжих газар эрхлэн гүйцэтгэнэ.

Гурав. Хуралдаан хийх

29. Ээлжит хуралдааныг долоо хоног бүрийн лхагва гаригийн 9.00 цагаас эхлэн явуулна.

Ээлжит бус хуралдааныг Ерөнхий сайдын товлосноор буюу Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал болгосноор зарлан хуралдуулна.

30. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хуралдааныг нээлттэй буюу хаалттай явуулахыг Ерөнхий сайд шийдвэрлэнэ. Хаалттай хуралдаанд зөвхөн Засгийн газрын гишүүд, Хэрэг эрхлэх газрын дарга оролцож нууцын ажилтан тэмдэглэл хөтөлнө.

31. Шаардлагатай гэж үзвэл агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, холбогдох бусад хүмүүсийг зөвлөх эрхтэйгээр оролцуулан хуралдааныг өргөтгөсөн хэлбэрээр хийж болно.

32. Ээлжит бус /энэ дэгийн 16 дугаар зүйл үл хамаарна/ болон өргөтгөсөн хуралдааныг хийхдээ энэхүү дэгийг баримтална.

33. Хуралдааныг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т зааснаар Засгийн газрын гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцох бөгөөд хуралдааныг Засгийн газрын гишүүд таслах /батлах/ эрхтэй оролцоно.

34. Хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан болон жилийн төлөвлөгөөнд тусгагдсан буюу шаардлагатай бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

35. Хуралдааныг Монгол Улсын Ерөнхий сайд даргална. Ерөнхий сайдын эзгүйд хуралдааныг түүний үүргийг хавсран гүйцэтгэх байгаа Засгийн газрын гишүүн даргална.

36. Хуралдаанаар асуудал хэлэлцүүлэхдээ түүнийг санаачлан оруулсан Засгийн газрын гишүүн буюу аймаг, нийслэлийн Засаг даргыг байлцуулна.

Шаардлагатай гэж үзвэл холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн дарыг хуралдаанд урьж оролцуулж болно.

Засгийн газрын гишүүний эзгүйд асуудал хэлэлцэх шаардлага гарвал түүний үүргийг албан ёсоор хавсран гүйцэтгэж байгаа Засгийн газрын гишүүн уг асуудлыг хариуцан хэлэлцүүлж, ямны Төрийн нарийн бичгийн дарыг нь хуралдаанд зөвлөх /санал гаргах, тайлбар өгөх/ эрхтэйгээр оролцуулна.

Танхимын үйл ажиллагаагаа дэмжих газар хуралдаанд оролцох хүмүүсийг, асуудлыг хэлэлцэхээс 15 минутын өмнө дуудан ирүүлж, нэрсийн жагсаалтын дагуу хяналт тавин хуралдааны танхимд оруулна.

37. Хуралдааныг дор дурдсан журмыг баримтална:

а/ хуралдаан даргалагчаас хуралдааныг нээж тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг Засгийн газрын гишүүд зөвшөөрч байгаа эсэхийг хуралдааны эхэнд лавласны үндэсэн дээр хэлэлцэх асуудлыг тодотгож, төлөвлөгөөнд орсон дараалалын дагуу нэг асуудлыг хэлэлцэж дуусаад дараагийн асуудлыг хэлэлцэнэ;

б/ төлөвлөгөөнд ороогүй боловч хуралдаанаар зайлшгүй нэн яаралтай хэлэлцэх шийдвэрлэх шаардлагатай асуудал гарвал хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр хэлэлцэх хэргийн төлөвлөгөөнд нэмэн оруулж болно;

в/ хэлэлцэх асуудлын танилцуулгыг тухайн асуудлыг оруулж байгаа Засгийн газрын гишүүн буюу түүний эзгүйд үүрэг гүйцэтгэгч гишүүн хийнэ;

г/ хэлэлцэж буй асуудалд холбогдох зураг, видео бичлэг,биет зүйлс, түүний загвар, хэсгийг хуралдаан дээр үзүүлж болно;

д/ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариултыг дуусгасны дараа хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр санал гаргах бөгөөд тэгэхдээ нэг асуудлын талаар гурваас илүүгүй удаа санал гаргана. Нэг удаа санал гаргах үг хэлэх хугацаа тухай бүр 5 минутаас хэтрэхгүй байна. Шаардлагатай гэж үзвэл хэлэлцэж байгаа асуудлаар Хэрэг эрхлэх газрын дарга, дэд дарга, Хэрэг эрхлэх газрын дотоорхи газрын дарга нар тайлбар өгч болно;

е/ асуултыг зөвхөн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд тавих бөгөөд асуулт, хариулт, санал нь хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой, товч тодорхой байна;

ж/ Засгийн газрын гишүүд Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, хуралдааны дэгийг чанд сахин, хэлэлцэж байгаа асуудалд ахаваралтай хандаж, асуух лавлах, санал гаргах үг хэлэхдээ хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна.

з/ хуралдааны үед гар утсаар ярих, хуралдаан даргалагчийн зөвшөөрөлгүйгээр 5 минутаас дээш хугацаагаар тур гарахыг хориглоно;

и/ хуралдаанд асуудал оруулж буй хүмүүс асуултанд хариулахдаа босч өөрийгөө танилцуулж, үг хэлэх бол хуралдаан даргалагчид хандаж зөвшөөрөл авна;

к/ Засгийн газрын гишүүн чөлөө авч хуралдааныг гарсан нөхцөлд үлдэж хуралдах гишүүдийн тоо Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан нөхцөлийг хангасан байвал зохино.Энэ нөхцөлийг хангаагүй тохиолдолд хуралдааныг зогсоно;

л/ хуралдаан даргалагчаас хэлэлцэх асуудал дууссныг мэдэгдэж хуралдааныг хаана;

м/ Засгийн газрын нээлттэй хуралдааны ажиллагаат сурвалжлах хүмүүсийг хуралдааны танхимд оруулах зөвшөөрлийг Хэрэг эрхлэх газрын дарга олгоно.

38. Хамгаалалтын ажилтан хуралдааны танхимд орох хүмүүсийн тур нэвтрэх зөвшөөрлийн бичгийг нэрсийн жагсаалттай тулган шалгаж оруулна.

39. Хуралдааныг 2 цаг тутамд завсарлагатай хийх бөгөөд завсарлагын хугацаог хуралдаан даргалагч тухай бүр тогтооно.

Дөрөв. Шийдвэр гаргах

40. Хуралдаан даргалагч хэлэлцэж байгаа асуудлын талаар гарсан саналыг нэгтгэн дүгнэж, тэдгээрээс юуг нь хүлээж авах, юуг нь хэрэгсэхгүй тухай хэлэлцүүлж шийдвэрийн төслийг үншиж сонсгоно.

Санал зөрүүтэй асуудлыг шийдвэрлүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл санал хураалтыг ил явуулна.

Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг шийдвэр гарган батлах, шаардлагагүй гэж буцаах, хугацаа тогтоон дахин боловсруулахаар хойшлуулах гэсэн гурван хэлбэрээр шийдвэрлэнэ.

Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, батлаж гаргасан шийдвэрт хуралдаанаас хойш зарчмын өөрчлөлт хийхийг хориглоно.

Хуралдааны шийдвэрийн томъёоллыг тухайн асуудлыг оруулж байгаа референт хийж, хууль зүйн техникийн хувьд хуулийн зөвлөхөөр хянуулна.

41. Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай буюу шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана.

42. Засгийн газар нь хуулиар болон Улсын Их Хурлаас тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн түүнийг иш үндэс болгон бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргана. Энэ эрхийн акт нь тогтоол хэлбэртэй байна.

43. Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар шийдвэрлэх асуудлыг Ерөнхий сайд уг асуудлыг эрхэлсэн сайдтай санал тохиролцсон нөхцөлд шийдвэр гаргана.

Иймэ шийдвэр гаргасан тухай Хэрэг эрхлэх газрын дарга Засгийн газрын гишүүдэд мэдээлнэ.

44. Хуралдаанд оролцож амжаагүй Засгийн газрын гишүүдэд хуралдаанаас гаргасан шийдвэрийг Хэрэг эрхлэх газар нөхөн танилцуулж байна.

45. Хуулийн төсөл, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бусад асуудал, олон улсын гэрээ, нийтлэг хэм хэмжээ тогтоосон болон хууль тогтоомжид тусгайлан заасан асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

46. Дэгийн 43 дугаар зүйлд зааснаас бусад асуудлаар Ерөнхий сайд олонхиос өөр саналтай боловч тухайн асуудлаар гарах шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд /гишүүн/-тай нэг саналтай бол уг асуудлаар шийдвэр гаргаж болно. Иймхүү шийдвэр гарсан бол энэ тухай Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд санал зөрсөн бусад гишүүн Улсын Их Хуралд мэдэгдэх эрхтэй. Харин Ерөнхий сайд болон шийдвэрийн биелэлтийг хариуцсан гишүүний аль нэг нь олонхитой нэг саналтай, нөгөө нь өөр саналтай байвал уг асуудлыг дахин боловсруулж хэлэлцэнэ.

Тав. Хуралдааны явцыг баримтжуулах, тэдгээрийг ашиглах, хадгалах

47. Тухайн асуудлыг хариуцсан референт хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаар гарах тогтоол, захирамжийг хуралдаан болсноос хойш хоёр өдөрт багтаан эцэслэн боловсруулна. Хуралдаанаас зөвхөн зарчмын хувьд дэмжиж засвар өөрчлөлт оруулах, дахин хянан боловсруулах болсон шийдвэрийн төслийг ажлын 5 өдөрт багтаан эцэслэн боловсруулж гарын үсэг зуруулна.

48. Тухайн асуудлыг хариуцсан референт хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаар гарах тогтоол, захирамжийн төслийг Хэрэг эрхлэх газрын даргаар нотлуулахын өмнө хуулийн зөвлөхөөр хянуулж гарын үсэг зуруулсан байна.

49. Хуралдаанаар хэлэлцсэн шийдвэрийн төслийг тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан Засгийн газрын гишүүн хянан үзэж ёсчлон гаргах зөвшөөрөл өгнө.

50. Засгийн газрын тогтоолд түүний биелэлтийг хариуцсан сайд, дараа нь Ерөнхий сайд гарын үсэг зурна.

Засгийн газрын шийдвэрт Ерөнхий сайд гарын үсэг зурахын өмнө тухайн шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нотолж гарын үсэг зурна.

Монгол Улсын Ерөнхий сайдын эзгүйд түүний үүргийг хавсран гүйцэтгэх тухайн хуралдааныг даргалсан Засгийн газрын гишүүн тогтоолын эх хувь дээр Ерөнхий сайдын нэрийн өмнөөс түүнийг төлөөлөн гарын үсэг зурж ёсчлон

гаргана. Шийдвэрт гарын үсэг зуруулж ёсчлон гаргуулах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, түүний эзгүйд Хэрэг эрхлэх газрын дэд дарга хариуцан гүйцэтгэнэ.

51. Хуралдаанаар хэлэлцэх Улсын Их Хурлаа өргөн мэдүүлэхээр тогтсон асуудлыг тухайн асуудал хариуцсан референт ажлын 7 өдөрт багтаан бэлэн болгож Хэрэг эрхлэх газрын даргад танилцуулан Улсын Их Хурлаа өргөн мэдүүлэх албан бичигт Монгол Улсын Ерөнхий сайдын гарын үсгийг зуруулна.

52. Танхимын үйл ажиллагаат дэмжих газар нь тогтоол, захирамжийг гарын үсэг зурагдсанаас хойш ажлын нэг өдөрт багтаан олшруулан бэлтгэж Төрийн ордон дахь байгууллага, албан тушалтанд 2 цагийн дотор хүргүүлнэ.

Яам, агентлаг, бусад байгууллага, аймаг, нийслэлд явуулах шийдвэрийг 3 цагийн дотор дуртуйлж, Төрийн тусгай холбооны газрын Төрийн ордон дахь салбарт тус тус шилжүүлж байна.

53. Хуралдааны явц, хуралдаан дээр хэмүүсийн хэлсэн үг, гаргасан саналыг Танхимын үйл ажиллагаат дэмжих газрын холбогдох ажилтан соронзон хальсанд бичиж авна.

Шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвшөөрснөөр хуралдааны явцын талаар дурс бичлэг хийж болно.

54. Засгийн газрын хаалттай хуралдааны тэмдэглэлийг нууц хариуцсан ажилтан хөтөлж, холбогдох байгууллагаас тусгайлан зөвшөөрөл авсан техникийн ажилтан соронзон бичлэг хийнэ.

55. Хуралдааны явцын тэмдэглэл нь хураангуй болон дэлгэрэнгүй гэж хоёр хэлбэртэй байх бөгөөд хураангуй тэмдэглэл /протокол/-д хэлэлцсэн асуудлын нэр, түүнийг танилцуулсан хүний албан тушаал, нэр, уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай болон холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргад үүрэг даалгавар өгсөн бүүр зөвшөөрөл олгосон тухай заах тусгасан байна.

56. Хуралдааны явцын хураангуй болон дэлгэрэнгүй тэмдэглэлд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гарын үсэг зурж албажуулна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эзгүйд түүний нэрийн өмнөөс тус газрын дэд дарга төлөөлөн гарын үсэг зурж болно.

57. Хуралдааны явцын хураангуй тэмдэглэлд дор дурдсан баримт бичгийг хавсаргана:

а/ тухайн өдрийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт;

б/ Засгийн газрын гишүүдийн ирцийн байдал /тоо, хувь, хурлаас хоцорсон болон хуралд оролцоогүй гишүүний нэр, шалтгаан/ болон хуралдаанд оролцсон бусад хэмүүсийн албан тушаал, нэрийг бичсэн бүртгэл;

в/ хуралдаанаас гаргасан шийдвэрийн нэр хувийг хуралдаанд анх оруулсан хууль, бусад шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, дүгнэлт, санал, холбогдох бусад баримт бичиг, тооцоо, судалгааны хамт хэлэлцсэн дараалаар нь дугаа хавсаргана.

58. Хуралдааны хураангуй тэмдэгл төслийг Танхимын үйл ажиллагаат дэмжих г ажилтан 2 өдөрт багтаан бичиж, референт хянуулж гарын үсэг зуруулна.

59. Хуралдааны хураангуй тэмдэгл Танхимын үйл ажиллагаат дэмжих газрын эцэслэн хянаж Хэрэг эрхлэх газрын даргаар гарь зуруулан албажуулна.

60. Танхимын үйл ажиллагаат дэмжих хуралдааны хураангуй тэмдэглэлийн шаардл хэсгийг холбогдох яам, агентлаг болон нийслэлийн Засаг даргын Тамгын газрт асуудлыг хэлэлцсэн хуралдаан болсноос хойш а өдөрт багтаан шуудангаар илгээнэ.

61. Хуралдааны явцын дэлгэ тэмдэглэлд хуралдаан эхэлсэн, завсарласан, д хугацаа /он, сар, өдөр, цаг минут/-г заавал тусган

62. Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэгл бичих ажлыг тухайн хуралдаанд соронзон хийсэн Танхимын үйл ажиллагаат дэмжих г ажилтан ажлын 14 өдөрт багтаан дуусгаж, Хэрэг гарын даргад буюу дэд даргаар гарын үсэг зуруул

63. Засгийн газрын тогтоол, хурал тэмдэглэлээс шаардлагатай заалтуудыг эхналт шийдвэрийн биелэлтэд мониторингийн хяналт ажлыг Танхимын үйл ажиллагаат дэмжих хариуцан хийнэ.

64. Хуралдааны явцын хураангуй дэлгэрэнгүй тэмдэглэл, ёсчлон гарын үсэг зур тогтоол, захирамжийн эх хувийг Хэрэг эрхлэх Танхимын үйл ажиллагаат дэмжих газрын дарга бүр нууц хариуцан ажилтанд хүлээлгэн өгнө. хариуцсан ажилтан зохих журмын дагуу архивы болгон хадгална.

65. Засгийн газрын тогтоол, Ерөнхий захирамжийг Монгол Улсын Засгийн газрын хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу мэдээлнэ.

66. Хуралдаанд Ерөнхий сайдын мэдээллэл хариуцсан албаны дарга эсвэл а тогтмол оролцож, хуралдаанаар хэлэлцсэн ас гарсан шийдвэрийн талаар хэвлэл, мэдэ суртачлах ажлыг хариуцан зохион байгуулна.

Засгийн газрын хуралдаан болохоос хэлэлцэх асуудал, шийдвэрийн төслийн талаар мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг хориглоно.

Шаардлагатай гэж үзвэл Ерөнхий Засгийн газрын гишүүд болон Хэрэг эрхлэх газрын даргатай хуралдааны даваа хэлэлцсэн асуудал, шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн төлөөл мэдээллэл хийж болно.

67. Засгийн газрын хаалттай хурал хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу мэдээлж байна.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн эрхлэх

Улаанбаатар-12 329612
Төрийн ордон Индекс 14503

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арванхоёрдугаар сарын 15 №56 (135)

Гарчиг

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

204. Зарим шүүгчийг томилох тухай Дугаар 204 981

205. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 205 982

206. Өргөмжит консул И. Г. Брюммелхөөсийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 206 982

207. И. Х. Боуманыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 207 982

208. Сандуйн Пүрэвхүүг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 208 982

209. Данзангийн Ганболдыг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 209 982

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

210. Гаалийн тарифын хэмжээг бууруулах тухай Дугаар 165 983

211. Зарим отряд, салбарыг өргөтгөх, байгуулах, санхүүжүүлэх тухай Дугаар 169 983

212. Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 170 984

213. ХБНГУ-ын Засгийн газраас Монгнол Улсын Засгийн газарт олгосон зээлийн талаар авах арга хэмжээний тухай Дугаар 172 984

214. Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай Дугаар 174 985

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

оны 12 дугаар ын 02-ны өдөр Дугаар 204 Улаанбаатар хот

Зарим шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин гээр зүйлийн 2, "Шүүхийн тухай ийн"-ийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх ийг баримтлан, Шүүхийн ерөнхий өлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох

оржийн Тайванхүү Булган аймгийн ийн шүүгч, ерөнхий шүүгчийн, нгийн Бямбацэрэнг Ховд аймгийн хийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Гэндэндоржийн Болормаа Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Самдангийн Цэрэндоржийг Баян-Өлгий аймгийн шүүхийн шүүгчийн, Марууширн Хүрэлбаатарыг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай

МОНГОЛ УЛСЫН

ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 12 дугаар сарын 02-ны өдөр **Дугаар 205** **Улаанба хот**

Зарим хүмүүсийг шүүгчийн тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Доржийн Тайванхүүг Ховд аймгийн шүүхийн шүүгчийн, Ёндонгийн Бямбацэрэнг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Гэндэндоржийн Болормаагг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Самдангийн Цэрэндоржийг Баян-Өлгий дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Мару Хүрэлбаатарыг Говь-Алтай аймаг дахь дундын шүүхийн шүүгчийн албан тушаала тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 12 дугаар сарын 03-ны өдөр **Дугаар 206** **Улаанб хот**

Өргөмжит консул И. Г. Брюммелхө "Найрамдал" медалиар шагнах тух

Монгол Улс, Нидерландын Вант Улсын найрсаг харилцааг хөгжүүлэх, соёл, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааг өргөтгөх, манай улсыг сурталчлахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нидерландын Вант Улс дахь Монгол Улсын Өргөмжит Иоханес Герхардус Брюммелх "Найрамдал" медалиар шагнасугай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 12 дугаар сарын 03-ны өдөр **Дугаар 207** **Улаанб хот**

И. Х. Боуманыг "Найрам медалиар шагнах тухай

Монгол адууны өвөг-тахийг эх газарт нь нутагшуулах ажлыг зохион байгуулах, монгол орны байгаль орчныг хамгаалах үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нидерландын Вант Улсын иргэн Инге Хейндийк Бо "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 12 дугаар сарын 03-ны өдөр **Дугаар 208** **Улаанб хо**

Сандуйн Пүрэвхүүг "Шу журам" медалиар шагнах тух

Эр зориг авхаалж самбаа гарган галын аюулаас хүүхдүүдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Ховд аймгийн Жаргалант сумын Алагтолгой багийн иргэн Сандуйн Пүрэвхүүг "Шударга журам" ме шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1999 оны 12 дугаар сарын 03-ны өдөр **Дугаар 209** **Улаанб хо**

Данзангийн Ганболдыг "Ш журам" медалиар шагнах тух

Эр зориг авхаалж самбаа гарган үерийн уснаас хүүхдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 4 дүгээр багийн иргэн Данзангийн Ганболдыг "Шударга журам" ме шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

оны 10 дугаар ын 13-ны өдөр | Дугаар 165 | Улаанбаатар хот

Гаалийн тарифын хэмжээг бууруулах тухай

Энэ оны ургацын байдал, ирэх оны гурилын эмж, хүрэлцээг харгалзан Гаалийн тарифын й хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, заасныг үндэслэн Гаалийн тарифын элийн саналын дагуу Монгол Улсын Засгийн ас ТОГТООХ нь:

1.Хилийн Цагаannуур, Даян, Ярант, астай, Боршоо, Арц суурь боомтоор ртлох гурилын гаалийн албан татварыг 1999 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2000 оны 4 р сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд тэг ("0") байхаар өөрчилсүгэй.

2.Ирэх оны тариалалтад зориулан импортлох үрийн улаан буудайн гаалийн албан татварыг 1999 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 2000 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд 50.0 хувиар хөнгөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД Я.ОЧИРСҮХ

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД Ч.СОДНОМЦЭРЭН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

оны 10 дугаар ын 20-ны өдөр | Дугаар 169 | Улаанбаатар хот

Зарим отряд, салбарыг өргөтгөх, байгуулах, санхүүжүүлэх тухай

Цэргийн шинэчлэлийн бодлого, Засгийн ын үйл ажиллагааны хөтөлбөрт үүлсэн иргэний хамгаалалтын талаархи тыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын йн газраас ТОГТООХ нь:

1.Архангай, Дорнод аймгийн байгалийн игтай тэмцэх салбарыг Аврах отряд ын өргөтгөх, Ховд аймагт Аврах отряд, Төв т Аврах салбар байгуулах, эдгээр отряд, арыг техник хэрэгсэл, боловсон хүчин, ажлийн аврагчдаар хангах арга хэмжээ ыг Батлан хамгаалахын сайд, Улсын тын онцгой комиссын дарга вдэндоржид даалгасугай.

2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан к отряд, салбарын зардлыг Архангай, Дорнод, Ховд, Төв аймгийн төсвөөс, эдгээр отряд, салбарыг өөр аймагт үүргийн дагуу шилжүүлэн ажиллуулсны зардлыг тухайн аймгийн төсвөөс тус тус санхүүжүүлж байхаар тогтоосугай.

3.Иргэний хамгаалалтын мэргэжлийн аврагч бэлтгэх, сургах болон аврах отряд, салбарыг шаардлагатай багаж, техник хэрэгслээр хангах чиглэлээр гадаад орон, олон улсын холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллахыг Гадаад харилцааны сайд Н.Туяад үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ш.ТҮВДЭНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 170** **Улаанб х**

Мал аж ахуйн өвөлжилтий бэлтгэлийг хангах талаар а зарим арга хэмжээний тух

Баруун болон говийн бүсийн аймгуудад зуншлага оройтож гантай буюу гандуу байсан,зарим аймагт намрын дунд сард ихэхэн цас орсон, ус цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас гаргасан урьдчилсан мэдээгээр ирэх өвөл, хавар цагийн байдал хүндрэлтэй байх төлөвтэй байгаа зэргийг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Зуншлага оройтож, гантай буюу гандуу байсан говийн болон баруун бүсийн зарим аймгийн мал сүргийг байгалийн эрсдэл, гамшгаас хамгаалах зорилгоор Дундговь, Говьсүмбэр, Завхан, Баянхонгор аймаг дахь улсын нөөцийг 3400 тонн өвс, 240 тонн тэжээлээр нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэнд даалгасугай.

2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан цэгүүдээс авч хэрэглэ-сэн өвс,тэжээлийн үнийг 2000 оны 9 дүгээр сард багтаан Улсын нөөцийн газартай тооцоо хийж дуусгахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт, эдгээр өвс, тэжээлийг борлуулснаас орсон орлогыг цаашид малын тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр ашиглан[illegible]э хэмжээ авахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэнд ту даалгасугай.

3.Дээр дурдсан цэгүүдэд нэмж нө өвс,тэжээлийн үнэ, зардал,түүнчлэн і байдалтай газар дээр нь танилцах,шу удирдлагаар хангах,зохицуулах Улсын ба онцгой комиссын ажлын хэсгийн онгоцны за зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс (гурван зуун) сая төгрөг гаргахыг Сангийн Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

4.Тогтоолын хэрэгжилт болон орон дахь мал өвөлжилтийн явцын тухай 1999 с дугаар сард багтаан Засгийн танилцуулахыг Хөдөө аж ахуй, үйлдвэрий Ч.Содномцэрэн, Засгийн газрын Хэрэг газрын дарга Н.Батбаяр нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖ**

САНГИЙН САЙД **Я.ОЧ**

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД **Ч. СОДНОМЦ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 10 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 172** **Улаанб х**

ХБНГУ-ын Засгийн газраас Монго Улсын Засгийн газарт олгосон зээ таалаар авах арга хэмжээний тухай

ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгосон 10,0 сая доллар маркийн зээлийн төлөтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хөрөнгө оруулалт, технологи шинэчлэлтийн банк төлберийн чадваргүй болсноос 1993 онд ХБНГУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор олгосон 10,0 сая дойч маркийн зээлийн орлогыг төсөвт төвлөрүүлэх бололцоогүй болсон учир уг зээлийг, эх үүсвэрийн хамт 1999 оны 10 дугаар сард багтаан Банкны өр барагдуулах шилжүүлсүгэй.

2.Зээлийг шилжүүлэх ажлыг яаралтай байгуулж, төлөтийг эрчимжүүлэх арга авч ажиллахыг Сангийн сайд Я.Очи даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖ**

САНГИЙН САЙД **Я.ОЧ**

оны 10 дугаар
ын 27-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар
хот

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хэтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны ажиллагааны стратеги, зохион байгуулалтын йн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг 1 дүгээр алтын өсөөр зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны н байгуулалтын бүтцийг дор дурдсанаар өн батална:

а/Стратегийн удирдлага, төлөвлөлтийн

-хүний хөгжлийн хэлтэс;
-удирдлага, эдийн засгийн хэлтэс.

б/Төрийн захиргааны удирдлагын газар:
-төрийн захиргаа, хүний нөөцийн с;
-гадаад харилцаа, ёслолын с;
-үйлчилгээ, аж ахуйн хэлтэс.

в/Салбарын бодлого, зохицуулалтын

-эрүүл мэндийн хэлтэс;
-хөдөлмөр, нийгмийн хамгаллын хэлтэс.

г/Мэдээлэл, мониторингийн газар:
-мониторингийн хэлтэс;
-мэдээллийн хэлтэс.

3.Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан яамны орон тоог 2 дугаар хавсралтын ёсоор өөрчлөн батална.

4."Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 164 дүгээр тогтоол, "Яамдын орон тоо, цалингийн сан батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамтай холбоотой 6 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД С.СОНИН

Засгийн газрын 1999 оны 174 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1.Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны жиллагааны стратеги, зохион байгуулалтын йн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид лбөр" гэх)-т Эрүүл мэнд, нийгмийн аллын сайдын болон Засгийн газрын мын шийдвэрийг боловсруулан гаргах, күүлэхэд чиглэгдсэн стратегийн төлөвлөлт, гын удирдамж, төрийн захиргааны лага, зохицуулалтаар хангах, бодлогын жилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) ур дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан т мэнд, нийгмийн хамгаллын яамны үйл лагааны стратегийн болон бүтцийн загварыг хойлов.

1.2.Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 тослийн хүрээнд боловсруулсан "Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөл загвар" тослийн тайланг үндэслэн боловсруулав.

1.3.Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль;
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль;
- Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль;
- Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хууль;
- Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль;
- Бусад холбогдох хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5.Чиглэлийн яамны харицуцлагын өрөнхий хуваарь


Чиглэлийн яамдын нэг болох Эрүүл нийгмийн хамгааллын яам нь Засгийн газр ажиллагааны стратегийг хэрэжүүлэх үүрэг харицуцлага хүлээж, Эрүүл мэнд, ни хамгааллын сайд, Засгийн газрын танхи талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын я салбарын бодлого, төлөвлөлтийн болон бо төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан холбоог хангах асуудалд Засгийн газар, өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зо удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ. З газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх бүхий чиглэлийн яамдын нэг болох Эрүүл нийгмийн хамгаалллын яам нь Засгийн эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын зөв үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6.Стратегийн удирдлага, байгуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын стратегийн удирдлага, зохицуу хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодор нь тус яамны үйл ажиллагааны стр үндэслэл сайтай тогтоохоод чухал холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсв дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамра

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалллын яамны Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын ны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь л мэнд, нийгмийн хамгааллын сайд, ийн газрын танхим байна.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын ны стратегийн удирдлага, зохицуулалт дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, гуяа үндсэн үйлчлүүлэгч буюу глэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай огдон үүсэх олон төрлийн нарийн тэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын ны стратегийн удирдлага зохицуулалтын гцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, эрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр оон тус яамны зохион байгуулалтын ийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, йн албан хаагчдын ажлын байр /албан ал/-ны тодорхойлотод нарийвчлан ж хэрэгжүүлнэ.

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги

2.1.Үйл ажиллагааны стратегийн чанар

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын ны үйл ажиллагааны стратегийн мөн р нь Засгийн газрын үйл ажиллагааны үүлэх чиглэл, Засгийн газрын үйл лагааны хөтөлбөр, Эрүүл мэнд, мийн хамгааллын сайдын эрхлэх длын хүрээний зорилт, чиг үүргийг гжүүлэхэд чиглэсэн Эрүүл мэнд, мийн хамгааллын сайдын үйл лагаанд өндөр мэргэжлийн, цаг үеэ н, шуурхай зөвлөлгөө, бүх талын клэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх эл

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1.Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд Засгийн газрын танхимд үзүүлэх зөвлөлгөө үйлчилгээ, дэмжлэгийн үр дүнг сайжруулах;

2.Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын удирдлагын чадавхийг нэмэгдүүлж бүтэц үйл ажиллагааг өөрчлөн боловсронгуй болгох;

3.Улсын болон хувийн хэвшлийн зохистой харьцаа тогтоож, хувийн хэвшлийг бүх талаар дэмжин хөгжүүлэх;

4.Иргэдийг эрүүл мэндээ хамгаалах, бэзжүүлэх, хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах арга зүйд сургах, нийгмийн эмзэг хэсгийг хамгаалах.

2.3.Үйл ажиллагааны эрхэм зорилго

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын хүн ам эрүүл өсч хөгжих, бүтээлчээр хөдөлмөрлөх, сайн сайхан амьдрах, нийгмийн хамгаалал халамжийн зохистой нөхцөл бүрдүүлэх

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

3.Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо,санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчим баримтлав:

1.Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

2.Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохүйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3.Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, тухайн яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь яамны үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

4.Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хэ доод нэгжээ хүртэл аль болох цөөн (илүүгүй) шат дамжлагатай байх);

5.Тэнцвэрийг хангах, хяналтын х тогтоох зарчим (тухайн яамны үйл ажиллаг стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцв хангах замаар аль болох хялбар удирдах, з боломжтой байх, үйл ажиллагааны страт зорилтыг аль болохоор оновчтой бүл замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогт байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн х болон бусад нөөцийг зөв хуваар хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлч үзүүлэх, үүрэг хариуцлагыг жигд хуваар боломжийг бүрдүүлсэн байх);


6.Улс төрийн хувьд төвийг сахисан зарчим (тухайн яамны төрийн захиргааны а хаагч нь тухайн сайд, Засгийн газар (тэ бусад үйлчлүүлэгч буюу улс төрийн аль нөлөөлөлд автахгүй төвийг сахисан е мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг үйлч үзүүлж байх);

7.Ханглаттай чадавхи, бодитой ажиллагааны зарчим (бүтцийн ерөнхий з зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа дүүргэн илүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц б ажиллах чадвартай байх).

3.2.Үйл ажиллагааны бүтцийн ерө тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Эрүүл нийгмийн хамгааллын яамны үйл ажил (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэ яамны үйл ажиллагааны бүтцийн дор дур ерөнхий тогтолцооны загварыг санал б байна:

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын
ны үйл ажиллагаа /бизнес/-ны
атегийн болон бүтцийн ерөнхий
олцооны загвараас тус яамны дор
дсан зохион байгуулалтын бүтцийн
урган гарч байна:

1.Стратегийн удирдлага, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны
тегийн 1 дүгээр зорилтын хүрээнд
л мэнд, нийгмийн хамгааллын
ын эрхлэх асуудлын хүрээний
ого, төлөвлөгөө, хөтөлбөр
всруулах үндсэн үүргийг хүлээж, хүн
н бодлого, эрүүл мэнд, хөдөлмөр,
мийн хамгааллын урт, дунд, богино
цааны стратегийн төлөвлөгөө,
ногын удирдамжаар хангах, хөтөлбөр,
л боловсруулах, гадаад хамтын
лагааг хөгжүүлэхэд мэргэжлийн
өлгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх
г үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь
л мэнд, нийгмийн хамгааллын сайд,
ийн газрын танхимын үйл
лагааны үр нөлөө, үр ашгийг
лүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газрын танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газар /танхим/ байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээний хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

2.Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд энэ нэгж нь төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж ямагт үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэжсэн албаны хүчээр ямагт тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдад болон ямагт аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвш үнэлж дүгнэх, ажиллах нөх нийгмийн баталгааг хангах зам хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзү үйлчилгээний үндсэн хэрэглэгч Эрүүл мэнд, нийгмийн хамгаал сайд, ямагт Төрийн нарийн бич дарга, зохион байгуулалтын бүт нэгжүүд, төрийн захиргааны а хаагчид байх бөгөөд шууд хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэ Засгийн газрын тохируулагч б хэрэгжүүлэгч агентлаг, т байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бусад хэрэглэгч байна.

Үйлчилгээг үзүүлэхэд оро гол түнш нь Хууль зүйн яам, Зас газрын Хэрэг эрхлэх газар, болов сургалт, эрдэм шинжилгээний б гадаад орон, олон улсын байгуул байна.

3.Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлс зохион байгуулалтын бүтци нэгж, түүний үндсэн үүрэг, ч үүрэг

Үйл ажиллагааны стратегийн 3 аар зорилтын хүрээнд энэ нэгж нь үл мэнд, хөдөлмөр, нийгмийн гааллын бодлого, төлөвлөгөө, элбэр, төслийн хэрэгжилтийг ицуулах үндсэн үүргийг хүлээж, гмийн болон мэргэжлийн, тэрчлэн амж, асрамж, үйлчилгээний арга жээг зохицуулах зэрэг үндсэн чиг гийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь лого, төсвийн тэнцвэрт байдал, илцан уялдаа, холбоог хангахад гийн газар, Эрүүл мэнд, нийгмийн гааллын сайдын бодлого, двэрийн хэрэгжилт, гадаад илцаа, хамтын ажиллагааг ицуулах, зохион байгуулан эгжүүлэхэд чиглэнэ.

Энэ нь төсөв, санхүүгийн болон ад нөөцийг оновчтой хуваарилах аар бодлого хэрэгжүүлэхэд пцож байгаа бүх байгууллагатай шийн харилцаа тогтоож, тэдний ажиллагааг бодлого, төлөвлөгөө, элбэрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн ион байгуулах, зохицуулах замаар эгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газрууд, аж ахуйн нэгж, ард иргэд болон бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Засгийн газрын түүнчлэн олон улсын болон төрийн бус зарим байгууллага байна.

4.Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, норм, норматив, стандартын хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээ, сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд энэ үйлчилгээг шууд бус хэлбэрээр хэрэглэгч нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд болон бусад хэрэглэгч байна

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

Засгийн газрын 1999 оны 174 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ОРОН ТОО

Яамдын нэр	Нийт орон тоо	Улс төрийн	Төрийн захиргааны								Төрийн үйлчилгээний					
			Үүнээс								Үүнээс					
			ТЗ-13	ТЗ-12	ТЗ-11	ТЗ-10	ТЗ-9	ТЗ-8	ТЗ-7	ТЗ-6	ТҮ-6	ТҮ-5	ТҮ-4	ТҮ-3	ТҮ-2	ТҮ-1
6 Эрүүл мэнд, нийгмийн хамгаа…																

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 329612
Төрийн ордон Индекс 14503

Улсын Их Хурлын Тамгын газр…
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот *1999 оны арванхоёрдугаар сарын 20* *№57 (136)*

Гарчиг

Нэг. Монгол Улсын Засгийн газрын тогтоол

515. Гэгээрлийн яамны бүтцийг батлах тухай Дугаар 178 995

516. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 179 997

Хоёр. Яам, агентлагийн акт

517. Жагсаалт шинэчлэн батлах тухай (Монгол Улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын тушаал) Дугаар А/204 1000

518. Жагсаалт батлах тухай (Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын тушаал) Дугаар А/206 1004

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

оны 11 дүгээр
н 3-ны өдөр

Дугаар 178

Улаанбаатар
хот

Гэгээрлийн яамны бүтцийг батлах тухай

нгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

эгээрлийн яамны зохион байгуулалтын
йг дор дурдсанаар батлсугай:
а/Стратегийн удирдлага, төлөвлөлтийн

-Бодлого, төлөвлөлтийн хэлтэс;
-Хөтөлбөр, төслийн хэлтэс;
-Хамтын ажиллагааны хэлтэс.

б/Төрийн захиргааны удирдлагын

-Захиргааны удирдлагын хэлтэс;
-Хүний нөөцийн удирдлагын хэлтэс.

в/Бодлогын хэрэгжилтийг зохицуулах

-Бодлогын хэрэгжилтийн хэлтэс;
-Нөөцийн зохицуулалтын хэлтэс.

г/Мэдээлэл, хяналт-шинжилгээ,
үнэлгээний газар:
-Хяналт-шинжилгээ, үнэлгээний
с;

-Мэдээлэл, статистикийн хэлтэс.

Гэгээрлийн яамны бүтэц өөрчлөгдөй холбогдуулан "Гэгээрлийн яамны ажиллагааны стратеги, зохион үулалтын бүтцийн өөрчлөлтийн лберийг зөвшөөрөх, тус яамны йг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 142 дугаар тогтоолоор батлсан хавсралтын "3.2.Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар" гэсэн хэсгийг 1 дүгээр хавсралт ёсоор өөрчлөн найруулж, мөн яамны орон тоог 2 дугаар хавсралтын ёсоор батлуулсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлберийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 142 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, "Яамдын орон тоо, цалингийн санг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 26-ний өдрийн 219 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын Гэгээрлийн яамтай холбоотой 4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд **Р.АМАРЖАРГАЛ**


Гэгээрлийн сайд **А.БАТТӨР**

Засгийн газрын 1999 оны 178 дугаа
тогтоолын 1 дүгээр хавсралт

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Гэгээрлийн ажиллагааны бүтцийн дор дурдсан ер
яамны үйл ажиллагаа (бизнес)-ны тогтолцооны загвартай байна:
стратегийн загварыг үндэслэн тус яам үйл

Гэгээрлийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



Засгийн газрын 1999 оны 178 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ГЭГЭЭРЛИЙН ЯАМНЫ ОРОН ТОО

Яамдын нэр	Нийт орон тоо	Үүнээс										Үүнээс	
		Улс төрийн	Төрийн захиргааны	ТЗ-13	ТЗ-12	ТЗ-11	ТЗ-10	ТЗ-9	ТЗ-8	ТЗ-7	ТЗ-6	Төрийн үйлчилгээний	ТУ-4	ТЗ-2
Гэгээрлийн яам	61	2	55	1	-	4	-	5	5	6	34	4	2	2

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

оны 11 дүгээр
ын 11-ний өдөр Дугаар 179 **Улаанбаатар хот**

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

онгол Улсын Засгийн газраас ГООХ нь:

Засгийн газрын 1998 оны 14 дүгээр ээлоор батлсан "Шинжлэх ухаан, ологийн төсөл хэрэгжүүлэх журам"-д дурдсан нэмэлт оруулсугай:

а/2 дугаар зүйлийн "бий болгох" ий дараа "үйлдвэрлэл, үйлчилгээнд оруулэх, ашиглах" гэсэн;

б/ 4 дүгээр зүйлд "улсын алгатай төсөл нь улс орны эдийн , нийгмийн хөгжилд дорвитой хувь р оруулж чадахуйц томоохон үр дүн их, шинжлэх ухаан, технологи, вэрлэл, үйлчилгээний асуудлыг олбор байдлаар шийдвэрлэх, төлөв- буй судалгаа, туршилтын ажлыг огдох байгууллага, эрдэмтэн, мэргэ- ний хамтын хүчээр явуулж түүнд уулах хөрөнгийг төвлөрүүлэн үр ктэй ашиглахад чиглэсэн байх" гэсэн аалт;

дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "ж", "з" тын "овог нэр," гэсний дараа "албан ал," гэсэн;

г/17 дугаар зүйлийн 2 дахь т"төслийн өртөг зардлын товчоол- ооцоо, түүний задаргаа, холбогдох бусад материал" гэсэн "е" заалт;

д/"Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18.1.1, 20.1.1, 22.4-т заасныг үндэслэн онолын суурь судалгааны ажлыг төслийн бус хэлбэрээр зардлын тодорхой хязгаарт багтаан гэрээ захиалгын дагуу Шинжлэх ухаан, технологийн санд улсын төвлөрсөн төсвөөс олгосон хөрөнгөөс шууд санхүүжүүлэн гүйцэтгэж болно.

Онолын суурь судалгааны ажлын сэдэв болон гүйцэтгэгчийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн сонгон шалгаруулж, гүйцэтгэх хугацаа болон жил жилийн зардлыг тогтооно." гэсэн 27[1] зүйл;

е/"Шинээр захиалах болон үргэлжлэн хэрэгжих төслийн төсвийн тооцоог захиалагч байгууллага энэ журмын 28 дугаар зүйлд заасны дагуу тооцож холбогдох материалын хамт жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор Санд ирүүлнэ. Сан нь шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх ирэх оны төсвийг

хянан боловсруулж нэгтгэсэд шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулан жил бүрийн 8 дугаар сарын 20-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ." гэсэн 31[1] зүйл;

ж/"Шаардлагатай гэж үзвэл төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээ, судалгаа, туршилт, төсөл боловсруулах үйл ажиллагаанд ашиглах хэлбэр, хугацаа, хариуцах этэн, гарах зардал, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэр, талуудын хүлээх үүрэг, гүйцэтгэх ажил зэргийг харилцан тохиролцсон нэмэлт гэрээ хийж үр дүнг хүлээн авсан тухай актдаа хавсаргана. Энэхүү гэрээг нотариатаар батлуулах бөгөөд захиалагч нь үр дүнг ашиглахтай холбогдон гарах зардлыг тухайн жилийн төсөвтөө тусган хэрэгжүүлнэ." гэсэн 47[1] зүйл;

з/"Хүлээн авсан үр дүнгээ үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаагүй, эсхүл ашиглах боломлоогүй үр дүн захиалсан захиалагч нь төсөлд зарцуулсан хөрөнгийг Санд буцааж төлөх бөгөөд энэ чиглэлээр дахин төсөл захиалах эрхээ хасуулна." гэсэн 50 дугаар зүйл;

и/журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх гэрээ"-ний 4-ийн 1 дэх хэсгийн "е"-д "хэрэгжүүлэх;" гэсний өмнө "журмын 47[1] дүгээр зүйлд заасны дагуу авч" гэсэн.

2.Мөн журмын 10, 15, 18, 20, 26, 39, 46 дугаар зүйлд болон 47 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрийг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

а/10 дугаар зүйл:

"10. Дараа онд шинээр хэрэгжүүлж эхлэх төслийг тендер зарлах хэлбэрээр захиалах бөгөөд захиалагчийн боловсруулсан тендерийн болзлыг шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага 3 дугаар сарын 1-ний дотор хүлээн авч хянан нэгтгэсэд 3 дугаар сарын 31-ний дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр тендерийг зарлана." гэж;

б/15 дугаар зүйл:

"15. Тендерийг зарлахад шаардах хөрөнгийг Сангаас гаргана" гэж;

в/18 дугаар зүйл:

"18.Ирүүлсэн төслийн сан шинжлэх ухааны салбараар анги Төслийн саналд экспертиз хийх аж хэсгүүдийг шинжлэх ухааны са бүрээр томилон ажиллуулах бө бүрэлдэхүүнийг нь шинжлэх ух технологийн асуудал эрхэлсэн Зас газрын гишүүн батална.

Ажлын хэсгийн ахлагч нь шин ухаан, технологийн асуудал хариу төрийн захиргааны төв байгууллл холбогдох нэгжийн дарга байна. Аж хэсэгт захиалагч болон санхүүжүү байгууллага, Шинжлэх ухааны акаде холбогдох Бага чуулган төлөөле байх бөгөөд түүний бүрэлдэхүүн экспертиз хийх төслийн тоо, төс гүйцэтгэх ажлын онцлогоос хама харилцан адилгүй байж болно." гэж;

г/20 дугаар зүйл:

"20. Ажлын хэсгүүд нь төслийн ба бичгийг 7 дугаар сарын 1-ний д Ажлын албанд экспертизийн үнэл дүгнэлтийн хамт ирүүлнэ" гэж;

д/26 дугаар зүйл:

"26.Төслийн гүйцэтгэгч батлаг төслийн баримт бичгийг дөрвөн үйлдэж захиалагч, санхүүжүүлэгч гууллага болон шинжлэх ухаан, техн гийн асуудал хариуцсан төрийн за гааны төв байгууллагад тус бүр хувийг ирүүлнэ." гэж;

е/39 дүгээр зүйл:

"39.Арга зүйн хяналтыг холбо эрдэм шинжилгээний байгууллагын мийн зөвлөл, санхүүгийн хяна санхүүгийн эрх бүхий байгууллага б Сан, үр дүнгийн хяналтыг захиа болон шинжлэх ухаан, технологий дал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус хэрэгжүүлнэ." гэж

ж/46 дугаар зүйл:

"46.Төслийн ажлыг дор дурдсан р хэлбэрээр тайлагнана. Үүнд:

а/захиалсан үр дүн, санхүүгийн үйл лллагааны явц, байдлын талаар зохих мын дагуу бичсэн Төслийн тайланг алагч болон санхүүжүүлэгч нарт оосон хугацаанд нь хүлээлгэн өгөх;

б/төслийн хүрээнд бий болсон жлэх ухааны шинэ мэдлэгийн талаар ын стандартын дагуу бичсэн Эрдэм жилгээний ажлын тайланг шинжлэх ан, технологийн асуудал хариуцсан ийн захиргааны төв байгууллагаас алсан Итгэмжлэн хадгалагч ("Шинж- ухаан, технологийн мэдээллийн төв" ораци)-д төсөл дуусснаас хойш 2 ын дотор хүлээлгэн өгөх" гэж;

з/47 дугаар зүйлийн 2 дахь лбэр:

"Төслийн үр дүнг хүлээлгэн өгсөөс нжлэх ухаан, технологийн төслийн үр үнэлж, хүлээн авсан акт"-ын рчилсэн загвар (журмын 3 дугаар ралт)-ын дагуу 4 хувь үйлдэж алагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч он шинжлэх ухаан, технологийн дал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус бүр нэг хувийг ална" гэж.

3.Мөн журмын 4 дүгээр зүйлийн "б" т, 6 дугаар зүйлийн "а" заалт, 11, 16, 21, 37 дугаар зүйл болон журмын 1, 2, угаар хавсралтыг дор дурдсанаар илсүгэй:

а/4 дүгээр зүйлийн "б" заалтын гийн" гэснийг "сан (цаашид "Сан" гийн" гэж;

б/6 дугаар зүйлийн "а" заалтын алгаа, туршилт, үйлдвэрлэл, бизне- корпораци" гэснийг "шинжлэх ухаан, юлоги, үйлдвэрлэлийн нэгдэл ораци/" гэж;

в/11 дүгээр зүйлийн "Төслийн чиглэ- тодорхойлохдоо" гэснийг "Тенде- болсол боловсруулахдаа" гэж;

г/16 дугаар зүйлийн "ажлын албанд" ийг "Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл (цаашид "Үндэсний зөвлөл" гэх)-ийн ажлын алба (цаашид "Ажлын алба" гэх)-нд" гэж;

д/16 дугаар зүйлд "чиглэл (тендер)-ийн", 17 дугаар зүйлд "чиглэлийн" гэснийг тус тус "тендерийн" гэж;

е/21 дүгээр зүйлд "8 дугаар сарын 1-ний" гэснийг "7 дугаар сарын 20-ны" гэж;

ж/37 дугаар зүйлд "батлуулна" гэснийг "хэлэлцүүлсний үндэсн дээр шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж;

з/журмын 1 дүгээр хавсралтаар батлсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх гэрээ"-ний 8-д "Үндэсний зөвлөлийн ажлын албанд" гэснийг "шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад" гэж;

и/журмын 2 дугаар хавсралтаар батлсан "Шинжлэх ухаан, технологийн төслийг санхүүжүүлэх гэрээ"-ний 11-д "Үндэсний зөвлөлийн ажлын албанд" гэснийг "шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад" гэж;

к/журмын 3 дугаар хавсралтаар батлсан "Шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үнэлж, хүлээн авсан акт"-ын 6-д "Үндэсний зөвлөлийн ажлын албанд" гэснийг "шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад" гэж.

4.Журмын 12, 13, 14, 34 дүгээр зүйл, журмын 1 дүгээр хавсралтын 4-ийн 1 дэх хэсгийн "б" заалт, 2 дугаар хавсралтын 7-гийн 1 дэх хэсгийн "б" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын
Ерөнхий сайд Р.АМАРЖАРГАЛ

Гэгээрлийн сайд А.БАТТӨР

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 8 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар А/204** **Улаанба хот**

Жагсаалт шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйл, 109 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1."Эмэгтэй хүн ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралтын, "Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус шинэчлэн батлуулсугай.

2.Энэхүү жагсаалтыг мөрдөж ажиллах ахуйн нэгж, байгууллагын удирдлагад болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ С. СОНИН

ЭМНХ-ын сайдын 1999 оны А/204 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

ЭМЭГТЭЙ ХҮН АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОСОН АЖЛЫН ЖАГСААЛТ

Нэг. Үүл үүрхайн олборлох үйлдвэрлэл

Газар доорх бүх төрлийн ажил, газрын тос олборлох, нэрэх, шатдаг хий ашиглах

Хоёр. Арьс ширний үйлдвэрлэл

Арьс шир идээлэх, натри, хромын шим бэлтгэх зэрэг шохойн дамжлагын бүх ажил, идээлсэн ширийг зөөж хураах

Гурав. Шилний үйлдвэрлэл

1. Шил амаар үлээх
2. Карбид гараар бутлах

Дөрөв. Нэхмэлийн үйлдвэрлэл

1. Анилины давс, флюс, гараар бэлтгэх
2. Гидрохлорит гар ажиллагаагаар бэлтгэх

Тав. Хэвлэлийн үйлдвэрлэл

1. Хэвлэлийн хэвлэгч
2. Сэвэт хэвлэл, цайр, зургийг буулгах, хордуулах
3. Стереотип цутгах
4. Тугалга хайлуулах
5. Усаг цутгах
6. Нэгтгэл огтлоо машины машинч

Зургаа. Өөдлын үйлдвэрлэл

1.Эрэх дамжлагын нарийвчилсан болон хэсэгчилсэн огтолгооны машинч
2.Тусай зориулалтын пресс индүү ажиллуулах

Долоо. Махны үйлдвэрлэл

1.Мал, гахай, шувуу мэдрэл алдуулах, цусалгах хийх
2.Мал нядлах
3.Аммикан хөргүүртэй зооринд ажиллах.

Найм. Тээвэр

а. Төмөр замын тээвэр

1.Вагон холбогч, найруулагч
2.Хос дугуйн жийрэг, мөөр суулгах
3.Гүүрийн слесарь
4.Дэр мод идээлэх, ачиж буулгах
5.Яндан цэвэрлэх, хөвлөгөх, үлээлгэх
6.Ивүүрчин
7.Вагон доогуур орж үйлчилгээ, хяналт хи
8.Илчит тэрэгний дизель, туслах тон түлш, цахилгаан моторын засварлах ажил
9.Цахилгаан чигжүүрээр замчигжих
10.Зам засварын хүнд механизмын жоло

б. Усан тээвэр

1.Усан онгоцны дизельчин
2.Залуурч, усан цэрэг
3.Усанд шумбах
4.Усан онгоцны механик
5.Усан замын тэмдэг тавих

в. Авто тээвэр

1. 2.5 тн-оос дээш даацын автомашин, дээш суудалтай автомашины жолооч
2. Шатах тослох материал, агуулах резе цистернийн дотор засвар хийх, гаргах

г. Агаарын тээвэр

1.Нисэх онгоцны механик
2.Нисэх онгоцны холбоочин
3.Онгоц болон түүний хөдөлгүүрт техн үйлчилгээ хийх

Ес. Барилга угсралт

1.Яндан хоолой угсрах
2.Худаг малтах
3.Хавтан гараар цутгах, эвдэж бутлах
4.Чулуу бутлах
5.Автоклавчин

Аолв. Нийгмийн үйлчилгээ

1.Бохир усны шүүр цэвэрлэх
2.Бохир усны шугамын сантехникч

Арван нэг. Мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэл

1.Мод бэлтгэх, усаар урсгах бүх дамжлага
2.Гуалин гаралтай ачиж буулгах
3.Доод агуулахад мод тайрах, ялгаж хураах
4.Цаасны үйлдвэрийн хлор найруулах
5.Мод бүтлэх

Арванхоёр. Түгээмэл ажил, мэргэжил

1.Антен, мачтын ажил
2.Битум, асфальт чанах
3.Улын аврах ажил
4.Шүхэрчин-гал сөнөөгч
5.Мөнгөн устай харьцаж ажиллах
6.Мөнгөн устай будаг найруулах, будах
7.Бүх төрлийн уурын зуухны галч
8.Шатах тослох материал хадгалдаг цестерн, сав орж цэвэрлэх, будах, засварлах, гагнах
9.Бензинд этил холих
10.Зуух, яндан, хоолой, камер цэвэрлэх
11.Нүүрс, нурам, үнс, гарган, зөөх
12.Уурын зуух галлах, уурын тогоо засварлах, цэвэрлэх, түлш, үнс зөөх
13.Ширэм, металл хайлуулах, цувих, юулэх, савлах
14.Хар тугалга хайлуулах, цутгах, сунгах, цувих, хэвэнд цохих, гүйлгэх, аккумлятор хийх, гагнах, кабелийг тугалгадах, гар ажиллагаа-гаар хар тугалган здлэл боловсруулах
15.Хүдрээс хар тугалга, зэс, мөнгөн ус, алт, цайр, мөнгө зэрэг өнгөт металл хайлуулах
16.Шугам хоолой гагнах
17.Лантуучин
18.25 тн-оос дээш хүчээр металлыг хүйтнээр хэвлэх автоматчин, прессчин
19.Хүрд зорох суурь машинч
20.Бутлагч
21.Автомашины дугуй жигнэх
22.Зуухны засварчин
23.Өндөр даралтын шугам хоолой гагнах, засварлах
24.Хохивч цутгах
25.Цахилгаан шүүлтүүр цутгах
26.Суурин дизелийн цахилгаан станцын машинч, засварчин
27.Компрессорчин
28.Химийн аргаар металл өнгөлөх хүчил

ЭМНХ-ын сайдын 1999 оны А/264 тоот тушаалын 2 дугаар хавсралт

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХӨН АЖИЛЛУУЛАХЫГ ХОРИГЛОСОН АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

Нэг. Уул уурхайн олборлох үйлдвэрлэл

Газар доорх бүх төрлийн ажил, газрын тос өрлох, нэрэх, шатдаг, хий ашиглах

Хоёр. Уурхайн газрын дээрх ба ил уурхайн үйлдвэрлэл

1. Нүүрсний үйлдвэрлэл
2.Бүх төрлийн машин механизмын жолооч
3.Өрөмдөгч
4.Трриконикийн ажил
5.Тэсэлгээчин
6.Туузан дамжуулагч ажиллуулах
7.Уурхайн түймэр унтраах
8.Уурхайн төмөр замын ажил
9.Уурхайн гэрлийн тасгийн ажил
10.Уурхайн цахилгааны слесарьч
11. Баяжуулалтын ажил
12.Ачиж буулгах машинч
13.Асбест гаргах г
14.Дүүжин зам засах
15.Бензин болон карбидан ламп цэвэрлэх
16.Баяжуулалтын үйлдвэр, уурхайн тоног төхөөрөмжийн засварын ажил
17.Вагон онхолдуулан асгах
18.Вагон түрэх
19.Дээж бутлах
20.Дохиочин
21.Баяжмал хатаах, холих, зөөх, савлах, ачих
22.Нүүрс хүлээн авах
23.Насосны станцын моторчин
24.Өрмийн хошуу ирлэх
25.Пультны операторч
26.Сепаратарчин
27.Тэсэлгээний бодис бэлтгэх
28.Тунгаах машинч
29.Уурхайн усан сан цэвэрлэх
30.Уурхайн хөлдөөх машинч
31.Хөвсрүүлэн ялгах машинч
32.Чулуу, шавар, шохой бутлах
33.Хөрс, хүдрийг хөлдөхөөс хамгаалах
34.Шавар цэвэрлэх
35.Шахах машинч

Гурав. Эрэл хайгуул, байр зүйн зургийн зүйл

1.Бүх төрлийн өрөмдлөг
2.Говь цөлийн ба өндөрлөг уулын нөхцөлд хийгдэх геологийн ажил
3.Дээж бутлах, ялгах, угаах
4.Каротажийн станцын өргөх машинч
5.Өрмийн цамхаг угсрах бүх төрлийн ажил
6.Иончлох цацраглатаар хэмжилт, судалгаа хийх
7.Уур, усаар газар гэсгээх
8.Улын өрөмдлөг, бэхэлгээ хийх

Дөрөв. Металл боловсруулах үйлдвэрлэл

1.Худэр, металл эдлэл цэвэрлэх
2.Бүх төрлийн хэв хийх
3.Зуухны засварын ажил

4.Ширэм ган хайлуулах
5.Лантуучин
6.Цутгуурын ажил
7.Металл эдлэл өнгөлөх
8.Металл эдлэл хатаах
9.Пресслэх
10.Дарханы ажил
11.Угсрах слесарьч
12.Хэв дарах
13.Цахилгаан слесарь
14.Цутгасан металл ховхлох
15.Цутгамал цэвэрлэх, засах
16.Металл, никель, хром, алт, мөнгөөр эдэл хийх, бүрэх

Тав. Эрчим хүчний үйлдвэрлэл

1.Бүх төрлийн ажил

Зургаа. Шаазан, ваарны үйлдвэрлэл

1.Гипс, шаазан эдлэл хатаах, зуухнаас гаргах
2.Материал холих, бутлах, шигших
3.Шаазан хэвлэх
4.Шаазан эдлэлийг цэвэрлэх, өнгөлөх, пааландах, хэш тавих

Долоо. Шил, толины үйлдвэрлэл

1.Бэжжүлсэн шилэн эдлэлд сонголт хийх
2.Зуух засах, ерлег хийх, галлах
3.Материал хэмжих, хольж найруулах
4.Толь цайрдах
5.Шил захлах
6.Халуун шил пресслэх
7.Химийн материал бутлах, холих, шигших
8.Шил бэжжүлэх, зуухнаас гаргах
9.Шил үлээх
10.Шил үлээх хагас автоматын операторч
11.Шилэн эдлэл уяраах, тайрах
12.Шил өнгөлөх

Найм. Барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэл

а. Барилга-угсралт
1.Бетон зуурах
2.Антен, цамхаг угсрах
3.Галд тэсвэртэй эдлэл хийх
4.Замын чулуу бэлтгэх, суулгах
5.Зуурах машинаар шавар зуурах
6.Мод чанах
7.Бетончин
8.Полихлорвинил ба бакелитээр тусгаарлаж бүрэх
9.Рам зангидах
10.Дээвэр тавих
11.Цахилгаан монтажчин
12.Чулуу засах
13.шугам хоолой яндан далдлах
14.Төмөр бетон эдлэл угсрах
б. Цементийн үйлдвэрлэл
1.Агааржуулагчийн машинч
2.Туузан дамжуулагч, клинкер зэрэг технологийн ба цахилгаан эрчим хүчний бүх төрлийн машин, тоног төхөөрөмжийн машинч
3.Тоног төхөөрөмжийг тослох
4.Тоостой битүү агуулахад ажилладаг грей скреперийн жолооч
5.Түүхий эд бутлах, нунтаглах тээр машинч
6.Цемент савлах
7.Эргэх зуухны машинч, зуух засварлах
в. Төмөр бетоны үйлдвэрлэл
1.Автоклавчин
2.Бетоныг уураар шарах
3.Хуурай холио, зуурмаг бэлтгэх
4.Бутлах машинч
г. Тоосго, силикат, тоосгоны үйлдвэрлэл
1.Бишинкер, бигунь, элеватор, шигшүүр, т дамжуулагч, бункер ажиллуулах
2.Грейдер, скреперийн жолооч
3.Тоосгоны зуурмаг бэлтгэх, хувиарлах
4.Тоосго прессээр хэвлэх, зүсэх
5.Зууханд тоосго, өрөх, гаргах
6.Тоосго, шохой шатаах, зуух баажу га үнс нурам зөөх
7.Шохой унтраах
8.Шохой унтрааж тээрэмдэх

Ес. Ойн аж ахуй, мод бэлтгэх, боловсруул үйлдвэрлэл

а. Ойн аж ахуй
1.Баглах хураасан модны хамгаалалт зад
2.Гуалин, банз зүсэх
3.Давирхай чанах
4.Хөрөө, харуул ажиллуулах
5.Мод унагаах
6.Гуалин ачиж, буулгах, хураах
7.Мод уснаас гаргах, хураах
8.Модыг лөвдөх, трактор, өрдийн хөсгөөр цагаалах, булхайлах
9.Мод мөчирлөх, холтослох
10.Тээврийн хэрэгсэл холбох
11.Модны нүүрс боловсруулах
12.Ойн хортон мэрэгч устгах
13.Сал боох, татах, сал ба мод урсгах
14.Хөрөө солих, ирлэх
б. Мод боловсруулах үйлдвэрлэл
1.Хөрөө ирлэх
2.Цавуу чанах
3.Гуалин чанах, холтослох
4.Ноцоох хольц найруулах
5.Фанер наах, халуун прессээр шахах
6.Цавуугаар наасан эдлэлийг хатаах
7.Шүдэнзний ишинд ноцоох уусмал түрхэх
8.Химийн материал бутлах, нунтаглах
9.Мод бутлах

Арав. Хэвлэлийн үйлдвэрлэл

1.Гараар үсэг өрөх
2.Хэвлэлийн хэвлэгч
3.Машинаар үсэг өрөх ажил /линотипч/
4.Огтлох машинаар хийх ажил
5.Цавуу найруулах
6.Резин эдлэл хийх
7.Стериотип матриц авах, хуулах
8.Тугалга хайлах
9.Торгон хэвлэлийн лакдах, будах ажил
10.Үсэг цутгах, тугалгаар үсэг хэв гаргах

1.Үсэг сийлэх
2.Фольга дарах , бороншдох, лакдах
3.Тоног төхөөрөмжийн слесарь, тохируулга

4.Хутга ирлэх
5.Хордуулах, хордуулан буулгах
6.Цайр зургийн ажил

Арваннэг. Хөнгөн үйлдвэрлэл

оос үгаах, нэхмэл, хивсний үйлдвэрлэл
будаг, химийн уусмал, эмульс найруулах
.будах ажил
.Гараар ноос холих
.Индүүдэх
.Карванжуулах
.Ноос сэгсрэх
.Ноос ялгах
.Ноос хатаах
.Ноос баглаж, пресслэх, зөөх, хураах
0.Самнах машин цэвэрлэх
1.Ноос үгаах
2.Хивс зүсэх
3.Хивс хайчилж тэгшлэх
эдлын үйлдвэрлэл
.Арьс шир цавуудах, наах
.Брезент оёх
.Тусгай зориулалтын пресс индүү
луулах
Эсгэх дамжлагын нарийвчилсан болон
чилсэн огголгооны машин ажиллуулах
Арьс шир, үслэг эдлэл боловсруулах
вэрлэл
.намааз түрхэх
.Арьс шир татах
.Нитро будгаар шурших
.Арьс ширний шар мах гараар ба машинаар

.Арьс шир шохойдох, шохой зуурах, арилгах
.Арьс ширийг хүрдээр эвлүүлэх
.Идээлсэн арьсны ус шахах
.Арьсны үсийг гараар ба машинаар авах
.Арьс гараар захлах, годлох, шир зоолох
0.Арьс, шир баглах, зүлгэх өнгөлөх, идээлэх
1.Машин, тоног төхөөрөмж, хүрд худаг,
уу цэвэрлэх ажил
2.Хөх шир, юфть тослох, шевро шевретийн
рилгах
3.Эмульс, техникийн төрөл бүрийн уусмал,
г найруулах
4.Нэхийн тос авах
5.Тоног төхөөрөмж цэвэрлэх
6.Ангийн үс, ноос утах, ариутгах
7.Будах
8.Индүүдэх
9.Нэхий, ноос үгаах
0.Ноос сэгсрэх
1.Арьс элдэх
2.Уусмал, будаг найруулах
3. Наах, цавуудах
4.Арьс дэвтээх
5. Үс авах
6. Арьс шир гандах
7. Шохойн шим, намаз үгаах
8. Уусмалаар арьс үгаах
9. Арьс ялгах

г. Гутлын үйлдвэрлэл
1.Гутлын рант оёх, хуучин гутал тахлах
2.Цавуудах, наах
3. Цавуу найруулах, резинэн хольц бэлтгэх
4. Цавууны суурь машин бэлтгэх

д. Эсгий, эсгий гутлын үйлдвэрлэл
1. Гутал хэвлэх, хэв сугалах
2. Гутал будах, түрий тайрах, өнгөлөх, цэвэрлэх
3. Гараар ноос холих, зулах
4. Ноосны үс шахах
5. Гутал хатаах
6. Хүчлээр ажиллах
7. Самнах, сэмлэх, даахь урах, сэгсрэх машинч, түүнийг засварлах
8. Эсгий, эсгий гутлын чангаруулах машинч
9. Эмульс цавуу найруулах
10. Эсгий үгаах, татах, сунгах

Арванхоёр. Хүнсний үйлдвэрлэл

а. Талхны үйлдвэрлэл
1.Талх, боов жигнэх
2.Шуудай сэгсрэх
б. Чихэр боовны үйлдвэрлэл
1.Гараар чихрийн масс боовны зуурмаг хольж найруулах
2.Боов зууханд хайрах, шарах
в. Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
1.Мал, гахай, шувуу нядлах, толгой шийр хүйхлах
2.Мах, хиам шарах, утах
3.Өлөн гэдэс боловсруулах
4.Мах татах
5.Яс бутлах
6.Даралтад савыг ажиллуулах
7.Цусалгаа хийх
г. Давс олборлох үйлдвэрлэл
1.Давс олборлох
2.Давс тээрэмдэх
д. Гурил, тэжээлийн үйлдвэрлэл
1.Хийн тээврийн машинч
2.Хатаагуурын галч
3.Тээрэмдэх машины гол ирлэх
е. Архины үйлдвэрлэл
1.Архи савлах, бөглөх

Арвангурав. Хөдөө аж ахуй

1.Комбайнчин, тракторчин
2.Механик бухалдагч, хадуур дээр ажиллах
3.Үр тариа хордуулах
4.халдварт өвчтэй мал маллах, саах, ноос хөөвөр авах
5.Хортон устгах

Арвандөрөв. Тээвэр, холбоо

а. Төмөр замын тээвэр
1.Авто ба мотор дрезины жолооч
2.Хос дугуй жийрэг, мөөр суулгах
3.Вагон үзэгч
4.Өртөө, зөрлөгийн жижүүр
5.Вагон холбох, найруулах

6.Зүтгүүрийн машинч, түүний туслах
7.Мотовозын машинч
8.Замын бүх төрлийн машин, механизмын машинч, слесарь, механикч
9.Дохиоллын монтёр, механик
10.Механикжсан довын оператор, монтёр
11.Замын эргүүл
12.Битүү сав, цистерн угаах
13.Антисептик модонд шингээх
14.Дохиочин
15.Зам тэмдийг бэхлэх
16.Зам засварлах
17.Төрөл бүрийн жижүүр
18.Ивүүрчин
19.Нумчин
20.Нурмаг газрын эргүүл
21.Замын болон гүүрийн мастер
22.Замд тосолгоо хийх

б. Усан тээвэр
1.Залуурчин
2.Усан цэрэг
3.Механикч, түүний туслах

в. Авто тээвэр
1.Автомашины ба троллейбусны жолооч
2.Шатах,, тослох материал түгээгч
3.Битум, асфальт чанах
4.Дугуй жигнэх, өөлөх, цавуудах, угсрах
5.Хортой шингэн ба нефть бүтээгдэхүүнээр эд анги угаах, цэвэрлэх, будах
6.Тос нэрэх, тунгаах

г. Агаарын тээвэр
1.Механикч
2.Моторчин
3.Онгоц будах
4.Онгоц, эд анги угаах
5.Талбай гэрэлтүүлэх
6.Нисдэг тэрэг, онгоцны багийн бүрэлдэхүүнд орж ажиллах
7.Нисдэг тэрэг, онгоц сумлах
8.Засварын ажил
9.Онгоц асаах
10.Цахилгаан механикч
11.Шүхэр боох

д. Холбоо
1.Антенн, мачтын ажил
2.Газар доорх холбооны ажил
3.Зай тэжээлийн ажил
4.Мөнгөн устай шулуутгагч ажиллуулах
5.Төрөл бүрийн өндөр үелзлийн байгууламжид ажиллах
6.Шон босгох
7.Агаарын ба кабелийн шугамын монтёр
8.Залгагч

Арвантав. Нийгмийн үйлчилгээ

а. Ус сураг, ариутгах татуурга
1.Ариутгах татах, шүүх байгууламжийн ажил
2.Муу усны сүлжээ, сураг шуудуу цэвэрлэх, тоног төхөөрөмжид үйлчлэх
3.Ариутгах, хлоржуулах
4.Хог, хаягдал ачиж буулгах

б. Угаалга, хими цэвэрлэгээ
1.Химийн хортой бодисоор угаах, цэвэрлэх

Арванзургаа. Хүн, мал эмнэлэг, эмийн үйлдвэрл

1.Сэтгэцийн эмгэгтэй өвчтөн эмчлэх, су
байгууллагад ажиллах
2.Ампул гагнах
3.Эмэг согоотой хүүхдийг асрах байгуул
ажиллах
4.Халдвартай материалаар ажиллах
5.Минериал ба шавар эмчилгээ хийх
6.Мал, хүн эмнэлгийн хүүр, шарил хадгалах га
ажил
7.Нян, хортон мэрэгчийг устгах, ариутгах
8.Халдварт өвчин эмчлэх, сувилах байгуул
ажил
9.Түргэн тусламжийн ажил
10.Хортой эм, бодистой харьцан ажиллах

Арвандолоо. Түгээмэл ажил, мэргэжил

1.Аккумляторчин
2.Автомеханизм ажиллуулах
3.Ацетелин ба хийн генераторч
4.Бункер, туузан дамжуулагч, нефть химийн б
хадгалсан сав цэвэрлэх
5.Багаж ирлэх
6.Цахилгаан монтёр, слесарь
7.Бүх төрлийн гагнуурын ажил
8.Нүүрс, нурам, үнс гаргах, зөөх, буулгах, бутл
9.Бүх төрлийн гагнуурын ажил
10.Дизельчин, компресорчин
11.Ачиж, буулгах бүх төрлийн ажил
12.Зуух, яндан хоолой, камер цэвэрлэх ажил
13.Кабель, шугамын ажил
14.Бүх төрлийн уурын зуухны галч
15.Мөнгөн устай багаж төхөөрөмж дээр ажи
засварлах
16.Зүлгүүрийн ажил
17.Ионжлогддогүй цацрагаар ажиллах
18.Өндөрт авирах бүх төрлийн ажил
19.Халуун аргаар резин наах
20.Тэсэлгээний ажил
21.Төрөл бүрийн зооринн ажил
22.Тугалга хайлах
23.Химийн 1,2,3 дугаар зэргийн бодистой аж
бүх төрлийн ажил
24.Хийн станцын машинч, моторчин
25.Ионжлох цацрагаар ажиллах
26.Цахилгаан ба авто ачигчийн жолооч
27.Шилэн хөвөнтэй ажиллах
28.Экскаваторчин, бульдозер, грейдер, скр
анжис дээр ажиллах
29.Электрод хийх
30.Нүүрсэн электродтой гэрэлтүүлгээр гэрэлтү
31.Бүх төрлийн будаг, лак, эмаль, э
найруулах
32.Усан буучин, драгийн ажилчин

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 8 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар А/206** **Улаанба хот**

Жагсаалт батлах тухай

Монгол улсын "Хөдөлмөрийн тухай" хуулийн 92 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Шинээр ажилд орох иргэн болон ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулж, эрүүл мэндийн бүрдмэл үзлэгийн м лагаа гаргуулахдаа Эрүү мэнд, нийгмийн хам лын сайдын 1999 оны А/243 тоот тушаал дугаар хавсралтын дагуу зохион байгуул ажил олгогч нарт даалгасугай.

. Ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт лах ажил, үйлчилгээний жагсаалтыг 1 дүгээр ралтын ёсоор батална.

Энэ тушаалын хэрэжилтэд хяналт тавьж лахыг Иэдээлэл, хяналт шинжилгээ, гээний газар /П. Алтанхуяг/, Хөдөлмөр, нийгмийн хамгаллын хяналтын алба /Ц. Энхтайван/-нд тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн яамны сайдын 1982 оны 137 дугаар тушаалыг үүчингүй болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ С. СОНИН

ЭМНХ-ын сайдын А/206 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

АЖИЛТНЫГ АЖИЛЛАХ ЯВЦАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУГАЦААТ ҮЗЛЭГТ ОРУУЛАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

Нэг. Химийн бодис, түүний нэгдлүүдийн хүчин зүйлийг хэрэглэдэг ажил үйлчилгээ

1. Хар тугалга, түүний нэгдлүүдийг гаргаж , хэрэглэх

Хар тугалга, дэрвөн этилт хар тугалга, тэй бензин

6 сард 1 удаа

' Хар тугалга, агуулсан хүдэр, хар тугалгын цтой нэгдэл

12 сард 1 удаа

2.Мөнгөн ус түүний нэгдлүүдийг гаргаж авах, авсруулах, хэрэглэх

' Мөнгөн усыг хүдрээс салгах, хайлах, мөнгөн хэрэглэж алт болон бусад металл ялгах, ен усны органик нэгдэл, түүний хольц

6 сард 1 удаа

' Битүү саванд байгаа мөнгөн устай ажиллах, ен устай тос, эм бэлтгэх, амелгам

12 сард 1 удаа

3.Марганц, түүний нэгдлүүдийг гаргах, авсруулах

' марганцын хүдэр, түүний органик биш эл, марганцын хольцтой нэгдэл, марганцын ник нэгдэл

6 сард 1 удаа

/ 10% хүртэл марганц агуулсан металл ган уулах, марганцын органик нэгдэл

12 сард 1 удаа

4.Металлуудын нэгдэл гаргах, боловсруулах, глэх

/ кадми, кобальт, магни, молибден, титан, они, хром, хөнгөн цагааны электрод, шамот езит

12 сард 1 удаа

/ вольфрам, кобальт, никель, түүний нэгдэл

12 сард 1 удаа

/ берилли. Түүний нэгдэл, бериллийн фторок, льт, вольфрам, радиокерамик эдлэл

6 сард 1 удаа

5. Металл биш нэгдлүүдийн үйлдвэрлэх, глэх

а/ Фтор, түүний органик ба органик биш лүүд

6 сард 1 удаа

/ Хлор, түүний нэгдэл, хүхрийн хүчил, азотын л ба түүний ангидрид, хүхэр устөрөгч, хүхэрт стөрөгч, түүний нэгдэл, кеантогенатууд, рөгчийн хэт исэл, мышьяк, шар, улаан, цагаан фор, цианы хүчил, селен, теллур түүний эл, азот, фосфорын бордоо, фреонууд

12 сард 1 удаа

1.6. Органик бодисуудыг хэрэглэх, гаргаж авах

а/ гексан, формальдегид, фенол, фенолформальдегид, мочевиноформольдегид, эпоксидын, давирхай тослог эгнээний смин, никотин, никотины хүчил

24 сард 1 удаа

б/ инсектицид, фунгицид, пестицид, /хлор органик, фосфор органик, металл органик нэгдлүүд, синилын, цианы хүчлүүд/ дихлорэтан, дөрвөнхлорт нүүрс-устөрөгч, хлорвинил, полихлорвинил, перхлорвинил, хлортметилен, бромметилен, нафталин, дифенил, дивинил, дивинметил, дивинилстирол, дивинилизопрен, этилбензол, изопропилбензин, стирол, хлорпрен, полифен, полиуретан, бензин, дианаздин, толуодин, альфнафталамин, уросол, метил, метакрилат, тиурам, неозинд, каптак нитробензол, керезол, эстралин, анилин, ксилидин, толуодин, пикриний хүчил, бензол, толуол, кеимол болон түүний эгнээний нэгдлүүд

12 сард 1 удаа

1.7. Чулуун нүүрс ба нефтийн үйлдвэрлэл

а/ Чөлөөт хүхэрт-устөрөгч агуулагдаг нефтийн гарган авах, озокеритийг гарган авах боловсруулах, чулуун нүүрснээс ялгасан эпоксидийн давирхай ба цавуутай ажилтах.

12 сард 1 удаа

б/ Нефтийг боловсруулах, нефтээс анхилуун нэгдэл, бензол, толуол, ксилол, түүний гомологуудыг гарган авах, үйлдвэрлэх, пробензол парафиныг үйлдвэрлэх, тосыг селективт аргаар ялгах, нефть зөөдөг онгоц, цистерн, цистерний таглаа засаж цэвэрлэх, чулуун нүүрсний давирхай пек, сланцын давирхай, антарцин крестозын тос үйлдвэрлэх, хэрэглэх,

в/ Коксжилтын бүтээгдэхүүнийг хураах, авах коксын зууханд чулуун нүүрсний давирхайг нэрэх, ароматик нэгдлүүд гаргаж авах, нефтийн ханасан, ханаагүй нүүрстөрөгч, пирогазын үйлдвэрлэх.

12 сард 1 удаа

1.8. Нийлэг эдлэлийн үйлдвэрлэл

Нийлэг ширхэгийн давирхайнууд, капролактам, цахиурт органик нэгдэл, алекилхлорсиланууд, этоксиланууд үйлдвэрлэх, хэрэглэх.

12 сард 1 удаа

Хоёр. Физикийн хүчин зүйлийн нөлөөнд байдаг ажил үйлчилгээ

а/ Ионжуулагч цацраг, түүний үүсгүүр, радио идэвхт бодис, иончлогддоггүй цацраг, лазерийн туяа, тогтмол цахилгаан ба соронзон орон, радио узел, СВЧ, УВЧ, ВЧ, хэт өндөр давтамжийн богино долгионы төхөөрөмжтэй харьцан ажилладаг ажил үйлчилгээ

6 сард 1 удаа

б/ Үйлдвэрлэлийн ерөнхий ба хэсгийн до 80ДБА болон түүнээс дээш шуугиан, атмосф өндөр нам даралт /кессон, барокамер, газрын ба өндөр уулын бүсэд нисэх онгоц/ хэт бага б өндөр агаарын хэм, дулааны цацрагийн нөл ажиллах ажил үйлчилгээ

12 сард 1

Гурав. Үйлдвэрлэлийн тоос болон аэрозолийн хүчин зүйлийн нөлөөнд байдаг ажил үйлчилгээ

а/ Кварц, силикат, нүүрс болон бусад тоостой нөхцөлд ажиллагсад, 10% -иас дээш цахиурын давхар исэл агуулсан хүдрийн ба хүдрийн бус ашигт малтмалыг ил, далд уурхайгаас гаргах, боловсруулах, өрөмдөх, газрын дор нүүрс гаргах, баяжуулах, сланц гаргах боловсруулах ажил

12 сард 1 удаа

б/ Кокс ялгах, шахах, тэсвэрлэх, шатаах, мартены ба металл хайлах зуух, батарей засагчид, хайлагч хэв оруулагч, төмөр гаргагч, оглогч, точилдогч /үрэгч/, крананаар өргөгч, хайлуулсан ганг цэвэрлэгч, кварц агуулсан хүдэр баяжуулагч, цахиуртай хайлш бэлтгэгч, уурын зуухны галч, цахилгаан гагнуурчин, хөө шохойтой харьцан ажиллах ажил үйлчилгээ

12 сард 1

в/ Кварцжуулсан хүдрийг баяжу боловсруулах, асбестийн хүдрийг хуурай аг боловсруулах, асбест, цементээр цахи дулааны тусгаарлагч материал үйлдвэ асбест, оливен, нефолин, тальк, апатин це слюд, шилэн хөвөн, минералын ширхэг зэрэг агуулсан материал үйлдвэрлэх ажлууд

6 сард 1

г/ Үр тариа, яс, ноос боловсруулалтын эрхлэх

12 сард 1

Дөрөв. Биологийн хүчин зүйл

Антибиотик, түүний концентрац үйлдвэрлэх, хөгц, мөөгөнцөрийн гаралтай бүтээгдэхүүн, уураг, аминдэмийн бөөгнүүрсэн тэжээл, херенгэ, дарш, ферментийн бэлдмэл, биологийн идэвхжүүлэгч бодис, нянгийн өсгөвөр, хор гаргах, бэлдэх,

аллергеныг оношлох, цусан болон иммуноло бэлдмэлүүд, халдвартай болон авгал өндгөөр халдварлагдсан материал, брүцөлл үүсгүүртэй харьцан ажиллах ажил, үйлчи

6 сард 1

Тав. Хөдөлмөрийн үйл ажиллагааны хүчин зүйл

а/ Гараар ачаа байгаа өргөх, шилжүүлэх ажлыг цагт 2-оос дээш удаа хийж гүйцэтгэх /эрэгтэй 15 кг, эмэгтэй 7 кг буюу түүнээс дээш жинтэй ачаа/, өвдөгний үеэр болон явган суух, хэвтээ байралд ажлын хугацааны 25%-иас илүү хугацаанд ачаа үүрэх, шилжүүлэх, зөөх ажил үйлчилгээ гарын болон мөрний булчингийн хэсэгт хүч ихээр шаардагдах ажил, оптикийн багаж хэрэгсэл болон дэлгэцэнд ажиглалт хийх зэрэг

харааны хүчдэл байгаа, ихээр шаардагдах а багш, холбоочин, радио нэвтрүүлэгч, зэрэг д болон ярианы хөвчид хэт ачаалал өгөх үйлчилгээ

12 сард 1

б/ өндөр өөд авирах, өргөх байгуул цамхаг, бусад механизм зэрэг өндөрт өргөгдө холбоотой ажил үйлчилгээ

12 сард 1

Зургаа. Бусад ажил, үйлчилгээ

а/ Алслагдсан цаг агаарын тааламжгүй, хүнд нөхцөлд геологи, хайгуул, газар зүйн байрлал судлах болон барилгын ажил

24 сард 1 удаа

б/ Даралтат сав, тэсрэх болон галын аюултай үйлдвэрлэл, галт зэвсгийг засварлах ажил

12 сард 1 удаа

в/ Байгаа анхаарал төвлөрүүлэх шаардлагатай нарийн хуваарь хэмжүүртэй багаж, хөдөлгөөнт хэрэгслүүдийг шууд удирдан чиглүүлэгч ажил

12 сард 1 удаа

г/ Сүү боловсруулах, сүүн бүтээгдэхүүн бэлтгэх, түгээх, борлуулах, тэжээрлэх, хадгалах, худалдах ажил үйлчилгээ

12 сард 1

д/ Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэ худалдаа нийтийн хоолны газарт ажиллах б дадлага хийх

12 сард 1

е/ Эмчлэх, урьдчилан сэргийлэх болон ам сувиллын гарт эм бэлтгэх, савлах, борлу ажил үйлчилгээ

12 сард 1 у

ё/ үндны ус түгээх, усан сэлэлт, эмчилгэ халуун усны зэрэг ахуй үйлчилгээний ажил

12 сард 1 у

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Төр, Засгийн Үйлчилгээ аж ахуй эрхлэх газрын харьяа хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 327806, 320407

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арванхоёрдугаар сарын 27 №58 (137)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

519. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай Дугаар 77 1007

520. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай Дугаар 78 1008

521. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 79 1008

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

522. Хувьчлах барилга байгууламж, тоног төхөөрөмжийн жагсаалт батлах тухай Дугаар 181 1008

523. Журам батлах тухай Дугаар 184 1009

524. Авто замын засвар, арчлалтын нэгтгэлийг компанийн хэлбэрт оруулан ажиллуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 185 1011

525. Хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалтад нэмэлт оруулах тухай Дугаар 186 1012

Гурав. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

526. Журам батлах тухай (Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгаллын сайдын хамтарсан тушаал) Дугаар 237, А/287 1012

527. Журам батлах тухай (Байгаль орчны сайдын тушаал) Дугаар 114 1014

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

9 оны 12 дугаар ын 16-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусаж байгаатай холбогдуулан Суурийн Жанцанг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 1999 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 78** **Улаанбаа хот**

Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох ту

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Дашдоржийн Дэмбэрэлцэрэнг Үндсэн ху цэцийн гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 1999 оны 12 д сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.Улсын дээд шүүхийн санал болгосноор

ДАРГА **Р.ГОНЧИГД**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 79** **Улаанбаа хот**

Зарим Байнгын хорооны бүрэлдэх өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүдийн өөрсдийнх нь гаргасан хүсэлтийг харгалзан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Р.Бадамдамдин нарыг Эдийн засгийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бямбадорж, О.Энхтуяа нарыг Нийгмийн бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Батж.Батбаяр, Л.Лувсан-Очир, О.Энхтуяа, Ч.Сайханбилэг нарыг Хууль зүйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Р.Нарангэрэл, Ц.Төмөртогоо нарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Д.Хувьтөгөлдерийг Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ц. Д.Цогт-Очир, Д.Цэвээнжав нарыг Т байгуулалтын байнгын хорооны бүрэлдэхү тус тус чөлөөлж, Улсын Их Хурлын ги Н.Алтанхуяг, Бат-Эрдэнийн Батбаяр Аюулгүй байдал, гадаад бодлогын ба хорооны, Улсын Их Хурлын г Р.Бадамдамдинг Төсвийн байнгын хор Улсын Их Хурлын гишүүн Батж.Батбаяр, Д Очир, Д.Цэвээнжав нарыг Эдийн засгийн ба хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ц.Өө Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн ба хорооны, Улсын Их Хурлын гишүүн Шж.Бат Ж.Бямбадорж нарыг Хууль зүйн ба хорооны, Улсын Их Хурлын гишүүн Р.Нара О.Энхтуяа нарыг Төрийн байгуулалтын ба хорооны гишүүнээр тус тус батална

ДАРГА **Р.ГОНЧИГД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 11 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 181** **Улаанба хот**

Хувьчлах барилга байгууламж тоног төхөөрөмжийн жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 38 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Нийтийн дуудлагын худалдаагаар хувьчлах барилга байгууламж, тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралтын батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖА**

САНГИЙН САЙД **Я.ОЧИ**

ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУВЬЧЛАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

Хувьчлагдах төрийн өмчийн байрны байршил	Түрээсээр эзэмшиж буй аж ахуйн нэгж	Түрээслэж буй талбайн хэмжээ	Одоогийн ашиглалт
Баянгол дүүргийн III хорооллын үйлчилгээний II төвийн хэвлэлийн цех	"Хаваржаа" ХХК	287,0 м^2	Хүнсний дэлгүүр
Баянзүрх дүүргийн XI хорооны нутаг дахь 88 дугаар сургуулийн хуучин барилга	Ашиглалтгүй	396,0 м^2	
Баянзүрх дүүргийн ОСНАА-н ХШ конторын харьяа мужааны це-хийн байр, тоног төхөөрөмж	Ашиглалтгүй	42,0 м^2	
Хан-уул дүүргийн Төв цэнгэлдэх хүрээлэн-гийн арын павильоны 2, 3, 4, 5 дугаар барилга	"Говийн од групп" ХХК	178,0 м^2 178,0 м^2 327,0 м^2 317,0 м^2	Хоронгө оруулалт хийж байгаа

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

оны 11 дүгээр
ын 17-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Таримал ургамлын үр, сортын й Монгол Улсын хуулийн 5 дугаар ийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол ын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1."Үрийн нөөцийн улсын сан үүлэх, зарцуулах журам"-ыг ралтын ёсоор батлсугай.

2.Үрийн нөөцийн улсын санг ргийн орон тоо, тесвэт багтаан зохион уулж, энэхүү журмын дагуу луулахыг Хөдөө аж ахуй, вэрийн сайд Ч.Содномцэрэнд гасугай.

3.Үрийн нөөцийн улсын сан бүрдүүлж ажиллуулахад шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд Ч.Содномцэрэн нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН САЙД БӨГӨӨД ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАТХҮҮ

Засгийн газрын 1999 оны 184 дүг
тогтоолын хавсра

ҮРИЙН НӨӨЦИЙН УЛСЫН САН БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас тарих үрээ нөөцөлж чадаагүй үйлдвэрлэгч болон хүнс, тэжээлийн үр тариа дагнан тариалдаг иргэн, хуулийн этгээдэд үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилготой үрийн нөөцийн улсын санг бүрдүүлэх, зарцуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

2.Үрийн нөөцийн улсын сан /цаашид "Сан" гэх/ нь Монгол Улсын төсвийн хөрөнгөөр бий болсон төрийн өмч бөгөөд түүнийг бүрдүүлэх, хадгалах үүрэг бүхий Сангийн салбартай байж болно.

3.Сангийн салбар шинээр байгуулах, татан буулгахыг Сангийн сайдтай зөвшилцөн Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд шийдвэр гаргана.

Хоёр.Үр хүлээн авах бэлтгэл ажил

4.Сангийн салбар нь үр хүлээн авах доорхи бэлтгэл ажлыг жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний дотор хангасан байна:

а/сортын цэвэр байдлаараа стандартын шаардлага хангах нь сортын хяналтаар батлагдсан талбайгаас Санд үр авах тухай урьдчилсан гэрээг иргэн, хуулийн этгээдтэй хийх бөгөөд уг гэрээнд авах үрийн хэмжээ, чанар, үнэ, нийлүүлэх хугацаа зэргийг тусгасан байх;

б/гэрээний дагуу үрийг хүлээн авах, агуулахад байрлуулах зураглалыг боловсруулсан байх;

в/агуулах болон үр ачих, буулгах, дамжуулах, салхилуулах төхөөрөмжийг цэвэрлэн засварлаж ариутгасан байх;

г/үрийн төрөл, сорт бүрт хөтлөгдөх бүртгэл, хаягийг бэлтгэсэн байх.

Гурав.Санд үр хүлээн авах

5.Санд хүлээн авах үр нь чанарын талаар доорхи шаардлагыг хангасан байна:

а/цэвэршилтээрээ үрийн чанарын стандартад тэнцсэн;

б/чийг нь 14-15 хувиас дээшгүй байх;

в/агуулахын хортон шавьж болон элдэв өвчин илрээгүй;

г/баталгаат сортын торгон болон 1-5 дугаар үеийн үр.

6.Санд хүлээн авах торгон, дээд үржүүлгийн үр ба бага хэмжээний царгас, судан өвс зэрэг олон наст өвс болон хар будаа, рапсын үрийг нийлүүлэгч байгууллага нь тусгайлан савлаж стандартад заасны дагуу хаягласан байна.

7.Үр хүлээн авахдаа итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүн, сертификатын гэрчилгээ, хянан баталгаажуулах акт зэрэг баримтыг бичгийг үндэслэнэ.

8.Санд улсын жилийн хэрэгцээнээс шаардагдах үр тарианы үрийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний үрийг бүрдүүлнэ.

9.Үр тээвэрлэхэд доорхи шаардлага тавигдана:

а/үрийг тоос болон хөлдөх, норох, хамгаалсан байх;

б/үрийг гэмтээж болох эд зүйлтэй тээвэрлэхгүй байх;

в/тусгайлан савласан үрийг хоорондоо холихгүй байх.

Дөрөв.Үрийг байрлуулах, хадгалах хугацаа

10.Үрийг агуулахад урьдчилан бэлтгэсэн зураглалын дагуу доорхи байдлаар байрлуулж, хадгална:

а/таримлын төрлөөр;

б/таримлын дотор сортоор;

в/сортын дотор үржүүлгийн үе;

г/үржүүлгийн үеэр ижил сортын категориор;

д/категорийн дотор үрийн анги;

е/хүлээн авсан оноор нь.

11.Үр нь таримал, сортын нэр, хүлээн авсан он, сортын категор, үрийн анги, чийг зэргийг бичсэн хаягтай байна.

12.Нэг сортын ижил чанартай хэмжээний үрийг нэг дор хадгалж болох бөгөөд хольсон тухай бүрт албан ёсны акт үйлдэж байна.

13.Тусгайлан савласан үрийг үйлдвэрийн стандартад заасны дагуу байрлуулж хадгалана.

14.Үр хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор үрийн итгэмжлэгдсэн лабораториор үрийн чанарын шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулна.

15.Цэвэршилт, соёолоттоороо ялгарах үрийг хольж хадгалахыг хориглоно.

16.Үр хадгалах дээд хугацааг дараах байдлаар тогтооно:

а/буудай, арвай 7 жил;

б/хөх тариа, хошуу будаа, хар будаа 3 жил;

в/наранцэцэг, рапс, гич, вандуй, буурцаг 2 жил;

г/олон наст ургамлын үрийг 5 жил.

.Хадгалалтын үеийн ажиглалт, шинжилгээ

17.Хадгалж буй үрэнд ажиглалт, жилгээг дараахь зүйлд байнга хийж дэглэл хөтөлнө:

а/чийг;
б/өнгө, үнэр;
в/дулааны горим;
г/өвчин, хортон.

18.Хадгалж байгаа үрэнд үрийн 1 ба 2 ар шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор бүр заавал хийлгэнэ.

19.Халах шинж илэрсэн үед үрийг сэлгэх, илуулах арга хэмжээг яаралтай авч ажүүлнэ.

ргаа.Үрийн нөөцийн улсын санг зарцуулах

20.Үрийг зөвхөн дараахь үндэслэлээр зарцуулна:

а/байгалийн гамшгийн улмаас алах үрээ нөөцөлж чадаагүй иргэн, хуулийн эдэд дутагдах үрийн хэрэгцээг хангах;

б/сорт солих, үр шинэчлэх.

21.Үрийн үнийг чанар, зах зээлийн ийг үндэслэн Хөдөө аж ахуй, үйлдвэрийн тогтооно.

22.Иргэн, хуулийн этгээдэд олгож байгаа д сортын гэрчилгээ, шинжилгээний актыг арган тэмдэг дарж баталгаажуулсан байна. баримт бичгийг 2 хувь үйлдэнэ.

23.Үрийн захиалгыг хөдөө аж ахуйн дал эрхэлсэн төрийн захиргааны төв уулагаас эрх олгосон хүчлийн этгээд жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хүлээн авч нэгтгэн, хуваарийг тариалын төрөл, сортоор Сангийн салбар бүрээр гаргаж Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдад уламжилж батлуулна.

24.Сангийн үрийг зарцуулах шийдвэрийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын санал болгосноор Засгийн газар гаргана.

25.Үрийн нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтын тухай тайланг Сангийн салбар улирал тутам Санд, Сан хагас, бүтэн жилээр хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнаж байна.

Долоо.Санхүүжилт

26.Сангийн үр хүдалдан авах, тээвэрлэх, арчлах, хадгалах,борлуулахтай холбогдож гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

27.Борлуулах үрийн үнэ нь худалдан авсан үнэ дээр тээврийн зардал, анхны жилийн хадгалалтын зардлыг оролцуулан 20 хувиас илүүгүй нэмэгдэлтэй байна.

28.Иргэн, хуулийн этгээд нь үрийн үнийг Сангийн төвлөрсөн дансанд шилжүүлнэ. Үрийн үнийг төлсөн тохиолдолд үр олгоно.

29.Санд үр худалдан авахдаа үнийн дүнгийн 30 хувийг гэрээний үндсэн дээр урьдчилан олгож, тарих үрийн шинжилгээний дүн гарсны дараа жил бүрийн 12 дугаар сард багтаан эцсийн тооцоог хийж иргэн, хуулийн этгээдэд шилжүүлнэ.

30.Салбар нь үр хүлээн авсны дараа 1 сарын дотор үрийн үнэ, тээврийн зардал болон үрийн чанарын анхдагч баримт бичгитэй ирж Сантай тооцоо нийлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

оны 11 дүгээр ын 17-ны өдөр Дугаар 185 Улаанбаатар хот

Авто замын засвар, арчлалтын нэгтгэлийг компанийн хэлбэрт оруулан ажиллуулахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн ах хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн ас ТОГТООХ нь:

1.Авто замын засвар, арчлалтын нэгтгэл ийн өмчит улсын үйлдвэр)-ийг компанийн эрт шилжүүлэн ажиллуулсугай.

2.Авто замын засвар, арчлалтын нэгтгэл даат компанийн үүсгэн байгуулагч бөгөөд хувь үүлэгчээр Төрийн өмчийн хороо, төрийн өмчийн өллийг хэрэгжүүлэгчээр Төрийн өмчийн хороо, замын газар байхаар тус тус тогтоосугай.

3.Авто замын засвар, арчлалтын нэгтгэл ХК-компанийн тухай хуульд нийцүүлэн зохион улахыг Төрийн өмчийн хорооны дарга ргит, Авто замын газрын дарга С.Очирбат нарт болгосугай.

4.Улсын чанартай авто замын засвар, арчлалтын ажлыг Авто замын засвар, арчлалтын нэгтгэл ХК-д хариуцуулж байгаатай холбогдуулан нэг км авто зам, нэг уртааш метр гүүрийн засвар, арчлалтын ажлын жилийн нормативыг тогтоож 2000 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдүүлэхийг Сангийн сайд Я.Очирсүх, Дэд бүтцийн хөгжлийн сайд Г.Батхүү нарт даалгасугай.

5.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Авто замын байгуулагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 151 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн "б" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ

ДЭД БҮТЦИЙН
ХӨГЖЛИЙН САЙД Г.БАТХҮҮ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр **Дугаар 186** **Улаанба хот**

Хувьчлах аж ахуйн нэгж жагсаалтад нэмэлт оруулах т

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 160 дугаар тогтоолоор батлсан "Төрийн өмчийг 1997-2000 онд хувьчлах хөтөлбөр"-ийн "Гурав.Хувьчлах томоохон аж ахуйн нэгжүүд гэсэн 2 дугаар жагсаалтын Б-д 125.Улаанбаатар.Баянгол.Эрчим хүчний засварын үйлдвэр, 100, 374," гэж нэмсүгэй.

2.Эрчим хүчний удирдах газрын харьяа Э хүчний засварын үйлдвэр (УҮГ)-ийн хувьчл зохих хууль тогтоомжийн дагуу зө байгуулахыг Төрийн өмчийн хорооны Д.Зоригтод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Р.АМАРЖАГ**

САНГИЙН САЙД **Я.ОЧИР**

ХУУЛЬ ЗҮЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1999 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр **Дугаар 237, А/287** **Улаанба хот**

Журам батлах т

Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Гадаадын иргэнд Монгол Улсын харъяат хүүхдийг үрчлүүлэх журмыг хавсралтын ёсоор батлуулсугай.

ХУУЛЬ ЗҮЙН САЙД **ДАШ. ГАНБОЛД**

ЭРҮҮЛ МЭНД НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД **С. СОНИН**

Хууль зүйн сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын 1999 оны 237, А/287 дугаар тушаалын хавсралт

ГАДААДЫН ИРГЭНД МОНГОЛ УЛСЫН ХАРЪЯАТ ХҮҮХДИЙГ ҮРЧЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авахад энэхүү журмыг баримтална.

1.2. Гадаад улсад суугаа тус улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газраас гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гадаад улсад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэхэд энэ журмыг нэгэн адил мөрдөнө.

1.3. Монгол Улсын харьяат хүүхдийг урьд нь үрчлэн авсан гадаадын иргэн харьяалалгүй хүн-д эхний хүүхэд үрчлэн авсанаас хойш нэг жилийн дараа дахин хүүхэд үрчлэн авахыг зөвшөөрөх болно. /Энэ нь ихэр хүүхэд, эсхүл ах, эгч, дүү нарыг үрчлэн авахад хамаарахгүй /

1.4. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны буюу байнга оршин суугаа газрынхаа эрх бүхий байгууллагаар уламжлан Монгол Улсын Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөлд гаргана.

1.5. Энэ журмын 1.4-д заасны дагуу х гаргахдаа Гэр бүлийн тухай хуулийн 58 д зүйлийн 3 дахь хэсэгт заасан дор дурьдсан баримтыг бүрдүүлнэ

1.5.1. Хүүхэд үрчлэн авахыг хүсэ хүсэлт, түүний нотариатаар гэрчлүү орчуулга.

1.5.2. Сурьеэ, ДОХ, сэтгэцийн өвчтэй таларр эмнэлгийн байгууллагын магадлагаа.

1.5.3. Төрсний болон гэрлэ гэрчилгээний хуулбар /гэр бүлтэй бол/

1.5.4. Байнга оршин суугаа газрын болон гэмт хэрэгт холбогдож байсан эсэх т оршин суугаа газрын холбогдох байгуул буюу цагдаагийн байгууллагын тодорхойлол

1.5.5. Хүсэлт гаргагчийн цали тодорхойлолт, эсхүл санхүүгийн амьдралын боломжийн тухай холб байгууллагын тодорхойлолт.

1.5.6. Хүсэлт гаргагчийн гэр бүл, зан йдлын тухай холбогдох эрх бүхий ігууллагын тодорхойлолт

1.5.7.Хүсэлт гаргагчийн талаархи хүн зүйн асуудал эрхэлсэн Төрийн иргааны төв байгууллагын тодорхойлолт

1.5.8.Үрчлэн авах гэж буй хүүхдийг лэн авагчийн харъяалагдах улсад нэвтрэн ах, байнга оршин суух зөвшөөрөл олгох юмжтой эсэх талаар тухайн орны аачлалын асуудал эрхэлсэн байгууллагын орхойлолт

1.6 Энэ журмын 1.5-д дурьдсан бичиг имт тус бүрийг тухайн улсын холбогдох бүхий байгууллага, албан тушаалтан ын үсэг зурах буюу боломжтой бол тамга дэг/дарж баталгаажуулсан байна.

1.7 Монгол Улсын харъяат хүүхдийг эр, нөхөр үрчлэн авах тохиолдолд энэ й хүсэлтээ эхнэр, нөхөр хоёр бичгээр тран гаргаж, энэхүү журмын 1.5-д заасан иг баримтыг тус бүрдээ бүрдүүлж үлнэ.

1.8 Гадаадын иргэдийн асуудал эрхлэх лел хүүхэд үрчлэн авах тухай хүсэлт гасан хүнийг бүртгэн авч, хүсэлтийг ээн авсанаас хойш 30 хоногийн дотор элт гаргагч этгээдэд хүүхэд үрчлүүлэх омжтой эсэхийг магадлана. Ингэхдээ аадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөл аад улсын холбогдох байгууллагаар мжлуулан ирүүлсэн гадаадын иргэн, ъяалалгүй хүний материалд Эрүүл мэнд, гмийн хамгаллын яам, Улсын аюулгүй длыг хангах газар болон Цагдаагийн нхий газрын эрх бүхий албан тушаалтны алыг авсан байна.

1.9 Гадаадын иргэдийн асуудал эрхлэх лөл тухайн гадаадын иргэнд хүүхэд түүлэх боломжгүй гэж үзвэл энэ тухай лтийг уламжилсан гадаад улсын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

1.10 Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөл гадаадын иргэнд хүүхдээ үрчлүүлэх сонирхолтой эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон байгууллагыг эрж олоход туслах ажлыг гүйцэтгүүлэхэр хүүхдийн асуудал эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж болно.

1.11 Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөл гадаадын иргэн харъяалалгүй хүнд хүүхэд үрчлүүлэх боломжтой гэж үзвэл үрчлэгдэх хүүхдийн талаар дараахь бичиг баримтыг нэг сарын дотор бүрдүүлнэ.

1.11.1 Хүүхдийн эцэг, эхийн бичгээр өгсөн зөвшөөрөл,/ энэ заалт гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөрт нэгэн адил хамаарна/.

1.11.2 Хүүхдийн эцэг, эхийн хэн нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсонд тооцсон бол түүний төрөл, садангийн хүмүүсийн бичгээр өгсөн зөвшөөрөл эсхүл аль аль нь нас барсан бол нас барсныг тодорхойлсон гэрчилгээ, хүүхдийн эцэг эх нь сураггүй алга болсон, эцэг эх байх эрхээ хасуулсан тухай шүүхийн шийдвэр;

1.11.3 Бүтэн өнин хүүхэд асрамжийн байгууллагад хүмүүжиж байгаа бол эцэг, эхийн ойрын төрөл, садан эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хүүхдийг асран хүмүүжүүлж байгаа байгууллагын зөвшөөрөл

1.11.4 Олдмол хүүхэд асрамжийн байгууллагад хүмүүжиж байгаа бол асран хүмүүжүүлж буй байгууллагын зөвшөөрөл

1.11.5 Эцэг, эх нь ахуйн амьдралын гачигдлаас шалтгаалж хүүхдээ хэвийн асран өсгөх боломжгүй бол энэ тухай сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт

1.11.6 Хүүхдийн эрүүл мэндийн тодорхойлолт, хүүхэд тахир дутуу бол энэ тухай эмнэлгийн байгууллагын магадлагаа

1.11.7 Хүүхдийн гэр бүлийн байдлын тухай баг, хорооны Засаг дарга эсхүл асрамжийн байгууллагын тодорхойлолт

1.12 Гадаадын иргэдийн асуудал эрхлэх эвлэл үрчлүүлэх хүүхдийн талаарх материалыг гадаад улсын эрх бүхий байгууллагаар уламжлан хүүхэд үрчлэн авах тухай хүсэлт тавьсан гадаадын иргэнд явуулж, хүүхэд үрчлэн авах боломжтой тухай мэдэгдэнэ.

1.13 Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч гадаадын иргэн, харьяалалгүй хүн хүүхдийг үрчлэн авахаар шийдэн тохиолдолд үрчлэгдэж буй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч шаардлагатай гэж үзвэл хүүхдийн талаар гэрээ байгуулах хүсэлт гаргаж болно. Гэрээг хүүхэд үрчлэн авсан эцэг эх гадаадын иргэдийн асуудал эрхлэх эвлэлтэй байгуулна. Гэрээнд гадаадын иргэн харьяалалгүй хүн нь хүүхэд үрчлэн авсан эхний 3 жилийн хугацаанд хүүхэд хэрхэн өсөн бойжиж, хүмүүжиж байгаа талаар гадаадын иргэдийн асуудал эрхлэх эвлэлдэжил бүр мэдээлэл ирүүлж байх, хүүхдийг хэвийн өсөж хүмүүжих, сурч боловсрох шаардлагатай нөхцлөөр хангах, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн буюу Консулийн газраас шаардлагатай тохиолдолд тухайн хүүхдийг жилд нэг удаа эргэн очиж, хүүхдийн аж байдалтай танилцаж, түүнтэй ярилцах боломжоор хангах, хэрэв хүүхдийг хэвийн өсгөж хүмүүжүүлээгүй, түүнийг хавчин гадуурхах, хүчирхийлэх зэрэг үйлдэл илэрвэл үрчлэлтийг хүчингүйд тооцож, хүүхдийг буцаан авч болох зэрэг асуудлыг тусгаж болно.

Хоёр. Хүүхэд үрчилснийг бүртгэх

2.1 Энэ журмын 1.5 болон 1.11, 1. дурьдсан бичиг баримтыг үндэслэн хүүхэд үр авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүн өрг гаргаж, нийслэлд Иргэний бүртгэл мэдээл улсын төв, орон нутагт аймгийн Засаг да дэргэдэх Иргэний бүртгэл, мэдээллийн алб биечлэн бүртгүүлнэ.

2.2 Хүүхэд үрчлэн авсаныг бүртг үрчлүүлж байгаа эцэг, эх, эсхүл хэн нэгийг түүнчлэн асран хамгаалагч, харга дэмжигчийг заавал байлцуулна.

2.3 Долоон нас хүрсэн хүүх үрчлүүлэхэд өөрийнх нь зөвшөөрлийг авч тухай тэмдэглэл хөтөлнө.

2.4 Олдмол хүүхдийн үрчлэл бүртгэхдээ цагдаагийн буюу асран хамга байгууллагын төлөөлөгчийг оролцуулна.

2.5 Үрчлэлтийг бүртгэх байгууллага үрчлэгдэх хүүхдийн гэрчилгээг хураан ши төрсний гэрчилгээ олгож хоёр дугаар өгнө.Э дугаар нь төрсний гэрчилгээний дугаар бөгөөд түүний араас ташуу зураас т үрчлэлтийн дугаарыг бичнэ. Төрсний гэрчилг хүүхдийн овог, үрчилж авсан эцгийн/ эхийн регистрийн дугаар, төрсөн он, сар өдрийг б баруун доод талд бүртгэв тэмдэг дарж, үрч хийгдсэн он, сар, өдрийг бичнэ.

2.6 Үрчлэлтийг бүртгэх байгуул өргөдлийг хүлээж авсан өдрөөс хойш 5 хоно дотор бүртгэн, холбогдох бичиг бари гардуулна.

2.7 Хүүхэд үрчлэн авч байгаа гадаа иргэн нь бүртгэлийн үйлчилгээний хура төлнө. Хураамжийн хэмжээг Иргэний бүр мэдээллийн улсын төвийн саналыг үндэ Хууль зүйн сайд тогтооно.

МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

1999 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр **Дугаар 114** **Улаанбаа хот**

Журам батлах ту

“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 15-дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, “Ан агнуурын тухай ” хуулийн 18 дугаар зүйлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТУШААХ нь:

1. “Загасны аж ахуй эрхлэх журам” -ыг нэгдүгээр, Үйлдвэрлэлийн зориулалттай загас барих гэрээний загварыг хөрдугаар хавсралтын ёсоор тус тус батлсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуу “Журам батлах тухай” Байгаль орны сайдын оны 12 дугаар сарын 29 ний өдрийн 176 ду тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД **С. МӘНДСАЙ**

Байгаль орчны сайдын 1999 оны 114 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт

ЗАГАСНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Үйлдвэрлэлийн зориулалттай загас их, загасны нөөцийг хамгаалах, нөхөн гээх үйл ажиллагаа явуулахад энэхүү мыг мөрдөнө.

1.2. Загасны аж ахуй эрхлэх гэдэгт рын агнуурын загасыг үйлдвэрлэлийн иулалтаар өсгөн үржүүлэх, барих, овсруулахтай холбогдсон үйл ажиллагаа аарна.

ЁР. Загасны аж ахуй эрхлэхэд лцогч талуудын хүлээх эрх, үүрэг

2.1. Загасны аж ахуй эрхлэхэд Байгаль ны яам дараах эрх үүрэгтэй байна:

2.1.1. Нуурын агнуурын загасны нөөц, эгцээг харгалзан жилд барих загасны д хэмжээг нуур тус бүрээр тогтоох:

2.1.2. Аж ахуйн нэгж , байгууллагад сны аж ахуй эрхлэх эрх олгох түүнийг пах, үйл ажиллагааг нь үнэлэлт, дүгнэлт с:

2.1.3. Загасны аж ахуй эрхлэх аж ахуйн к, байгууллагыг байгаль орчинд нөлөөлөх длын үнэлгээнд хамруулах, тэдгээрийн ажиллагаанд мэргэжлийн удирдлагаар ахад дэмжлэг үзүүлэх.

2.2. Загасны аж ахуй эрхлэхэд аймаг, ын Засаг дарга дараах эрх үүрэгтэй на:

2.2.1. загасны аж ахуй эрхлэх эрх ан аж ахуйн нэгж байгууллагатай загас их гэрээ байгуулж, хэрэгжилтэнд нь алт тавих:

2.2.2. нуурын загасны нөөц, загас урын бүсийг мэргэжлийн байгууллагаар оолгох ажлыг зохион байгуулах:

2.2.3. Үйлдвэрлэлийн зориулалтаар с бариулснаас сумын төсөвт орсон ргын зохих хувийг сумын Иргэдийн өөлөгдийн Хурлын шийдвэрийг үндэслэн ын загасыг хамгаалах, өсгөн үржүүлэх, гшуулах арга хэмжээнд зарцуулах:

2.2.4. нуурын загасны нөөцийг тогтоосон материал, үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих гэрээг дүгнэсэн протокол, нуурын загасны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, талаар хийсэн ажлын тайлангийн хамт дараа оны 2 дугаар сарын 1 ний дотор Байгаль орчны яаманд ирүүлэх.

2.3. Загасны аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага дараах эрх үүрэгтэй байна:

2.3.1. агуурын загасыг зориулалтын тор хэрэгсэл, зөвшөөрсөн арга технологийн дагуу барих:

2.3.2. үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих, боловсруулах, үржүүлэхэд дэвшилтэт технологи, техник хэрэгсэлийг нэвтрүүлэх, ажиллагсдыг сургаж дадлагжуулах:

2.3.3. үйлдвэрлэлийн зориулалтаар загас барих, боловсруулах, үржүүлэх ажилд холбогдох эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагын хүмүүсийг татан оролцуулах:

2.3.4. загас барих төлбөрийн хураамж, орлогын татварыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь төлж байх:

2.3.5. загас агнуурын ажлыг Ан агнуурын тухай Монгол Улсын хуулиар тогтоосон хугацаанд явуулах ба жилд барих загасны 60-аас илүүгүй хувийг өвлийн улиралд, үлдэх хэсгийг бусад улиралд барих:

2.3.6. загасыг бусад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад худалдахдаа байгууллагынхаа албан ёсны тодорхойлолтыг хавсаргасан байх:

2.3.7. нуурын загасны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах өсгөж үржүүлэх, нуурын эрэг, усны толио, нуурын ёроолыг бохирдлоос сэргийлэх, байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тавигдсан шаардлагыг бүрэн биелүүлж, энэ талаар хийсэн ажлын тайланг аймгийн засаг даргад дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор гаргаж ирүүлэх.

ГУРАВ.Загасны аж ахуй эрхлэх эрх олгох

3.1. Загасны аж ахуй эрхлэх эрх хүссэн аж ахуйн нэгж, байгууллага дараах бичиг баримт бүрдүүлнэ.

3.1.1. загасны аж ахуй эрхлэх тухай хүсэлт:

3.1.2. загасны аж ахуй эрхлэх төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн дүгнэлт:

3.1.3. аймаг, сумын засаг даргын тодорхойлолт:

3.1.4. загасны аж ахуй эрхлэх техник, тоног төхөөрөмжийн жагсаалт, мэргэжлийн боловсон хүчний дипломын хуулбар:

3.1.5. нуурын загасны нөөцийг хамгаалах зохистой ашиглах, зориуд өсгөн үржүүлэх, нуурын эрэг, ус, усны толио, нуурын ёроолыг бохирдлоос сэргийлэх арга хэмжээний хөтөлбөр.

3.2. Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар загасны аж ахуй эрхлэх эрх хүссэн аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, 21 хоногийн дотор хянан үзэж, дүгнэлт гарган загасны аж ахуй эрхлэх эрх олгох, эсэх асуудлыг Байгаль орчны Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.

3.3. Загасны аж ахуй эрхлэх эрхийг Байгаль орчны сайдын тушаалаар 2 жилийн хугацаатай олгоно.

3.4. Загасны аж ахуй эрхлэх эрхийн хугацаа дуусахаас 2 сарын өмнө эрх сунгуулахыг хүссэн өргөдөл гаргаж, тухайн шатны засаг даргын тодорхойлолт, гүйцэтгэсэн ажлын тайлангийн хамт Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлсэн байна.

3.5 Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор хянан үзэж, загасны аж ахуй эрхлэх эрхийн хугацаат сунгах, эсэх талаар дүгнэлт гаргана.

3.6. Байгаль орчны сайдын тушаалаар загасны аж ахуй эрхлэх эрхийг 3 жилийн хугацаагаар сунгана.

ДӨРӨВ.Бусад зүйл

4.1. Байгаль орчны яам загасны аж эрхлэх эрхийг дараах тохиолдолд хүч болгоно:

4.1.1. аймаг, сумын засаг дарга харг үзэх үндэслэлтэй хүсэлт, дүгнэлт гаргасан:

4.1.2. загасны аж ахуй эрхлэх хө санхүү, боловсон хүчний чадавхигүй болсон:

4.1.3. эрхлэх ажлын чиглэл өөрчлөгдс

4.1.4. загасны аж ахуйн өөрийн хүсэл

4.1.5. Ан агнуурын тухай хууль тогт болон энэхүү журмыг зөрчсөн:

4.1.6. Байгаль орчны нөлөөлөх бай үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэ

4.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар барихад дараахь үйл ажиллагаа явуулах, хэрэгсэл хэрэглэхийг хориглоно:

4.2.1. нуурт цутгаж буй болон, нуура авч буй гол горхины бэлчирээс 200 ме дотор загас агнуур явуулах:

4.2.2. морин /хамдаг/ тор нь хөвөөс хэцтэй, нуурын гүнээс 2 метрээс илүү өрг байх:

4.2.3.морин торны гүвчуур уутны н хэмжээ 30х30мм-ээс торны хөвөө жигүү нүдний хэмжээ 40х40 мм-ээс тус тус доош ба

4.3. Загасны аж ахуй эрхлэхтэй холбо гаргасан аливаа маргааныг энэ журмын Байгаль орчны яам хүлээн авснаас хой хоногийн дотор шийдвэрлэнэ.

4.4. Энэ журмыг зөрчсөн аж ахуйн байгууллага, албан тушаалтанд байгаль о хянлатын бүх шатны байцаагч, Ан агнуурын Монгол Улсын хууль, болон бусад тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлг зэрэгцүүлэх, загас агнуурын ажилгаа түр зогс улмаар бүрмөсөн зогсоох, асуудлыг Ба орчны яаманд тавьж шийдвэрлүүлнэ.

4.5. Байгаль орчны яамны шийдвэр зөвшөөрөл гомдлоо хууль хяна байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Улсын Их Хурлын Тамгын газрь
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 329487

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 1999 оны арванхоёрдугаар сарын 24 №59 (138)

Гарчиг

528. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт 1017

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэгдүгээр зүйл

Монгол Улсын Үндсэн хуульд аалт нэмсүгэй:

1/ Хорин хоёрдугаар зүйлийн ахь хэсэгт:

"Үндсэн хуульд өөрөөр гаагүй бол Монгол Улсын Ерөнхий дыг томилох саналыг Улсын Их алд өргөн мэдүүлснээс хойш ин тав хоногийн дотор Улсын Их ал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй өөрөө тарах буюу эсхүл Монгол ын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг аах тухай шийдвэр гаргана."

2/ Гучин есдүгээр зүйлийн 2 ь хэсэгт:

"Ерөнхий сайд уул асуудлыг нхийлөгчтэй долоо хоногийн дотор шилцөж чадаагүй бол Улсын Их алд өөрөө өргөн мэдүүлнэ."

Хоёрдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, хорин долдугаар зүйлийн 2, 6 дахь хэсэг, хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Улсын Их Хурлын дарга, дэд даргыг Улсын Их Хурлын гишүүдийн дотроос нэр дэвшүүлэн саналаа илээр гаргаж сонгоно. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно."

2/ Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна."

3/ Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ."

4/ Хорин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна.Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, алб тушаал хавсарч болохгүй."

5/ Гучин гуравдугаар зүйли 1 дэх хэсгийн 2:

"2/ Улсын Их Хуралд олон суудал авсан нам, эвслээс н дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвс олонхийн суудал аваагүй бол хамги олон суудал авсан нам, эвсэл бус нам; эвсэлтэй зөвшилцөн н дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамги олон суудал авсан нам, эвсэл бус нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнх сайдад нэр дэвшүүлж чадаагүй б Улсын Их Хуралд суудал авсан на эвсэл зөвшилцөн олонхиоро н дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайда томилох саналыг тав хоногийн дот Улсын Их Хуралд оруулах;"

Гуравдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуул оруулсан энэ нэмэлт, өөрчлөлт 2000 оны долдугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Р.ГОНЧИГДОРЖ**

1999 оны арван хоёрдугаар сарын 24-ний өдрийн 12 цаг 50 минут

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14503

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 329487